



# ҮНЭТ ШААСНЫ

IPO

ТАНИЛЦУУЛГА | 2021

Үнэт цаас  
гаргагч:



Үндсэн  
Андеррайтер:



Туслах  
Андеррайтер:



## ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

### Үндсэн андеррайтер



Голомт Капитал ҮЦК ХХК  
✉ info@golomtcapital.com  
☎ +976-7012 1530  
🌐 www.golomtcapital.mn

### Туслах андеррайтер



Апекс Капитал ҮЦК ХХК  
✉ investment@apex.mn  
☎ +976-7510 7500  
🌐 www.apex.mn

### Аудитын компани



БДО Аудит ХХК  
☎ +976-7740 4040  
☎ +976-7745 1150  
🌐 www.bdo.mn

### Хуулийн фирм



Өмгөөллийн Батбаяр Энд Партнерс ХХН  
✉ contact@bnp.mn  
☎ +976-8888 9008  
☎ +976-7711 9008

### Үнэлгээний компани



Гэрэгэ Эстимэйт ХХК  
✉ gantulga@geregepartners.mn  
☎ +976-9910 7317  
☎ +976-7000 5000


### Байгаль орчин, нийгмийн засаглалын үнэлгээний компани



Ризилиенс Консалтинг Сервиз ХХК  
✉ nyamgarav@rcs.mn  
☎ +976-8810 4587







## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох журмуудын дагуу өөрийн хувьцаанаас анх удаа олон нийтэд санал болгож байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас 24,952,940,480 төгрөгийн үнийн дүн бүхий 119,966,060 ширхэг энгийн хувьцааг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй арилжихтай холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар өөрийн хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд өөрийн мэргэжлийн санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэйгээ зөвлөлдөхийг зөвлөж байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа аль болох үнэн зөв мэдээллийг ашиглан бодит байдалд нийцүүлэхийг зорьсон боловч мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭСЭН НЬ АЛИВАА ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ БАТАЛГАА БИШ БОЛОХЫГ АНХААРНА УУ. ЭРХЭМ ТА ҮНЭТ ЦААС ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ ГЭДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ТУХАЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ЗАХ ЗЭЭЛД ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛЖ ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч болон Андеррайтер Голомт Капитал ҮЦК ХХК-д хандаж тодруулна уу.



## ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 23 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 61.1.7 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.2, 62.1.3, 62.1.4 дэх заалт, 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Үнэт цаас гаргагчийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.6.2 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.5.1, 9.5.2, 9.5.4, 9.5.15 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 7 сарын 26-ны өдрийн 6 тоот тогтоол, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 7 сарын 26-ны өдрийн 11 тоот тогтоол, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 9 сарын 9-ний өдрийн 151021-13 тоот хурлын тогтоолыг тус тус үндэслэн нийт 799,773,734 ширхэг хувьцааны 15 хувь 119,966,060 ширхэг хувьцаа нэмж гарган Монголын Хөрөнгийн Биржийн III ангиллаар анх удаа нийтэд санал болгон арилжихаар шийдвэрлэсэн байна.

Үнэт цаас гаргагч	Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Нийт гаргасан хувьцааны тоо ширхэг	679,807,674
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ	100 төгрөг
Нийтэд санал болгох эзэмшлийн хувь	15%
<ul style="list-style-type: none"> <li>Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох хувь</li> </ul>	50%
<ul style="list-style-type: none"> <li>Олон нийтэд санал болгох хувь</li> </ul>	50%
Нэмж гаргах хувьцааны тоо ширхэг	119,966,060
Нэмж гаргасны дараах хувьцааны тоо ширхэг	799,773,734
Нэгж хувьцааны үнэ	208 төгрөг
Олон нийтээс татан төвлөрүүлэх дүн	24,952,940,480 төгрөг
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Нэмэлт дэлгүүрийн хөрөнгө оруулалт, түгээлтийн төвийн тоног төхөөрөмж, хоолны үйлдвэрийн тоног төхөөрөмж
Хувьцааг арилжаалах арга	Тогтоосон үнийн арга


Үндсэн андеррайтер

Туслах андеррайтер









## МЭНДЧИЛГЭЭ

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Хөрөнгө оруулагч таны энэ өдрийн амгаланг айлтгая.

Өнгөрсөн гуч гаруй жилд Монголчуудын амьдралын хэв маяг багагүй өөрчлөгджээ. Бидний өдөр тутмын амьдралын хэмнэл улам цаг завгүй, хурдтай болон өөрчлөгдөж байна. Ийм ч учраас бид өнөөдрийн Монголчуудын амьдралын хэв маягт тохирох үргэлж нээлттэй байдаг, хаанаас ч олж болох, чанартай бүтээгдэхүүн, соёлтой үйлчилгээтэй дэлхийн стандартын конвиниенс дэлгүүрийн сүлжээг Монголдоо байгуулах шийдвэрийг эдүгээгээс 4 жилийн өмнө гаргаж, дэлхийн шилдэг брэндүүдийн нэг болох БНСУ-ын "CU" конвиниенс дэлгүүрийн мастер франчайзийн эрхийг авч өнөөдрөөс 3 жилийн өмнө анхны "CU" дэлгүүрээ Улаанбаатар хотод нээж байлаа. Тэгвэл өнөөдөр бид 127 салбар дэлгүүртэй, өдөр бүр 38 мянган хүнд үйлчилдэг, Улаанбаатарчуудын өдөр тутмын амьдралын салшгүй нэг хэсэг болон өргөжин тэлжээ.

Бид аливаа бизнесийн амжилттай оршин тогтнох үндэс нь нийгэмдээ бүтээж буй үнэ цэнээр тодорхойлогддог гэдэгт итгэдэг. Сүүлийн 3 жилийн хугацаанд нээсэн салбар дэлгүүрүүдийн борлуулалт өсөж, үнэнч үйлчлүүлэгчдийн тоо өдрөөс өдөрт нэмэгдсээр байгаа нь бидний нийгэмдээ бүтээж буй үнэ цэнийн баталгаа гэж бид үздэг.


Бид соёлтой, шуурхай үйлчилгээ, дэлхийн жишиг болсон бүтээгдэхүүн үйлчилгээгээр хэрэглэгчдийнхээ өдөр тутмын амьдралыг илүү жаргалтай болгож, дэлгүүр бүрээ инээмсэглэл, эелдэг харилцаагаар дүүргэхийг эрмэлздэг. Үүний тулд ажилтан албан хаагчиддаа дэлхийн жижиглэн худалдааны тэргүүний туршлага, ур чадварыг эзэмшүүлж, олон улсын шилэгдмэл нөү хауг эх орондоо нутагшуулж, жижиглэн худалдааны салбарыг шинэ түвшинд хүргэхээр ажиллаж байна.

Мөн бид "CU" -ийн шилдэг туршлагаас суралцаад зогсохгүй, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг эх орондоо татсанаар Монголынхоо брэнд бүтээгдэхүүнийг CU-ийн олон улсын 15000 гаруй салбар дэлгүүрт экспортлох үүд хаалгыг нээгээд байна.


Бид оюутан залууст боловсрол эзэмшихийнхээ сацуу дэлхийн хэмжээний үйлчилгээний стандартаас суралцан, тогтвортой орлого олох боломжоор хангаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг тэгш боломжоор ханган нийгмийн оролцоог нь дэмждэг.

Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдний бизнесийн тогтвортой байдлыг хангах зорилгоор бид франчайз хөтөлбөр хэрэгжүүлдэг бөгөөд өнөөдөр 23 жижиг дунд бизнес эрхлэгчидтэй хамтран салбар дэлгүүрүүдээ ажиллуулж байна. Нөгөө талдаа хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжин, тэдэнтэй хамтран бүтээгдэхүүнийг нь хөгжүүлж, өөрийн түгээлт, борлуулалтын сувагаараа дамжуулан





Үнэт цаасны танилцуулга  
МОНГОЛ УЛСЫН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE



127-салбар дэлгүүрээрээ түгээн борлуулж байна. Мөн манай байгуулсан борлуулалт түгээлтийн дэд бүтцийг ашиглан дотоодын 300 гаруй бэлтгэн нийлүүлэгч бараа бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд хүргэдэг.

Манай дэлгүүрийн сүлжээ нь зөвхөн шуурхай, соёлтой үйлчилгээний цэг биш, орчин тойрондоо буй иргэдийн өдөр тутмын амьдралын түшиг тулгуур, нийгмийн дэд бүтэц болон хөгжихийг бид зорьдог. Өнөөдөр бид нийтийн ариун цэврийн өрөөгөөр үнэ төлбөргүй үйлчлүүлэх, аюул осол тохиолдсон үед аюулгүй байдлаа хангуулах, халуун хүйтэнд амсхийх цэг зэрэг боломжуудыг олон нийтэд санал болгож, замын ачаалал бага үеэр барааны түгээлтээ зохион байгуулж Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулахад ч хувь нэмрээ оруулж байна.

Бид үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн өндөр боловсролтой, ур чадвартай, зөв хандлагатай залуусыг багтаа нэгтгэж чадсан нь амжилтын маань нэг үндэс бөгөөд бидний бүрэлдүүлсэн хамт олон манай өрсөлдөх чадварын илэрхийлэл, компанийн хамгийн үнэ цэнтэй хэсэг нь билээ. Ийм ч учраас цаашид тэмүүлж буй зорилгодоо хүрч чадна гэдэгт бид итгэлтэй байдаг.

Ирээдүйд олон жилийн турш тогтвортойгоор үнэ цэн нь өсөх "Сэнтрал Экспресс Си Ви Эс" компанийн хувьцааг та бүхэнд нээлттэй санал болгож байгаадаа миний бие туйлын баяртай байгаа бөгөөд цаашид Монгол Улсын хөгжилд хувь нэмрээ хамтдаа оруулахыг хүсч байна.

CU-д ТАВТАЙ МОРИЛ!

А.Ганхуяг

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга





<b>1</b>	<b>ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ</b> .....	<b>14</b>
	1.1 Үнэт цаас гаргагчийн товч танилцуулга .....	14
	1.2 Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл.....	16
	1.3 Үнэт цаас гаргагчийн хаяг, байршил.....	16
	1.4 Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд.....	17
	1.5 Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт .....	23
	1.6 Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан .....	31
	1.7 Үнэт цаас гаргагчийн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл .....	32
<b>2</b>	<b>ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ</b> .....	<b>38</b>
	2.1 Товч танилцуулга .....	38
	2.2 Үйл ажиллагааны онцлог, давуу тал.....	40
	2.3 Хүний нөөц .....	55
	2.4 Тогтвортой хөгжлийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд .....	57
	2.5 Эрсдэлийн удирдлагын бодлого .....	62
	2.6 Санхүүгийн тайлан, шинжилгээ .....	74
<b>3</b>	<b>ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ</b> .....	<b>92</b>
	3.1 Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал.....	92
	3.2 Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн төлөв байдал .....	101
	3.3 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл .....	102
	3.4 Зах зээлийн багтаамж .....	117
	3.5 Дунд хугацааны стратеги .....	123
	3.6 Санхүүгийн төсөөлөл.....	133
<b>4</b>	<b>ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ</b> .....	<b>146</b>
	4.1 Нийтэд санал болгох үнэт цаасны тухай .....	146
	4.2 Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт .....	147
	4.3 Нийтэд санал болгох үнэ тогтоосон үндэслэл.....	147
	4.4 Үнэт цаас гарган татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт .....	150
	4.5 Үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг .....	153
	4.6 Ногдол ашгийн бодлогын төсөл .....	155
	4.7 Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө .....	160
	4.8 Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөр .....	164
	4.9 Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх төлөвлөгөө .....	166
	4.10 Андеррайтерийн худалдан авах хувь хэмжээ .....	167
<b>5</b>	<b>ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД</b> .....	<b>170</b>
	5.1 Хөндлөнгийн үнэлгээний байгууллагын танилцуулга, гэрээ .....	170
	5.2 Хөндлөнгийн аудитын байгууллагын танилцуулга, гэрээ .....	171
	5.3 Хуулийн фирмийн танилцуулга, гэрээ.....	173
	5.4 БОНЗ-ын үнэлгээний байгууллага, гэрээ .....	175
	5.5 Үндсэн андеррайтерийн танилцуулга, гэрээ.....	177
	5.6 Туслах андеррайтерийн танилцуулга, гэрээ .....	179
	5.7 Андеррайтерийн дүгнэлт.....	181
<b>6</b>	<b>ХАВСРАЛТ</b> .....	<b>196</b>



**ХҮСНЭГТ**

Хүснэгт 1. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч хувь хүмүүсийн мэдээлэл .....	19
Хүснэгт 2. Эрх бүхий албан тушаалын ажлын байрны мэдээлэл .....	31
Хүснэгт 3. Үнэт цаас гаргагчийн сургалтын мэдээлэл .....	56
Хүснэгт 4. Үнэт цаас гаргагчийн орлого үр дүнгийн тайлан, сая төгрөгөөр .....	74
Хүснэгт 5. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлан, сая төгрөгөөр .....	83
Хүснэгт 6. Макро эдийн засгийн үзүүлэлтүүд .....	93
Хүснэгт 7. Бодит ДНБ-ий өсөлтийн төсөөлөл, хувиар .....	95
Хүснэгт 8. Инфляцын төсөөлөл, хувиар .....	96
Хүснэгт 9. Худалдааны салбарын үйл ажиллагааны үзүүлэлт .....	105
Хүснэгт 10. Монгол Улсын жижиглэн худалдаа эрхлэгчдийн тоо, 2020 оны 6 сар .....	109
Хүснэгт 11. Цар тахал ба хэрэглэгчдийн онлайн худалдан авалтын хандлага .....	110
Хүснэгт 12. Олон улсын конвинеенс дэлгүүрийн салбарын орлогын өсөлт, хувиар .....	112
Хүснэгт 13. Нийтийн хоолны зах зээлд оролцогчдын тоо .....	117
Хүснэгт 14. Эдийн засгийн өсөлт, инфляцын төсөөлөл, хувиар .....	118
Хүснэгт 15. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, хувиар .....	118
Хүснэгт 16. ДНБ ба өрхийн хэрэглээ, их наяд төгрөгөөр .....	120
Хүснэгт 17. Хөгжингүй болон хөгжиж буй орны жижиглэн худалдааны зах зээлийн бүтэц .....	121
Хүснэгт 18. Улаанбаатар хотын нэг дэлгүүрт ногдох хүн амын тоо .....	122
Хүснэгт 19. Орлого, үр дүнгийн хураангуй тайлан, тэрбум төгрөгөөр .....	133
Хүснэгт 20. Олон улсын конвинеенс дэлгүүрийн борлуулалтын өртгийн хувь .....	137
Хүснэгт 21. Санхүүгийн байдлын тайлан, тэрбум төгрөгөөр .....	139
Хүснэгт 22. Олон улсын конвинеенс дэлгүүрийн бараа материалын дундаж насжилт, хоногоор .....	140
Хүснэгт 23. Мөнгөн гүйлгээний тайлан, тэрбум төгрөгөөр .....	142
Хүснэгт 24. Үнэт цаасны мэдээлэл .....	146
Хүснэгт 25. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц .....	147
Хүснэгт 26. Үнэлгээний үр дүн .....	150
Хүснэгт 27. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт .....	150
Хүснэгт 28. Үнэт цаас гаргагчийн хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжаанаас эргүүлэх худалдан авах нөхцөл .....	165
Хүснэгт 29. Үнэт цаас гаргагчийн хувьцаа нэмж гарган ажилтнууддаа шууд болон опционоор хэлбэрээр эзэмшүүлэх нөхцөл .....	166





## ЗУРАГ

Зураг 1. Сэнтрал Экспресс, БиЖиЭф Ритэйл нарын хооронд байгуулсан Мастер франчайзийн гэрээнд гарын үсэг зурах ёслол.....	14
Зураг 2. Өөрчлөлт орохоос өмнөх хувьцаа эзэмшигчдийн бүтэц.....	17
Зураг 3. Өөрчлөлт орсны дараах хувьцаа эзэмшигчдийн бүтэц.....	18
Зураг 4. CU конвниенс сүлжээ дэлгүүрийн тархац.....	19
Зураг 5. Премиум Группийн амжилтын товчоон.....	21
Зураг 6. Үнэт цаас гаргагчийн төлөвлөж буй засаглалын бүтэц.....	24
Зураг 7. Үнэт цаас гаргагчийн удирдлагын бүтэц.....	28
Зураг 8. CU конвниенс дэлгүүрийн албан ёсны нээлт.....	38
Зураг 9. Үнэт цаас гаргагчийн амжилтын товчоон.....	39
Зураг 10. Үнэт цаас гаргагчийн амжилтын тоон үзүүлэлт.....	40
Зураг 11. CU конвниенс дэлгүүрийн онцлог, давуу талууд.....	42
Зураг 12. Үнэт цаас гаргагчийн бэлтгэдэг хоол, хүнсний бүтээгдэхүүн.....	43
Зураг 13. Үнэт цаас гаргагчийн импортын бүтээгдэхүүн болох GET Café Latte.....	43
Зураг 14. Үнэт цаас гаргагчийн CU Eats нэрийн хоолны бүтээгдэхүүнүүд.....	44
Зураг 15. Үндэсний үйлдвэрлэгчтэй хамтран хөгжүүлсэн бүтээгдэхүүнүүд.....	44
Зураг 16. Үнэт цаас гаргагчийн импортын тренд бүтээгдэхүүнүүд.....	45
Зураг 17. Үнэт цаас гаргагчийн хүргэлтийн үйлчилгээ.....	46
Зураг 18. Үнэт цаас гаргагчийн түгээлтийн төвийн байршил.....	47
Зураг 19. Хэвийн температурын горимтой бүтээгдэхүүний түгээлтийн төв (гадна талаас).....	48
Зураг 20. Хэвийн температурын горимтой бүтээгдэхүүний түгээлтийн төв.....	49
Зураг 21. Үнэт цаас гаргагчийн хоолны үйлдвэр(гадна талаас).....	49
Зураг 22. Үнэт цаас гаргагчийн хоолны үйлдвэрийн төв.....	50
Зураг 23. Үнэт цаас гаргагчийн хоол үйлдвэрлэлийн процесс.....	51
Зураг 24. Үнэт цаас гаргагчийн хоол үйлдвэрлэлийн процесс (Будааны ороомог).....	51
Зураг 25. CU аппликэйшн буюу CU app.....	53
Зураг 26. CU конвниенс дэлгүүрийн Улаанбаатар хот дахь байршил.....	54
Зураг 27. Франчайз эрх олголт.....	55
Зураг 28. Үнэт цаас гаргагчийн ажилтнууд.....	55
Зураг 29. CU конвниенс дэлгүүрийн ажилтнууд.....	57
Зураг 30. Үнэт цаас гаргагчийн БОНЗ-ын суурь үнэлгээний дүн.....	58
Зураг 31. Зүрх мартаггүй төсөл.....	58
Зураг 32. Мэс заслын хүлээлгийн танхим.....	59
Зураг 33. Сургуулиудын галын булан.....	59
Зураг 34. CU ЧАМД ТУСАЛЪЯ төсөл.....	60
Зураг 35. Монгол гэр төсөл.....	61
Зураг 36. Монгол гэрийн дулаалгын төслийн хүрээнд цахилгааны халаагуур суурилуулсан байдал.....	61
Зураг 37. Эрсдэлийн матриц.....	73
Зураг 38. Дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалт, хагас жилээр, мянган төгрөгөөр.....	75
Зураг 39. Бодит ДНБ, ДНБ-ын өсөлт, бууралт, их наяд төгрөгөөр.....	76
Зураг 40. Дэлгүүрийн тоо, борлуулалтын орлого, тэрбум төгрөгөөр.....	77
Зураг 41. 2021 оны дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалт, мянган төгрөгөөр.....	77
Зураг 42. Борлуулалтын өртөг, борлуулалтад эзлэх хувь, тэрбум төгрөгөөр.....	78
Зураг 43. Ерөнхий ба удирдлагын зардал, борлуулалтад эзлэх хувь, тэрбум төгрөгөөр.....	81
Зураг 44. Татварын дараах ашиг, алдагдал, тэрбум төгрөгөөр, дэлгүүр өдөрт ногдох ашиг, алдагдал, мянган төгрөгөөр.....	82

Зураг 45. Нийт хөрөнгө, тэрбум төгрөгөөр.....	84
Зураг 46. Хувьцаат капитал, тэрбум төгрөгөөр.....	84
Зураг 47. Эздийн өмч, тэрбум төгрөгөөр.....	85
Зураг 48. Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд.....	86
Зураг 49. Үйл ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд, хоног.....	87
Зураг 50. Бэлэн мөнгөний цикл, хоногоор.....	88
Зураг 51. Монгол Улсын нэрлэсэн ДНБ (их наяд төгрөгөөр) болон бодит ДНБ-ний өсөлт, хувиар.....	94
Зураг 52. Монгол Улсын ДНБ-ний салбарын бүтэц, хувиар.....	95
Зураг 53. Инфляцын түвшин, хувиар.....	96
Зураг 54. Төсвийн тэнцэл, тэрбум төгрөгөөр.....	97
Зураг 55. Гадаад худалдааны тэнцэл, сая ам.доллараар.....	98
Зураг 56. М2 мөнгөний нийлүүлэлт, их наяд төгрөгөөр.....	99
Зураг 57. Хүүний түвшин, хувиар.....	100
Зураг 58. Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, тэрбум төгрөгөөр болон ДНБ-д эзлэх хувь.....	101
Зураг 59. МХБ-ийн индексүүд, 2021 оны эхэн үетэй харьцуулахад.....	101
Зураг 60. Хамгийн анхны конвينيенс дэлгүүр, АНУ.....	102
Зураг 61. Худалдааны салбарын орлого, их наяд төгрөгөөр.....	105
Зураг 62. Худалдааны салбарын орлогын бүтэц, бүс нутгаар, их наяд төгрөгөөр болон хувь хэмжээгээр..	106
Зураг 63. Худалдааны салбарын борлуулалтын сувгаарх орлогын бүтэц, их наяд төгрөгөөр болон хувь хэмжээгээр.....	107
Зураг 64. Жижиглэн худалдааны салбарын бүтэц.....	108
Зураг 65. Хэрэглээний зан төлөвт өөрчлөлт орсон хэрэглэгчдийн хувь, улс орнуудаар.....	110
Зураг 66. Онооны урамшууллын системийн худалдан авалтад нөлөөлөх хувь.....	111
Зураг 67. Олон улсын конвينيенс дэлгүүрийн салбарын орлого.....	112
Зураг 68. Олон улсын конвинеенс дэлгүүрийн салбарын бизнесийн насжилт.....	113
Зураг 69. Конвينيенс дэлгүүрийн зах зээлд оролцогчид.....	113
Зураг 70. Конвينيенс дэлгүүрийн салбарын тоо.....	114
Зураг 71. Багавтар ангиллын дэлгүүрийн зах зээлийн бүтэц.....	115
Зураг 72. Бага болон багавтар ангиллын дэлгүүрийн бүтэц.....	115
Зураг 73. Монгол Улсын нийтийн хоолны салбарын орлого, тэрбум төгрөгөөр.....	116
Зураг 74. Улаанбаатар хотын нийтийн хоолны салбарын орлого, тэрбум төгрөгөөр.....	116
Зураг 75. Улаанбаатар хотын жижиглэн худалдааны зах зээлийн багтаамж, их наяд төгрөгөөр.....	119
Зураг 76. Улаанбаатар хотын нийтийн хоолны зах зээлийн багтаамж, тэрбум төгрөгөөр.....	119
Зураг 77. ДНБ-ний зарцуулалтын аргаарх задаргаа, 2010 оны зэрэгцүүлэх үнээр.....	120
Зураг 78. Улаанбаатар хотын өрхийн нийт хэрэглээ, их наяд төгрөгөөр.....	121
Зураг 79. Олон улсын нэг конвينيенс дэлгүүрт ногдох хүн амын тоо.....	123
Зураг 80. Жижиглэн худалдаанд зориулсан технологийн шийдлүүд.....	131
Зураг 81. Жижиглэн худалдаанд зориулсан хиймэл оюуны шийдлүүд.....	132
Зураг 82. Дэлгүүр өдрийн дундаж борлуулалт, мянган төгрөгөөр.....	135
Зураг 83. Дэлгүүрийн тоо, орлого, тэрбум төгрөгөөр.....	135
Зураг 84. Борлуулалтын өртөг, тэрбум төгрөгөөр.....	136
Зураг 85. Ерөнхий ба удирдлагын зардал, тэрбум төгрөгөөр.....	137
Зураг 86. Цэвэр ашиг, тэрбум төгрөгөөр.....	138
Зураг 87. Нийт хөрөнгө, тэрбум төгрөгөөр.....	140
Зураг 88. Өр төлбөр ба эздийн өмч, тэрбум төгрөгөөр.....	141
Зураг 89. Эздийн өмч, тэрбум төгрөгөөр.....	141
Зураг 90. Мөнгөн гүйлгээ, тэрбум төгрөгөөр.....	142
Зураг 91. Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө.....	160
Зураг 92. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцоход авах алхмууд.....	163



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Ам.доллар	Америкийн Нэгдсэн Улсын мөнгөн тэмдэгт
ААН	Аж ахуйн нэгж
АНЭУ	Арабын Нэгдсэн Эмират Улс
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТТ	Арилжааны Төлбөр Тооцоо ХХК
БӨӨ	Борлуулсан барааны өртөг
БДК	Брокер, дилерийн компани
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БОНЗ	Байгаль орчин, нийгэм, засаглал
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДХ	Жинлэсэн дундаж хүү
МБТХНС	Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан
МХБ	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НЖДӨ	Нийлмэл жилийн дундаж өсөлт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОУВС	Олон Улсын Валютын Сан
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СЗХ	Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хороо
Төгрөг	Монгол Улсын мөнгөн тэмдэгт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБ	Улаанбаатар хот
УБЕГ	Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ҮЦЗЗТХ	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
ҮЦТХТ	Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК
ҮЦК	Үнэт цаасны компани
ХК	Хувьцаат Компани
ХХАХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХН	Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл
ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал



**НЭГ.  
ҮНЭТ ЦААС  
ГАРГАГЧИЙН  
ТУХАЙ**





# 1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

## 1.1 Үнэт цаас гаргагчийн товч танилцуулга

Премиум Групп ХХК (Премиум Групп) нь Сэнтрал Экспресс төслийг 2015 онд эхлүүлж, Монгол Улсад конвинеенс сүлжээ дэлгүүрийн анхны шавыг тавьсан. Улмаар 2017 онд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК (Сэнтрал Экспресс) компанийг үүсгэн байгуулснаар хэрэглэгч ая тухтай орчинд, өөрийн бүхий л хэрэгцээг нэг дороос хангах боломжтой сүлжээ дэлгүүрийн бизнес загварыг Монгол Улсад анх удаа нэвтрүүлсэн.

Дэлхий нийтээр завгүй амьдралын хэв маягт шилжиж буй энэ цагт хэрэглэгчид цэвэр цэмцгэр, тав тухтай, сэтгэлд таатай орчинд цаг хугацаа, орон зайг товчилсон түргэн шуурхай үйлчилгээг нэн тэргүүнд сонгон үйлчлүүлэх болсон.


Үнэт цаас гаргагч нь олон улсын жишиг, стандарт шаардлагыг хангасан, иргэдийн өдөр тутмын амьдралын хэв маягт нийцсэн энэхүү үйлчилгээг Монгол Улсад түгээн дэлгэрүүлэх зорилтыг үйл ажиллагааныхаа тэргүүн зэрэгт тавин өдрөөс өдөрт өргөжүүлэн хөгжүүлж байна.

**Зураг 1. Сэнтрал Экспресс, БиЖиЭф Ритэйл нарын хооронд байгуулсан Мастер франчайзийн гэрээнд гарын үсэг зурах ёслол**



Үнэт цаас гаргагч нь 2018 оны 4 сарын 17-ны өдөр Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын БиЖиЭф Ритэйл Ко., ЭлТиДи (BGF Retail Co., Ltd. "БиЖиЭф Ритэйл") компанитай тус улсын CU






олон улсын конвинеенс сүлжээ дэлгүүрийг Монгол Улсын жижиглэн худалдааны салбарт нэвтрүүлэх Мастер франчайзийн гэрээг албан ёсоор амжилттай байгуулсан юм.

БНСУ-ын БиЖиЭф Ритэйл компани нь CU конвинеенс сүлжээ дэлгүүрийн Глобал мастер франчайз эрхийг эзэмшигч бөгөөд жижиглэн худалдааны салбарт 30 жил үйл ажиллагаа явуулсан арвин туршлага бүхий салбартаа тэргүүлэгч компани юм.



## АЛСЫН ХАРАА

Хэрэглэгчийн үйлчилгээгээрээ дэлхийд танигдана



## ҮНЭТ ЗҮЙЛС

Чухал зүйлд төвлөрдөг  
Хувь хүний үнэт зүйлийг бус асуудлыг шүүмжилдэг  
Зоригтой  
Нийтийн төлөө  
Нээлттэй сэтгэдэг  
Шулуун шударга  
Тууштай



### 1.2 Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл

Оноосон нэр	Сэнтрал Экспресс Си Ви Эс
Компанийн хэлбэр	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Байгуулагдсан огноо	2017 он 02 сар 20-ны өдөр
Улсын бүртгэлд бүртгэсэн огноо	2017 он 02 сар 22-ны өдөр
Улсын бүртгэлийн дугаар	9011651142
Регистрийн дугаар	6155804
Үйл ажиллагааны чиглэл	Хүнсний дэлгүүр Худалдааны зуучлал Хүнсний үйлдвэрлэл Франчайзийн гэрээний үндсэн дээр бизнесийн үйл ажиллагаа явуулах Гадаад худалдаа
Хувьцаа эзэмшигчийн тоо	9
Дүрмийн сангийн хэмжээ	67,980,767,400 төгрөг
Компанийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа	Хугацаагүй
Гүйцэтгэх захирал	Ганболд овогтой Чинзориг

### 1.3 Үнэт цаас гаргагчийн хаяг, байршил

Хаяг	Монгол Улс, Улаанбаатар хот 14241 Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Олимпийн гудамж 19А Шангри-Ла төв, 23 давхар
Цахимхуудас	<a href="http://www.cumongol.mn">www.cumongol.mn</a>
Цахим шуудан	<a href="mailto:info@cumongol.mn">info@cumongol.mn</a>
Утас	+976 7733 0101




## 1.4 Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд

### Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд хувьцаагаа санал болгохтой холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 6 сарын 08-ны өдрийн хуралдаанаар хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулсан болно.

Зураг 2. Өөрчлөлт орохоос өмнөх хувьцаа эзэмшигчдийн бүтэц




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн компанийн дүрэм

Бүтцийн өөрчлөлтийн өмнө Сэнтрал Экспресс нь Премиум Группийн 90.01 хувь, БиЖиЭф Ритэйл компанийн 9.99 хувийн эзэмшилд байсан.

Үнэт цаас гаргагчийн хувьцаагаа олон нийтэд санал болгож, санхүүжилт татан төвлөрүүлэх үйл явцтай холбогдуулан Премиум Групп нь Сэнтрал Экспрессд эзэмшиж байсан хувьцаагаа өөрийн эцсийн өмчлөгч хувь хүмүүст шилжүүлсэн. Энэ нь Сэнтрал Экспрессийн хувьцаа эзэмшигч хувь хүмүүсийн эзэмшиж буй хувийг олон нийтэд ил тод болгох, компанийн засаглалыг сайжруулах, сонирхлын зөрчилтэй аливаа үйлдлээс зайлсхийх зорилготой.

Мөн CU конвениенс сүлжээний гол үйл ажиллагаа болох дэлгүүрийн логистик буюу тээвэрлэлт түгээлт, хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхэлдэг Премиум Дистрибьюшн ХХК (Премиум Дистрибьюшн)-ийг Сэнтрал Экспрессийн 100 хувийн эзэмшилд шилжүүлсэн.






Үнэт цаасны танилцуулга

Ингэснээр CU конвинеенс сүлжээ дэлгүүрийн үйл ажиллагаанд голлох үүрэг гүйцэтгэж буй бүх хуулийн этгээдийг Үнэт цаас гаргагчийн эзэмшилд нэгтгэн, ил тод, нээлттэй компани болох бүхий л суурь нөхцөлийг хангаад байна.

Зураг 3. Өөрчлөлт орсны дараах хувьцаа эзэмшигчдийн бүтэц



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн компанийн дүрэм

### Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид

#### Хувьцаа эзэмшигч БиЖиЭф Ритэйл

2018 онд БНСУ-ын конвинеенс сүлжээ дэлгүүрийн тэргүүлэгч компани болох БиЖиЭф Ритэйл нь Сэнтрал Экспрессд Мастер франчайз эрхийг олгож, Үнэт цаас гаргагчийн 9.99 хувийн хувьцаа эзэмшигч болсон.

Тус компани нь Монгол Улсын жижиглэн худалдааны зах зээлд CU конвинеенс сүлжээ дэлгүүрийг нэвтрүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэж ирсэн билээ.

1990 онд БиЖиЭф Ритэйл компанийн толгой компани болох БиЖиЭф Ко., ЭлТиДи (BGF Co., Ltd. “БиЖиЭф Ко”) нь Япон улсын Family Mart конвинеенс дэлгүүрийг The Bogwang Family Mart Corporation нэрийн дор БНСУ-ын зах зээлд нэвтрүүлж, жижиглэн худалдааны салбарт хөл тавьсан түүхтэй. Улмаар 22 жилийн дараа буюу 2012 онд компанийн оноосон нэрийг БиЖиЭф Ритэйл, брэндийн нэрийг CU болгож өөрчилсөн байна.

БиЖиЭф Ритэйл нь БНСУ даяар CU брэндийн 15 мянга гаруй салбар дэлгүүртэй бөгөөд тус брэндийг Монгол Улсаас гадна Малайз, Вьетнам улсад амжилттай нэвтрүүлсэн. Сард дунджаар 8 тэрбум хүнд үйлчилгээ үзүүлдэг, жижиглэн худалдааны гадаад болон дотоод зах зээлд арвин туршлагатай тэргүүлэгч компани юм.



2014 онд БиЖиЭф Ритэйл нь БНСУ-ын хөрөнгийн бирж дээр үнэт цаас гаргаж нээлттэй компани болсон. Тус компанийн 30 орчим хувийг CU конвинеенс сүлжээ дэлгүүрийн үүсгэн байгуулагч БиЖиЭф Ко нь дангаар эзэмшдэг бөгөөд хамгийн том хувьцаа эзэмшигч нь юм. Үлдсэн 70 гаруй хувийг Канад, БНСУ-ын хөрөнгө оруулалтын сангууд болон хувь хүмүүс эзэмшдэг байна.

Зураг 4. CU конвинеенс сүлжээ дэлгүүрийн тархац



**Хувьцаа эзэмшигч хувь хүмүүс**

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд 8 хувь хүн байдаг бөгөөд хувь эзэмшлийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч хувь хүмүүсийн мэдээлэл

Хувьцаа эзэмшигчдийн нэр	Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо	Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ (төгрөг)	Эзэмшиж буй энгийн хувьцааны нийт үнэ (төгрөг)	Эзэмшиж буй хэмжээ
А.Ганхуяг	235,408,889	100	23,540,888,900	34.64%
А.Ганболд	172,327,784	100	17,232,778,400	25.35%
Ц.Баяржаргал	88,164,258	100	8,816,425,800	12.97%
А.Одончимэг	32,304,463	100	3,230,446,300	4.75%
А.Ганбаатар	31,248,463	100	3,124,846,300	4.60%
О.Батмөнх	19,731,751	100	1,973,175,100	2.90%
Г.Бат-Эрдэнэ	19,731,751	100	1,973,175,100	2.90%
Ө.Мөнхбаяр	12,909,548	100	1,290,954,800	1.90%
<b>Нийт</b>	<b>611,826,907</b>	<b>100</b>	<b>61,182,690,700</b>	<b>90.01%</b>

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн компанийн дүрэм







Үнэт цаасны танилцуулга



### Үүсгэн байгуулагч Премиум Групп

Премиум Групп нь менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 2011 онд үүсгэн байгуулагдсан инженеринг, барилгын дэд бүтэц болон жижиглэн худалдааны салбарт бизнесийн үйл ажиллагаа эрхлэн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулсаар ирсэн.

Тус компани нь 2017 онд Сэнтрал Экспрессийг үүсгэн байгуулж, Монголын анхны конвинеенс сүлжээ дэлгүүрийн салбарыг ажиллуулснаар жижиглэн худалдааны салбарт өөрийн түүхийг эхлүүлсэн. 2018 онд БиЖиЭф Ритэйл компанийн эзэмшдэг CU конвинеенс сүлжээ дэлгүүрийн мастер франчайзийн эрхийг авсан бөгөөд Сэнтрал Экспрессийн үйл ажиллагааг өнөөгийн түвшинд хүргэхэд удирдлагын арга барилаар хангаж, стандарт, компанийн соёлыг төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан.



Премиум Групп нь улс орны хөгжил дэвшил, улсын нэгдсэн төсвийн бүрдүүлэлтэд өөрийн хувь нэмрээ оруулах, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх зорилтын хүрээнд хөрөнгө оруулалт, татвар хураамж, тогтвортой ажлын байр шинээр бий болгох зэрэг үүргээ амжилттай биелүүлж буй томоохон групп компани болсон билээ.

Премиум Групп нь Монгол Улсын барилга, дэд бүтэц болон жижиглэнгийн салбарт тэргүүлэгч аж ахуйн нэгжийн хувьд бизнесийн бүхий л үйл ажиллагаандаа орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан бизнесийн шийдлүүд, өндөр стандарт, чанартай гүйцэтгэлийг нутагшуулан, оролцогч талуудын үнэ цэнийг бий болгохыг эрхэмлэн ажилладаг.

2020 онд Премиум Групп нь өдөрт 87 сая, сард 2.6 орчим тэрбум төгрөгийн татвар, шимтгэлийг улсын төсөвт төвлөрүүлэн, 1,621 ажилтанд сард 2.2 тэрбум төгрөгийн цалин олгож нийгмийн хариуцлагаа амжилттай биелүүлж байна.

Мөн дотоодын 2,974 орчим бизнес эрхлэгчээс сар бүр 22.3 гаруй тэрбум төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авч, шууд бусаар 10,954 хүнийг тогтмол ажлын байртай болгосноор сард доод хязгаар нь 5.2 орчим тэрбум төгрөгийн цалин тавих боломжийг олгож улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмрээ оруулж байна.





Зураг 5. Премиум Группийн амжилтын товчоон

2016 он

2016 оны Шилдэг татвар төлөгч, Премиум Индастриал энд Инженеринг

2017 он

2017 оны Top 100 Аж ахуйн нэгж, Премиум Индастриал энд Инженеринг

2018 он

2018 оны Top 100 Аж ахуйн нэгж, Премиум Индастриал энд Инженеринг

2019 он

2019 оны Шилдэг НӨАТ төлөгч, Сэнтрал Экспресс

2019 оны Top 100 Аж ахуйн нэгж, Сэнтрал Экспресс

Оюу Толгойн аюулгүй ажиллагааны 2019 оны шилдэг гүйцэтгэлтэй компани, Премиум Индастриал энд Инженеринг

2020 он

Оюу Толгойн гүний уурхайн 2020 оны шилдгийн шилдэг гэрээт байгууллага, Премиум Индастриал энд Инженеринг

Рио Тинто группийн 2020 оны шилдэг гэрээт компани, Премиум Индастриал энд Инженеринг

### Премиум Индастриал энд Инженеринг

Тус компани нь 2011 онд үүсгэн байгуулагдсан Монголын анхны Америкийн Бетоны Институт (ACI)-ийн гишүүн компани бөгөөд Рио Тинто компанийн удирдаж буй Оюу Толгой төсөлд туслан гүйцэтгэгчээр ажиллаж бетон зуурмаг ханган нийлүүлж байна. Премиум Индастриал энд Инженеринг нь Чанарын удирдлагын ISO 9001:2015 тогтолцоо, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын чанарын удирдлагын ISO 45001:2018 тогтолцоог үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн.

### Премиум Бьюлдинг Материалс ХХК

Премиум Бьюлдинг Материалс ХХК нь 2018 онд үүсгэн байгуулагдсан дотоодын болон олон улсын төсөл хөтөлбөрийн бетон зуурмагийг ханган нийлүүлэгч юм. Тус компани Чанарын



удирдлагын ISO 9001:2015 тогтолцоо, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын чанарын удирдлагын ISO 45001:2018 тогтолцоог нэвтрүүлсэн. АНУ-д төвтэй Үндэсний Бетон Зуурмагийн Ассоциациас олгодог Олон улсад бетон зуурмагийн үйлдвэрлэл үйлчилгээ явуулах эрхийн гэрчилгээтэй.

### Юу Эм Эс ХХК

Юу Эм Эс ХХК нь барилгын материалын физик, химийн шинжилгээ, судалгаа, барилгын материалын матрицад химийн хольцыг хэрэглэх технологи, тэдгээрийн тун, тээвэрлэлт, төрөл бүрийн хэлбэрийн химийн хольцыг ялгах технологитой холбоотой техникийн үйлчилгээ зэрэг чанарын удирдлагын тогтолцооны MNS ISO/IEC 17025:2007 итгэмжлэгдсэн лабораторийн үйлчилгээ үзүүлдэг компани юм.



### Үнэт цаас гаргагчийн охин компани


Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 заалтын дагуу компанийн нийт гаргасан хувьцааны 50-аас дээш хувийг өөр (толгой) компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг бие даасан компанийг охин компани гэх бөгөөд Үнэт цаас гаргагч нь Премиум Дистрибьюшн ХХК (РД: 6169287) гэсэн нэг охин компанитай байна.

### Үнэт цаас гаргагчийн хамаарал бүхий болон нэгдмэл сонирхолтой этгээд

Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30-т зааснаар Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг компани буюу Үнэт цаас гаргагчийн хамаарал бүхий болон нэгдмэл сонирхолтой этгээд дараах байдалтай байна.

Компанийн нэр	Регистрийн дугаар	Хувьцаа эзэмшигчийн нэр, компани дах шууд болон шууд бус эзэмшлийн хувь	
		А.Ганхуяг	А.Ганболд
Премиум Групп ХХК	5476992	37.8	28.78
Премиум Индастриал энд Инженеринг ХХК	5528534	37.8	28.78
Премиум Бьюлдинг Материалс ХХК	6266258	19.3	14.68
Премиум Эквити ХХК	6565263	22.7	17.26
Премиум Ойл энд Энержи ХХК	6552544	12.13	9.23
Премиум Прожектс ХХК	5401135	37.8	28.78
Премиум Майнинг энд Сервисэс ХХК	6625223	32.1	24.46
Юу Эм Эс ХХК	5166829	37.8	28.78
Сэлэнгэ Агро ХХК	3764176	37.8	28.78
Сабвэй Монгол ХХК	6510736	32.1	24.46





Сэрмүүн Хүнс ХХК	4201272	37.8	28.78
Аркадиа Гарден ХХК	6429289	37.8	28.78
Блүфин Катеринг ХХК	3644367	18.9	14.39
Саут Гоби Рок ХХК	3637921	18.9	14.39
Сүлд Итгэл Соёмбо ХХК	5508835	29.5	27.7
Эддмикс Кемикал ХХК	5800501	39	38
Финланд Лайф Хаус ХХК	6576869	37.8	28.78

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч Б.Батмөнх нь Премиум Майнинг энд Сервисэс ХХК-ийн 17.7 хувийг, Блүфин Катеринг ХХК-ийн 16.6 хувийг, Оч-Альянс ХХК (РД: 5124204)-ийн 50 хувийг, хувьцаа эзэмшигч Г.Бат-Эрдэнэ нь Глобал Ресурс ХХК (РД:5980259)-ийн 100 хувийг тус бүр шууд болон шууд бусаар эзэмшдэг байна.

## 1.5 Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт

Үнэт цаас гаргагч нь компанийн засаглалын стандартыг баримталж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийн төлөө хүчин чармайлт гарган ажилладаг бөгөөд сайн засаглал нь бизнесийн стратегийг хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг хэмээн үздэг.

Үнэт цаас гаргагч нь компанийн засаглалын тулгуур дөрвөн зарчим болох хариуцлагатай, ил тод, шударга байдал, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэсэн, сайн засаглалын туршлагад тулгуурласан засаглалын бүтцийг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөөд байна.


Тус төлөвлөгөөний дагуу Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болсны дараа (i) хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, (ii) санхүү, хөрөнгө оруулалтын асуудлуудыг цаг тухайд нь үнэн зөв мэдээлэх, (iii) хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлыг хамгаалах, (iv) бизнесийн ёс зүй, шударга байдлыг хангахад чиглэсэн тогтолцоог бүрдүүлнэ.

Энэ нь Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журамд нийцсэн, Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлох, дотоод хяналт, эрсдэлийг зөв зохистой удирдах, гүйцэтгэх удирдлагыг удирдан чиглүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн засаглалын бүтэц юм.





Зураг 6: Үнэт цаас гаргагчийн төлөвлөж буй засаглалын бүтэц



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн хувьцаат компанийн дүрмийн төсөл

## Засаглалын бүтэц


### Үнэт цаас гаргагчийн хөндлөнгийн аудиторрууд

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК: 2018-2020 оны жилийн эцсийн тайланд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн.

БДО Аудит ХХК: 2021 оны 6 сарын 30-ны өдрөөр Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 34-ийн дагуу санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар нягтлах ажлыг хийж гүйцэтгэсэн.

### Үнэт цаас гаргагчийн оролцогч талууд

Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдог хөрөнгө оруулагчид, төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, шинжээчид, мэргэжлийн байгууллага, хэрэглэгч, нийлүүлэгч, бизнесийн түншүүд болон Үнэт цаас гаргагчийн нийт ажиллагсад багтдаг.



### Төлөөлөн Удирдах Зөвлөл

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) нь хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудад урт хугацааны үнэ цэнийг бий болгох зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцүүлсэн үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлох, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн, гүйцэтгэх удирдлагыг удирдан чиглүүлж, хяналт тавин ажилладаг.

### ТУЗ-ийн дарга А.Ганхуяг



**А.Ганхуяг** нь Премиум Группийн үүсгэн байгуулагч, Премиум Групп болон Сэнтрал Экспрессийн ТУЗ-ийн дарга бөгөөд сүүлийн 20 гаруй жил Монголын нэр нөлөө бүхий томоохон компаниуд болох М-Си-Эс Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгч, М-Си-Эс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, М-Си-Эс Кока-Кола ХХК болон Юнител ХХК-ийн ТУЗ-ийн дарга, Монголиан Майнинг Корпорацийн (НКЕХ: 975)-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү эрхэлсэн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж ирсэн туршлагатай. Тэрээр эдгээр компаниудын үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх, таниулахад үнэтэй хувь нэмэр оруулж, эрчим хүч, уул уурхай, хөнгөн үйлдвэр, дэд бүтэц, барилга, худалдааны салбарт томоохон хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт татах зэрэг ажлыг амжилттай удирдан зохион байгуулсан. А.Ганхуяг нь Монгол Улсын Их Сургуулийг Санхүү, эдийн засгийн бакалаврын зэрэгтэй төгссөн.

### ТУЗ-ийн гишүүн А.Ганболд



**А.Ганболд** нь Сэнтрал Экспрессийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Группийн үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, Премиум Группийн охин, хараат компаниудын үйл ажиллагааг удирдан, стратегийн чиглэл, зорилтыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж ирсэн. Монгол Улсын авто зам барилга, хотын дэд бүтцийн компани болох Нэйшнл Девелопер ХХК-ийн Гүйцэтгэх захирал, тансаг зэрэглэлийн тавилга үйлдвэрлэгч Ганброс ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд Ерөнхий захирлаар ажиллаж байсан. Түүний барилгын салбарын хөгжилд оруулж буй хувь нэмрийг төр засгаас өндрөөр үнэлж Алтан гадас одонгоор шагнасан юм. Тэрээр Оросын Холбооны Улсын Харьков хотын Барилгын дээд сургуулийг цахилгаан тээврийн инженер, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийг Цахилгаан системийн инженерийн бакалаврын зэрэгтэйгээр тус тус төгссөн.





**Г.Бат-Эрдэнэ** нь Сэнтрал Экспрессийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Группийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү хариуцсан дэд ерөнхийлөгч бөгөөд тус группийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийн удирдлагын тогтолцоог хариуцан ажилладаг. Тэрээр анхны ажлын гараагаа үйлдвэрлэл, худалдааны салбарт тэргүүлэгч М-Си-Эс Кока Кола ХХК-д санхүү төлөвлөлтийн газрын даргаар эхлүүлж байв. Сүүлийн 18 жилийн хугацаанд өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, уул уурхай, эрчим хүч, аж үйлдвэрлэл, барилгын салбарт ажиллаж, Монголиан Майнинг Корпораци (НКЕХ: 975) болон Премиум Группийн санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан бөгөөд М-Си-Эс Энержи ХХК-ийн дэд захирал, Монголиан Майнинг Корпорацийн Санхүү хариуцсан Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан туршлагатай. Г.Бат-Эрдэнэ нь Хан-Уул Дээд Сургуулийг бизнесийн удирдлага, хэрэглээний математикч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.

**ТУЗ-ийн гишүүн О.Батмөнх**



**О.Батмөнх** нь Сэнтрал Экспрессийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Группийн ТУЗ-ийн гишүүн, Дэд ерөнхийлөгч, Премиум Индастриал Инженеринг ХХК-ийн Гүйцэтгэх захирал бөгөөд тус группийн уул уурхай, барилга, бетон зуурмагийн бизнесийг хариуцан ажилладаг. Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал (NUBIA), Шангри-Ла зочид буудал цогцолбор төсөл, Салхит (50 МВт), Сайншанд (55 МВт), Цогтцэций (50 МВт) зэрэг салхин цахилгаан станцын төслүүд, Оюу толгой Бетон зуурмагийн 4 дүгээр үйлдвэрийн цогцолбор болон бутлуурын үйлдвэрүүдийн зураг төсөл, барилга, үйл ажиллагааг хариуцах зэргээр томоохон төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн, бизнесийн удирдлагын чиглэлээр ажилласан 15 жилийн туршлагатай. Тэрээр АНУ-ын Үндэсний Их Сургуулийг Компьютерын шинжлэх ухааны бакалавр, Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр төгссөн.





ТУЗ-ийн гишүүн Г.Чинзориг

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

Үнэт цаасны танилцуулга

2021-09-17

БҮРТГЭВ-02



Г.Чинзориг нь Сэнтрал Экпресс Си Ви Эс ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал юм. Тэрээр программ хангамж, бизнес процесс, бизнес интелиженс, мэдээллийн технологийн мастер төлөвлөлт, инженерчлэлийн чиглэлээр ажилласан туршлагатай бөгөөд Мэдээллийн Технологи, Шуудан, Харилцаа Холбооны Газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагт Эдийн засгийн бодлогын шинэчлэл ба өрсөлдөх чадварын төслийн мэдээллийн технологийн зөвлөх, Азийн Хөгжлийн Банкны Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх төсөл, Хөрөнгийн зах зээлийн мэдээллийн систем ба санхүүгийн дэд бүтцийн зөвлөхөөр тус тус ажиллаж байсан туршлагатай. Тэрээр МТШХГ-д ажиллаж байхдаа Цахим засаглал хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, Монгол Улсын Харилцаа холбоо, интернэт, шуудан, хэвлэл мэдээлэл, хиймэл дагуулын холбооны талаар баримтлах төрийн бодлого болон Мобайл сүлжээний 4G үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх зохицуулалтын бодлогыг боловсруулсан. Г.Чинзориг нь ШУТИС-ийг компьютерын шинжлэх ухааны бакалавр, АНУ-ын Луисвиллийн Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэйгээр төгссөн.

### Үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт

Үнэт цаас гаргагчийн бүтэц зохион байгуулалтын хувьд Гүйцэтгэх захирлын шууд удирдлага доор Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн алба, Маркетинг сурталчилгааны алба, Дэлгүүр хөгжүүлэлтийн алба, Захиргаа хүний нөөцийн алба, Стратеги төлөвлөлтийн албууд үйл ажиллагаа явуулдаг.


Үйл ажиллагаа хариуцсан захирлын удирдлагад Ханган нийлүүлэлт, худалдан авалтын алба, Борлуулалт үйлчилгээний албууд хамаардаг.

Санхүү хариуцсан захирлын удирдлагад Санхүү, бүртгэл хяналтын алба, Санхүү, төлөвлөлт менежментийн алба, Гомдол санал эрсдэлийн алба багтдаг.

Мэдээлэл технологи хариуцсан захирлын шууд удирдлагад Мэдээлэл, технологийн алба, Дижитал бизнес хөгжүүлэлтийн албууд үйл ажиллагаа явуулдаг.








Үнэт цаасны танилцуулга



Зураг 7. Үнэт цаас гаргагчийн удирдлагын бүтэц



Эх сурвалж: Үнэт цаас гаргагч

### Гүйцэтгэх удирдлага

Үнэт цаас гаргагчийн бизнесийн өдөр тутмын үйл ажиллагааг Гүйцэтгэх захирлаар удирдуулсан баг ТУЗ-өөс олгосон эрх мэдлийн хүрээнд удирдан зохион байгуулдаг.

### Гүйцэтгэх захирал Г.Чинзориг



#### Боловсрол

АНУ-ын Луисвиллын Их Сургууль (University of Louisville)  
Бизнесийн удирдлагын магистр

#### Туршлага

Мэдээллийн Технологи, Шуудан, Харилцаа Холбооны Газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, Азийн Хөгжлийн Банкны төслүүдэд санхүүгийн зах зээлийн мэдээллийн системийн мастер төлөвлөлт, инженерчлэлийн чиглэлээр 15 жил ажилласан туршлагатай.



## Үйл ажиллагаа хариуцсан захирал Б.Цэвэлмаа **БҮРТГЭВ-02**



### Боловсрол

ШУТИС, Үйлдвэрлэлийн Автоматжуулалтын инженер

### Туршлага

Монголын Монголиан Майнинг Корпораци (НКЕХ: 975)-д Уул Уурхайн Корпорацад Логистикийн менежерээр ажлын гараагаа эхлүүлж, Монос Фарм Трейд ХХК-ийн Ханган Нийлүүлэлтийн төслийн ахлах менежер, Премиум Групп-д Логистикийн менежерээр ажилласан ханган нийлүүлэлт, үйл ажиллагааны чиглэлээр 14 жил ажилласан туршлагатай.

## Санхүү хариуцсан захирал С.Дашдорж, CFA



### Боловсрол

МУИС, СЭЗДС

Эдийн засгийн онолын магистр

### Туршлага

СЭЗИС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхимд тасралтгүй 8 жил ажилласан, ахлах багш зэрэгтэй. Мөн, олон улсын шинэ нисэх буудлын Концессын гэрээг боловсруулах, хэрэгжүүлэхэд Санхүүгийн зөвлөхөөр ажиллаж байсан. 2019 онд Премиум Групп-д Хөрөнгө оруулалтын менежерээр ажиллаж эхэлсэн бөгөөд академик, практик хослуулсан 10 жилийн ажлын туршлагатай.

## Мэдээллийн технологи хариуцсан захирал Т.Билгүүн



### Боловсрол

Нью-Йорк Их Сургууль,

Өгөгдлийн шинжлэх ухааны магистр


### Туршлага

Мобиком Корпорацид софтвэйр архитект, Япон улсын Никкэй телеком 21 компанид ситемийн инженер, Рио Тинто Монголд өгөгдлийн шинжээчээр тус тус ажиллаж байсан ба давхар технологийн стартап компаниудыг үүсгэн байгуулж, амжилттайгаар удирдаж байна. Салбартаа нийт 12 жил ажилласан туршлагатай.





Үнэт цаасны танилцуулга



Захиргаа, хүний нөөцийн албаны захирал **Г.Сарангэрэл**



**Боловсрол**

Удирдлагын академи,  
Бизнесийн удирдлагын диплом

**Туршлага**

Мобиком Корпорацийн Монгол Контент ХХК-д Хүний нөөцийн хэлтсийн дарга, 7 жил Таван Богд Фүүдс компанийн Хүний нөөцийн хэлтсийн дарга, Гоёо ХХК-ийн Дотоодын борлуулалтын захирлаар 1 жил ажилласан.

Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн албаны захирал **Ч.Сараа**



**Боловсрол**

Австралийн Сиднейн Их Сургууль,  
Худалдааны магистр

**Туршлага**

Эрин Системс ХХК, Зам Тээврийн Хөгжлийн Яам, Иргэний Нисэхийн Ерөнхий Газар, Хүмүүнлэгийн Их Сургууль зэрэг боловсрол, нисэх, технологи, жижиглэн худалдааны салбарт төр хувийн хэвшилд нийт 12 жил ажилласан туршлагатай.

Бүтээгдэхүүн соурсингийн албаны захирал **Д.Нямсүрэн**




**Боловсрол**

Сингапурын Стаффордширын Их Сургууль,  
Бизнесийн удирдлага

**Туршлага**

Таван Богд групп, Нарантуул зочид буудал, Нано Интернэшнл зэрэг компаниудад худалдааны чиглэлээр 18 жил ажилласан туршлагатай. Тэрээр дэлхийн зах зээлд танигдсан 40 гаруй брэнд бүтээгдэхүүнийг Монголын зах зээлд импортоор оруулж иржээ.





Маркетинг сурталчилгааны албаны захирал



**Боловсрол**  
СЭЗИС,  
Бизнесийн удирдлага

**Туршлага**  
Мобиком Корпораци, Хаан банк, Лэндмн ББСБ-д маркетингийн чиглэлээр 9 жил ажилласан туршлагатай ба санхүүгийн технологи дээр суурилсан Лэнд хэтэвч үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх маркетингийн үйл ажиллагааг амжилттай удирдаж ажилласан.

1.6 Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан

Компанийн тухай хуулийн 84.1 дэх заалтад “Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, Гүйцэтгэх захирал, Санхүүгийн албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч, Ерөнхий мэргэжилтэн, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.” гэж заасны дагуу үнэт цаас гаргагч нь дараах эрх бүхий албан тушаалтнуудын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 2. Эрх бүхий албан тушаалын ажлын байрны мэдээлэл

Овог, нэр	Албан тушаал
Ганболдын Чинзориг	Гүйцэтгэх захирал
Батмөнхийн Цэвэлмаа	Үйл ажиллагаа хариуцсан захирал
Соронзоннайгалын Дашдорж	Санхүү хариуцсан захирал
Шагдарсүрэнгийн Одончимэг	Ерөнхий нягтлан бодогч
Тогоогийн Гантулга	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн компанийн дүрэм





## 1.7 Үнэт цаас гаргагчийн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл

### Их хэмжээний хэлцлийн тухай


Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалтад “хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын (санхүүгийн байдлын тайлангийн) активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй)” болон 87 дугаар зүйлийн 87.1.2 дахь заалтад “компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт”-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна.

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтад “хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын (санхүүгийн байдлын) активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй)” болон 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтад “компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт”-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна.

Үнэт цаас гаргагчийн хэлцэл хийхийн өмнөх санхүүгийн байдлын тайлан болон Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн гэрээ, хэлцэл, мэдээлэлд үндэслэхэд Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд буюу 2018 оны 5 сарын 01-ний өдрөөс 2021 оны 5 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд 3 (гурван) их хэмжээний хэлцэл байгуулагдсан байна. Үүнд:

- (i) Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2019 оны 3 сарын 06-ны өдрийн №12 тоот тогтоолын дагуу Голомт Банк ХХК-тай





зээлийн багц бүтээгдэхүүний гэрээг 2019 оны 3 сарын 04-ны өдөр байгуулсан (тус гэрээ 2021 оны 6 сарын 25-ны өдөр дуусгавар болсон);

- (ii) Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2020 оны 9 сарын 07-ны өдрийн №01 тоот тогтоолын дагуу БиЖиЭф Ритэйл-тэй 7 жилийн хугацаатай, 5,000,000,000 (таван тэрбум) БНСУ-ын вонтой тэнцэхүйц ам.долларын үнийн дүн бүхий зээлийн гэрээг 2020 оны 9 сарын 15-ны өдөр байгуулсан;
- (iii) Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2021 оны 6 сарын 08-ны өдрийн №4 тоот тогтоолын дагуу нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 437,519,607 (дөрвөн зуун гучин долоон сая таван зуун арван есөн мянга зургаан зуун долоон) ширхэг хувьцааг нэмж гаргах хэлцлийг байгуулсан.

Үүнээс дүгнэж үзэхэд Үнэт цаас гаргагчийн их хэмжээний 3 (гурван) хэлцэл нь Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлд заасны дагуу Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор зөвшөөрөл олгогдсон, хууль тогтоомжийн дагуу хийгдсэн байна.

### Сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай

Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт “Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай Компанийн тухай хуульд тодорхойлсон харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно” гэж заасан байна.

Компанийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.3 дахь хэсэгт заасны дагуу компани нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэлийг тухай бүр хөтлөх үүрэгтэй бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь компанийн ТУЗ-д өөрийн хувийн байдлын талаар мэдээлэл өгөх хуулиар ногдуулсан үүрэгтэй.

Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн хугацаанд буюу 2018 оны 5 сарын 01-ний өдрөөс 2021 оны 5 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд байгуулсан гэрээ, хэлцлийн жагсаалтыг авч үзэхэд




гэрээ, хэлцэл байгуулснаас тасалбар болгосон өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч нь дараах 5 сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийг ТУЗ-өөс зөвшөөрөл авсны үндсэн дээр байгуулсан байна. Үүнд:

- (iv) Үнэт цаас гаргагчийн 2019 оны 6 сарын 20-ны өдрийн №А3 тоот сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тогтоолын дагуу Нэтизен ХХК-тай №CVS-2019-364 тоот ажил гүйцэтгэх гэрээг 2019 оны 6 сарын 20-ны өдөр 3 жилийн хугацаатай байгуулсан;
- (v) Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2019 оны 12 сарын 27-ны өдрийн №А5 тоот сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тогтоолын дагуу Премиум Дистрибьюшн ХХК-тай №CVS2019-514 тоот Түгээлтийн үйлчилгээ үзүүлэх гэрээг 2019 оны 12 сарын 24-ний өдөр 3 жилийн хугацаатай байгуулсан;
- (vi) Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2020 оны 7 сарын 31-ний өдрийн №А1 тоот сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай тогтоолын дагуу Рио Гранде ХХК-тай №CVS-2020-297 тоот Худалдан авах гэрээг 2020 оны 7 сарын 31-ний өдөр 3 жилийн хугацаатай байгуулсан;
- (vii) Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2020 оны 9 сарын 21-ний өдрийн №А3 тоот сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай тогтоолын дагуу Рио Гранде ХХК-тай №2020-406 тоот хамтран ажиллах гэрээг 2020 оны 9 сарын 21-ний өдөр 3 жилийн хугацаатай байгуулсан;
- (viii) Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2020 оны 9 сарын 18-ны өдрийн №А2 тоот тогтоолын дагуу Рио Гранде ХХК-тай №1-2020-530 тоот Түрээсийн гэрээг 2020 оны 9 сарын 18-ны өдөр 3 жилийн хугацаатай байгуулсан.

Хэлцэл хийх тухай зөвшөөрөл олгосон ТУЗ-ийн тогтоолд ТУЗ-ийн сонирхлын зөрчилгүй гишүүдийн гарын үсэг зурагдсан, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлаар аливаа эсрэг санал тэмдэглэгдээгүй байх тул ТУЗ нь сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай зөвшөөрлийг хуульд заасан журмын дагуу хэлцэл хийх тухай бүрд олгосны үндсэн дээр байгуулсан байна.

Үүнээс дүгнэж үзэхэд Үнэт цаас гаргагчаас нэгдмэл сонирхолтой этгээдтэй байгуулсан сонирхлын зөрчилтэй 5 хэлцэл нь Компанийн тухай хуульд заасан журмын дагуу ТУЗ-өөс зөвшөөрөл олгосны үндсэн дээр байгуулагдсан байна.



**Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцлийн тухай**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5.7 дахь хэсэг, Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 4.3.7 дахь хэсэгт заасны дагуу 2018 оны 5 сарын 01-ний өдрөөс 2021 оны 5 сарын 01-ний өдрийг хүртэл Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл 11, Премиум Дистрибьюшнгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл 29 байна. Тус хэлцлүүд Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн хүчин төгөлдөр гэрээ байна.

Дээрх хэсэгт дурдсан их хэмжээний, сонирхлын зөрчилтэй, хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцлүүдийн дэлгэрэнгүйг Хавсралтад тусгагдсан хуулийн дүгнэлтээс үзнэ үү.







**ХОЁР.  
ҮНЭТ ЦААС  
ГАРГАГЧИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ**



## 2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

### 2.1 Товч танилцуулга


Үнэт цаас гаргагчийн өмнөх хувьцаа эзэмшигч болох Премиум Групп нь Монголын хамгийн анхны конвiniенс дэлгүүр Сэнтрал Экспрессийг 2017 онд үүсгэн байгуулсан бөгөөд Улаанбаатар хотод 3 салбар дэлгүүртэйгээр үйл ажиллагаа явуулж, Монгол Улсын жижиглэн худалдааны салбарт сүлжээ дэлгүүрийн бизнесийн эхлэлийг тавьсан түүхтэй.

Премиум Групп нь олон улсын конвiniенс сүлжээ дэлгүүрийн бизнесийн шилдэг туршлагыг Монгол Улсад нутагшуулах зорилгоор БНСУ-ын БиЖиЭф Ритэйл компанитай CU конвiniенс сүлжээ дэлгүүрийн Мастер франчайзийн гэрээг амжилттай байгуулан 2018 оны 8 сарын 23-ны өдөр Улаанбаатар хотод 6 дэлгүүрийг зэрэг нээж үйл ажиллагааг нь эхлүүлсэн билээ.

Үнэт цаас гаргагч нь CU конвiniенс сүлжээ дэлгүүрийн бүтээгдэхүүн үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлснээр уламжлалт найман нэрийн хүнсний дэлгүүрийн үйлчилгээг шинэ түвшинд гаргаж, хэрэглэгчид олон улсын стандартад нийцсэн цэвэр цэмцгэр, тохилог орчинд өөрт хэрэгцээт бүтээгдэхүүнийг сонгон үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлээд байна. Энэ нь Монгол Улсын жижиглэн худалдааны салбарын хөгжлийг урагшлуулсан алхам болсон юм.

Зураг 8. CU конвiniенс дэлгүүрийн албан ёсны нээлт





Зураг 9. Үнэт цаас гаргагчийн амжилтын товчоон

2015 он

Сэнтрал Экспресс нэртэй Монголын хамгийн анхны конвинеенс сүлжээ дэлгүүрийн суурийг тавив.

2017 он

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нэртэй компани үүсгэн байгуулагдав.

2018 он

БНСУ-ийн BGF Retail компанийн мастер франчайз эрхийг Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК хүлээн авав.

Монгол улсын "Анхны ая тухтай" дэлгүүр MNS гэрчилгээ авав.

2019 он

12 сар Үнэнч хэрэглэгчийн гишүүнчлэлийн хөтөлбөр "CU аппликейшн"-ийг нэвтрүүлэв.

2020 он

3 сар 4200 м2 энгийн температурын горимтой Түгээлтийн төвийг ашиглалтад оруулав.

4 сар Петровисийн ШТС-үүдэд салбар дэлгүүрүүд нээв.

5 сар Монголын ТОП-100 аж ахуйн нэгжийн нэгээр шалгарав.

5 сар Монголын хамгийн хурдан 30 минутын дотор хүргүүлэх "CU Хүргэлтийн үйлчилгээ" -г нэвтрүүлэв

7 сар CU салбар дэлгүүрийг франчайзийн эрхээр жижиг дунд бизнес эрхлэгчдэд эзэмшүүлж эхлэв

11 сар Монголын хамгийн анхны 100 салбар дэлгүүртэй сүлжээ болов.

11 сар Монголын хамгийн анхны хүнсний аюулгүй байдлын олон улсын GMP, HACCP стандартыг хангасан Хоолны үйлдвэрийг байгуулж, ашиглалтад оруулав.

2021 он

5 сар CU брэнд НҮБ-ын хүүхдийн сантай хамтран "Байгальд ээлтэй Монгол гэр" төслийг хэрэгжүүлж эхлэв.

6 сар ЦЕГ-ын Хүүхэд хамгааллын хэлтэстэй хамтран "CU ЧАМД ТУСАЛТЯ" төслийг хэрэгжүүлж эхлэв.





Зураг 10. Үнэт цаас гаргагчийн амжилтын тоон үзүүлэлт<sup>1</sup>



Эх сурвалж: Үнэт цаас гаргагч

## 2.2 Үйл ажиллагааны онцлог, давуу тал

CU конвениенс дэлгүүр нь хэрэглэгчийн өдөр тутмын амьдралд эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгийн ойр байрлах ая тухтай орчинд 24 цагийн турш санал болгох худалдаа, үйлчилгээний цогц шийдэл юм.

Конвениенс дэлгүүрийн сүлжээ нь уламжлалт хүнсний дэлгүүр, жижиглэн худалдааны мухлагтай харьцуулахад олон тооны дэлгүүртэй. Тиймээс өөрийн болон бэлтгэн нийлүүлэгчидтэй хамтарсан өргөн сонголт, ялгарал бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг тасралтгүй хөгжүүлэх боломжтойгоороо онцлогтой юм. Жишээлбэл, CU конвениенс сүлжээ дэлгүүр нь үйлчлүүлэгч шууд хэрэглэх боломжтой 10 нэрийн 80 орчим төрлийн халуун ба хөргүүрийн шинэ, эрүүл ахуйн шаардлагыг хангасан хоолоор үйлчилж байна. Мөн зөвхөн CU сүлжээ дэлгүүрээр борлуулдаг нэрийн ба онцгой эрхтэй дотоод, гадаадын бүтээгдэхүүнийг

<sup>1</sup> Хэрэглэгчийн тоог сараар илэрхийлсэн болно.



Үнэт цаасны танилцуулга

2021-09-17

байршуулсан нь хэрэглэгчид зөвхөн CU дэлгүүрийг сонгон үйлчлүүлэх нэг шалтгаан болдог.

Олон тооны дэлгүүрт (одоогийн байдлаар 127 дэлгүүр) өдөр бүр шинэ бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэхийн тулд найдвартай хоол үйлдвэрлэл, тасалдалгүй, зардал багатай логистикийн шийдэл чухал юм. Уламжлалт хүнсний дэлгүүрийн бэлтгэн нийлүүлэгч нь өөрийн барааг хүргэж өгөх, хүнсний дэлгүүрийн эзэн, ажилтан нь бараа, бүтээгдэхүүнээ цуглуулах зэрэг бэрхшээл үүсдэг бол CU конвинеенс дэлгүүрийн хувьд түгээлтийн оновчтой шийдлийг нэвтрүүлсэн нэгдсэн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлдэг.

Мөн дэлгүүр бүрийн захиалга, ханган нийлүүлэлт, борлуулалт зэргийг хэмжих, удирдах, сүлжээ дэлгүүрээр хэрэглэгчийг урамшуулахын тулд үйл ажиллагаа, санхүү, хүний нөөцийн цогц шийдэл бүхий мэдээллийн технологийн хөгжүүлэлтийг тасралтгүй гүйцэтгэх шаардлагатай юм.

Тиймээс ч CU конвинеенс дэлгүүр нь олон улсын практикт хэдийн өргөн ашиглагддаг Microsoft NAV, Power BI зэрэг жижиглэн худалдаа, логистикийн цогц системүүдийг нэвтрүүлсэн нь дэлхийн хөгжилтэй эн зэрэгцсэн шинэ үйлчилгээ, шийдлүүдийг хамгийн шуурхайгаар нэвтрүүлэх давуу талыг олгодог.

CU конвинеенс сүлжээ дэлгүүрээс сим карт сэргээх, ая тухтай орчинд хоол идэх, амрах, Wi-Fi, ариун цэврийн өрөөгөөр үйлчлүүлэх зэрэг хэрэглэгчийн өдөр тутмын хэрэгцээг хангах нийгмийн дэд бүтцийн үйлчилгээг авч болдогоруу давуу талтай юм.

Цаашид Үнэт цаас гаргагч нь төрийн болон шуудангийн үйлчилгээ, банкны ба төлбөр тооцооны үйлчилгээ, зураг ба бичиг баримт хэвлэх, олшруулах гэх мэт үйлчилгээг нэвтрүүлэхээр зорьж байна. Түүнчлэн, конвинеенс дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг жижиг, дунд бизнес эрхлэгчдэд франчайз эрхээр олгож, бизнесийн үнэ цэнийг нь нэмэгдүүлж эхэлсэн нь тус бизнесийг урт хугацаанд тогтвортой экосистем болгож байна.

Бусад уламжлалт хүнсний дэлгүүр, мухлагтай харьцуулахад CU конвинеенс дэлгүүрийн үйл ажиллагаа нь дараах 4 үндсэн онцлог давуу талтай. Үүнд:



1. Бүтээгдэхүүн үйлчилгээний ялгарал
2. Логистикийн цогц шийдэл
3. Технологийн цогц шийдэл
4. Нийгмийн дэд бүтэц

Зураг 11. CU конвiniенс дэлгүүрийн онцлог, давуу талууд




### Бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгарал

Жижиглэн худалдааны салбарт хэрэглэгчийн хувьсан өөрчлөгдөж буй амьдралын хэв маягт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг тасралтгүй хөгжүүлэх нь тус зах зээлд тогтвортой оршин тогтнох үндэс суурь нь болдог.

Тиймээс Үнэт цаас гаргагчийн CU конвiniенс дэлгүүрийн хувьд өөрийн нэрийн, үндэсний үйлдвэрлэгчидтэй хамтран хөгжүүлсэн болон импортын шинэлэг тренд бүтээгдэхүүнийг үнийн уян хатан бодлого баримтлан хэрэглэгчдэд санал болгож, олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг үзүүлж байна.







Зураг 12. Үнэт цаас гаргагчийн бэлтгэдэг хоол, хүнсний бүтээгдэхүүн




**CU-ийн ялгарах бүтээгдэхүүн**

CU конвениенс дэлгүүр нь GET Coffee, Delaffe, HeyRoо, CU Slushie зэрэг өөрийн нэрийн 50 орчим бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн нь хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн болж чаджээ. Эдгээр бүтээгдэхүүнийг зөвхөн CU конвениенс дэлгүүрээр борлуулдаг тул бүтээгдэхүүний ялгарлыг бий болгож, өдөр тутмын үнэнч хэрэглэгчидтэй болоход нөлөө үзүүлдэг юм.

Зураг 13. Үнэт цаас гаргагчийн импортын бүтээгдэхүүн болох GET Café Latte







Үнэт цаасны танилцуулга

CU конвинеенс сүлжээ дэлгүүр нь өдөр бүр шинээр үйлдвэрлэсэн өөрийн нэрийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчид санал болгосноор тэдгээрийн завгүй амьдралын хэв маяг болон хэрэгцээ шаардлагыг хангаж, үнэ цэнийг нэмэгдүүлдэг.


Зураг 14. Үнэт цаас гаргагчийн CU Eats нэрийн хоолны бүтээгдэхүүнүүд



Хэрэглэгч CU Eats нэрийн хоолны бүтээгдэхүүн болон дэлгүүрт шууд бэлтгэдэг Гоёдоог, Хөвсгөр бууз, Beefer хуушуур, өглөөний цайны сэндвич, панини зэрэг 35 нэр төрлийн бүтээгдэхүүнийг зөвхөн CU конвинеенс дэлгүүрийн салбаруудаас өдөр бүр шинээр нь худалдан авах боломжтой.

Зураг 15. Үндэсний үйлдвэрлэгчтэй хамтран хөгжүүлсэн бүтээгдэхүүнүүд





Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих тэдгээрийн бүтээгдэхүүнийг олон нийтэд таниулах зорилтынхоо хүрээнд Үнэт цаас гаргагч нь Айсмарк, Милко, Фрэшбокс зэрэг 10 орчим бэлтгэн нийлүүлэгчтэй хамтран зайрмаг, халуун шингэн бүтээгдэхүүн, сэндвич, пай зэрэг 40 нэр төрлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлсэн нь хэрэглэгчдийн дунд өндөр эрэлттэй байна.

Эдгээр бүтээгдэхүүнд CU брэндийн онцлог, давуу талыг шингээсэн тул хэрэглэгчдэд цоо шинэ мэдрэмж, үнэ цэнийг өгдөг.

Зураг 16. Үнэт цаас гаргагчийн импортын тренд бүтээгдэхүүнүүд



Олон улсад тренд болж буй бүтээгдэхүүнийг бусдаас түрүүнд хэрэглэгчид хүргэхийн тулд дотоодын зах зээлд байршаагүй, шинээр нэвтрүүлэх боломжтой бараа, бүтээгдэхүүнийг судалж, нэр төрлийг тогтмол шинэчилдэг.

### **Уян хатан үнийн бодлого**


Жижиглэн худалдааны зах зээлийн өрсөлдөөнд үнийн бодлого чухал байр суурь эзэлдэг тул CU конвиниенс дэлгүүр нь хэрэглэгчид өгөх үнэ цэнээс хамаарсан ялгаатай үнийн бодлогыг хэрэгжүүлдэг.

Тухайлбал, талх, сүү, өндөг зэрэг өргөн хэрэглээний бүтээгдэхүүнийг зах зээл дэх үнээс хямд буюу үйлдвэрийн үнээр борлуулдаг нь хэрэглэгчийн урсгалыг нэмэгдүүлэх өндөр ач холбогдолтой.

### **Олон улсын стандартад нийцсэн үйлчилгээ**

Конвиниенс дэлгүүрийн салбарт 31 жилийн турш үйл ажиллагаа явуулж буй БНСУ-ын БиЖиЭф Ритэйл компанийн туршлагад үндэслэж CU конвиниенс дэлгүүр нь олон улсын стандартад нийцсэн хэрэглэгч төвтэй үйлчилгээ үзүүлж байна.





Үнэт цаасны танилцуулга

CU конвинеенс сүлжээ дэлгүүр нь дэлгүүрийн дотоод орчны тохижилт, өөртөө үйлчлэх зай талбай, тоног төхөөрөмжийг оновчтой байршуулснаар хэрэглэгч өөрт илүү хялбар байдлаар бүтээгдэхүүн үйлчилгээг сонгох, худалдан авах, хэрэглэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Үнэт цаас гаргагч нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийг өндөрт байлгаж, үйлчилгээний стандартыг алдагдуулахгүйн тулд дэлгүүрийн стандартын нийцлийн үнэлгээ болон чанарын хяналт, зөрчлийн залруулгын удирдлагын QSC системийг ашигладаг.

**Гарт ойр хүргэлтийн үйлчилгээ**

Зураг 17. Үнэт цаас гаргагчийн хүргэлтийн үйлчилгээ




Сэнтрал Экспресс нь 30 минутын дотор хүргэж өгөх хамгийн хурдан хүргэлтийн үйлчилгээг 2020 оны 5 сард нэвтрүүлж 2,000 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчид санал болгож, бүх салбар дэлгүүрээр дамжуулан хүргэлтийн үйлчилгээг үзүүлж байна.

2021 оны 6 сарын байдлаар Үнэт цаас гаргагч нь нийт 124 мянган хэрэглэгчийн 780 мянган бүтээгдэхүүнийг хүргэсэн бөгөөд нийт захиалгын 70 хувь нь онлайнаар хийгдсэн байна.







### Логистикийн цогц шийдэл

#### Түгээлтийн төв

Конвиниенс дэлгүүр нь төвлөрөл ихтэй бүсийн нэгж метр квадрат талбайгаас хамгийн өндөр борлуулалтыг хийхээр зорьдог тул жижиг талбайд үйл ажиллагаа явуулдаг онцлогтой. Иймд бараа бүтээгдэхүүнийг тогтмол нийлүүлэхийн тулд нөөцийн хэмжээ, эргэцийн хурдыг тооцоолсон хяналт, хадгалалт, түгээлт, тээвэрлэлтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажилладаг.

Түгээлтийн төвүүд нь өдөрт 500 орчим ханган нийлүүлэгчийн 3.5 мянга орчим бараа бүтээгдэхүүнийг хүлээн авч, салбаруудад түгээдэг. Ингэснээр бараа бүтээгдэхүүний чанар алдагдах, солигдох, хугацаа алдах зэрэг бэлтгэн нийлүүлэгчээс хамаарсан үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах зэргээр бараа бүтээгдэхүүний урсгалыг удирддаг.

Мөн бүтээгдэхүүний онцлогоос хамаарсан хэвийн температурын болон хүйтэн хэлхээний түгээлтийн төвүүдээс өдөрт 3-4 удаагийн давтамжтайгаар дэлгүүрийн барааг ханган нийлүүлж байна.

Зураг 18. Үнэт цаас гаргагчийн түгээлтийн төвийн байршил







Үнэт цаасны танилцуулга



**Хүйтэн хэлхээт түгээлтийн төв**

Хүйтэн хэлхээт түгээлтийн төв нь +4°C горим шаарддаг бүтээгдэхүүнийг хадгалах, бэлтгэх, түгээх зориулалт бүхий 375 м<sup>2</sup> талбайтай, зориулалтын тоног төхөөрөмж, агаар сэлгэлтийн системтэй.

Тус төвд CU хоолны үйлдвэрээс бэлтгэгдэн гарч буй хоолнуудаас гадна дотоодын бусад ханган нийлүүлэгчдийн бүтээгдэхүүнийг хүлээн авч, өдөрт дунджаар 55 мянган ширхэг бүтээгдэхүүнийг бэлтгэж нийт 127 дэлгүүрүүдэд түгээж байна.

**Хэвийн температурын горимтой бүтээгдэхүүний түгээлтийн төв**


Үнэт цаас гаргагчийн 100 хувийн охин компани болох Премиум Дистрибьюшн нь Баянгол дүүрэгт 4,200 м<sup>2</sup> талбайд Хэвийн горимын түгээлтийн төвийг ашиглалтад оруулж, Агуулахын удирдлагын систем (Warehouse Management System)-ээр үйл ажиллагааг удирдан ажиллаж байна.

**Зураг 19. Хэвийн температурын горимтой бүтээгдэхүүний түгээлтийн төв (гадна талаас)**



Тус түгээлтийн төв нь өдөрт 80 мянган ширхэг бүтээгдэхүүнийг бэлтгэн түгээж байгаа нь нийт хүчин чадлын 50 орчим хувь бөгөөд цаашид 360 хүртэлх дэлгүүрт тээвэрлэлт, түгээлтийн үйлчилгээг үзүүлэх боломжтой юм.





**Зураг 20. Хэвийн температурын горимтой бүтээгдэхүүний түгээлтийн төв**



**Олон улсын стандартад нийцсэн хоол үйлдвэрлэл**

Премиум Дистрибьюшн нь 2020 оны 11 сард Баянзүрх дүүргийн Хонхор тосгонд 2,960м<sup>2</sup> талбайтай CU хоолны үйлдвэрийг ашиглалтад оруулсан. Тус үйлдвэр нь CU конвениенс дэлгүүрт савласан хоолыг нийлүүлдэг бөгөөд хүнсний аюулгүй байдлын олон улсын Аюулын дүн шинжилгээ ба Эгзэгтэй цэгийн хяналтын (Hazard Analysis Critical Control Point) болон Үйлдвэрлэлийн зохистой дадлын (Good Manufacturing Practice) тогтолцооны болзлыг хангасан Монголын анхны нэг чиглэлийн урсгалтай нийтийн хоолны үйлдвэр юм.

**Зураг 21. Үнэт цаас гаргагчийн хоолны үйлдвэр(гадна талаас)**





СЗХ  
2021.09.13  
БҮРТГЭВ  
№01

Тус хоолны үйлдвэр нь хэрэглэгчид чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлын өндөр шаардлагыг хангасан шинэхэн хоолыг өглөө бүр хүргэдэг.

Үнэт цаас гаргагч нь тус хоолны үйлдвэрийг өөрийн 100 хувь охин компаниар дамжуулж ажиллуулснаар хоолны өртгийг бууруулж, бүтээгдэхүүний амт, чанарыг олон улсын стандартад нийцүүлж, сайжруулах боломжийг бүрдүүлсэн.

Зураг 22. Үнэт цаас гаргагчийн хоолны үйлдвэрийн төв



Тус хоолны үйлдвэр нь өдөр бүр 20 гаруй нэр төрлийн 8 мянган ширхэг хоолыг хүнсний хугацаа уртасгагч, тогтворжуулагч бодисгүйгээр үйлдвэрлэж байна. Мөн жижиг дунд бизнес эрхлэгчдэд СУ хоолны үйлдвэрийн дэд бүтэц, ажиллах хүчинд түшиглэн бүтээгдэхүүн хөгжүүлэх, СУ конвениенс дэлгүүрээр борлуулах боломжийг нээсэн билээ.

Тус үйлдвэрийн барилгын давуу тал нь хүнсний үйлдвэр болон хөргөх өрөөг зориулалтын EPS, полиуретан хавтангаар дугуй булан гарган хийсэн нь нян бактери үржихгүй байх нөхцөлийг бүрдүүлсэнд оршдог. Түүнчлэн, цэвэр усны хангамж, агаар сэлгэлт, бохир зайлуулах систем нь олон улсад болон Монгол Улсад мөрдөгдөж буй стандартын шаардлагуудыг бүрэн хангасан, чанарын болон тоон тохируулгатай, мэдрэх, дохиолох автомат системтэй.

Голын  
121000013

50

Зураг 23. Үнэт цаас гаргагчийн хоол үйлдвэрлэлийн процесс



Зураг 24. Үнэт цаас гаргагчийн хоол үйлдвэрлэлийн процесс (Будааны ороомог)



### Технологийн цогц шийдэл

Үнэт цаас гаргагч нь өдөр тутмын үйл ажиллагаандаа технологийн дэвшилтэд шийдлийг ашиглан бараа бүтээгдэхүүний оновчтой удирдлагыг хэрэгжүүлэхээс гадна хэрэглэгчийн хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагыг өгөгдөлд суурилсан судалгаа шинжилгээгээр нээн илрүүлж, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг тогтмол хийдэг.







Үнэт цаасны танилцуулга



### **Бараа бүтээгдэхүүний оновчтой удирдлага**

Үнэт цаас гаргагч нь бараа бүтээгдэхүүний урсгалыг оновчтой удирдахын тулд Vendor portal буюу хэрэглэгчтэй хамгийн богино хугацаанд бүтээгдэхүүн, урамшуулал, үнийн мэдээллийг солилцох, тооцоо хийх зэрэг процессыг хялбаршуулж, хурдасгах зориулалттай програм хангамжийг ашиглаж эхэлсэн.

CU конвениенс сүлжээ дэлгүүрийн өдөр бүрийн бараа, бүтээгдэхүүний захиалгыг тухайн байршлын онцлогт нийцүүлэн гүйцэтгэх, тасралтгүй ханган нийлүүлэхийн тулд Бараа захиалгын удирдлагын систем (Order Management System)-ийг 2021 онд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Дэлхийн бусад орнуудын жижиглэн худалдааны бизнест өргөнөөр ашигладаг Microsoft LS Retail NAV цогц систем, Microsoft Power BI программ хангамжийг нэвтрүүлснээр Үнэт цаас гаргагч нь борлуулалтын тоо хэмжээ, бүтээгдэхүүний эргэцийн шинжилгээг тасралтгүй хийдэг.

### **Үнэнч хэрэглэгчийн хөтөлбөр**

Үнэнч хэрэглэгчийн хөтөлбөр нь лоялти оноогоор шагнах, худалдан авалтын давтамжид суурилсан урамшуулал олгох, хувь хэрэглэгчийн онцлогт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох замаар урт хугацаанд хэрэглэгчид хүрэх үнэ цэнийг нэмэгдүүлдэг бөгөөд CU аппликэйшнээр дамжуулан тус хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

2021 оны 6 сарын байдлаар CU аппликэйшнийг 600 мянга гаруй хэрэглэгч гар утсандаа суулгаж, худалдан авалт, хүргэлтийн захиалга өгөхдөө тогтмол ашиглан, 70 хувь хүртэлх бодит хямдрал урамшууллыг авч байна.



Зураг 25. CU аппликэйшн буюу CU app



CU аппликэйшн 3.0 шинэ хувилбарын нэвтрүүлэлт эхэлсэн бөгөөд хайлтын сайжруулсан функц, барааны үлдэгдэл харах систем, дижитал төлбөрийн систем, цахим хэтэвч, хэрэглэгчийн судалгааны функц, баннер сурталчилгааны орон зай гэх мэт интерфейс дээр суурилсан хэд хэдэн давуу талтай юм.

### Нийгмийн дэд бүтэц

Конвиниенс дэлгүүр нь хэрэглэгчид хамгийн ойр байдаг үйлчилгээний дэд бүтцийн үүргийг гүйцэтгэдэг. Тодруулбал, CU конвиниенс сүлжээ дэлгүүр нь зөвхөн бараа бүтээгдэхүүн борлуулахаас гадна хэвлэлийн үйлчилгээ, шуудангийн үйлчилгээ зэрэг хэрэглэгчийн хувьсан өөрчлөгдөж буй амьдралын хэв маягт нийцсэн бусад үйлчилгээг хэрэглэгчид нэг цэгээс хүргэх боломжийг бүрдүүлж байна.

CU конвиниенс сүлжээ дэлгүүр нь хурдацтай, далайцтайгаар тэлж байгаа нь Улаанбаатар хотын гудамж талбайд аюулгүй, гэрэлтэй, харуул хамгаалалттай, үнэгүй интернэт бүхий орчныг 24 цагийн туршид бүрдүүлж байна. Мөн дэлгүүр бүрд гадна, дотор хяналтын камержуулалт хийгдсэн, дохиолол хамгааллын мэдээлэх системтэй тул гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, төөрсөн хүүхдүүдийг хамгаалах, мэдээлэл солилцох чиглэлд цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.

**Ойр байршил**

CU конвiniенс дэлгүүр нь хэрэглэгчид хамгийн ойр буюу орон сууцны хороолол, оффис, эмнэлэг, сургууль, автобусны буудал, нисэх буудал, автовокзал зэрэг хүн амын хөдөлгөөний урсгал ихтэй байршлуудад нэвтэрсэн.

**Зураг 26. CU конвiniенс дэлгүүрийн Улаанбаатар хот дахь байршил**




**Франчайзийн хөтөлбөр**

CU конвiniенс дэлгүүр нь 2019 онд жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан франчайз хөтөлбөрийг эхлүүлсэн. Уг хөтөлбөрийн хүрээнд олон улсын жижиглэн худалдааны сайн туршлагыг CU сургалтын төв болон дэлгүүрийн зөвлөх үйлчилгээгээр дамжуулан жижиг дунд бизнес эрхлэгчдэд түгээж, ирээдүйд илүү их үнэ цэнийг бүтээхийг зорьж байна.

Мөн франчайз хөтөлбөр нь харилцан ашигтай байх зарчимд үндэслэхээс гадна CU конвiniенс дэлгүүрийг эзэмшиж, үйл ажиллагааг нь дэмждэг нэгдсэн системийн давуу талыг ашиглан бизнесийн эрсдэлийг бууруулж, урт хугацаанд үр ашигтай бизнес эрхлэх боломжийг олгодог. Түүнчлэн франчайз эрх эзэмшигчдэд зориулсан хүний нөөц, IT систем, агуулахын менежмент зэрэг







чиглэлээр багц хичээл ордог. Ингэснээр франчайз дэлгүүрүүдийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар компаниас мөрддөг нэгдсэн стандарт, загварын дагуу явагдах нөхцөлийг бүрдүүлдэг.

Зураг 27. Франчайз эрх олголт



### 2.3 Хүний нөөц

Үнэт цаас гаргагч нь конвениенс сүлжээ дэлгүүрийг Монгол Улсад нутагшуулахын тулд мэргэжлийн өндөр ур чадвар, ажлын туршлагатай, нийгэмдээ манлайлж буй залуусаар удирдлагын багийг бүрдүүлсэн. Мөн үйл ажиллагааны тогтмол тэлэлтийн үр дүнд 2021 оны 6 сарын байдлаар нийт 800 гаруй ажилтантай болжээ.

Зураг 28. Үнэт цаас гаргагчийн ажилтнууд





Үнэт цаас гаргагчийн нийт ажилтнуудын 36 хувь нь эрэгтэй, 64 хувь нь эмэгтэй бол 65 хувь нь 21-23 насны залуу боловсон хүчин байна. Нийт ажилчдын дийлэнх хувийг залуу ажилчид бүрдүүлж байгаа нь тэдгээр боловсон хүчнийг цаашид өсөн дэвших, хөгжих боломжоор хангах компанийн нэн тэргүүний зорилго амжилттай хэрэгжиж буйн илрэл юм.

2018 онд Мастер франчайзийн гэрээний хүрээнд удирдлагын багийн бүх гишүүдийг 31 жилийн туршлагатай БНСУ-ын CU конвениенс сүлжээ дэлгүүрийн сургалтад хамруулж, мэргэшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлснээс гадна БНСУ-ын зөвлөхтэй 6 сарын турш хамтран ажиллаж, удирдлагын баг болон дэлгүүрийн ажилчдад олон улсын стандартаар ажиллах мэдлэг туршлагыг суулгаж чадсан.

Үнэт цаас гаргагчийн зүгээс худалдаа, үйлчилгээний стандартыг өндөр түвшинд байлгахад анхаарч ажилтнуудад зориулсан байгууллагын соёл, хувь хүний хөгжил, манлайлал, үйлчилгээний соёл, чанар, эрүүл ахуй зэрэг ажлын байранд шаардагдах ур чадвар олгох сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг.


2020 онд Сэнтрал Экспресс болон Премиум Дистрибьюшны ажилтнуудад нийт 5,105,915 хүн цаг сургалт орсон байна.

**Хүснэгт 3. Үнэт цаас гаргагчийн сургалтын мэдээлэл**

Компанийн нэр	Сургалтад хамрагдсан ажилчдын тоо (давхардсан тоогоор)	Сургалтын үргэлжилсэн цаг	Нийт хүн цаг
Сэнтрал Экспресс	5290	949	5,020,210
Премиум Дистрибьюшн	963	89	85,707

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагч*

Үнэт цаас гаргагч нь тусгай хэрэгцээт иргэдийг дэмжих зорилгоор нийт ажилчдын 4-өөс доошгүй хувийг бүрдүүлэх зорилт тавьдаг бөгөөд 2020 оны байдлаар 3.85 хувийг эзэлж байна.



Зураг 29. CU конвинеенс дэлгүүрийн ажилтнууд




## 2.4 Тогтвортой хөгжлийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд

### Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)


Үнэт цаас гаргагч нь 2021 оны 5 сарын 10-ны өдрөөс 6 сарын 21-ний өдрийг хүртэл тогтвортой хөгжлийн үнэлгээний мэргэшсэн компани болох Ризилиенс Консалтинг Сервис ХХК (БОНЗ-ын үнэлгээний байгууллага)-иар Сэнтрал Экспресс болон Премиум Дистрибьюшн нарын харьяа CU сүлжээ дэлгүүрүүд, нэгдсэн түгээлтийн төв, хоолны үйлдвэр гэсэн үйл ажиллагааны бүх шатанд Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын суурь үнэлгээг хийлгэсэн.

БОНЗ-ын үнэлгээчид үнэлгээг хийхдээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилтууд, олон улсын санхүүжүүлэгч байгууллагуудын түгээмэл мөрддөг БОНЗ-ын шаардлагууд болох Олон Улсын Санхүүгийн Корпорацын Байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн стандарт, конвенц, тунхаглал болон Монгол Улсын холбогдох хууль, стандарт, журамд заасан 182 шалгуур үзүүлэлтийг суурь үнэлгээ болгон авч үзсэн. Үүнээс Үнэт цаас гаргагч нь нийт 174 шалгуурыг бүрэн, 8 шалгуурыг бүрэн бус биелүүлсэн буюу 95.6 хувийн бүрэн биелэлттэй гарсан байна.





Үнэт цаасны танилцуулга



Зураг 30. Үнэт цаас гаргагчийн БОНЗ-ын суурь үнэлгээний дүн



Эх сурвалж: БОНЗ-ын тайлан

Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болох үйл явцтай холбогдуулан Монгол Улсад анхлан БОНЗ-ын үнэлгээг хийлгэж хангалттай үнэлгээг авсан. Үнэлгээний дэлгэрэнгүй тайланг Хавсралтаас харна уу.


### Тогтвортой хөгжлийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд

#### Зүрх мартаггүй төсөл

Зураг 31. Зүрх мартаггүй төсөл







Үнэт цаас гаргагч нь олон мянган бяцхан зүрхийг аварч амьдрал бэлэглэж буй Зүрх мартахгүй төсөлд зориулан 3 хүүхдийн зүрхний мэс заслын зардал болон мөнгөн тусламжийг олгож, төслийн үйл ажиллагаанд өөрсдийн хувь нэмрээ оруулсан.

**П.Н.Шастины нэрэмжит Улсын Гуравдугаар Төв Эмнэлгийн мэс заслын хүлээлгийн танхимын тохижуулалт**

Зураг 32. Мэс заслын хүлээлгийн танхим



Нийгмийн хариуцлагын хүрээнд Үнэт цаас гаргагч нь П.Н.Шастины нэрэмжит Улсын Гуравдугаар Төв Эмнэлгийн Мэдрэл болон Зүрхний мэс заслын тасгийн хүлээлгийн танхимыг засварлан тохижуулсан. Улсын хэмжээнд яаралтай мэс ажилбар хийлгэх шаардлагатай мэдрэл болон зүрх судасны хүнд, хөнгөн хэлбэрийн оноштой 1000 гаруй хүмүүс тус тасгаар жил бүр үйлчлүүлдэг байна.

**Нийслэлийн Ерөнхий Боловсролын Сургуулиудын галын булан**

Зураг 33. Сургуулиудын галын булан





Нийслэлийн Ерөнхий Боловсролын Сургуулийн сурагчдад гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээллийг олгох зорилгоор Үнэт цаас гаргагч нь сургууль бүрд галын булан тохижуулах ажлыг санаачлан эхлүүлсэн байна.

**Хүүхэд хамгааллын CU ЧАМД ТУСАЛЪЯ төсөл**

Зураг 34. CU ЧАМД ТУСАЛЪЯ төсөл



Үнэт цаас гаргагч нь Нийслэлийн Цагдаагийн Ерөнхий Газрын Гэр Бүлийн Хүчирхийлэл, Хүүхдийн Эсрэг Гэмт Хэрэгтэй Тэмцэх Газартай хамтран хүүхэд хамгааллын CU ЧАМД ТУСАЛЪЯ төслийг санаачлан, CU конвинеенс сүлжээ дэлгүүрээр дамжуулан хэрэгжүүлж эхэлсэн байна.



Төслийн гол зорилго нь бага насны хүүхдийг төөрөхөөс сэргийлэх, төөрсөн хүүхдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлж CU конвинеенс сүлжээ дэлгүүрээр дамжуулан гэр бүлд нь хүлээлгэн өгөхөд оршдог.



**Байгальд ээлтэй Монгол гэр төсөл**

Зураг 35. Монгол гэр төсөл




Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан болон CU конвинеенс сүлжээ дэлгүүрийн БНСУ дахь БиЖиЭф Ритэйл компаниуд хамтран Монгол Улсад байгаль орчинд ээлтэй, дулааны алдагдал багатай монгол гэрийн дулаалгын төслийг хэрэгжүүлэх албан ёсны санамж бичигт гарын үсэг зурсан байна.


Зураг 36. Монгол гэрийн дулаалгын төслийн хүрээнд цахилгааны халаагуур суурилуулсан байдал



Төслийн гол зорилго нь хүүхэд, эмэгтэйчүүд болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлийг бууруулах, тав тухтай, дулаахан орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, амьдрах орчныг нь сайжруулж ахуйн хог хаягдлыг бууруулах зорилготой юм. Төслийн хүрээнд эрт



Үнэт цаасны танилцуулга



амьдардаг өрхүүдэд цахилгааны халаагуур суурилуулахад Үнэт цаас гаргагч дэмжлэг үзүүлсэн байна.

Энэхүү төслийг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд 500,000 ам.долларын хөрөнгө оруулалтыг Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт оршин суудаг 500 гаруй өрх, 10 гэр цэцэрлэгт Байгальд орчинд ээлтэй Монгол гэрийн дулаалга, халаалтын СНІР багцыг (Монгол гэрийн халаалт, дулаалгын бүтээгдэхүүн) олгоход зориулна.

## 2.5 Эрсдэлийн удирдлагын бодлого

Үнэт цаас гаргагч нь 2018 онд Солонгосын CU брэндийн Мастер франчайз эзэмшигч болсноор сүлжээ дэлгүүрийн тоог хурдацтай нэмэгдүүлсэн. Анх Сэнтрал Экспресс брэндийн дэлгүүр нь 3 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байсан бол 2018 онд CU брэндийг нэвтрүүлснээр тус онд дэлгүүрийн тоо 18-аар нэмэгдэж нийт 21, 2019 онд 35 дэлгүүрээр нэмэгдэж нийт 56, 2020 онд 47 дэлгүүр нэмэгдэж нийт 103 дэлгүүртэй Монгол Улсад өмнө нь байгаагүй нэгдсэн удирдлага бүхий дэлгүүрийн сүлжээг бий болгосон. Тус тоо нь 2021 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаар 127 болж нэмэгдсэн байна.


Дэлгүүрийн тоо нэмэгдэхийн хэрээр бараа бүтээгдэхүүний сонголтыг оновчтой зохион байгуулах, логистик, нийлүүлэлтийг тасалдалгүй гүйцэтгэх, дэлгүүрийн үйл ажиллагаа, хүний нөөцийн зохион байгуулалтыг найдвартай байлгах зэргээр бизнесийн үйл ажиллагааны цар хүрээ нь хурдацтай нэмэгдсээр байна.

Олон улсын түүхэн туршлагаар, жижиглэн худалдааны салбарын гол анхаарах шаардлагатай түгээмэл эрсдэлд өрсөлдөөний эрсдэл, брэндийн нэр хүндийн эрсдэл, дэлгүүрийн үйл ажиллагаа, нийлүүлэлтийн сүлжээний тасалдалгүй байдлын эрсдэл зэрэг багтдаг.

Эдгээр нь сүлжээ дэлгүүрийн борлуулалтын орлого буурахгүй байх, үйл ажиллагааны зардал зохистой, төлөвлөсөн дүнгээс хэтрэхгүй байхтай шууд холбоотой юм. Түүнчлэн, компанийн санхүүгийн нөхцөл байдалтай холбогдох хөрвөх чадварын эрсдэл, хүүгийн түвшний эрсдэл, зээлийн эрсдэлүүдийг түгээмэлд тооцдог байна.







2020, 2021 онд Ковид-19 цар тахлын улмаас Монгол Улсад тэр дундаа Улаанбаатар хотод тогтоосон хатуу хөл хорио, сургууль, цэцэрлэг, олон нийтийн үйл ажиллагааны хязгаарлалт, дэлгүүрийн үйлчилгээний цагийн хязгаар, улсын хилийг хаасан зэрэг арга хэмжээнүүдээс шалтгаалсан макро орчны нөлөөллөөс үүдэлтэй эрсдэл үүссэн.

Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагааны цар хүрээ томорч буйтай холбоотойгоор ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын менежментийн баг нь учирч болох эрсдэлүүдийг тасралтгүй тодорхойлох, бууруулах, арилгахын тулд богино ба дунд хугацааны арга хэмжээг тогтмол авч, урт хугацааны стратегийн шийдвэр гаргалтуудад гол эрсдэлүүдийг харгалзах зэргээр эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж ирсэн.

Үнэт цаас гаргагчийн менежментийн эрсдэлийг таних, хэмжих, удирдах гол аргачлал нь бизнесийн үйл ажиллагаа ба санхүүгийн байнгын хяналт, тогтмол хэлэлцүүлэг, хамтын ажиллагаа, богино ба дунд хугацааны төлөвлөлт юм. Үүнд, Үйл ажиллагаа хариуцсан захирал, Санхүү хариуцсан захирлын харьяалал дахь алба, хэлтсүүдийн оролцоо, нөлөө чухал байдаг.

Дараах хэсэгт Үнэт цаас гаргагчийн тодорхойлсон гол эрсдэлүүд тэдгээрийн нөлөө, эрсдэлийн удирдлага авч хэрэгжүүлдэг арга хэмжээг авч үзлээ.

### **Бараа нийлүүлэлтийн тасалдлын эрсдэл**


Бэлтгэн нийлүүлэгч нь бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг захиалгын дагуу гүйцэтгэхгүй байх, тасалдал үүсэх, бэлэн байдал алдагдсанаар борлуулалтын орлого тасалдахыг энэ төрлийн эрсдэлд хамруулж тодорхойлдог.

CU конвiniенс дэлгүүрийн тоо нэмэгдсэнээр дэлгүүр бүрийн бараа, бүтээгдэхүүний захиалга, нийлүүлэлтийг өдөр бүр зохион байгуулахад, ялангуяа шинэ хоол, хүнсийг найдвартай нийлүүлэхэд үйл ажиллагааны эрсдэл үүсэх боломжтой.

Тиймээс Үнэт цаас гаргагч нь CU конвiniенс сүлжээ дэлгүүрийн системийн хэмжээний бараа бүтээгдэхүүний борлуулалтын түүхэн мэдээлэлд түшиглэж нэгдсэн сувгаар бараа бүтээгдэхүүний нөөцийг үүсгэх, тус нөөцөөс дэлгүүр бүрийн







Үнэт цаасны танилцуулга



захиалгад тулгуурласан тасалдалгүй нийлүүлэлтийг гүйцэтгэхийг эрмэлзэн ажиллаж байна.

Мөн дотоодын бэлтгэн нийлүүлэгчдээс хамааралгүйгээр Ковид-19 цар тахлын хүндрэлээс шалтгаалсан импортын бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлт, газрын ачаа тээврийн хоцролт үүсэх эрсдэлтэй тул тухайлсан бараа бүтээгдэхүүний аюулгүйн нөөцийг үүсгэх нь зайлшгүй юм.

Дээрх шалтгааны улмаас дотоодын бэлтгэн нийлүүлэгчдийн импортын нөөц нь газрын ачаа тээврийн хоцролтоос хамаарч дутагдахад хүрвэл энэ нь бараа нийлүүлэлтийн тасалдлыг үүсгэнэ. Уг тохиолдолд тухайн нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг орлуулах замаар эрсдэлийг бууруулах боломжтой.

### Нэр хүндийн эрсдэл

Үйлчилгээний стандарт алдагдах, ажилтнууд, франчайз эзэмшигчид болон бусад оролцогч талуудын зохисгүй үйлдлийн улмаас брэндийн нэр хүнд унах, харилцагчдын итгэлийг алдах зэргийг уг эрсдэлд авч үзнэ.


Хэрэглэгчтэй шууд харилцдаг дэлгүүрийн ажилтнуудад QSC (quality service control) үйлчилгээний стандартын сургалтыг тогтмол явуулдаг. CU-д тавтай морилно уу, цэвэр цэмцгэр орчинд ая тухтай үйлчлүүлнэ үү гэсэн байгууллагын үйлчилгээний соёл, үзэл баримтлалыг дэлгүүрийн ажилтнуудад ойлгуулах, тэдний үйл хөдлөл бүрд шингээх нь тус стандартын үндсэн зорилго юм.

Тиймээс хэрэглэгчийн гомдол, саналыг нээлттэй хүлээн авах, барагдуулах харилцагчийн үйлчилгээний төвийг ажиллуулдаг.

Дэлгүүрийн менежерүүдэд хэрэглэгчийн үйлчилгээний ажилтныг сонгон шалгаруулах эрхийг олгож, зорилтод зан төлөвт тохируулж харилцах ур чадвартай ажилтнуудаар багаа бүрдүүлэх боломжийг олгодог.

Үйлчилгээний төлөөлөгч (Service Ambassador) хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нийт ажилтнууд дундаас үйлчилгээний ажилтны жишиг болсон сайн дүрийг бодитоор тодруулж, бусад ажилтнуудад үлгэр дуурайлал үзүүлэх, сайн туршлагаа зааж хуваалцах зэрэг бодлогыг хэрэгжүүлдэг. Ханган нийлүүлэгч, гүйцэтгэгч, франчайз эзэмшигчидтэй байгуулсан гэрээнд





брэндийн стандартыг барих, нэр төрд халтай үйлдэл, эс үйлдэл хийхгүй байх талаар маш тодорхой заалтуудыг оруулж, даган мөрдүүлэх дээр хүчин чармайлттай ажилладаг байна.

CU брэнд нэвтэрснээс хойш тус брэндийн нэр хүндтэй холбоотой ноцтой зөрчил, үл нийцэл үүсэж байгаагүй нь компанийн соёл, үнэт зүйлс, түүнийг ойлгох, баримтлах хүчин чармайлттай шууд холбоотой.

### **Мэдээллийн технологийн системийн доголдлоос үүсэх эрсдэл**

Мэдээллийн технологийн найдвартай тогтолцоо Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаанд хамгийн чухал хүчин зүйлсийн нэг мөн. Уг тогтолцоо доголдсоноос үүдэн CU конвинеенс сүлжээ дэлгүүрийн бараа захиалга тасалдах, санхүү, хүний нөөцийн бүртгэл алдагдах зэргээр бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Уг эрсдэлийг арилгах үүднээс жижиглэн худалдааны салбарт түгээмэл ашиглагддаг олон улсын Бизнесийн нөөцийн төлөвлөлт (ERP)-ийн системийг нэвтрүүлсэн бөгөөд уг системийн найдвартай үйл ажиллагааг тасралтгүй хангах, техникийн алдааг засах зорилгоор NaviWorld Vietnam компанитай ажил үйлчилгээ үзүүлэх мастер гэрээг байгуулан ажиллаж байна.



Мэдээллийн технологийн цаашдын тасралтгүй хөгжүүлэлт нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа доголдохгүй байх хүчин зүйл болж уг төрлийн эрсдэлийг бууруулна.

### **Франчайз дэлгүүрүүдтэй үүсэх эрсдэл**

Франчайзуудын хамтын ажиллагаа болон харилцаанд үл ойлголцол үүсэж, улмаар үйл ажиллагааны тогтвортой байдал доголдохыг уг эрсдэлд хамруулдаг.

Үнэт цаас гаргагч нь Франчайз хөтөлбөрийн хүрээнд 2021 оны 7 сарын байдлаар нийт 22 дэлгүүрийн франчайз эрхийг жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олгоод байна. Тус эрхийг олгохдоо дэлгүүрийн үйл ажиллагааг зохион байгуулах чадвартай, CU брэндийн нэр хүндийг унагаах эрсдэл багатай бизнес эрхлэгчийг таньж тодорхойлохыг зорин ажилладаг. Үнэт цаас гаргагч нь франчайз эрхийг байршил сайтай, борлуулалт, ашигт ажиллагаа





нь тогтворжсон дэлгүүрүүдэд олгох бодлогыг хэрэгжүүлдэг бөгөөд Ковид-19 цар тахлын нөхцөл байдал сайжирснаар Франчайз дэлгүүрүүдэд үүсэх эрсдэл буурна.

Үнэт цаас гаргагч нь дэлгүүрийн зөвлөхөөр дамжуулан Франчайз дэлгүүрийн үйл ажиллагаанд үүсэж буй бүх төрлийн асуудлыг хэлэлцэж хамтдаа шийдвэрлэх замаар дэмжлэг үзүүлдэг бөгөөд цаг үргэлж харилцаатай байхыг эрмэлздэг.

Тухайлбал, бараа бүтээгдэхүүний тасалдал үүсэх тохиолдолд өөрийн шууд удирдлагатай дэлгүүрээс дээгүүр эрэмбэлэх бодлогыг баримтлах зэргээр уг төрлийн эрсдэлийг бууруулахын тулд хамтын ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлэх, тасралтгүй сайжруулан ажилладаг.

### **Бүтээгдэхүүний сонголт, хөгжүүлэлтийн эрсдэл**

Зах зээлийн эрэлт, трендийн чиг хандлагад үл нийцэх бараа, бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд санал болгосноор борлуулалт буурах, хэрэглэгчдийг уйдаах эрсдэлийг уг ангиллын эрсдэлд авч үздэг.

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааны туршлагадаа үндэслэн эрүүл ахуй, чанарын шаардлагад нийцсэн шинэ бүтээгдэхүүн сонгох, хөгжүүлэх үйл явцыг тодорхойлон ажилладаг.

Мөн бэлтгэн нийлүүлэгч болон шинийг санаачлагч ресторануудтай хамтран шинэ хоол хөгжүүлэхийг зорин ажиллаж байгаа нь бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн үйл явцыг хурдасгах чухал алхам болж байна.

Үнэт цаас гаргагч нь өндөр хүчин чадал бүхий хоол үйлдвэрлэлийн төвтэй учир бэлтгэн нийлүүлэгчдийн ашиг сонирхолтой зөрчилдөх эрсдэлийг үүсгэж болзошгүй ч тус төвд түшиглэж шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, CU сүлжээ дэлгүүрээр борлуулах боломжийг нээлттэй олгодог нь тус эрсдэлийг бууруулдаг.

Иймд Үнэт цаас гаргагч өөрийн болон бусад бэлтгэн нийлүүлэгчдийн технологийг тасралтгүй хөгжүүлэх дадал бүрдэж байгаа нь цаашид бүтээгдэхүүний сонголт, хөгжүүлэлтийн эрсдэлийг бууруулах боломжтой.





Үнэт цаасны танилцуулга

2021-09-17

Бүтээгдэхүүн

Хэрэглэгчийн худалдан авалтын зан төлөв, хүсэл сонирхол, бүтээгдэхүүний эрэлтийн чиг хандлагыг таньж мэдэх боломж сүлжээ дэлгүүрүүдэд илүү байдаг нь бүтээгдэхүүний сонголт, хөгжүүлэлтийн эрсдэлийг бууруулдаг.

### Өрсөлдөөний эрсдэл

Ойролцоо байршил дахь хүнсний дэлгүүр, конвениенс дэлгүүрийн тоо нэмэгдсэнээр нэгж дэлгүүрийн болон дундаж борлуулалт буурах, хэрэглэгчдийн тоо хуваагдахыг уг эрсдэлийн ангилалд авч үзнэ.

Circle-K, GS25 зэрэг бусад конвениенс дэлгүүрүүдийн тоо өсөх нь өрсөлдөөний эрсдэл ихсэж буй мэт боловч салбарын хэмжээнд конвениенс дэлгүүрийн зах зээлийн багтаамж нэмэгдэж, уламжлалт хүнсний дэлгүүрийн зах зээлийн багтаамж буурдаг олон улсын түүхэн туршлага байдаг. Түүнчлэн салбарын хөгжлийг шинэ түвшинд гаргаж буй уг төрлийн дэлгүүрүүд нэмэгдэх нь хэрэглэгчдийг шинэ дадал, хэрэглээний хэв маягт сургах, бэлтгэн нийлүүлэгчдийг хамтран хөгжүүлэх зэрэг олон давуу талуудыг олгодог.

Харин өрсөлдөгч брэндийн конвениенс дэлгүүрт сайн байршлуудыг алдахгүй байх нь өрсөлдөөний гол хэсэг тул эдгээр байршлуудад дэлгүүрийн сүлжээгээ тэлэх шаардлагатай байдаг. Иймд Үнэт цаас гаргагч нь Ковид-19 цар тахлын улмаас эдийн засгийн уналттай үед ч дэлгүүрийн тоог нэмж байна.

Ижил брэндийн дэлгүүр хэт ойрхон байрлах нь уг төрлийн эрсдэлийг үүсгэх бөгөөд 150-200 метрийн зайд байрласнаар борлуулалт хуваагдах эрсдэл буурдаг нь тогтоогдсон.

Үнэт цаас гаргагч нь олон тооны сайн байршилд өөр хоорондоо оновчтой зайтайгаар сүлжээ дэлгүүрийг тэлж буй нь өрсөлдөөнд давуу байдлыг бий болгож, уг төрлийн эрсдэлийг бууруулна.

### Хүний нөөцийн эрсдэл

Түлхүүр ажилтнуудаа алдах, тухайн ажилтныг орлох ажилтан олоход бэрхшээл учрах, цаашлаад идэвхтэй ажилтны (engaged employee) тоо буурснаар хүний нөөцийн эрсдэл үүсдэг.


Үнэт цаас гаргагч нь дэлгүүр, хоол үйлдвэрлэлийн төв, түгээлтийн төв зэрэг шууд хөдөлмөрийн орчинд ажиллаж буй







Үнэт цаасны танилцуулга



ажиллагсадтай хөдөлмөрийн уян хатан гэрээ байгуулах, тусгай хэрэгцээт ажиллагсдын тоог нэмэгдүүлэх, цалин урамшууллыг ажиллагсдын ур чадвар, бүтээмжээс шууд хамааруулах зэргээр байгууллагын соёл, үнэт зүйлсийн хувьд нийгэмд эерэг хандлагыг бий болгохоор зорьж буй нь дунд, урт хугацаандаа уг төрлийн эрсдэлийг бууруулах чухал хүчин зүйлс юм.

Мөн нийт ажилтнууд дунд карьер хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн нь удирдлагын багийн залгамж халааг бэлтгэх, шилдэг туршлага, ур чадвараас нь суралцах боломжийг олгох юм. Түлхүүр ажилтнуудад үндсэн цалин, урамшууллаас гадна компанийн хувьцааг бизнесийн амжилттай уялдуулсан ESOP хөтөлбөрөөр санал болгох замаар урт хугацаанд тогтвортой ажиллах эрмэлзлийг нэмэгдүүлнэ. Ингэснээр, түлхүүр ажилтнуудаас хамаарсан бизнесийн эрсдэлийг бууруулж чадна.

### Хууль, зохицуулалтын эрсдэл


Зарим нэр төрлийн бүтээгдэхүүнийг тухайн нэгж дэлгүүрт борлуулах эрхийг хязгаарлах, холбогдох хууль, зохицуулалт өөрчлөгдөх, түүнийг даган мөрдөөгүйгээс шалтгаалан үйл ажиллагааны хязгаарлалтад орох, борлуулалт буурах зэрэг нь уг төрлийн эрсдэлд ангилагдана.

CU конвиниенс сүлжээ дэлгүүр нь Монголын зах зээлд нэвтэрснээс хойш холбогдох хууль, дүрэм журмыг сайтар мөрдөж, зохицуулагч байгууллагуудтай харилцан ойлголцож ирсэн нь зохицуулагч байгууллагын шаардлагыг бүрэн биелүүлэх бизнес туршлагыг нэмэгдүүлсэн. Тиймээс, хууль, дүрэм журмыг даган мөрдөөгүйгээс шалтгаалах эрсдэл үүсэх магадлал маш багад тооцогдоно.

Сургуулийн ойролцоо байрлах хүнсний дэлгүүрүүдэд хийжүүлсэн ундаа, элсэн чихрийн агууламж ихтэй бүтээгдэхүүн, мөн зарим нэр төрлийн бүтээгдэхүүнийг борлуулахыг хязгаарлах тогтоол гарсан нь тухайн орчинд байрлах нийт худалдааны цэгүүдэд эрсдэл үүсгэнэ.

Хэрэглэгч талаас нь авч үзвэл тухайн байршлуудаас орлуулах бүтээгдэхүүн худалдан авах, эсвэл бусад байршлаас сонголтоо хийх боломжтой.





Үнэт цаасны танилцуулга

Орлуулах сонголтын хувьд CU конвинеенс сүлжээ дэлгүүр нь бэлтгэн нийлүүлэгчидтэй хамтарсан шинэ бүтээгдэхүүнийг тасралтгүй хөгжүүлж ажилладаг тул бусад жижиглэн худалдааны цэгтэй харьцуулахад уг эрсдэлийг амжилттай давах нөхцөлийг бүрдүүлсэн.

Монголын зах зээлд үйл ажиллагаа явуулж буй конвинеенс дэлгүүрийн брэнд, оролцогч талуудын тоо ихэссэнээр бизнес эрхлэгчдийн холбоо үүсэх, түүгээр дамжуулан зохицуулагч байгууллагуудад салбарын онцлог, нөхцөл байдлыг зөв зүйтэй тайлбарлаж, эрх зүйн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх боломжууд ихэснэ.

### Түрээсийн төлбөр нэмэгдэх эрсдэл

Зах зээл дэх өрсөлдөөн нэмэгдсэнээр одоо үйл ажиллагаа явуулж байгаа болон шинээр нээгдэх дэлгүүрийн байршлуудын түрээсийн төлбөр нэмэгдэх, компанийн зардал өсөх эрсдэлийг уг ангилалд авч үзнэ.

Үнэт цаас гаргагч нь Улаанбаатар хотын түрээсийн төлбөр хамгийн өндөр байршлуудад дэлгүүрээ хэдийн нээсэн бөгөөд урт хугацаанд тогтвортой байхуйцаар түрээсийн гэрээгээ байгуулсан нь одоогийн дэлгүүрүүдэд тулгарч болох эрсдэлийг бууруулсан.

Шинээр нээгдэх дэлгүүрүүдийн хувьд түрээсийн төлбөр нь өрсөлдөөнөөс шалтгаалан өсөх эрсдэлтэй. Нөгөө талаас Ковид-19 цар тахлаас үүдэн эдийн засгийн идэвхжил буурснаар талбайн эзэн буюу түрээслүүлэгчдийн түрээслэх боломжтой талбайн нийлүүлэлт нэмэгдсэн. Иймд шинэ дэлгүүрийн түрээсийн төлбөр огцом нэмэгдэх эрсдэл бага юм.

Үнэт цаас гаргагч нь урт хугацаанд түрээсийн төлбөрийг инфляцтай уялдаж өсөх нөхцөлийг ирээдүйн санхүүгийн тооцоололдоо тусгасан. Түрээслэгчид нь CU конвинеенс дэлгүүрт өөрийн байршлаа түрээсэлснээр урт хугацаанд тогтвортой өгөөж хүртэх, тухайн байршлын үнэ цэн нэмэгдэх зэрэг олон давуу тал үүсдэг учир түрээстэй холбоотой зөрчил, маргаан үүсэх нь бага байдаг.


### Эдийн засгийн хэлбэлзлээс үүсэх эрсдэл

Монгол Улсын эдийн засаг буурах, бизнесийн мөчлөгөөс үүдэлтэйгээр хэрэглэгчдийн худалдан авах чадвар муудах, энэ нь





Үнэт цаасны танилцуулга



дэлгүүрийн борлуулалтад нөлөөлөхийг уг төрлийн эрсдэлд ангилан авч үзнэ.

2020 онд Монгол Улсын бодит дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь 5.3 хувиар буурсан нь цар тахлаас үүдэлтэй. Гол статистик үзүүлэлтүүдэд 2021 онд эдийн засгийн сэргэлт ажиглагдаж эхэлсэн төдийгүй олон улсын зах зээлд түүхий эдийн үнэ өсөж байгаа нь ойрын жилүүдэд дотоодын эдийн засгийн буурах эрсдэлийг багасгаж байна.

Олон улсын судалгаа, статистикаас үзэхэд конвинеенс дэлгүүрийн бизнес нь жижиглэн худалдааны дэд салбарт ангилагддаг учраас бизнесийн мөчлөгийн мэдрэг байдал нь харьцангуй бага юм.

CU конвинеенс сүлжээ дэлгүүрийн бизнес нь зах зээлд нэвтэрснээс хойш 3 жилийн хугацаанд суурь хэрэглэгчидтэй болж, тэдний өдөр тутмын хэрэгцээ шаардлагын хүрээнд конвинеенс сүлжээ дэлгүүрийг зорих дадлыг хэвшүүлж байгаа нь цаашид уг бизнесийг тогтвортой, мөчлөгөөс үл хамаарах бизнес болгох юм.


### Ковид-19 эрсдэл

Ковид-19 цар тахлаас үүдэлтэйгээр үйлчилгээний байгууллагын ажиллах цагийн хуваарь, горим, хэрэглэгчийн тоонд хязгаарлалт тавьснаар борлуулалт буурах, ажилтнуудын дунд халдвар тархах нөхцөл байдал үүссэнээр бизнесийн хэвийн үйл ажиллагаанд саатал учрах зэргийг уг ангиллын эрсдэлд авч үзнэ.

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсад тэр дундаа Улаанбаатар хотод тогтоосон хатуу хөл хорионы дэглэмийн үеэр дэлгүүрийн ойролцоох байршлуудад хүргэлтийн үйлчилгээг идэвхжүүлсэн нь тус эрсдэлийг урьдчилан харсан чухал арга хэмжээ байсан. Гэсэн хэдий ч хатуу хөл хорионы үед шат шатны сургуулиуд ажиллаагүй, конвинеенс дэлгүүрээр үйлчлүүлэгчдийн тоо тодорхой хэмжээнд буурснаар борлуулалтын хэмжээ багассан юм.

Монгол Улсын Засгийн газар, Онцгой Байдлын Ерөнхий Газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд Ковид-19 халдварын тархалт буурах хүлээлттэй байсан учраас Үнэт цаас гаргагч нь үйлчилгээний ажилтнуудын ажлын байрыг хадгалах, сүлжээ





дэлгүүрийг боломжит түвшинд ажиллуулах арга хэмжээг авч байсан.

Энэ нь урт хугацаанд ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах компанийн соёл болон хэрэглэгчдийн итгэх итгэлд эерэг нөлөөтэй ч богино хугацааны борлуулалтын бууралттай үед бизнесийн үйл ажиллагааны алдагдлыг нэмэгдүүлсэн.

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны саатлыг бууруулах үүднээс дэлгүүр, түгээлт, үйлдвэр, агуулах болон оффисын нийт ажилтнуудыг вакцинд хамруулж, сэжигтэй тохиолдолд түргэвчилсэн тестийг тогтмол хийн, боломжтой ажилтнуудыг зайнаас ажиллах нөхцөлөөр хангасан.

Цаашид Ковид-19 цар тахлын нөлөө нь хүмүүсийн амьдралд тодорхой түвшинд байсаар байх төлөвтэй ч, энэ нь харьцангуй бага байх магадлалтай байна. Монгол Улсын Засгийн газар цаашид хатуу хөл хорио тавих магадлал бага, бүх нийтийн онцгой байдлын зэргийг бууруулах чиглэлтэйгээр ажиллаж байна.

### **Гадаад валютын ханшийн эрсдэл**

CU конвинеенс дэлгүүрт шууд хамааралтай ам.доллар, вон, юанийн ханш өссөнөөр импортын бараа, бүтэгдэхүүний өртөг өсөж, ашиг буурах, шинэ дэлгүүр нээхэд шаардлагатай бараа импортын бараа материал, эд анги, тоног төхөөрөмжийн өртөг нэмэгдэхийг уг төрлийн эрсдэлд авч үзнэ.


Жижиглэн худалдааны цэг, хүнсний дэлгүүрүүдэд өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн борлуулдаг учир импортын бүтээгдэхүүний өртөг өсөх тохиолдол цөөнгүй.

Салбарын түүхэн туршлагаас үзэхэд өртгийн өсөлтийг хэрэглэгч рүү шууд шилжүүлэх замаар уг эрсдэлээс зайлсхийдэг.

Харин Үнэт цаас гаргагч нь томоохон худалдан авагч тул уг төрлийн эрсдэлийн зарим хэсгийг импортын бүтээгдэхүүн нийлүүлэгч рүү шилжүүлэх, шууд импортын хувьд гадаад валютыг ханшийн огцом өсөлтөөс өмнө нөөцлөх замаар бүтээгдэхүүний үнэ рүү шууд шилжүүлэхгүйгээр зохицуулалт хийснээр уламжлалт дэлгүүрүүдтэй харьцуулахад хэрэглэгчдийг татах боломж нээгдэнэ.







Үнэт цаасны танилцуулга



Шинээр нээгдэх дэлгүүрүүдийн барилгын материалын үнэ, тоног төхөөрөмжийн үнэ нь валютын ханшийн өсөлтөөр дамжин нэмэгдэх хандлагатай тул Үнэт цаас гаргагч нь дунд, урт хугацааны санхүүгийн төсөөлөлд төлөвлөх, богино хугацаанд гадаад валютын нөөц бэлтгэх замаар эрсдэлийг бууруулах боломжтой.

### Инфляцын эрсдэл

Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт нь эрэлт, нийлүүлэлтээс үүдэлтэйгээр нэмэгдсэнээр CU конвениенс дэлгүүрийн бараа, бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлэх, ашигт ажиллагааг бууруулах эрсдэлийг уг төрлийн эрсдэлд авч үзнэ.

Инфляцын эрсдэл нь гадаад валютын эрсдэлтэй харьцангуй ижил ба уг эрсдэлээс зайлсхийхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь ойролцоо юм.



### Хөрвөх чадварын эрсдэл

Борлуулалтын алба, нэгж дэлгүүрийн менежер, түгээлтийн төв зэрэг холбогдох алба, хэлтсийн хамтын ажиллагаа алдагдсанаар бараа материалын нөөц хэт ихсэх, эргэц удаашрах, үүнээс үүдэн бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх төлбөрийг цаг хугацаанд нь төлж чадахгүй байхыг уг ангиллын эрсдэлд авч үзнэ.

Жижиглэн худалдааны цэг, хүнсний дэлгүүрүүдийн хувьд, бэлтгэн нийлүүлэгчдээс худалдааны таатай нөхцөл авах боломж бага байдаг. Харин CU конвениенс сүлжээ дэлгүүр нь 127 дэлгүүртэй учир бэлтгэн нийлүүлэгчидтэй харьцах хүч харьцангуй нэмэгдсэн. Цаашид ч дэлгүүрийн тоо нэмэгдэх хэрээр томоохон худалдан авагч болж бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх үнэ цэн нэмэгдэхэд үндэслэсэн нийлүүлэлтийн таатай нөхцөлүүдийг улам сайжруулах юм.

CU конвениенс сүлжээ дэлгүүр нь эцсийн хэрэглэгч рүү чиглэсэн жижиглэн худалдаа эрхэлдэг учир их дүнтэй дансны авлага үүсдэггүй, авлагын ба бараа материалын үлдэгдэл багатай. Харин хугацаа хэтрээгүй дансны өглөг ихтэй байх замаар богино хугацааны санхүүгийн менежментээ сайжруулснаар хөрвөх чадварын эрсдэлийг бууруулах боломжтой.






### Төлбөрийн чадваргүй болох эрсдэл

Үнэт цаас гаргагч нь зээлийн санхүүжилтийн хүү, үндсэн төлбөрийг төлөх чадваргүй болсноос үүдэх сөрөг үр дагаврыг уг төрлийн эрсдэлд авч үзнэ.

2021 оны 6 сард санхүүжилтийн бүтцийн өөрчлөлт хийх замаар урт хугацаат зээлийг 16 тэрбум төгрөгөөр, өмнөх толгой компаниас авсан 19 тэрбум төгрөгийн хоорондын тооцооны өглөгийг бууруулсан. Ингэснээр 6 сарын 30-ны өдрөөр нэгтгэгдсэн санхүүгийн тайлан дээр 12 тэрбум төгрөг (4.6 хувийн хүүтэй 2 тэрбум воны зээл, хувьсах хүүтэй 7 тэрбум төгрөгийн зээл)-ийн зээлтэй үлдсэн нь санхүүгийн тогтмол зардлыг бууруулах чухал үйл явдал болж зээлийн ачаалал буурсан нь төлбөрийн чадваргүй болох эрсдэлийг багасгасан.

Зураг 37. Эрсдэлийн матриц



Эх сурвалж: Үнэт цаас гаргагч

Дээрх матрицад гол эрсдэлүүдийн үзүүлэх нөлөө, тохиолдох магадлалаар нь ангилан Үнэт цаас гаргагчийн шууд удирдах боломжгүй нөлөөлөл ихтэй эрсдэлийг дурдвал Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан хатуу хөл хорио болон онцгой дэглэм буурахгүй байх эрсдэл юм. Бусад удирдагдахгүй эрсдэлүүд буюу хууль зүйн болон зохицуулалтын эрсдэл, инфляцын эрсдэл, валютын ханшийн эрсдэл, эдийн засгийн хэлбэлзлийн эрсдэл зэрэг нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаанд томоохон шууд нөлөөг үзүүлэхгүй.



Үлдсэн эрсдэлийн хувьд, Үнэт цаас гаргагч нь компанийн үйл ажиллагаа, менежмент, бизнес төлөвлөгөөг сайжруулснаар эрсдэл учрах магадлал, нөлөөллийг бууруулах боломжтой юм.

## 2.6 Санхүүгийн тайлан, шинжилгээ

Үнэт цаас гаргагч нь 2018-2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хөндлөнгийн аудитыг ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК (PwC Mongolia)-иар хийлгэсэн. Түүнчлэн БДО Аудит ХХК 2021 оны 6 сарын 30-ны өдрөөр тасалбар болсон завсар үеийн санхүүгийн тайланд нягтлах ажил гүйцэтгэж, дүгнэлт гаргасан.

Компанийн 3 жилийн ба хагас жилийн түүхэн санхүүгийн мэдээлэл дээр тулгуурлан Монголд хурдацтай тэлж буй конвниенс сүлжээ дэлгүүрийн бизнесийн онцлог, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны ба санхүүгийн үр дүнг тайлбарлах, цаашдын дүр зургийг таних боломжтой.

### Орлогын тайлангийн шинжилгээ


Хүснэгт 4. Үнэт цаас гаргагчийн орлого үр дүнгийн тайлан, сая төгрөгөөр

Орлогын тайлан	2018	2019	2020	2021.II <sup>2</sup>
Борлуулалтын орлого	5,687	37,468	45,348	32,457
Борлуулалтын өртөг	(7,335)	(43,356)	(50,707)	(36,255)
Нийт ашиг, алдагдал	(1,648)	(5,888)	(5,359)	(3,798)
Ерөнхий ба удирдлагын зардал	(2,012)	(4,190)	(5,102)	(2,703)
Үйл ажиллагааны бусад орлого, зардал	(2,269)	1,988	(34)	343
Үйл ажиллагааны ашиг, алдагдал	(5,929)	(8,090)	(10,495)	(6,158)
Санхүүгийн орлого	4	7	159	192
Санхүүгийн зардал	-	(3,191)	(5,588)	(2,481)
Татварын өмнөх ашиг, алдагдал	(5,925)	(11,274)	(15,924)	(8,447)
Орлогын албан татварын хөнгөлөлт, (зардал)	(0)	(1)	196	1,254
Татварын дараах ашиг, алдагдал	(5,926)	(11,275)	(15,728)	(7,192)

Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

Үнэт цаас гаргагчийн орлого нь 2018-2020 оны хооронд жилд дунджаар 182.3 хувиар, 2020 онд өмнөх жилтэй харьцуулахад 21.0 хувиар, харин 2021 оны эхний хагас жилд өмнөх оны мөн

<sup>2</sup> 2021.II нь 2021 оны 2 дугаар улирал буюу 6 сарын 30-ны өдрийг илэрхийлсэн болно.



Этэй харьцуулахад (2020 оны эхний хагас жилийн борлуулалтын дүн 17,650 сая төгрөг) 83.9 хувиар тус тус өсчээ. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого нь конвениенс сүлжээ дэлгүүрийн өдөр тутмын борлуулалтын орлогоос бүрдэх ба үүнд дараах хүчин зүйлс шууд нөлөөлнө.

- i. Сүлжээ дэлгүүрийн өдрийн дундаж хэрэглэгчийн тоо;
- ii. Сүлжээ дэлгүүрийн хэрэглэгчийн дундаж худалдан авалтын дүн;
- iii. Сүлжээ дэлгүүрийн тоо;
- iv. Сүлжээ дэлгүүрийн ажилласан өдөр

Эхний 2 хүчин зүйлсийн үржвэр нь дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалтыг, дараагийн 2 хүчин зүйлсийн үржвэр нь дэлгүүр өдрийн тоог илэрхийлнэ. Дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалт нь конвениенс дэлгүүрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ цэн, хэрэглэгчид танигдсан байдал, нээгдсэнээс хойшхи хугацаа зэргээс шууд хамааралтай. Өөрөөр хэлбэл, жижиглэн худалдаа, үйлчилгээний ая тухтай шийдэл нь Монголын хэрэглэгчдэд харьцангуй шинэ учраас өдөр бүр ая тухтай үйлчилгээ үзүүлсний үр дүнд хэрэглэгчдийн тоогоо нэмэгдүүлэх, ингэснээр өдрийн дундаж борлуулалтаа нэмэгдүүлэх боломж ба сорилт үүсдэг.

Зураг 38. Дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалт, хагас жилээр, мянган төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл

2019 онд дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалт нь 2.5 сая – 2.6 сая төгрөгийн хооронд, мөн 2019 ондоо хагас жил хооронд өсч байсан нь дэлгүүр өдрийн тоо нэмэгдэж байгаатай давхцаж





байжээ. Энэ нь дээр дурьдсан борлуулалтыг бүрдүүлэх хүчин зүйлс хамтдаа сайжирч байгааг илтгэх сайн үзүүлэлт юм.

Гэтэл 2020 оны эхний хагас жилд өдрийн дундаж борлуулалт 1.57 сая төгрөг болж, 2019 оны 2-р хагас жилтэй харьцуулахад 41.1 хувиар огцом буурсан нь нийт сүлжээ дэлгүүрийн орлогыг 17.6 тэрбум болж буурахад нөлөөлжээ.

Ковид-19 цар тахлын нөхцөл байдал хүндэрсний улмаас Монгол Улсын Засгийн газар гадаад хилээ хааж, сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг хязгаарлах, хатуу хөл хориог тогтоох зэрэг арга хэмжээг авсан. Цаашлаад, худалдааны салбарын ажиллах цагийн хуваарьт хязгаарлалт тогтоосон нь дэлгүүрийн ажилласан цаг, түүнчлэн хэрэглэгчдийн тоог огцом буурахад нөлөөлсөн. Ковид-19 цар тахал Монголын эдийн засгийн идэвхжилд хэрхэн нөлөөлснийг доорх бодит ДНБ-ийн бууралтаас харж болно.

Зураг 39. Бодит ДНБ, ДНБ-ын өсөлт, бууралт, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: УСХ, Голомт Капитал УЦК-ийн тооцоолол

Сүлжээ дэлгүүрийн нийт борлуулалт буурсан гол шалтгаан нь эдийн засгийн идэвхжил, хүний хөдөлгөөн ихтэй дэлгүүрийн байршлууд болох оффис бүсийн дэлгүүрүүдийн борлуулалтын бууралт юм. 2020 оны 11 дүгээр сараас 2021 оны 5 дугаар сарыг хүртэлх хугацаанд Монгол Улсын Засгийн газраас хатуу хөл хорио 4 удаа, нийт 105 хоногийн хугацаанд тогтоосон нь Үнэт цаас гаргагчийн сүлжээ дэлгүүрийн борлуулалтын томоохон хувийг эзэлдэг оффис бүсийн салбаруудын орлогыг огцом буурах шалтгаан болжээ.

Дээрх шалтгааны улмаас, конвениенс сүлжээ дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалт буурч, эдийн засгийн хүндрэлтэй цаг үе үргэлжилсэн хэдий ч Үнэт цаас гаргагч нь 2018 оны 8 сараас конвениенс эхлүүлсэн дэлгүүрийн хурдацтай тэлэх бодлогоо үргэлжлүүлсэн. Учир нь тэлэлтийн үйл ажиллагаа нь шаардлагатай цаг хугацаа, байршлын сонголт, өрсөлдөөний орчин, олон дэлгүүрийн үйл ажиллагааг эрт жигдрүүлэх зэрэг олон хүчин зүйлсээс шууд хамаарна. Дараах зурагт Үнэт цаас гаргагчийн тэлэлтийн хурд, түүнийг дагасан сүлжээ дэлгүүрийн нийт борлуулалтын өсч буй трендийг харуулжээ.

Зураг 40. Дэлгүүрийн тоо, борлуулалтын орлого, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл

Доорх зурагт харагдаж буйгаар 2021 оны 5, 6 дугаар саруудад цагийн хязгаартай үйл ажиллагаа явуулж буй хэдий ч, сүлжээ дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалт нь 2.5 сая төгрөг болсон байгаа нь Ковид-19 нөлөө аажмаар буурч байгааг харуулж байна.

Зураг 41. 2021 оны дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалт, мянган төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл

СЭХ  
2021.10.13  
БҮРТГЭВ  
№ 1

2021 оны 4 дүгээр улирал, 2022 оноос эхлэн сүлжээ дэлгүүрийн цагийн хуваарь буцаж 24 цагийн үйл ажиллагаатай болох, бүх шатны сургуулийн хэвийн үйл ажиллагаа эхэлбэл борлуулалт сайжрах нөхцөл бүрдэхээр байна.


Борлуулалтын өртөгт борлуулж буй бараа бүтээгдэхүүний өртгөөс гадна дэлгүүр дээр үүсч буй хөдөлмөр, түрээс, тээвэрлэлт, ашиглалт, хангамж, харуул хамгаалалт, програм хангамж, интернет зэрэг бүх мөнгөн зардлууд, мөн дэлгүүрийн биет хөрөнгө оруулалт, үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн зарчмаар элэгдүүлж буй мөнгөн бус зардлууд багтдаг.

Борлуулалтын өртөг нь борлуулалтын орлоготой харьцуулахад 2019 оны 1 дүгээр хагас жилд 118 хувь байсан бол 2020 оны 2 дугаар хагаст 109 хувь, 2021 оны 1 дүгээр хагас жилд 112 хувь болж буурсан байна. Борлуулалтын өртөг нь борлуулалтын орлогоос өндөр байгаа шалтгаан болон цаашид буурах боломжийг зардлын ангиллаар авч үзье.

Борлуулалтыг даган өөрчлөгдөх эсэхээс хамааран зардлыг хувьсах ба тогтмол гэж ангилах бөгөөд цаашдын нийт зардлын бууралтад дараах 2 бүлэг зардлын бууралт чухал нөлөөтэй байна.

- Нэгж дэлгүүрийн дундаж хувьсах зардлын бууралт
- Нэгж дэлгүүрийн тогтмол зардлын тогтворжилт, бууралт

Зураг 42. Борлуулалтын өртөг, борлуулалтад эзлэх хувь, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан



Үнэт цаасны танилцуулга

2021-05-17

БҮРТЭЭ-02

### Хувьсах зардлын бууралт

2018 оны төгсгөлд 18 дэлгүүр, 2019 оны эхний хагаст 43 дэлгүүртэй байсан CU конвينيенс сүлжээ дэлгүүр нь 2021 оны 6 сарын 30-ны өдрөөр 127 дэлгүүртэй болж сүлжээ дэлгүүрийн хэмжээний борлуулалт, татан авалтын хэмжээг нэмэгдсэн. Үнэт цаас гаргагчийн худалдан авах чадварыг сайжирсаар байгаа нь борлуулсан бүтээгдэхүүний өртөг буюу татан авч буй бараа бүтээгдэхүүнийг уламжлалт хүнсний дэлгүүртэй харьцуулахад харьцангуй хямд худалдан авах боломжийг нэмэгдүүлэх юм.

Жишээлбэл, 2019 онд Үнэт цаас гаргагч нь 37,468 тэрбум төгрөгийн цэвэр борлуулалттай байсан ба үүнээс бараа бүтээгдэхүүний өртөг нь 28,167 байсан нь 75.18% байгаа юм. Харин, 2020 онд 45,348 тэрбум төгрөгийн цэвэр борлуулалттай байснаас бараа бүтээгдэхүүний өртөг нь 31,940 тэрбум болж, бараа бүтээгдэхүүний өртгийн борлуулалтад эзлэх хувь нь 70.43% болж томоохон хувьсах зардал буурсан байна.

Үнэт цаас гаргагч нь өөрийн охин компанийн Хоол үйлдвэрлэлийн төв дээр хөгжүүлсэн савлагаатай бэлэн хоол зэрэг үнэ цэн нэмэгдүүлсэн бүтээгдэхүүн болон өөрөө шууд импортлох боломжтой бүтээгдэхүүний борлуулалтад эзлэх харьцааг сайжруулснаар бараа бүтээгдэхүүний өртгийг цаашид дахин бууруулах боломжтой юм.

Зөвхөн бараа, бүтээгдэхүүний өртөг төдийгүй, нэгж дэлгүүрийн түвшинд гарч буй хангамжийн материал, барааны акт, дутагдал зэрэг хувьсах зардлууд нь үйл ажиллагаа жигдэрч, үр ашигт байдал сайжрахын буурах нөхцөл бүрдэнэ.


### Тогтмол зардлын тогтворжилт, бууралт

Тогтмол зардлын хамгийн чухал бүрдэл нь хөдөлмөр, түрээс, ашиглалтын зардал зэрэг юм. Нэгж дэлгүүрийн борлуулалтын үйл ажиллагаанаас үл хамааран гарч буй эдгээр зардлууд нь борлуулалтыг өсөхөд шууд даган өсөхгүй, мөн борлуулалтыг буурахад шууд дагаж буурахгүй учир борлуулалт багатай үед уг ангиллын зардлын нөлөөгөөр алдагдал ихсэх төлөвтэй байдаг.

Цаашид тогтмол зардлууд дээр үр ашгийн хяналт тависнаар тогтворжуулах, боломжит зардлыг тодорхой түвшинд бууруулах зэрэг нь борлуулалт өсөн нэмэгдэх үед ашигт ажиллагааг







сайжруулна. Тогтмол зардлын бүрдэлд багтаж буй өөр нэг зардал нь мөнгөн бус зардал буюу үндсэн хөрөнгийн элэгдэл юм.

Конвинеенс сүлжээ дэлгүүрийн онцлог нь ая тухтай үйлчилгээг санал болгож буй учраас борлуулалтын түвшин тогтворжоогүй эхний 12-18 саруудад дэлгүүрийн түвшний тогтмол зардлууд нь борлуулалттай харьцуулахад өндөр байдаг учраас тус зардлыг давахын тулд тухайн нэгж дэлгүүр нь байршил, хэрэглэгчдийн хэрэгцээг мэдрэн борлуулалтаа нэмэгдүүлэх, мөн нийт сүлжээ дэлгүүрийн хувьд цар хүрээгээ тэлснээр хувьсах өртгүүдийг бууруулах шаардлага үүснэ.

Үүний зэрэгцээ Үнэт цаас гаргагч нь бизнесийн ноу-хаугаа сайжруулан дэлгүүрийн тогтмол зардлуудыг цаашид нэмэгдүүлэхгүйгээр тогтворжуулж чадвал нэгж дэлгүүрийн түвшинд эерэг ашигтай ажиллаж эхлэх хугацаа ойртсох юм.

Уг төрлийн бизнесийн онцлог нь үйлчилгээний стандартыг сайжруулахын зэрэгцээ, олон тооны бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх боломж их бөгөөд, хэрвээ 2020 онд Ковид-19-ээс үүдэлтэй эдийн засгийн идэвхжил буураагүй бол олон тооны дэлгүүрийн үйл ажиллагаа тогтворжиж, эерэг ашиг руугаа орох боломжтой байсан юм.

Хэрэглэгчдийн конвинеенс дэлгүүрээр үйлчлүүлэх хэрэгцээ шаардлага цаашид улам нэмэгдсээр байгаа учраас, CU брэндийг нэвтрүүлснээс хойшх 3 жилд Үнэт цаас гаргагч нь ирээдүйд үйл ажиллагаа нь тогтворжих боломжтой байршлуудад дэлгүүрийн тоог хурдацтай нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн сууриа бэлтгэх үүднээс ая тухтай үйлчилгээг стандартын дагуу хүргэхэд анхаарч, түүнийг хүргэх үнэ цэнтэй ажилтнуудаа бэлтгэх зэргийг анхаарч ажилласан учраас борлуулалтын өртгийг борлуулалтын орлогоос өндөр байлгах хамгийн том шалтгаан болжээ.

Үүний зэрэгцээ, бизнесийн үйл ажиллагааны үйл явцаа жигдрүүлэх, бэлтгэн нийлүүлэгчидтэй харилцаа холбоогоо сайжруулах, суурь дэд бүтцээ бэлтгэхэд анхаарч, их дүнтэй хөрөнгө оруулалтуудыг хийж ирсэн нь хувьсах зардлыг бууруулах боломжийг бүрдүүлж өгчээ.



Зураг 43. Ерөнхий ба удирдлагын зардал, борлуулалтад эзлэх хувь, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

Ерөнхий ба удирдлагын зардалд дэлгүүрийг нийтэд нь цогцоор төлөвлөх, сурталчлах, мэдээллийн технологийн дэд бүтцээр хангах, дэд бүтцийг сайжруулах, хөгжүүлэх зардлууд багтдаг.

Конвиниенс дэлгүүрийн давуу тал нь дэлгүүр тус бүрийн худалдааны болон бусад мэдээллийг боловсруулж, үйл ажиллагааг сайжруулахад оршдог бөгөөд үүнтэй холбоотойгоор мэргэжлийн болон оффисын ажилтнуудын цалин, хүний нөөцийг бүрдүүлэх, сургах, бэлтгэх, хадгалах зардлууд гардаг.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа өргөжихийн хэрээр ерөнхий ба удирдлагын зардал аажмаар нэмэгдэж байгаа ч өргөжилтийн эерэг үр өгөөжийн нөлөөгөөр борлуулалтын орлогод эзлэх хувь нь тогтвортой буурч байна.


2019 оны 1 дүгээр хагаст ерөнхий ба удирдлагын зардал 1.6 тэрбум төгрөг байсан нь борлуулалтын орлогын 11.6 хувьтай тэнцүү байсан бол 2021 оны 2 дугаар улирлын байдлаар 2.7 тэрбум төгрөг буюу нийт орлогын 8.3 хувьтай тэнцэж байна.

Санхүүгийн зардалд СТОУС-ын тайлагналын стандартын дагуу түрээсийн зардлын зарим хэсгийг санхүүгийн түрээсийн хүүгийн зардлаар бүртгэн оруулдаг. Тус мөнгөн бус шинжтэй зардал нь 2019, 2020, 2021 оны эхний хагас жилд нийт санхүүгийн зардлын 55-иас 72 хувь орчим байжээ. Санхүүгийн зардлын үлдсэн хэсэг нь урт хугацаат зээлийн хүүгийн зардал болон гадаад валютын зээлийн ханшийн өөрчлөлтөөс үүдэлтэй гарз юм.

Үнэт цаас гаргагч нь 2021 оны 6 сарын байдлаар 21.3 тэрбум төгрөгөөр хүүтэй зээлийг бууруулсан нь цаашид хүүгийн зардлыг бууруулах нөлөөтэй байна. 2021 оны 6 сарын 30-ны өдрөөр БНСУ-ын хөрөнгө оруулагчаас 4.6 хувийн хүүтэй 2 тэрбум воны зээл (5.075 тэрбум төгрөг), мөн Голомт банкнаас бодлогын хүү + 5 хувь буюу 11 хувийн хөвөгч хүүтэй 7.5 тэрбум төгрөгийн зээлтэй байна.

Орлогын албан татварын хуулийн дагуу компани алдагдалтай ажилласан тохиолдолд татварын хувь хэмжээгээр хойшлогодсон татварын хөрөнгө үүсгэж болдог. Ингэснээр ирээдүйд ашигтай ажиллах үед тухайн жилийн татварын зардлыг бууруулан төлөх боломжтой.

**Зураг 44. Татварын дараах ашиг, алдагдал, тэрбум төгрөгөөр, дэлгүүр өдөрт ногдох ашиг, алдагдал, мянган төгрөгөөр**



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл

Татварын дараах алдагдал нь 2020 оны 1 дүгээр хагаст 8.1 тэрбум төгрөгт хүрсэн бол 2021 оны 1 дүгээр хагаст 7.2 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнийг дэлгүүр өдөрт ногдуулж тооцвол 2019 оны 1 дүгээр хагаст нэг дэлгүүр өдрийн цэвэр алдагдал 1,025 мянган төгрөг байсан бол хувьсах ба тогтмол зардлын бууралтын үр нөлөөгөөр 2021 оны 1 дүгээр хагаст 302 мянган төгрөг болж 70 хувь буурсан байна.



МОНГОЛЫН ХӨРӨНГӨН НЬСЭГ  
 MONGOLIAN STOCK EXCHANGE  
 Үнэт цаасны танилцуулга  
 2021-09-17

## Санхүүгийн байдлын тайлангийн шинжилгээ **17030-02**

### Хүснэгт 5. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлан, сая төгрөгөөр


Санхүүгийн байдлын тайлан	2018	2019	2020	2021.II
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>				
Үндсэн хөрөнгө	5,685	13,613	17,916	33,115
Ашиглах эрхтэй хөрөнгө	-	15,617	16,813	19,033
Биет бус хөрөнгө	2,468	2,913	2,808	2,897
Бусад хөрөнгө	460	384	3,078	9,161
<b>Эргэлтийн хөрөнгө</b>				
Бараа материал	2,507	4,025	6,711	7,475
Бусад эргэлтийн хөрөнгө	430	1,725	3,486	4,648
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	188	652	6,104	3,962
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>11,737</b>	<b>38,929</b>	<b>56,917</b>	<b>80,292</b>
Хувьцаат капитал	10,951	17,145	17,145	67,981
Хуримтлагдсан ашиг	(6,522)	(17,797)	(33,525)	(40,718)
<b>НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>4,428</b>	<b>(652)</b>	<b>(16,380)</b>	<b>27,263</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>				
Урт хугацаат түрээсийн төлбөр	-	15,321	19,571	24,334
Урт хугацаат зээл	-	12,551	10,520	12,570
Урт хугацаат санхүүгийн өглөг	2,038	-	-	-
<b>Богино хугацаат өр төлбөр</b>				
Дансны болон бусад өглөг	5,271	7,422	25,218	14,725
Богино хугацаат өр төлбөр	-	3,282	16,361	103
Богино хугацаат түрээсийн төлбөр	-	1,005	1,628	1,293
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,309</b>	<b>39,581</b>	<b>73,297</b>	<b>53,029</b>

Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө нь 2021 оны 1 дүгээр хагас жилийн байдлаар 80.3 тэрбум төгрөгт хүрснээс 64.2 тэрбум төгрөгийг эргэлтийн бус, 16.1 тэрбум төгрөгийг эргэлтийн хөрөнгө бүрдүүлж байна.







Үнэт цаасны танилцуулга

Зураг 45. Нийт хөрөнгө, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

Эргэлтийн бус хөрөнгийн дийлэнх хэсгийг үндсэн хөрөнгө буюу салбар дэлгүүрийн засварын хөрөнгө, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил эзэлж байна. Мөн охин компанийн үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмж үүнд багтана. Эргэлтийн хөрөнгийн дийлэнх хэсэг нь борлуулалтын зориулалттай бараа материал байна.

Зураг 46. Хувьцаат капитал, тэрбум төгрөгөөр




Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

Үнэт цаас гаргагчийн эздийн өмч нь 2021 оны 2 дугаар улиралд 50.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний задаргааг авч үзвэл:

- i. 19.8 тэрбум төгрөгийн дүн бүхий Премиум Группд төлөх хоорондын тооцооны өглөгийг хувьцаат капитал руу хөрвүүлэх;






Үнэт цаасны танилцуулга

- ii. 16.2 тэрбум төгрөгийн банкны зээлийг хөрвүүлэх;
- iii. 7.7 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий Премиум Дистрибьюшн ХХК-ийг охин компани болгон нэгтгэх;
- iv. 2.0 тэрбум төгрөгийн шинэ хувьцаат капиталын санхүүжилт;
- v. 5.1 тэрбум төгрөгийн хувьцаа эзэмшигчийн зээлийг хувьцаат капитал руу хөрвүүлэх зэрэг

үүнийг ерөнхий ангиллаар авч үзвэл, нийт 41.1 тэрбум төгрөгийн урт хугацаат зээл, өглөгийг хөрвүүлэх, 7.7 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий охин компанийг нэгтгэх, 2 тэрбум төгрөгийн мөнгөн санхүүжилт татсан байна.

Ингэснээр ii ба v-д дурьдагдсан 20 гаруй тэрбум төгрөгийн урт хугацаат зээлийн дүн буурсан байна.

Зураг 47. Эздийн өмч, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

Үнэт цаас гаргагч нь 2019 оноос хойш өргөжилтийн капитал зарцуулалтыг санхүүжүүлэх зорилгоор зээлийн эх үүсвэрийг тогтмол ашиглаж ирсэн бөгөөд 2020 онд гуравдагч талаас авсан 26.9 тэрбум төгрөгийн зээлтэй байв.

Компанийн өр төлбөрийн харьцаа (урт ба богино хугацаат зээлийн нийт хөрөнгөд эзлэх хувь) 2021 оны 2 дугаар улирлын байдлаар 11.4 хувь болж, капиталын бүтэц дэх хөшүүрэг багасч, санхүүгийн эрсдэл буурсан байна.



### Харьцаа үзүүлэлтийн шинжилгээ

Зураг 48. Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд



Эх сурвалж: Голомт Капитал ҮЦК-ийн тооцоолол

Компанийн хөрвөх чадварын харьцаа 2019 оны 1 дүгээр хагаст 1.27 байсан бол 2020 оны 2 дугаар хагаст 0.38 болж буурч 2021 оны 1 дүгээр хагаст эргэн 1.0 болж өссөн байна.

2020 оны 2 дугаар хагасын бууралт нь богино хугацаат зээл болон холбоотой талуудын өр төлбөрийн дүнтэй холбоотой байв. Харин 2021 онд эдгээр өр төлбөрүүд хаагдсанаар эргэлтийн өр төлбөр буурч эргэлтийн хөрөнгө өссөн тул харьцаа нь эргэн сайжирчээ.

Худалдааны салбарын компанийн хувьд авлага, бараа материал, өглөгийн насжилт өндөр ач холбогдолтой үзүүлэлт бөгөөд зөв менежмент хийснээр үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой.

Тус үзүүлэлтийг жилийн дүнгээр тооцох нь өндөр эргэцтэй конвинуенс зах зээлийн хувьд оновчгүй бөгөөд компанийн сарын үзүүлэлтүүдийг ашиглан тооцоолсон үр дүнг дараах зурагаас харах боломжтой.

Зураг 49. Үйл ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд, хоног



Эх сурвалж: Голомт Капитал ҮЦК-ийн тооцоолол

Үнэт цаас гаргагчийн борлуулалт нь шууд тооцоогоор хийгддэг тул зээлийн борлуулалтын түүх үүсдэггүй. Бэлтгэн нийлүүлэгчид захиалсан бараа бүтээгдэхүүний төлбөрийг урьдчилж төлсөн үед барааны тоо хэмжээ дутуу ирэх зэрэг шалтгаанаас үүдэн дансны авлага үүсдэг бөгөөд материаллаг хэмжээний авлага үүсдэггүй. Франчайз олголт эрчимжсэнтэй холбоотойгоор тооцоо нийлэлтийн зөрүү нэмэгдэж авлага цуглуулах дундаж хугацаа тодорхой хэмжээнд өссөн.

Үнэт цаас гаргагчийн бараа материалын насжилтыг татан авсан бараа дунджаар хэд хоногийн хугацаанд борлогдож буйгаар илэрхийлдэг. Энэхүү үзүүлэлт 2019 оны 1 дүгээр хагаст 53 хоног байсан бол 2020 оны 2 дугаар хагаст 34 хоног болж сайжирсан байна. 2021 оны 1 дүгээр хагаст цар тахлын улмаас олон хоногийн хөл хорио тогтоосон нь бараа материалын эргэц удааширч насжилт 48 хоногт хүрэхэд нөлөөлжээ.

Цаашид дэлгүүрийн нэрийн бүтээгдэхүүнүүд зах зээлд танигдаж, бараа материалын удирдлагын систем илүү үр ашигтай болсноор бараа материалын эргэц сайжрах боломжтой.

Төлбөр гүйцэтгэх дундаж хугацаа нь татан авсан бараа материалын төлбөрийг хэд хоногийн дараа нийлүүлэгчдэд төлж буйг илэрхийлдэг. Тус үзүүлэлт 2021 оны 1 дүгээр хагас жилийн байдлаар тус үзүүлэлт 57 хоног байна.

Бэлэн мөнгөний циклийг авлага цуглуулах дундаж хугацаа, бараа материалын насжилт хоёрын нийлбэрээс төлбөр гүйцэтгэх дундаж хугацааг хасч тооцдог.




2021.10.13  
он сар өдөр  
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГӨТЭЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2021-09-17  
БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга

Зураг 50. Бэлэн мөнгөний цикл, хоногоор



Эх сурвалж: Голомт Капитал ҮЦК-ийн тооцоолол


2019-2021 оны хооронд Үнэт цаас гаргагчийн бэлэн мөнгөний цикл хасах дүнтэй байгаа нь бэлтгэн нийлүүлэгчид барааны төлбөрийг төлөхөөс өмнө тухайн барааг борлуулан төлбөрийг хүлээн авдаг болохыг харуулж байна. Бэлтгэн нийлүүлэгчдэд төлбөр төлөхөөс өмнө барааны борлуулалт хийгддэг тул Үнэт цаас гаргагч нь эргэлтийн хөрөнгөтэй холбоотой хөрвөх чадварын эрсдэл багатай байна.

Golomt Capital  
Delivered to Quality  
1172370014015300  
Ytsankh@ms.com.mn

88




Үнэт цаасны танилцуулга





**ГУРАВ.  
ҮНЭТ ЦААС  
ГАРГАГЧИЙН ЗАХ  
ЗЭЭЛИЙН ТУХАЙ**





### 3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ

#### 3.1 Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал

2020 онд Монгол Улсын эдийн засаг Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 1992 оны шилжилтийн үеэс хойших хамгийн том уналтыг үзүүлж, 5.3 хувиар агшиж, эдийн засгийн эрэлт, нийлүүлэлт саарснаар экспорт 0.6 хувиар, импорт 14 хувиар буурсан. Харин гадаад худалдааны тэнцэл 2.3 тэрбум ам.доллар, төлбөрийн тэнцэл 722.3 сая ам.долларын ашигтай гарлаа.


Цар тахлын үеийн эдийн засгийг дэмжих зорилгоор Монголбанк мөнгөний зөөлөн бодлогыг хэрэгжүүлснээр бодлогын хүү түүхэн доод түвшин буюу 6 хувьд, мөнгөний нийлүүлэлт 24.6 их наяд төгрөгт хүрэв. Энэ нь өмнөх оноос 16.2 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. Монгол Улсын Засгийн газар иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалахад чиглэсэн төсвийн тэлэх бодлогыг хэрэгжүүлснээр төсвийн алдагдал 4.5 их наяд төгрөгт хүрэв.

2021 оны 1 дүгээр улиралд олон улсын зах зээлд түүхий эдийн ханш нэмэгдэж, уул уурхайн салбар сэргэснээр эдийн засаг 15.7 хувиар өслөө. Ийнхүү Монгол Улсын импортын голлох бүтээгдэхүүний үнэ олон улсын зах зээлд өссөнөөр нийлүүлэлтийн инфляц бий болж, 2021 оны 5 сард инфляц 6.2 хувьд хүрэв. Түүнчлэн мөнгөний зөөлөн бодлого үргэлжилснээр мөнгөний нийлүүлэлт 26.9 их наяд төгрөг болжээ. Төсвийн зөөлөн бодлогын үр дүнд 2021 онд Монгол Улсын төсөв 3.7 их наяд төгрөгийн алдагдалтай гарах хүлээлттэй байна.

Монгол Улсын Засгийн газар 2022 онд төлөгдөх Чингис бонд, 2023 онд төлөгдөх Гэрэгэ бондын нийт 1 тэрбум ам.долларын төлөлтийг дахин санхүүжүүлснээр дунд хугацаанд валютын гадагшлах урсгал буурч, төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн тогтвортой байдал хангагдах суурь тавигдсан.

Цаашид Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал дотоодод тархсан Ковид-19 цар тахлыг хяналтад оруулах хугацаа, хэрэгжүүлэх арга хэмжээнээс хамаарах бөгөөд олон улсын шинжээчид Монгол Улсын эдийн засгийг 2021 онд дунджаар 4.7 хувь, 2022 онд 6.2 хувиар өснө хэмээн таамаглаж байна.





**Хүснэгт 6. Макро эдийн засгийн үзүүлэлтүүд**

Үзүүлэлт	Нэгж	2017	2018	2019	2020
<b>Бодит сектор</b>					
ДНБ, оны үнээр	тэрбум төг.	27,876	32,411	36,898	36,958
ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр	тэрбум төг.	16,892	18,116	19,040	18,034
ДНБ-ний бодит өсөлт	хувь	5.3%	7.2%	5.1%	-5.3%
Нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр	сая төг	9.0	10.3	11.6	11.4
<b>Мөнгөний сектор</b>					
Мөнгө М1	тэрбум төг.	2,826	4,031	3,904	4,197
Мөнгө М2	тэрбум төг.	15,861	19,475	20,834	24,220
<b>Төсвийн сектор</b>					
Нэгдсэн төсвийн орлого	тэрбум төг.	7,958	10,054	11,937	10,402
Нэгдсэн төсвийн тэнцэл	тэрбум төг.	(1,059)	831	508	(4,539)
Гадаад валютын албан нөөц	сая ам.дол.	3,008	3,549	4,349	4,774
Засгийн газрын гадаад өр	сая ам.дол.	7,321	7,184	7,702	8,653
<b>Гадаад сектор</b>					
Экспорт	сая ам.дол.	6,201	7,012	7,620	7,576
Импорт	сая ам.дол.	4,337	5,875	6,127	5,293
Төлбөрийн тэнцэл	сая ам.дол.	1,460	(142)	453	2,282
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	сая ам.дол.	2,086	2,729	2,900	2,620
<b>Хүүний түвшин</b>					
Бодлогын хүү	%	11.0%	11.0%	11.0%	6.0%
Инфляцын түвшин	%	6.4%	8.1%	5.2%	2.3%
Хадгаламжийн хүү, жилээр	%	13.0%	11.2%	10.6%	8.3%
Зээлийн хүү, жилээр	%	19.0%	16.9%	16.9%	15.8%
Төгрөг ам.долларын албан ханш	төг.	2,427	2,644	2,734	2,849

Эх сурвалж: УСХ, Монголбанк

**Бодит сектор**

**Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)**

Монгол Улсын эдийн засгийн өсөлт, бууралт нь экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, стратегийн ач холбогдолтой төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтээс шууд хамааралтай байдаг.

2012 онд экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ дэлхийн зах зээлд өссөнөөр Монгол Улсын эдийн засаг түүхэн дээд түвшин болох 17.3 хувийн өсөлтийг үзүүлж байсан юм. Улмаар уул уурхайн экспортын хэмжээ аажмаар буурч, гадаад өрийн дарамт ихэссэнээр эдийн засаг уналтын мөчлөгт орсон.

Харин 2017 онд Монгол Улс нь Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон улсын зах зээлд зэс, нүүрсний үнэ өссөнөөр эдийн засаг аажмаар сэргэж эхэлсэн. Гэвч 2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр эдийн



засаг 5.3 хувиар агшсан нь 1992 оны шилжилтийн үеэс хойш тохиосон хамгийн том уналт болсон юм.

Хэдийгээр 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар эдийн засаг 15.7 хувиар өссөн боловч салбаруудын сэргэлт тэгш бус байна. Үүнд уул уурхайн салбар 7 нэгж хувиар, боловсруулах үйлдвэр 1.4 нэгж хувиар, худалдааны салбар 0.8 хувиар тус тус өсжээ.


Зураг 51. Монгол Улсын нэрлэсэн ДНБ (их наяд төгрөгөөр) болон бодит ДНБ-ий өсөлт, хувиар



Эх сурвалж: УСХ

2010 оноос хойш Монгол Улсын эдийн засагт эзлэх голлох салбарын үйл ажиллагаа харьцангуй төвлөрөл багатай болж эхэлсэн. 2020 оны байдлаар эдийн засгийг бүтцийн ангиллаар нь авч үзвэл уул уурхайн салбар хамгийн өндөр буюу 21.6 хувийг эзэлж байна.

2010-2020 он буюу 20 жилийн түүхэн хугацаанд худалдааны салбарын орлого дунджаар ДНБ-ий 7-12 хувийн түвшинд хэлбэлзсэн нь бусад салбартай харьцуулахад харьцангуй тогтвортой байна.



Зураг 52. Монгол Улсын ДНБ-ний салбарын бүтэц, хувиар



Эх сурвалж: УСХ

Монгол Улсын 2021-2022 оны эдийн засгийн төлөв байдал нь Ковид-19 цар тахлын нөхцөл байдал болон хариу авах арга хэмжээний үр дүн, Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын эрэлтийг дагасан уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, хөрөнгө оруулалтын орчин, хувийн секторын зээлийн өсөлт зэргээс хамаарч үр дүнтэй байх эсэх нь шалтгаална.

Дэлхийн банк, ОУВС, АХБ-ны шинжээчид Монгол Улсын эдийн засгийг 2021 онд дунджаар 4.7 хувь, 2022 онд 6.2 хувиар сэргэнэ гэж таамаглаж байна.

**Хүснэгт 7. Бодит ДНБ-ий өсөлтийн төсөөлөл, хувиар**

	2021Т	2022Т	2023Т	2024Т	2025Т	2026Т
Дэлхийн банк	4.3%	5.4%				
АХБ	4.8%	5.7%				
ОУВС	5.0%	7.5%	6.0%	5.0%	5.0%	5.0%
<b>Дундаж</b>	<b>4.7%</b>	<b>6.2%</b>	<b>6.0%</b>	<b>5.0%</b>	<b>5.0%</b>	<b>5.0%</b>

Эх сурвалж: Дэлхийн банк, АХБ, ОУВС, Монголбанк

**Инфляц**

2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын дотоодын эрэлт буурч, импорт агшсан, нефтийн үнэ олон улсын зах зээлд буусантай холбоотойгоор инфляцын түвшин 2.3 хувьд хүрч буурсан.

Харин 2021 оны 3 сараас нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлсээс хамаарч инфляцын түвшин өссөнөөр 5 сарын байдлаар улсын






хэмжээнд 6.2 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 6.8 хувьд хүрсэн.

Тодруулбал, газрын тосны үнэ олон улсын зах зээлд 2020 оны 6 сард 1 баррель нь 43 ам.доллар байсан бол 2021 оны 6 сард 73 ам.долларт хүрч 69 хувиар өссөн нь импортын голлох бүтээгдэхүүн болох шатахууны үнийг өсгөх суурь нөхцөл болсон.

Зураг 53. Инфляцын түвшин, хувиар



Эх сурвалж: Монголбанк

Цаашид цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр Засгийн газар болон Монголбанкнаас хэрэгжүүлж буй эрэлтийг дэмжих бодлогын арга хэмжээнүүд нь богино хугацаанд эрэлтийн шинжтэй инфляцыг өсгөх хандлагатай байна.

Монголбанк нь 2021-2023 онд мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлж, инфляцын түвшнийг 6 хувийн зорилгод түвшинд тогтвортой барих бодлоготой байна.

Монголбанк, ОУВС, АХБ-ны шинжээчид инфляцын түвшнийг 2021 онд дунджаар 6.5 хувь, 2022 онд дунджаар 6.9 хувьд хүрнэ гэж таамаглаж байгаа нь богино хугацаанд инфляцын түвшин өсөх өндөр магадлалтайг харуулж байна.

Хүснэгт 8. Инфляцын төсөөлөл, хувиар

	2021T	2022T	2023T	2024T	2025T	2026T
Монголбанк	7.2%	5.8%	6.0%	6.0%	6.0%	6.0%
АХБ	6.9%	8.5%				
ОУВС	5.4%	6.4%	6.1%	6.0%	6.0%	6.0%
Дундаж	6.5%	6.9%	6.1%	6.0%	6.0%	6.0%

Эх сурвалж: Дэлхийн банк, АХБ, ОУВС, Монголбанк



### Төсвийн сектор

Монгол Улсын Засгийн газраас Ковид-19 цар тахлын улмаас үүссэн эдийн засгийн хямралаас иргэд, аж ахуйн нэгжийг хамгаалах зорилгоор татварын чөлөөлөлт, зорилтод бүлэгт чилгэсэн тэтгэмжийг нэмэгдүүлснээр 2020 онд Монгол Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 4.5 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан.

2021 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын төсвийн орлого 5.9 их наяд төгрөгт, төсвийн зарлага 6.2 их наяд төгрөгт тус тус хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 866.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Зураг 54. Төсвийн тэнцэл, тэрбум төгрөгөөр



	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021-5
Орлого	3,122	4,241	4,887	5,940	6,277	5,981	5,835	7,275	9,226	10,802	9,422	3,874
Зарлага	3,081	4,997	6,018	6,165	7,145	7,138	9,495	9,017	9,223	11,429	13,961	6,172
Тэнцэл	42	(756)	(1,131)	(225)	(868)	(1,157)	(3,660)	(1,742)	3	(628)	(4,539)	(866)



Эх сурвалж: ҮСХ

2021 оны 6 сарын 20-ны өдрийн Улсын Их Хурлаар 2021 оны төсвийн тодотголыг баталсан. Тус тодотголд, Монгол Улсын төсвийн нэгдсэн орлогыг 13.7 их наяд төгрөг, төсвийн нэгдсэн зарлагыг 15.7 их наяд төгрөг, х төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 3.7 их наяд төгрөг буюу ДНБ-ий 8.8 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай байхаар тусгасан.

### Гадаад сектор

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлого, хөрш орнуудын эдийн засгийн нөхцөл байдлаас өндөр хамааралтай буюу гадаад хүчин зүйлийн шокт мэдрэг шинж чанартай.





Үнэт цаасны танилцуулга


2020 онд гадаад худалдааны нийт бараа эргэлт 12.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6 хувиар буурсан.

Тухайлбал, экспорт 0.6 хувиар буюу 43 сая ам.доллараар, импорт 14 хувиар буюу 834 сая ам.доллараар тус тус буурсан.

Мөн эдийн засгийн гадаад худалдааны идэвхжилт буурснаар 2020 онд худалдааны тэнцэл 2.3 тэрбум ам.доллар, төлбөрийн тэнцэл 722.3 сая ам.долларын ашигтай гарсан юм.

2021 оны 5 сарын байдлаар Монгол Улсын экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 65.7 хувиар өсөж 3.3 тэрбум ам.долларт, импорт 30.6 хувиар өсөж 2.6 тэрбум ам.долларт, улмаар гадаад худалдааны тэнцэл 722.3 сая ам.долларын ашигтай гарсан. Үүнд олон улсын зах зээл дэх уул уурхайн түүхий эдийн үнэ нэмэгдсэн болон экспортын гарц нэмэгдсэн нь голчлон нөлөөлсөн.

Зураг 55. Гадаад худалдааны тэнцэл, сая ам.доллараар




Эх сурвалж: ҮСХ

БНХАУ-ын эдийн засаг эрчимтэй сэргэж, олон улсын зах зээл дэх уул уурхайн түүхий эдийн үнэ өсөж байгаа нь Монгол Улсын экспортод дунд хугацаанд эргээр нөлөөлөхөөр байна.

Тодруулбал, БНХАУ-ын эдийн засаг 2021 оны 1 дүгээр улиралд 18.3 хувиар өсөж, барилгын салбараа эрчимтэй дэмжиж байгаа тул ган, төмрийн хүдрийн эрэлт өсөж, богино хугацаанд коксжих нүүрсний эрэлт нэмэгдэх хандлагатай байна.





### Мөнгөний сектор

Дэлхийн улс орнууд Ковид-19 цар тахлаас үүдсэн эдийн засгийн хямралыг бууруулахын тулд мөнгөний зөөлөн бодлогыг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хувьд мөн адил бодлогын хүүгийн түвшнийг 5 нэгж хувиар, банкны шаардлагатай нөөцийг 4.5 нэгж хувиар бууруулж, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор репо санхүүжилтийг хэрэгжүүлж эхэлсэн.

2020 онд M2 мөнгөний нийлүүлэлт 24.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар өссөн.

2021 оны 5 сарын байдлаар мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар өсөж 26.9 их наяд төгрөгт хүрсэн. Үүнд өсөлтийн 20.3 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 9.1 нэгж хувийг төгрөгийн харилцах, 1.2 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, 1.1 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, -1.4 нэгж хувийг гадаад валютын харилцах тус тус бүрдүүлж байна.

Дотоодод Ковид-19 цар тахлын тохиолдол нэмэгдэж байгаа тул 2021 он дуустал мөнгөний зөөлөн бодлого үргэлжлэх хандлагатай байна.

Зураг 56. M2 мөнгөний нийлүүлэлт, их наяд төгрөгөөр





Эх сурвалж: Монголбанк, УСХ

Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямрал, худалдаа тээвэрлэлтийн зогсонги байдал, дотоодод хөл хорио тогтоосон зэрэг шалтгаанаас болж иргэд, аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагаа тасалдаж, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдсэн.







2020 онд банкнуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар буурч, 17 их наяд төгрөгт хүрсэн юм. Улмаар эдийн засаг аажмаар сэргэж эхэлснээр 2021 оны 5 сарын байдлаар зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар өсөж 18.1 их наяд төгрөгт хүрсэн.

**Валютын ханш**

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сүүлийн хагас жил гаруйн хугацаанд 2,850 төгрөгийн орчимд тогтвортой хадгалагдаж байна. 2021 оны эхний 5 сард гадаад валютын орох урсгал 47 хувиар нэмэгдэж, гарах урсгал 3 хувиар буурсан.

Монгол Улсын гадаад валютын нөөц тасралтгүй нэмэгдэж байгаа бөгөөд 2021 оны 5 сарын байдлаар түүхэн дээд түвшин буюу 4.9 тэрбум ам.долларт хүрлээ.

Түүнчлэн 2021 оны 6 сард Монгол Улсын Засгийн газар 2022 онд төлөгдөх Чингис бонд, 2023 онд төлөгдөх Гэрэгэ бондын нийт 1 тэрбум ам.долларын төлөлтийг бага түвшний хүүтэйгээр дахин санхүүжүүлснээр дунд хугацаанд валютын гадагшлах урсгалыг бууруулж, төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн тогтвортой байдлыг хангах суурь нөхцөл бүрдээд байна.


**Хүүний түвшин**


2021 оны 5 сарын байдлаар шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жинлэсэн дундаж хүү (ЖДХ) 6.5 хувь, валютын хадгаламжийн жинлэсэн дундаж хүү 1.6 хувьд хүрч буурлаа.

Зураг 57. Хүүний түвшин, хувиар



Эх сурвалж: Монголбанк





Шинээр олгосон төгрөгийн зээлийн жинлэсэн дундаж хүү 14.8 хувь, валютын зээлийн жинлэсэн дундаж хүү 8.5 хувьд хүрч буурсан байна.

### 3.2 Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн төлөв байдал

2021 оны 5 сард Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 3.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 47.4 хувиар, оны эхэн үеэс 22.7 хувиар тус тус өссөн. Түүнчлэн хувьцааны хоёрдогч зах зээлийн өдрийн дундаж арилжаа 623 сая төгрөгт хүрсэн нь 2020 онтой харьцуулахад 3 дахин өссөн үзүүлэлт юм.


Зураг 58. Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, тэрбум төгрөгөөр болон ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: YCX, МХБ

2021 оны 5 сард Монголын Хөрөнгийн Биржийн (МХБ) ТӨП-20 индекс оны эхэн үеэс 79 хувиар, MSE-B индекс 56 хувиар, MSE-A индекс 7 хувийн өсөлтийг үзүүлсэн.

Зураг 59. МХБ-ийн индексүүд, 2021 оны эхэн үетэй харьцуулахад




Эх сурвалж: МХБ





Үнэт цаасны танилцуулга



Сүүлийн жилүүдэд Монголын хөрөнгийн зах зээлд өндөр өгөөжтэй санхүүгийн олон төрлийн шинэлэг бүтээгдэхүүн гарч буй нь хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох сонирхлыг нэмж байна. Нөгөө талаас инфляцын өсөлтийн улмаас хадгаламжийн бодит өгөөж буурсан нь хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх сонирхлыг нэмэгдүүлж байна.

Мөн 2022 оны 6 сарын 30-ны өдрийн дотор Монгол Улсын системийн нөлөө бүхий банкууд хувьцаагаа олон нийтэд санал болгох үүрэг хүлээсэн, институциональ хөрөнгө оруулагчид нэмэгдсэн, бондын зах зээл хөгжих буй зэрэг нь цаашид хөрөнгийн зах зээлийн идэвхжилийг өсөн нэмэгдүүлэх төлөвтэй байна.

### 3.3 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл


#### Конвиниенс дэлгүүрийн үүсэл хөгжил

##### Конвиниенс дэлгүүрийн эхлэл

1927 онд Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын Даллас хотод мөс зардаг 4 компани 21 салбар дэлгүүрээ нэгтгэн Southland Ice Company компанийг үүсгэн байгуулснаар дэлхийн конвиниенс дэлгүүрийн түүх эхэлсэн гэж үздэг.

Зураг 60. Хамгийн анхны конвиниенс дэлгүүр, АНУ





Тухайн үед гэр ахуйн цахилгаан бараа, тэр дундаа хөргөгч, хөлдөөгч харахан үүсэж хөгжөөгүй байсан тул өрхүүд хүнсээ зүссэн мөсөн дунд хадгалдаг байв. Мөсний мухлаг нь хаа сайгүй байрлаж, хүнсний захуудаас илүү уртасгасан цагаар ажилладаг байсан тул энэ давуу талаа ашиглан талх, сүү, өндөг зэрэг өдөр тутмын хүнсний бүтээгдэхүүнийг нэмэлтээр борлуулж эхэлсэн нь хэрэглэгчдийн дунд түгээмэл, эрэлттэй үйлчилгээ болжээ.

Тус компани нь өглөөний 7 цагаас шөнийн 11 цаг хүртэл ажилладаг байсан тул өөрийн брэндийн нэр, таних тэмдгээ 1946 онд өөрчилсөн нь одоогийн 7-Eleven брэндийн эхлэл болжээ.

Тухайн үеийн хэрэглэгчдийн урсгал, амьдралын хэв маягт тохируулан 1963 онд 7-Eleven нь анхны 24 цагаар ажилладаг дэлгүүрээ Техас мужийн Оустин хотод туршсан нь амжилттай хэрэгжсэнээр энэ төрлийн дэлгүүрийн тоогоо нэмэгдүүлж эхэлжээ.

### **Япон Улс**

1973 онд 7-Eleven брэнд нь АНУ, Канадад нийт 5,000 гаруй салбар дэлгүүртэй болсон бөгөөд Японы Ito-Yokado корпорацад 7-Eleven брэндийг нэвтрүүлэх франчайзийн эрхийг өгснөөр Ази тивийн конвиниенс дэлгүүрийн түүх эхэлжээ.

Тухайн жилд 7-Eleven -ийн өрсөлдөгч Family Mart брэндийг Японы Seibu Retail корпорац, дараа жил нь Lawson брэндийг The Daiei Inc корпорац тус тус үүсгэн байгуулсан юм. Ингэснээр 1974 он гэхэд Японы зах зээлд 7-Eleven, Family Mart, Lawson гэсэн 3 брэндийн конвиниенс дэлгүүрийн сүлжээ өрсөлдөж эхэлсэн.



Өнөөдрийн байдлаар Японы зах зээлд дээрх 3 брэнд конвиниенс дэлгүүрийн зах зээлийг тодорхойлдог бөгөөд одоогоор Япон улсад 7-Eleven Japan 20,000 салбар, Family Mart 12,000 салбар, Lawson 11,500 салбар дэлгүүртэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

### **Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)**

Японы эдийн засгийн огцом өсөлтийн үед конвиниенс дэлгүүрүүд амжилтад хүрсэн жишгээр БНСУ-д эдийн засгийн өсөлт эрчимжсэн 1989 онд Lotte групп 7-Eleven брэндийн франчайз эрхийг, 1990 онд тухайн үеийн Bogwang Group нь Family Mart франчайз эрхийг тус тус авчээ. Харин LG групп LG25







конвениенс дэлгүүрийг зах зээлд шинээр нэвтрүүлснээр БНСУ-ын конвениенс дэлгүүрийн түүх эхэлсэн.

2005 онд LG групп LG, GS гэсэн 2 группт хуваагдаж LG25 сүлжээ нь GS25 болгон нэрээ өөрчилсөн байна. 2012 онд Family Mart-тай хийсэн франчайзийн гэрээ дуусах үед Bogwang Group (одоогийн БиЖиЭф Ритэйл) гэрээгээ сунгахгүйгээр шийдвэрлэж, өөрийн CU брэндийг шинээр зах зээлд танилцуулжээ. Өнөөдөр Солонгосын зах зээлд CU, GS25 брэндүүд тус бүр 15,000 дэлгүүртэй, 7-Eleven 9,500 дэлгүүртэйгээр өрсөлдөж байна.

### **Монгол Улс**

Премиум Групп нь 2017 онд Монгол Улсад анхны конвениенс дэлгүүрийг Сэнтрал Экспресс нэртэйгээр үүсгэн байгуулсан ба 2018 оны 8 сарыг хүртэл 3 салбар дэлгүүртэйгээр үйл ажиллагаа эрхэлж байв.

Премиум Групп нь 2018 оны 4 сарын 17-ны өдөр БиЖиЭф Ритэйл компаниас CU брэндийн мастер франчайзийн эрхийг авснаар дэлхийн жишигт нийцсэн конвениенс дэлгүүрийн сүлжээг нэвтрүүлснээр Монголын жижиглэн худалдааны салбарын хөгжлийг урагшлуулах алхам болсон.

2018 онд Улаанбаатар хотод CU, Circle K брэндийн конвениенс дэлгүүрүүд нээгдсэн бол 2021 оны 5 сард Шунхлай Групп БНСУ-ын GS25 брэндийн франчайз дэлгүүрүүдийг нээгээд байна. Одоогоор CU брэнд 127 дэлгүүр, Circle K брэнд 22 дэлгүүр, GS25 брэнд 11 дэлгүүртэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна.

### **Монгол Улсын худалдааны салбар**

Монгол Улсын худалдааны салбар нь 2020 оны байдлаар ДНБ-ийн 9 орчим хувийг эзэлдэг тэргүүлэгч салбаруудын нэг бөгөөд нийт 165.6 мянган хүн буюу ажиллах хүчний 14.7 хувийг ажлын байраар хангаж байна.

2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр Монголд нийт 94.5 мянган аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэйгээс 40 хувь нь буюу 37.8 мянга нь худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байна.





Хүснэгт 9. Худалдааны салбарын үйл ажиллагааны үзүүлэлт


Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020
Нийт аж ахуйн нэгжийн тоо	64,301	72,182	78,585	85,749	94,425	94,491
Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн тоо	24,194	27,744	30,510	33,930	37,706	37,784
Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн нийт аж ахуйн нэгжид эзлэх хувь хэмжээ	37.6%	38.4%	38.8%	39.6%	39.9%	40.0%

Эх сурвалж: ХХААХҮЯ

Худалдааны салбарын нийт орлого 2014-2020 онд жилд дунджаар (CAGR) 4.4 хувиар өсжээ. 2020 онд Ковид-19 цар тахлаас сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн хөл хорио тогтоох, дэлгүүрийн үйл ажиллагааны цагийн хуваарьт өөрчлөлт оруулах, тэмдэглэлт баяруудыг хориглох, сургууль цэцэрлэгүүдийг хаах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлснээр худалдааны салбарын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад (YoY) 6.9 хувиар буурч, 22 их наяд төгрөг болжээ.

2021 оны 5 сарын байдлаар худалдааны салбарын нийт орлого 9.4 их наяд төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21.0 хувиар өссөн байна.

Зураг 61. Худалдааны салбарын орлого, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: ҮСХ

Бүсчлэлээр нь авч үзвэл 2016 оноос өмнө худалдааны салбарын нийт орлогын 10-аас доош хувийг орон нутагт бүрдүүлдэг байсан бол сүүлийн 4 жилийн хугацаанд орон нутгийн иргэдийн худалдан авах чадвар нэмэгдэж, зах зээл өргөжсөнөөр 2020 онд тус үзүүлэлт 16 хувь болж өссөн байна.



2020 онд Улаанбаатар хотын худалдааны салбарын орлого 8.4 хувиар буурч, 18.4 их наяд төгрөгт, орон нутгийн худалдааны салбарын орлого 2.8 хувиар өсөж, 3.6 их наяд төгрөгт хүрчээ.

2021 оны 5 сарын байдлаар Улаанбаатар хотын худалдааны салбарын орлого 7.8 их наяд, орон нутгийн худалдааны салбарын орлого 1.5 их наяд төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21.8 хувь, 17.4 хувиар тус тус өссөн байна.


**Зураг 62. Худалдааны салбарын орлогын бүтэц, бүс нутгаар, их наяд төгрөгөөр болон хувь хэмжээгээр**



Эх сурвалж: YCX

Худалдааны салбарын борлуулалт нь жижиглэн болон бөөний гэсэн хоёр үндсэн сувгаар хийгддэг бөгөөд жижиглэн худалдаа нь дахин боловсруулалт хийлгүйгээр эцсийн хэрэглэгчид хүрдэг бараа бүтэгдэхүүний худалдаа багтана. Харин бөөний худалдаа нь үйлдвэрлэлийн эсвэл дараагийн шатны худалдаа юм.

2020 оны байдлаар жижиглэн худалдааны салбарын орлого 13.7 их наяд, бөөний худалдааны салбарын орлого 8.3 их наяд төгрөгөөр тус тус хэмжигдэж байна.



Зураг 63. Худалдааны салбарын борлуулалтын сувгаарх орлогын бүтэц, их наяд төгрөгөөр болон хувь хэмжээгээр



Эх сурвалж: УСХ

2021 оны 5 сарын байдлаар жижиглэн худалдааны салбарын орлого 5.8 их наяд төгрөг, бөөний худалдааны салбарын орлого 3.5 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 17.8 хувь, 26.6 хувиар тус тус өсчээ.

### Монгол Улсын жижиглэн худалдааны салбар

Жижиглэн худалдаа нь хүн амын өсөлт, өрхийн худалдан авах чадвараас шууд хамааралтай салбар бөгөөд 2014-2020 онд жилд дунджаар 9.8 хувийн хурдацтай өсөлтийг үзүүлжээ.


2020 оны байдлаар Монгол Улсад нийт 15,763 жижиглэн худалдаа эрхлэгчид үйл ажиллагаа явуулж байгаагаас 44 хувь нь Улаанбаатар хотод, 56.2 хувь нь хөдөө орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байна. Жижиглэн худалдааны салбарын 63 хувийг хүнсний дэлгүүр, 14 хувийг мухлаг, 10 хувийг төрөлжсөн барааны дэлгүүр, 1 хувийг конвениенс дэлгүүр бүрдүүлж байна. Жижиглэн худалдааны зах зээлд оролцогчдыг 3 ангилдаг. Үүнд:

#### Уламжлалт зах зээл

Уламжлалт зах зээлд худалдагч дэлгүүрийн лангуунаас хэрэглэгчтэй шууд харилцах замаар худалдаа, төлбөр тооцоог хийж гүйцэтгэдэг. Монгол Улсын уламжлалт худалдааны зах зээлд задгай зах, 8 нэрийн хүнсний дэлгүүр, мухлаг, түц зэрэг дэлгүүр багтдаг.







**Орчин үеийн зах зээл**

Орчин үеийн зах зээлд хэрэглэгч өөртөө үйлчлэн, бараа бүтээгдэхүүнээ сонгож, тэрэг болон сагсанд хийн кассад очин төлбөр тооцоогоо хийж гүйцэтгэдэг. Монгол Улсын орчин үеийн зах зээлд хайпермаркет, супермаркет, минимаркет, конвинеенс дэлгүүр болон төрөлжсөн дэлгүүр багтаж байна.

**Онлайн зах зээл**

Онлайн зах зээлд хэрэглэгч онлайн платформ ашиглан төлбөр тооцоо хийх, хүргэлтийн үйлчилгээ авах боломжтой. Монгол Улсад вэбсайт, аппликэйшн, социал групп, хуудас зэрэг платформуудаар дамжин онлайн зах зээл хөгжиж байна.

**Зураг 64. Жижиглэн худалдааны салбарын бүтэц**




Эх сурвалж: [www.ub-speeda.com](http://www.ub-speeda.com)

2020 оны 6 сарын байдлаар Монгол Улсад нийт 15,763 жижиглэн худалдаа эрхлэгч үйл ажиллагаа явуулж байгаагаас 44 хувь нь Улаанбаатар хотод, 56.2 хувь нь хөдөө орон нутагт байна.

Жижиглэн худалдааны салбарын 63 хувийг хүнсний дэлгүүр, 14 хувийг мухлаг, 10 хувийг төрөлжсөн барааны дэлгүүр, 1 хувийг конвинеенс дэлгүүр бүрдүүлдэг.





Хүснэгт 10. Монгол Улсын жижиглэн худалдаа эрхлэгчдийн тоо, 2020 оны 6 сар

№	Ангилал	Дэлгүүрийн төрөл	Тоо ширхэг		Нийт
			Улаанбаатар хот	Орон нутаг	
1	Том	Хайпермаркет	33	10	43
2	Дунд	Супермаркет	142	175	317
3	Багавтар	Минимаркет	670	574	1,244
4		Конвиниенс дэлгүүр	84	70	154
5		Хүнсний дэлгүүр	3,638	6,332	9,970
6	Бага	ШТС-ын дэргэдэх дэлгүүр	30	69	99
7		Мухлаг	1,669	582	2,251
		<b>Нийт</b>	<b>6,266</b>	<b>7,812</b>	<b>14,078</b>

Эх сурвалж: ХХААХҮЯ

Жижиглэн худалдааны салбарын том ангилалд 2,000м<sup>2</sup>-аас дээш талбайтай E-mart, Номин, Миний дэлгүүр зэрэг 33 хайпермаркет, дунд ангилалд 501-2,000м<sup>2</sup> хүртэлх талбайтай Номин, Сансар, Оргил зэрэг 142 супермаркет Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. Харин 500-аас доош м<sup>2</sup> талбайтай 6,611 худалдааны суваг Улаанбаатар хотод байгаагаас 8 нэрийн хүнсний дэлгүүр 3,638 ширхэг, мухлаг 1,669 ширхэг тус тус байна.

### Жижиглэн худалдааны салбарын цаашдын төлөв

Хэрэглэгч нь тодорхой худалдан авалтын дадал зуршилтай байдаг. 2020 онд цар тахлаас үүдэлтэйгээр хүмүүс гэрээсээ ажиллаж, хичээллэх болсноор худалдан авалтын хандлага нь өөрчлөгдөж үүнийг дагаад жижиглэн худалдааны салбарын чиг хандлага хурдацтай шинэчлэгдэж байна. Цаашид онлайн худалдаа нэмэгдэх төлөвтэй байгаа бол урамшууллын систем өндөр нөлөөтэй хэвээр байх хандлагатай байгаа юм.


### Худалдан авалтын зан төлөвийн өөрчлөлт

Дэлхийн шилдэг менежментийн консалтинг байгууллага МкКинзи (McKinsey)-гаас хийсэн судалгаагаар цар тахлын улмаас дэлхийн жижиглэн худалдааны салбараар үйлчлүүлэгчдийн 60 хувийнх нь худалдан авалтын зан төлөв өөрчлөгджээ.

Улс орнуудаар нь авч үзвэл Энэтхэг улсын хэрэглэгчдийн 91 хувь, БНХАУ-ын хэрэглэгчдийн 82 хувь, АНУ-ын хэрэглэгчдийн 75 хувьд нь зан төлөвийн өөрчлөлт орсон бол Япон улсад хөл хорио тогтоогоогүй учир хэрэглэгчдийн 33 хувьд нь л өөрчлөлт орсон байна.



Зураг 65. Хэрэглээний зан төлөвт өөрчлөлт орсон хэрэглэгчдийн хувь, улс орнуудаар



Эх сурвалж: МкКинзигийн судалгаа

Нийт хэрэглэгчдийн 20 гаруй хувь нь хөл хорионы өмнө үйлчлүүлдэг байсан дэлгүүр, брэндээсээ өөрийг сонголт хийх болжээ. Үүнд үнэ, дэлгүүрийн ая тухтай байдал болон бүтээгдэхүүний бэлэн байдал (availability) нөлөөлсөн байна.

### Онлайн худалдаа


Цар тахалтай холбоотойгоор хэрэглэгчид онлайнар худалдан авах хандлага нэмэгдэж байна. Оракл (Oracle)-ийн жижиглэн худалдааны салбарт хийсэн судалгаанд цар тахлаас өмнө дэлхийн нийт хэрэглэгчдийн 49 хувь нь онлайнар хүнсний худалдан авалт хийж үзсэн байсан бол цар тахлын дараагаар 77 хувь болж өсжээ. Цар тахлын нөхцөл байдал сайжирсан ч эдгээр хэрэглэгчийн 92 хувь цаашид үргэлжлүүлэн онлайн худалдан авалт хийхээр байна.

Хүснэгт 11. Цар тахал ба хэрэглэгчдийн онлайн худалдан авалтын хандлага

	Цар тахлын үеэр хэрэглэгчдийн онлайнар хүнсний худалдан авалт хийсэн хувь	Цар тахлаас өмнө хэрэглэгчдийн онлайнар хүнсний худалдан авалт хийсэн хувь	Онлайн худалдан авалтыг илүүд үзэж буй хэрэглэгчдийн хувь	Дэлгүүрт очиж үйлчлүүлэхийг илүүд үзэж буй хэрэглэгчдийн хувь
<b>Дэлхийн дундаж</b>	<b>67%</b>	<b>49%</b>	<b>41%</b>	<b>20%</b>
БНХАУ	90%	89%	72%	18%
АНУ	66%	41%	37%	16%
Бразил	66%	40%	46%	20%
Мексик	66%	38%	41%	25%
АНЭУ	81%	62%	46%	35%
Франц	52%	52%	40%	18%

Эх сурвалж: Оракл-ийн судалгаа





Өөрөөр хэлбэл цар тахлын нөхцөл байдал нь жижиглэн худалдааны хүртээмжийг нэмэгдүүлж цаашид дэлхийн хэмжээнд онлайн худалдаа өсөх суурь нөхцөл болж байна.

### Урамшууллын систем

Лоялти онооны урамшууллын систем нь нийт хэрэглэгчдийн 88 хувьд ямар нэгэн байдлаар нөлөөлдөг бөгөөд 30 хувь нь онооны урамшууллын системтэй дэлгүүрүүдээр үйлчлүүлдэг байна. Цар тахлын өмнө болон дараагаар тус үзүүлэлтэд өөрчлөлт ороогүй байна.

Зураг 66. Онооны урамшууллын системийн худалдан авалтад нөлөөлөх хувь



Эх сурвалж: Ораклын судалгаа

Улс орнуудаар авч үзвэл урамшууллын систем нь АНУ-ын хэрэглэгчдийн 91 хувь, БНХАУ-ын хэрэглэгчдийн 86 хувь, Арабын Нэгдсэн Эмират Улс (АНЭУ)-ын хэрэглэгчдийн 86 хувийн худалдан авалтын шийдвэрт нөлөөлж байна. Иймд онооны урамшууллын систем нь харилцагчдад чухал ач холбогдолтой.

### Олон улсын конвениенс дэлгүүрийн зах зээл

Олон улсын конвениенс дэлгүүрийн зах зээл нь 3 их наяд гаруй ам.доллараар хэмжигдэж байна. Улс орнуудын конвениенс дэлгүүрийн зах зээлийн өсөлт нь эдийн засгийн өсөлт, хотжилттой шууд хамааралтай тул БНХАУ зэрэг хурдацтай хөгжиж буй орнуудад өндөр өсөлттэй байна.

Харьцангуй тогтворжсон зах зээлд буюу Япон улсад конвениенс дэлгүүрийн салбарын орлого жилд дунджаар 2-4 хувиар өсөж, 12.2 их наяд иен буюу 314.15 их наяд төгрөгөөр хэмжигдэж байна. Мөн Тайван улсад нийт конвениенс дэлгүүрийн орлого жилд дунджаар 3-6 хувиар тогтвортой өсөж байна.

Харин зах зээлийн өсөлтийн үе шатаас тогтворжилтын үе шат руу шилжиж буй БНСУ-д 2020 оны байдлаар салбарын орлого 26.5 их






наяд вон буюу 60.95 их наяд төгрөгт хүрсэн байна. БНСУ-ын БиЖиЭф Ритэйл (CU brand) болон ЖиЭс Ритэйл (GS Retail, GS25 brand) компаниуд тус бүр 15 мянга орчим салбартайгаар зах зээлд тэргүүлдэг.

**Хүснэгт 12. Олон улсын конвiniенс дэлгүүрийн салбарын орлогын өсөлт, хувиар**

	2016	2017	2018	2019	Дундаж
БНСУ	18.4%	14.2%	9.8%	5.2%	11.9%
Индонези	12.5%	11.1%	10.0%	9.1%	10.7%
Тайван	0.0%	2.8%	6.3%	2.8%	3.0%
Япон	4.1%	2.6%	2.0%	1.7%	2.6%

Эх сурвалж: Statista.com


**Зураг 67. Олон улсын конвiniенс дэлгүүрийн салбарын орлого**




Эх сурвалж: Statista.com

Япон улсад конвiniенс дэлгүүрийн үйл ажиллагаа 1970-аад онд эхэлсэн бөгөөд 50 жилийн дараа ч орлого нь өсөлттэй хэвээр байна. Конвiniенс дэлгүүрийн зах зээл Тайван улсад 1980-аад оноос хойш 40 жил, БНСУ-д 1990-ээд оноос хойш 30 жил, Индонези улсад 2010-аад оноос хойш 11 жил тус тус хөгжиж, жил бүр өссөөр байна.





Зураг 68. Олон улсын конвениенс дэлгүүрийн салбарын-бизнесийн насжилт




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн судалгаа

Аливаа салбарын амьдралын мөчлөг нь хөгжлийн, өсөлтийн, тогтворжилтын болон уналтын гэсэн дөрвөн үе шаттай байдаг ч конвениенс дэлгүүрийн салбарт тогтворжих үе шат үргэлжилсээр байгаа нь энэхүү бизнес нь амьдралын урт мөчлөгтэй болохыг харуулж байна.

### Монгол Улсын конвениенс дэлгүүрийн зах зээл

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын анхны конвениенс дэлгүүрийг 2017 онд байгуулсан. Өдгөө жижиглэн худалдааны салбарт конвениенс дэлгүүрийн зах зээл нь хамгийн хурдтай өсөж байна.

Зураг 69. Конвениенс дэлгүүрийн зах зээлд оролцогчид




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн судалгаа



Конвiniенс дэлгүүрийн үүсэл хөгжлөөс харвал Япон, БНСУ-ын зах зээлд богино хугацаанд олон шинэ конвiniенс дэлгүүрийн брэндүүд нэвтэрч, зах зээлд байр сууриа олохын төлөөх ширүүн өрсөлдөө өрнөсөн түүхтэй. Монгол Улсын конвiniенс дэлгүүрийн зах зээлд ч мөн адил энэ түүх давтагдахаар харагдаж байна.

Зураг 70. Конвiniенс дэлгүүрийн салбарын тоо





Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн судалгаа


2021 оны эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хотод нийт 5 брэндийн 172 конвiniенс дэлгүүр үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс Үнэт цаас гаргагчийн мастер франчайзийн эрхээр эзэмшиж буй CU конвiniенс сүлжээ дэлгүүр 2018 оноос тасралтгүй өсөж 127 салбар дэлгүүрийг шинээр нээсэн байна. Үүний дараа Circle K брэнд 22, Eсоexpress брэнд 12, Vpoint брэнд 0, GS25 брэнд 11 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Конвiniенс дэлгүүрийн салбар нь Улаанбаатар хотын нийт жижиглэн худалдааны багавтар ангиллын дэлгүүрийн тооны 1 хувийг, бага болон багавтар ангиллын дэлгүүрийн тооны 11 хувийг тус тус эзэлж байна.





Зураг 71. Багавтар ангиллын дэлгүүрийн зах зээлийн бүтэц



Зураг 72. Бага болон багавтар ангиллын дэлгүүрийн бүтэц



Эх сурвалж: ХХААХҮ яам

### Монгол Улсын нийтийн хоолны салбар

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын дунджаар 31.7 хувийг хоолны борлуулалт бүрдүүлж, Үнэт цаас гаргагчийн охин компани болох Премиум Дистрибьюшн нь хоол үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг тул нийтийн хоолны үйлчилгээний салбарыг авч үзэх нь зүйтэй.


Монгол Улсын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт нийт 8,500 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдгаас 47 хувь нь орон нутагт, 53 хувь нь Улаанбаатар хотод байршиж байна.

Үүнд 2,369 цайны газар, 1,570 ресторан, 1,331 бар, 400 кафе, 85 түргэн хоолны газар, эмнэлэг сувиллын 544, сургуулийн 1,600, дотуур байрны 283 зэрэг нийт 8,467 хоолны газар тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.





Зураг 73. Монгол Улсын нийтийн хоолны салбарын орлого, тэрбум төгрөгөөр




Эх сурвалж: ҮСХ

Улсын хэмжээнд нийтийн хоолны салбар 2014 оноос 2020 оны хооронд 201 тэрбум төгрөгөөс 451 тэрбум төгрөгт хүрч, жилд дунджаар 14.3 хувиар өссөн. Мөн оны байдлаар Монгол Улсын нийтийн хоолны салбарын орлого өмнөх 2019 оноос 7 хувиар буурч, 451 тэрбум төгрөгөөр Улаанбаатар хотын нийтийн хоолны салбарын орлого өмнөх оноос 7.2 хувиар буурч, 383 тэрбум төгрөгөөр тус тус хэмжигдэж байна.



Улаанбаатар хотын нийтийн хоолны салбарын орлого 2014 оноос 2020 оны хооронд 174 тэрбум төгрөгөөс 383 тэрбум төгрөгт хүрч, жилд дунджаар 14 хувиар өссөн.

Зураг 74. Улаанбаатар хотын нийтийн хоолны салбарын орлого, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: ҮСХ

Улаанбаатар хотын хэмжээнд 1,021 ресторан, 945 бар, 1,297 цайны газар, 225 кафе болон кофе шоп, 2,100 архи согтууруулах



төрлийн ундааны тусгай зөвшөөрөлтэй хоолны газар, 950 гаруй гал тогоо бүхий сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж ажиллаж байна.

**Хүснэгт 13. Нийтийн хоолны зах зээлд оролцогчдын тоо**

Үйлчилгээний төрөл	Үйлчилгээний байгууллагын тоо
Ресторан	
Зочид буудлын дэргэдэх ресторан	1,021
Амралтын газрын дэргэдэх ресторан	
Кафе	225
Кофе шоп	
Бар (караоке, пиво)	945
Бусад	1,297
<b>Нийт</b>	<b>3,488</b>

Эх сурвалж: ХХААХҮ яам

### 3.4 Зах зээлийн багтаамж

Үнэт цаас гаргагч нь жижиглэн худалдааны зах зээл болон нийтийн хоолны салбарт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд орлогын түвшинд болон сүлжээ дэлгүүрийн салбарын тоон багтаамжийн түвшинд зах зээлийн хэмжээг таамаглалаа.

Орлогын түвшинд жижиглэн худалдааны зах зээл болон нийтийн хоолны салбарын 2020 оны гүйцэтгэлд суурилж зах зээлийн багтаамжийг тооцоолсноос гадна өрхийн хэрэглээний мэдээлэлд суурилж хоёр аргаар тооцож үзэв. Салбарын тоон багтаамжийн хэмжээг хүн амын нягтаршилд суурилсан тооцооллоор авч үзлээ.

#### Зах зээлийн орлогын багтаамж

##### Орлогод суурилсан арга

2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Монгол Улсын эдийн засаг 5.3 хувиар агшиж, нэрлэсэн ДНБ 37.0 их наяд төгрөг болжээ. Худалдааны салбар нь эдийн засгийн нөхцөл байдал, хүн амын худалдан авах чадвараас шууд хамааралтай.

Тухайлбал, Монгол Улсын худалдааны салбарын орлого болон нэрлэсэн ДНБ-ий 2005.1-2021.1 хүртэлх 65 улирлын өгөгдөлд суурилсан корреляцийн түвшнийг тодорхойлоход 0.98 буюу өндөр



ээрэг хамааралтай байна. Түүнчлэн Улаанбаатар хотын худалдааны салбарын орлоготой дээрхтэй ижил харьцуулалт хийхэд корреляцийн түвшин 0.97 буюу мөн адил өндөр эерэг хамааралтай байна.

Улаанбаатар хотын худалдааны салбарын орлого эдийн засгийн өсөлттэй нягт хамааралтай байгаа учир 2021-2026 оны Улаанбаатар хотын жижиглэн худалдааны зах зээлийн болон нийтийн хоолны салбарын өсөлтийг эдийн засаг судалгааны институтүүдийн гаргасан Монгол улсын бодит эдийн засгийн өсөлт болон инфляцын түвшний таамаглалд үндэслэн тодорхойллоо.

**Хүснэгт 14. Эдийн засгийн өсөлт, инфляцын төсөөлөл, хувиар**

	2021Т	2022Т	2023Т	2024Т	2025Т	2026Т
<b>Бодит ДНБ өсөлт</b>						
Дэлхийн банк	4.3%	5.4%				
АХБ	4.8%	5.7%				
ОУВС	5.0%	7.5%	6.0%	5.0%	5.0%	5.0%
<b>Дундаж</b>	<b>4.7%</b>	<b>6.2%</b>	<b>6.0%</b>	<b>5.0%</b>	<b>5.0%</b>	<b>5.0%</b>
<b>Инфляцын түвшин</b>						
Монголбанк	7.2%	5.8%	6.0%	6.0%	6.0%	6.0%
АХБ	6.9%	8.5%				
ОУВС	5.4%	6.4%	6.1%	6.0%	6.0%	6.0%
<b>Дундаж</b>	<b>6.5%</b>	<b>6.9%</b>	<b>6.1%</b>	<b>6.0%</b>	<b>6.0%</b>	<b>6.0%</b>

Эх сурвалж: Дэлхийн банк, АХБ, ОУВС, Монголбанк (Т = таамаглал)


**Хүснэгт 15. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, хувиар**

	2021Т	2022Т	2023Т	2024Т	2025Т	2026Т
Нэрлэсэн ДНБ өсөлт	11.5%	12.3%	12.4%	10.3%	10.3%	10.3%

Эх сурвалж: Голомт Капитал ҮЦК-ийн тооцоолол

2020 оны байдлаар Улаанбаатар хотын жижиглэн худалдааны зах зээл 11.4 их наяд төгрөг, нийтийн хоолны зах зээл 383 тэрбум төгрөгөөр тус тус хэмжигдэж байна.

Зураг 75. Улаанбаатар хотын жижиглэн худалдааны зах зээлийн багтаамж, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Голомт Капитал ҮЦК-ийн тооцоолол

Дээрх тооцооллоос үзэхэд 2026 онд Улаанбаатар хотын жижиглэн худалдааны салбарын орлого 21.5 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна. Энэ нь 2020-2026 оны хооронд жилд дунджаар 11.2 хувиар өсөж буй үзүүлэлт юм.

Зураг 76. Улаанбаатар хотын нийтийн хоолны зах зээлийн багтаамж, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Голомт Капитал ҮЦК-ийн тооцоолол



Харин Улаанбаатар хотын нийтийн хоолны зах зээлийн хувьд 2026 он гэхэд 721 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна.

**Өрхийн хэрэглээнд суурилсан арга**

2020 оны байдлаар Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 37.0 их наяд төгрөгөөр хэмжигдэж байгаагаас 57 хувийг өрхийн







Үнэт цаасны танилцуулга

хэрэглээ, 15 хувийг Засгийн газрын хэрэглээ, 28 хувийг үндсэн хөрөнгийн хуримтлал тус тус бүрдүүлж байна.

Зураг 77. ДНБ-ний зарцуулалтын аргаарх задаргаа, 2010 оны зэрэгцүүлэх үнээр



Эх сурвалж: ҮСХ

2020 оны байдлаар Монгол Улсын ДНБ 37.3 их наяд төгрөг ба Улаанбаатар хотын ДНБ үүний 65.6 хувь буюу 24.3 их наяд төгрөгөөр хэмжигдэж байна. Улаанбаатар хотын ДНБ-ийг эцсийн ашиглалтын аргаар тооцсон мэдээлэл байхгүй тул улсын ДНБ-д эзлэх өрхийн хэрэглээний хувь хэмжээг нийцтэй гэж үзэн тооцооллолд ашиглав. Үүнээс үзвэл 2020 оны Улаанбаатар хотын өрхийн хэрэглээ 13.1 их наяд төгрөгөөр хэмжигдэж байна.

Хүснэгт 16. ДНБ ба өрхийн хэрэглээ, их наяд төгрөгөөр

	2014	2015	2016	2017	2018	2019	2020
ДНБ	22.2	22.9	23.9	27.9	32.4	37.3	37.0
УБ хотын ДНБ	14.1	14.7	15.7	18.3	21.8	25.2	24.3
УБ өрхийн нийт хэрэглээ	7.5	8.1	8.1	9.2	11.0	12.7	13.1

	2021T	2022T	2023T	2024T	2025T	2026T
ДНБ	41.4	46.7	52.6	58.5	65.1	72.5
УБ хотын ДНБ	27.1	30.7	34.5	38.4	42.7	47.5
УБ өрхийн нийт хэрэглээ	14.2	16.0	18.0	20.0	22.3	24.8

Эх сурвалж: ҮСХ, Голомт Капитал ҮЦК тооцоолол



Зураг 78. Улаанбаатар хотын өрхийн нийт хэрэглээ, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: YCX, Голомт Капитал YЦК тооцоолол

Дээрх тооцооллын дагуу 2026 онд Улаанбаатар хотын өрхийн хэрэглээ 24.8 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна. Энэ нь 2020-2026 оны хооронд жилд дунджаар 10.4 хувиар өсөж буй үзүүлэлт юм.

### Зах зээлийн орлогын багтаамж

Орлогод суурилсан арга болон өрхийн хэрэглээнд суурилсан аргын хүрээнд жижиглэн худалдаа болон нийтийн хоолны зах зээл 2020 оны байдлаар 12.6 их наяд төгрөгөөр хэмжигдэж, 2026 онд 23.9 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна.


2020 онд Үнэт цаас гаргагч нь 45.3 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь тус зах зээлийн 0.4 хувийг бүрдүүлж байна.

### Хүснэгт 17. Хөгжингүй болон хөгжиж буй орны жижиглэн худалдааны зах зээлийн бүтэц

	Хөгжингүй орны жижиглэн худалдааны салбарын бүтэц	Хөгжиж буй орны жижиглэн худалдааны салбарын бүтэц
Том супермаркет	35%	13%
Хайпермаркет	30%	12%
Конвиниенс дэлгүүр	15%	3%
Жижиг супермаркет	7%	14%
Эмийн сан	5%	7%
Хямдралын дэлгүүр	5%	2%
Бусад	2%	8%
Жижиглэн худалдааны дэлгүүр	1%	38%
ТҮЦ	0%	2%
Төрөлжсөн дэлгүүр	0%	1%

Эх сурвалж: www.ub-speeda.com





Олон улсын жишгийн дагуу конвениенс дэлгүүр нь хөгжингүй орнуудад жижиглэнгийн худалдааны салбарын 15 хувийг, хөгжиж буй орнуудын хувьд 3 хувийг тус тус эзэлдэг байна.

Дээрх үзүүлэлтээс харвал бусад улс орны жишгийн дагуу жижиглэн худалдааны салбарт эзлэх конвениенс дэлгүүрийн байр суурь цаашид өргөжин тэлэх боломжтой харагдаж байна.

### Салбарын тоон багтаамж

Хүн амын нягтаршилд суурилсан зах зээлийн багтаамж

Хүн амын нягтаршилд суурилсан аргын хүрээнд 2020 оны байдлаарх Улаанбаатар хотод бүртгэлтэй (Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа эрхэлдэггүй Багахангай, Багануур, Налайх дүүргийн хүн амыг хасч тооцсон) 1,426,645 хүн 2020 оны 6 сарын байдлаарх 84 конвениенс дэлгүүрийн тоонд харьцуулж үзэхэд нэг конвениенс дэлгүүрт 17,847 хүн, 2021 оны 6 сарын байдлаар үйл ажиллагаа явуулж буй 172 конвениенс дэлгүүрийн тоонд харьцуулж үзэхэд нэг конвениенс дэлгүүрт 8,294 хүн ногдож байна.

Харин нэг хайпермаркетад 45,428 хүн, нэг супермаркетад 10,557 хүн, нэг минимаркетад 2,238 хүн, 8 нэрийн хүнсний нэг дэлгүүрт 412 хүн тус тус ногдож байна.


#### Хүснэгт 18. Улаанбаатар хотын нэг дэлгүүрт ногдох хүн амын тоо

УБ хүн амын тоо	Дэлгүүрийн тоо	Нэг дэлгүүрт ногдох хүн ам
Хайпермаркет +	33	45,428
Супермаркет +	142	10,557
Минимаркет +	670	2,238
Конвениенс дэлгүүр	84	17,847
Хүнсний дэлгүүр	3,638	412
ШТС-ын дэргэдэх дэлгүүр	30	49,971
Мухлаг	1,669	898

Эх сурвалж: ХХААХҮЯ, Голomt Капитал ҮЦК-ийн тооцоолол

Бусад Азийн орнуудын жишгээс харахад 2012 оны байдлаар нэг конвениенс дэлгүүрт дунджаар 2,340 хүн ногдож байсан бол 2018 онд 1,891 болсон болж, конвениенс дэлгүүрийн тоо нэмэгдэж нэг дэлгүүрт ногдох хүн амын нягтаршил нэмэгджээ.





Зураг 79. Олон улсын нэг конвниенс дэлгүүрт ногдох хүн амын тоо



Эх сурвалж: [www.ub-speeda.com](http://www.ub-speeda.com)

Улаанбаатар хотын Багахангай, Багануур, Налайх дүүргийн хүн амыг хасаж тооцсон 1,426,645 хүн амыг дээрх үзүүлэлттэй харьцуулан тооцсон зах зээлийн багтаамж 754 дэлгүүр буюу жижиглэн худалдааны зах зээлийн 12 хувийг эзлэх багтаамжтай байна.

### 3.5 Дунд хугацааны стратеги

Үнэт цаас гаргагч нь хэрэглэгчийн хувьсан өөрчлөгдөж буй амьдралын хэв маягт тохирсон ая тухтай, түргэн шуурхай өглөөний цай, өдрийн хоол, хүнс болон бусад өдөр тутмын үйлчилгээг нэг дороос, хамгийн ойроос авах боломжийг бүрдүүлж байна.

Цаашид илүү ойр байршиж, илүү хялбар, ухаалаг бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхээр зорьж байна.


Энэхүү зорилтдоо хүрэхийн тулд Үнэт цаас гаргагч нь дараах 5 стратегийг дунд хугацаанд хэрэгжүүлнэ.

#### Зах зээлд давамгайлах стратеги

Конвниенс дэлгүүрийн бизнест салбар дэлгүүрийн тоог нэмэх нь чухал бөгөөд борлуулалтаа өсгөн, зах зээлд нөлөөлөх хүчээ нэмж, тэр хэмжээгээр худалдан авалтын өртгөө бууруулснаар ашиг нэмэгдэх (economies of scale) үр шимтэй.







Үнэт цаасны танилцуулга

Үүнийг дагаад Үнэт цаас гаргагчийн хувьд брэндийн нэр хүнд өсөх, нийлүүлэлтийн тасралтгүй байдал сайжрах, чадварлаг ажилтнуудыг татах давуу талтай. Нөгөө талаас хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, ажил, гэрт нь ойртох зэргээр үйлчлүүлэхэд илүү хялбар болж өдөр тутмын амьдралд нь үнэ цэн бий болгох юм.


Иймд Үнэт цаас гаргагч нь аль болох олон салбар дэлгүүрийг хамгийн богино хугацаанд нээх стратегийг чухалчилдаг бөгөөд үйлчлүүлэгчид хамгийн хэрэгцээтэй байршлуудад нээхийг зорьдог.

Шинэ байршилд дэлгүүр нээхдээ БНСУ-ын CU франчайзийн туршлагад тулгуурласан шийдвэрийг гаргадаг. Конвиниенс дэлгүүрийн хэрэглэгчид нь ихэвчлэн завгүй, идэвхтэй амьдралын хэв маягтай хүмүүс байдаг бөгөөд 3-5 минутын зай дотор байрших нь нэн чухал байдаг.

2021 оны 6 сарын байдлаар Үнэт цаас гаргагч нь Улаанбаатар хотын хамгийн хөл хөдөлгөөн, нягтаршил ихтэй гол бүсүүдэд 127 салбар дэлгүүрээ байгуулаад байна. CU дэлгүүрийн Улаанбаатар хот дахь дахин давтагдашгүй, онцгой байршлуудаас дурдвал:

1. Шангри-Ла Төв – Улаанбаатар хотын хамгийн өндөр зэрэглэлийн худалдааны төвд конвиниенс дэлгүүрийн цор ганц онцгой эрхтэйгээр байршсан
2. Гранд оффис – Улаанбаатар хотын хамгийн өндөр нягтаршилтай оффисийн бүст байршсан
3. Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал (NUBIA) – Монгол Улсын агаарын тээврийн гол зангилаа цэг, Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудалд конвиниенс дэлгүүрийн ганц онцгой эрхтэйгээр байршсан
4. Энхтайваны гүүрний урд байрлах Петровис ШТС салбар – Улаанбаатар хотын төвд байрлах хамгийн эрэлттэй ШТС-д байршсан
5. Элизабет хотхон – Монгол Улсын хамгийн их хүн амын нягтаршилтай орон сууцны бүсийн хамгийн их хөдөлгөөний эрчимтэй байршилд байршсан
6. П.Н.Шастины нэрэмжит Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг – Монгол Улсын хамгийн олон үйлчлүүлэгчтэй эмнэлэгт байршсан





## 7. Улаанбаатар хотын хамгийн захын салбарууд

- a. Баруун зүгт – 22-н товчоо Петровис ШТС
- b. Зүүн зүгт –Хуучин Баянзүрхийн товчоо Петровис ШТС
- c. Урд зүгт – Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал (NUBIA)
- d. Хойд зүгт – Pro One оффис

Сүүлийн 3 жилийн хугацаанд 127 салбар дэлгүүрийг шинээр байгуулах явцдаа Улаанбаатар хотын ажил хэргийн, орон сууцны, худалдаа, үйлчилгээний бүсүүд зорчигч тээврийн зангилаа цэгүүдийг судалж, конвينيенс дэлгүүрийн хэрэгцээ хамгийн өндөр байх магадлалтай байршлуудыг тогтоогоод байна. Тус судалгаанд үндэслэн цаашид шинээр 240 гаруй CU конвينيенс дэлгүүрийг борлуулалт хамгийн өндөр байх боломжтой байршлуудад байгуулахыг зорино.

Борлуулалтын боломж өндөр байршлууд нь эрэлт ихтэй байдаг тул Үнэт цаас гаргагч нь өрсөлдөгчдөөсөө түрүүлж тухайн байршлуудад CU дэлгүүрээ нээх шаардлагатай. Иймд 2023 оны төгсгөлд нийт 360 байршилд өрсөлдөөнөөс өрсөж CU дэлгүүрийг байгуулахыг зорьж байна.

## Босоо интеграцын стратеги


CU конвينيенс дэлгүүрийн богино хугацааны хурдацтай тэлэлтийн хүрээнд стандарт шаардлагыг нэгэн жигд барих, бүтээгдэхүүн, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах нь бизнесийн стратегийн хувьд өндөр ач холбогдолтой.

Үүнтэй холбоотойгоор сүүлийн 3 жилийн хугацаанд [127] дэлгүүрийг байгуулахдаа түгээлтийн төв, хоолны үйлдвэр, мэдээлэл технологийн цогц систем болох үндсэн 3 дэд бүтцийг шинээр байгуулан босоо интеграцын стратегийг (vertical integration strategy) баримтлан ажиллаж байна.

## Түгээлтийн дэд бүтэц

Үнэт цаас гаргагч нь босоо интеграцын стратегийн хүрээнд бараа бүтээгдэхүүнийг хэвийн температурын болон хүйтэн хэлхээт түгээлтийн төвүүдээр дамжуулан, автозамын ачаалал, нийлүүлэгчээс бараа хүлээн авах хуваарь болон дэлгүүрийн ачаалалтай уялдуулан төлөвлөж хүргэх процесс бүхий түгээлтийн дэд бүтцийг бүрдүүлээд байна.





Үнэт цаасны танилцуулга



### **Хоолны үйлдвэр**

Мөн чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлын өндөр шаардлагыг хангасан 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр салбар дэлгүүрүүдийг хангаж буй хоолны үйлдвэрийг ашиглалтад оруулаад байна.

### **Цогц мэдээллийн систем**

CU конвينيенс сүлжээний түвшинд өдөр тутмын худалдан авалт, үйлдвэрлэл, түгээлт, маркетинг, борлуулалтын үйл ажиллагааг Microsoft Dynamics NAV ERP дээр суурилсан LS Retail NAV худалдааны цогц мэдээллийн системээр нэгтгэн удирдаж байна.

Цаашид хурдацтай тэлэх салбар дэлгүүрийн бүтээгдэхүүн үйлчилгээний тасралтгүй бэлэн байдлыг хангах хүчин чадал бүхий түгээлт, хоол үйлдвэрлэл, худалдааны цогц мэдээллийн системийн дэд бүтцийн өргөтгөл, шинэчлэл сайжруулалтыг тасралтгүй хийнэ.

### **Бүтээгдэхүүнээр ялгарах стратеги**

Конвينيенс дэлгүүрийн зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн, хэрэглэгчид өдөр тутамд шаардлагатай, илүү үнэ цэн өгсөн үйлчилгээг тасралтгүй нэвтрүүлж орчин тойрныхоо нийтийн үйлчилгээний төв болох замаар өрсөлдөөнд ялгардаг.

CU конвينيенс дэлгүүр нь бүтээгдэхүүний ялгарал, шинэлэг, тренд байдлыг бий болгохын тулд бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг тогтмол шинэчилж байна.


### **Нэрийн бүтээгдэхүүн**

GET, CU Eats, HEYROO зэрэг брэндийн зөвхөн CU конвينيенс дэлгүүрээр борлуулагддаг нэрийн бүтээгдэхүүн нь өдөр тутмын үнэнч хэрэглэгчийг бий болгох чухал үүрэгтэй юм. Нэрийн бүтээгдэхүүнүүд нь борлуулалтын хэмжээ болон ахиуц ашгийн хувь хэмжээ өндөр байдаг тул цаашид нэрийн бүтээгдэхүүнийг тогтмол хөгжүүлэх шаардлагатай.

### **Онцгой эрхтэйгээр борлуулдаг бүтээгдэхүүн**

CU-тэй зайрмаг, iBerry жимсний шүүс, Фрэшбокс сэндвич зэрэг тодорхой нийлүүлэгч, үйлдвэрлэгчидтэй хамтран зарим брэнд,





нэр төрлийн барааг зах зээлд онцгой эрхтэйгээр борлуулдаг. Ингэснээр дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих, тэдний бүтээгдэхүүнийг олон нийтэд таниулахаас гадна хэрэглэгчид CU брэндийн онцлог, давуу талыг шингээсэн цоо шинэ мэдрэмж, үнэ цэнийг хүргэх чухал үүрэгтэй тул цаашид үйлдвэрлэгчидтэй хамтран бүтээгдэхүүн хөгжүүлэх нь Үнэт цаас гаргагчийн хувьд стратегийн чухал ач холбогдолтой.

### ***Импортын бүтээгдэхүүн***

Монголын зах зээлд хараахан нэвтрээгүй, Ази, Европ, Америкийн конвинеенс дэлгүүрт тренд болж буй, Монголын хэрэглэгчид тохирох бүтээгдэхүүнийг илрүүлж, тэдгээрийг импортлон үйлчлүүлэгчдэдээ санал болгодог.

Цаашид импортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний шинэлэг байдлыг өсгөхөөр ажиллаж байна.

### ***Тренд бүтээгдэхүүн***

Худалдааны зах зээлд шинээр нэвтэрч буй, өсөлтийн өндөр боломжтой бүтээгдэхүүнийг нээн илрүүлж, түрүүлж нэвтрүүлэх нь шинэ үнэ цэнийг хэрэглэгчид хүргэх нь Үнэт цаас гаргагчийн хувьд чухал ач холбогдолтой.

Өнгөрсөн 3 жилд CU конвинеенс дэлгүүрийн хэмжээнд нийт 11 мянга гаруй шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэн бөгөөд 2021 оны эхний 6 сард нийт 1,943 нэр төрлийн шинэ бүтээгдэхүүн сүлжээнд нэвтрүүлсэн нь нийт борлуулалтын 20.4 хувийг эзэлж байна. Цаашид долоо хоног бүр шинэлэг тренд бүтээгдэхүүнийг сүлжээнд нэвтрүүлэн үйлчлүүлэгчдэдээ татах төлөвлөгөөтэй ажиллаж байна.


### ***Үйлчилгээний нэгдсэн төв***

Япон, БНСУ, Тайван зэрэг конвинеенс дэлгүүр өндөр хөгжсөн орнуудад хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралд хэрэгцээтэй үйлчилгээг үзүүлдэг нь тухайн орчныхоо үйлчилгээний нэгдсэн төвийн үүргийг гүйцэтгэж эхлээд байна.


CU конвинеенс дэлгүүрт үүрэн холбооны сим карт авах, нэгж цэнэглэх, төлбөр төлөх, хэвлэх, олшруулах, шуудан илгээмж илгээх, хүлээн авах; төрийн болон банкны зарим үйлчилгээг авах,







Үнэт цаасны танилцуулга



жуулчдад мэдээлэл өгөх зэрэг өдөр тутмын үйлчилгээг нэвтрүүлж үйлчилгээний нэгдсэн төв болохоор зорьж байна.

### **Үнэнч хэрэглэгчийг нэмэгдүүлэх стратеги**

CU конвiniенс дэлгүүрийн нийт борлуулалтын орлогын 37 хувийг тогтмол хэрэглэгчид буюу CU аппликэйшн хэрэглэгчид бүрдүүлдэг. Үнэнч хэрэглэгч нь CU брэндийн хувьд хамгийн эрхэм юм.

Цаашид хэрэглэгчид CU конвiniенс дэлгүүрээр үйлчлүүлэх хүслийг төрүүлэхийн тулд цэвэр цэмцгэр тохилог орчинд чанартай бүтээгдэхүүнийг санал болгож, найрсаг, дотно, шуурхай үйлчлэн, худалдан авалт бүрийг урамшуулахаар төлөвлөж байна.

### ***Найрсаг, дотно үйлчилгээг хүргэх***

CU конвiniенс дэлгүүрийн “Сайн байна уу? CU-д тавтай морил” гэсэн угталтын мэндчилгээ зэрэг үйлчилгээний соёл нь хэрэглэгчдэд хэдийн танигдсан бөгөөд урт хугацааны үнэ цэнийг бүтээсэн.

Мөн өдөр тутмын үйл ажиллагаандаа Quality, Service, Cleanliness (QSC) буюу чанар, үйлчилгээ, ариун цэврийн стандартыг мөрддөг нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлдэг байна.

CU брэндийн үндсэн болон франчайз эрхтэй дэлгүүрийн ажилтнууд нь чадвартай, идэвхи санаачилгатай, хэрэглэгч төвтэй байх нь QSC стандартыг хэвшүүлэх, брэндийн үнэ цэнийг хадгалахад гол нөлөө үзүүлдэг.


Иймд дэлгүүрийн ажилтнуудыг тогтмол сургах, урамшуулах, карьер өсөлтийг нь дэмжих замаар QSC стандартыг тогтвортой хадгалж, Монголын хамгийн сэтгэлд ойр үйлчилгээтэй дэлгүүр байхыг зорино.

### ***Үнэнч хэрэглэгчийг урамшуулах***

CU конвiniенс дэлгүүр нь CU аппликэйшнээр дамжуулан үнэнч хэрэглэгчийг урамшуулах, лоялти оноогоор шагнах, урт хугацаанд хэрэглэгчид хүрэх үнэ цэнийг нэмэгдүүлж ажилладаг.

Мөн CU аппликэйшн хэрэглэгчийн худалдан авалтын өгөгдөлд суурилсан судалгааг боловсронгуй болгох замаар тухайн





хэрэглэгчийн хүсэл сонирхолд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгохоор зорьж байна. Энэ нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, тэдгээрийн хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлох, хангах, улмаар үнэнч хэрэглэгчийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

## **Технологийн дэвшилд тулгуурласан борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх стратеги**

### ***Сувгийн төрөлжилт (Omnichannel)***

Хэрэглэгч дэлгүүрт очдог байсан бол дижитал шилжилтийн үр дүнд дэлгүүр хэрэглэгчдэд очиж үйлчилдэг болж хувьсан өөрчлөгдөөд байна.

Сэнтрал Экспресс нь дижитал сувгийг салбар дэлгүүр, болон түгээлтийн дэд бүтэцтэй хослуулж буй нь хэрэглэгчид цоо шинэ мэдрэмж, үнэ цэнийг өгдөг.

Тухайлбал, 2020 оны 8 сард хэрэглэгчид CU аппликэйшнийг ашиглаж өөрт хамгийн ойр CU дэлгүүрээс бүтээгдэхүүн захиалах онлайн худалдааны үйлчилгээг нэвтрүүлсэн нь амжилттай хэрэгжиж, нийт борлуулалтын орлогын 4 хувийг бүрдүүлэх болжээ.

Тус аппликэйшнд өдөрт 12 мянган хэрэглэгч ханддагаас 1.9 мянга хүргэлтийн үйлчилгээг сонирхож, 550 орчим худалдан авалт хийгдэж байна.

Цаашид Үнэт цаас гаргагч нь 24 цагаар ажилладаг салбар дэлгүүр болон дижитал сувгийн борлуулалтыг хослуулж, хэрэглэгчийн өдөр тутмын болон долоо хоног, сарын худалдан авалтын хэрэгцээг хангахаар зорьж байна.


### ***Финтек (Fintech)***

CU конвиниенс дэлгүүр нь SocialPay, Monpay, Memechat Pay, Mongolchat Pay зэрэг Монголын шилдэг финтекийн шийдлийг ашиглан төлбөр тооцоо хийх боломжийг хэрэглэгчид олгодог бөгөөд хэрэглэгчид финтек ашиглах дадал хэвшлийг суулгахад чухал үүрэг гүйцэтгэж байна.





Үнэт цаасны танилцуулга



Цаашид финтекийн шийдлийг хөгжүүлэх замаар үйлчилгээний хурдыг нэмэх, төлбөр тооцооны аюулгүй байдлыг хангах, бэлэн мөнгөтэй холбогдон гардаг зардлыг бууруулна.

Хэрэглэгч CU аппликэйшнийг цахим хэтэвч хэлбэрээр ашигласнаар төлбөр тооцоо, мөнгөн шилжүүлэг, зээл болон бусад төрлийн санхүүгийн бүтээгдэхүүнийг ашиглах боломжийг бүрдүүлнэ.

### **Технологийн шийдлүүд (In-store tech)**

2021 оны 6 сарын байдлаар CU конвениенс дэлгүүрүүд нь видео хяналтын болон клауд аудио зарлан мэдээлэх систем зэрэг технологийн дэвшлийг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна.

Цаашид дэлгүүр доторх үйл ажиллагааг автоматжуулах, хялбаршуулах ухаалаг технологийн шийдлийг ашиглан үйлчилгээний чанараа дээшлүүлэхээр зорьж байна.

### **Хиймэл оюун (Machine learning)**

CU конвениенс дэлгүүрээр өдөр бүр 25 мянга гаруй хүн үйлчлүүлж, 74 мянган ширхэг бүтээгдэхүүнийг 127 өөр байршлаас худалдан авч байна.

Дэлгүүрийн тоо нэмэгдэх хэрээр бүтээгдэхүүн, хэрэглэгч, байршил, цаг хугацаатай холбоотой мэдээллийн өгөгдлийн санг үүсгээд (big data) байна.

CU конвениенс дэлгүүрийн үйлчилгээг улам ухаалаг, оновчтой болгоход хиймэл оюуныг ашигласнаар техникийн зардал багасаж, шинэ технологи нэвтрүүлэхэд хялбар болсон. Цаашид CU конвениенс дэлгүүр нь хиймэл оюун ухааныг үйл ажиллагаанд нэвтрүүлж, өгөгдлийн судалгаа шинжилгээг сайжруулж, хэрэглэгчид хүртээмжтэй үйлчилгээг бий болгоно.



Зураг 80. Жижиглэн худалдаанд зориулсан технологийн шийдлүүд




Эх сурвалж: СиБи Инсайтс (CB Insights)





Зураг 81. Жижиглэн худалдаанд зориулсан хиймэл оюуны шийдлүүд



Эх сурвалж: СиБи Инсайтс (CB Insights)

### 3.6 Санхүүгийн төсөөлөл

#### Орлогын тайлангийн төсөөлөл

##### Хүснэгт 19. Орлого, үр дүнгийн хураангуй тайлан, тэрбум төгрөгөөр


Орлогын тайлан	2021Т	2022Т	2023Т	2024Т	2025Т	2026Т	2027Т	2028Т	2029Т	2030Т
Борлуулалтын орлого	88.5	237.9	390.1	475.4	518.0	561.4	595.1	630.8	668.7	708.8
Борлуулалтын өртөг	(94.8)	(229.8)	(356.9)	(424.1)	(449.6)	(475.7)	(502.8)	(531.1)	(559.6)	(590.8)
Нийт ашиг, алдагдал	(6.2)	8.0	33.2	51.3	68.3	85.7	92.3	99.8	109.0	118.0
Ерөнхий ба удирдлагын зардал	(6.8)	(9.8)	(11.0)	(11.4)	(11.8)	(12.2)	(12.5)	(13.0)	(13.5)	(14.1)
Үйл ажиллагааны ашиг, алдагдал	(13.1)	(1.7)	22.2	39.9	56.5	73.5	79.8	86.8	95.5	103.9
Цэвэр санхүүгийн зардал	(1.8)	(1.7)	(2.3)	(1.9)	(1.5)	(1.1)	(0.6)	(0.1)	-	-
Түрээсийн хүүгийн зардал	(5.2)	(8.7)	(11.6)	(13.6)	(12.6)	(11.5)	(11.7)	(10.1)	(8.2)	(7.7)
Татварын өмнөх ашиг, алдагдал	(20.1)	(12.0)	9.5	25.6	43.6	61.8	68.0	76.7	87.3	96.2
Орлогын албан татварын хөнгөлөлт, (зардал)	(0.0)	-	(0.7)	(2.5)	(7.3)	(14.0)	(15.5)	(17.2)	(19.1)	(20.7)
Татварын дараах ашиг, алдагдал	(20.1)	(12.1)	7.7	22.0	35.2	47.0	52.1	59.4	68.2	75.6

Эх сурвалж: СТОУС-ын дагуух Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл


Санхүүгийн тайлангийн шинжилгээнд дурьдсанчлан СУ конвинеенс сүлжээ дэлгүүрийн борлуулалтын орлого нь i) өдрийн дундаж борлуулалт (өдрийн хэрэглэгчийн тоо, сагсны үнэ), ii) нийт ажилласан дэлгүүр өдөр (дэлгүүрийн тоо, нэг дэлгүүрийн ажилласан өдөр)-өөс шууд хамааралтай.

2019 онд нэг дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалтын орлого 2,624 мянган төгрөг байсан нь 2020 он, 2021 оны эхний хагас жилүүдэд 1.683 мянган төгрөг болон 1,804 мянган төгрөг болж буурч, харин 2021 оны 5-р сарын 8-ны өдөр дууссан Ковид-19 хатуу хөл хорионы дараагаар 2021 оны 5, 6 саруудад 2,500 мянган төгрөг болж буцаж өсч эхэлсэн байна. Тус өдрийн дундаж борлуулалтын сэргэлт нь цагийн хязгаартай үйл ажиллагаатай, эдийн засгийн идэвхжил сул хэвээр байхад харьцангуй сайн үзүүлэлт болж байна.





Үнэт цаасны танилцуулга



Цаашид бүх шатны сургууль хэвийн үйл ажиллагаатай ажиллах, цагийн хязгаарлалт буурах зэргээр эдийн засгийн идэвхжил нэмэгдвэл өдрийн дундаж борлуулалт 2019 оны түвшин рүү буцаж хүрэх, цаашлаад бизнес төлөвлөгөөний хүрээнд нэмэгдэх хүлээлттэй байна.

Нэгж дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалт цаашид өсөхөд өдрийн хэрэглэгчийн тооны сэргэлтээс гадна, худалдан авч буй сагсны сонголт, түүний үнийн дүнгийн өсөлт нөлөөлөхөөр байна.

2021 оны сүүлийн хагас жилд борлуулалт сайжирч, жилийн дунджаар авч үзвэл нэг дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалт 1,914 мянган төгрөг, борлуулалтын орлого 88 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөгдөж байна.


Үнэт цаас гаргагч нь 2022 онд Ковид-19 цар тахлын нөлөө буурснаар нэг дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалт нь 2,823 мянган төгрөг буюу Ковид-19 өмнөх 2019 оны ойролцоо түвшинд хүрэх төлөвлөгөөтэй байна. Улмаар дэлгүүрийн өргөжин тэлэлт үргэлжилснээр 2022 онд дунджаар 235 дэлгүүр 84,278 өдөр ажиллаж, нийт 238 тэрбум төгрөгийн цэвэр борлуулалтын орлоготой ажиллахаар хүлээгдэж байна.

Иж бүрэн логистик, мэдээллийн системийн шийдэл, бэлтгэн нийлүүлэгчид, үйлчилгээний байгууллагуудтай хамтарсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх боломж улам өргөсч байгаа, дэлгүүрийн тоог нэмэгдүүлэх зах зээлийн багтаамж, түүнд хүрэх стратеги байгаа нь Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орон зайг нэмэгдүүлэх суурь хүчин зүйлийг бий болгож байгаа бөгөөд 2023 онд 390 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 7.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллах төлөвлөгөөтэй байна.

Нэгж дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалтын өсөлтийг авч үзвэл, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг Монголбанкны зорилтод инфляцын түвшин болох 6 хувиар, үлдсэн өсөлт нь өдрийн хэрэглэгчийн тоо болон үнийн өсөлтөөс хамааралгүй дундаж сагсны өсөлтөөс үүдэлтэй юм.



Зураг 82. Дэлгүүр өдрийн дундаж борлуулалт, мянган төгрөгөөр




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл

- Нэг дэлгүүрийн өдрийн хэрэглэгчийн тоог 2019 онд 598, 2020 онд 330, 2021 оны төсөөллөөр 400 орчим байгааг 2030 онд 584 байхаар тогтвортой авч үзсэн.
- Нэг худалдан авагчийн сагсны үнэ нь 2019 онд 4,386 төгрөг, 2020 онд 5,098 төгрөг, 2021 онд 4,879 төгрөг байгаа нь 2030 онд 9,244 төгрөг болохоор байна. 2030 оны сагсны үнийг инфляциар бууруулан өнөөгийн үнэ цэнээр илэрхийлбэл 5,314 төгрөг байна.
- Нэгж дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалтыг 2030 онд 5,394 мянган төгрөг байхаар төсөөлсөн. Үүнийг инфляциар бууруулан өнөөгийн үнэ цэнээр илэрхийлбэл 3,101 мянган төгрөг байхаар байна.

Эндээс дүгнэвэл, дэлгүүрийн тооны өсөлтөөс бусад хүчин зүйлс болох өдрийн дундаж хэрэглэгчийн тоо, нэг худалдан авалтын дундаж үнийг ирэх жилүүдэд тогтвортой байхаар төсөөлсөн.

Зураг 83. Дэлгүүрийн тоо, орлого, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө





Борлуулалтын дүнг өсгөхөд Үнэт цаас гаргагчийн зүгээс дэлгүүрийн тоог тогтвортой нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байна. Нийт дэлгүүрийн тоог 360 байхаар төлөвлөсөн нь Улаанбаатарт багтах боломжтой 754 орчим конвينيенс сүлжээ дэлгүүрийн (Зах зээлийн багтаамж хэсэгт дэлгэрэнгүй тусгагдсан) 47 хувийг бүрдүүлж байна.

2030 онд 360 дэлгүүртэйгээр Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого 709 тэрбум байхаар төсөөлж буй нь өнөөдрийн үнэ цэнээр 407 тэрбум төгрөг байна.

Зураг 84. Борлуулалтын өртөг, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөний дагуу i) нэгж дэлгүүрийн дундаж борлуулалт нэмэгдэж, ii) борлуулалтыг дагах хувьсах зардал, ялангуяа бараа бүтээгдэхүүний өртөг, түгээлтийн зардал, барааны акт буурч, iii) дэлгүүрийн тогтмол зардлын дүн тогтворжсоноор 2022 оны 3 сараас нэгж дэлгүүр 2.8 сая төгрөгийн өдрийн дундаж борлуулалттайгаар дэлгүүрийн түвшинд ашигтай ажиллаж эхэлнэ.

Цаашид дэлгүүрийн тэлэлт улам нэмэгдсэнээр бараа материалын өртөг буурах боломжийг бүрдүүлж байна. 2030 онд борлуулалтын өртөг нь 83 хувь болох төлөвлөгөөтэй байна.



Хүснэгт 20. Олон улсын конвниенс дэлгүүрийн борлуулалтын өртгийн хувь

Борлуулалтын өртгийн хувь	2015	2016	2017	2018	2019	2020	2021.3
БНСУ BGF CU				46%	44%	56%	
БНСУ GS 25	80%	81%	81%	79%	78%	79%	80%
Хонгконг Circle-K	66%	66%	65%	64%	47%	46%	46%
Малайз 7 Eleven	69%	69%	68%	68%	69%	72%	
Филиппин 7 Eleven	67%	67%	66%	65%	66%	67%	67%
ОХУ Magnit	72%	72%	75%	76%	77%	76%	
Тайван Family Mart	64%	63%	62%	63%	63%	64%	
Тайван 7 Eleven	68%	67%	67%	66%	66%	66%	66%
Тайланд 7 Eleven	78%	78%	78%	78%	77%	78%	78%
Тайланд CRC		70%	70%	70%	71%	75%	75%
<b>Дундаж</b>	<b>71%</b>	<b>65%</b>	<b>67%</b>	<b>67%</b>	<b>66%</b>	<b>68%</b>	<b>69%</b>
<b>Медиан</b>	<b>69%</b>	<b>68%</b>	<b>68%</b>	<b>67%</b>	<b>67%</b>	<b>69%</b>	<b>71%</b>

Эх сурвалж: www.ub-speeda.com

Олон улсын конвниенс дэлгүүрийн жишгээс үзэхэд борлуулалтын өртөг 67-69 хувьд хүрч тогтворждог. Өөрөөр хэлбэл нийт ахиуц ашиг олон улсын түвшинд дунджаар 31-33 хувь байгаа нь Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл хүрэхэд боломжтойг илэрхийлж байна.

Зураг 85. Ерөнхий ба удирдлагын зардал, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл


Ерөнхий ба удирдлагын зардал нь конвниенс дэлгүүрийн тооноос үл хамаарч, тогтмол шинж чанартай байдаг бөгөөд нийт орлого нэмэгдсэнээр зардлын эзлэх хувь буурч байна. 2021 онд 6.2 тэрбум төгрөг орчим байгаа зардал 14.1 тэрбум төгрөг болж нэмэгдэх бөгөөд зардлын дийлэнх хэсгийг цалин, хөдөлмөрийн зардал эзэлж байна.

Ерөнхий ба удирдлагын нийт зардлыг бүтцээр нь авч үзвэл 40-44 орчим хувийг цалин, 9-10 орчим хувийг дэлгүүр дахин



төлөвлөлтийн зардал, 9-10 орчим хувийг маркетинг, 6-7 хувийг хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой сургалт, хөгжүүлэлтийн зардал, 5-6 хувийг элэгдэл, хорогдлын зардал эзэлж байна.

Зураг 86. Цэвэр ашиг, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл

Санхүүгийн зардалд СТОУС-ын тайлагналын стандартын дагуу түрээсийн зардлыг хэсгийг санхүүгийн түрээсийн хүүгийн зардлаар бүртгэн төлөвлөсөн. Үүнд мөн зээлийн хүүгийн зардал болон гадаад валютын зээлийн ханшийн гарз орсон бөгөөд Үнэт цаас гаргагчийн БНСУ-ын хөрөнгө оруулагчаас 4.9 хувийн хүүтэй зээл болон Голомт банкнаас бодлогын хүү +5 хувь буюу 2021 оны 6 сарын байдлаар 11 хувийн хөвөгч хүүтэй зээлийн хүүний зардлын төсөөллийг оруулсан.

Орлогын албан татварын хуулийн дагуу өнгөрсөн жилүүдийн алдагдлаас хамаарч, тухайн жилийн орлогын татварын 50 хувь хүртэлх хувийг хөнгөлөх боломжтой юм. Үнэт цаас гаргагчийн хувьд 6 тэрбум төгрөг хүртэл ашигт 10 хувь, түүнээс дээш ашигт 25 хувийн татвар төлнө.

Татварын дараах цэвэр ашиг 2023 оноос эерэг болж, 2030 он гэхэд 75.6 тэрбум төгрөгт, цэвэр ахиуц ашиг 11 орчим хувьд хүрэх төлөвтэй байна.



2021-09-17

Үнэт цаасны танилцуулга

**Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл****Хүснэгт 21. Санхүүгийн байдлын тайлан, тэрбум төгрөгөөр**

Санхүүгийн байдлын тайлан	2021Т	2022Т	2023Т	2024Т	2025Т	2026Т	2027Т	2028Т	2029Т	2030Т
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>										
Үндсэн хөрөнгө	44.2	60.8	66.6	57.4	49.9	44.6	40.7	37.2	31.2	27.8
Ашиглах эрхтэй хөрөнгө	38.6	56.8	67.0	66.0	56.4	46.8	45.7	35.3	26.4	27.9
Биет бус хөрөнгө	3.0	3.2	3.4	2.9	2.4	2.0	1.5	1.2	1.1	0.9
Бусад хөрөнгө	3.8	3.7	3.6	3.4	3.3	3.2	3.0	2.9	2.9	2.9
<b>Эргэлтийн хөрөнгө</b>										
Бараа материал	10.3	15.8	12.7	13.0	13.9	14.8	15.6	16.4	17.4	18.4
Бусад эргэлтийн хөрөнгө	6.6	6.2	5.7	4.9	4.6	4.6	4.6	4.6	4.6	4.6
Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгө	10.6	2.2	16.9	47.8	87.1	132.7	183.3	244.0	315.8	389.7
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>117.1</b>	<b>148.8</b>	<b>175.8</b>	<b>195.6</b>	<b>217.7</b>	<b>248.6</b>	<b>294.4</b>	<b>341.6</b>	<b>399.4</b>	<b>472.2</b>
Хувьцаат капитал	91.2	91.2	91.2	91.2	91.2	91.2	91.2	91.2	91.2	91.2
Хуримтлагдсан ашиг	(52.1)	(64.2)	(56.5)	(34.5)	0.7	47.6	99.7	159.0	227.3	302.9
<b>НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>39.1</b>	<b>26.9</b>	<b>34.7</b>	<b>56.7</b>	<b>91.8</b>	<b>138.8</b>	<b>190.9</b>	<b>250.2</b>	<b>318.5</b>	<b>394.0</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>										
Урт хугацаат түрээсийн төлбөр	41.6	63.0	77.0	80.2	73.8	66.2	66.5	55.7	43.0	38.1
Урт хугацаат зээл	16.9	25.0	22.3	17.9	13.7	8.7	3.0	0.0	0.0	0.0
<b>Богино хугацаат өр төлбөр</b>										
Дансны болон бусад өглөг	19.5	32.4	38.9	37.2	34.1	30.1	28.9	30.4	32.1	33.9
НӨАТ-ын өглөг	-	1.5	2.9	3.6	4.3	4.7	5.1	5.3	5.8	6.1
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>78.0</b>	<b>121.9</b>	<b>141.1</b>	<b>138.9</b>	<b>125.8</b>	<b>109.8</b>	<b>103.6</b>	<b>91.4</b>	<b>80.9</b>	<b>78.1</b>


Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл

2021 оны эцэст эргэлтийн бус хөрөнгө 90 орчим тэрбум төгрөг байх төлөвтэй байгаагаас 44.2 тэрбум төгрөгийг үндсэн хөрөнгө, 38.6 тэрбум төгрөгийг ашиглах эрхтэй хөрөнгө буюу түрээсийн хөрөнгө, бусад хэсгийг биет бус хөрөнгө болон гүүдвилл тус тус эзэлж байна. Дэлгүүрийн тоо нэмэгдэхтэй холбоотойгоор эргэлтийн бус хөрөнгийн дүн 2023 он хүртэл нэмэгдэх бөгөөд үүнээс хойш тогтворжиж байна.





Зураг 87. Нийт хөрөнгө, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл

Эргэлтийн хөрөнгийн бүтцийн хувьд дийлэнх хэсгийг бараа материал эзэлж байгаа бөгөөд 2023 оноос эхлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө дийлэнх хэсгийг бүрдүүлэхээр төсөөлж байна.

2021 оны 6 сарын байдлаар Үнэт цаас гаргагчийн бараа материалын дундаж насжилт 38.2 хоног, өглөгийн дундаж насжилт 46.6 хоног байна. Олон улсын томоохон конвинеенс дэлгүүрүүдийн бараа материалын дундаж насжилтыг харвал БиЖиЭф Ритэйл 7.6 хоног, GS Ритэйл 9.9 хоног тус тус байна.

**Хүснэгт 22. Олон улсын конвинеенс дэлгүүрийн бараа материалын дундаж насжилт, хоногоор**

Бараа материалын дундаж насжилт	2018	2019	2020	2021-II
BGF Retail	7.59	7.25	7.56	7.62
GS Retail	12.12	10.54	9.66	9.97
Circle - K	9.42	10.37	11.12	15.39
Japan 7 Eleven	17.87	14.81	15.46	17.37

Эх сурвалж: Morningstar

Үнэт цаас гаргагч нь бараа материалын эргэцийг цаашид аажмаар сайжран 15 хоногт хүргэхээр төлөвлөсөн байна. Үнэт цаас гаргагчийн бараа материалын эргэц сайжирснаар нөгөө талдаа нийлүүлэгчдээ төлбөр түргэн гүйцэтгэх боломжтой болох бөгөөд тус үзүүлэлтийг 25 хоног болгон бууруулахаар төлөвлөжээ.



Зураг 88. Өр төлбөр ба эздийн өмч, тэрбум төгрөгөөр




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл

2021 оны эцэст Үнэт цаас гаргагчийн өр төлбөрийн дүн 78 орчим тэрбум төгрөг байх төлөвтэй байгаагийн 20 орчим тэрбум төгрөг нь богино хугацаат өглөг буюу дийлэнх хэсэг нь дансны өглөг байна. Үлдсэн 58 орчим тэрбум төгрөгийн урт хугацаат зээлийн 41.6 тэрбум нь түрээсийн гэрээтэй холбоотой санхүүгийн түрээсийн өглөг бол 9.2 тэрбум төгрөг нь охин компанийн урт хугацаат зээл, 7.7 тэрбум төгрөг нь гадаад валютын зээл байна.

Борлуулалтын дүн нэмэгдэж байгаатай холбоотойгоор дансны өглөг болон НӨАТ-ын өглөг нэмэгдэхээр төлөвлөгдөж байгаа нь богино хугацаат өглөгийг нэмэгдүүлж байна.

Дэлгүүрийн тоо өссөнөөр урт хугацаат зээлийн санхүүгийн түрээсийн өр төлбөр 2024 он хүртэл нэмэгдэж байна. 2022 онд Үнэт цаас гаргагч нь 9.3 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авахаар төлөвлөсөн бол 2028 оноос зөвхөн санхүүгийн түрээсийн өглөгтэй буюу бодит зээлгүй болохоор төлөвлөжээ.

Зураг 89. Эздийн өмч, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл



Үнэт цаас гаргагч нь 2021 оны эцэст 17 тэрбум төгрөгийн зээл, 39 тэрбум төгрөгийн эздийн өмчтэй байхаар төлөвлөсөн байна. Одоогийн хувьцаа эзэмшигчид нэмэлт хөрөнгө оруулснаас гадна, IPO хийсний дараагаар хувьцаат капитал 91.2 тэрбум төгрөг болно. Мөн ашигт ажиллагаа нэмэгдсээр 2030 он гэхэд хуримтлагдсан ашиг 303 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөжээ.

### Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл


Хүснэгт 23. Мөнгөн гүйлгээний тайлан, тэрбум төгрөгөөр

Мөнгөн гүйлгээний тайлан	2021T	2022T	2023T	2024T	2025T	2026T	2027T	2028T	2029T	2030T
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(9.5)	9.0	34.6	37.2	45.9	54.8	61.5	68.9	73.9	76.7
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(25.9)	(25.2)	(16.9)	(1.5)	(2.2)	(3.9)	(5.1)	(5.2)	(2.1)	(2.9)
Санхүүжилтийн цэвэр мөнгөн гүйлгээ	39.5	7.7	(2.9)	(4.8)	(4.5)	(5.3)	(5.9)	(3.1)	(0.0)	(0.0)
<b>Цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>4.2</b>	<b>(8.5)</b>	<b>14.8</b>	<b>30.9</b>	<b>39.2</b>	<b>45.6</b>	<b>50.6</b>	<b>60.7</b>	<b>71.9</b>	<b>73.8</b>

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 2022 оноос эерэг болох төлөвтэй байгаа ба 2023 оноос үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр ирээдүйн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлэх боломжтой байна.

Зураг 90. Мөнгөн гүйлгээ, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө



МОНГОЛЫН ХЭРЭНГИЙН БИР  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-09-17

Үнэт цаасны танилцуулга


БҮРТГЭВ-02





**ДӨРӨВ.  
ҮНЭТ  
ЦААСНЫ  
ТУХАЙ**





## 4 ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

### 4.1 Нийтэд санал болгох үнэт цаасны тухай

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 23 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 61.1.7 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.2, 62.1.3, 62.1.4 дэх заалт, 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Үнэт цаас гаргагчийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.6.2 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.5.1, 9.5.2, 9.5.4, 9.5.15 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 7 сарын 26-ны өдрийн 6 тоот тогтоол, ТУЗ-ийн 2021 оны 7 сарын 26-ны өдрийн 11 тоот тогтоол, ТУЗ-ийн 2021 оны 9 сарын 09-ний өдрийн 151021-13 тоот хурлын тогтоолыг үндэслэн нийт 799,773,734 ширхэг хувьцааны 15 хувь 119,966,060 ширхэг хувьцаа нэмж гарган Монголын Хөрөнгийн Биржийн III ангиллаар анх удаа нийтэд санал болгон арилжихаар шийдвэрлэсэн байна.

#### Хүснэгт 24. Үнэт цаасны мэдээлэл

Үнэт цаас гаргагч	Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Нийт гаргасан хувьцааны тоо ширхэг	679,807,674
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ	100 төгрөг
Нийтэд санал болгох эзэмшлийн хувь	15%
Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох хувь	50%
Олон нийтэд санал болгох хувь	50%
Нэмж гаргах хувьцааны тоо ширхэг	119,966,060
Нэмж гаргасны дараах хувьцааны тоо ширхэг	799,773,734
Нэгж хувьцааны үнэ	208 төгрөг
Олон нийтээс татан төвлөрүүлэх дүн	24,952,940,480 төгрөг
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Нэмэлт дэлгүүрийн хөрөнгө оруулалт, түгээлтийн төвийн тоног төхөөрөмж, хоолны үйлдвэрийн тоног төхөөрөмж
Хувьцааг арилжаалах арга	Тогтоосон үнийн арга



## 4.2 Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт

Үнэт цаас гаргагчийн зарласан болон гаргасан энгийн хувьцааны тоо ширхэг сүүлийн байдлаар 679,807,674 ширхэг байгаа бөгөөд нэмж 119,966,060 ширхгийг буюу олон нийтэд санал болгосны дараах хувь эзэмшлийн 15 хувьтай тэнцэх энгийн хувьцааг нийтэд нээлттэй санал болгон арилжина.

### Хүснэгт 25. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцаа гаргахаас өмнө		Хувьцаа гаргасны дараа	
	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь хэмжээ	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь хэмжээ
А.Ганхуяг	235,408,889	34.64%	235,408,889	29.43%
А.Ганболд	172,327,784	25.35%	172,327,784	21.55%
Ц.Баяржаргал	88,164,258	12.97%	88,164,258	11.02%
А.Одончимэг	32,304,463	4.75%	32,304,463	4.04%
А.Ганбаатар	31,248,463	4.60%	31,248,463	3.91%
О.Батмөнх	19,731,751	2.90%	19,731,751	2.47%
Г.Бат-Эрдэнэ	19,731,751	2.90%	19,731,751	2.47%
Ө.Мөнхбаяр	12,909,548	1.90%	12,909,548	1.61%
БиЖиЭф Ритэйл	67,980,767	9.99%	67,980,767	8.50%
Ко.Лтд	-	-	-	-
Олон нийт	-	-	119,966,060	15.00%
<b>Нийт</b>	<b>679,807,674</b>	<b>100%</b>	<b>799,773,734</b>	<b>100%</b>

## 4.3 Нийтэд санал болгох үнэ тогтоосон үндэслэл


Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдэд үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хөндлөнгийн үнэлгээний байгууллага болох Гэрэгэ Эстимэйт ХХК нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг гүйцэтгэж, үр дүнг 2021 оны 7 сарын 26-ны өдрийн болон 9 сарын 13-ны өдрийн Хараат бус бизнесийн үнэлгээний тайлангаар хүргүүлсэн.

Үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчийн хувьцааг нийтэд анх удаа санал болгох үйл ажиллагаанд зориулж 100 хувь бизнес өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг 2021 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаар тодорхойлсон. Олон Улсын Стандартын дагуу үнэлгээний байгууллага нь зах зээлийн үнэ цэний суурийг сонгож, үнэт цаас гаргагчийн бизнесийг хөрөнгөд суурилсан, зах зээлийн харьцуулалтын болон орлогын хандлагын аргаар үнэлсэн.


### Хөрөнгөд суурилсан үнэлгээ







Үнэт цаасны танилцуулга



Хөрөнгөд суурилсан үнэлгээ нь тухайн бизнесийн нийт хөрөнгөөс өр төлбөрүүдийг хасах замаар бизнесийн үнэ цэнийг тодорхойлдог. Энэ аргаар үнэлгээ хийхийн тулд Сэнтрал Экспресс болон Премиум Дистрибьюшн компаниудын биет ба биет бус бүх хөрөнгүүд болон өр төлбөрийн үзүүлэлтүүдийн зах зээлийн үнэ цэнийг тогтоох замаар цэвэр хөрөнгийн хэмжээг тодорхойлох шаардлагатай.

Энэхүү тооцоолол дахь Үнэт цаас гаргагчийн цэвэр хөрөнгө үнэлгээний өдрийн байдлаар 26,650 сая төгрөг байна. Гэвч тус тооцоололд Үнэт цаас гаргагчийн ирээдүйн орлого олох чадварт чухал нөлөө үзүүлэх гүүдвилл, барааны тэмдэгт, менежментийн ур чадвар зэрэг биет бус хөрөнгүүд ороогүй байна. Харьцуулан судлах ижил төстэй бизнесийн зах зээлийн мэдээлэл хомс үед Үнэт цаас гаргагчийн ирээдүйн ашигт ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэх эдгээр биет бус хөрөнгийн үнэ цэнийг тооцоолоход бизнесийн нийт үнэ цэнээс бусад хөрөнгийн үнэ цэнийг хасах зарчим дээр тулгуурлан тооцоолол хийх нь оновчтой байдаг. Энэхүү аргачлал нь үнэлгээний ажлын даалгаварт өгөгдсөн бизнесийн үнэ цэнийг тооцоолох ажилтай давхцаж байгаа тул хөрөнгөд суурилсан аргыг бизнес өмчлөлийн үнэ цэнийг тооцоолоход тохиромжгүй гэж хөндлөнгийн үнэлгээний байгууллага үзсэн.

### **Зах зээлийн харьцуулалтын аргаарх үнэлгээ**

Үнэт цаас гаргагчийн бизнес өмчлөлийн үнэ цэнийг зах зээлийн харьцуулалтын аргаар тооцоолоход харьцуулах компаниар авч ашиглах итгэл үнэмшил төрүүлэхүйц, найдвартай мэдээлэлтэй дотоодын нээлттэй компани одоогоор байхгүй гэж хөндлөнгийн үнэлгээний байгууллага үзсэн байна. Иймд зах зээлийн харьцуулалтын аргаарх үнэлгээг ижил төстэй олон улсын компаниудын үзүүлэлтийг ашиглан хийж гүйцэтгэсэн.

Үнэт цаас гаргагчийн Post-Money бизнесийн үнэлгээ буюу хувьцааг олон нийтэд санал болгон санхүүжилт татсаны дараах 100 хувь бизнес өмчлөлийн дундаж үнэлгээ олон улсын зах зээлийн дундаж P/B үржүүлэгч болон харьцуулсан компаниудын дундаж P/B үржүүлэгчийг тус тус ашиглан тооцоолоход харгалзан 207,990 сая төгрөг, 282,903 сая төгрөг гарсан. Түүнчлэн хөндлөнгийн үнэлгээний байгууллага EV/Sales болон EV/EBITDA үржүүлэгчийг ашиглан бизнесийн үнэлгээг тооцсон боловч тус үнэлгээ нь нэмэлтээр босгох санхүүжилтийн үр дүнд бий болох





ОЛГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЭГ  
OLGOLYI STOCK EXCHANGE

2021-09-17  
Үнэт цаасны танилцуулга  
БҮРТГЭЛ-02

бизнесийн тэлэлтийг авч үзэхгүй байгаа тул учир дутагдалтай гэж үзсэн байна. Иймд ашгийн үзүүлэлт, харьцаанд үндэслэн хийсэн үнэлгээ нь үнэлгээний ажлын зорилгод нийцэл муутай байгаа тул орлогын хандлагыг ашигласан байна.

### Орлогын хандлагын аргаарх үнэлгээ

Үнэт цаас гаргагчийн бизнесийн мөчлөг болон санхүүгийн загварт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр олон нийтээс хөрөнгө татсаны дараах үеийн орлогын хандлагаар хийсэн үнэлгээ (Post-Money valuation) нь үнэлгээний ажлын зорилго болон үнэлгээний даалгавартай нийцнэ гэж хөндлөнгийн үнэлгээний байгууллага дүгнэсэн байна. Үнэлгээнд орлогын хандлагын хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга, тодруулбал байгууллагын цэвэр мөнгөн гүйлгээ (Free Cash Flow to Firm)-ний загварыг ашигласан.

Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь борлуулалтын орлогын төсөөлөлд Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөнд шинжилгээ хийн, 2021 оны 2 дугаар хагаст 61 дэлгүүр, 2022 онд 100 дэлгүүр, 2023 онд 75 дэлгүүр нээж, 2023 оны төгсгөлд нийт 360 дэлгүүртэй байхаар, нэгж дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалтын орлогыг Ковид-19 цар тахал дотоодод тархсанаас үүдэн хатуу хөл хорио тогтоохоос өмнөх сар болох 2020 оны 10 сарын мэдээлэлд үндэслэн төсөөлсөн байна. Түүнчлэн үнэлгээний төсөөлөлд урт хугацааны бизнесийн өсөлтийг 4 хувиар, капиталын жинлэсэн дундаж өртгийг 18 хувиар тус тус тооцон, Үнэт цаас гаргагчийн 100 хувийн бизнес өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг 2021 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаар 211,818 тэрбум төгрөг байхаар тогтоосон байна. Энэ Үнэт цаас гаргагчийн олон нийтээс санхүүжилт татаж эздийн өмчийг нэмэгдүүлсний дараах үед хамаарах үнэлгээ (Post-Money valuation) болно.

### Үнэлгээний үр дүн

Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчийн бизнес хөгжүүлэлтийн өнөөгийн нөхцөл байдал, үнэлгээний ажлын зорилготой уялдуулан үнэлгээний эцсийн үр дүнг хорогдуулсан мөнгөн урсгалын аргаар хийж гүйцэтгэсэн үр дүнгээр авсан болно.



**Хүснэгт 26. Үнэлгээний үр дүн**

Үнэлгээний арга	Бизнесийн үнэ цэн, сая төгрөгөөр
Зах зээлийн харьцуулалтын арга	207,990-282,903
Хорогдуулсан мөнгөн урсгалын арга	211,818
<b>Үнэлгээчний сонгосон үнэлгээ</b>	<b>211,818</b>

Хөндлөнгийн үнэлгээний байгууллагын тооцоолсон бизнесийн үнэлгээний үр дүнгээр нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэн 265 төгрөг байхаар тогтоогдсон. Үнэт цаас гаргагч болон Андеррайтеруудын зүгээс зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 9 сарын 9-ний өдрийн хурлын шийдвэрээр нэгж хувьцааны үнийг 208 төгрөг буюу 21.5 хувийн хөнгөлөлттэй үнээр нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

#### 4.4 Үнэт цаас гарган татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь 2023 он хүртэлх бизнес төлөвлөгөөний хүрээнд Улаанбаатар хот болон ойролцоох бүсэд нийт 360 конвиниенс дэлгүүрийг бий болгох зорилт тавин ажиллаж байна.

CU конвиниенс дэлгүүрийн бараа бүтээгдэхүүний нэгдсэн агуулах, бэлтгэн нийлүүлэлтийг үр ашигтай зохион байгуулах иж бүрэн логистикийн цогц шийдлийг хөгжүүлсээр байна.


Түүнчлэн 2020 оны 11 сард ашиглалтад орсон хоол үйлдвэрлэлийн төвийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үйлдвэрлэлийн боломжийг нэмэгдүүлсээр байна.

Үнэт цаас гаргагч нь олон нийтээс татан төвлөрүүлэх 24,953 сая төгрөгийг дараах зориулалтаар зарцуулахаар төлөвлөж байна.

**Хүснэгт 27. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт**

№	Хөрөнгө оруулалтын зориулалт	Үнийн дүн, сая төгрөг	Зарцуулалтад эзлэх хувь хэмжээ
1	Нэмэлт 95 дэлгүүрийн хөрөнгө оруулалт	19,000	76%
2	Түгээлтийн төвийн нэмэлт тоног төхөөрөмжийн худалдан авалт, суурилуулалт	2,950	12%
3	Хоол үйлдвэрлэлийн төвийн нэмэлт тоног төхөөрөмжийн худалдан авалт, суурилуулалт	3,003	12%
	<b>Нийт татан төвлөрүүлэх хөрөнгө</b>	<b>24,953</b>	<b>100%</b>





### **Нэмэлт дэлгүүрийн хөрөнгө оруулалт (19,000 сая төгрөг)**

Нэгж дэлгүүрийн хөрөнгө оруулалт нь одоогийн 127 дэлгүүрийн хувьд талбайн хэмжээнээс хамаарч 110-400 сая төгрөгийн хооронд дунджаар 200 сая төгрөгийн өртөгтэй байна. Нэгж дэлгүүрийн хөрөнгө оруулалтад дэлгүүрийн барилгын ажил, тавилга, тоног төхөөрөмж, мэдээлэл технологийн системийн зардал багтдаг. Олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн 76 хувь болох 19,000 сая төгрөгөөр CU конвинеенс дэлгүүрийг өргөтгөж, шинээр 95 дэлгүүрийг нээнэ.

### **Түгээлтийн төвийн нэмэлт тоног төхөөрөмж (2,950 сая төгрөг)**


CU конвинеенс дэлгүүрээр борлуулах бараа, бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийг тасалдалгүй, оновчтой удирдан зохион байгуулахын тулд түгээлтийн төвийн үйл ажиллагаа нь дэлгүүр нэмэгдэхийн хэрээр илүү хялбар, автомат, хүчин чадал сайтай болох шаардлагатай. Иймд Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлэх дүнгийн 12 хувийг буюу 2,950 сая төгрөгийг түгээлтийн төвийн бүтээмжийг нэмэгдүүлэх, захиалгыг хялбар, алдаагүй бэлтгэхэд зориулсан агуулахын удирдлагын тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай дэд системүүд, түүнтэй холбогдох тоног төхөөрөмжийг худалдан авахад зарцуулна.

Агуулахын удирдлагын тогтолцоо гэдэг нь бэлтгэн нийлүүлэгчээс бүтээгдэхүүнийг хүлээн авахаас эхлээд тусгай цахим кодоор хаяглан өрж байршуулах, салбар дэлгүүрийн захиалгыг бэлтгэх, ачуулах, илгээх, хүргэлтийн явцыг хянах бүх үе шатад тухайн бараа бүтээгдэхүүний шилжилт, байршлыг бүртгэж, хянах удирдлагын цогц систем юм. Түгээлтийн төвд зориулагдах нэмэлт тоног төхөөрөмж, системийг дурдвал:

- захиалга бэлтгэх систем;
- туузан дамжуургын систем (конвейер);
- сэрээт өргөгч, агуулахын зориулалт бүхий даацын тавиур, паллет бүтээмж, хүчин чадлыг нэмэгдүүлэх систем, тоног төхөөрөмж, эд хогшил тус тус багтаж байна.

### **Захиалга бэлтгэх систем**

Захиалга бэлтгэх систем нь тусгай электрон хаяг, бүтээгдэхүүний мэдээллийг цогц бүртгэл дээр үндэслэн тухайн бүтээгдэхүүнийг





аль байршлаас хэдэн ширхгийг бэлтгэхийг заадаг, цаасгүй технологи юм. Энэхүү системийг нэвтрүүлснээр захиалга бэлтгэх хурд 30 хувиас доошгүй сайжрахаас гадна хүнээс хамаарсан алдаа буурна. Энэхүү технологийг Үнэт цаас гаргагч нь түгээлтийн төвөөс дэлгүүр лүү хүргэгдэх захиалгыг ширхэглэн бэлтгэх хэсэгт байршуулна.

### Туузан дамжуургын систем (конвейер)

Бэлтгэсэн захиалгыг хаягжуулж, ачуулах хэсэг рүү механик ажиллагаа багатайгаар хурдан хугацаанд зөөвөрлөхийн тулд захиалга бэлтгэх хэсгээс ачилтын хэсгийг холбосон туузан дамжуургын системийг суурилуулахаар төлөвлөж байна.

Түгээлтийн төвийн хөрөнгө оруулалтын үр дүнд дараах сайжруулалтууд бий болно. Үүнд:

Одоогийн байдлаар захиалга бэлтгэгч цагт дунджаар 70 мөр захиалга бэлтгэж байна. Захиалга бэлтгэх системийг ашиглалтад оруулснаар бүтээмж 2 дахин нэмэгдэнэ.

- Бараа бүтээгдэхүүн хүлээн авах, захиалга бэлтгэх үйл ажиллагааны алдаа багасаж, бараа бүтээгдэхүүний үлдэгдэл, тоо ширхэгийн мэдээлэл сайжрана.
- Түгээлтийн үйл ажиллагааны шат бүрийн гүйцэтгэлийн хугацааг хянах тогтолцоог бий болгож, бизнес процессийн үр ашгийг нэмэгдүүлнэ.

### Хоол үйлдвэрлэлийн төвийн нэмэлт тоног төхөөрөмж (3,003 сая төгрөг)

Хоол үйлдвэрлэлийн төвийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт нь шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх зориулалттай тоног төхөөрөмж болон дэлгүүрийн өргөтгөлтэй уялдаатай нэмэлт тоног төхөөрөмжөөс бүрдэнэ. Тодруулбал,

- Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх зориулалттай тоног төхөөрөмжүүдийг үйл ажиллагаанд ашигласнаар шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлнэ.
- Дэлгүүрийн өргөтгөлтэй уялдаатай нэмэлт тоног төхөөрөмжид бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн, боловсруулалтын, угсралтын тоног төхөөрөмжүүд багтаж байна. Одоогийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүд нь 130-140 дэлгүүрийг хангах хүчин



чадалтай ажиллаж байна. Цаашид дунд хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу нэмэлт дэлгүүрийн өргөжилтөд шаардлагатай хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх шаардлагатай.

Хоол үйлдвэрлэлийн төвийн бизнес төлөвлөгөөгөөр шинэ төрлийн болон нэмэлт тоног төхөөрөмж худалдан авах, хүйтэн агуулахын үр ашгийг нэмэгдүүлэх зэрэгт 3,003 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай.

Үнэт цаас гаргагч нь нийтэд хувьцааг гаргах замаар татан төвлөрүүлэх 24,953 сая төгрөгийн санхүүжилтийг нэмэлт дэлгүүрийн өргөтгөл, түгээлтийн төв болон хоол үйлдвэрлэлийн төвийн нэмэлт тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад зарцуулна.


#### 4.5 Үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг

##### Үнэт цаас эзэмшигчийн эрх

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн Дүрэм болон хувьцаат компанийн Дүрмийн төсөлд зааснаар дараах эрхүүдийг эдэлнэ. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүү санал өгөх;
- Эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээгээр ногдол ашиг авах;
- Компанийн талаарх бүх мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах;
- Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
- Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон Компанийн Дүрэмд заасны дагуу Компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг өөрийн эзэмшиж байгаа хувьцаанд хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах;






Үнэт цаасны танилцуулга

- Хувьцаа эзэмшигч нь компаниас доорх мэдээллийг шаардан авах эрхтэй. Үүнд:
  - o Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн тайлан, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах;
  - o Компанийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн дүрэм журмаар тогтоосон бусад мэдээлэлтэй танилцах;
  - o Компанийн бусад энгийн хувьцаа эзэмшигчдийн эцэг/эхийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшлийн хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардах эрхтэй бөгөөд үүнтэй холбогдон гарах зардлыг шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч хариуцна;
- Хууль тогтоомж болон Компанийн дүрмээр тогтоосон бусад эрх багтана.

### Үнэт цаас эзэмшигчийн үүрэг

- Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- Өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эзэмшиж байгаа үнэт цаасны тоог Компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх этгээдэд мэдээлэх, түүнчлэн эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрд нь мэдэгдэх;
- Нийт гаргасан хувьцааны гуравны нэг болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авч эзэмшихийг хүссэн этгээд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу тендер санал зарлах;
- Нийт гаргасан хувьцааны таваас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэйгээ хамтран





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИР;  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-09-17

Үнэт цаасны танилцуулга

**БҮРТГЭВ-02**

эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүсэнээс хойш ажлын 3 хоногийн дотор энэ тухай Компанид бичгээр мэдэгдэх;

- Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 дахь заалтад зааснаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээх;
- Хууль тогтоомж болон Компанийн дүрмээр тогтоосон бусад үүрэг орно.

#### 4.6 Ногдол ашгийн бодлогын төсөл

Үнэт цаас гаргагчийн бизнесийн мөчлөгийн эхэн үе шат буюу өсөлтийн үе шатанд явж байгаа тул өнгөрсөн жилүүдэд ногдол ашиг хуваарилах нөхцөл бүрдээгүй байна. Тус хугацаанд Үнэт цаас гаргагч нь бизнесийг өргөжүүлэх үр ашигтай хөрөнгө оруулалтыг хийн, ирээдүйд өндөр өгөөж, үнэ цэнийг хөрөнгө оруулагчдад бий болгох гэсэн урт хугацааны тогтвортой бодлогыг баримталж ирсэн. Үнэт цаас гаргагч нь тус бодлогыг цаашид баримтлан ажиллахаар төлөвлөж буй бөгөөд ногдол ашгийн бодлогыг дараах байдлаар тодорхойлсон.

### СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХУВЬЦААТ КОМПАНИЙН

#### НОГДОЛ АШГИЙН ЖУРАМ

#### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ


- 1.1. Энэхүү Ногдол ашгийн журам (цаашид **"Журам"** гэх) нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (цаашид **"Компани"** гэх)-ийн ногдол ашгийн бодлогын баримт бичиг болох бөгөөд хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, ногдол ашиг хуваарилах нөхцөлийг тодорхойлох, ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах, ногдол ашиг хуваарилах, мэдээлэх, тайлагнахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү Журам нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон зохицуулах байгууллагаас гаргасан холбогдол бүхий дүрэм, журмуудад нийцсэн байх бөгөөд Компанийн ногдол







Үнэт цаасны танилцуулга



ашиг хуваарилах, төлөх ажиллагаанд тэдгээрийг мөрдлөг болгоно.

- 1.3. Энэхүү Журмыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) баталснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Журам нь шинэчлэн батлагдах болон хүчингүй болгох хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.4. Энэхүү Журмыг Компани өөрийн цахим хуудсанд байршуулж нийтийн хүртээл болгох ба ТУЗ-ийн нарийн бичгийн дарга сонирхсон бүх этгээдэд уг баримттай танилцах боломжийг олгоно.

### ХОЁР. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

- 2.1. Компани нь хууль тогтоомж, Компанийн Дүрмийг үйл ажиллагаандаа баримтлал болгон оновчтой менежментийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, нэгж хувьцаанд ногдох ашиг болон өөрийн хөрөнгийн өгөөжийг хамгийн өндөр түвшинд хүргэхийг эрмэлзэн ажиллах ба ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд байлгах бодлого баримтална.
- 2.2. Ногдол ашгийг тодорхойлсон тооцооллыг тухайн жилд ТУЗ тогтоох бөгөөд тус тооцооллыг Гүйцэтгэх удирдлагаас санал болгож болно.
- 2.3. Ногдол ашгийг Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлүүд бүрэн хангагдсан тохиолдолд татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна. Үүнд:
  - 2.3.1. Компани ашигтай ажилласан байх;
  - 2.3.2. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хүртэх өгөөжийг өсгөх зорилгоор ТУЗ-өөс боловсруулсан бизнес төлөвлөгөө, төсөл хөтөлбөрийг тэргүүн ээлжинд хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт үлдсэн байх;




- 2.3.3. Ногдол ашиг төлсний дараа Компани төлбөрийн чадвартай байх;
- 2.3.4. Ногдол ашиг төлсний дараа Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс их байх;
- 2.3.5. Компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн, өрийн бичгээ эргүүлэн худалдан авах хугацаа болон эдгээр үнэт цаасыг бүрэн эргүүлэн авсан, эсхүл бүрэн худалдан авахад шаардагдах хөрөнгөтэй байх; болон
- 2.3.6. Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.
- 2.4. Компани нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.

### ГУРАВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ШИЙДВЭР

- 3.1. Компанийн ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг ТУЗ гаргаж, энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулна. ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 3.2. ТУЗ ногдол ашиг хуваарилахаар шийдсэн бол уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр, ногдол ашиг төлөх өдөр, ногдол ашиг олгох хэлбэрийг тусгана.
- 3.3. ТУЗ ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол үндэслэл болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тайлант жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулна.
- 3.4. Ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хэлбэрээр хуваарилах бөгөөд бэлэн мөнгө болон эд хөрөнгө, эсхүл





Компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.

3.5. ТУЗ нь ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт дараах зүйлсийг тусгана. Үүнд:

3.5.1. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ;

3.5.2. Ногдол ашиг төлөх хугацаа;

3.5.3. Ногдол ашиг төлөх хэлбэр;

3.5.4. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах өдөр буюу бүртгэлийн өдөр; болон

3.5.5. Бусад.

3.6. ТУЗ нь Компанийн батлагдсан бизнес төлөвлөгөөтэй уялдуулан ногдол ашиг төлөх өдрийг тогтооно.

3.7. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлж, хувийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.

3.8. ТУЗ нь ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг Компанийн цахим хуудсанд байршуулж, хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу олон нийтэд мэдээлнэ.

#### **ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, ТӨЛӨХ, ТАЙЛАГНАХ, МЭДЭЭЛЭХ**

4.1 ТУЗ нь Компанийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр буюу бүртгэлийн өдрийг тогтоох бөгөөд тус өдрөөр тасалбар болгож Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иас хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй хуулгыг гаргуулна.

4.2 Компани нь хувьцаанд ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хуульд заасан нөхцөл, журамд заасан шаардлагыг биелүүлсэн байх ба ногдол ашиг олгох





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-09-17

Үнэт цаасны танилцуулга

**БҮРТГЭВ-02**

хэлбэр, хугацаа, журам нь холбогдох хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагын журам, зөвлөмжийн дагуу хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн байна.

- 4.3 Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилах тохиолдолд тус ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигч бүрийн дансанд байршуулна.
- 4.4 Компани ногдол ашиг хуваарилалтын тайланг Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.14-т заасны дагуу ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 (арван тав) өдрийн дотор гаргаж, тогтсон хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.
- 4.5 Ногдол ашгаа аваагүй хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтлөн хадгалах бөгөөд хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй.

#### ТАВ. БУСАД ЗҮЙЛ

- 5.1. Компани нь ногдол ашгийг тогтоосон хугацаандаа бүрэн төлж дуусгах ба хугацаандаа төлөөгүй нь хувьцаа эзэмшигчдийн нэхэмжлэлээр ногдол ашгийг алдангийн хамт төлөх үүргийг үүсгэнэ. Ийнхүү нэхэмжлэлээр алданги төлснөөс Компанид хохирол учирсан бол тухайн хохирлыг Компанийн Гүйцэтгэх удирдлагаар нөхөн төлүүлнэ.
- 5.2. ТУЗ-ийн тогтоосон хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.
- 5.3. Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэлх хугацаанд өөрийн эзэмшилд байсан хувьцааг бусад этгээдэд шилжүүлсэн тохиолдолд ногдол ашиг авах эрх нь уг хувьцааны хуучин эзэмшигч этгээдэд үлдэнэ.





#### 4.7 Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө


Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нь МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 сарын 25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам, СЗХ-ны 2015 оны 11 сарын 23-ны өдөр баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам болон МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын дагуу явагдана.

Үнэт цаас гаргагч нь МХБ-ийн хувьцааны бүртгэлийн III ангиллын шалгуурын дагуу Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.19-д заасан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдийн хүрээнд хувьцааг санал болгон арилжаална. Тус үнэт цаасыг мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч биш этгээд худалдан авч болно. Энэ тохиолдолд тухайн үнэт цаасыг мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгосон болохыг ойлгож шийдвэрээ гаргасан тухай үйлчлүүлж буй ҮЦК-д бичгээр мэдэгдсэн байна.

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 9 сарын 9-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу нийтэд санал болгох хувьцааны үнийг 208 төгрөгөөр тогтоосон бөгөөд МХБ-ийн анхдагч зах зээлийн арилжааны тогтоосон үнийн аргыг ашиглан санал болгохоор шийдвэрлэсэн.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй 119,966,060 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд танилцуулах үйл ажиллагааг МХБ болон СЗХ үнэт цаасыг бүртгэсэн өдрөөс хойш ажлын 10 хоногт, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг ажлын 5 хоногт хүлээн авах бөгөөд 2021 оны 10 сарын 14-ны өдөр анхдагч зах зээлийн арилжааг хаахаар төлөвлөж байна.

Зураг 91. Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө





## **МХБ болон СЗХ-д үнэт цаасыг бүртгүүлэх**

### ***Үнэт цаасыг бүртгүүлж, холбогдох зөвшөөрөл авах***

Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгох үнэт цаасыг бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг СЗХ болон МХБ-д гаргах бөгөөд эдгээр эрх бүхий байгууллагуудаас үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно.

### ***Олон нийтэд танилцуулах***

Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох, арилжаалах зөвшөөрөл гарсны дараа үнэт цаасыг нийтэд санал болгон танилцуулах аяныг зохион байгуулна. Үүнд хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч, олон нийт болон стратегийн хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулга уулзалт болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэт цаасыг танилцуулах мэдээ мэдээлэл зэрэг нь багтана.

### ***Анхдагч зах зээлийн арилжааны захиалга хүлээн авах***


Үнэт цаас гаргагч болон Үндсэн андеррайтер нь анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс ажлын гурваас доошгүй хоногийн өмнө анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх хүсэлтийг СЗХ-нд гаргах бөгөөд тус зөвшөөрөл олгогдсоноор анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авах болно.

### ***Анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалт хийх***

Үнэт цаасны анхдагч зах зээлийн хуваарилалт хийх үйл ажиллагааг Үндсэн болон Туслах андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай зөвшилцөн, МХБ-ийн Анхдагч зах зээлийн арилжааны журмын дагуу гүйцэтгэнэ.

Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан арилжааны тайланг СЗХ-нд хүргүүлнэ. СЗХ нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн арилжааг амжилттай явагдсанд тооцвол Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК-д өмчлөх эрхийн бүртгэл хийх болон арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус ажлын 3 өдөрт багтаан хүргүүлнэ.





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

Үнэт цаасны танилцуулга 1

БҮРТГЭВ-02

**Анхдагч зах зээлд арилжаалах хувьцааны тоог нэмэгдүүлэх нөхцөл**

Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгосон хувьцааны эрэлт нийлүүлэлтээс давсан тохиолдолд СЗХ-с баталсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 7.20-т заасны дагуу давсан тоо ширхэгээс хамаарч Үнэт цаас гаргагчийн шийдвэрээр нийтэд санал болгосон хувьцааны 15 хүртэлх хувь буюу 17,994,909 ширхэг хүртэлх хувьцаагаар нэмэгдүүлж, МХБ-ийн анхдагч зах зээлийн арилжаагаар нийт 137,960,949 ширхэг хүртэлх хувьцааг санал болгоно. Тус тохиолдолд нэмэгдсэн татан төвлөрүүлсэн хөрөнгийг шинэ дэлгүүрийн хөрөнгө оруулалтад зарцуулна.

**Тогтоосон үнээр санал болгох арилжааны арга**

МХБ-ийн 2009 оны Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журамд зааснаар тогтоосон үнээр санал болгон арилжих арга гэдэгт үнэт цаас гаргагчийн зүгээс үнэт цаасыг тогтоосон тодорхой нэг үнээр олон нийтэд санал болгон арилжих үйл ажиллагааг хэлэх бөгөөд хөрөнгө оруулагчийн зүгээс тогтоосон үнээс өндөр үнээр худалдан авах захиалга өгч болох эсвэл үнэт цаас гаргагчийн зүгээс зөвхөн нэг үнээр санал болгох хоёр хувилбар байдаг.

Үнэт цаас гаргагчийн хувьд зөвхөн тогтоосон үнээр буюу нэг үнийн түвшинд арилжааг явуулах ба худалдан авах захиалгын тоо ширхэг худалдах захиалгын тоо ширхэгээс илүү гарсан тохиолдолд хувь тэнцүүлэх аргыг ашиглана. Хувь тэнцүүлэх аргаар хуваарилалт хийхэд захиалгын үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй.

**Стратегийн хөрөнгө оруулагч**

Стратегийн хөрөнгө оруулагч гэдэгт МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.4 дэх хэсэгт тодорхойлсон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд давуу талыг бий болгох, үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш 6-аас доошгүй сарын хугацаанд хувьцаагаа арилжаалахгүй байх нөхцөлийг зөвшөөрсөн, стратегийн хөрөнгө оруулагчид санал болгох үнийн түвшинд (нэг зуун сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хувьцаа захиалах хөрөнгө оруулагч багтана.


Үнэт цаас гаргагч нь олон нийтэд санал болгож буй хувьцааны 50 хүртэл хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад хуваарилна.





### Үнэт цаасны анхдагч арилжаанд оролцох заавар

Зураг 92. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцоход авах алхмууд



Үнэт цаас худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нь анхдагч зах зээлийн арилжаанд дараах зааврын дагуу оролцоно.

#### **Мөнгөн хөрөнгө байршуулах**

Үнэт цаас худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь өөрийн хүссэн банкаар дамжуулан Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК дэх өөрийн нэрийн дансандаа мөнгөө байршуулах боломжтой.


Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК-д хувьцааны мөнгөн төлбөр нь бүрэн байршсан хөрөнгө оруулагчдын дансны мэдээллийг МХБ рүү анхдагч зах зээлийн арилжаа эхлэхээс өмнө хүргүүлэх ба Үндсэн болон Туслах андеррайтер нь МХБ-тэй хамтран тус хөрөнгө оруулагчдын захиалгыг нийлүүлэх ажиллагааг анхдагч зах зээлийн арилжаа хаасны дараа холбогдох тайлан мэдээг СЗХ-нд хүргүүлнэ.

#### **Арилжааны шимтгэл**


Үнэт цаасанд хөрөнгө оруулагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон үнэт цаасны компанид төлөх ба уг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын болон үнэт цаасны компаниудын шимтгэлийн нийт дүн багтсан байна. Үнэт цаасны компаниудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг анхаарна уу.







Үнэт цаасны танилцуулга



### Албан татвар

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хувь хүн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.3-т заасан орлого (ногдол ашгийн орлого)-ын нийт дүнгээс, 17.1.3-т заасан орлого (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого)-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 21.5-т заасан 5 хувийн хэмжээгээр татвар төлнө.

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.6.2-т заасан (ногдол ашгийн орлого) нийт дүнгээс, 18.3-т заасан (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого) худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 20.2.5-т заасан 5 хувийн хэмжээгээр татвар төлнө.

### Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Үнэт цаасыг анх удаа нийтэд санал болгох ажиллагаа амжилттай болсон тохиолдолд МХБ-ийн журмын дагуу СЗХ-ны зөвшөөрлөөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр хувьцааг анхдагч зах зээлээс худалдан авсан хөрөнгө оруулагчид хувьцаагаа бусдад худалдаалах эрх нээлттэй болно.

## 4.8 Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөр

Үндсэн андеррайтер болох Голомт Капитал ҮЦК ХХК нь үнэт цаас гаргагчийн гаргасан нийт энгийн хувьцааг хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн хэт өсөлт, бууралтаас хамгаалах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах зорилгоор хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд Үндсэн андеррайтер нь МХБ дээр Үнэт цаас гаргагчийн хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжаанаас эргүүлэн худалдаж авах буюу хувьцааны үнийг тогтворжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр Үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчтэй гэрээ байгуулсан. Тус хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааг дараах нөхцөлтэйгөөр явуулах бөгөөд хувьцааны үнэ тогтворжуулах гэрээг Хавсралтаас үзнэ үү.



**Хүснэгт 28. Үнэт цаас гаргагчийн хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжаанаас эргүүлэх худалдан авах нөхцөл**

	Нөхцөл	Хязгаарлалт
1.1	Эргүүлэн худалдаж авах хувьцааны нийт хэмжээ	Компанийн гаргасан нийт энгийн хувьцааны 5 (тав) хувийн хувьцаанаас хэтрэхгүй.
1.2	Эргүүлэн худалдан авах нэгж хувьцааны дээд үнэ	Өмнөх 15 хоногийн арилжааны жинлэсэн дундаж ханшийн 105 (нэг зуун тав) хувиас хэтрэхгүй. 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгөөс
1.3	Багц арилжааны худалдан авах ханшийн дээд хэмжээ	дээш үнийн дүн бүхий багц арилжааны хэлцлийн ханш нь өмнөх 30 хоногийн арилжааны жинлэсэн дундаж ханшийн 105 (нэг зуун тав) хувиас хэтрэхгүй.
1.4	Нэг өдөрт эргүүлэн худалдаж авах хувьцааны тоо	Төлөөлөн удирдах зөвлөлийн эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрсөн нийт энгийн хувьцааны 15 (арван тав) хувиас хэтрэхгүй. Үүнд 1.3 дахь хэсэгт заасан Багц худалдан авалтад хамаарахгүй.
1.5	Хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааны хугацаа	Хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 1 жилийн хугацаанд гүйцэтгэнэ
1.6	Хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагаанаас гарах зардлын тухай	Үнэт цаас гаргагчийн нийтээс татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгөнөөс суутган тооцохгүй
1.7	Зах зээлийг урвуулан ашиглах тухай	Хувьцааны үнийг тогтворжуулах нэрийн дор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасан хэлбэрээр зах зээлийг урвуулан ашиглахгүй

Түүнчлэн Үндсэн андеррайтер нь хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны идэвхийг нэмэгдүүлэх, хувьцааны үнийг зах зээлд бодитоор тогтоход дэмжлэг үзүүлэх зорилгоор Үнэт цаас гаргагчийн ирүүлсэн мэдээллийг нэгтгэн боловсруулж олон нийт болон хөрөнгө оруулагчдад тогтмол хүргэж ажиллана. Үүнд, цаг үеийн мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн хувьцааны хөндлөнгийн судалгаа, шинжилгээ, аливаа онцгой үйл явдлуудыг нийтийн цахим сүлжээгээр шууд дамжуулах, мэдээлэл оруулах, хөрөнгө оруулагчдын цахим шуудан, гар утсаар нь дуудлага хийх замаар мэдээллийг тухай бүр хүргэх зэрэг нь багтаж байна.

#### 4.9 Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болсны дараа компанийн менежмент, түлхүүр ажилтнуудад хувьцааг шууд ба опционоор эзэмшүүлэх төлөвлөгөөг нарийвчлан боловсруулахаар шийдвэрлээд байна.

Менежментийн баг, түлхүүр ажилтнуудад хувьцааг эзэмшүүлэх хөтөлбөр нь олон улсын туршлагад өсөлтийн боломж өндөр компаниудын жишээнд өргөн ашиглагддаг. Ажилтныг урамшуулах нөхцөл нь компанийн амжилт, бодит гүйцэтгэлтэй уялдаж хэрэгждэг.

Үнэт цаас гаргагч нь тус төлөвлөгөөний хүрээнд 3-4 үе шаттайгаар нийт 3.5 хувь хүртэлх хувьцааг нэмж гарган ажилтнуудад шууд эзэмшүүлэх (stock grant) болон опционоор эзэмшүүлэх (stock option) юм. Хэрэгжих нөхцөл нь хувьцааны зах зээлийн нийт үнэлгээ ба санхүү, үйл ажиллагааны үр дүн гэсэн хоёр шалгууртай. Тухайн шалгуурт хамааралтай шууд урамшуулах болон опционоор арилжих хувьцааны тоог урьдчилан тодорхойлно. Үүнд:

- Урамшуулалд олгогдох хувьцаа, опционы зарим хэсэг нь компанийн зах зээлийн үнэлгээтэй,
- Үлдсэн хэсэг нь санхүүгийн ба үйл ажиллагааны гол шалгуур үзүүлэлттэй уялдаатай байна.

**Хүснэгт 29. Үнэт цаас гаргагчийн хувьцаа нэмж гарган ажилтнууддаа шууд болон опционоор хэлбэрээр эзэмшүүлэх нөхцөл**

	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
Нэг. Шалгуур 1-ийн зорилт ба биелүүлсэн тохиолдолд шууд эзэмшүүлэх болон опционоор арилжих хувьцааны тоо:			
Сүүлийн 6 сарын хувьцааны дундаж үнэ	[•]	[•]	[•]
Шууд эзэмшүүлэх хувьцааны тоо	[•]	[•]	[•]
Опционоор хэрэгжих хувьцааны тоо	[•]	[•]	[•]
Хоёр. Шалгуур 2-ийн зорилт ба биелүүлсэн тохиолдолд шууд эзэмшүүлэх болон опционоор арилжих хувьцааны тоо:			
Сүүлийн 12 сарын нийлбэр борлуулалтын дүн	[•]	[•]	[•]
Шууд эзэмшүүлэх хувьцааны тоо	[•]	[•]	[•]
Опционоор хэрэгжих хувьцааны тоо	[•]	[•]	[•]

Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болсны дараа компанийн засаглалын гадаад, дотоодын сайн туршлагыг





2021-09-17

БҮРТГЭВ.О:

хэрэгжүүлж, хөрөнгө оруулагчидтай байнгын харилцаатай, ил тод байхыг зорино.

Үүний тулд менежментийн баг, түлхүүр ажилтнуудыг компанийн соёл, амжилт, гүйцэтгэл, цаашлаад хувьцааны үнийг тогтвортойгоор сайжруулахын төлөө зөв механизмаар урамшуулж ажиллах нь чухал юм. Үнэт цаас гаргагч нь хувьцаа эзэмшигчид ба менежментийн хоорондын заагийг арилгахын тулд үр дүнд суурилсан хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг санаачилж буй нь Үнэт цаас гаргагч, түүний хөрөнгө оруулагчдад эерэг нөлөөтэй. Ижил төрлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн компанийн хувьцааны үнэ дунд, урт хугацаандаа өндөр өсөлттэй байдгийг олон судалгааны ажлуудад дурдсан байдаг.

Менежментийн баг, түлхүүр ажилтнуудад нийт 3.5 хувь хүртэлх хувьцааг үе шаттайгаар эзэмшүүлэх хөтөлбөрийн дэлгэрэнгүй, нарийвчилсан нөхцөлийг нээлттэй хувьцаат компани болсны дараа засаглалын кодексийн дагуу цалин урамшууллын хороо, нийт хувьцаа эзэмшигчид, ТУЗ-өөр дамжуулан шийдвэрлэхээр төлөвлөж байна.

Дээрх хүснэгтэд авч үзэж буй шалгуур, механизм зэрэг нь урьдчилсан төсөөлөл юм.

#### 4.10 Андеррайтерийн худалдан авах хувь хэмжээ

Үндсэн Андеррайтер болох Голомт Капитал ҮЦК нь хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцаанаас хамгийн багадаа 100,000 ширхэг хувьцааг худалдан авах болно.





**ТАВ.  
ҮНЭТ ЦААС ГАРГАХ  
АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН  
БАЙГУУЛАГУУД**



## 5 ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

### 5.1 Хөндлөнгийн үнэлгээний байгууллага танилцуулга, гэрээ

#### Хөндлөнгийн үнэлгээний байгууллагын танилцуулга


Гэрэгэ Эстимэйт ХХК нь хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний чиглэлээр ажилладаг үнэлгээний мэргэжлийн компани юм. Үнэлгээний баг нь үнэлгээчин, актуарч, нягтлан бодогч, эдийн засагч, санхүүч зэрэг олон чиглэлийн нарийн мэргэжлийг гадаад дотоодын их дээд сургуулиудад эзэмшиж, мэргэжлээрээ ажилласан туршлагатай чадварлаг мэргэжилтнүүдээс бүрддэг.


Бизнесийн үнэлгээний болон хөрөнгийн үнэлгээний томоохон ажлууд дээр Гэрэгэ Эстимэйт ХХК болон Гэрэгэ Партнерс ХХК-ийн мэргэжилтнүүдийн хамтарсан баг ажилладаг. Гэрэгэ Партнерс ХХК нь эдийн засаг, санхүү, бизнес, актуарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээний компани юм.

Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь Монголын Хөрөнгийн Бирж дээр үнэт цаас арилжаалах компаниудын бизнесийн үнэлгээ хийх эрхтэй Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгэлтэй компани бөгөөд үнэлгээний багт Монгол Улсын Сангийн Яамнаас олгодог мэргэшсэн үнэлгээчин сертификаттай 3 үнэлгээчин ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр анхлан гаргах зориулалтаар хийсэн үнэлгээний багийн ахлагчаар Доноровын Гантулга ажиллав. Д.Гантулга нь Мэргэшсэн Үнэлгээчдийн Роял Институт (RICS)-ийн гишүүн, бизнесийн болон биет бус хөрөнгийн үнэлгээний мэргэшсэн үнэлгээчин ба RICS нь газар, хөрөнгө, дэд бүтэц, байгууламжийн үнэлгээний мэргэшил болон стандарт тогтоодог дэлхийн тэргүүлэх байгууллага юм.

Хөндлөнгийн үнэлгээний байгууллагын үнэлгээчид нийт 20 орчим бизнесийн үнэлгээний ажил хийж гүйцэтгэсэн. Тэрээр 2017 онд Монгол Улсын анхны финтек компани болох ЛендМН ББСБ, 2018 онд Инвескор ББСБ, 2019 онд Бодь Даатгал зэрэг





компаниудын бизнесийн үнэлгээг тус компаниудын хувьцааг хөрөнгийн биржид анхлан гаргах зориулалтаар хийж гүйцэтгэсэн туршлагатай бөгөөд эдгээр компаниудын хувьцаа нь Монголын Хөрөнгийн Бирж дээр амжилттай арилжаалагдаж байна.

### **Хөндлөнгийн үнэлгээний байгууллагатай байгуулсан гэрээний тухай**

Үнэт цаас гаргагч нь үнэлгээний Гэрэгэ Эстмэйт ХХК-тай 2021 оны 5 сарын 11-ний өдөр байгуулсан CVS-2021/0136 дугаартай Бизнесийн ба хувьцаат капиталын үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээний дагуу Гэрэгэ Эстимэйт ХХК нь Үнэт цаас гаргагч болон түүний 100 хувь охин компани болох Премиум Дистрибьюшн ХХК-ийн бизнесийн нэгтгэсэн үнэлгээг хийж, Үнэт цаас гаргагчийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр анх удаа олон нийтэд санал болгох (IPO) зориулалтаар Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж шаардлагын хүрээнд Үнэлгээний олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэхээр тохиролцсон байна.

Бизнесийн үнэлгээний гэрээнд Үнэт цаас гаргагч нь үнэлгээний ажилд шаардагдах мэдээ, мэдээллээр хангах, гэрээгээр тохиролцсон ажлын хөлсийг төлөх, Гэрэгэ Эстмэйт ХХК нь үнэлгээний тайланг үнэт цаас гаргагчийн Санхүүгийн Зохицуулах Хорооноос Олон нийтэд анх удаа үнэт цаас гаргах зөвшөөрөл хүсэх ажлын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах, гэрээний хугацаанд Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулагчдад танилцуулга хийх аянд оролцох, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцдаа олж мэдсэн Үнэт цаас гаргагчийн болон эд хөрөнгийн өмчлөгчийн талаарх бүхий л мэдээлэл, баримт бичиг, зураг, төсөл, программ хангамж, дижитал мэдээллийг (үүгээр хязгаарлагдахгүй) түүний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр задруулахгүй, дамжуулахгүй байх үүрэг хүлээхээр тохиролцсон байна.


## **5.2 Хөндлөнгийн аудитын байгууллагуудын танилцуулга, гэрээ**

### **Хөндлөнгийн аудитын байгууллагуудын танилцуулга**

БДО Аудит ХХК нь дэлхийд 5-д эрэмбэлэгдэж буй сүлжээ компани болох BDO Global-ийн жинхэнэ гишүүн бөгөөд Монгол улсад 2013 оны 01 сарын 01-ний өдрөөс BDO брэндийг Монгол







улсад төлөөлж эхэлсэн. BDO Global нь дэлхийн 167 улсын 1658 оффисын 90,000 гаруй ажилтнуудаар дамжуулан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг сүлжээ пүүс юм. БДО Монгол нь БДО Аудит ХХК, БДО Такс ТМЗ ХХК болон БДО Академи ТББ-ын нийт 4 Партнер, 60 гаруй мэргэжилтнээр дамжуулан аудит, нягтлан бодох бүртгэл, татварын зөвлөх үйлчилгээ, хөрөнгийн ба бизнесийн үнэлгээ, аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байна.

БДО Аудит ХХК нь Үнэт цаас гаргагчид аудитын болон үнэлгээний үйлчилгээ үзүүлэх эрхийг Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан бөгөөд хөрөнгийн зах зээлд идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг.

Өнгөрсөн хугацаанд БДО Аудит ХХК нь


- АПУ ХК (Бизнес нэгдэл - Үнэлгээ)
- Ард Кредит ББСБ ХК (IPO - үнэлгээ)
- Ард Санхүүгийн нэгдэл (Хувьцаат компани нэгтгэх - үнэлгээ)
- Инвескор ББСБ ХК (IPO - аудит)
- Ард Даатгал ХК (IPO - үнэлгээ)
- Мандал Даатгал ХК (IPO - үнэлгээ)
- Хөвсгөл алтан Дуулга (Нэмэлт хувьцаа гаргалт - үнэлгээ)
- Эрдэнэс Тавантолгой ХК (Бонд гаргалт - Үнэлгээ)

зэрэг компаниудын олон нийтэд хувьцаа, үнэт цаас анх удаа санал болгох үйл ажиллагаанд мэргэжлийн оролцогч (аудит ба үнэлгээ)-оор амжилттай ажилласан туршлагатай бөгөөд Голомт Капитал ҮЦК ХХК, Ти Ди Би Капитал ҮЦК ХХК, Би Ди Сек ҮЦК ХК, Бумбат-Алтай ҮЦК ХХК, Инвескор капитал ҮЦК ХХК, Ард секюритиз ҮЦК ХХК, Ард Капитал ҮЦК (Өлзий энд ко капитал ҮЦК) ХХК зэрэг үнэт цаасны компаниудтай хамтран ажиллаж байна.

### **Хөндлөнгийн аудитын компанитай байгуулсан гэрээний тухай**

БДО Аудит ХХК нь Үнэт цаас гаргагчтай 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр REL/10/21 тоот "Гэрээт ажлын захидал"-ыг байгуулсан бөгөөд "Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХХК-ийн 2021 оны 6 сарын 30-ны өдрөөр тасалбар болсон завсар үеийн санхүүгийн мэдээллүүд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 34, Завсар үеийн санхүүгийн тайлагнал болон бусад холбогдох СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар нягтлах ажлыг гүйцэтгэж байна. Тус гэрээт ажлын





хүрээнд хараат бус аудитор нь үнэт цаас гаргагчийн завсар үеийн санхүүгийн мэдээллийг Нягтлах Ажлын Олон Улсын Стандарт (ISRE) 2400-ийн дагуу дунд түвшний баталгаа гаргана.

Гэрээт ажлын захидлын дагуу үнэт цаас гаргагчийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг зохих үзэл баримтлалын дагуу үнэн зөв, шударгаар бэлтгэж, санхүүгийн тайлангуудыг залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг тодорхойлж бүрдүүлсэн байх бөгөөд аудиторыг бүртгэл, баримт, бусад мэдээлэл зэрэг санхүүгийн тайлан бэлтгэхтэй холбоотой бүх мэдээлэлд нэвтрэх, нягтлах ажлын зорилгоор бусад нэмэлт мэдээллээр хангах, нягтлах ажлын нотолгоо олж авахад зайлшгүй шаардлагатай гэж аудиторын тодорхойлсон ажилтнуудтай ямар нэгэн бэрхшээлгүй харилцах боломжоор хангах үүрэг хүлээнэ. Хараат бус аудитор нь олж авсан нотолгоондоо үндэслэн үнэт цаас гаргагчийн 2021 оны 06 сарын 30-аар тасалбар болсон завсар үеийн санхүүгийн тайлангууд нь НББОУС 34 Завсар үеийн санхүүгийн тайлагнал болон бусад холбогдох СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар Нягтлах ажлын дүгнэлт илэрхийлэх үүрэг хүлээнэ.


### 5.3 Хуулийн фирмийн танилцуулга, гэрээ

#### Хуулийн фирмийн танилцуулга


Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН (Хуулийн фирм) нь 2013 оны 6 сарын 18-ны өдөр Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн мэргэшсэн бизнесийн хуулийн фирм юм. Тус Хуулийн фирм нь концесс, төр хувийн хэвшлийн түншлэл (дэд бүтэц, төмөр зам, авто зам, угаах үйлдвэр, барилга, эрчим хүчний салбар) бизнест компанийн хууль, эрх зүйн түгээмэл тохиолддог асуудлуудаар аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч, компаниудад хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд уул уурхай, барилга, ашигт малтмал, санхүүгийн салбарт мэргэшсэн туршлагатай.

Хуулийн фирм нь үнэт цаасны зах зээлийн оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооны 2014 оны 72 тоот тогтоолын дагуу авсан бөгөөд үнэт цаасны зах зээлийн оролцогчдод хууль зүйн туслалцаа, хөндлөнгийн дүгнэлт гаргаж өгөх үйлчилгээ үзүүлэх эрхтэй, гадаад, дотоодын хөрөнгийн биржид хувьцаа, өрийн бичиг, хөрөнгөөр баталгаажсан





Үнэт цаасны танилцуулга



үнэт цаас гаргах зэрэг үнэт цаасны зах зээлийн бүхий л үе шатанд ажиллаж байсан туршлагатай. Тухайлбал, Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК-ийн олон улсын хөрөнгийн зах зээл 250 сая ам.доллар болон 300 сая ам.долларын өрийн хэрэгсэл буюу бонд гаргах, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааг дотоодын хөрөнгийн зах зээлийн арилжаа эрхлэх, зохицуулагч байгууллагын бүртгэлд бүртгүүлэх, 2 их наяд төгрөг хүртэлх өрийн хэрэгсэл буюу бонд гаргах, Монголын даатгалын салбарт анхдагч IPO болох Мандал Даатгал ХХК-ийн хэлбэрийг өөрчлөх замаар анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгон үнэт цаас гаргах, Монгол Улсын анхны финтек компани МОСТ Финтек ХХК-ийн хэлбэрийг өөрчлөх замаар анх удаа нийтэд санал болгон үнэт цаас гаргах, тусгай зориулалтын компанид АПУ ХК-ийг нэгтгэх, АПУ ХК-иас нэмж хувьцаа гаргах замаар нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах, ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргах, тусгай зориулалтын компаниар дамжуулан үнэт цаас гаргах зэрэг ажилд хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийх, хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлж ажилласан туршлагатай.

### Хуулийн фирмтэй байгуулсан гэрээний тухай

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчтай 2021 оны 4 сарын 30-ны өдөр байгуулсан CVS-2021/0165 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах хөндлөнгийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэх, улмаар хуулийн дүгнэлт гаргах ажлыг хийхээр тохиролцсон. Уг ажилтай холбогдуулан Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн мэдээлэл, баримт, материалыг шалгаж, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 408 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр зүйлийн 4.2.2 дахь хэсэгт заасан асуудал, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2018/01 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасан асуудлын хүрээнд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, хуулийн дүгнэлтийг бэлтгэхээр тохиролцсон байна.

Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу Үнэт цаас гаргагч нь тус гэрээний дагуу гүйцэтгэх ажилтай холбоотой бүхий л мэдээлэл, баримт бичиг, шийдвэрийг үнэн зөв, бүрэн гүйцэд,



шаардлагатай цаг хугацаанд нь тухай бүр гаргаж өгөх, холбогдох тайлбар, нэмэлт мэдээлэл, баримтыг гаргаж өгөх, гэрээгээр тохиролцсон ажлын хөлсийг тохиролцсон хугацаанд бүрэн төлөх, Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн гаргаж өгсөн баримт, материал мэдээлэлд үндэслэн үнэт цаасны бүртгэлийн журамд заасан асуудлаар үнэн зөв дүгнэлт гаргах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой олж авсан Үнэт цаас гаргагчаас хүлээн авсан бүхий л мэдээлэл, бичиг баримт (үүгээр хязгаарлагдахгүй) нууцлалыг чанд хадгалах үүрэг хүлээх, мөн зөвлөх үйлчилгээний ажлын талаар (энэхүү мэдээлэл нь нийтэд ил болох хүртэлх хугацаанд) гуравдагч этгээдэд аливаа байдлаар мэдээлэхийг хориглохоор тохиролцсон байна.

## 5.4 БОНЗ-ын үнэлгээний байгууллага, гэрээ

### БОНЗ-ын үнэлгээний байгууллагын танилцуулга

Ризилиенс Консалтинг Сервиз ХХК нь 2020 онд тогтвортой хөгжлийг дэмжих төрөл бүрийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аж ахуйн нэгжүүдэд тогтвортой хөгжлийн зөвлөгөө өгөх чиглэлээр байгуулагдсан.

БОНЗ-ын үнэлгээний байгууллагын зөвлөхүүдийн БОНЗ-ын менежментийн чиглэлээр хийсэн ажлын туршлагаас дурдвал:


- Монголиан Майнинг Корпораци (НКЕХ: 975) нь Хонконгийн хөрөнгийн бирж дээр 2010 онд хувьцаа гаргасан бөгөөд тус төслийн баримт бичгийн нийгэм болон байгаль орчны хэсгүүдийг боловсруулсан.
- Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны санхүүжилтэд тавих үндсэн шаардлагын хүрээнд Ухаа худаг коксжих нүүрсний уурхайн нэг ба хоёрдугаар үе шатны үйл ажиллагааны Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайлан, менежментийн төлөвлөгөөг боловсруулж амжилттай хэрэгжүүлсэн.
- Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн стандарт (2012)-ын дагуу Оюу Толгойн төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ ний тайлан, менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлсэн.







Үнэт цаасны танилцуулга



- Таван Толгойн зүүн Цанхийн ордын үйл ажиллагаанд зориулж Хонг Конгийн Хөрөнгийн Биржээс санхүүжилт босгох ажлын хүрээнд төслийн БОНЗ-ын үнэлгээ хийх ажилд оролцсон.
- Энержи Ресурс ХХК-ийн Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог бий болгосон;
- Мөн зөвлөхүүд нь ISO 9001, ISO 14001, ISO22000 ба ISO / PAS 45005 стандартын аудиторууд бөгөөд ISO 9001, ISO 14001, ISO45001, Хөдөө аж ахуйн зохистой дадал стандартуудын зөвлөгөө өгөх, аудит хийж байсан туршлагатай.


### **БОНЗ-ын үнэлгээний байгууллагатай байгуулсан гэрээний тухай**

БОНЗ-ын үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчтай Зөвлөх үйлчилгээний гэрээг 2021 оны 5 сарын 5-ны өдөр байгуулсан. Тус гэрээгээр тодорхойлсон зөвлөх үйлчилгээний агуулга нь Сэнтрал Экспресс, Премиум Дистрибьюшний харьяа CU конвиеинс сүлжээ дэлгүүрүүд болон нэгдсэн түгээлтийн систем, хоол боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд БОНЗ-ын суурь үнэлгээ хийх ажлыг хийж гүйцэтгэхээр тусгасан байна.

БОНЗ-ын үнэлгээний байгууллага нь гэрээний дагуу Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны БОНЗ-ын суурь үнэлгээг хийх гэрээгээр хүлээсэн үүрэгт ажлаа чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, ажлыг гүйцэтгэх явцад сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон даруйд Үнэт цаас гаргагчид мэдэгдэх, түүний нэр хүндэд харш үйлдэл хийхгүй байх, гэрээний хугацаанд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, хоорондоо солилцсон аливаа материал, баримт бичиг болон мэдээллийг гэрээний хугацаа дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд нууцлах, Үнэт цаас гаргагчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд танилцуулах, шилжүүлэх, мэдэгдэх, задруулахгүй байх үүрэг хүлээн ажилласан.

Нөгөө талаас Үнэт цаас гаргагч нь БОНЗ-ын үнэлгээний байгууллагад гэрээгээр тохиролцсон зөвлөх үйлчилгээний хөлсийг хугацаанд нь бүрэн төлөх, гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох мэдээ, мэдээлэл, баримт бичгийг гүйцэтгэгч талын шаардсанаар үнэн зөв гаргаж өгөх зэрэг





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-09-17

Үнэт цаасны танилцуулга  
БҮРТГЭВ-02

шаардагдах бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэг хүлээн харилцан тохиролцсон байна.

## 5.5 Үндсэн андеррайтерийн танилцуулга, гэрээ


### Үндсэн андеррайтерийн танилцуулга

Үндсэн андеррайтер болох Голомт Капитал ҮЦК ХХК нь 2012 онд Голомт Банк ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар байгуулагдсан. Үндсэн андеррайтер нь СЗХ-оос 2011 онд брокерын үйлчилгээ, 2014 онд хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ, 2015 онд андеррайтерийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус авч иргэд, аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулалтын цогц үйлчилгээг үзүүлж байна.

Үндсэн андеррайтерийн хөрөнгийн зах зээлд гаргасан гол амжилтууд:

- 2015 онд Монголын анхны даатгагдсан бонд болох Эрчим бондыг хөрөнгийн зах зээлд гаргаж, 500 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн
- 2017 онд хаалттай хүрээнд ММФ бонд болон Урбан бондыг гаргасан
- 2017 онд Монголын анхны нээлттэй бонд болох Сүү бондын андеррайтераар ажиллаж 6.0 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн
- 2018 онд хаалттай хүрээнд Нэт, Бэрс, Алтан намар бондыг тус тус гаргасан
- 2018 онд Торонтогийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК-ийн давхар бүртгэлийн туслах андеррайтераар, даатгалын зах зээлд тэргүүлэгч Мандал Даатгал ХК-ийн IPO үндсэн андеррайтераар ажиллаж 10 тэрбум төгрөг амжилттай татан төвлөрүүлсэн
- 2019 онд шувууны аж ахуйн салбарт тэргүүлэгч Түмэн Шувуут ХК IPO үндсэн андеррайтераар, эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрлэлийн зах зээлд тэргүүлэгч Монос Хүнс ХК-ийн IPO үндсэн андеррайтераар тус тус ажиллаж 18.6 тэрбум төгрөг амжилттай татан төвлөрүүлсэн





Үнэт цаасны танилцуулга

- 2020 онд Монголын анхны хайбрид бонд болох Мастер бонд, анхны 100 хувийн банкны баталгаат бонд болох Нөмөр бондын андеррайтераар ажиллаж, 4.8 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

### Үндсэн андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Үндсэн андеррайтер нь 2015 оны 3 сарын 23-ны өдөр СЗХ-ны 156 тоот тогтоолоор авсан 3/97 тоот Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд Үнэт цаас гаргагчтай байгуулсан 2021 оны 6 сарын 25-ны өдрийн CVS-2021/0221 (21/17) тоот Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд энгийн хувьцаа санал болгох үйл ажиллагаанд андеррайтерийн үүрэг гүйцэтгэж байна. Тус гэрээний хүрээнд Үндсэн андеррайтер нь Үнэт цаас гаргагчид хөрөнгийн зах зээлээс нээлттэй хүрээнд хөрөнгө татахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх, шаардагдах тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулагч нарт Үнэт цаас гаргагч болон түүний гаргаж буй үнэт цаасыг танилцуулах, санал болгох, санхүүжилт татаж өгөх, Үнэт цаас гаргагч нь Андеррайтерийг гэрээгээр хүлээсэн ажлаа гүйцэтгэхэд нь дэмжин ажиллаж, шаардлагатай мэдээлэл, материалыг гарган өгч хамтран ажиллахаар харилцан тохиролцсонтой холбоотой талуудын хооронд үүсэх харилцаа зохицуулагдсан.

Үндсэн андеррайтер нь Үнэт цаас гаргагчид нээлттэй хүрээнд санхүүжилт татахад СЗХ болон МХБ-ээс гаргасан Үнэт цаасны бүртгэлийн журын дагуу үнэт цаас гаргах төлөвлөгөөг бэлтгэн, тухайн хамтарсан төлөвлөгөөний дагуу оролцогч талуудын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэт цаасны бүртгэлийн шалгуурыг хангахад зөвлөгөө өгөх, үнэт цаасны танилцуулга материалыг бэлтгэхэд шаардлагатай удирдлагаар хангах, санал зөвлөмжийг өгөх, стратегийн хөрөнгө оруулагч нарт хувьцааны танилцуулгыг компанийг төлөөлөн танилцуулах болон нийт татан төвлөрүүлэх санхүүжилтээс 10 тэрбум төгрөгийг заавал биелүүлэх (firm commitment) баталгааг гаргасан болно.

Үнэт цаас гаргагч нь Үндсэн андеррайтерт гэрээнд заасан үйлчилгээг үзүүлэхэд нь шаардлагатай үнэн зөв, бодит мэдээлэл, бичиг баримт болон материалуудын эх хувь эсвэл баталгаажсан хуулбарыг Үндсэн андеррайтераас шаардсан цаг тухайд нь бүрэн гаргаж өгөх үүрэг хүлээнэ.



## 5.6 Туслах андеррайтерийн танилцуулга, гэрээ

### Туслах андеррайтерийн танилцуулга


Туслах андеррайтер Апекс Капитал ҮЦК ХХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан ба 2018 онд компанийн менежментийн багийг шинэчилснээр одоогийн удирдлагын баг ажиллаж эхэлсэн. Апекс Капитал ҮЦК ХХК нь СЗХ-оос брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн тусгай зөвшөөрөлтэй, гадаад арилжааны үйлчилгээ үзүүлэх эрхтэйгээр санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлдэг.

2018 оноос хойш андеррайтерийн үйлчилгээг 30 гаруй аж ахуйн нэгжид үзүүлэн нийт 130 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилт татах ажил дээр амжилттай ажилласан.


Туслах андеррайтерийн хөрөнгийн зах зээлд хийсэн голлох ажлууд:

- 2018-2020 онд хаалттай хүрээнд нийт 60 орчим тэрбум төгрөгийн бондын санхүүжилтийг татсан ба салбараар ангилбал:
  - o Хүнсний салбарын байгууллагуудад 11.5 тэрбум төгрөг
  - o Барилгын салбарын байгууллагуудад 11.8 тэрбум төгрөг
  - o Тээвэр зуучлалын салбарын байгууллагуудад 13.9 тэрбум төгрөг
  - o Санхүүгийн салбарын байгууллагуудад 21.8 тэрбум төгрөгийн санхүүжилт татсан.
- 2021 онд хаалттай хүрээний санхүүжилтийн цар хүрээ тэлж эхний хагас жилд 27.3 тэрбум төгрөгийн санхүүжилт дээр ажилласан.
- 2021 оны 7 сард 50 тэрбум төгрөгийн санхүүжилт босгож буй Мандал Ирээдүйн Өсөлт хамтын хөрөнгө оруулалтын санд Андеррайтераар нь ажиллаж байна. Тус сан нь Монголын хамгийн том хамтын хөрөнгө оруулалтын санд тооцогдох юм.





Үнэт цаасны танилцуулга



### Туслах андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Алекс Капитал ҮЦК ХХК нь Үнэт цаас гаргагч болон Үндсэн андеррайтертай 2021 оны 6 сарын 28-ны өдрийн 21/21 тоот гурван талт Хамтын ажиллагааны гэрээг байгуулсны үндсэн дээр Үнэт цаас гаргагчийн анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгох ажиллагаанд Туслах андеррайтераар оролцож байна.

Туслах андеррайтер нь Монгол Улсын хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн холбогдох журамд заасанд нийцүүлэн андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхээр харилцан тохиролцсон.

Хамтран ажиллах гэрээний дагуу Туслах андеррайтер нь нээлттэй хүрээнд хөрөнгө татахад зөвлөх, шаардагдах тооцоолол, судалгаа гүйцэтгэх ажилд Үнэт цаас гаргагч болон Үндсэн андеррайтертай хамтран ажиллах, санал зөвлөмж өгч оролцох, хөрөнгө оруулагчдад Үнэт цаас гаргагч болон түүний гаргаж буй үнэт цаасыг танилцуулах, санал болгох, санхүүжилт татаж татан төвлөрүүлэх ажлыг бие даан гүйцэтгэнэ.

Туслах андеррайтер нь нийт татан төвлөрүүлэх санхүүжилтээс 2 тэрбум төгрөгийг заавал биелүүлэх (firm commitment) баталгааг гаргасан болно.

Үнэт цаас гаргагч болон Үндсэн андеррайтер нь гэрээнд заасан үйлчилгээг үзүүлэхэд нь шаардлагатай үнэн зөв, бодит мэдээлэл, бичиг баримтыг шаардсан цаг тухайд нь бүрэн гаргаж өгөх үүргийг гэрээний дагуу хүлээсэн.





2021-09-17

Үнэт цаасны танилцуулга  
БҮРТГЭВ-02

## 5.7 Андеррайтерийн дүгнэлт

**Golomt Capital**  
*Delivering diversity*

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
Чингисийн өргөн чөлөө 24, Парк Плейс  
оффисын барилга, 4 давхар, 403 тоот,  
Утас: 7012-1530, 7012-1529  
И-мэйл: info@golomtcapital.com,  
Вэбсайт: www.golomtcapital.com

2021.09.13 № 21/205  
-ны № \_\_\_\_\_ т

### СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК-ИЙН ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ХҮРЭЭНД САНАЛ БОЛГОЖ БҮЙ ЭНГИЙН ХУВЬЦААНД ӨГӨХ АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

Голомт Капитал ҮЦК ХХК нь (цаашид "Үндсэн андеррайтер" гэх) нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2015 оны 3 дугаар сарын 23-ны өдөр олгосон Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК (цаашид "Үнэт цаас гаргагч" гэх)-тай 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдөр CVS-2021/0221 (21/17) тоот Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ (цаашид "Андеррайтерийн гэрээ" гэх)-г байгуулсан. Тус гэрээний хүрээнд Үнэт цаас гаргагчийн 119,966,060 ширхэг хувьцааг нэмж гарган Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нэгж хувьцааны үнийг 208 төгрөгөөр олон нийтэд нээлттэй санал болгон, нийт 24,952,940,480 төгрөгийг татан төвлөрүүлж нээлттэй хувьцаат компани болох үйл ажиллагаанд Үндсэн андеррайтераар ажиллаж байна.


Үндсэн андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд санал болгох үйл ажиллагааг Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн ТУЗ-ийн 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам болон бусад холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэж байгаа болно.

Мөн Үндсэн андеррайтерийн үйлчилгээний төрлийг Андеррайтерийн гэрээнд заасан андеррайтерийн төрлөөр буюу нийт татан төвлөрүүлэх санхүүжилтийн тодорхой хувийг заавал биелүүлэх (firm commitment) баталгаатай гүйцэтгэж байна.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд нээлттэй худалдах үнэт цаасны бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, СЗХ-ны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 408 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журам шинэчлэн батлах тухай журмын 4.1, Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ийн 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам, МХБ-ийн 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 2015/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан МХБ-ийн ТУЗ-ийн 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан МХБ ТӨХК-ийн Арилжааны хурмын дагуу явагдана.

000409





Олон нийтэд үнэт цаас санал болгон хөрөнгө оруулалт татах бэлтгэл ажлын хүрээнд Үнэт цаас гаргагч нь Үндсэн андеррайтертай Андеррайтерийн үйлчилгээний гэрээ байгуулан ажиллахаас гадна дараах бэлтгэл ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Үнэт цаас гаргагч нь Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН-тай 2021 оны 4 сарын 30-ны өдөр CVS-2021/0165 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох үйл ажиллагаанд хөндлөнгийн хуулийн дүгнэлт гаргах ажлыг гүйцэтгүүлсэн.
2. Үнэт цаас гаргагч нь БДО Аудит ХХК аудитын компанитай 2021 оны 6 сарын 30-ны өдөр REL/10/21 тоот Аудитын үйлчилгээний гэрээг байгуулан үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох үйл ажиллагааны 2021 оны хагас жилийн 2021 оны 06-р сарын 30-ны өдрөөр тасалбар болсон завсар үеийн санхүүгийн мэдээллүүд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 34, Завсар үеийн санхүүгийн тайлагнал болон бусад холбогдох СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар нягтлах ажлыг гүйцэтгүүлсэн.
3. Үнэт цаас гаргагч нь Гэрэгэ Эстимэйт ХХК-тай 2021 оны 5 сарын 11-ний өдөр CVS-2021/0136 тоот Бизнесийн ба хувьцаат капиталын үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээг байгуулан үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээний дүгнэлтүүдийг гаргуулсан.
4. Үнэт цаас гаргагч нь Ризилиенс Консалтинг Сервиз ХХК-тай 2021 оны 6 сарын 28-ны өдөр CVS-2021/0164 тоот Зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох үйл ажиллагаанд CU конвиниенс сүлжээ дэлгүүрүүд болон нэгдсэн түгээлтийн систем, хоол боловсруулах үйлдвэрийн Байгаль орчин, нийгмийн засаглал (БОНЗ)-ын суурь үнэлгээг хийлгүүлсэн.
5. Үнэт цаас гаргагч болон Үндсэн андеррайтер болох Голомт Капитал ҮЦК, Туслах Андеррайтер болох Апекс Капитал ҮЦК ХХК-тай 2021 оны 6 сарын 28-ны өдөр 21/21 тоот гурван талт Хамтын ажиллагааны гэрээг байгуулсан.
6. Үнэт цаас гаргагч нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 7 сарын 26-ны өдрийн 6 тоот тогтоол, ТУЗ-ийн 2021 оны 7 сарын 26-ны өдрийн 11 тоот тогтоол, ТУЗ-ийн 2021 оны 9 сарын 09-ний өдрийн 151021-13 тоот тогтоолоор энэхүү Үнэт цаасыг гаргах тухай шийдвэр гаргасан.



Үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгон арилжих ажлын хүрээнд Үндсэн андеррайтер нь мэргэжлийн түвшинд хийгдсэн судалгаа шинжилгээний үр дүнд тулгуурлан Үнэт цаасны танилцуулгыг боловсруулан, дараах мэргэжлийн дүгнэлтийг танилцуулж байна. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийн бизнес, үйл ажиллагаа
- Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн төлөв байдал
- Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны стратеги болон бизнес төлөвлөгөө
- Үнэт цаас гаргагчийн санхүүгийн шинжилгээ
- Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээ
- Үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт
- Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн шинжилгээ


#### **Үнэт цаас гаргагчийн бизнес, үйл ажиллагаа**

Премиум Групп ХХК нь Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийг 2017 онд үүсгэн байгуулж Монгол Улсад анх удаа анхны конвينيенс дэлгүүрийн сүлжээг нэвтрүүлсэн. Улмаар 2018 оны 8 сард БНСУ-ын БиЖиЭф Ритэйл компанитай CU конвينيенс дэлгүүрийн Мастер франчайзийн гэрээг байгуулснаар Улаанбаатар хотод 6 дэлгүүрийг зэрэг нээсэн. 2021 оны 6 сарын байдлаар Үнэт цаас гаргагч нь нийт 127 салбар дэлгүүр, 800 гаруй ажилтантайгаар Монгол Улсын конвينيенс дэлгүүрийн 74 хувийг дангаар бүрдүүлэн салбартаа тэргүүлж байна.

Үнэт цаас гаргагч нь CU конвينيенс дэлгүүрээр дамжуулан хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралд эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгийн ойр байрлах ая тухтай орчинд 24 цагийн турш санал болгохыг зорьдог. Тус бүтээгдэхүүн үйлчилгээг тасралтгүй хүргэх, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг тогтмол өндөр түвшинд байлгахын тулд Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүн үйлчилгээний ялгарал, логистикийн, технологийн цогц шийдлийг бий болгож, нийгмийн дэд бүтцийн нэг хэсэг болон ажиллаж байна.








Бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгарал

Үнэт цаасны танилцуулга



CU конвинеенс дэлгүүр нь GET Coffee, Delaffe, HeyRoо, CU Slushie зэрэг өөрийн нэрийн 50 орчим бүтээгдэхүүн, Айсмарк, Милко, Фрэшбокс зэрэг 10 орчим үндэсний үйлдвэрлэгчидтэй хамтран хөгжүүлсэн 40 нэр төрлийн болон олон улсад тренд болж буй бүтээгдэхүүнийг санал болгосноор бүтээгдэхүүний ялгарлыг бий болгож, найрсаг үйлчилгээ болон ая тухтай орчныг бүрдүүлснээр хэрэглэгчид өгөх үнэ цэнийг нэмэгдүүлдэг. Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүний хэрэглэгчид өгөх үнэ цэнээс хамааруулан үнийн уян хатан үнийн бодлого баримталдаг. Үнэт цаас гаргагч нь 2020 оны 5 сард 30 минутын дотор хүргэж өгөх хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлж 2,000 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчид санал болгосон нь хувьсан өөрчлөгдөж буй хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг бий болгож, дижитал шилжилтийг амжилттай нэвтрүүлж буйн илрэл юм.

#### Логистикийн цогц шийдэл

Үнэт цаас гаргагч нь бараа бүтээгдэхүүний бэлэн байдлыг тогтмол хангахын тулд 2020 онд охин компани болох Премиум Дистрибьюшн ХХК-иар дамжуулан хүйтэн хэлхээт болон хэвийн температурын горимтой бүтээгдэхүүний түгээлтийн төвүүдийг ашиглалтад оруулсан. Эдгээр түгээлтийн төвүүд нь өдөрт 500 орчим ханган нийлүүлэгчийн 3.5 мянга орчим бараа бүтээгдэхүүнийг хүлээн авдаг бөгөөд бүтээгдэхүүний онцлогоос хамаарч өдөрт 3-4 удаагийн давтамжтайгаар дэлгүүрүүдэд түгээдэг. Ингэснээр Үнэт цаас гаргагч нь бараа бүтээгдэхүүний чанар алдагдах, солигдох, хугацаа алдах зэрэг бэлтгэн нийлүүлэгчээс хамаарсан үйл ажиллагааны эрсдэлийг бууруулж, бараа бүтээгдэхүүний нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлж байна.

Үнэт цаас гаргагчийн охин компани болох Премиум Дистрибьюшн ХХК нь 2020 оны 11 сард Баянзүрх дүүргийн Хонхор тосгонд 2,960м<sup>2</sup> талбайтай CU хоолны үйлдвэрийг ашиглалтад оруулсан. Тус үйлдвэр нь CU конвинеенс дэлгүүрт савласан хоолыг нийлүүлдэг бөгөөд өдөрт 20 гаруй нэр төрлийн 8 мянган ширхэг хоолыг хүнсний хугацаа уртасгагч, тогтворжуулагч бодисгүйгээр үйлдвэрлэж байна. CU хоолны үйлдвэр нь хүнсний аюулгүй байдлын олон улсын Аюулын дүн шинжилгээ ба Эгзэгтэй цэгийн хяналтын (НАССР) болон Үйлдвэрлэлийн зохистой дадлын (GMP) тогтолцооны болзлыг





ГИЙН БИРХ  
EXCHANGE

Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-02

хангасан Монголын анхны нэг чиглэлийн урсгалтай нийтийн хоолны үйлдвэр юм. Ингэснээр Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын 31.7 хувийг бүрдүүлдэг хоолны бүтээгдэхүүний чанарын эрсдэлийг бууруулж, хэрэглэгчийн завгүй амьдралын хэв маягт нийцсэн бүтээгдэхүүнийг өдөр бүр шинээр хүргэж байна.

#### Технологийн цогц шийдэл

Үнэт цаас гаргагч нь өдөр тутмын үйл ажиллагаанд технологийн дэвшилтэд шийдлийг тогтмол ашигладаг байна. Тодруулбал, бараа бүтээгдэхүүний урсгалыг оновчтой удирдахын тулд Vendor portal программ хангамж, борлуулалтын тоо хэмжээ, бүтээгдэхүүний эргэцийг сайжруулахын тулд Microsoft LS Retail NAV цогц систем, Microsoft Power Bi программ хангамжийг тус тус ашигладаг.

Үнэт цаас гаргагч нь үнэнч хэрэглэгчийг урамшуулах зорилгоор CU аппликэйшн (CU app)-д суурилсан лоялти хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. 2021 оны 6 сарын байдлаар CU app-ийг 600 мянга гаруй хэрэглэгч гар утсандаа суулгаж, худалдан авалт, хүргэлтийн захиалга өгөхдөө тогтмол ашиглан, 70 хувь хүртэлх бодит хямдрал урамшууллыг авч буй нь жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа явуулдаг Үнэт цаас гаргагчийн хувьд урт хугацаанд үнэнч хэрэглэгчийн бааз суурийг бий болгоход чухал ач холбогдолтой байна.

#### Нийгмийн дэд бүтэц

Конвиниенс дэлгүүр нь бараа бүтээгдэхүүн борлуулахаас гадна хэрэглэгчийн өдөр тутмын хэрэгцээг нэг дороос олгох нийгмийн дэд бүтцийн үүргийг гүйцэтгэдэг. Тодруулбал, CU конвиниенс дэлгүүр нь Улаанбаатар хотын гудамж талбайд аюулгүй, гэрэлтэй, харуул хамгаалалттай, үнэгүй интернэт бүхий орчныг 24 цагийн туршид бүрдүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, төөрсөн хүүхдүүдийг хамгаалах нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлдэг.

Үнэт цаас гаргагч нь 2021 оны 6 сарын байдлаар 127 CU конвиниенс дэлгүүрийг байгуулснаар Улаанбаатар хот дахь томоохон хэмжээний дэд бүтцийг бий болгож, тус дэд бүтцээр дамжуулан хэрэглэгчийн өдөр тутамд шаардлагатай нийгмийн үйлчилгээг нэг дороос үзүүлэх үйлчилгээний нэгдсэн төв хэлбэрээр ажиллаж эхлээд байна.



## Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн төлөв байдал

### Өнөөгийн нөхцөл байдал

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй худалдааны салбар нь эдийн засгийн өсөлт, өрхийн худалдан авах чадвараас шууд хамааралтай оршдог. Тодруулбал, Монгол Улсын худалдааны салбарын орлого болон нэрлэсэн ДНБ-ий 2005 оны 1 дүгээр улирлаас 2021 оны 1 дүгээр улирал хүртэлх 65 улирлын өгөгдөлд суурилж корреляцын түвшинг тодорхойлоход 0.98 буюу өндөр зэрэг хамааралтай байна.


2020 оны байдлаар Монгол Улсын худалдааны салбар нь ДНБ-ийн 9 орчим хувийг эзэлж, 22.0 их наяд төгрөгөөр, үүнээс жижиглэн худалдааны салбарын орлого 13.7 их наяд төгрөгөөр тус тус хэмжигдэж байна. 2021 онд Ковид-19 цар тахалтай холбоотой худалдааны салбарын үйл ажиллагаан дах хязгаарлалт буурч, эдийн засаг идэвхжиж эхэлснээр 5 сарын байдлаар жижиглэн худалдааны салбарын орлого 5.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 17.8 хувиар өссөн.

ХХААХҮЯамны судалгаагаар Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй жижиглэн худалдааны салбарын 63 хувийг хүнсний дэлгүүр, 14 хувийг мухлаг, 10 хувийг төрөлжсөн барааны дэлгүүр, 1 хувийг конвينيенс дэлгүүр тус тус бүрдүүлж байна. Олон улсын жишгийн дагуу хөгжингүй орнуудад конвينيенс дэлгүүрийн зах зээл нь жижиглэн худалдааны зах зээлийн 15 хувийг, хөгжиж буй орнуудад 3 хувийг тус тус бүрдүүлдэг.

2021 оны 6 сарын байдлаар нийт 5 брэндийн 172 дэлгүүр конвينيенс дэлгүүрийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаагаас Үнэт цаас гаргагчийн Мастер франчайзийн эрх эзэмшиж буй CU конвينيенс дэлгүүрийн цар хүрээ тасралтгүй өсөж 127 салбар дэлгүүрт хүрсэн. Үүний дараа Circle K конвينيенс дэлгүүр 22, Eсоexpress конвينيенс дэлгүүр 12, GS25 конвينيенс дэлгүүр 11 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн охин компани болох Премиум Дистрибьюшн ХХК-ийн үйл ажиллагаа явуулж буй Улаанбаатар хотын нийтийн хоолны салбарын орлого 2014 оноос 2020 оны





хооронд 174 тэрбум төгрөгөөс 383 тэрбум төгрөгт хүрч жилд дунджаар 14 хувиар өссөн.

*Зах зээлийн багтаамж болон Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх байр суурь*

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийг орлогын багтаамж (орлогод суурилсан, өрхийн хэрэглээнд суурилсан) болон салбарын тоон (хүн амын нягтаршилд суурилсан) багтаамжаар тус тус тодорхойлсон.

Орлогод суурилсан аргын хүрээнд (орлогын багтаамж) top-down аргачлал ашиглаж, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй Улаанбаатар хотын жижиглэн худалдааны зах зээл болон нийтийн хоолны салбарын өсөлтийг олон улсын эдийн засаг судалгааны институтуудын гаргасан Монгол Улсын бодит эдийн засгийн өсөлт (ОУВС, АХБ, Дэлхийн банк) болон инфляцын түвшний таамаглалд (ОУВС, АХБ, Монголбанк) үндэслэж тодорхойлсон. Тус аргачлалын хүрээнд 2020 оны байдлаар Улаанбаатар хотын жижиглэн худалдааны зах зээл 11.4 их наяд төгрөг, нийтийн хоолны зах зээл 383 тэрбум төгрөгөөр хэмжигдэж, 2026 онд Улаанбаатар хотын жижиглэн худалдааны салбарын зах зээл 21.5 их наяд төгрөгт, нийтийн хоолны зах зээл 721 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна.

Өрхийн хэрэглээнд суурилсан аргын (орлогын багтаамж) хүрээнд top-down аргачлал ашиглаж, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй Улаанбаатар хотын ДНБ-ийг орлогод суурилсан аргын өсөлтөд суурилан тооцож, эцсийн ашиглалтын аргаар өрхийн хэрэглээний хэмжээг тодорхойлсон. Тус аргачлалын хүрээнд 2020 оны байдлаар Улаанбаатар хотын өрхийн хэрэглээ 13.1 их наяд төгрөгөөр хэмжигдэж, 2026 онд 24.8 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна.

Дээрх хоёр тооцооллын аргачлалын дунджаар авч үзэхэд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй жижиглэн худалдаа болон нийтийн хоолны зах зээл 2020 оны байдлаар 12.6 их наяд төгрөгөөр хэмжигдэж, 2026 онд 23.9 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна. 2020 онд Үнэт цаас гаргагч нь 45.3 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь тус зах зээлийн 0.4 хувийг бүрдүүлж байна.







Үнэт цаасны танилцуулга

2021-06-17

Хүн амын нягтаршилд суурилсан аргын (салбарын тоон багтаамж) хүрээнд 2020 оны байдлаарх Улаанбаатар хотод бүртгэлтэй (Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа эрхэлдэггүй Багахангай, Багануур, Налайх дүүргийн хүн амыг хасч тооцсон) 1,426,645 хүн амыг ХХААҮЯ-аас гаргасан 2020 оны 6 сарын байдлаарх 84 конвiniенс дэлгүүрийн тоонд харьцуулж үзэхэд нэг конвiniенс дэлгүүрт 17,847 хүн, 2021 оны 6 сарын байдлаар үйл ажиллагаа явуулж буй 172 конвiniенс дэлгүүрийн тоонд харьцуулж үзэхэд нэг конвiniенс дэлгүүрт 8,294 хүн ногдож байна.

Бусад Азийн орнуудын жишгээс үзэхэд нэг конвiniенс дэлгүүрт 1,891 хүн ногддог. Үүнийг Улаанбаатар хотын хүн амд харьцуулж тооцоход конвiniенс дэлгүүрийн зах зээл 754 дэлгүүр буюу жижиглэн худалдааны зах зээлийн 12 хувийг эзлэх багтаамжтай байна.

Үнэт цаас гаргагч нь 2021 оны 6 сарын байдлаар 127 салбар дэлгүүртэйгээр үйл ажиллагаа явуулж буй нь конвiniенс дэлгүүрийн багтаамжийн 17 хувийг, 2020 оны 6 сарын байдлаарх ХХААҮЯ-аас гаргасан жижиглэн худалдааны зах зээлийн 2 хувийг тус тус эзэлж байна.

#### **Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны стратеги болон бизнес төлөвлөгөө**

Конвiniенс дэлгүүрийн зах зээлд салбарын тоог өргөжүүлснээр борлуулалтыг өсгөх, зах зээлд нөлөөлөх хүчийг (bargaining power) нэмэгдүүлэх, худалдан авалтын өртгийг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх (economies of scale) хөшүүрэг болдог онцлогтой.

Хүн амын төвлөрөл ихтэй байршлуудад ашигт ажиллагаа өндөр байдаг тул Үнэт цаас гаргагч нь дунд хугацаанд зах зээлд давамгайлах стратегийг баримтлан, 2023 оны төгсгөлд нийт 360 байршилд өрсөлдөөнөөс өрсөж CU дэлгүүрийг нээж, цар хүрээг тэлэхээр төлөвлөж байна.

CU конвiniенс сүлжээ дэлгүүрийн богино хугацааны хурдацтай тэлэлтийн хүрээнд стандарт шаардлагыг нэгэн жигд барих, бүтээгдэхүүн, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн стратегийн хувьд өндөр ач холбогдолтой. Иймд Үнэт цаас гаргагч нь босоо интеграцын стратегийг баримтлан, бий болгосон түгээлтийн төв болон





ӨНГИЙН БИР,  
STOCK EXCHANGE.

2021-09-17

Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-02

хоолны үйлдвэрт автоматжуулалтыг бий болгож, мэдээлэл технологийн цогц системийг хөгжүүлэх зорилттой байна.

Үнэт цаас гаргагч нь дунд хугацаанд конвينيенс дэлгүүрийн зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн, хэрэглэгчид өдөр тутамд шаардлагатай, илүү үнэ цэн өгсөн үйлчилгээг тасралтгүй нэвтрүүлж, үйлчилгээний төвлөрсөн дэд бүтэц болох замаар өрсөлдөөнд ялгарах, үнэнч хэрэглэгчийг нэмэгдүүлэх, технологийн дэвшилд суурилсан борлуулалтын сувгийг өргөжүүлэх стратегийг дунд хугацаанд хэрэгжүүлэхээр зорьж байна.

### Үнэт цаас гаргагчийн санхүүгийн шинжилгээ

Үнэт цаас гаргагч нь 2020 оны байдлаар нийт 56.9 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй (71 хувь нь эргэлтийн бус, 29 хувь нь эргэлтийн) үйл ажиллагаа явуулж байсан бол 2021 оны 2 дугаар улирлын байдлаар нийт хөрөнгийн хэмжээ 80.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тодруулбал, 2021 оны 2 дугаар улирлын байдлаар нийт хөрөнгийн 80 хувийг эргэлтийн бус (салбар дэлгүүрийн засварын хөрөнгө, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил), 20 хувийг эргэлтийн хөрөнгө тус тус эзэлж байна.

2020 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн капиталын бүтцийг авч үзэхэд өр төлбөр 73.3 тэрбум төгрөг, эздийн өмч 16.3 тэрбум төгрөгийг бүрдүүлж байсан бол 2021 оны 2 дугаар улирлын байдлаар өрийн хөшүүрэг буурч, өр төлбөр 53.0 тэрбум төгрөг, эздийн өмч 27.3 тэрбум төгрөгөөр тус тус хэмжигдэж байна. Эздийн өмчийг нэмэгдүүлэхэд


Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого 2018 оноос 2020 оны хооронд жилд дунджаар 182.4 хувиар өсч, 2020 онд 45.3 тэрбум төгрөгт хүрсэн. Борлуулалтын орлогын 94.0 хувийг эцсийн хэрэглэгчид бараа борлуулсан, 5.3 хувийг дэд франчайзад бараа борлуулсан, 0.7 хувийг дэд франчайзийн үйлчилгээний орлого тус тус эзэлж байна.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт бараа, бүтээгдэхүүний борлуулалтад шаардлагатай дэлгүүрийн түвшний зардлууд багтдаг. 2020 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг 50.7 тэрбум төгрөг буюу борлуулалтын орлогын 112 хувьтай тэнцэж байна. Цаашид Үнэт цаас гаргагчийн





Үнэт цаасны танилцуулга



үйл ажиллагаа өргөжихийн хэрээр худалдан авалтын өртөг буурч, нийт ахиуц ашгийг нэмэгдүүлэх боломжтой.



Үнэт цаас гаргагч нь хурдацтай өргөжин тэлж, 2019 онд 35 салбар, 2020 онд 47 салбар, 2021 оны 1 дүгээр хагаст 24 салбар дэлгүүрийг шинээр ашиглалтад оруулж, түгээлтийн төв, хоол үйлдвэрлэлийн төв, мэдээлэл технологийн системд хөрөнгө оруулж томоохон хэмжээний дэд бүтцийг бий болгосон. Үнэт цаас гаргагчийн бизнесийн амьдралын мөчлөг өсөлтийн үе шатад явж буй тул ашигт ажиллагаа хугарлын цэгт хүрээгүй байна. Тодруулбал, 2020 онд Үнэт цаас гаргагч нь 15.7 тэрбум төгрөг, 2021 ны 1 дүгээр хагаст 7.2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадвар өрийн хөшүүрэг өндөр байсантай холбогдуулан 2020 оны байдлаар 0.4х буюу хангалтгүй түвшинд байсан. Харин 2021 оны 2 дугаар улиралд Үнэт цаас гаргагч нь өрийн дарамтыг бууруулснаар хөрвөх чадвар сайжирч, хөрвөх чадварын түвшин сайжирч, эргэлтийн харьцаа 1.0х түвшинд хүрсэн байна. Цаашид Үнэт цаас гаргагч нь өмчийн санхүүжилтээр үйл ажиллагааг санхүүжүүлж, өрийн хэмжээг зохистой түвшинд барьснаар хөрвөх чадварыг тогтмол хангах боломжтой.

Конвениенс дэлгүүр нь бусад жижиглэн дэлгүүртэй харьцуулахад бага талбайд үйл ажиллагаа явуулж, нэгж метр квадрат талбайгаас хамгийн өндөр борлуулалт хийхийг зорьдог тул бараа материалын нөөцийн хэмжээ, эргэц чухал ач холбогдолтой байдаг. Үнэт цаас гаргагчийн бараа материалын насжилт 2019 оны 2 дугаар улирлын байдлаар 53 хоног байсан бол 2020 оны байдлаар 34 хоног болж сайжирсан байна.

Үнэт цаас гаргагчийн борлуулалт шууд тооцоогоор хийгддэг тул зээлийн борлуулалтын түүх үүсдэггүй буюу авлага түгжигдэх эрсдэл бага байдаг. Төлбөр гүйцэтгэх дундаж хугацаа нь татан авсан бараа материалын төлбөрийг хэд хоногийн дараа нийлүүлэгчдэд төлж буйг илэрхийлдэг бөгөөд тус үзүүлэлт 2021 оны 2 дугаар улирлын байдлаар 57 хоног байна. Үүнээс үзэхэд, Үнэт цаас гаргагч нь бэлтгэн нийлүүлэгчид төлбөр төлөхөөс өмнө борлуулалт хийдэг тул хөрвөх чадварын эрсдэл багатай байна.





### Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээ

Үнэт цаас гаргагчийн хөндлөнгийн бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг Гэрэгэ Эстимэйт ХХК хорогдуулсан мөнгөн урсгалын аргаар хийж гүйцэтгэсэн. Тус хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчийн 100 хувийн бизнес өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг 2021 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаар 211,818,313,851 төгрөг байхаар тогтоосон байна.

Хөндлөнгийн үнэлгээний байгууллагын тооцсон бизнесийн үнэлгээний үр дүнд үндэслэхэд Үнэт цаас гаргагчийн нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэн 265 төгрөг байна. Үнэт цаас гаргагчийн бизнесийн мөчлөгийн эрсдэл, зах зээлийн нөхцөл байдал, хөрөнгө оруулагчдад өгөөж хүртэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор ТУЗ-ийн 2021 оны 9 сарын 09-ны өдрийн 151021-13 тоот тогтоолоор Үнэт цаас гаргагчийн нэгж хувьцааны үнийг 21.5 хувийн хөнгөлөлттэй үнээр буюу 208 төгрөгөөр нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

### Үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь нийтэд хувьцааг анх удаа санал болгох замаар татан төвлөрүүлэх 24,953 сая төгрөгийг 2023 он хүртэлх бизнес төлөвлөгөөнд тусгагдсан дэлгүүрийн тэлэлт, түгээлтийн төв болон хоол үйлдвэрлэлийн төвийн нэмэлт тоног төхөөрөмжид зарцуулахаар төлөвлөсөн.

### Нэмэлт дэлгүүрийн хөрөнгө оруулалт


Үнэт цаас гаргагчийн нэгж дэлгүүрийн хөрөнгө оруулалт дунджаар 200 сая төгрөгийн өртөгтэй байна. Нэгж дэлгүүрийн хөрөнгө оруулалтад дэлгүүрийн барилгын ажил, тавилга, тоног төхөөрөмж, мэдээлэл технологийн системийн зардал багтдаг. Олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн 76 хувь болох 19.0 тэрбум төгрөгөөр Үнэт цаас гаргагч нь CU конвينيенс дэлгүүрийг өргөтгөж, шинээр 95 дэлгүүрийг нээх төлөвлөгөөтэй байна.

### Түгээлтийн төвийн автоматжуулалт


CU конвينيенс сүлжээ дэлгүүрийн тэлэлтийн хүрээнд бараа, бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийг тасалдалгүй, оновчтой удирдан зохион байгуулах, нэгдсэн стандартаар хангахад Үнэт цаас гаргагчийн түгээлтийн төвд автоматжуулалт хийх шаардлагатай байна. Иймд Үнэт цаас гаргагч нь татан







Үнэт цаасны танилцуулга



төвлөрүүлэх дүнгийн 12 хувь буюу 2.95 тэрбум төгрөгийг түгээлтийн төвийн бүтээмжийг нэмэгдүүлэх, захиалгыг хялбар, алдаагүй бэлтгэхэд зориулсан агуулахын удирдлагын тогтолцоог түгээлтийн төвд нэвтрүүлэхэд шаардлагатай дэд систем, тоног төхөөрөмжийг худалдан авахад зарцуулна.

#### Хоол үйлдвэрлэлийн төвийн тоног төхөөрөмж

Үнэт цаас гаргагч нь босоо интеграцын стратегийн хүрээнд хоол үйлдвэрлэлийн төвийн шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх болон дэлгүүрийн өргөтгөлтэй уялдаатай худалдан авах тоног төхөөрөмжид татан төвлөрүүлэх дүнгийн 12 хувь буюу 3.003 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг зарцуулах төлөвлөгөөтэй байна.

Үнэт цаас гаргагч нь шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлэх тоног төхөөрөмж худалдан авахаар төлөвлөж байна. Түүнчлэн одоогийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хүчин чадал 130-140 дэлгүүрийг хангах боломжтой тул цаашид дэлгүүрийн өргөжилтийн хүрээнд 2023 он хүртэл шинээр байгуулагдах 240 дэлгүүрт зориулан тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.


#### Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн шинжилгээ

Андеррайтерийн хувьд Үнэт цаас гаргагчаас бидэнд ирүүлсэн мэдээлэл нь үнэн зөв, цаашид төсөл хөтөлбөрүүд нь төлөвлөсний дагуу хэрэгжих боломжтой гэсэн таамаглалд үндэслэн энэхүү Үнэт цаасны танилцуулгыг боловсруулсан.

Гэвч энэхүү төсөөлөл нь ирээдүйд учирч болзошгүй эрсдэлээс хамаарч өөрчлөгдөх боломжтой тул Үнэт цаас гаргагчид учирч болзошгүй эрсдэл, тэдгээрийг удирдах төлөвлөгөө, хэрэгжүүлж буй арга хэмжээг нарийн судалж, дор дурдсан эрсдэлийг ойлгосны үндсэн дээр хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй гэж үзэж байна.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болзошгүй нийт 15 эрсдэл болон тэдгээрийг удирдах эрсдэлийн бодлогыг бид Үнэт цаасны танилцуулгын 2.5 хэсэгт дэлгэрэнгүй тусгасан тул тус эрсдэлүүдийг хохирлын хэмжээ болон тохиолдох магадлалаар ангилан голлох 4 эрсдэлийг бид дараах байдлаар тодорхойллоо.





### Ковид-19 эрсдэл

Ковид-19 цар тахлаас үүдэлтэйгээр үйлчилгээний байгууллагын ажиллах цагийн хуваарь, горим, хэрэглэгчийн тоонд хязгаарлалт тавьснаар борлуулалт буурах, ажилтнуудын дунд халдвар тархах нөхцөл байдал үүссэнээр бизнесийн хэвийн үйл ажиллагаанд саатал учрах эрсдэлтэй.

Цаашид Үнэт цаас гаргагч нь Монгол Улсад тэр дундаа Улаанбаатар хотод тогтоосон хатуу хөл хорионы дэглэмийн үеэр дэлгүүрийн ойролцоох байршлуудад нэвтрүүлсэн хүргэлтийн үйлчилгээг өргөжүүлснээр Ковид-19 цар тахлаас үүдэлтэй хязгаарлалт, тэдгээрийн борлуулалтад үзүүлэх нөлөөг бууруулах боломжтой.

Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь бизнесийн хэвийн үйл ажиллагааны саатлыг бууруулах үүднээс дэлгүүр, түгээлт, үйлдвэр, агуулах болон оффисын нийт ажилтнуудыг вакцинд хамруулж, сэжигтэй тохиолдолд түргэвчилсэн тестийг тогтмол хийн, боломжтой ажилтнуудыг зайнаас ажиллах нөхцөлөөр хангаснаар бизнесийн үйл ажиллагаа доголдох эрсдэлээс сэргийлэх боломжтой.

### Өрсөлдөөний эрсдэл


Жижиглэн худалдааны зах зээл өрсөлдөөн ихтэй тул ойролцоо байршил дахь хүнсний дэлгүүр, конвينيенс дэлгүүрийн тоо нэмэгдсэнээр нэгж дэлгүүрийн болон дундаж борлуулалт буурах, хэрэглэгчдийн тоо хуваагдах эрсдэлтэй.

Өрсөлдөгч брэндийн конвينيенс дэлгүүрт сайн байршлуудыг алдахгүй байх нь өрсөлдөөний гол хэсэг тул эдгээр байршлуудад дэлгүүрийн сүлжээг тэлэх шаардлагатай байдаг. Иймд Үнэт цаас гаргагч нь зах зээлд давамгайлах стратегийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хүн амын хөдөлгөөний урсгал байршлуудад түргэн байршиж, олон тооны сайн байршилд өөр хоорондоо оновчтой зайтайгаар буюу 150-200 метрийн зайд конвينيенс дэлгүүрийг тэлснээр өрсөлдөөнд давуу байдлыг бий болгож, уг төрлийн эрсдэлийг бууруулах боломжтой байна.


### Нэр хүндийн эрсдэл

Олон улсын франчайз эрх эзэмшиж буй Үнэт цаас гаргагчийн хувьд үйлчилгээний стандарт алдагдах, ажилтнууд, франчайз





Үнэт цаасны танилцуулга



эзэмшигчид болон бусад оролцогч талуудын зохисгүй үйлдлийн улмаас брэндийн нэр хүнд унах, харилцагчдын итгэлийг алдах нэр хүндийн эрсдэл үүсэх магадлалтай.

Нэр хүндийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор Үнэт цаас гаргагч нь хэрэглэгчтэй шууд харилцдаг дэлгүүрийн ажилтнуудад QSC (quality service control) үйлчилгээний стандартын сургалтыг тогтмол явуулж, хэрэглэгчийн гомдол, саналыг нээлттэй хүлээн авах, барагдуулах харилцагчийн үйлчилгээний төвийг ажиллуулдаг.

Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь ханган нийлүүлэгч, гүйцэтгэгч, франчайз эзэмшигчидтэй байгуулсан гэрээнд брэндийн стандартыг барих, нэр төрд халтай үйлдэл, эс үйлдэл хийхгүй байх талаар маш тодорхой заалтуудыг оруулж, даган мөрдүүлэх дээр хүчин чармайлттай ажилладаг байна.

Цаашид тус жишгийг тогтмол баримтлан компанийн соёл, үнэт зүйлсийг ажилтнуудад ойлгуулж, үйлчилгээний сайн стандартыг хэрэгжүүлж буй ажилтнууд болон франчайз эзэмшигчдийг урамшуулснаар нэр хүндийн эрсдэлийг бууруулах боломжтой.

#### *Бараа нийлүүлэлтийн тасалдлын эрсдэл*

Бэлтгэн нийлүүлэгч нь бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг захиалгын дагуу гүйцэтгэхгүй байх, тасалдал үүсэх, бэлэн байдал алдагдсанаар борлуулалтын орлого тасалдах, улмаар хэрэглэгч өрсөлдөгч дэлгүүрийг сонгон үйлчлүүлэх, үнэнч хэрэглэгчийг алдах эрсдэлтэй. Түүнчлэн CU конвинеенс дэлгүүрийн тоо нэмэгдсэнээр дэлгүүр бүрийн бараа, бүтээгдэхүүний захиалга, нийлүүлэлтийг өдөр бүр зохион байгуулахад, ялангуяа шинэ хоол, хүнсийг найдвартай нийлүүлэхэд үйл ажиллагааны эрсдэл үүсэх боломжтой.

Үнэт цаас гаргагч нь өөрийн нэгдсэн түгээлтийн төвөөр дамжуулан CU конвинеенс сүлжээ дэлгүүрийн системийн хэмжээний бараа бүтээгдэхүүний удирдлагыг нэгдсэн сувгаар хангаж, бараа бүтээгдэхүүний нөөцийг үүсгэх, тус нөөцөөс дэлгүүр бүрийн захиалгад тулгуурласан тасалдалгүй нийлүүлэлтийг гүйцэтгэх замаар тус эрсдэлийг бууруулах боломжтой.





СЭНГИЙН БИРЭГ  
BANK EXCHANGE

2021-09-17

Үнэт цаасны танилцуулга  
БҮРТГЭВ-02

### Дүгнэлт

Голомт Капитал ҮЦК нь Үндсэн андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийсэн дээрх болон бусад судалгаа шинжилгээ, тооцоо, мөн үнэт цаас гаргахтай холбогдуулан бусад мэргэжлийн байгууллагуудын хийсэн тайлан дүгнэлтүүдэд үндэслэн Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувьцааг олон нийтэд санал болсон арилжаалах боломжтой гэж үзсэн. Энэхүү хувьцааны анхдагч зах зээлийн нэг бүрийн үнийг 208 төгрөгөөр, нийт 119,966,060 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгон 24,952,940,480 төгрөгийг татан төвлөрүүлэх боломжтой гэсэн дүгнэлтийг гаргалаа.

Энэхүү дүгнэлт нь дээрх тооцоолол болон Үнэт цаас гаргагчийн ирээдүйн төсөөллийн биелэлтийн баталгаа болохгүй. Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулагчид нь компанийн үйл ажиллагаа болон хувьцааны үнэлгээнд нөлөөлж болох гадаад хүчин зүйлийн эрсдэлийг ойлгосны үндсэн дээр өөрийн шийдвэрээр хөрөнгө оруулахыг бид зөвлөж байна.

Дүгнэлтийг гаргасан:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ЗАХИРАЛ  М. МӨНХТУЯА

Хянаж баталгаажуулсан:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  С. ГАН-ЭРДЭНЭ






**ЗУРГАА.**  
**ХАВСРАЛТ**

1862





Үнэт цаасны танилцуулга



# 6 ХАВСРАЛТ

## 6.1 Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ

Хууль гүйн сийдэн 2016 оны  
А/204 дугаар тушаалар багц

**МОНГОЛ УЛС**  
**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН**  
**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**  
000136572

2017.02.22 <i>/ Бүртгэсэн он, сар, өдөр /</i>	9011651142 <i>/ Улсын бүртгэлийн дугаар /</i>
	6155804 <i>/ Регистрийн дугаар /</i>
Сэнтрал экспресс Си Ви Эс <i>/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /</i>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани <i>/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /</i>
Шийдвэр <i>/ шийдвэрийн нэр /</i>	Дүрэм <i>/ Үүсэн байгуулах баримт бичиг /</i>
01 <i>/ дугаар /</i>	2017.02.20 <i>/ он, сар, өдөр /</i>
4721 <i>/ код /</i>	Хүнсний дэлгүүр <i>/ Үндсэн эрхлэх үйл ажиллвөөны чиглэл /</i>
4799 <i>/ код /</i>	Худалдааны зуучлал <i>/ Туслах эрхлэх үйл ажиллвөөны чиглэл /</i>
Хугацаагүй <i>/ хугацаа /</i>	1 <i>/ гишүүдийн тоо /</i>
	100,0 <i>/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /</i>

Улаанбаатар, Баянгол, 16-р хороо, энхтайвны өргөн чөлөө, 35, Махс моол худалдааны төв, 501 тоот, Утас: 88103889, Утас2: , Факс: 70122292  
*/ хуулийн этгээдийн албан ёсны хаяв /*

Оюуны өмч, улсын бүртгэлийн  
эрэнхий газар Хуулийн этгээдийн  
бүртгэлийн газар  
*/ бүртгэсэн байгууллагын нэр /*





2021-09-17

Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-02

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн БҮРТГЭГЧ	
		Огноо	Ажилтан/Тэмдэг
1	Адилбиш овогтой Ганболд-а Гүйцэтгэх захирал -р томилсныг бүртгэв.	2017.02.22	С.Мөнхсанчир
1	Өөрийн хөрөнгийн хэмжээ 527327 мян.төг-р нэмэгдэж нийт 527427 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2017.02.22	С.Мөнхсанчир
2	Адилбиш овогтой Ганхуяа -а Гүйцэтгэх захирал -р томилсныг бүртгэв.	2017.02.22	С.Мөнхсанчир
3	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, юнэско, . . МПМ цогцолбор, 12 дөвхөрт тоот, Утас1 88103889, Утас2 . Факс 70122292 хаягийг шинээр бүртгэв.	2018.01.05	С.Мөнхсанчир
4	Ганболд овогтой Чинзориг -а Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2018.02.19	С.Мөнхсанчир
5	Өөрийн хөрөнгийн хэмжээ 1206573 мян.төг-р нэмэгдэж нийт 1734000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2018.04.05	С.Мөнхсанчир
6	Өөрийн хөрөнгийн хэмжээ 9216730 мян.төг-р нэмэгдэж нийт 10950730 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2018.12.25	С.Мөнхсанчир
7	1075 Хүнсний үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2018.12.28	С.Мөнхсанчир
8	4610 Гадвад худалдаа эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2019.01.14	С.Мөнхсанчир
9	Өөрийн хөрөнгийн хэмжээ 4480000 мян.төг-р нэмэгдэж нийт 15430730 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2019.04.30	Д.Чулуунтуйв
10	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, . олимпын, 19а, Шангри-Ла төв, Шангри-Ла оффис 23 дөвхөрт тоот, Утас1 88103889, Утас2 . Факс 70122292 хаягийг шинээр бүртгэв.	2019.08.20	Д.Гансүмбэрэн
11	Дүрмийн 11.1-т оруулсан өөрчлөлтийг бүртгэв.	2019.09.24	Ж.Нямдорж
12	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1714525.5 мян.төг-р нэмэгдэж нийт 17145255.3 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2019.11.06	Ж.Нямдорж
13	Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2019.11.06	Ж.Нямдорж
19	Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв.	2020.09.25	В.Мөнхсүрэн
20	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 50835511.9 мян.төг-р нэмэгдэж нийт 67980767.4 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2021.06.11	С.Мөнхсанчир
21	Хувьцаа эзэмшигч 8 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 9 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2021.06.11	С.Мөнхсанчир
22	Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв.	2021.06.11	С.Мөнхсанчир
23	77300 Францэзын гэрээний үндсэн дээр бизнесийн үйл ажиллагаа явуулах үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2021.06.11	С.Мөнхсанчир



Нийслэлийн тойргийн нотариатч  
Д.Амаржаргал би энэ хуулбарын  
үнэн зөвийг гэрчлэв.  
Нотариатч .....*D. Amargajargal*.....







СЭХ  
 2021 оны 10 сар 15 өдөр  
 БҮРТГЭВ  
 № 01

МОНГОЛЫН ХОРОМЖИЛ ДУГААР  
 MONGOLIAN STANDARD SPECIFICATION  
 2017-04-17  
 БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга

6.2 Үнэт цаас гаргагчийн охин компани болох Премиум Дистрибьюшн ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ

Хууль зүйн сансрын 2016 оны  
 А.204 дүгээр гуушалгаар батлагдсан

**МОНГОЛ УЛС**  
**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН**  
**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**  
 000189291

2017.04.05 / Бүртгэсэн он, сар, өдөр /

9011668040 / Хувийн хэргийн дугаар /

6169287 / Регистрийн дугаар /

Премиум дистрибьюшн / Хуулийн этгээдийн нэр, хариуцаагч хэлбэр /  
 Хязгаарлагдмал хариуцлагатай компани

**Дүрэм**  
 / Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр / шийдвэрийн нэр /

01 / дугаар /

2017.04.03  
 2017 оны 4 сар 03 өдөр  
 76

4663 / код / Барилгын материалын худалдаа / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

4610 Гадаад худалдаа

1079 Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл

4630 Хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа

4923 Агуулахын болон тээврийн туслах үйл ажиллагаа

1 / код / / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй / хугацаа / 1 / гишүүдийн тоо / 10,000.0 / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимпын, 19а, Шангри-Ла төв, Шангри-Ла оффис 23 давхарт. Утас: 70122292, Утас2: Факс: 70122292

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

**Гэрчилгээ дахин олгосон 2019 оны 8 сар 21 өдөр**

Улсын бүртгэлийн ерөнхий газар  
 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар  
 / бүртгэсэн баяжууллагын нэр /

Толгойн Голын Улс ХХК  
 Golden Capital  
 Delivering diversity  
 11192091114-5001509  
 Улаанбаатар хот

Улаанбаатар хот  
 200



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРХ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-09-17

Үнэт цаасны танилцуулга  
БҮРТГЭВ-02

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/А	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Адилбиш овогтой Ганболд-в Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2017.04.05	М.Моналжин
2	Дахин гэрчилгээ олгов.	2019.08.21	О.Цолмон
3	Ганболд овогтой Чинзориг-г Гүйцэтгэх захирал -р томилсоныг бүртгэв.	2019.09.20	Э.Эрдэнэбилэг
4	Шинэчилсэн дүрэм бүртгэв.	2019.09.20	Э.Эрдэнэбилэг
5	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1072263 мян.төг-р нэмэгдэж нийт 1082263 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2020.05.11	Г.Санжваа
6	Эцсийн өмчлөгч 2 иргэн бүртгэв.	2020.05.11	Г.Санжваа
7	Эцсийн өмчлөгч 2 иргэн бүртгэв.	2020.09.04	Г.Санжваа
8	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 6642132.8 мян.төг-р нэмэгдэж нийт 7724395.8 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2021.05.05	Э.Эрдэнэбилэг
9	Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж 1 хэсэгдэж хувьцаа эзэмшигчид тооцсон болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2021.06.11	Г.Санжваа
10	Эцсийн өмчлөгч бүртгэв.	2021.06.11	Г.Санжваа



2021 он 09 сар 17 өдөр Бүртгэлийн № 687...


Нийслэлийн тойргийн нотариатч  
Д.Амаржаргал би энэ хуулбарын  
үнэн зөвийг гэрчлэв.  
Нотариатч: *Д.Амаржаргал*

Энэхүү гэрчилгээг үзүүлж байгаа үйлчилгээг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үзүүлж байна. Үүсгэн бүртгэлийн гэрчилгээг үзүүлж байна.





Үнэт цаасны танилцуулга



### 6.3 Үнэт цаас гаргагчийн компанийн дүрэм



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 06 сарын 09 өдрийн 4 тоот тогтоолын Хавсралт 9

СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

#### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад үүсгэн байгуулагдсан Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК ("Компани") нь Монгол Улсын Компанийн тухай хууль ("Компанийн тухай хууль")-д заасны дагуу өөрийн Дүрэм ("Дүрэм")-ийг батлав.

#### ХОЁР. КОМПАНИЙН ОНООСОН НЭР, ОРШИН БАЙГАА ГАЗАР

- 2.1. Компанийн оноосон нэр нь Монгол хэлээр Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК, Англи хэлээр Central Express CVS LLC байна.
- 2.2. Компани нь Монгол Улс, Улаанбаатар хот 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 19А, Шангри-Ла Төв, Шангри-Ла Оффис, 23 давхар хаягт байрлана.
- 2.3. Компани нь бүртгэх байгууллагад бүртгэгдсэн өөрийн бэлгэдэл (эмблем) болон барааны тэмдэгтэй байж болно.
- 2.4. Компани нь өөрийн нэр бүхий албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг (тамга) хэрэглэнэ.

#### ГУРАВ. КОМПАНИЙН ЭРХ


- 3.1. Компани нь Компанийн тухай хуулийн дагуу зохион байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, банканд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх хуулийн этгээд байна. Компанийн хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж түүнийг захиран зарцуулах эрх нь энэ Дүрэм болон Компанийн тухай хуулиар хязгаарлагдах хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр ажиллана.
- 3.2. Компани нь өөрийн нэрийн өмнөөс гадаадын болон Монголын байгууллага, иргэнтэй гэрээ, хэлцэл байгуулах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх олж авах, захиран зарцуулах, үүрэг хүлээх, шүүх, арбитрын үйл ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох эрхтэй.
- 3.3. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.
- 3.4. Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 дахь заалтад зааснаас бусад тохиолдолд Компани нь хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй, хувьцаа эзэмшигчид нь Компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 3.5. Компани нь Монгол Улсын нутаг дэвсгэр болон гадаадад өөрийн салбар, төлөөлөгчийн газраар байгуулж болно.
- 3.6. Компани нь өөрийн Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн бүх үйл ажиллагаандаа ашиглана.
- 3.7. Компани нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Боловсролын тухай хуульд нийцүүлэн, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (International Financial Reporting Standards) ("СТОУС")-д заасны дагуу нарийвчилсан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.
- 3.8. Компани нь дотоод, гадаадын банканд төгрөг болон гадаад валютын данстай байна.

#### ДӨРӨВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 4.1. Компани нь дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна. Үүнд:







Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 06 сарын 09 өдрийн 7 тоот тогтоолын Хавсралт 9

- 4.1.1. хүнсний дэлгүүр,
- 4.1.2. хүнсний үйлдвэрлэл,
- 4.1.3. худалдааны зуучлал,
- 4.1.4. фрайнчайзын гэрээний үндсэн дээр бизнесийн үйл ажиллагаа явуулах, болон
- 4.1.5. гадаад худалдаа.

**ТАВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ**

- 5.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 67,980,767,400 (жаран долоон тэрбум есөн зуун наян сая долоон зуун жаран долоон мянга дөрвөн зуун) төгрөг байна.
- 5.2. Компанийн гаргасан энгийн хувьцааны тоо 679,807,674 (зургаан зуун далан есөн сая найман зуун долоон мянга зургаан зуун далан дөрвөн) ширхэг энгийн хувьцаа байна.
- 5.3. Нэгж энгийн хувьцааны нэрлэсэн үнэ 100 (Нэг зуун) төгрөг байна.
- 5.4. Компанийн энгийн хувьцаа тус бүр 1 (нэг) саналын эрхтэй байна.
- 5.5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн Компанийн тухай хуульд заасны дагуу өөрчилж болно.
- 5.6. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн дор дурдсан хэлбэрээр өөрчилж болно. Үүнд:
  - 5.6.1. нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх эсхүл бууруулах,
  - 5.6.2. хувьцаа нэмж гаргах замаар өсгөх, болон
  - 5.6.3. өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар бууруулах.
- 5.7. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.2 дахь хэсэгт зааснаар тодорхойлно.



**ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД**

- 6.1. Компани нь 9 (Есөн) хувьцаа эзэмшигчидтэй бөгөөд хувьцаа эзэмшигчид нь Компанийн гаргасан нийт энгийн хувьцааг 100 (Нэг зуун) хувь эзэмшинэ.

Хувьцаа эзэмшигчдийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээ, регистрийн дугаар, хаяг	Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо	Нэгж үнэ (төгрөг)	Эзэмшиж буй хувьцааны нийт үнэ (төгрөг)	Эзэмшлийн хувь хэмжээ
<b>Адилбишийн Ганхуяг</b> (ШД77052271) Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 4-р хэсэг, Бэлла Виста 200-212 тоот (88883889)	235,408,889	100	23,540,888,900	34.64
<b>Адилбишийн Ганболд</b> (УЖ69100211) Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 7-р хэсэг, Маршал Таун 109-10 тоот (88884545)	172,327,784	100	17,232,778,400	25.35








Сантрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 06 сарын 08 өдрийн 4 тоот тогтоолын Хавсралт 9

Хувьцаа эзэмшигчдийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээ, регистрийн дугаар, хаяг	Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо	Нэгж үнэ (төгрөг)	Эзэмшиж буй хувьцааны нийт үнэ (төгрөг)	Эзэмшлийн хувь хэмжээ
Цогбадрахын Баяржаргал (ЕВ73102208) Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 7-р хэсэг, Маршал Таун 101-9 тоот (88887700)	88,164,258	100	8,816,425,800	12.97
Адилбишийн Одончимэг (ШД73082966) Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Гэрэлт хотхон 25-351 тоот (88882020)	32,304,463	100	3,230,446,300	4.75
Адилбишийн Ганбаатар (УЖ68040111) Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө, 2-р хороо, 44-р байрны 25 тоот (88103887)	31,248,463	100	3,124,846,300	4.60
Очирбатын Батмөнх (АЭ74032476) Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 7-р хэсэг, Ривер гарден, 407-901 тоот (88882999)	19,731,751	100	1,973,175,100	2.90
Гансүхийн Бат-Эрдэнэ (ЧР80051112) Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Тайм Сүхэр 505-1001 тоот (88880039)	19,731,751	100	1,973,175,100	2.90
Өсөхбаярын Мөнхбаяр (ХБ81020210) Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12-р хороо, Жанжин 14 гудамж, 217 тоот (88886651)	12,909,548	100	1,290,954,800	1.90
БиЖиЭф Ритейл Ко., Лтд. (BGF Retail Co., Ltd.) 893-88-00792, 110111-6555770 405, Teheran-ro(Samseong-dong), Gangnam-gu, Seoul, Korea	67,980,767	100	6,798,076,700	9.99
<b>Нийт</b>	<b>679,807,674</b>		<b>67,980,767,400</b>	<b>100.00</b>

**ДОЛОО. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 7.1. Компанийн энгийн Хувьцаа эзэмшигчид нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:
- 7.1.1. хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүү санал өгөх,
  - 7.1.2. эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээгээр ногдол ашиг авах.





Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 06 сарын 8 өдрийн 4 тоот тогтоолын Хавсралт 2

- 7.1.3. Компанийн талаарх бүх мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах,
- 7.1.4. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх,
- 7.1.5. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон Компанийн Дүрэмд заасны дагуу Компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг өөрийн эзэмшиж байгаа хувьцаанд хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах,
- 7.1.6. Компанийн болон бусад хувьцаа эзэмшигчдийн худалдах хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг гуравдагч этгээдэд санал болгох үнээр өөрийн эзэмшлийн хувьцааныхаа тоонд хувь тэнцүүлэн энэ хууль болон Компанийн Дүрэмд заасны дагуу тэргүүн ээлжид худалдан авах,
- 7.1.7. Компанийн нууцыг чандлан хадгалах, болон
- 7.1.8. Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 дахь заалтад зааснаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээх.

#### НАЙМ. КОМПАНИЙН УДИРДЛАГА

- 8.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна.
- 8.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") байна.
- 8.3. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг Компанийн гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.

#### ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН БҮРЭН ЭРХ


- 9.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 4 (дөрвөн) сарын дотор хуралдана. Ээлжит хурлын зарыг уг хурлаар хэлэлцэж батлах тогтоолын төслийн хамт хурал хийхээс 30 (гуч) хоногоос доошгүй хугацаанд хургуулна.
- 9.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан журмын дагуу зарлан хуралдуулна.
- 9.3. Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50 (тавь)-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчд биечлэн эсвэл төлөөлөгчөөр дамжуулан хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно. Хэрэв хувьцаа эзэмшигчдийн хурлын зарлагдсан цагаас хойш 60 (жаран) минутын дотор хурлын ирц бүрдээгүй бол уг хурлыг хойшлогдсонд тооцно. Хойшлогдсон хурлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргын тогтоосон өдөр хүртэл хойшлуулах бөгөөд тус хугацаа нь эхний хурлаас хойш 10 (арав) хоногоос доошгүй, 21 (хорин нэг)-ээс ихгүй хоногийн дотор анх зарласантай адил цаг болон газарт Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3, 69.4-д заасан журмыг баримтлан хуралдуулна.
- 9.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг телефон утас, видеофон буюу түүнтэй адилтгах холбооны хэрэгсэл гэх мэт хэлбэрээр хуралдуулж болно. Ийнхүү хуралдсан хурлыг биечлэн хуралдсанд тооцно.
- 9.5. Дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. Үүнд:
  - 9.5.1. энэхүү Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн нэмэлт батлах,
  - 9.5.2. нийлэх, нэгдэх, хуваах буюу өөрчлөх хэлбэрээр Компанийг өөрчлөн байгуулах батлах,
  - 9.5.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний хэмжээг тогтоох

4 / 10





Үнэт цаасны танилцуулга



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 06 сарын 28 өдрийн 4 тоот тогтоолын Хавсралт 9

- 9.5.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх,
  - 9.5.5. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох,
  - 9.5.6. хувьцааг хуваах буюу нэгтгэх,
  - 9.5.7. ТУЗ-ийн гишүүдийг томилох, бүрэн эрхийг тогтоох болон хугацаанаас нь өмнө дуусгаар болгох, цалин, урамшууллын хэмжээг тогтоох,
  - 9.5.8. хувьцаатай холбоотой эрхэд өөрчлөлт орох,
  - 9.5.9. Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авах,
  - 9.5.10. Компанийн хөрөнгийн бүтэцтэй холбоотой аливаа бусад асуудал,
  - 9.5.11. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
  - 9.5.12. Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах,
  - 9.5.13. Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах,
  - 9.5.14. Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4 дэх заалтад заасан тайлан,
  - 9.5.15. хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагаас оруулсан бусад асуудал.
- 9.6. Дүрмийн 9.5.1-9.5.6 дугаар зүйлд заасан асуудлыг тухайн асуудлаар санал өгөх эрх бүхий нийт хувьцааны 2/3 (гурван хоёр)-оос багагүй хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид биечлэн эсвэл төлөөлөгчөөр дамжуулан баталснаар хүчин төгөлдөр болно. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж байгаа бусад асуудлыг хуралд саналын эрхтэй оролцож байгаа гишүүдийн саналын олонхоор шийдвэрлэнэ.
- 9.7. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хэлэлцсэн асуудал бүрээр гаргасан шийдвэрийг тогтоол хэлбэрээр баталгаажуулж, тухайн асуудлыг хэлэлцсэн хурлын гэмдэгчдийн хамт Компанийн архивд хадгална.
- 9.8. Хувьцаа эзэмшигчид биечлэн оролцохгүйгээр электрон шуудангаар хэлэлцэх асуудлын тухай мэдээлэл, тогтоолын төслийг хүргүүлж санал солилцсоныг үндэслэн хувьцаа эзэмшигчийн тогтоол, шийдвэр гаргаж болно. Хувьцаа эзэмшигчийн тогтоолын төслийг буй хувьцаа эзэмшигчдэд хүргүүлж зөвшөөрсөн буюу татгалзсаныг баталгаажуулж гарын үсэг зуруулснаар хүчин төгөлдөрт тооцогдоно. Хувьцаа эзэмшигчид тогтоолд зөвшөөрсөн буюу татгалзсан саналаа баталж 3 (гурван) хоногийн дотор ирүүлнэ, ийнхүү ирүүлээгүй бол хүргүүлсэн тогтоолын төслийг зөвшөөрсөнд тооцно.

АРАВ. ТУЗ

- 10.1 Компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон 5 (таван) гишүүнтэй байна. ТУЗ хороодтой байж болно.
- 10.2 ТУЗ-ийн дарга болон гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 3 (гурван) жил байна.
- 10.3 ТУЗ-ийн даргыг гишүүдийн дотроос нийт гишүүний олонхын саналаар сонгоно. ТУЗ-ийн даргын түр эзгүйд үүргийг нь түүний томилсон, эсхүл ТУЗ-өөс тухайн удаад сонгогдсон аль нэг гишүүн гүйцэтгэнэ.
- 10.4 ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгож болно. ТУЗ-ийн гишүүн нь Компанийн хувьцаа эзэмшигч биш байж болно.
- 10.5 ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан болон дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээн гүйцэтгэнэ.
  - 10.5.1 үнэт цаас гаргах,
  - 10.5.2 гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг тогтоох,





СЗХ  
2021 оны 06 сарын 13  
БҮРТГЭЭ  
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

Үнэт цаасны ганилцуулга

БҮРТГЭВ-02

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 06 сарын 09 өдрийн 4 тоот тогтоолын Хавсралт 2


- 10.5.3 Компанийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийг томилох, тэдгээрийн бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох,
- 10.5.4 гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллыг тогтоох,
- 10.5.5 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гүйцэтгэх удирдлагаас гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
- 10.5.6 Компанийн дараа жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн талаарх төлөвлөгөөг хэлэлцэж батлах,
- 10.5.7 ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах,
- 10.5.8 ногдол ашгийн хэмжээг тогтоож, төлөх журмыг батлах,
- 10.5.9 Компанийн салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах,
- 10.5.10 Компанийн аудиторыг сонгох, гэрээний нөхцөлийг тогтоох,
- 10.5.11 Компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох.
- 10.5.12 Компанийн тухай хуулийн 11, 12 дугаар бүлэгт заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах,
- 10.5.13 Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4 дэх заалтад заасан тайлан,
- 10.5.14 гүйцэтгэх удирдлагын саналаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудал, болон
- 10.5.15 Энэ Дүрэм, Премиум Групп ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан Эрх мэдлийн хуваарилалт болон Компанийн тухай хуульд заасан бусад асуудал.
- 10.6 ТУЗ-ийн хурлыг телефон утас, видеофон буюу түүнтэй адилтгах холбооны хэрэгсэл болон бичгээр санал хураах гэх мэт хэлбэрээр хуралдуулж болно. Ийнхүү хуралдсан хурлыг биечлэн хуралдсанд тооцно.
- 10.7 ТУЗ-ийн гишүүд биечлэн оролцохгүйгээр электрон шуудангаар хэлэлцэх асуудлын тухай мэдээлэл, тогтоолын төслийг хүргүүлж санал солилцсоныг үндэслэн ТУЗ-ийн тогтоол, шийдвэр гаргаж болно. ТУЗ-ийн тогтоолын төслийг бүх гишүүдэд хүргүүлж зөвшөөрсөн буюу татгалзсаныг баталгаажуулж гарын үсэг зуруулснаар хүчин төгөлдөр тогтооно. Гишүүд тогтоолд зөвшөөрсөн буюу татгалзсан саналаа баталж 3 (гурван) хоногийн дотор ирүүлнэ, ийнхүү ирүүлээгүй бол хүргүүлсэн тогтоолын төслийг зөвшөөрсөнд тооцно.
- 10.8 ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн хуралд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулж оролцох эрхтэй бөгөөд тухайн итгэмжлэгдсэн төлөөлөгч итгэмжлэл олгосон этгээдийн өмнөөс ТУЗ-ийн хуралд оролцох болон санал өгөхийг зөвшөөрнө.

#### АРВАН НЭГ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- 11.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Компанийн гүйцэтгэх захирал энэ Дүрэм, ТУЗ-тэй байгуулсан гэрээ, Эрх мэдлийн хуваарилалтаар олгогдсон эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.
- 11.2. Гүйцэтгэх удирдлага өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, Компанийг төлөөлөх зэргээр Компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.
- 11.3. Гүйцэтгэх захирал өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ. Үүнд:
  - 11.3.1. энэхүү Дүрэм болон холбогдох хууль тогтоомж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн шийдвэр, тухайн жилийн бизнес төлөвлөгөөг биелүүлэх арга замыг хянаж, гүйцэтгэлийг хангуулах,







Үнэт цаасны танилцуулга



Сантрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 06 сарын 08 өдрийн 2 тоот тогтоолын Хавсралт 2

- 11.3.2. Компанийн нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах,
- 11.3.3. Компанийн ажилтнуудын орон тоо, үндсэн болон нэмэгдэл цалин, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоох,
- 11.3.4. ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тогтоох, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх,
- 11.3.5. Компанийн гэрээ хэлцэл, албан захидал, баримт бичигт гарын үсэг зурах,
- 11.3.6. Компанийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулахад шаардлагатай дүрэм журмыг батлан мөрдүүлэх,
- 11.3.7. Компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах,
- 11.3.8. энэхүү Дүрэмд заасан үүргээ биечлэн гүйцэтгэх,
- 11.3.9. Компанид учруулсан хохирлыг төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах, Компанид холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох, эсхүл Компанийг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон оролцуулах,
- 11.3.10. хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн шийдвэр, Эрх мэдлийн хуваарилалтад заасны дагуу Гүйцэтгэх захиралд олгогдсон эрх хэмжээний хүрээнд Компанийн хөрөнгийг захиран зарцуулах,
- 11.3.11. Компаниас хөрөнгө захиран зарцуулах төлбөрийн баримтад гарын үсэг зурах,
- 11.3.12. Компанийн санхүүгийн тайлан тэнцэлд хөндлөнгийн хяналт хийх байгууллагатай гэрээ байгуулах, хяналт хийлгэх, тайланг хэлэлцэж дүгнэлт гаргах,
- 11.3.13. Компанийн Гүйцэтгэх удирдлага Компанийн нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцах, болон
- 11.3.14. Компанийн тухай хууль, Эрх мэдлийн хуваарилалт ТУЗ болон Гүйцэтгэх захирал нарын хооронд байгуулсан гэрээнд заасан бусад эрх, үүргийг
- 11.4. Гүйцэтгэх захирал ээлжийн амралт эдлэх, гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, удаан хугацаагаар өвчлөх болон шаардлагатай бусад тохиолдолд өөрийн эрх, үүргийг өөрийн томилсон этгээдэд шилжүүлнэ. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.



**АРВАН ХОЁР. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ТҮҮНИЙ ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА**

- 12.1. Дараах албан тушаалтнууд нь компанийн эрх бүхий албан тушаалтан байна. Үүнд:
  - 12.1.1. гүйцэтгэх захирал,
  - 12.1.2. үйл ажиллагаа хариуцсан захирал,
  - 12.1.3. худалдан авалт хариуцсан захирал,
  - 12.1.4. санхүүгийн албаны дарга, болон
  - 12.1.5. ерөнхий нягтлан бодогч,
- 12.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь өөрийн санаатай, гэм буруутай үйл ажиллагаа, хайнга хайхрамжгүй байдлаас Компанид хохирол учруулсан тохиолдолд хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлөх хариуцлага хүлээнэ.
- 12.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хууль, Эрх мэдлийн хуваарилалт ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.





МОНГОЛЫН ХОРОНГИЙН БИРХ  
ОНСОЛМАЗ СТОК БИРХЭНГЭ

Үнэт цаасны танилцуулга

2021-09-17  
БҮРТГЭВ-02

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 06 сарын 08 өдрийн 9 тоот тогтоолын Хавсралт 9

- 12.4. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ 1 (Нэг) сарын өмнө бичгээр гаргана.
- 12.5. Санхүүгийн албаны дарга болон ерөнхий нягтлан бодогч нь энэхүү Дүрмийн 12.3-т заасан үүргийг хүлээхээс гадна дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
  - 12.5.1. Компанийн хөрөнгө, ашиг, зарлагын бүртгэлийг нягт нарийн бөгөөд бүрэн хөтлөх,
  - 12.5.2. Компанийн нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцаж, тайланг СТОУС-ын дагуу бэлтгэх зэрэг нягтлан бодох бүртгэлийн бүхий л харилцааг удирдаж, зохион байгуулах,
  - 12.5.3. Компанийн нийт зарлагыг зөвшөөрсөн хэмжээнд зарцуулах, болон
  - 12.5.4. Гүйцэтгэх захирал, ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийн хурлын өмнө санхүүгийн бүх хэлцэл болон Компанийн санхүүгийн байдлын талаар хариуцлага хүлээх.

**АРВАН ГУРАВ. ТАТВАР НОГДУУЛАЛТ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН, НОГДОЛ АШГИЙН ХУВААРИЛАЛТ**

- 13.1. Компанийн санхүүгийн жил нь бүртгэгдсэн өдрөөс эхэлж 12 сарын 31 өдөр дуусна. Компанийг татан буулгах онд санхүүгийн жил нь 01 сарын 01 өдөр эхэлж татан буулгасан өдөр дуусна. Бусад онд санхүүгийн жил нь 01 сарын 01 өдөр эхэлж 12 сарын 31 өдөр дуусна.
- 13.2. Санхүүгийн ба нягтлан бодох бүртгэлийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандартын дагуу хөтөлнө.
- 13.3. Компанийн сонгосон аудитор нь Монгол улсын болон олон улсын нягтлан бодох стандартын дагуу нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий нягтлан бодогч буюу нягтлан бодох, бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлдэг компани байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шаардлагаар Компанийн санхүүгийн баримт бичгийг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчлэн шалгалт хийлгэх, арилгоо гэрээний үндсэн дээр аудитын байгууллагыг томилох ажиллуулж болно.
- 13.4. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу ногдуулах аллага, татвар, төлбөрийг зохих ёсоор төлнө.
- 13.5. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу орлогын татварыг улсын төсөвт төлсний дараа Компани өөрийн санхүүгийн байдлаас хамааран Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон хэмжээгээр нөвцийн болон бусад санг байгуулж болно.
- 13.6. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу элэгдлийн сан байгуулж болно.
- 13.7. Компанийн нягтлан бодох бүртгэлийн тайланд хийх жилийн аудитыг хөндлөнгийн аудитор хийх бөгөөд аудитын тайланг Хувьцаа эзэмшигчдийн хурал, Монгол Улсын холбогдох байгууллагад гаргаж өгнө.
- 13.8. Компани нь Компанийн тухай хууль болон Компаниас батлан гаргасан ногдол ашиг хуваарилах бодлогод нийцүүлэн ногдол ашиг хуваарилж болно.


**АРВАН ДӨРӨВ. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ, ӨР ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХ**

- 14.1. Компанийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр буюу шүүхийн шийдвэрийн дагуу өөрчлөн байгуулах буюу татан буулгаж болно.
- 14.2. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуулийн 18-29 дүгээр зүйлүүдийн үндэслэн шийдвэрлэнэ.





Үнэт цаасны танилцуулга



Сантрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 06 сарын 18 өдрийн 2 тоот тогтоолын Хавсралт 2

- 14.3. Компанийг татан буулгасан тохиолдолд түүний өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр хуваарилна.
- 14.4. Компанийг өөрчлөн байгуулах буюу татан буулгах ажлыг Компанийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасны дагуу гүйцэтгэнэ.

**АРВАН ТАВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ХУГАЦАА**

- 15.1. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

**АРВАН ЗУРГАА. ҮЙЛЧЛЭХ ХУУЛЬ ТОГТООМЖ**

- 16.1. Энэхүү Дүрмийг батлах, түүний хүчин төгөлдөр байдал, хэрэгжүүлэлт, нэмэлт өөрчлөлт оруулах, түүний заалтууд хүчин төгөлдөр бус болох асуудал Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулагдана.


**АРВАН ДОЛОО. БУСАД**

- 17.1. Энэхүү Дүрмийг 2 хувь үйлдэж нэг хувийг бүртгэх байгууллагад, үлдсэн нэг хувийг Компани өөртөө хадгална.
- 17.2. Энэхүү Дүрэм нь Компани бүртгэх байгууллагад бүртгэгдэж гарчилгаа авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 17.3. Энэхүү Дүрэм нь Компанийн үндсэн баримт бичиг байна.
- 17.4. Энэхүү Дүрмээр зохицуулаагүй бусад харилцааг Компаний тухай Монгол Улсын хууль, өөрөөр холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.



(Гарын үсгийн хуудас дагалдана)





Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 06 сарын 13 өдрийн 1 тоот тогтоолын Хавсралт 2

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

А.Ганхуу (УД77052271)

А.Ганболд (УЖ69100211)

Ц.Баяржаргал (ЕВ73102208)

БиЖиЭф Ригэйл Ко. Лтд-ийг төлөөлж  
Г.Чингирал (ТЗ86050612)

А.Одончимэг (УД73082966)

А.Ганбаатар (УЖ68040111)

О.Батмөнх (АЭ74032476)

Т.Бат-Ордон (УП90051112)



Ө.Мөнхбаяр (ХБ81020210)







### 6.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлын ТОГТООЛ



## CENTRAL EXPRESS CVS LLC SHAREHOLDERS RESOLUTION

Date: 26 July 2021

Ref: 6

Ulaanbaatar

### Change of legal form of the Company and initial public offering

Pursuant to provision 17.1 of Article 17, provision 18.1 of Article 18, Article 23, provision 31.2.2 of Article 31, provision 38.8 of Article 38, provision 42.1 of Article 42, provisions 61.1.5 and 61.1.7 of Article 61, provisions 62.1.1, 62.1.2, 62.1.3 and 62.1.4 of Article 62, provision 68.1 of Article 68 and provision 69.1 of Article 69 of the Company Law of Mongolia, provision 6.1 of Article 6 and provision 11.1 of Article 11 of the Securities Market Law of Mongolia, and provision 5.6.2 of Article 5, provision 8.1 of Article 8 and provisions 9.5.1, 9.5.2, 9.5.4, and 9.5.15 of Article 9 of the Charter of Central Express CVS LLC ("**Company**"), it is **RESOLVED** as follows:


1. **THAT** the Company be and is hereby authorized to commence its preparation for the listing of the shares of the Company on the Mongolian stock exchange by offering a certain percentage to public through an initial public offering ("**Public Offering**") in order to raise the funds to ensure further financing CU convenience store chain of the Company;
2. **THAT** the number of authorized share of the Company be and is hereby increased by 169,951,919 (one hundred sixty-nine million nine hundred fifty-one thousand nine hundred nineteen) shares with a par value of MNT100 (one hundred) each;
3. **NOTED** that, as a result of creation of the shares contemplated in Resolution 2 above, the total number of the authorized shares of the Company shall be 849,759,593 (eight hundred forty-nine million seven hundred fifty-nine thousand five hundred and ninety-three) shares and the total number of the issued shares of the Company shall be 679,807,674 ordinary shares (six hundred seventy-nine million eight hundred seven thousand six hundred seventy-four);
4. **THAT** preemptive rights of the shareholders of the Company be and is hereby disappled with respect to the shares contemplated in Resolution 2 above;
5. **THAT** the Board be and is hereby authorized to determine number and a per share price of new shares to be offered by the Company to the public for subscription in consultation with underwriters and to allot, issue and offer such shares on the Mongolian Stock Exchange;
6. **THAT** the Board be and is hereby authorized to undertake actions to effect Public Offering pursuant to relevant rules and regulation and approve and submit the final print of the prospectus with the Financial Regulatory Commission and the Mongolian Stock Exchange;
7. **THAT** changing the legal form of the Company to joint stock company and transferring the rights and responsibilities of the Company to the newly formed joint stock company be and is hereby approved;
8. **THAT** the draft charter of the newly formed joint stock company, attached hereto as Annex 1, be and is hereby approved; and
9. **THAT** the Board be and is hereby authorized to exercise all the powers of the Company in connection with the reorganization of the Company and the Public Offering and to take all such steps as may be necessary or desirable.

(Signature page follows)



1910006 / 8DCD16CE-00F1-4472-8959-D73BC564F6C1





Resolution No. 6 of the shareholders of Central Express CVS LLC dated July 2021



*[Signature]*  
Gankhuyag Adlbish (ShD77052271)

*[Signature]*  
Ganbold Adlbish (UJ69100211)

*[Signature]*  
Bayarjargal Tsogbadrakh (YeV73102208)

*[Signature]*  
BGF/Retail Co., Ltd

*[Signature]*  
Odonchimeg Adlbish (ShD73082966)

*[Signature]*  
Ganbaatar Adlbish (UJ68040111)

*[Signature]*  
Batmunkh Ochirbat (AE74032476)


*[Signature]*  
Bat-Erdene Gansukh (ChR80051112)

*[Signature]*  
Munkhbayar Usukhbayar (KhB81020210)




1910006 / 6DCD18CE





Үнэт цаасны танилцуулга



Англы хэлнээс орчуулав

СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 07 сарын 26 өдөр

Дугаар: 6

Улаанбаатар хот


Компанийн хэлбэрийг өөрчлөх замаар өөрчлөн байгуулах болон  
нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 18 дугаар зүйл 18.1 дэх хэсэг, 23 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 61.1.7 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.2, 61.2.3, 62.1.4 дэх заалт, 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК ("Компани")-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.6.2 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.5.1, 9.5.2, 9.5.4, 9.5.15 дахь заалтыг тус тус үндэслэн тогтоох нь:

1. Компанийн "CU" сүлжээ дэлгүүрийн цаашдын санхүүжилтийг хангах зорилгоор Монголын хөрөнгийн бирж дээр Компанийн хувьцааг анх удаа нийтэд санал болгох журмаар гарган арилжаалахыг зөвшөөрсүгэй.
2. Компанид нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 169,951,919 (нэг зуун жаран есөн сая есөн зуун тавин нэгэн мянга есөн зуун арван есөн) ширхэг зарласан хувьцааг нэмэлтээр гаргахаар шийдвэрлэсүгэй.
3. Тогтоолын 2-т дурдсан хувьцааг нэмэлтээр гаргаснаар Компанийн нийт зарласан энгийн хувьцаа 849,759,593 (найман зуун дөчин есөн сая долоон зуун тавин есөн мянга таван зуун ерэн гурав) ширхэг, гаргасан энгийн хувьцаа 679,807,674 (зургаан зуун далан есөн сая найман зуун долоон мянга зургаан зуун далан дөрвөн) ширхэг болсныг дурдсугай.
4. Тогтоолын 2-т заасан нэмэлтээр гаргах хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг одоогийн хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
5. Компанийн зарласан хувьцаанаас эргэлтэд гарган нийтэд санал болгох энгийн хувьцааны тоо, үнийг мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр тогтоож, Монголын хөрөнгийн биржийн анхдагч зах зээлийн арилжаагаар санал болгох эрхийг ТУЗ-д олгосугай.
6. Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгох, худалдах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, үнэт цаасны танилцуулгыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэхийг ТУЗ-д үүрэг болгосугай.
7. Компанийг хувьцаат компани болгох замаар Компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулахыг зөвшөөрч, Компанийн эрх, үүрэг хариуцлагыг шинээр бий болж байгаа хувьцаат компанид шилжүүлэхээр шийдвэрлэсүгэй.
8. Компанийг хэлбэрийг өөрчлөх замаар үүсэх хувьцаат компанийн дүрмийн төслийг Хавсралт 1-ээр баталсугай.
9. Компанийг өөрчлөн байгуулах, нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах болон энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлагатай арга хэмжээ авч ажиллах, холбогдон гарсан асуудлыг тухай бүр шийдвэрлэж ажиллах бүрэн эрхийг ТУЗ-д олгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)





Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 07 сарын 26 өдрийн 6 тогтоол

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:  
[байгууллагын тэмдэг]

[гарын үсэг]  
А.Ганхуяг (ШД77052271)

[гарын үсэг]  
А.Ганболд (УЖ69100211)

[гарын үсэг]  
Ц.Баяржаргал (ЕВ73102208)

[гарын үсэг, тэмдэг]  
БиЖиЭф Ритэйл Ко. Лтд.

[гарын үсэг]  
А.Одончимэг (ШД73082966)

[гарын үсэг]  
А.Ганбаатар (УЖ68040111)



[гарын үсэг]  
О.Батмөнх (АЭ74032476)

[гарын үсэг]  
Г.Бат-Эрдэнэ (ЧР80051112)

[гарын үсэг]  
Ө.Мөнхбаяр (ХБ81020210)







Үнэт цаасны танилцуулга

## 6.5 Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол



### СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 07 сарын 26 өдөр

№ 11

Улаанбаатар хот


Хувьцаа нэмж гаргах болон  
нийтэд санал болгох хувьцааны үнийг тогтоох

Компанийн тухай хуулийн, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 43 дугаар зүйл, 55 дугаар зүйл, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.4, 76.1.5, 76.1.6, 76.1.13, 76.1.15, 76.1.18 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК ("Компани")-ийн Дүрмийн 10 дугаар зүйлийн 10.5.1, 10.5.7, 10.5.11, 10.5.15 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 07 сарын 26 өдрийн 6 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн зарласан хувьцаанаас 75,534,186 (далан таван сая таван зуун гучин дөрвөн мянга нэг зуун наян зургаан) ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгон анх удаа эргэлтэд гарган Монголын хөрөнгийн биржийн анхдагч зах зээлийн арилжаагаар санал болгохоор шийдвэрлэсүгэй.
2. Компанийн эргэлтэд гаргах хувьцааны нэг бүрийн үнийг 208 (хоёр зуун найман) төгрөгөөр тогтоосугай.
3. Анхдагч зах зээлийн арилжаагаар олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 15,711,110,688 (арван таван тэрбум долоон зуун арван нэгэн сая нэг зуун арван мянга зургаан зуун наян найман) төгрөг байхаар тогтоож, мөнгөн хөрөнгийг Үнэт цаасны танилцуулгад дурдсан зориулалтаар зарцуулахаар шийдвэрлэсүгэй.
4. Компанийг хэлбэрийг өөрчлөх замаар үүсэх хувьцаат компанийн Ногдол ашгийн бодлогын төслийг Хавсралт 1-р баталсугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид холбогдох журмын дагуу мэдэгдэж, зөвшөөрөл авах, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах, холбогдох баримт бичигт Компанийг төлөөлж гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Г Чинзориг)-д олгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-09-17  
Үнэт цаасны танилцуулга

**БҮРТГЭВ-02**

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 07 сарын 16 өдрийн 11 тоот тогтоол

		Гарын үсэг	
		Зөвшөөрсөн	Эс зөвшөөрсөн
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:	А.ГАНХУЯГ		
Төлөөлөн удирдах зөвлөлийн Гишүүд:	А.ГАНБОЛД		
	О.БАТМӨНХ		
	Г.БАТ-ЭРДЭНЭ		
	Г.ЧИНЗОРИГ		
Тогтоолын батлагдсан хувь:		100%	





Үнэт цаасны танилцуулга



## 6.6 Төлөөлөн удирдах зөвлөлийн нэмэлт тогтоол



### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ДУГААР 151021-13  
 ХАВСРАЛТ 0  
 Огноо 2021 оны 09-р сарын 09

УТГА Компанийн нийтэд санал болгон анх удаа гаргах хувьцааны тоог шинэчлэн тогтоох тухай


Компанийн тухай хуулийн, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг 43 дугаар зүйл, 55 дугаар зүйл, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.4, 76.1.5, 76.1.6, 76.1.13, 76.1.15, 76.1.18 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК ("Компани")-ийн Дүрмийн 10 дугаар зүйлийн 10.5.1, 10.5.7, 10.5.11, 10.5.15 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 07-р сарын 26-ны өдрийн 6 тоот тогтоол, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2021 оны 07-р сарын 26-ны өдрийн 11 тоот тогтоол, ТУЗ-ийн 2021 оны 09-р сарын 09-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн зарласан хувьцаанаас нийтэд санал болгон анх удаа эргэлтэд гаргах 75,534,186 (далан таван сая таван зуун гучин дөрвөн мянга нэг зуун наян зургаан) ширхэг энгийн хувьцааг 44,431,874 (дөчин дөрвөн сая дөрвөн зуун гучин нэгэн мянга найман зуун далан дөрвөн) ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн нийт 119,966,060 (нэг зуун арван есөн сая есөн зуун жаран зургаан мянга жаран) ширхэг энгийн хувьцааг (тус хувьцааг нэмж гаргасны дараах байдлаар Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 15 (арван таван) хувьтай тэнцэх) Монголын хөрөнгийн биржийн анхдагч зах зээлийн арилжаагаар санал болгохоор өөрчлөн тогтоосугай.
2. Компанийн эргэлтэд гаргах хувьцааны нэг бүрийн үнийг 208 (хоёр зуун найман) төгрөгөөр тогтоосугай.
3. Тогтоолын 1 дэх хэсэгт дурдсан өөрчлөлттэй холбоотойгоор анхдагч зах зээлийн арилжаагаар олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 24,952,940,480 (хорин дөрвөн тэрбум есөн зуун тавин хоёр сая есөн зуун дөчин мянга дөрвөн зуун наян) төгрөг байхаар тогтоож, мөнгөн хөрөнгийг Үнэт цаасны танилцуулгад дурдсан зориулалтаар зарцуулахаар шийдвэрлэсүгэй.
4. Энэхүү тогтоолын хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид холбогдох журмын дагуу мэдэгдэж, зөвшөөрөл авах шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах, холбогдох баримт бичигт Компанийг төлөөлж гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д олгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

Сэнтрал Экспресс СиВиЭс ХХК  
 Улсын бүртгэлийн дугаар: 9011651142  
 Улаанбаатар хот





ДУГААР 151021-13  
ОГНОО 2021 оны 09-р сарын 09

		Зөвшөөрсөн	Эс зөвшөөрсөн
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:	А.ГАНХУЯГ		
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:	А.ГАНБОЛД		
	О.БАТМӨНХ		
	Г.БАТ-ЭРДЭНЭ		
	Г.ЧИНЗОРИГ		
Тогтоолын батлагдсан хувь:		100%	








## 6.7 Хувьцаат компанийн дүрмийн төсөл



Үнэт цаасны танилцуулга



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн  
2021 оны \_\_ сарын \_\_ өдрийн \_\_ тоот тогтоолын  
Хавсралт \_\_

### СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

#### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад үүсгэн байгуулагдсан Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани") нь Монгол Улсын Компанийн тухай хууль ("Компанийн тухай хууль")-д заасны дагуу өөрийн Дүрэм ("Дүрэм")-ийг батлав.
- 1.2. Энэхүү Дүрмийг батлах, түүний хүчин төгөлдөр байдал, хэрэгжүүлэлт, нэмэлт өөрчлөлт оруулах, түүний заалтууд хүчин төгөлдөр бус болох асуудал Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулагдана.
- 1.3. Энэхүү Дүрэм болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ" гэх)-өөс баталсан аливаа журмаар тусгайлан зохицуулаагүй харилцааг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

#### ХОЁР. КОМПАНИЙН ОНООСОН НЭР, ОРШИН БАЙГАА ГАЗАР

- 2.1. Компанийн оноосон нэр нь Монгол хэлээр Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК, Англи хэлээр Central Express CVS JSC байна.
- 2.2. Компани нь Монгол Улс, Улаанбаатар хот 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 19А, Шангри-Ла Төв, Шангри-Ла Оффис, 23 давхар хаягт байрлана.
- 2.3. Компани нь бүртгэх байгууллагад бүртгэгдсэн өөрийн бэлгэдэл (эмблем) болон барааны тэмдэгтэй байж болно.
- 2.4. Компани нь өөрийн нэр бүхий албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг (тамга) хэрэглэнэ.
- 2.5. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

#### ГУРАВ. КОМПАНИЙН ЭРХ

- 3.1. Компани нь Компанийн тухай хуулийн дагуу зохион байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, банканд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх хуулийн этгээд байна.
- 3.2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг хувьцаат компани хэлбэрээр ажиллана.
- 3.3. Компани нь өөрийн нэрийн өмнөөс гадаадын болон Монгол Улсын болон гадаадын хуулийн этгээд, хувь хүнтэй гэрээ, хэлцэл байгуулах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх олж авах, захиран зарцуулах, үүрэг хүлээх, шүүх, арбитрын үйл ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч болон гуравдагч этгээдээр оролцох эрхтэй.
- 3.4. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд Компани нь бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.
- 3.5. Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 дахь заалтад зааснаас бусад тохиолдолд Компани нь хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй, хувьцаа эзэмшигчид нь Компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 3.6. Компани нь Монгол Улсын нутаг дэвсгэр болон гадаадад өөрийн салбар, төлөөлөгчийн газраа байгуулж болно.
- 3.7. Компани нь өөрийн Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК болон Central Express CVS JSC гэсэн нэрийг бүх үйл ажиллагаандаа ашиглана.



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны \_\_ сарын \_\_ өдрийн \_\_ тоот тогтоолын Хавсралт \_\_

- 3.8. Компани нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Аудитын тухай хуульд нийцүүлэн, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (International Financial Reporting Standards) ("СТОУС")-д заасны дагуу нарийвчилсан нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргана.
- 3.9. Компани нь дотоод, гадаадын банканд төгрөг болон гадаад валютын данстай байна.

#### ДӨРӨВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ


- 4.1. Компани нь дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна. Үүнд:
- 4.1.1. хүнсний дэлгүүр,
  - 4.1.2. хүнсний үйлдвэрлэл,
  - 4.1.3. худалдааны зуучлал,
  - 4.1.4. франчайзын гэрээний үндсэн дээр бизнесийн үйл ажиллагаа явуулах, болон
  - 4.1.5. гадаад худалдаа,
  - 4.1.6. менежментийн зөвлөх үйлчилгээ,
  - 4.1.7. хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа.

#### ТАВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

- 5.1. Компанийн зарласан энгийн хувьцаа нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 849,759,593 (найман зуун дөчин есөн сая долоон зуун тавин есөн мянга таван зуун ерэн гурав) ширхэг байна.
- 5.2. Компанийн гаргасан энгийн хувьцааны тоо [●●●] ([●●●]) ширхэг энгийн хувьцаа байна.
- 5.3. Компанийн энгийн хувьцаа тус бүр 1 (нэг) саналын эрхтэй байна.
- 5.4. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.2 дахь хэсэгт зааснаар тодорхойлно.
- 5.5. Зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, Дүрэмд зааснаас бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг ТУЗ гаргана.
- 5.6. Компани нь өөрийн хувьцаа болон үнэт цаасны хадгаламж, үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

#### ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1. Компанийн энгийн Хувьцаа эзэмшигчид нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:
- 6.1.1. хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүү санал өгөх;
  - 6.1.2. эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээгээр ногдол ашиг авах;
  - 6.1.3. Компанийн талаарх бүх мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах;
  - 6.1.4. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
  - 6.1.5. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон Компанийн Дүрэмд заасны дагуу Компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг өөрийн эзэмшиж байгаа хувьцаанд хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах;



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны \_\_ сарын \_\_ өдрийн \_\_ тоот тогтоолын Хавсралт \_\_

- 6.1.6. Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 дахь заалтад зааснаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээх;
- 6.1.7. Өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эзэмшиж байгаа үнэт цаасны тоог Компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх этгээдэд мэдээлэх, түүнчлэн эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрд нь мэдэгдэх;
- 6.1.8. Хууль тогтоомж болон энэхүү Дүрмээр тогтоосон эрх, үүрэг.

#### ДОЛОО. КОМПАНИЙН УДИРДЛАГА

- 7.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна.
- 7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна.
- 7.3. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг Компанийн гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.

#### НАЙМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН БҮРЭН ЭРХ

- 8.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-өөс баталсан Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журамд заасны дагуу зарлан хуралдуулна.
- 8.2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-өөс тогтоосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон Компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээд гаргана.
- 8.3. Дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. Үүнд:
  - 8.3.1. энэхүү Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах,
  - 8.3.2. нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар Компанийг өөрчлөн байгуулах,
  - 8.3.3. Компанийн хэлбэрийг өөрчлөх,
  - 8.3.4. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох,
  - 8.3.5. ТУЗ-ийн гишүүдийг томилох, бүрэн эрхийг тогтоох болон хугацаанаас нь өмнө дуусгавар болгох,
  - 8.3.6. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
  - 8.3.7. Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4 дэх заалтад заасан тайлан,
  - 8.3.8. хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагаас оруулсан бусад асуудал.
- 8.4. Дүрмийн 8.3.1-8.3.4 дүгээр зүйлд заасан асуудлаар гарах шийдвэр хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын дэмжсэн саналаар, бусад асуудлаар гарах шийдвэр хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхын дэмжсэн саналаар хүчин төгөлдөр болно.
- 8.5. Дүрмийн 8.3.5 дугаар зүйлд заасан асуудлыг Дүрмийн 9.1 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 8.6. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хэлэлцсэн асуудал бүрээр гаргасан шийдвэрийг хурлын тэмдэглэл, тогтоол хэлбэрээр гаргаж хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд, тэдгээрийг Компанийн архивд хадгална.





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИР  
ЭХЭГ

2021.09.17  
Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-02

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны \_\_ сарын \_\_ өдрийн \_\_ тоот тогтоолын Хавсралт \_\_


8.7. Хувьцаа эзэмшигчдийн хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор хурлын тэмдэглэлийг гаргаж, хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд уг тэмдэглэлийн үнэн зөвийг хурлын дарга хариуцна.

#### ЕС. ТУЗ

- 9.1. ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон 9 (есөн) гишүүнтэй байх ба гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгоно.
- 9.2. ТУЗ-ийн даргыг гишүүдийн дотроос нийт гишүүдийн олонхын саналаар сонгоно. ТУЗ-ийн даргын түр эзгүйд үүргийг нь түүний томилсон, эсхүл ТУЗ-өөс тухайн удаад сонгогдсон аль нэг гишүүн гүйцэтгэнэ. ТУЗ-ийн дарга нь Компанийн Гүйцэтгэх захирлын албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.
- 9.3. ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 3 (гурван) жил байна.
- 9.4. ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан болон дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:
  - 9.4.1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
  - 9.4.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
  - 9.4.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
  - 9.4.4. Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
  - 9.4.5. Дүрэмд заасан хувьцаанд хамаарах үнэт цаас болон бусад үнэт цаас, өрийн бичиг гаргах;
  - 9.4.6. Компанийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;
  - 9.4.7. Компанийн гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багийг сонгох, тэдгээрийн бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох;
  - 9.4.8. ТУЗ, Компанийн Гүйцэтгэх захирал болон Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдтэй байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
  - 9.4.9. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
  - 9.4.10. Компанийн жилийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, төсвийг хэлэлцэж батлах;
  - 9.4.11. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
  - 9.4.12. ногдол ашгийн хэмжээг тогтоох, хуваарилах журмыг тодорхойлох;
  - 9.4.13. Компанийн охин, хараат компани, салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах, тэдгээрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
  - 9.4.14. Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох;
  - 9.4.15. Компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох;
  - 9.4.16. Компанийн үндсэн хөрөнгийг актлах, данснаас хасах, худалдах, шилжүүлэх, хөрөнгийн үнэлгээний дүнгээр үнэ цэний бууралтыг бүртгэх, хүлээн зөвшөөрөх асуудлыг шийдвэрлэх;
  - 9.4.17. Компанийн өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;








Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны \_\_ сарын \_\_ өдрийн \_\_ тоот тогтоолын Хавсралт \_\_

- 9.4.18. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 9.4.19. Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4 дэх заалтад заасан тайлан;
- 9.4.20. энэ Дүрэм болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон асуудал; болон
- 9.4.21. гүйцэтгэх удирдлагын саналаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.
- 9.5. ТУЗ үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батлах бөгөөд үүнд ТУЗ-ийн хурлыг хуралдуулах журмыг мөн заасан байна.
- 9.6. ТУЗ-ийн хурлыг улиралд 1 (нэг)-ээс доошгүй удаа хуралдуулах, шаардлагатай тохиолдолд хэдийд ч ТУЗ-ийн хурлыг зарлан хуралдуулж болох бөгөөд ТУЗ-ийн хурал гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно. ТУЗ-ийн хурлаас тогтоол гарах бөгөөд түүнд ТУЗ-ийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонх зөвшөөрч гарын үсэг зурснаар шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 9.7. ТУЗ-ийн хурлыг телефон утас, видеофон буюу түүнтэй адилтгах холбооны хэрэгслээр цахим хэлбэрээр хуралдуулж болно. Ийнхүү хуралдсан хурлыг биечлэн хуралдсанд тооцно.
- 9.8. ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн хуралд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулж оролцох эрхтэй бөгөөд тухайн итгэмжлэгдсэн төлөөлөгч итгэмжлэл олгосон этгээдийн өмнөөс ТУЗ-ийн хуралд оролцох болон санал өгөхийг зөвшөөрнө.
- 9.9. ТУЗ нь шаардлагатай тохиолдолд биечлэн эсвэл цахимаар хурал хуралдуулахгүйгээр тогтоол хэлбэрээр шийдвэр гаргаж болно. Энэ тохиолдолд электрон шуудангаар шийдвэрлэх асуудлын тухай мэдээлэл, тогтоолын төслийг ТУЗ-ийн гишүүдэд хүргүүлж, тэдгээрийн зөвшөөрсөн эсвэл татгалзсан саналыг үндэслэн ТУЗ-ийн тогтоол гаргаж болох ба тогтоолд ТУЗ-ийн нийт гишүүдийн олонх зөвшөөрч гарын үсэг зуруулснаар шийдвэр хүчин төгөлдөр болно. ТУЗ-ийн гишүүд тогтоолын төслийг зөвшөөрсөн эсвэл татгалзсан саналаа 3 (гурв) хоногийн дотор мэдэгдэх ба ийнхүү мэдэгдээгүй бол хүргүүлсэн тогтоолын төслийг зөвшөөрсөнд тооцно.
- 9.10. ТУЗ нь Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороотой байх ба хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
- 9.11. ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно.
- 9.12. ТУЗ-ийн хороодын чиг үүргийг ТУЗ-өөс баталсан журмаар тодорхойлох ба ТУЗ-ын хороод нь тодорхой асуудлаар дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах, зарим асуудлаар шийдвэр гаргах эрхтэй байна.
- 9.13. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилох ба ТУЗ-ын дарга нь ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийг томилно.
- 9.14. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-өөс баталсан ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журамд заасан үүргийг хүлээнэ.

#### АРАВ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- 10.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Компанийн Гүйцэтгэх захирал энэ Дүрэм, ТУЗ-тэй байгуулсан гэрээгээр олгогдсон эсвэл ТУЗ-өөс тусгайлан олгосон эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.
- 10.2. Гүйцэтгэх захиралд олгогдсон эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин хөлс, урамшуулал зэргийг ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заана.
- 10.3. Гүйцэтгэх удирдлага өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлыг шийдвэрлэх, эрх олгох, хэлцэл хийх, гэрээ байгуулах, Компанийн ажиллагсдыг ажилд томилох, чөлөөлөх, ажилтны ажлын байрын тодорхойлолтыг батлах.





Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны \_\_ сарын \_\_ өдрийн \_\_ тоот тогтоолын Хавсралт \_\_

ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах, Компанийг төрийн байгууллагын өмнө төлөөлөх зэрэг компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

10.4. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно.

#### АРВАН НЭГ. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

11.1. Дараах албан тушаалтнууд нь Компанийн эрх бүхий албан тушаалтан байна. Үүнд:

- 11.1.1. ТУЗ;
- 11.1.2. Гүйцэтгэх захирал;
- 11.1.3. Санхүү хариуцсан захирал;
- 11.1.4. Үйл ажиллагаа хариуцсан захирал; болон
- 11.1.5. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга.

11.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хууль, ТУЗ эсвэл Компанитай байгуулсан гэрээнд заасан эрх эдэлж, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

#### АРВАН ХОЁР. ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

- 12.1. Их хэмжээний хэлцэлд Компанийн тухай хуулийн 87.1-д заасан хэлцлийг тооцно.
- 12.2. Их хэмжээний хэлцэлд Компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл хамаарахгүй.
- 12.3. Их хэмжээний хэлцлийг Компанийн тухай хуулийн 87, 88 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.
- 12.4. Сонирхлын зөрчилтэй хэлцэлд Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасан этгээдтэй хийсэн хэлцлийг тооцно.
- 12.5. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг Компанийн тухай хуулийн 91, 92 дугаар зүйлд заасан шаардлага, журмын дагуу хийнэ.

#### АРВАН ГУРАВ. ТАТВАР НОГДУУЛАЛТ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- 13.1. Компанийн санхүүгийн жил нь бүртгэгдсэн өдрөөс эхэлж 12 сарын 31 өдөр дуусна. Компанийг татан буулгах онд санхүүгийн жил нь 01 сарын 01 өдөр эхэлж татан буулгасан өдөр дуусна. Бусад онд санхүүгийн жил нь 01 сарын 01 өдөр эхэлж 12 сарын 31 өдөр дуусна.
- 13.2. Санхүүгийн ба нягтлан бодох бүртгэлийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандартын дагуу хөтөлж, хувьцаа эзэмшигч болон эрх бүхий этгээдэд танилцуулна.
- 13.3. Компанийн хөндлөнгийн аудитын байгууллага нь Монгол улсын болон олон улсын нягтлан бодох стандартын дагуу нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий нягтлан бодогч буюу нягтлан бодох, бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлдэг компани байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шаардлагаар Компанийн санхүүгийн баримт бичгийг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчлэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр хөндлөнгийн аудитын байгууллагыг томилон ажиллуулж болно.
- 13.4. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу ногдуулах аливаа татвар, төлбөрүүдийг зохих ёсоор төлнө.
- 13.5. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу орлогын татварыг улсын төсөвт төлсний дараа Компани өөрийн санхүүгийн байдлаас хамааран Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон хэмжээгээр нөөцийн болон бусад санг байгуулж болно.



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны \_\_ сарын \_\_ өдрийн \_\_ тоот тогтоолын Хавсралт \_\_

- 13.6. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу элэгдлийн сан байгуулж болно.
- 13.7. Компанийн нягтлан бодох бүртгэлийн тайланд хийх жилийн аудитыг хөндлөнгийн аудитын байгууллага хийх бөгөөд аудитын тайланг Хувьцаа эзэмшигчдийн хурал, Монгол Улсын холбогдох байгууллагад гаргаж өгнө.

#### АРВАН ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ

- 14.1. Компанийн ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.
- 14.2. Компанийн ногдол ашгийн бодлого, төлөх журмыг ТУЗ батална.
- 14.3. Компанийн ногдол ашгийн бодлогыг нийтэл ил тод байршуулна.

#### АРВАН ТАВ. ДОТООД ХЯНАЛТ

- 15.1. Компанийн дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Компанийн удирдлагын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байх ба үүнтэй холбогдох журмыг ТУЗ батална. Тус журам нь Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйл болон бусад холбогдох хуульд нийцсэн байна.
- 15.2. Компанийн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлж ажиллах дотоод аудитыг Аудитын хороо томилж, үйл ажиллагаанд хяналт тавьж удирдлагаар хангаж ажиллана.

#### АРВАН ЗУРГАА. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ, ӨР ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХ

- 16.1. Компанийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр буюу шүүхийн шийдвэрийн дагуу өөрчлөн байгуулах буюу татан буулгаж болно.
- 16.2. Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу компани нийт энгийн хувьцааны 75 хувиас дээш хувийг эзэмшдэг өөрийн охин компаниа нэгтгэх, ийнхүү нэгтгэснээр компанийн дүрэмд өөрчлөлт орох шаардлагагүй тохиолдолд ТУЗ уг компанийг нэгтгэх шийдвэр гаргаж, нэгтгэх журмыг баталж болно.
- 16.3. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуулийн 18-29 дүгээр зүйлүүдийг үндэслэн шийдвэрлэнэ.
- 16.4. Компанийг татан буулгасан тохиолдолд түүний өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр хуваарилна.
- 16.5. Компанийг өөрчлөн байгуулах буюу татан буулгах ажлыг Компанийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасны дагуу гүйцэтгэнэ.

#### АРВАН ДОЛОО. БУСАД

- 17.1. Энэхүү Дүрмийг 2 хувь үйлдэж нэг хувийг бүртгэх байгууллагад, үлдсэн нэг хувийг Компани өөртөө хадгална.
- 17.2. Энэхүү Дүрэм нь Компани бүртгэх байгууллагад бүртгэгдэж гэрчилгээ авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 17.3. Энэхүү Дүрэм нь Компанийн үндсэн баримт бичиг байна.

-----oOo-----



6.8 Засаглалын гэрчилгээ

СЗХ  
2021.10.13  
БҮРТГЭВ  
№.1

МОНГОЛЫН ХӨРӨНГНИЙ БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2021-09-17  
Үнэт цаасны танилцуулга  
БҮРТГЭВ-02

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

**CERTIFICATE  
ГЭРЧЛЭГЭЭ**

№ 0731239

Ажилчин овогтой Тэнгүрэг нь

Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалтын үндэслэн

"Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга" нарт зориулсан

Компанийн засаглалын 36 цагийн сурвалжанд хамрагдсан тул эвэрчлээ олоов.

Д.ГАНБАЯР  
Компанийн засаглалын  
Үндэсний зөвлөлийн дарга

Х.ДҮҮРЭН  
Монголын Үндэсний Хуралдаа Аж  
Үйлдвэрийн Таагварын Гүйцэтгэх Захирал

2021 оны 09-р сарын 31 өдөр

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

**CERTIFICATE  
ГЭРЧЛЭГЭЭ**

№ 0731244

Тэнгүрэг овогтой Чингүрэг нь

Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалтын үндэслэн

"Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга" нарт зориулсан

Компанийн засаглалын 36 цагийн сурвалжанд хамрагдсан тул эвэрчлээ олоов.

Д.ГАНБАЯР  
Компанийн засаглалын  
Үндэсний зөвлөлийн дарга

Х.ДҮҮРЭН  
Монголын Үндэсний Хуралдаа Аж  
Үйлдвэрийн Таагварын Гүйцэтгэх Захирал

2021 оны 09-р сарын 31 өдөр

Goldman Sachs  
Delivering diversity  
1119212111 111921580  
Урьдчилсан үнэ

1117231006 0159801 227





**СЗХ**  
2021 оны 13 өдөр  
**БҮРТГЭВ**  
№ 01

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ  
ҮЙЛДЭВРИЙН ТАНХИМЫН ГҮЙШЭТГЭХ ЗАХИРАЛ  
Унэт цаасны танилцуулга  
2021  
**БҮРТГЭВ-02**

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

**CERTIFICATE**  
**ГЭРЧИЛГЭЭ**

Фугаар 0731240

*Агуйнш* оюутай *Тангуй* нь

Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалттай үндэслэн  
"Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ашгуур, нарийн бичгийн дарга" нэрт зориулсан  
Компанийн засаглалын 36 цагийн суралтанд хамрагдсан тул эерчилжээ олоог.

*[Signature]*  
Д.ГАНБАЯР  
Компанийн засаглалын  
Үндэсний зөвлөлийн дарга

*[Signature]*  
Т.ДУУРЭН  
Монголын Үндэсний Худалдаа Аж  
Үйлдвэрийн Танхимын Гүйцэтгэх Захирал

2021 оны 13-р сарын 13 өдөр

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

**CERTIFICATE**  
**ГЭРЧИЛГЭЭ**

Фугаар 0731197

*Несс* оюутай *Тангуйа* нь

Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалттай үндэслэн  
"Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ашгуур, нарийн бичгийн дарга" нэрт зориулсан  
Компанийн засаглалын 36 цагийн суралтанд хамрагдсан тул эерчилжээ олоог.


*[Signature]*  
Д.ГАНБАЯР  
Компанийн засаглалын  
Үндэсний зөвлөлийн дарга

*[Signature]*  
Т.ДУУРЭН  
Монголын Үндэсний Худалдаа Аж  
Үйлдвэрийн Танхимын Гүйцэтгэх Захирал

2021 оны 13-р сарын 13 өдөр

Global Capital  
Delivering diversity  
41102501114 0451509  
Уулзахаас 100 метр

*[Signature]*  
228



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

**CERTIFICATE**  
**ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар 0731243

*Тануух* овогтой *Хан-Агва* нь

Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалттай үндэслэн

"Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ашгуур, нарийн бичгийн дарга" нэрт зориулсан

Компанийн засаглалын 36 цэвийн сурвалжанд хамрагдсан тул ээрчилгээ олгов.

*[Signature]*  
Д.ГАНБЯАР  
Компанийн засаглалын  
Үндэстэй зөвлөлийн дарга

*[Signature]*  
Т.ДҮҮРЭН  
Монголын Үндэсний Худалдаа Аж  
Үйлдвэрийн Тэнхимын Гүйцэтгэх Захирал

20 21 оны 03-р сарын 21 өдөр

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

**CERTIFICATE**  
**ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар 0731242

*Сүрбэл* овогтой *Ганзориг* нь

Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалттай үндэслэн

"Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ашгуур, нарийн бичгийн дарга" нэрт зориулсан

Компанийн засаглалын 36 цэвийн сурвалжанд хамрагдсан тул ээрчилгээ олгов.

*[Signature]*  
Д.ГАНБЯАР  
Компанийн засаглалын  
Үндэстэй зөвлөлийн дарга

*[Signature]*  
Т.ДҮҮРЭН  
Монголын Үндэсний Худалдаа Аж  
Үйлдвэрийн Тэнхимын Гүйцэтгэх Захирал

20 21 оны 03-р сарын 21 өдөр







СЭХ  
2019.05.13 дөр  
БҮРТГЭВ

Үнэт цаасны танилцуулга

2019-05-17  
БҮРТГЭЭ-02

6.9 Үндсэн андеррайтерийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл

Хууль зүйн салбарын 2016 оны  
А-204 дүгээр тушаалаар баталсан

**МОНГОЛ УЛС**  
**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН**  
**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**

000189287

2011.05.19 <i>/ Бүртгэсэн он, сар, өдөр /</i>	9011287134 <i>/ Хуулийн хэргийн дугаар /</i>	
	5481589 <i>/ Регистрийн дугаар /</i>	
Голомт капитал ҮЦК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	
<i>/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /</i>		
<b>Дүрэм</b> <i>/ Үүсэн байгуулах баримт бичиг /</i>		
Шийдвэр <i>/ шийдвэрийн нэр /</i>	01 <i>/ дугаар /</i>	2011.05.17 <i>/ он, сар, өдөр /</i>
6612 <i>/ код /</i>	Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавараар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ <i>/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /</i>	
6630 6419 <i>/ код /</i>	Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа <i>/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /</i>	
<b>Хугацаагүй</b> <i>/ хугацаа /</i>	1 <i>/ гишүүдийн тоо /</i>	1,130,400.0 <i>/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /</i>
Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, чингисийн өргөн чөлөө, 24, Парк Плейс оффисын барилга, 4 давхар, 403,404, Утас1: 311971, Утас2: , Факс: 70110549 <i>/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /</i>		
		Улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар <i>/ бүртгэсэн байгууллагын нэр /</i>
Гэрчилгээ дахин олгосон 2019 он 8 сар 21 өдөр		





СЗХ  
2021.09.13  
БҮРТГЭВ  
№ 01

МОНГОЛЫН ХЭРЭНГИЙН  
ТОНСОЛЫН ТӨСӨВ  
STOCK EXCH.

2021-09-17  
Үнэт цаасны танилцуулга  
БҮРТГЭВ-02

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Отгон овогтой Мөнхжаргал-а Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2019.08.21	С.Цолмон
2	Дөхін гэрчилгээ олгов.	2019.08.21	С.Цолмон
1	Өөрийн хөрөнгийн хэмжээ 199609.8 мян.төг-р нэмэгдэж нийт 1330009.8 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2019.08.05	Д.Ганзамөрөн
2	6492 Үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2019.09.05	Д.Ганзамөрөн
(5)	Улаанбаатар Хан-Уул 11-р хороо зайсан дүнжингарав Энтертаймент үйлчилгээний төвийн 1-р давхар, А-3 тоот-д байрлах салбар нэгжийг улсын бүртгэлээс хассаныг бүртгэв.	2020-02-21	М.Монголжин
6	64200 Номинал дансвар дамжуулан харилцаагчдад мөнгөн хөрөнгийн солого, зарлэсын гүйлгээний үйлчилгээ үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2020.03.11	М.Монголжин
7	Санжхуяа овогтой Гансүрэн-а Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2021.08.28	Д.Ганзамөрөн
10	Чултэм овогтой Мөнхцэцэг-э ТУЗ-ийн дарга-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2021.07.29	С.Мөнхсанчир
11	Гишүүн 3 нэмэгдэж 3 хасвагдж ТУЗ-н гишүүн тоо нийт 3 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2021.07.29	С.Мөнхсанчир

Энэхүү гэрчилгээг хуурамцаар үйлдсэн болгохд Монгол Улсын хуулийн дэглэм, зарим хууль, тогтоол, Улсын бүртгэлийн гэрчилгээгасвартай бол хуульгүй.



\* 0 0 0 1 8 9 2 8 7 \*







МОНГОЛ УЛСЫН  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 301/97

2011 оны 11 сарын 02 өдөр

Монгол улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 сарын 02 өдрийн 317 дугаар тогтоолоор  
**"ГОЛОМТ КАПИТАЛ УЦК" ХХК** -д  
ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА  
"тамга"



*Д. Баярсайхан*


Д. БАЯРСАЙХАН

Энэхүү гэрчилгээ нь  
хавсралтын хамт  
хүчинтэй










Үнэт цаасны танилцуулга



### 6.10 Туслах андеррайтерийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл

Хууль зүйн сайдын 2016 оны  
А/204 дүгээр тушаалаар батлан

**МОНГОЛ УЛС**  
**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН**  
**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**  
000162477

2011.03.02 <i>/Бүртгэсэн он, сар, өдөр /</i>	9011274085 <i>/Хувийн хэргийн дугаар /</i>	
	5453283 <i>/Регистрийн дугаар /</i>	
Апекс капитал ҮЦК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	
<i>/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /</i>		
<b>Дүрэм</b> <i>/Үүсгэн байгуулах баримт бичиг /</i>		
Шийдвэр <i>/шийдвэрийн нэр /</i>	01 <i>/дугаар /</i>	2011.02.21 <i>/он, сар, өдөр /</i>
4610 <i>/код /</i>	Худалдааны зуучлал <i>/Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /</i>	
6611 <i>/код /</i>	Брокер, дилерийн үйл ажиллагаа <i>/Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /</i>	
<b>Хугацаагүй</b> <i>/хугацаа /</i>	1 <i>/ гишүүдийн тоо /</i>	1,350,000.0 <i>/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган тогрозвор /</i>
Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Цэнтрал тауэр, 9 давхар 903 тоот. Утас1 99111561, Утас2 Факс <i>/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /</i>		

Гэрчилгээ дахин олгосон 2018 он 5 сар 18 өдөр







Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Тайлбар	Ажилтан тэмдэг
1	Мөнхбаяр овогтой Амар-е Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2018.04.23	Э.Эрдэнэбилэг
2	Дахин гэрчилгээ олгов.	2018.05.18	О.Шижиртуяа
1	Буюндэлээр овогтой Лхамдолгор -а Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2018.08.22	Ч.Батдэлгэр
2	6499 Андеррайтерийн үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2018.11.02	Ж.Нямдорж
6	66300 Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2019.09.24	С.Мөнхсөнцр
7	Эцсийн өмчлөгч 1 ирээн бүртгэв.	2020.04.14	Д.Чулуунтуяа
8	64300 Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2020.04.14	Д.Чулуунтуяа
9	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1700000 мян.төг-р нэмэгдэж нийт 3050000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2020.05.07	О.Өлзийбат
9	Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2020.05.07	О.Өлзийбат
10	Эцсийн өмчлөгч 1 нэмэгдэж 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2020.05.07	О.Өлзийбат
11	66110 Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх үйл ажиллагаа үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2020.05.07	О.Өлзийбат

Энэхүү танилцуулга хуульчид үйлчилгээ үзүүлж Монгол Улсын хуулийн дагуу хариуцаж мэдээлсэн. Үүсгэн бүртгэлийн гэрээг эх мөхөөрлийг болгохгүй.



\* 0 0 0 1 6 2 4 7 7 \*







МОНГОЛ УЛСЫН  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 301/62

2011 оны 03 сарын 28 өдөр

Монгол улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 03 сарын 28 өдрийн 75 дугаар тогтоолоор "АПЕКС КАПИТАЛ ҮЦК" ХХК -д ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА  
"тамга"



Д.БАЯРСАЙХАН

Энэхүү гэрчилгээ нь  
хавсралтын хамт  
хүчинтэй









СЗХ  
2021.09.13 өдөр  
БҮРТГЭВ

МОНГОЛ УЛС  
2021-09-17  
БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга

6.11 Хөндлөнгийн үнэлгээний байгууллагын гэрчилгээ, тусгай зөвшөөрөл

Хууль зүйн газрын 2016 оны  
А-204 дүгээр тушаалаар батлан

**МОНГОЛ УЛС**  
**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН**  
**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**  
000140132

2009.12.03 <i>/ Бүртгэсэн он сар өдөр /</i>	9011215085 <i>/ Улсын бүртгэлийн дугаар /</i>	
	5342961 <i>/ Регистрийн дугаар /</i>	
Гэрэгэ-Эстимэйт <i>/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /</i>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани <i>/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /</i>	
<b>Дүрэм</b> <i>/ Үүсэм байгуулах баримт бичиг /</i>		
Тогтоол <i>/ шийдвэрийн нэр /</i>	01/09 <i>/ дугаар /</i>	2009 11 11 <i>/ он сар өдөр /</i>
5820 <i>/ код /</i>	Хөрөнгийн үнэлгээ хийх /2014 06 23-2017 06 23/ <i>/ Тусгай зөвлөх үйл ажиллагааны чиглэл /</i>	
8299 8621	Бизнесийн зөвлөгөө өгөх Даатгалын хохирол үнэлэгчийн <i>/ код /</i>	
	<i>/ Туслах зөвлөх үйл ажиллагааны чиглэл /</i>	
Хугацаагүй <i>/ хугацаа /</i>	3 <i>/ гишүүдийн тоо /</i>	10.000 0 <i>/ оврийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /</i>
Улаанбаатар, Сүхбаатар, 6-р хороо, бага тойруу 376 Үйлчилгээний төвд, Утас1 99107317, Утас2 Факс <i>/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /</i>		



Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Хуулийн этгээдийн бүртгэлийн газар  
*/ бүртгэсэн байгууллагын нэр /*

Гэрчилгээ дахин олгосон 2017 он 3 сар 31 өдөр

Голын Гэрлийн ҮЦХ ХХК  
Gol-Golny  
Business Agency  
111722100000615

Улаанбаатар хот  
2021.09.17  
238  
111722100000615





Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан, тэмдэг
1	Цэнгэлбаяр овогтой Гоомарал-а Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв Дахин гэрчлээ олгов.	2017.03.31	С.Мөнхсаншир С.Мөнхсаншир
2		2017.03.31	
2	Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 0 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2018.01.08	О.Шижиртуяа
3	Улаанбаатар, Сүхбаатар, 6-р хороо, баян тойруу, 24/1-5а, "Монреаллекс" ХХК-ийн байр тоот, Утас1 70005000, Утас2, Факс хаягийг шинээр бүртгэв.	2018.01.08	О.Шижиртуяа
4	Доноров овогтой Ганбаатар -а Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2018.01.08	О.Шижиртуяа
5	6820 Хөрөнгийн үнэлгээ хийх /2017.01.11-2020.01.11/ эрхлэх үйл ажиллагааг шинээр бүртгэв.	2018.03.18	З.Эрдэнэбилэг
6	Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2019.03.28	Ж.Оюунва
7	Эцсийн өмчлөгч 1 ирсэн бүртгэв.	2021.03.10	Ш.Очирсүрэн
8	6820 Хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагааны чиглэлийн хугацааг 2019.12.17-2022.12.17 болгож сунгав.	2021.03.10	Ш.Очирсүрэн





СЭХ  
2017 оны 12 сарын 13 өдөр  
БҮРТГЭВ

БҮРТГЭВ-02

САНГИЙН ЯАМ

Сангийн сайдын 2010 оны 19 дугаар тушаалын 3 дугаар хэсэгд

### ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 051100154

Иргэний ургийн овог: \_\_\_\_\_  
 Иргэний овог, нэр: \_\_\_\_\_  
 Иргэний үнэмлэхний дугаар: \_\_\_\_\_  
 Иргэний бүртгэлийн дугаар: \_\_\_\_\_  
 Үнэлгээчний гэрчилгээний дугаар: \_\_\_\_\_  
 Иргэний хаяг: \_\_\_\_\_  
 Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: \_\_\_\_\_

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусад худалдаа, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД

*[Signature]*  
УЛААНБААТАР ХОТ

#### ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2015 оны 314 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2015 оны 12-р сарын 18-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД

*[Signature]* / Б.БОЛОР /

#### ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2018 оны 284 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2018 оны 12-р сарын 15-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД

*[Signature]* / Ч.ХҮРЭЛБААТАР /

#### ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20... оны ... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20... оны ...-р сарын ...-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-09-17

Үнэт цаасны танилцуулга  
БҮРТГЭВ-02

САНГИЙН ЯАМ Сангийн сайдын 2019 оны 19 дүгээр тушаалын 3 дугаар хамралт

### ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 121200001

Иргэний ургийн овог: \_\_\_\_\_  
Иргэний овог, нэр: \_\_\_\_\_  
Иргэний үнэмлэхний дугаар: \_\_\_\_\_  
Иргэний бүртгэлийн дугаар: \_\_\_\_\_  
Үнэлгээчний гэрчилгээний дугаар: \_\_\_\_\_  
Иргэний хаяг: \_\_\_\_\_

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: \_\_\_\_\_


Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдол бүрдэд худалдах, барьцаалах, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД  Ч.УЛААН  
УЛААНБААТАР ХОТ


**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

Сангийн сайдын 20.15 оны 344 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг  
20.15 оны 12-р сарын 18-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД  / Б.БОЛОР /

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

Сангийн сайдын 20.18 оны 284 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг  
20.18 оны 12-р сарын 18-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД  / Ч.ХҮРЭЛБААТАР /

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

Сангийн сайдын 20.... оны .... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг  
20.... оны ...-р сарын ...-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /





СЭХ  
 2021 оны 10-р сар  
 БҮРТГЭВ  
 5077

Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-02

САНГИЙН ЯАМ Сангийн сайдын 2010 оны 19 дугаар тушаалын 3 дугаар нэмэлт

### ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 101200188

Иргэний ургийн овог: Хөтхүл  
 Иргэний овог нэр: Дундговь аймагтай Гэрлэвчигэр  
 Иргэний үнэмлэхний дугаар:  
 Иргэний бүртгэлийн дугаар: 0077112572  
 Үнэлгээчний гэрчилгээний дугаар:  
 Иргэний хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 22-р хороо хөвчир бүлэг А-111 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 7 тоот тушаал

**Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.**

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тусгай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дэх хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдал, удагдал, баярлах, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД Х. ХҮРЭЛБААТАР

**ХЛААНБААТАР ХОТ**

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**  
 Сангийн сайдын 20... оны 262 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг  
 20... оны 12-р сарын 7-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.  
 САНГИЙН САЙД Х. ХҮРЭЛБААТАР

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**  
 Сангийн сайдын 20... оны ... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг  
 20... оны ...-р сарын ...-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.  
 САНГИЙН САЙД

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**  
 Сангийн сайдын 20... оны ... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг  
 20... оны ...-р сарын ...-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.  
 САНГИЙН САЙД







СЭХ  
2021.10.13  
БҮРТГЭВ  
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-09-17

Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-02

6.12 Хөндлөнгийн аудитын байгууллагын зөвшөөрөл

гэрчилгээ, тусгай

Хууль зүйн сайдын 2016 оны  
А.204 дүгээр тушаалаар батлав.


**МОНГОЛ УЛС**  
**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН**  
**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**  
000195810

<u>2007.02.15</u> <i>/ Бүртгэсэн он, сар, өдөр /</i>	<u>9018001010</u> <i>/ Хувийн хэргийн дугаар /</i>	
	<u>2546442</u> <i>/ Регистрийн дугаар /</i>	
<u>БДО аудит</u> <i>/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /</i>	<u>Хязгаарлагдмал хариуцлагатай компани</u>	
<u>Дүрэм</u> <i>/ Үүсэн байгуулах баримт бичиг /</i>		
<u>Тогтоол</u> <i>/ Илгээгчийн нэр /</i>	<u>526</u> <i>/ Дугаар /</i>	<u>1997.06.26</u> <i>/ Он, сар, өдөр /</i>
<u>64990</u> <i>/ Код /</i>	<u>Аудитын үйл ажиллагаа эрхлэх/2018.12.26-2021.12.26/</u> <i>/ Үйл ажиллагааны чиглэл /</i>	
<u>Хугацаагүй</u> <i>/ хугацаа /</i>	<u>3</u> <i>/ гишүүдийн тоо /</i>	<u>10,000.00</u> <i>/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /</i>
<u>Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, нарны зам, юнион бюлдинг б блок 15-р давхар 1502 тоот,</u> <u>Утас1: 77404040, Утас2: , Факс: 77404041</u> <i>/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /</i>		
 <div style="border: 1px solid red; padding: 5px; display: inline-block;"> <p style="text-align: center;">Улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар Бүртгэсэн байгууллагын нэр / GOLONTAL INVESTMENT</p> </div>		
<b>Гэрчилгээ дахин олгосон 2019 он 12 сар 23 өдөр</b>		


Golontal  
Investment  
1119209111-5421569  
Улаанбаатар хот

Улаанбаатар хот  
1119211000-615804





Үнэт цаасны танилцуулга



Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Гомбо овогтой Баянмөнх-в Захирал-р томилсныг бүртгэв.	2007.02.15	Ж.Төмөрсүх
2	Дахин гэрчилгээ олгов.	2019.12.23	Ж.Нямдорж

Энэ гэрчилгээг хуурамчар үйлдсэн болхыг Монгол Улсын гүйцэтгэх захирлын хурал мэдэж, Удсан бүртгэлийн гэрчилгээг өсөөртэй болгохгүй.



\* 0 0 0 1 9 5 8 1 0 \*





СЭХ  
2021.09.13  
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-09-17

Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-02

Сангийн сайдын 2010 оны 19 дүгээр  
тушаалын 4 дүгээр хавсралт

САНГИЙН ЯАМ

**АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар 009-1997

"БДО Аудит" ХХК

2546442

Аж ахуйн нэгжийн нэр: .....  
Улсын бүртгэлийн дугаар: .....  
Аж ахуйн нэгжийн хаяг: .....  
Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: .....

Улаанбаатар хот, СБД, 6-р хороо, Централ тауэр, 1304 тоот

Сангийн сайдын 2012 оны 12 сарын 27-ны өдөр, тушаал № 287

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад томоолдлод бусад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

*Ч.Улаан*  
Ч.УЛААН  
УЛААНБААТАР ХОТ


САНГИЙН САЙД

Golden Capital  
1119209111-1119209111  
Улаанбаатар хот

УЛААНБААТАР ХОТ  
111723160910-0122094



Үнэт цаасны танилцуулга



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

Сангийн сайдын 20.15 оны 325 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20.15 оны 12-р сарын 27-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД

Б.БОЛОР



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

Сангийн сайдын 20.15 оны 32 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20 оны 12-р сарын 27-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД

Б.БОЛОР



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

Сангийн сайдын 2018 оны 288 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2018 оны 12-р сарын 27-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР



0000104












Үнэт цаасны танилцуулга



Харилцах дансны бүртгэл

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан тэмдэг
Худалдаа хөгжлийн банк	Төгрөгийн	470006252	Э.Эрдэнэбилэг
Худалдаа хөгжлийн банк	Валютын	470006253	Э.Эрдэнэбилэг

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Ганбаяр овогтой Батбаяр-а Захирал-р томилсныг бүртгэв	2013.06.18	Э.Эрдэнэбилэг
2	Дахин гэрчилгээ олгов	2014.03.10	У.Даваасүрэн
2	Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасвагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2016.08.26	М.Мангалжин
3	Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасвагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2017.08.08	Б.Гэрэлзул
4	Баяраа овогтой Баасандорж-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2019.11.20	Б.Алтансүх

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.





МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

“Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх тухай”

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 451 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Өмгөөллийн батбаяр энд партнэрс” ХХН-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Өмгөөллийн батбаяр энд партнэрс” ХХН /Г.Батбаяр/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.


ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000074





Үнэт цаасны танилцуулга

6.14 Хөндлөнгийн БОНЗ-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ГЭРЧИЛГЭЭ


Хууль зүйн сайдын 2016 оны  
А/204 дүгээр тушаалаар батлав.

**МОНГОЛ УЛС**  
**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН**  
**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**  
000208603

<u>2020.06.16</u> <i>/Бүртгэсэн он, сар, өдөр /</i>		<u>9011819109</u> <i>/Хуулийн хэргийн дугаар /</i>
		<u>6585167</u> <i>/Регистрийн дугаар /</i>
<u>Ризилиенс консалтинг сервис</u> <i>/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /</i>		<u>Хязгаарлагдмал хариуцлагатай компани</u> <i>/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /</i>
	<u>Дүрэм</u> <i>/Үүсэн байгуулах баримт бичиг /</i>	
<u>Шийдвэр</u> <i>/Шийдвэрийн нэр /</i>	<u>01</u> <i>/Дугаар /</i>	<u>2020.06.15</u> <i>/Он, сар, өдөр /</i>
<u>70200</u> <i>/Код /</i>	<u>Менеджментийн зөвлөгөө өгөх</u>	
<u>72200</u>	<u>Нийгмийн эдийн засгийн судалгаа хийх</u>	
<u>78200</u>	<u>Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх</u>	
	<i>/Үйл ажиллагааны чиглэл /</i>	
<u>Хугацаагүй</u> <i>/хугацаа /</i>	<u>3</u> <i>/ гишүүдийн тоо /</i>	<u>100.00</u> <i>/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /</i>
<u>Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, чингисийн өргөн чөлөө, 75, 44 тоот, Утас1- 99992073, Утас2- 88104587, Факс:</u> <i>/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /</i>		









Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Цэрэндорж овогтой Нямгаараа-а Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2020.06.16	У.Мандахтуяа







Үнэт цаасны танилцуулга

## 6.15 Хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагааг хэрэгжүүлэх гэрээ

### ХУВЬЦААНЫ ҮНИЙГ ТОГТВОРЖУУЛАХ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

Энэхүү Хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагааг хэрэгжүүлэх гэрээ (цаашид "Гэрээ" Гэх)-г 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Иргэний Хууль, Үнэт Цаасны Зах Зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржээс гаргасан тогтоол, журам, заавар болон бусад энэ төрлийн харилцааг зохицуулсан холбогдох эрх зүйн актуудыг үндэслэн,

Нэг талаас "СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС" ХХК-ийн хамгийн том хувьцаа эзэмшигч А.Ганхуяг (цаашид "Хувьцаа эзэмшигч" гэх);

Нөгөө талаас "ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК" ХХК (цаашид "Андеррайтер" гэх), түүнийг төлөөлөн Гүйцэтгэх захирал С.Ган-Эрдэнэ нар (цаашид талуудыг хамтад нь "Талууд", тусад нь "Тал" гэх) дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

#### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- A. Компани болон Андеррайтер нь 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Компанид өөрийн энгийн хувьцааг олон нийтэд анх удаа санал болгох, худалдах ажлыг Андеррайтер нь удирдан зохион байгуулах, зөвлөгөө өгөх, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татахад андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхээр Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ (цаашид "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ" гэх) байгуулсан болохыг энд ТЭМДЭГЛЭН;
- B. Талууд нь энэхүү Гэрээнд заасан нөхцөл болон журмын дагуу Компанийн гаргасан энгийн хувьцааг хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн хэт өндөр өсөлт, бууралтаас хамгаалах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтээс хувьцааг эргүүлэн худалдан авч хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагааг хэрэгжүүлэхээр тохиролцсон болохыг энд ТЭМДЭГЛЭН;

Иймд, Андеррайтер болон Хувьцаа эзэмшигч нь дор дурдсан зүйлийг харилцан тохиролцов.

#### 1. Үйлчлэх хүрээ

- 1.1 Энэхүү Гэрээ нь Компанийн Монголын Хөрөнгийн Бирж дээр анх удаа гаргаж байгаа хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжаанаас эргүүлэн худалдаж авах буюу хувьцааны үнийг тогтворжуулах үйл ажиллагаанд үйлчилнэ.
- 1.2 Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдаж авах харилцаанд энэхүү Гэрээ хамаарахгүй.

#### 2. Хувьцааг эргүүлэн худалдаж авах нөхцөл

- 2.1 Эргүүлэн худалдаж авах хувьцааны нийт хэмжээ нь Компанийн гаргасан нийт энгийн хувьцааны 5 (тав) хувиас хэтрэхгүй.
- 2.2 Эргүүлэн худалдаж авах хувьцааны төлбөрийг үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр гүйцэтгэнэ.
- 2.3 Үнэ тогтворжуулах үйл ажиллагааг нийт 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөгийн хүрээнд үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс нэг сарын хугацаанд хамгийн ихдээ 500,000,000 (таван зуун сая) төгрөг хүртэл үнийн дүн бүхий хувьцааг худалдан авна. Цаашид, Талууд харилцан зөвшилцөх замаар үнэ тогтворжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 2.4 Андеррайтер нь хувьцааны үнийг тогтворжуулах арга хэмжээг туслах андеррайтер, эсхүл зах зээл үүсгэгчээр оролцох сонирхол бүхий бусад үнэт цаасны компанитай хамтран хэрэгжүүлж болно.



- 2.5 Андеррайтер нь хувьцааны үнийг тогтворжуулах арга хэмжээний хүрээнд хувьцаа эзэмшигчтэй арилжаа хийх тохиолдолд өөрийн брокероор дамжуулан арилжааг гүйцэтгэх бөгөөд, ингэхдээ брокерын хураамжийг 1%-иас хэтрүүлэхгүй байхаар тохиролцов.
- 2.6 Андеррайтер нь үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийн хэт өндөр өсөлт, бууралтаас хамгаалах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хувьцаа худалдан авах, зарах ажиллагааг гүйцэтгэж, эрэлт нийлүүлэлтийн зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөнө.
- 2.7 Хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааг дараах хязгаарлалтын хүрээнд явуулна:
- 2.7.1 Эргүүлэн худалдан авах нэгж хувьцааны дээд үнэ нь өмнөх 15 хоногийн Монголын Хөрөнгийн биржийн арилжааны жигнэсэн дундаж ханшийн 105 (нэг зуун тав) хувиас хэтрэхгүй;
- 2.7.2 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий багц арилжааны хэлцлийн ханш нь өмнөх 15 хоногийн Монголын Хөрөнгийн биржийн арилжааны жигнэсэн дундаж ханшийн 105 (нэг зуун тав) хувиас хэтрэхгүй.
- 2.7.3 Хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагаанаас гарах зардлыг Компанийн нийтээс татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгөнөөс суутган тооцохгүй.
- 2.7.4 Хувьцааны үнэ тогтворжуулах нэрийн дор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасан хэлбэрээр зах зээлийг урвуулан ашиглахыг хориглоно.


### 3. Талуудын эрх, үүрэг

- 3.1 Хувьцаа эзэмшигч нь дараах бүрэн эрхтэй:
- 3.1.1 Хувьцааны үнэ тогтворжуулах үйл ажиллагааг энэхүү Гэрээний 2.3 дахь хэсэгт заасны дагуу үе шаттайгаар хэрэгжүүлэхийг Андеррайтераас шаардах;
- 3.1.2 Хувьцааг эргүүлэн худалдаж авах асуудлаар хяналт тавих, асуулт тавих, зөвлөмж гаргах, болон
- 3.1.3 Бусад холбогдох хууль тогтоомж, журамд заасан эрх.
- 3.2 Андеррайтер хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой дараах бүрэн эрхтэй:
- 3.2.1 Хувьцааг эргүүлэн худалдаж авах ажиллагааг Компаниас олгосон бүрэн эрх хэмжээ болон Компаниас баталсан холбогдох журам болон энэхүү Гэрээнд заасан нөхцөл болзлын хүрээнд удирдан зохион байгуулах;
- 3.2.2 Хувьцаа эзэмшигчээс Хувьцааны үнэ тогтворжуулах үйл ажиллагааг энэхүү Гэрээний 2.3 дахь хэсэгт заасны дагуу үе шаттайгаар хэрэгжүүлэхийг шаардах;
- 3.2.3 Хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой аливаа гэрээ хэлцэл байгуулах;
- 3.2.4 Хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой мэдээллийг олон нийтэд болон эрх бүхий этгээдэд мэдэгдэх, мэдээлэх, Компанийн хувьцаа эзэмшигчдэд заавар, зөвлөгөө өгөх, эргүүлэн худалдаж авсан хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасуулах, үнэт цаасны бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулахтай холбоотой ажлыг тухай бүр зохион байгуулах.
- 3.3 Андеррайтер хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой дараах үүрэгтэй байна:
- 3.3.1 Энэхүү Гэрээний хэрэгжилт, эргүүлэн худалдаж авсан хувьцааны талаарх мэдээллийг тухай бүр Хувьцаа эзэмшигч болон Компанид тайлагнах;
- 3.3.2 Хувьцааг эргүүлэн худалдаж авах ажиллагаанд аливаа ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх;
- 3.3.3 Холбогдох хууль тогтоомж, журамд заасан бусад үүрэг.

### 4. Гэрээний хугацаа

- 4.1 Энэхүү Гэрээ нь батлагдсан өдрөөсөө хучин төгөлдөр болох бөгөөд Хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хугацаанд үргэлжилнэ.

### 5. Бусад зүйл



Үнэт цаасны танилцуулга

- 5.1 Дагаж мөрдөх хууль: Энэхүү Гэрээг Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу тайлбарлаж зохицуулна.
- 5.2 Энэхүү гэрээнд заагаагүй бусад асуудлыг холбогдох Монгол Улсын хууль тогтоомж болон "Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХХК-ийн дүрэм, Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам", "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам", Монголын Хөрөнгийн Биржийн "Арилжавны журам", "Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХХК-ийн хувьцааны үнийг тогтворжуулах талаар баталсан журмын дагуу тайлбарлаж зохицуулна.
- 5.3 Нэмэлт өөрчлөлт: Талууд харилцан тохиролцож энэ Гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 5.4 Маргаан шийдвэрлэх: Талууд нь энэхүү Гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхээс өмнө харилцан зөвшилцсөний үндсэн дээр эв зүйгээр шийдвэрлэхэд хүчин чармайлт гаргана. Маргааныг дээрх байдлаар шийдвэрлэх боломжгүй бол тухайн маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 5.5 Гэрээний хувь: Гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж Тал тус бүр нэг нэг хувийг хадгална.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

А.ГАНХУЯГ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК  
ХХК-ийг төлөөлж:  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
С.ГАН-ЭРДЭНЭ





## 6.16 Хуулийн дүгнэлт



Үнэт цаасны танилцуулга

Нүүц баримт  
Эх хувь



**ӨМГӨӨЛЛИЙН  
БАТБАЯР ЭНД  
ПАРТНЭРС ХХН**

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө - 15, Монгол ТВ цэцэг, 10-р давхар, 1001-1003 тоот, Утас/Факс: (+976) 7711 9008, Цахим илүүдэн: [contact@bnp.mn](mailto:contact@bnp.mn), Веб: [www.bnp.mn](http://www.bnp.mn)

**СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Г.ЧИНЗОРИГ ТАНАА**

Огноо: 2021.07.29  
Дугаар: BNP-111/21  
Утга: Хуулийн дүгнэлт




**СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК-ИЙН НИЙТЭД САНАЛ БОЛГОН  
АНХ УДАА ГАРГАЖ БҮЙ ХУВЬЦААГ НИЙТЭД САНАЛ БОЛГОХЫГ  
ЗӨВШӨӨРСӨН ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХТЭЙ  
ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН ХУУЛИЙН ДҮГНЭЛТ**

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН (цаашид "Хуулийн фирм" гэх) нь танай компанитай 2021 оны 04 сарын 30-ны өдөр байгуулсан №CVS-2021/0165 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК (цаашид "Үнэт цаас гаргагч" эсхүл "Компани" гэх)-ийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах хөндлөнгийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэх, улмаар хуулийн дүгнэлт гаргах ажлыг хийхээр тохиролцсон. Уг ажилтай холбогдуулан Хуулийн фирмийн зүгээс Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК (цаашид "Монголын хөрөнгийн бирж" гэх)-аас баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заасан асуудлын хүрээнд Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн үйл ажиллагаанд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, хуулийн дүгнэлт (цаашид "Хуулийн дүгнэлт" гэх)-ийг бэлтгэж үүгээр хүргүүлж байна. Хүлээн авна үү.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК, түүний эрх бүхий албан тушаалтан болон төрийн эрх бүхий гуравдагч этгээдээс бусад этгээдийн хувьд нүүц материалд тооцогдоно. Зөвшөөрөл аваагүй этгээд болон бусад эрх олгогдсон этгээд аливаа хэлбэрээр энэхүү нүүц материалд агуулагдсан мэдээ, мэдээллийг хэсэгчлэн болон бүтнээр нь бусдад дамжуулсан, цааш түгээсэн, түгээх нөхцөл боломжийг бүрдүүлсэн, задруулсан бол үүссэн үр дагаврыг бүрэн хариуцахыг анхаарна үү.

Тус Хуулийн фирм нь энэхүү Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас анх удаа нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх үйл ажиллагаанд оролцож байгаа андеррайтерийн компани болох тэргүүлэх андеррайтер Голомт Капитал ҮЦК ХХК, дэд андеррайтер Алсекс капитал ҮЦК ХХК, үнэлгээний компани болох Гэрэгэ эстимэйт ХХК болон Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, холбоотой этгээдүүдтэй аливаа байдлаар харилцан хамааралгүй бөгөөд ашиг сонирхлын хувьд холбоогүй болохыг үүгээр мэдэгдэж байна.



Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө - 15, Монгол ТВ цэцэг, 10-р давхар, 1001-1003 тоот, Утас/Факс: (+976) 7711 9008, Цахим илүүдэн: [contact@bnp.mn](mailto:contact@bnp.mn), Веб: [www.bnp.mn](http://www.bnp.mn)



Хуулийн дүгнэлт гаргах үндэслэл, ажлын даалгавар

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэх, Компанийн хэлбэрийг өөрчлөн нээлттэй хувьцаат компани болгож байгаатай холбогдуулан Хуулийн фирм нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт “Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг ... хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр, ... тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна”, 10.7 дахь хэсэгт “... хууль зүйн дүгнэлт нь тухайн үнэт цаасны танилцуулгын салшгүй хэсэг байна” болон Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны №408 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2 дахь заалт, Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №2018/01 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн дараах асуудлуудыг Үнэт цаас гаргагч үйл ажиллагаандаа мөрдөж, хангаж буй эсэхэд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, Хуулийн дүгнэлт гаргаж өгөхөөр тохиролцсон. Үүнд:

- (i) Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх болон улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх;
- (ii) Компанийн дүрэм, үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгон гаргаж байгаа компанийн хувьд хувьцаат компанийн дүрмийн төсөл, бусад дотоод журмууд нь холбогдох хууль тогтоомж, “Компанийн засаглалын кодекс”-т нийцсэн эсэх;
- (iii) Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-т заасан шаардлага хангасан эсэх болон гэмт хэрэгт холбогдож байсан эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага түршлагын байдал;
- (iv) Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ, контракт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх;
- (v) Сүүлийн 3 жил дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;
- (vi) Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой, сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл, үр дагавар буй эсэх;
- (vii) Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх;
- (viii) Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх;
- (ix) Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийг тодорхойлох.

Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээгээр хүлээсэн Ажлын даалгаварт багтсанаас бусад асуудлаар Хуулийн фирм хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлээгүй болно.

Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргаж байгаа хувьцааны тухай


Компанийн тухай хуулийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа зохицуулалт болон Компанийн дүрмээс үзвэл<sup>1</sup> компанийг хэлбэрийг өөрчлөх замаар өөрчлөн байгуулах, хувьцаа

<sup>1</sup> Компанийн тухай хууль (2011).

31 дүгээр зүйл. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх

31.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай бүрд компанийн дүрэмд өөрчлөлт оруулна.





Нүүц баримт  
Эх хувь

нэмж гаргах замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн дагуу шийдвэрлэх зохицуулалттай байна.

Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 07 сарын 26-ны өдрийн №6 тоот "Компанийн хэлбэрийг өөрчлөх замаар өөрчлөн байгуулах болон нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах тухай" шийдвэрээр Компанийн "CU" сүлжээ дэлгүүрийн цаашдын санхүүжилтийг хангах зорилгоор тус Компанийн хэлбэрийг өөрчилж хувьцаат компани болгох замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрч, нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэт бүхий 169,951,919 (нэг зуун жаран есөн сая есөн зуун тавин нэгэн мянга есөн зуун арван есөн) ширхэг хувьцаа нэмж гаргахаар шийдвэрлэж, Компанийн нийт зарласан хувьцаанаас нийтэд санал болгон гаргах эрхийг төлөөлөн удирдах зөвлөлд олгож шийдвэрлэсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн хувьд Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт "энэ хууль болон компанийн дүрэмд зааснаас дээгүүр хувь тогтоогоогүй, эсхүл хуульд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол гүйцэтгэх удирдлага)-ийн гишүүдийг сонгохоос бусад асуудлаар гаргах шийдвэр хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар хүчин төгөлдөр болно, 63.7 дахь хэсэгт "энэ хуулийн 62.1.1-62.1.6-д заасан асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ" гэж тус тус заасан байна. Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэгт "Дүрмийн 9.5.1-9.5.6 дугаар зүйлд заасан асуудлыг тухайн хурлаар санал өгөх эрх бүхий хувьцааны 2/3 (гуравны хоёр)-оос багагүй хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид биечлэн эсхүл төлөөлөгчөөр дамжуулан баталснаар хүчин төгөлдөр болно. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж байгаа бусад асуудлыг хуралд саналын эрхтэй оролцож байгаа гишүүдийн саналын олонхоор шийдвэрлэнэ", 9.8 дахь хэсэгт "Хувьцаа эзэмшигчид биечлэн оролцохгүйгээр электрон шуудангаар хэлэлцэх асуудлын тухай мэдээлэл, тогтоолын төслийг хүргүүлж санал солилцсоныг үндэслэн хувьцаа эзэмшигчийн тогтоол, шийдвэр гаргаж болно. Хувьцаа эзэмшигчийн тогтоолын төслийг бүх хувьцаа эзэмшигчдэд хүргүүлж зөвшөөрсөн буюу татгалзсаныг баталгаажуулж гарын үсэг зурүүлснаар хүчин төгөлдөрт тооцогдоно", 9.7 дахь хэсэгт "Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хэлэлцсэн асуудал бүрээр гаргасан шийдвэрийг тогтоол хэлбэрээр баталгаажуулж, тухайн асуудлыг хэлэлцсэн хурлын тэмдэглэлийн хамт Компанийн архивд хадгална" гэж хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох нөхцөл, саналын тоо, хэмжээг зохицуулсан. Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 07 сарын 26-ны өдрийн №6 тоот шийдвэрээс үзвэл Компанийн нийт гаргасан 679,807,674 (зургаан зуун далан есөн сая найман зуун долоон мянга зургаан зуун далан дөрвөн) ширхэг энгийн хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн 100 (зуун) хувийн саналаар шийдвэрлэсэн байх тул хувьцаа эзэмшигчдийн шийдвэр нь хүчин төгөлдөр бөгөөд Компанийн эрх барих дээд байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэр байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

31 дүгээр зүйл. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх

31.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай бүрд компанийн дүрэмд өөрчлөлт оруулна.

31.2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн дор дурдсан хэлбэрээр өөрчилж болно:

- 31.2.1. нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх, эсхүл бүүрүүлэх;
- 31.2.2 хувьцаа нэмж гаргах замаар өсгөх;
- 31.2.3 өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар бүүрүүлэх.

62 дугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх

62.1. Дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

- 62.1.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
- 62.1.2. нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
- 62.1.3. компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
- 62.1.4. компанийн хэлбэрийг өөрчлөх;


Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн дүрэм (2021.06.08).

Ес. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх

9.5. Дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. Үүнд:

- 9.5.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
- 9.5.2. нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
- 9.5.3. компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
- 9.5.4. компанийн хэлбэрийг өөрчлөх.





Нууц баримт  
Эх хувь

Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах шийдвэрийн хувьд Компанийн тухай хуулийн холбогдох зохицуулалтын дагуу компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргах зохицуулалттай байна<sup>2</sup>. Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн дүрмийн холбогдох зохицуулалтаас үзвэл Компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.5.1 дэх заалтад үнэт цаасыг гаргах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгож зохицуулсан. Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 07 сарын 26-ны өдрийн №6 тоот "Компанийн хэлбэрийг өөрчлөх замаар өөрчлөн байгуулах болон нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах тухай" шийдвэрээр Компанийн зарласан хувьцаанаас эргэлтэд гарган нийтэд санал болгох энгийн хувьцааны тоо, үнийг мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр тогтоож, Монголын хөрөнгийн биржийн анхдагч зах зээлийн арилжаагаар санал болгох эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгож шийдсэн байна. Энэхүү шийдвэрт үндэслэн Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2021 оны 07 сарын 26-ны өдрийн №11 тоот "Хувьцаа нэмж гаргах болон нийтэд санал болгох хувьцааны үнэ тогтоох тухай" тогтоолын дагуу Компанийн зарласан хувьцаанаас 75,534,186 (далан таван сая таван зүүн гучин дөрвөн мянга нэг зүүн наян зургаан) ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгон анх удаа эргэлтэд гарган Монголын хөрөнгийн биржийн анхдагч зах зээлийн арилжаагаар санал болгох, нийтэд санал болгох энгийн хувьцааны үнийг 208 (хоёр зуун найман) төгрөгөөр, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 09 сарын 09-ний өдрийн №151021-13 тоот "Компанийн нийтэд санал болгон анх удаа гаргах хувьцааны тоог шинэчлэн тогтоох тухай" тогтоолын дагуу Компанийн зарласан хувьцаанаас нийтэд санал болгон гаргах 75,534,186 (далан таван сая таван зүүн гучин дөрвөн мянга нэг зүүн наян зургаан) ширхэг энгийн хувьцааг 44,431,874 (дөчин дөрвөн сая дөрвөн зүүн гучин нэгэн мянга найман зүүн далан дөрвөн) ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн нийт 119,966,060 (нэг зүүн арван есөн сая есөн зүүн жаран зургаан мянга жара) ширхэг энгийн хувьцаа буюу хувьцааг нэмж гаргасны дараах байдлаар Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 15 хувьтай тэнцэх хувьцааг нийтэд санал болгон анх удаа эргэлтэд гарган Монголын хөрөнгийн биржийн анхдагч зах зээлийн арилжаагаар санал болгох, нийтэд санал болгох хувьцааны үнийг 208 (хоёр зуун найман) төгрөгөөр тогтоож шийдвэрлэсэн байна. (2021.09.10-ны өдөр шинэчлэв).

Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага хувьцаа эзэмшигчид болон төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан эдгээр шийдвэр, тогтоол нь Компанийн тухай хуульд болон Компанийн дүрэмд нийцсэн, хуульд заасан шаардлагыг хангасан, Компанийн эрх барих дээд байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэр байна гэж Хуулийн фирм үзлээ.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22 дахь заалтад "нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл" гэж энэ хуульд заасан журмын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлийг хэлнэ" гэж заасан байх бөгөөд мөн зүйлийн 4.1.21 дэх хэсэгт "нийтэд санал болгох" гэж Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу үнэт цаасаа 50-аас дээш тооны этгээдэд санал болгон худалдахаар мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдэгдэхийг хэлнэ гэж заасан байна. Эдгээр хуулийн зохицуулалтын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах замаар компанийн хэлбэрийг өөрчлөн нээлттэй хувьцаат компани болохыг зөвшөөрсөн тохиолдолд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хэлбэр өөрчлөгдөн хувьцаат компани болж Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК болон түүний хувьцаа эзэмшигчид үнэт цаасаа нийтэд чөлөөтэй арилжих, арилжихыг санал болгох эрхтэй гэж Хуулийн фирмээс үзсэн.

<sup>2</sup> Компанийн тухай хууль (2011 он).

42 дугаар зүйл. Үнэт цаас гаргах тухай шийдвэр

42.1. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хүргэлт/ гаргах бөгөөд уг шийдвэрт үнэт цаасны төрөл, тоо, гаргах хугацаа, нөхцөлийг заана.

42.2. Компани зарласан энгийн хувьцааг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь гаргах үүрэгтэй.


42.3. Компани давуу эрхийн хувьцааг зарласан хэмжээгээр нь, эсхүл зарим хэсгийг нь гаргаж болохоос гадна тодорхой хугацаанд гаргахгүй байж болно.

42.4. Компани нийтэд худалдахаар гаргаж байгаа үнэт цаас болон хувьцаат компанийн нэмж гаргаж байгаа хувьцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлнэ.





Нууц баримт  
Эх хувь



Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргасан хувьцааг үнэт цаасны бүртгэл болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэхийг зөвшөөрсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж, Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж баталж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг Хуулийн фирмээс зөвлөж байна.

**Товчилсон үгсийн товьёг**

Хуулийн дүгнэлт гаргахад ашигласан товчилсон үгсийг дараах үтгээр ойлгож хэрэглэнэ үү.

Үүнд:

*Үгсийн дарааллаар:*

БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
КТХ	Компанийн тухай хууль
ИХ	Иргэний хууль (2002)
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХН	Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл

**Дүн шинжилгээ хийсэн арга, аргачлал**

Энэхүү дүн шинжилгээг хийж гүйцэтгэхдээ Үнэт цаас гаргагчтай Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээгээр тохиролцсон асуудлын хүрээнд Үнэт цаас гаргагчийн гаргаж өгсөн баримт материалд үндэслэх зарчмыг баримталсан болно.

Дүн шинжилгээг хийхдээ хараат бус байх зарчмыг баримталсан бөгөөд Хуулийн дүгнэлт гаргахад ашиглах эх сурвалжийг сонгохдоо хөндлөнгийн гуравдагч этгээдээс олгосон/тодорхойлсон лавлагаа, тодорхойлолт, баримт бичиг болон гуравдагч этгээдтэй байгуулсан, солилцсон зэргээр Үнэт цаас гаргагчаас хараат бусаар баталгаажсан үйл баримтад үндэслэгдсэн байхыг удирдлага болгож ажилласан.

Хууль тогтоомжоор тодорхойлсон төрийн эрх бүхий байгууллагын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон гадаад улсын хуулийг хэрэглэх асуудлаар Хуулийн фирм дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргаагүй бөгөөд холбогдох лавлагаа, тодорхойлолтыг гаргуулан авч дүн шинжилгээндээ ашигласан болохыг тусгайлан анхаарч Хуулийн дүгнэлтэд дурдагдаагүй асуудлаар Үнэт цаас гаргагчаас, лавлагаа тодруулга бүхий албан бичигт дурдагдсан асуудлаар тухайн шатны төрийн эрх бүхий байгууллагаас тодруулж лавлана үү.

Хууль тогтоомжид тусгагдсан хэм хэмжээ, заалт, нөхцөл, журмыг тодорхойлж ойлгохдоо хууль зүйн ач холбогдол бүхий үг, үгс, үтгыг Улсын Дээд шүүхийн гаргасан албан ёсны тайлбар, түүнд тодорхойлсон үтгын дагуу, хэрэв тухайн нөхцөлд хэрэглэх албан ёсны тайлбар, практик байхгүй нөхцөлд хууль зүйн шинжлэх ухаанд түгээмэл тогтсон утга агуулгыг ашигласан бөгөөд ердийн хэрэглээний оноосон нэрийг тухайн үгийн хэлзүйн шууд утга агуулгаар ойлгон, ашиглаж тайлбарласан.

Үнэт цаас гаргагчийн шилжүүлэн өгсөн цаасан болон электрон хэлбэртэй баримт бичигт агуулагдаж байгаа эх болон хуулбар баримт материал, тэдгээрт агуулагдаж байгаа мэдээлэл, хөндлөнгийн эрх бүхий байгууллагын гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолт, баримт бичиг, түүнд агуулагдсан мэдээ, мэдээлэл, баримт, үйл баримтыг үнэн, зөв, хууль ёсны, хүчин төгөлдөр гэж үзэж ашигласан.


Хөндлөнгийн эрх бүхий байгууллагуудаас гаргуулан авсан лавлагаа, тодорхойлолт нь үнэн зөв бөгөөд дурдагдсан үйл баримт нь Хуулийн дүгнэлт гаргах өдрийг хүртэл хугацаанд хэвээр хадгалагдаж байгаа гэж үзсэн.







Үнэт цаасны танилцуулга



Нууц баримт  
Эх хувь

Хуулийн фирм нь төрийн эрх бүхий байгууллагаас гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолтод тусгагдсан оноосон нэр томъёонууд харилцан адилгүй тусгагдсан байсныг нэг ижил формат, стандартад оруулж илэрхийлсэн болно.

Хуулийн дүгнэлтэд дурдсан хуулийн этгээдүүдийн оноосон нэрийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн оноосон нэрээр, төрийн эрх бүхий байгууллагуудын нэрийг тухайн лавлагаа, тодорхойлолт, албан бичигт ашиглагдсан оноосон нэрээр ашиглаж хэрэглэсэн болно.

Энэхүү Хуулийн дүгнэлтийг Монгол Улсын хууль тогтоомж, хэм хэмжээний актаар тогтоосон нөхцөл, журмын хүрээнд бэлтгэсэн.

#### Хуулийн фирмийн мэдэгдэл

Хуулийн фирм нь дүн шинжилгээг Үнэт цаас гаргагчийн хүлээлгэн өгсөн баримт бичиг, материал, тэдгээрт агуулагдсан баримтат мэдээллийн хүрээнд хийж гүйцэтгэсэн бөгөөд Үнэт цаас гаргагчаас үнэн зөв, бүрэн мэдээлэл өгсөн, холбогдох шилжүүлж өгсөн баримт бичгүүд нь үнэн зөв, хүчин төгөлдөр, жинхэнэ эх эсхүл жинхэнэ эхээс хуулбарлагдсан гэж үзэж, ашигласан болно.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь хөндлөнгийн дүн шинжилгээ хийсэн баримт бичиг бөгөөд Үнэт цаас гаргагч, түүнээс хүлээн авсан бусад этгээдийн хувьд заавал дагаж мөрдөх, мөрдөхийг шаардах эрх, үүрэг, хариуцлага үүсгэхгүй, хууль зүйн туслалцаа, зөвлөгөө үзүүлсэнд тооцогдохгүй.

Хуулийн фирм нь Гэрээгээр хүлээсэн ажлын даалгаварт тусгагдсанаас бусдаар Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувьцаа нэмж гаргах, өрийг хувьцаагаар солих зэрэг хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт, хувьцаа эзэмшигчдийн бүтцийн өөрчлөлттэй холбоотой өмнөх асуудлаар тусгайлан дүн шинжилгээ болохыг анхаарна уу.

Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн өмнөх хувьцаа эзэмшигч Премиум Групп ХХК-аас Үнэт цаас гаргагчтай холбоотойгоор тухайн үед гаргасан тогтоол, шийдвэрийн хувьд холбогдох тогтоол, шийдвэрийн огноонд үндэслэн Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувьцаа эзэмшигч Премиум Групп ХХК гэж хуулийн дүгнэлтэд дурдсан болно.

Хуулийн дүгнэлтийг зөвхөн энд дурдагдсан зорилгоор хийж гүйцэтгэсэн бөгөөд Үнэт цаас гаргагч нь өөр бусад зорилгоор ашиглах, хэсэгчлэн болон бүхлээр нь нийтэд дэлгэх, түгээх болон Хуулийн фирмийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахыг хориглоно.

Хуулийн дүгнэлтэд ашигласан баримт бичиг, тэдгээрт агуулагдсан мэдээлэлд Хуулийн дүгнэлт гаргасан өдрөөс хойш аливаа өөрчлөлт орсон бол Хуулийн фирм хариуцлага хүлээхгүй.

Хуулийн фирм нь илэрхий үг үсэг, утга найруулгын зөрүүнээс бусдаар Үнэт цаас гаргагчийн шилжүүлж өгсөн баримт бичгийн материалд агуулагдаж байгаа дараах асуудлыг үнэн зөв гэж үзэж дүгнэлт гаргасан болно. Үүнд:


- Баримт бичигт агуулагдсан хүсэл зориг, гол санаа, дурдсан/дурдагдсан асуудал нь үндэслэлтэй, үнэн зөв, хууль ёсны дагуу илэрхийлэгдсэн, хүчин төгөлдөр;
- Баримт бичгүүд нь цаг хугацаандаа үйлдэгдсэн, үнэн, зөв, бүрэн, гарын үсэг зурсан этгээд нь хуулийн дагуу албан ёсоор төлөөлөх эрхтэй;
- Хуулийн дүгнэлт гаргах иш үндэслэл болсон баримт материалд дурдагдсан нөхцөл байдал нь Хуулийн дүгнэлт гаргаснаас хойш эсхүл тухайн баримт бичгийг үйлдсэн огноо, хугацаанаас хойш өөрчлөгдөөгүй бөгөөд аливаа байдлаар талуудын эрх ашигт сөргөөр нөлөөлөх үйл явдал үүсээгүй;
- Аливаа дарагдсан тэмдэг (тамга) нь үнэн, зөв, жинхэнэ, эрх бүхий ашиглах эрхтэй этгээдийн зөвшөөрлөөр дарагдсан.

**Энэхүү Хуулийн дүгнэлт нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасанд гаргасан аливаа төрлийн амлалт, баталгаанд тооцогдохгүй болохыг анхаарна уу.**





Нууц баримт  
Эх хувь



Үнэт цаас гаргагчийн бичгээр тавьсан хүсэлтийг үндэслэн Хуулийн фирм нь шаардлагатай гэж үзвэл Хуулийн дүгнэлтийн талаар гуравдагч этгээдэд нэмэлт тайлбар, тодруулга өгөх боломжтой болохыг дурдаж байна. Хуулийн фирмийн зүгээс өгөх нэмэлт тайлбар, тодруулга нь Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргасан ажлын даалгаварт тусгаснаас бусад асуудлаар нэмэлт дүн шинжилгээ хийх, тайлбар өгөх үүрэг үүсгэхгүй болно.

Хуулийн фирм нь дүн шинжилгээ хийхэд ашиглагдсан лавлагаа, тодорхойлолт, Үнэт цаас гаргагчийн гаргаж өгсөн аливаа баримт, материалд дурдагдсан үйл баримт, нөхцөл байдал Хуулийн фирмд мэдэгдэлгүйгээр өөрчлөгдсөн аливаа асуудлаар хариуцлага хүлээхгүй.

Энэхүү Хуулийн дүгнэлтийг Монгол Улсын хууль тогтоомж, хэм хэмжээний актаар тогтоосон нөхцөл, журмын хүрээнд бэлтгэсэн бөгөөд гадаад улсын хууль тогтоомж, хэм хэмжээг тайлбарлах, хэрэглэх, ашиглахтай холбоотой асуудал багтаагүй болохыг илэрхийлж байна.

#### Хууль тогтоомж, хэм хэмжээний акт

Хуулийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэхдээ энэхүү Хуулийн дүгнэлтийг бэлтгэж өгөх өдрийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, тэдгээрийг дагалдаж батлагдсан холбогдох хэм хэмжээний актуудыг үндэслэл болгон бэлтгэсэн.

#### Дүн шинжилгээ, дүгнэлт

Хуулийн фирм нь дүн шинжилгээ хийхэд шаардлагатай хөндлөнгийн лавлагаа, тодорхойлолтыг эрх бүхий байгууллагуудаас гаргуулан авч, Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн баримт материал, тэдгээрт агуулагдсан мэдээлэлд дүн шинжилгээ хийгээд дараах байдлаар дүгнэж үзэх үндэслэлтэй гэж үзлээ.

Нэн тэргүүнд Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн эрх зүйн байдал, хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгийн талаар тодруулж авч үзлээ.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 06 сарын 08-ны өдрийн №04 тоот шийдвэрээр дүрмийн нэмэлт өөрчлөлтийг баталсан байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн гарын үсэг зурагдсан, тамга тэмдэг дарагдсан бөгөөд дүрмийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2021 оны 06 сарын 11-ний өдөр бүртгэгдсэн байх тул Хуулийн фирмийн зүгээс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрэм ("Дүрэм") гэж үзэж энэхүү Хуулийн дүгнэлтийг бэлтгэлээ.

Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт "Компани нь Компанийн тухай хуулийн дагуу зохион байгуулагдсан бие даасан тайлан тэнцэлтэй, банканд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх хуулийн этгээд байна. Компанийн хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж түүнийг захиран зарцуулах эрх нь энэ Дүрэм болон Компанийн тухай хуулиар хязгаарлагдах хязгаарлагдмал хариуцлагатай компани<sup>1</sup> хэлбэрээр ажиллана" гэж Компани өөрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон байна.

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид, хувь нийлүүлсэн хөрөнгийн хувьд Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 67,980,767,400 (жаран

<sup>1</sup> Компанийн тухай хууль (2011).

3 дугаар зүйл.Компани, түүний хэлбэр

3.1.Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ.


3.2.Хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд харин компанийн эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

3.3 Хувьцаа эзэмшигчийн эрхийг энэ хууль болон компанийн дүрмээр тогтоох бөгөөд хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж байгаа асуудлаар санал өгөх, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг үндсэн эрх эдэлнэ.


3.4.Компани нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани гэсэн хэлбэртэй байна.

3.5.Хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь хууль болон компанийн дүрмээр хязгаарлагддаг компанийг хэлнэ.





Үнэт цаасны танилцуулга



Нууц баримт  
Эх хувь

долоон тэрбум есөн зуун наян сая долоон зуун жаран долоон мянга дөрвөн зуун) төгрөг байна”, 5.2 дахь хэсэгт “Компанийн гаргасан энгийн хувьцааны тоо 679,807,674 (зургаан зуун далан есөн сая найман зуун долоон мянга зургаан зуун далан дөрвөн) ширхэг энгийн хувьцаатай байна”, 5.3 дахь хэсэгт “нэгж энгийн хувьцааны нэрлэсэн үнэ 100 (нэг зуун) төгрөг байна” гэж тусгасан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2021 оны 06 сарын 23-ны өдрийн №08398 тоот дэлгэрэнгүй лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 679,807,674 (зургаан зуун далан есөн сая найман зуун долоон мянга зургаан зуун далан дөрвөн) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 67,980,767,400 (жаран долоон тэрбум есөн зуун наян сая долоон зуун жаран долоон мянга дөрвөн зуун) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бөгөөд 9 (есөн) хувьцаа эзэмшигчтэй хязгаарлагдмал хариуцлагатай компани болохыг тодорхойлсон байна.

Иймд Компанийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй Дүрэм болон улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаанд тусгагдсан мэдээлэлд үндэслэн энэхүү Хуулийн дүгнэлтийг бэлтгэсэн болохыг дурдаж байна.

Нэг. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх, Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх асуудлаар:

Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь үүсгэн байгуулагчийн 2017 оны 02 сарын 16-ны өдрийн №17/01 тоот шийдвэрээр “Централ экспресс” төслийг тусдаа бие даасан аж ахуйн нэгж болгож, үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Премиум Групп ХХК-ийн зуун хувийн хөрөнгө оруулалттай, “Сэнтрал Экспресс Си Ви Эс” оноосон нэртэй, 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,000 (нэг мянган) ширхэг хувьцаатай, 100,000 (нэг зуун мянган) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хүнсний дэлгүүр (4721), худалдааны зүүчлал (4799)-ын үйл ажиллагаа эрхлэх чиглэлтэйгээр хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнээс үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь улсын бүртгэлийн №9011651142 тоот дугаартай, регистрийн №6155804 тоот дугаартай, үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл хүнсний дэлгүүр (4721) болон туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл худалдааны зүүчлал (4799)-ын үйл ажиллагаа эрхлэхээр, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр 2017 оны 02 сарын 22-ны өдөр улсын бүртгэлийн байгууллагад бүртгэгдсэн байна. КТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг<sup>4</sup> заасан компани байгуулах тухай шийдвэр гарснаас хойш 30 (гуч) хоногийн дотор компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох баримт бичгийг бүртгэх байгууллагад өгч бүртгүүлэх тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу улсын бүртгэлд бүртгэгдсэн байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Компанийн тухай хуулийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа зохицуулалтаас үзвэл<sup>5</sup> хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг компанийн дүрэмд тусгах хуулийн зохицуулалттай байдаг. Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь нэмж хувьцаа гаргах

<sup>4</sup> Компанийн тухай хууль (2011).  
15 дугаар зүйл. Компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх  
15.1.Компани байгуулах тухай шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох баримт бичгийг бүртгэх байгууллагад өгнө.  
<sup>5</sup> Компанийн тухай хууль (2011).  
31 дүгээр зүйл.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх  
31.2.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн дор дурдсан хэлбэрээр өөрчилж болно:  
31.2.1 нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх, эсхүл бууруулах;  
31.2.2 хувьцаа нэмж гаргах замаар өсгөх;  
31.2.3 өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар бууруулах.





Нүүд баримт  
Эх хувь

МОНГОЛЫН ХӨРӨНГӨЙН БИРЖ  
MONGOLIAN FOREIGN EXCHANGE

2021-09-17  
Үнэт цаасны танилцуулга  
БҮРТГЭВ-02

замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг дараах үе шаттай нэмэгдүүлж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байна. Үүнд:

- Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувьцаа эзэмшигч Премиум Групп ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 02 сарын 24-ний өдрийн №17/02 тоот шийдвэрээр дэлгүүрт оруулсан хөрөнгийн зах зээлийн үнэ буюу 5,273,270 (таван сая хоёр зуун далан гурван мянга хоёр зуун далан) төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,274,270 (таван сая хоёр зуун далан дөрвөн мянга хоёр зуун далан) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 527,427,000 (таван зуун хорин долоон сая дөрвөн зуун хорин долоон мянган) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болсныг хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2017 оны 03 сарын 16-ны өдөр бүртгэгдсэн;
- Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувьцаа эзэмшигч Премиум Групп ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 04 сарын 04-ний өдрийн №18/1806 тоот тогтоолоор Премиум Групп ХХК-аас охин компанид оруулсан 1,206,573,000 (нэг тэрбум хоёр зуун зургаан сая таван зуун далан гурван мянган) төгрөгийн хөрөнгө оруулалтын хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 17,340,000 (арван долоон сая гурван зуун дөчин мянган) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 1,734,000,000 (нэг тэрбум долоон зуун гучин дөрвөн сая) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болсныг хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2018 оны 04 сарын 09-ний өдөр бүртгэгдсэн;
- Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувьцаа эзэмшигч Премиум Групп ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 сарын 12-ны өдрийн №19 тоот шийдвэрээр Компанийн хэрэгжүүлж буй "CU" олон улсын сүлжээ конвенциенс дэлгүүрийн төсөлд Премиум Групп ХХК-аас хөрөнгө оруулалт хэлбэрээр оруулсан 9,216,730,000 (есөн тэрбум хоёр зуун арван зургаан сая долоон зуун гучин мянган) төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийг нэгдүүлж нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 109,507,300 (нэг зуун есөн сая таван зуун долоон мянга гурван зуун) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 10,950,730,000 (арван тэрбум есөн зуун тавин сая долоон зуун гучин мянган) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болсныг хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2018 оны 12 сарын 25-ны өдөр бүртгэгдсэн;
- Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувьцаа эзэмшигч Премиум Групп ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 04 сарын 26-ны өдрийн №21 тоот тогтоолоор Компанийн хэрэгжүүлж буй "CU" олон улсын сүлжээ конвенциенс дэлгүүрийн төсөлд Премиум Групп ХХК-аас хөрөнгө оруулалт хэлбэрээр оруулсан 4,480,000,000 (дөрвөн тэрбум дөрвөн зуун наян сая) төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийг нэгдүүлж нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 154,307,300 (нэг зуун таван дөрвөн сая гурван зуун долоон мянга гурван зуун) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 15,430,730,000 (арван таван тэрбум дөрвөн зуун гучин сая долоон зуун гучин мянган) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болсныг хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2019 оны 04 сарын 30-ны өдөр бүртгэгдсэн;
- Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн 2019 оны 10 сарын 31-ний өдрийн №1 тоот шийдвэрээр Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 9.99%-тай тэнцэх хэмжээний энгийн хувьцааг нэмж гарган БНСУ-д бүртгэлтэй БиЖиЭф Ритейл Ко.,Лтд (BGF Retail Co.,Ltd.)-д эзэмшүүлэхээр шийдвэрлэж холбогдох Хувьцаа эзэмшигчдийн гэрээ болон Хувьцаа захиалах, худалдан авах гэрээнд заасан нөхцөлийн дагуу БиЖиЭф Ритейл Ко.,Лтд (BGF Retail Co.,Ltd.)-ээс хөрөнгө оруулалт хэлбэрээр оруулсан 1,714,525,500 (нэг тэрбум долоон зуун арван дөрвөн сая таван зуун хорин таван мянга таван зуун тавин таван) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 17,145,255,500 (арван долоон тэрбум нэг зуун дөчин таван сая хоёр зуун тавин таван мянга таван зуун) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болсныг хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2019 оны 11 сарын 06-ны өдөр бүртгэгдсэн;
- Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн 2021 оны 06 сарын 08-ны өдрийн №4 тоот шийдвэрээр компанийн бүтцийн өөрчлөлт хийхээр шийдвэрлэж Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувьцаа эзэмшигчид болон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд дараах өөрчлөлтүүд орсноор нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 679,807,674 (зургаан





зүүн далан есөн сая найман зүүн долоон мянга зургаан зүүн далан дөрвөн) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 67,980,767,400 (жаран долоон тэрбум есөн зүүн наян сая долоон зүүн жаран долоон мянга дөрвөн зүүн) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болсныг хуулийн этгээдийн үлсын бүртгэлд 2021 оны 06 сарын 11-ний өдөр тус тус бүртгэгдсэн. Үүнд:

- Компанийн 16,232,540,400 (арван зургаан тэрбум хоёр зүүн гучин хоёр сая таван зүүн дөчин мянга дөрвөн зүүн) төгрөгийн эзэлийг хувьцаа эзэмшигч Премииум Групп ХХК-д шилжүүлж, тус шилжүүлсэн дүнгээр хувьцаа нэмж гарган Премииум Групп ХХК-д эзэмшүүлсэн;
- Компанийн "CU" олон улсын сүлжээ конвениенс дэлгүүрийн төсөлд Премииум Групп ХХК-аас хөрөнгө оруулалт хэлбэрээр оруулсан 19,795,024,500 (арван есөн тэрбум долоон зүүн ерэн таван сая хорин дөрвөн мянга таван зүүн) төгрөгийн дүнгээр Компанийг хувьцааг нэмж гарган Премииум Групп ХХК-д эзэмшүүлсэн;
- Премииум Групп ХХК нь өөрийн 100 эзэмшлийн охин компани буюу Компанийн хоолны үйлдвэрлэл түгээлтийн үйл ажиллагааг эрхлэн явуулдаг Премииум Дистрибьюшн ХХК-ийг Компанийн 100 хувийн охин компани болгож, Премииум Групп ХХК-аас Премииум Дистрибьюшн ХХК-д оруулсан 7,724,395,814 (долоон тэрбум долоон зүүн хорин дөрвөн сая гурван зүүн ерэн таван мянга найман зүүн арван дөрвөн) төгрөгийн дүнгээр Компанийн хувьцааг нэмж гарган Премииум Групп ХХК-д эзэмшүүлсэн;
- Премииум Групп ХХК эзэмшиж буй эзэмшлийн нийт хувьцаа болох 591,826,907 (таван зүүн ерэн нэгэн сая найман зүүн хорин зургаан мянга есөн зүүн долоон) ширхэг хувьцааг өөрийн 8 (найман) хувьцаа эзэмшигчид дараах тоо хэмжээгээр шилжүүлсэн. Үүнд: (i) хувьцаа эзэмшигч А.Ганхуялт 223,710,569 (хоёр зүүн хорин гурван сая долоон зүүн арван мянга таван зүүн жаран есөн) ширхэг хувьцаа; (ii) хувьцаа эзэмшигч А.Ганболдод 170,327,784 (нэг зүүн далан сая гурван зүүн хорин долоон мянга долоон зүүн наян дөрвөн) ширхэг хувьцаа; (iii) хувьцаа эзэмшигч Ц.Баяржаргалд 85,282,258 (наян таван сая хоёр зүүн наян хоёр мянга хоёр зүүн тавин найман) ширхэг хувьцаа; (iv) хувьцаа эзэмшигч А.Ганбаатарт 31,248,463 (гучин нэгэн сая хоёр зүүн дөчин найман мянга дөрвөн зүүн жаран гурван) ширхэг хувьцаа; (v) хувьцаа эзэмшигч А.Одончимэгт 31,248,463 (гучин нэгэн сая хоёр зүүн дөчин найман мянга дөрвөн зүүн жаран гурван) ширхэг хувьцаа; (vi) хувьцаа эзэмшигч О.Батмөнхөд 18,760,911 (арван найман сая долоон зүүн жаран мянга есөн зүүн арван нэгэн) ширхэг хувьцаа; (vii) хувьцаа эзэмшигч Г.Бат-Эрдэнэд 18,760,911 (арван найман сая долоон зүүн жаран мянга есөн зүүн арван нэгэн) ширхэг хувьцаа; болон (viii) хувьцаа эзэмшигч Ө.Мөнхбаярт 12,487,548 (арван хоёр сая дөрвөн зүүн наян долоон мянга таван зүүн дөчин найман) ширхэг хувьцаа;
- Компанийн шинээр нэмэгдсэн хувьцаа эзэмшигчдийн 7 (долоон) хувьцаа эзэмшигчдэд нэг бүр нь 100 (нэг зүүн) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 20,000,000 (хорин сая) ширхэг хувьцааг дараах тоо хэмжээгээр нэмж гаргаж эзэмшүүлсэн. Үүнд: (i) хувьцаа эзэмшигч А.Ганхуялт 11,698,320 (арван нэгэн сая зургаан зүүн ерэн найман мянга гурван зүүн хорин) ширхэг хувьцаа; (ii) хувьцаа эзэмшигч А.Ганболдод 2,000,000 (хоёр сая) ширхэг хувьцаа; (iii) хувьцаа эзэмшигч Ц.Баяржаргалд 2,882,000 (хоёр сая найман зүүн наян хоёр мянган) ширхэг хувьцаа; (iv) хувьцаа эзэмшигч А.Одончимэгт 1,056,000 (нэг сая тавин зургаан мянган) ширхэг хувьцаа; (v) хувьцаа эзэмшигч О.Батмөнхөд 970,840 (есөн зүүн далан мянга найман зүүн дөчин) ширхэг хувьцаа; (vi) хувьцаа эзэмшигч Г.Бат-Эрдэнэд 970,840 (есөн зүүн далан мянга найман зүүн дөчин) ширхэг хувьцаа; болон (vii) хувьцаа эзэмшигч Ө.Мөнхбаярт 422,000 (дөрвөн зүүн хорин хоёр мянган) ширхэг хувьцаа;
- БиЖиЭф Ритейл Ко., Лтд. (BGF Retail Co., Ltd.)-ээс Компанид олгосон эзэлийн зарим хэсэг болох 5,083,551,200 (таван тэрбум наян гурван сая таван зүүн тавин нэгэн мянга хоёр зүүн) төгрөгийг хувьцаанд хөрвүүлж, БиЖиЭф Ритейл Ко., Лтд. (BGF Retail Co., Ltd.)-д нэг бүр нь 100 (нэг зүүн) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 50,835,512 (тавин сая найман зүүн гучин таван мянга таван зүүн арван хоёр) ширхэг хувьцааг нэмж гаргасан.

Үлсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн үлсын бүртгэлийн 2021 оны 06 сарын 23-ны өдрийн №08398 тоот дэлгэрэнгүй лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч Сэнтрал





Нууц баримт  
Эх хувь

Экспресс Си Ви Эс ХХК нь нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 679,807,674 (зургаан зуун далан есөн сая найман зуун долоон мянга зургаан зуун далан дөрвөн) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 67,980,767,400 (жаран долоон тэрбум есөн зуун наян сая долоон зуун жаран долоон мянга дөрвөн зуун) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бөгөөд дараах 9 (есөн) хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байна. Үүнд:

Хүснэгт №01. Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц.

№	Хувьцаа эзэмшигч	Тоо ширхэг	Нийт үнэ (төгрөгөөр)	Хувь хэмжээ (хувиар)
1.	А.Ганхуяг	235,408,889	23,540,888,900	34.64%
2.	А.Ганболд	172,327,784	17,232,778,400	25.35%
3.	Ц.Баяржаргал	88,164,258	8,816,425,800	12.97%
4.	А.Одончимэг	32,304,463	3,230,446,300	4.75%
5.	А.Ганбаатар	31,248,463	3,124,846,300	4.60%
6.	О.Батмөнх	19,731,751	1,973,175,100	2.90%
7.	Г.Бат-Эрдэнэ	19,731,751	1,973,175,100	2.90%
8.	Ө.Мөнхбаяр	12,909,548	1,290,954,800	1.90%
9.	БиЖиЭф Ритейл Ко.,Лтд (BGF Retail Co.,Ltd.)	67,980,767	6,798,076,700	9.99%
<b>Нийт</b>		<b>679,807,674</b>	<b>67,980,767,400</b>	<b>100.00%</b>

Үнэт цаас гаргагчийн үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн хувьд хүнсний дэлгүүр (4721)-ээр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн. Үнэт цаас гаргагч нь БиЖиЭф Ритейл Ко.,Лтд (BGF Retail Co.,Ltd.)-тай байгуулсан Мастер франчайзийн гэрээний дагуу орчин үеийн амьдралын хэмнэлд тохирсон, шинэ хэв маяг, соёлыг авчирч буй ая тухтай үйлчилгээ үзүүлэх "CU" олон улсын сүлжээ конвениенс дэлгүүрийг Монгол Улсад байгууж, үйл ажиллагаа явуулах эрхийг эзэмшиж байна. Энэхүү Хуулийн дүгнэлт гарах өдрийн байдлаар "CU" олон улсын сүлжээ конвениенс дэлгүүрийн нийт 127 (нэг зуун хорин долоон) салбар дэлгүүрээр үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн хувьд шинээр (i) хүнсний үйлдвэрлэл эрхлэх (1075); (ii) гадаад худалдаа эрхлэх (4610); болон (iii) Франчайзийн гэрээний үндсэн дээр бизнесийн үйл ажиллагаа явуулах (77300) үйл ажиллагааны чиглэлийг нэмсэн бөгөөд улсын бүртгэлийн байгууллагад тухай бүр бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэгдсэн байгааг дурдаж байна.

Эдгээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний өөрчлөлт, хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт болон шинээр эрхлэх үйл ажиллагааны чиглэлтэй холбоотойгоор гаргасан өөрчлөлт хийх үндэслэл болсон тогтоол, шийдвэр, Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлт нь холбогдох хуульд нийцсэн, бичгээр хийгдсэн, гарын үсэг зүрх эрхтэй этгээд баталсан, хүчин төгөлдөр баримт бичиг байх бөгөөд тухай бүр бүртгэлийн байгууллагад бүртгүүлж байсан байна.

Компанийн оршин байгаа газрын хувьд КТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг<sup>5</sup> заасны дагуу түүний ерөнхий захиргаа байршин байгаа газраар тодорхойлогдох бөгөөд Компанийн хаягийн өөрчлөлтийг бүртгэх байгууллагад бүртгүүлэх хуулийн зохицуулалттай. Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн одоогийн оршин байгаа газар буюу үйл ажиллагаа эрхлэн явуулах албан ёсны хаягийн хувьд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 19а, Шангри-Ла төв, Шангри-Ла оффис, 23 давхар хаягаар хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн.

Үнэт цаас гаргагчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд буюу Гүйцэтгэх захирлаар Монгол Улсын иргэн Г.Чинзориг бүртгэлтэй байна. Тэрээр Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувьцаа эзэмшигч Премиум Групп ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02 сарын 08-ны өдрийн хурлын №18/03 тоот тогтоолоор Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Гүйцэтгэх захирлын албан

<sup>5</sup> Компанийн тухай хууль (2011).

10 дугаар зүйл Компанийн оноосон нэр, оршин байгаа газар


10.4 Компанийн оршин байгаа газар, шүүдэнгийн хаягийг түүний ерөнхий захиргаа байршин байгаа газраар тодорхойлно.

10.5 Компанийн хаягийн өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.





Үнэт цаасны танилцуулга



Нууц баримт  
Эх хувь

тушаалд томилогдсон бөгөөд Гүйцэтгэх захирлаар томилогдсон бүртгэлийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд 2018 оны 02 сарын 19-ний өдөр бүртгэгдэж, тэмдэглэгдсэн байгааг дурдаж байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн байна.

Мөн энэхүү шалгуур асуултын хүрээнд Хуулийн фирм нь Монголын Хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 2 дугаар зүйлийн 2.6.1 дэх заалтад заасан Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх асуудлыг тодруулж төрийн эрх бүхий байгууллагад хандан дэлгэрэнгүй лавлагаа, тодорхойлолт гаргаж өгөхийг хүссэн.

Хуулийн фирмийн зүгээс Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх асуудлаар харьяа төрийн эрх бүхий байгууллагаас лавлагаа, тодорхойлолт хүссэн бөгөөд улсын бүртгэлийн байгууллагаас Хуулийн дүгнэлт гаргаж өгөх өдрийн байдлаар аливаа тодорхойлолт гаргаж өгөөгүй. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2021 оны 06 сарын 23-ны өдрийн №08398 тоот дэлгэрэнгүй лавлагаа болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнээс үзвэл Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний өөрчлөлт, хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт, шинээр эрхлэх үйл ажиллагааны чиглэл болон Компанийн үүсгэн байгуулах баримт бичиг, мэдээлэлд оруулсан өөрчлөлт бүртгэгдэж, тэмдэглэсэн байх тул Үнэт цаас гаргагч нь холбогдох бүртгэлийг улсын бүртгэлд бүртгүүлсэн байна гэж үзэх үндэслэлтэй гэж үзлээ.

Монголын татварын албаны 2021 оны 05 сарын 13-ны өдрийн №21.1003.b420043e-4ff3-4fe2-ad77-6465d5c29fd2 тоот татвар төлөгч хуулийн этгээдийн бүртгэгдсэн татварын төрлийн мэдээллийн бүртгэлийн цахим тодорхойлолтыг үндэслэн Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагч нь холбогдох татварын албанд бүртгэлтэй, татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байхгүй байна гэж үзсэн болно.

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 05 сарын 25-ны өдрийн №1/198 тоот лавлагаанаас үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь тус даатгалын хэлтэс бүртгэлтэй бөгөөд 1,133 (нэг мянга нэг зуун гучин гурван) даатгуулагчтай, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй гэсэн тодорхойлолтыг үндэслэн нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлтэй холбоотой зөрчил байхгүй байна гэж үзсэн.

Дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллага, татвар, нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсэн байх бөгөөд бүртгэлтэй холбоотой аливаа зөрчил байхгүй байна.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-тай холбогдуулан эрх бүхий байгууллагаас гаргуулан авсан лавлагаа, тодорхойлолтын эх хувийг энэхүү Хуулийн дүгнэлтэд хавсаргасан бөгөөд Хаасралт №09. "Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-тай холбогдуулан эрх бүхий байгууллагаас авсан хөндлөнгийн лавлагаа, тодорхойлолт" хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Үнэт цаас гаргагчийн охин компани Премиум Дистрибьюшн ХХК-ийн талаар:

Компанийн тухай хуулийн зохицуулалтын дагуу компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг өөр (толгой) компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг бие даасан компанийг охин компани<sup>7</sup>, компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20-50 хувийг өөр (толгой) компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой

<sup>7</sup> Компанийн тухай хууль (2011).


Б дугаар зүйл.Хараат болон охин компани, компанийн нэгдэл

6.3.Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг бие даасан компанийг охин компани гэнэ.





Нууц баримт  
Эх хувь



этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани<sup>9</sup> гэж тодорхойлж хуульчилсан.

Дээр дурдсан хуулийн тодорхойлолт болон Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн ирүүлсэн баримт материалд үндэслэн Премиум Дистрибьюшн ХХК-ийн нийт гаргасан энгийн хувьцааны 100 (нэг зуун) хувийг дангаараа эзэмшиж байх тул энэхүү Хуулийн дүгнэлт гарах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь Премиум Дистрибьюшн ХХК гэсэн нэг охин компанитай гэж үзсэн.

Премиум Дистрибьюшн ХХК-ийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тус компанийн дүрмийн 5 дугаар зүйлээс үзвэл Премиум Дистрибьюшн ХХК нь нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 77,243,958 (далан долоон сая хоёр зуун дөчин гурван мянга есөн зуун тавин найман) ширхэг энгийн хувьцаатай бөгөөд 7,724,395,800 (долоон тэрбум долоон зуун хорин дөрвөн сая гурван зуун ерэн таван мянга найман зуун) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2021 оны 06 сарын 23-ны өдрийн №08396 тоот дэлгэрэнгүй лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь Премиум Дистрибьюшн ХХК-ийн нийт гаргасан энгийн хувьцааг 100 (нэг зуун) хувь эзэмшдэг. Үүнд:

Хүснэгт №02. Премиум Дистрибьюшн ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн мэдээлэл.

№	Хувьцаа эзэмшигч	Тоо ширхэг	Нэгж үнэ	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (төгрөгөөр)	Хувь хэмжээ
1.	Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК	77,243,958	100	7,724,395,800	100%
	<b>Нийт</b>	<b>77,243,958</b>	<b>100</b>	<b>7,724,395,800</b>	<b>100%</b>

Премиум Дистрибьюшн ХХК (хувийн хэргийн дугаар: №9011668040, регистрийн дугаар: 6169287) нь (i) барилгын материалын худалдаа (4663); (ii) гадаад худалдаа (4610); (iii) хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл (1079); хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа (4630); болон агуулахын болон тээврийн туслах үйл ажиллагаа (4923) эрхлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд албан ёсны хаяг нь Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 хороо, Олимпын гудамж 19А, Шангри-Ла төв, Шангри-Ла оффис, 23 давхар хаягаар хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэлтэй байгааг дурдаж байна.

Үнэт цаас гаргагчийн охин компани Премиум Дистрибьюшн ХХК-ийн татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх болон бусдын өмнө хүлээсэн эр төлбөр, зээлийн гэрээний үүргийн талаар нягталж харьяа төрийн эрх бүхий байгууллагаас дэлгэрэнгүй лавлагаа, тодорхойлолт гаргуулан авлаа. Үүнд:


Монголбанкны Зээлийн мэдээллийн сангийн 2021 оны 05 сарын 12-ны лавлагаанаас үзвэл Премиум Дистрибьюшн ХХК нь банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс 7,987,339,800 (долоон тэрбум есөн зуун наян долоон сай гурван зуун гучин есөн мянга найман зуун) төгрөгийн зээл авснаас лавлагаа гаргах өдрийн байдлаар 6,963,335,300 (зургаан тэрбум есөн зуун жаран гурван сая гурван зуун гучин таван мянга гурван зуун) төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Тус зээлийн гэрээний талаар энэхүү Хуулийн дүгнэлтийн Дөрөвдүгээр бүлэг болох Премиум Дистрибьюшн ХХК-ийн хуулийн этгээд, хувь хүнтэй байгуулсан гэрээний хэсэг дэх Зээлийн гэрээ хэсгээс дэлгэрүүлэн харна үү.

Монголын татварын албаны 2021 оны 07 сарын 28-ны өдрийн №21.1003.cbe3535f-8644-4b94-ab12-60e46a8c4a84 тоот цахим лавлагаа, тодорхойлолтоос үзвэл Премиум Дистрибьюшн

<sup>9</sup> Компанийн тухай хууль (2011).  
<sup>9</sup> дугаар зүйл. Хараат болон охин компани, компанийн нэгдэл  
<sup>9</sup> 1. Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20-50 хувийг өөр улстой/компани дангаараа буюу нэгдмэл сониргогч этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани гэнэ.







Нууц баримт  
Эх хувь

ХХК нь 24,371,048.52 (хорин дөрвөн сая гурван зуун далан нэгэн мянга дөчин найман төгрөг тавин хоёр мөнгө) төгрөгийн илүү төлөлтэй болохыг тодорхойлсон байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны 05 сарын 12-ны өдрийн №ON215EQ11Z280007067392 тоот аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн цахим лавлагаанаас үзвэл Премиум Дистрибьюшн ХХК нь нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй болохыг тодорхойлсон байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Шийдвэр гүйцэтгэх албаны 2021 оны 05 сарын 21-ний өдрийн №0012619 тоот тодорхойлолтоос үзвэл Премиум Дистрибьюшн ХХК нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй болохыг тодорхойлсон байна.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын 2021 оны 05 сарын 21-ний өдрийн №4/703 тоот тодорхойлолтоос үзвэл Премиум Дистрибьюшн ХХК нь тус арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцож байгаагүй болохыг тодорхойлсон байна.

Улаанбаатар хотын Худалдааны танхимын дэргэдэх Арбитрын 2021 оны 05 сарын 21-ний өдрийн №GS-21-25 тоот тодорхойлолтоос үзвэл Премиум Дистрибьюшн ХХК нь сүүлийн 3 жилийн байдлаар арбитрын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцож байгаагүй болохыг тодорхойлсон байна.

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 05 сарын 19-ний өдрийн №3477 тоот албан бичгээс үзвэл Премиум Дистрибьюшн ХХК нь сүүлийн 3 жилийн байдлаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр оролцоогүй болохыг тодорхойлсон байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архивын 2021 оны 05 сарын 21-ний өдрийн №1/8193 тоот тодорхойлолтоос үзвэл Премиум Дистрибьюшн ХХК нь сүүлийн 3 жилийн байдлаар Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байгаагүй болохыг тодорхойлсон байна.


Гаалийн ерөнхий газрын 2021 оны 05 сарын 20-ны өдрийн №01-2/1254 тоот тодорхойлолтоос үзвэл Премиум Дистрибьюшн ХХК нь Гаалийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй болохыг тодорхойлсон байна.

Гаалийн ерөнхий газрын 2021 оны 05 сарын 27-ны өдрийн №03-1/1297 тоот тодорхойлолтоос үзвэл Премиум Дистрибьюшн ХХК нь гаалийн байгууллагад татварын өргүй болохыг тодорхойлсон байна.

Иймд дээр дурдсан төрийн эрх бүхий байгууллагын лавлагаа, тодорхойлолтод үндэслэн Премиум Дистрибьюшн ХХК нь тусгайлан дурдсан эзэлээс бусад асуудлаар татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон бүсдын өмнө хүлээсэн өр төлбөргүй болохыг Хуулийн фирмээс уламжилж байна.

Мөн түүнчлэн Премиум Дистрибьюшн ХХК-ийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг, үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх зэрэг компанийн үйл ажиллагаанд бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байгаа эсэх асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас авсан лавлагаа, тодорхойлолт гаргуулан авлаа. Үүнд:





Нууц баримт  
Эх хувь

Премиум Дистрибьюшн ХХК-ийн гаргаж өгсөн баримт материалаас үзвэл хууль тогтоомжид заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авахыг шаардсан буюу тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхтэй үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз эзэмшдэггүй байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Оюуны өмчийн газрын 2021 оны 05 сарын 27-ны өдрийн №3/240 тоот лавлагаанаас үзвэл Премиум Дистрибьюшн ХХК-ийн нэр дээр бүртгэгдэж, эрхийн хамгаалалт хийгдсэн зүйл байхгүй болохыг тодорхойлсон байна.

Премиум Дистрибьюшн ХХК-ийн гаргаж өгсөн мэдээллээс үзвэл тус компани нь эзэмшил, өмчлөлдөө аливаа төрлийн үнэт цаас буюу үнэт цаасны зах зээлд арилжаалагдах боломжтой санхүүгийн хэрэгсэл эзэмшдэггүй байна.

Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Газар зохион байгуулалтын албаны 2021 оны 06 сарын 14-ний өдрийн №02-06/3830 тоот лавлагаанаас үзвэл Премиум Дистрибьюшн ХХК-ийн нэр дээр Нийслэлийн Засаг даргын захирамжаар газар ашиглуулж, эзэмшүүлсэн эрхийн бүртгэл газрын кадастрын мэдээллийн сангийн "Лэнд менежер" программд бүртгэлгүй болохыг тодорхойлсон байна.

Автотээврийн үндэсний төвийн 2021 оны 06 сарын 15-ны өдрийн тодорхойлолтоос үзвэл Премиум Дистрибьюшн ХХК-ийн өмчлөлд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл бүртгэлгүй болохыг тодорхойлсон байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын 2021 оны 06 сарын 21-ний өдрийн №19 тоот лавлагаанаас үзвэл Премиум Дистрибьюшн ХХК-ийн өмчлөлд (i) Нийслэлийн, Баянзүрх дүүрэг, 11 хороо, Хонхор (13090) гудамж №82/1 тоот хаягт байршилтай, 876 м.кв талбайтай, үйлдвэрлэл-үйлчилгээний зориулалттай, эрхийн улсын бүртгэлийн Y-2204074141 дугаартай үл хөдлөх хөрөнгө; (ii) Нийслэлийн, Баянзүрх дүүрэг, 11 хороо, Хонхор (13090) гудамж №82/4 тоот хаягт байршилтай, 174.7 м.кв талбайтай, үйлдвэрлэлийн зориулалттай, эрхийн улсын бүртгэлийн Y-2204086219 дугаартай үл хөдлөх хөрөнгө; болон (iii) Нийслэлийн, Баянзүрх дүүрэг, 11 хороо, Хонхор (13090) гудамж №82 тоот хаягт байршилтай, 960 м.кв талбайтай, үйлчилгээний зориулалттай, эрхийн улсын бүртгэлийн Y-2204053926 дугаартай үл хөдлөх хөрөнгө буюу нийт 3 (гурван) үл хөдлөх эд хөрөнгө бүртгэлтэй байгааг тодорхойлсон байна. Улсын бүртгэлийн ерөнхий газар, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын 2021 оны 07 сарын 01-ний өдрийн лавлагаанаас үзвэл Премиум Дистрибьюшн ХХК-ийн өмчлөлд байгаа эдгээр 3 (гурван) үл хөдлөх эд хөрөнгө нь барьцаа, батлан зэрэг үүрэг ногдуулсан аливаа хэлцэлд бүртгэгдээгүй болохыг тодорхойлсон.

Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн сангийн бүртгэлээс үзвэл<sup>9</sup> Премиум Дистрибьюшн ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй барьцаатай холбоотой мэдээлэл байхгүй болохыг дурдаж байна.

Дүгнэж үзвэл Премиум Дистрибьюшн ХХК-ийн өмчлөлд байгаа үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр бөгөөд аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй тул тус компани болон Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байдал үүсээгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.


Премиум Дистрибьюшн ХХК-тай холбогдуулан төрийн эрх бүхий байгууллагаас авсан лавлагаа, тодорхойлолтын эх хувийг энэхүү Хуулийн дүгнэлтэд хавсаргасан бөгөөд Хавсралт №10. "Премиум Дистрибьюшн ХХК-тай холбогдуулан эрх бүхий байгууллагаас авсан хөндлөнгийн лавлагаа, тодорхойлолт" хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

<sup>9</sup> <https://mpr.gov.mn/search>





Үнэт цаасны ганилцуулга



Нууц баримт  
Эх хувь

Хоёр. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-т заасан шаардлага хангасан эсэх болон тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал асуудлын хувьд үзвэл:

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-т заасан шаардлага хангасан эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагатай холбоотойгоор тус Компаниас гаргаж өгсөн баримт материалд үндэслэн дүн шинжилгээ хийлээ.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн эрх барих дээд байгууллага болох Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 10 сарын 31-ний өдрийн ээлжит бус хурлын №3 тоот шийдвэрээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр А.Ганхуяг, А.Ганболд, О.Батмөнх, Г.Бат-Эрдэнэ, Г.Чинзориг нарыг 3 (гурван) жилийн хугацаатайгаар тус тус сонгосон байна.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 10 сарын 31-ний өдрийн №1 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар А.Ганхуягийг сонгосон байгааг дурдаж байна.

#### Төлөөлөн удирдах зөвлөл

Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтын хүрээнд үзвэл хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл<sup>10</sup> байх бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтоохоор<sup>11</sup> нарийвчлан зохицуулсан.

Хуулийн зохицуулалтын дагуу авч үзвэл Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна”, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон 5 (таван) гишүүнтэй байна” гэж заасан байх бөгөөд эдгээр зохицуулалт нь дээрх хууль тогтоомжид нийцсэн байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, бүрэлдэхүүний хувьд авч үзвэл энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Хүснэгт №03. Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд.

№	Овог, нэр	Албан тушаал	Төлөв
1.	Адилбишийн Ганхуяг	Премиум Групп ХХК-ийн үүсгэн байгуулагч, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
2.	Адилбишийн Ганболд	Премиум Групп ХХК-ийн үүсгэн байгуулагч, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирал	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

<sup>10</sup> Компанийн тухай хууль (2011).

<sup>11</sup> 75 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл

75.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна.


75.2 Хувьцаат компани нь төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлтэй байх болно.

<sup>11</sup> 75.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтооно.

75.4 Хувьцаат компани болон төрийн эмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь эс буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

75.8 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээ сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.





Нууц баримт  
Эх хувь

3.	Очирбатын Бэтмөнх	Премиум Групп ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Дэд ерөнхийлөгч, Премиум Индастриал энд Инженеринг ХХК-ийн Гүйцэтгэх захирал	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
4.	Гансүхийн Бат-Эрдэнэ	Премиум Групп ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Санхүү хариуцсан дэд ерөнхийлөгч	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
5.	Ганболдын Чинзориг	Премиум Групп ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Гүйцэтгэх захирал	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

#### Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

А.Ганхуяг нь Премиум Групп ХХК-ийн үүсгэн байгуулагч, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бөгөөд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 10 сарын 31-ний өдрийн ээлжит бус хурлын №3 тоот тогтоолоор Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Улмаар Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 10 сарын 31-ний өдрийн хурлын №1 тоот тогтоолоор Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сонгогдсон байна. Тэрээр Монгол Улсын Их Сургуулийг 1999 онд санхүүч, эдийн засагч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. А.Ганхуяг нь 1999 онд М-Си-Эс Интернэйшнл ХХК-д Санхүүгийн шинжээч, 2000-2005 онд М-Си-Эс Электроникс ХХК-ийн Дэд захирал, 2005-2010 онд М-Си-Эс Холдинг ХХК-ийн Дэд ерөнхийлөгч, Санхүү хариуцсан захирал, 2010-2015 онд М-Си-Эс Холдинг ХХК-ийн Дэд ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал, 2010-2011 онд Монголиан Майнинг Корпораци (НКЕх: 0975)-ийн Санхүү хариуцсан дэд ерөнхийлөгч, 2015-2018 онд М-Си-Эс Холдинг ХХК-ийн Мэдээлэл холбооны технологи, хэрэглэгчийн бизнесийн дарга, 2018-2020 онд М-Си-Эс Холдинг ХХК-ийн Захирлуудын зөвлөлийн даргын зөвлөхөөр тус тус ажиллаж байгаад 2016 оноос Премиум Групп ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар өнөөг хүртэл ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга А.Ганхуяг нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2021 оны 03 сард хамрагдаж №0731239 дугаартай гэрчилгээ авсан байна.

#### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

А.Ганболд нь Премиум Групп ХХК-ийн үүсгэн байгуулагч, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирал бөгөөд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 10 сарын 31-ний өдрийн ээлжит бус хурлын №3 тоот тогтоолоор тус Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Тэрээр Оросын Холбооны Улс (ОХУ)-ын Хот байгуулалтын дээд сургуулийг 1993 онд Цахилгаан тээврийн инженер мэргэжлээр бакалаврын зэрэг, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль (ШУТИС)-ийг 2002 онд Цахилгааны системийн инженер мэргэжлээр бакалаврын зэрэгтэй тус тус төгссөн. А.Ганболд нь 1993-1996 онд Голденлинк ХХК-ийн Борлуулалтын менежер, 2003-2007 онд Ганброс ХХК-ийн Ерөнхий захирал, 2007-2011 онд Нэйшнл Девелопер ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байгаад 2018 оноос Премиум Бьюлдинг Материалс ХХК-ийн Гүйцэтгэх захирал, 2015 оноос Юу Эм Эс ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар өнөөг хүртэл ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн А.Ганболд нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2021 оны 03 сард хамрагдаж №0731240 дугаартай гэрчилгээ авсан байна.

О.Батмөнх нь Премиум Групп ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Дэд ерөнхийлөгч, Премиум Индастриал энд Инженеринг ХХК-ийн Гүйцэтгэх захирал бөгөөд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 10 сарын 31-ний өдрийн ээлжит бус хурлын №3 тоот тогтоолоор тус Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Тэрээр Технологийн дээд сургуулийг 1997 онд Физикч, инженер мэргэжлээр бакалаврын зэрэг, Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын Үндэсний Их сургуулийг 2004 онд Компьютерын шинжлэх ухааны чиглэлээр бакалаврын зэрэг, АНУ-ын Үндэсний Их сургуулийг 2008 онд Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй тус тус төгссөн. О.Батмөнх нь 1996-1998 онд Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвд Эрдэм шинжилгээний ажилтан, 2005-2009 онд АНУ-ын Си Пи Ай Кард







Үнэт цаасны танилцуулга



Гууд баримт  
Эх хувь

Группт Чанарын хяналтын багийн ахлагч, 2010-2011 онд Канад улсад Агуулахын системчлэлийн стратегийн багийн удирдагч, 2012-2016 онд Монголын Бетоны Холбооны Ерөнхийлөгчөөр тус тус ажиллаж байгаад 2011 оноос Премиум Индастриал энд Инженеринг ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар өнөөг хүртэл ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн О.Батмөнх нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2021 оны 03 сард хамрагдаж №0731242 дугаартай гэрчилгээ авсан байна.

Г.Бат-Эрдэнэ нь Премиум Групп ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Санхүү хариуцсан дэд ерөнхийлөгч бөгөөд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 10 сарын 31-ний өдрийн ээлжит бус хурлын №3 тоот тогтоолоор тус Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Тэрээр Хан-Уул дээд сургуулийг 2003 онд Бизнесийн удирдлага, хэрэглээний математикч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. Г.Бат-Эрдэнэ нь 2003-2007 онд М-Си-Эс Кока-кола ХХК-ийн Санхүү, төлөвлөлтийн газрын дарга, 2008 онд М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төслийн санхүүгийн менежер, 2008-2011 онд Монголиан Майнинг Корпораци (НКЕх: 0975)-ийн Санхүү хариуцсан дэд захирал, 2012-2016 онд М-Си-Эс Энержи ХХК-ийн Дэд захирлаар тус тус ажиллаж байгаад 2016 оноос Премиум Групп ХХК-ийн Санхүү хариуцсан дэд ерөнхийлөгчөөр өнөөг хүртэл ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Г.Бат-Эрдэнэ нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2021 оны 03 сард хамрагдаж №0731243 дугаартай гэрчилгээ авсан байна.


Г.Чинзориг нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 10 сарын 31-ний өдрийн ээлжит бус хурлын №3 тоот тогтоолоор тус Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон бөгөөд Премиум Групп ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн юм. Тэрээр ШУТИС-ийн Компьютерын шинжлэх ухаан, менежментийн сургуулийг 2008 онд Компьютерын шинжлэх ухаан, мэдээллийн системийн инженер мэргэжлээр бакалаврын зэрэг, АНУ-ын Лүвильийн их сургууль, Бизнесийн сургуулийг 2012 онд Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус төгссөн. Тэрээр 2009-2010 онд Азийн хөгжлийн банк, Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх төсөлд Хөрөнгийн зах зээлийн мэдээллийн систем ба санхүүгийн дэд бүтцийн зөвлөх, 2010-2011 онд АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Эдийн засгийн бодлогын шинэчлэл ба өрсөлдөх чадварын төсөлд Мэдээллийн технологийн зөвлөх, 2014-2016 онд Засгийн газрын тохируулагч агентлаг, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Мэдээлэл, инновацийн албаны дарга, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, 2017-2018 онд Премиум Групп ХХК-ийн Бизнесийн хөгжлийн захирлаар тус тус ажиллаж байгаад 2018 оноос Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар өнөөг хүртэл ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Г.Чинзориг нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2021 оны 03 сард хамрагдаж №0731244 дугаартай гэрчилгээ авсан байна.

**Эрх бүхий албан тушаалтан**

Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэгт “Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шүүд болон шүүд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно” гэж хуульчилсан байдаг бөгөөд хуулийн этгээд өөрийн үүсгэн байгуулах баримт бичиг буюу дүрмээрээ илүү нарийвчлан тодорхойлох эсхүл албан тушаалаар нэр заан тодорхойлох боломжийг олгосон байдаг.

Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн дүрмийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Дараах албан тушаалтнууд нь компанийн эрх бүхий албан тушаалтан байна. Үүнд: (i) гүйцэтгэх захирал; (ii) үйл ажиллагаа хариуцсан захирал; (iii) худалдан авалт хариуцсан захирал; (iv) санхүүгийн албаны дарга; болон (iv) ерөнхий нягтлан бодогч” гэж тусгасан байна. Тус нөхцөл,





Нүүц баримт  
Эх хувь

журмыг удирдлага болгон Хуулийн фирмд ирүүлсэн баримт материалд үндэслэн дараах эрх бүхий албан тушаал буюу ажлын байр, орон тоо Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн бүтцэд байна гэж үзлээ. Үүнд:

Хүснэгт №04. Эрх бүхий албан тушаалын ажлын байрны мэдээлэл.

№	Овог, нэр	Албан тушаал	Орон тоо
1	Ганболдын Чинзориг	Гүйцэтгэх захирал	1
2	Батмөнхийн Цэвэлмаа	Үйл ажиллагаа хариуцсан захирал	1
3	Соронзоннайгалын Дашдорж	Санхүү хариуцсан захирал	1
4	Шагдарсүрэнгийн Одончимэг	Ерөнхий нягтлан бодогч	1
5	Тогоогийн Гантулга	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга	1

#### Гүйцэтгэх удирдлага

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.3 дахь хэсэгт “Хувь хүн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд уг этгээд нь гүйцэтгэх захирал байна” гэж хуульчилсан. Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгээс үзвэл “Компанийн гүйцэтгэх удирдлагыг Компанийн гүйцэтгэх захирал дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээ, Эрх мэдлийн хуваарилалтаар олгогдсон эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ” хэмээн тусгасан байна.

Компанийн тухай хууль, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн дүрэм, Гүйцэтгэх захирлын анкет болон тэдгээрт холбогдох баримт материалаас үзэхэд Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал Г.Чинзориг хэрэгжүүлж байна.

Г.Чинзориг нь хувьцаа эзэмшигч Премиум Групп ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02 сарын 08-ны өдрийн №18/03 тоот тогтоолоор Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон байна. Гүйцэтгэх захирлаар томилогдсон бүртгэлийг Компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд 2018 оны 02 сарын 19-ний өдөр бүртгэгдэж, тэмдэглэгдсэн байна.

#### Бусад эрх бүхий албан тушаалтан

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн гаргаж өгсөн мэдээлэлд үндэслэж үзвэл эрх албан тушаал буюу ажлын байранд дараах албан тушаалтнууд томилогдон ажиллаж байна. Үүнд:

- § Б.Цэвэлмаа Премум Групп ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 07 сарын 06-ны өдрийн №35 тоот тогтоолоор Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирлын албан тушаалд томилогдон ажиллаж байна.
- § С.Дашдорж Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 06 сарын 17-ны өдрийн №8 тоот тогтоолоор Санхүү хариуцсан захирал албан тушаалд томилогдон ажиллаж байна.
- § Ш.Одончимэг Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 09 сарын 16-ны өдрийн №19/Б-1439 тоот тушаалаар Ерөнхий нягтлан бодогч албан тушаалд томилогдон ажиллаж байна.
- § Т.Гантулга Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 10 сарын 31-ний өдрийн хурлын №1 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилогдон ажиллаж байна.

Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль тогтоомжийн зохицуулалт болон Компанийн засаглалын кодексийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтанд тавигддаг шаардлагын хүрээнд Хуулийн фирм нь Компанийн эрх бүхий албан



Нууц баримт  
Эх хувь

тушаалтнуудын мэдээлэл, анкет, тэдгээрийн мэдлэг чадварыг тодорхойлох баримт материалыг гаргаж өгөхийг хүссэн.

Хуулийн фирм нь Компаниас ирүүлсэн баримт материалд үндэслэн Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг дараах хүснэгтээр дэлгэрүүлэн авч үзлээ.

Хүснэгт №05. Сантрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст тавигдсан шаардлагыг хангасан эсэх мэдээлэл.

№	Эрх бүхий албан тушаал	Эрх бүхий албан тушаалтны нэрс	Компанийн тухай хууль (НТХ)				Компанийн засаглалын кодекс (КЗК)
			Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх (Тийм/Үгүй/Н/А)*	Төрийн болон нутгийн захиргааны байгууллагдах удирдах албан тушаал хашдаг эсэх Тийм/Үгүй	Ял шийтгэл эдлэл байгаа эсэх Тийм/Үгүй	ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэглүүлдэг эсэх Тийм/ Үгүй/ N/A	
Нэг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд							
1.	ТУЗ-ийн дарга	Адилбишийн Ганхуяг	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
2.	ТУЗ-ийн гишүүн	Адилбишийн Ганболд	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
3.	ТУЗ-ийн гишүүн	Батмөнхийн Очирбат	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
4.	ТУЗ-ийн гишүүн	Гансүхийн Бат-Эрдэнэ	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
5.	ТУЗ-ийн гишүүн	Ганболдын Чинзориг	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
Хоёр Бусад эрх бүхий албан тушаалтан							
6.	Гүйцэтгэх захирал	Ганболдын Чинзориг	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
7.	Үйл ажиллагаа хариуцсан захирал	Батмөнхийн Сэвэлмаа	N/A	Үгүй	Үгүй	N/A	N/A
8.	Санхүү хариуцсан захирал	Сэрэмзоннайгалын Дашдорж	N/A	Үгүй	Үгүй	N/A	N/A
9.	Ерөнхий нягтлан бодогч	Шагдарсүрэн Одончимэг	N/A	Үгүй	Үгүй	N/A	N/A
10.	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга	Тогоогийн Гантулга	Тийм	Үгүй	Үгүй	N/A	N/A

\*N/A: Компанийн тухай хууль болон компанийн засаглалын кодексийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтанд тусгайлан тавигдсан шаардлагад үндэслэн шаалгаг шаардлагатай гэж үзсэн этгээдийн харгалзах нүдэнд тус тэмдэглэгээг оруулсан болно хуулийн фирм.

Дээр дурдсан хүснэгт дэх мэдээлэл болон Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материалд үндэслэн Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлага хангасан эсэх асуудлыг дэлгэрүүлэн авч үзэж, дараах байдлаар дүгнэлээ.


Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх шаардлагыг Компанийн тухай хуулийн 75.8 дахь хэсэг<sup>12</sup> хуульчилсан байх бөгөөд Компаниас ирүүлсэн

<sup>12</sup> Компанийн тухай хууль (2011).

75 дугаар зүйл Төлөөлөн удирдах зөвлөл

75.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.





Нууц баримт  
Эх хувь

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын анкет, засаглалын сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбарыг үзвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга А.Ганхуяг, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн А.Ганболд, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн О.Батмөнх, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Г.Бат-Эрдэнэ, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Г.Чинзориг болон Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Т.Гантулга нар нь Компанийн засаглалын сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх тул Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх хуулийн шаардлагыг хангасан байна гэж үзлээ.

Эрх бүхий албан тушаалтны хувьд Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд<sup>13</sup> (i) хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг байхыг хориглох; болон (ii) ял шийтгэл эдэлж байгаа этгээдийг Компанийн эрх бүхий албан тушаалд ажиллахыг хориглохоор заасан хуулийн шаардлагын хүрээнд Компаниас ирүүлсэн эрх бүхий албан тушаалтны эрхэлж байгаа ажил, албан тушаал, анкет, баримт бичигт тусгагдсан мэдээлэл, эрх бүхий албан тушаалтнуудын гаргаж өгсөн ял шийтгэл эдэлж байгаагүй тухай лавлагаа болон Баталгаанд үндэслэн Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаггүй бөгөөд ял шийтгэл эдлээгүй гэж Хуулийн фирмээс дүгнэсэн болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэргэшсэн дадлага, түршлагын шаардлагын талаар Компанийн засаглалын кодексийн 5 дугаар зүйлийн 5.2.1 дэх заалтад<sup>14</sup> аудит эсвэл нягтлан бодох бүртгэл, санхүү, хууль, эрх зүй, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн дадлага, түршлага бүхий хувь хүнийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгон ажиллуулах зүйтэй гэж нарийвчилсан зохицуулалттай байх бөгөөд Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, бусад дурдагдсан эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл, анкетад үндэслэн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, бусад дурдагдсан эрх бүхий албан тушаалтнууд нь санхүү, эдийн засаг, инженер, бизнесийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн бөгөөд эдгээр албан тушаалтнууд нь удирдах албан тушаал эрхлэхэд шаардагдах мэргэжлийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн түүхтэй байна гэж үзлээ.

Иймд Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэгт заасан "Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна", 75 дугаар зүйлийн 75.3 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтооно", 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэгт "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүний олонхын саналаар сонгоно", 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор төлөөлөн удирдах зөвлөл томилно", 75 дугаар зүйлийн 75.8 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна", 83 дугаар

<sup>13</sup> Компанийн тухай хууль (2011).

<sup>14</sup> 84 дүгээр зүйл. Компанийн эрх бүхий албан тушаалтан

84.3 Дараах этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалд ажиллахыг хориглоно:

84.3.1 хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг;

84.3.2 ял шийтгэл эдэлж байгаа.

<sup>14</sup> Компанийн засаглалын кодекс (2014).

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх ба түүний бүтэц

5.2.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн үйл ажиллагааг зохистой удирдах, хяналт тавихад нийцэхүйц бүтэцтэй байна. Аудит эсвэл нягтлан бодох бүртгэл, санхүү, хууль, эрх зүй, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн дадлага, түршлага бүхий хувь хүнийг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгон ажиллуулах нь зүйтэй.





зүйлийн 83.2 дахь хэсэгт “Компанийн дүрэмд гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэхээр заагаагүй бол хувь хүн хэрэгжүүлнэ”, 83 дугаар зүйлийн 83.4 дэх хэсэгт “Компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга байхыг хориглоно”, 84 дүгээр зүйлийн 84.2 дахь хэсэгт “Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна” гэсэн холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг тус тус хангаж байна гэж үзлээ.

Үнэт цаас гаргагч нь хувьцаат компани болж өөрчлөгдөж байгаатай холбогдуулан Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэгт “Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна”, Компанийн засаглалын кодексийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалтад “Төлөөлөн удирдах зөвлөл нь хангалттай тооны (гуравны нэгээс доошгүй хувь) хараат бус гишүүдтэй байна”, Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.6 дахь хэсэгт “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас энэ хуулийн 75.4-т заасан тооны хараат бус гишүүнийг төлөөлөн удирдах зөвлөлд сонгож ...” гэж зохицуулсан байх тул Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг ес болон түүнээс дээш гишүүнтэй болгон нэмэгдүүлэх, мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь буюу хангалттай тооны хараат бус гишүүнээр бүрдүүлэх болон Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2 дахь хэсэгт “Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна” гэж заасан байх тул Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг Компанийн дүрмийн эрх бүхий албан тушаалтанд нэмэх нь зүйтэй гэж нь зүйтэй гэж Хуулийн фирмээс үзэж санал болгож байна.

Мөн Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсэгт “Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно”, 81.2 дахь хэсэгт “Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ”, Компанийн засаглалын кодексийн 5 дугаар зүйлийн 5.5.2 дахь заалтад “Хороо нь тухайн үйл ажиллагааг явуулах өндөр үр чадвар бүхий мэргэшсэн, түршлагатай 3-аас доошгүй гишүүдтэй байх...”, 81 дүгээр зүйлийн 81.4 дэх хэсэгт “энэ хуулийн 81.2-т заасан аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх” гэж зохицуулсны дагуу Үнэт цаас гаргагч нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг байгуулах нь зүйтэй гэж Хуулийн фирмээс үзэж санал болгож байна. Та бүхэн судалж үзэн өөрсдийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэхийг Хуулийн фирмээс зөвлөж байна.

Гурав. Компанийн дүрэм, дотоод журмууд, үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгон гаргаж байгаа компанийн хувьд хувьцаат компанийн дүрмийн төсөл, бусад дотоод журмуудын төсөл нь хууль тогтоомж, Хорооноос баталсан “Монголын Компанийн Засаглал кодекс”-т нийцсэн эсэх асуудлын хувьд үзвэл:

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд Компанийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа журамд дүн шинжилгээ хийлээ. Компаниас Хуулийн фирмд ирүүлсэн материалаас үзвэл нийт 36 (гучин зургаан) журам хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Компанийн журмын жагсаалтыг Хавсралт №01. “Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журмын жагсаалт” хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.



Нууц баримт  
Эх хувь

Хүснэгт №06. Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журмын жагсаалтын тоон үзүүлэлт.

№	Журмын нэр, төрөл	2018.05.01- ээс өмнөх	2018.05.01 – 2019.05.01	2019.05.01 – 2020.05.01	2020.05.01 – 2021.05.01	Нийт
1	Хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах журам	2	-	4	1	7
2	Дэлгүүрийн үйл ажиллагаанд хамаарах журам	1	4	-	5	10
3	Түгээлтийн үйл ажиллагаанд хамаарах журам	-	4	1	-	5
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд хамаарах журам	-	2	1	5	8
5	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хамаарах журам	-	1	-	1	2
6	Чанар, хяналтын үйл ажиллагаанд хамаарах журам	-	-	2	1	3
7	Онцгой байдлын үед дагаж мөрдөх журам	-	1	-	-	1
<b>Нийт</b>		<b>3</b>	<b>12</b>	<b>8</b>	<b>13</b>	<b>36</b>

(i) Хөдөлмөрийн харилцаа хүний нөөцөд хамаарах журам

Үнэт цаас гаргагч нь тасалбар болгосон өдрийн байдлаар Компанийн дотоод үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах нийт 7 (долоон) журмыг Хуулийн фирмд ирүүлсэн байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн дотоод журам;
2. Байгууллагын дотоод дүрэм журам боловсруулах журам;
3. Microsoft Planner ашиглах журам;
4. Оффисын ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн журам;
5. Зэрэг дэвийн журам;
6. Хуримтлалын сангийн тухай журам;
7. Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулал тооцох журам.

Эдгээр журмаас онцгойлон дурдвал Үнэт цаас гаргагч нь Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт<sup>15</sup> заасан ажил олгогч нь хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлнэ гэж заасны дагуу Гүйцэтгэх захирлын 2019 оны 10 сарын 22-ны өдрийн №А/19-45 тоот тушаалаар Компанийн Хөдөлмөрийн дотоод журмыг баталсан байна. Энэхүү журмаар хөдөлмөр зохион байгуулалт, ажил олгогч болон ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон тусгасан нь Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцсэн байна. Хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах бусад журмын хувьд Компанийн ажилчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулал олгохтой холбоотой нөхцөл шаардлагыг тодорхойлж зохицуулсан Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцсэн байна.

Компанийн хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дээр дурдсан журмууд нь холбогдох Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомжид нийцсэн байна гэж үзлээ.

<sup>15</sup> Хөдөлмөрийн тухай хууль (1999).

5 дугаар зүйл. Ажил олгогчийн эрх, үүрэг

5.1. Ажил олгогч нь хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлэх, ажилтнаас хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, энэ хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх эрхтэй.



**(ii) Дэлгүүрийн үйл ажиллагаанд хамаарах журам**

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас Хуулийн фирмд гаргаж өгсөн журмын жагсаалтаас үзвэл "CU" конвенциенс сүлжээ дэлгүүрийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй нийт 10 (арван) журам байна. Үүнд:

1. Бараа захиалга хүлээн авах журам;
2. Бараа бүтээгдэхүүн буцаалт хийх, актлах үйл ажиллагааны журам;
3. Түүхий эд материалын хяналтын журам;
4. Мөшгөлтийн журам;
5. Үл тохирлын хяналтын журам;
6. "CU" франчайз дэлгүүрийн үйл ажиллагааны журам;
7. Шинэ бүтээгдэхүүн үйл ажиллагаанд нэвтрүүлэх журам;
8. Импортын бүтээгдэхүүн үйл ажиллагаанд нэвтрүүлэх журам;
9. Долоо хоног тутмын катологи гаргах журам;
10. Нийлүүлэгчид үнэлгээ хийх журам.

Эдгээр журмаас онцгойлон дурдвал Гүйцэтгэх захирлын 2020 оны 10 сарын 30-ны өдрийн №А/20-45 тоот тушаалаар батлагдсан Шинэ бүтээгдэхүүн үйл ажиллагаанд нэвтрүүлэх журам нь "CU" конвенциенс дэлгүүрийн салбаруудад шинэ болон сайжруулсан бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийх, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн бий болгох, үйл ажиллагаанд нэвтрүүлэх харилцааг зохицуулсан байна. Тус журмаар компанийн бүтээгдэхүүн, хөгжүүлэлтийн ажилтан нь аливаа шинэ санаа, шийдлийг гадаад, дотоод хэрэглэгч болон эх үүсвэрээс нээлттэй байдлаар тогтмол авч компанийн зах зээлд нийлүүлж байгаа бүтээгдэхүүн болон үйлчилгээний чанар, үнэ, шинж чанар зэргийг байнга сайжруулах боломжийг бүрдүүлснээрээ онцлог болсон байна. Түүнчлэн хоолны үйлдвэрийн бүтээгдэхүүн, дэлгүүрт үгсран боловсруулах бүтээгдэхүүн, нийлүүлэгчийн шууд борлуулах бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэх журмуудыг тус бүрд нь ялгамжтайгаар нарийвчлан зохицуулсан нь давуу тал болжээ.

Гүйцэтгэх захирлын 2021 оны 03 сарын 12-ны өдрийн №А/21-06 тоот тушаалаар батлагдсан Нийлүүлэгчид үнэлгээ хийх журам нь түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүн нийлүүлж хамтран ажиллах аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хүнсний аюулгүй байдал, үйлдвэрийн болон эрүүл ахуйн зохистой дадлын түвшнийг үнэлж "CU" конвенциенс сүлжээ дэлгүүрийн салбар сүлжээнд үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, дүгнэлт гаргах харилцааг зохицуулсан байна. Тус журмыг Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2015 стандарт, нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал MNS CAC RCP CAC RCP 39:2011 стандарт, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага MNS 4946:2019 стандарт, мах, махан бүтээгдэхүүн, эрүүл ахуйн аюулгүй байдлын үндсэн шаардлага MNS 5032:2001, худалдааны агуулах, ерөнхий шаардлага MNS 5364:2011 стандартад тус тус нийцүүлэн баталсан байна.


Түүнчлэн Гүйцэтгэх захирлын 2020 оны 08 сарын 19-ний өдрийн №А/20-36 тоот тушаалаар батлагдсан "CU" конвенциенс франчайз дэлгүүрийн үйл ажиллагааны журам нь "CU" конвенциенс сүлжээ дэлгүүрийн эрхийг франчайзийн гэрээний үндсэн дээр эрх хүлээн авагчид шилжүүлэх, тус гэрээний үндсэн дээр эрх хүлээн авагчийн үйл ажиллагааг удирдан явуулахад баримтлах бодлого болон франчайзийн харилцаанд оролцогчдын үүрэг хариуцлагыг тогтоох, дэлгүүрийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулсан байна.

Нэгтгэн дүгнэвэл Компанийн "CU" конвенциенс сүлжээ дэлгүүрийн үйл ажиллагаанд хамаарах журмууд нь холбогдох хууль тогтоомж, стандартуудад нийцсэн байна.

**(iii) Түгээлтийн үйл ажиллагаанд хамаарах журам**

Компаниас Хуулийн фирмд ирүүлсэн журмын жагсаалтаас үзвэл түгээлтийн үйл ажиллагаанд хамаарах 5 (таван) журмыг баталсан байна. Үүнд:





Нууц баримт  
Эх хувь

1. Түгээлтийн төвд барааг хүлээн авах, бүртгэж, байршуулах журам;
2. Түгээлтийн төвийн ерөнхий шаардлагын журам;
3. Түгээлтийн төвд захиалга бэлтгэх, гаргах журам;
4. Түгээлтийн төвөөр дамжуулан нийлүүлдэг бараа бүтээгдэхүүн актлах журам;
5. Түгээлтийн төвийн бараа бүтээгдэхүүний тооллого хийх журам.

Эдгээр журмаар түгээлтийн төвд барааг хүлээн авах, бүртгэж байршуулах, түгээлтийн төвд тавигдах ерөнхий шаардлага, бараа бүтээгдэхүүнд тооллого хийх актлахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна. Компанийн түгээлтийн үйл ажиллагаанд хамаарах эдгээр журмууд нь холбогдох хууль тогтоомж, стандартуудад нийцсэн байна.

**(iv) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд хамаарах журам**

Үнэт цаас гаргагч нь тасалбар болгосон өдрийн байдлаар Компанийн дотоод үйл ажиллагаанд мөрдөж байгаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд хамаарах нийт 8 (найман) журмыг Хуулийн фирмд ирүүлсэн байна. Үүнд:

1. Гэрээт болон туслан гүйцэтгэгч нарын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, байгаль орчны журам;
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах журам;
3. Хүнсний аюулгүй байдал, Эрүүл ахуйн зохистой дадлыг хэвшүүлэх, хяналт тавих журам;
4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий журам;
5. Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл ашиглах журам;
6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого;
7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, зааварчилгаа өгөх журам;
8. Галын аюулгүй байдлын журам.

Компани нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд хамаарах журмуудаа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6-д “Ажил олгогч нь ажлын байрны онцлогт нийцсэн дүрэм, заавар, журам баталж, мөрдүүлэх үүрэгтэй” гэж заасанд нийцүүлэн Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан байна. Эдгээр журмыг “CU” конвенциенс сүлжээ дэлгүүрт ажиллаж байгаа ажилчид үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байна. Үнэт цаас гаргагчаас Хуулийн фирмд ирүүлсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд хамаарах журмууд нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцсэн байна.

Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.10 дахь заалтад<sup>16</sup> аж ахуйн нэгж нь галын аюулгүй байдлын дүрэмтэй байх үүрэгтэй гэж заасны дагуу Гүйцэтгэх захирлын №А/21-20 тоот тушаалаар Галын аюулгүй байдлын журмыг батлан, мөрдүүлж байна.

Нэгтгэн дүгнэвэл Компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд хамаарах дээр дурдсан журмууд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

**(v) Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хамаарах журам**

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас Хуулийн фирмд ирүүлсэн журмын жагсаалтаас үзвэл санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хамаарах 2 (хоёр) журмыг баталсан байна. Үүнд:

1. Худалдан авалтын журам;
2. Төлбөр гүйцэтгэх зөвшөөрөл авах, төлбөр тооцоо гүйцэтгэх журам.

<sup>16</sup> Галын аюулгүй байдлын тухай хууль (2015).

17 дугаар зүйл. Галын аюулгүй байдлыг хангах талаар аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

17.2. Галын аюулгүй байдлыг хангах талаар аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага дараах үүрэг хүлээнэ:

17.2.10. галын аюулгүй байдлын дүрэм, гал түймэр унтраах шүүрхэй төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий этгээдээр баталгаажуулах;





Нууц баримт  
Эх хувь

Гүйцэтгэх захирлын 2018 оны 09 сарын 04-ний өдрийн №А/18-07 тоот тушаалаар батлагдсан Худалдан авалтын журам нь компанийн хэрэгцээнд бараа, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохицуулсан байна. Тус журам нь "CU" конвенциенс сүлжээ дэлгүүрээр бараа, бүтээгдэхүүн худалдан борлуулах харилцаанд хамаарахгүй, харин Компанийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохицуулсан байна. Мөн Гүйцэтгэх захирлын 2021 оны 03 сарын 31-ний өдрийн №А/21-12 тоот тушаалаар батлагдсан Төлбөр тооцоо гүйцэтгэх зөвшөөрөл авах, төлбөр тооцоо гүйцэтгэх журам нь компанийн бэлэн болон бэлэн бус төлбөр тооцооны зөвшөөрөл авах, төлбөр гүйцэтгэх, хянах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулсан байна.

Нэгтгэн дүгнэвэл Компанийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хамаарах дээр дурдсан журмууд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

**(vi) Чанар, хяналтын үйл ажиллагаанд хамаарах журам**

Үнэт цаас гаргагчаас Хуулийн фирмд чанар, хяналтын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй 3 (гурван) журмыг ирүүлсэн байна. Үүнд:

1. Дотоод хяналтын журам;
2. Баримтжуулсан мэдээллийн хяналтын журам;
3. Хэрэглэгчийн санал, гомдлыг шийдвэрлэх журам.

Эдгээрээс онцгойлон дурдвал, Гүйцэтгэх захирлын 2020 оны 06 сарын 29-ний өдрийн №А/20-32 тоот тушаалаар батлагдсан Дотоод хяналтын журам нь Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавьж дотоод болон гадаад хяналт шалгалт хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөвлөмж өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах санал өгөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна. Компанийн Чанар, хяналтын алба дотоод хяналт шалгалтыг тасралтгүй, бие даасан, бодитой, хараат бус байх зарчмын үндсэн дээр удирдамжийн дагуу Компанийн агуулах, үйлдвэр, дэлгүүрт холбогдох хяналт шалгалтыг хийхээр журманд тусгажээ. Хяналт шалгалтын үр дүн, авсан арга хэмжээний талаар холбогдох албан тушаалтнуудад хэлэлцүүлж, шаардлагатай шийдвэр гаргуулан ажиллах тогтолцоог журмаар тогтоосноороо үйл ажиллагаагаа сайжруулах, зөрчил дутагдлыг залруулах боломжийг бий болгосон байна. Үнэт цаас гаргагчаас дотоод хяналтын журмыг батлан мөрдүүлсэн нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг<sup>17</sup>, Эрүүл ахуйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг<sup>18</sup> тус тус заасантай нийцэж байна.

Мөн Гүйцэтгэх захирлын 2021 оны 02 сарын 25-ны өдрийн №А/21-04 тоот тушаалаар батлагдсан Хэрэглэгчийн санал, гомдлыг шийдвэрлэх журмаар хэрэглэгчээс бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой ирсэн санал, гомдлыг хүлээн авах, мөшгөх, залруулах, шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2015 стандартад нийцсэн байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Нэгтгэн дүгнэвэл Компанийн чанар, хяналтын үйл ажиллагаанд хамаарах журмууд нь холбогдох хууль тогтоомж, стандартуудад нийцсэн байна.

<sup>17</sup> Төрийн хяналт шалгалтын тухай хууль (2003).

13 дугаар зүйл. Хяналт шалгалтын талаарх байгууллага, аж ахуйн нэгжийн үүрэг

13.1. Байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч нь холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, тухайн Хурал, Засаг даргын болон өөрийн шийдвэрийг байгууллагынхаа хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн дотоодын хяналт шалгалтын журам тогтоож ажиллана.

<sup>18</sup> Эрүүл ахуйн тухай хууль (2016).

7 дугаар зүйл. Үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих эрүүл ахуйн шаардлага

7.3. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нь энэ хуулийн 7.2-т заасан эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэмд нийцүүлсэн дотоод хяналтын журмыг боловсруулан баталж, мөрдөнө.



(vii) Онцгой байдлын үед дагаж мөрдөх журам

Үнэт цаас гаргагч нь Онцгой байдлын үед дагаж мөрдөх 1 (нэг) журмыг Хуулийн фирмд ирүүлсэн байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалтад “Ажил олгогч нь хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол, бэртэл, өвчлөлөөс ажилтныг хамгаалах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх үүрэгтэй”, 28.1.6 дахь заалтад “Ажил олгогч нь ажлын байрны онцлогт нийцсэн дүрэм, заавар, журам баталж, мөрдүүлэх үүрэгтэй” гэж тус тус заасны дагуу Компани нь болзошгүй осол, аваар, онцгой нөхцөл байдлыг таних, сэргийлэх, хянах, ослын үеийн харилцаа холбоог хангах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэл болон байгаль орчны сөрөг нөлөөг бүүруулах, эдгээр үйл явдлыг тодорхой давтамжтайгаар шалгах, үр дүнтэй байдлыг хангах харилцааг зохицуулахаар Онцгой байдлын үеийн бэлэн байдал, харилцаа холбоо, авах арга хэмжээ, зохион байгуулалтын журмыг батлан, мөрдүүлж байна.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн дүрмийн төсөл

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 07 сарын 26-ны өдрийн №6 тоот “Компанийн хэлбэрийг өөрчлөх замаар өөрчлөн байгуулах болон нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах тухай” шийдвэрийн Хавсралт №1-ээр Компанийн хэлбэрийг өөрчлөх замаар үүсэх хувьцаат компанийн дүрмийн төслийг баталсан байна.

Тус дүрмийн төслөөс үзвэл Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг<sup>19</sup> заасан компанийн дүрэмд заавал тусгах зүйл буюу (i) компанийн оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ; (ii) компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ; (iii) хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх; (iv) төлөөлөн удирдах зөвлөл; болон (v) компанийн үйл ажиллагааны чиглэл зэргийг бүрэн тусгасан байна.

Түүнчлэн хувьцаат компанийн дүрмийн төсөлд компанийн эрх, компанийн удирдлага, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, компанийн эрх бүхий албан тушаалтан, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, татвар ногдуулалт, санхүүгийн тайлан, ногдол ашиг хуваарилах, дотоод хяналт, компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах, өр төлбөрийг барагдуулах зэрэг асуудлыг тусгасан нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.7 дахь заалтад “Компанийн дүрэмд тусгахаар энэ хуульд заасан бусад зүйл”, 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэгт “хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна”, 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт “Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ”, 84 дүгээр зүйлийн 84.2 дахь хэсэгт “Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна”, 92 дугаар зүйлийн 92.8 дахь хэсэгт “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт тогтоосон журмыг тодорхой төрлийн хэлцэл хийхэд баримтлах тухай энэ хууль буюу компанийн дүрэмд заасан журмын хамт нэгэн зэрэг баримтална”, 95 дугаар

<sup>19</sup> Компанийн тухай хууль (2011).

16 дугаар зүйл. Компанийн дүрэм

16.1. Компанийн дүрэм нь түүнийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг мөн.

16.2. Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана:

16.2.1. компанийн бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ;

16.2.2. компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;

16.2.3. компанийн дүрмээр давуу эрхийн хувьцааг зарласан нөхцөлд давуу эрхийн хувьцааны зарласан тоо, түүний эзэмшигчийн эрх;

16.2.4. хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо;

16.2.5. хувьцаа эзэмшигчдийн хүсэл, төлөөлөн удирдах зөвлөлийн энэ хуулиар тодорхойлсноос бусад бүрэн эрх;

16.2.6. компанийн үйл ажиллагааны чиглэл;


16.2.7. компанийн дүрэмд тусгахаар энэ хуульд заасан бусад зүйл.

16.3. Компанийн дүрэмд Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийг зөрчилдөөгүй зүйлийг тусгаж болно.





Үнэт цаасны танилцуулга



Нууц баримт  
Эх хувь

зүйлийн 95.3 дахь хэсэгт “Компанийн санхүүгийн жилийн эхлэх, дуусах хугацааг компанийн дүрмээр тогтооно” заасан шаардлагад тус тус нийцэж байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Нэгтгэн дүгнэвэл Компанийн дотоод үйл ажиллагаандаа мөрдөж байгаа 36 (гучин зургаан) журам болон үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгон гаргаж байгаа компанийн хувьд хувьцаат компанийн дүрмийн төсөл нь холбогдох бусад хууль, тогтоомжид нийцсэн байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Компанийн засаглалын кодексийн 2 дугаар зүйлийн 2.2.5.в дэх дэд заалтад “Компани ямар төрлийн мэдээллийг нийтэд тогтмол болон тухай бүр хүргэх, түүнтэй холбогдон гарах харилцааг зохицуулсан мэдээллийн үйл ажиллагааны журмыг боловсруулан төлөөлөн удирдах зөвлөл батлан мөрдүүлдэг байх ёстой”, 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх хэсэгт “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хүралдуулах тухай журамтай байна”, Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсэгт “Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батлах”, Компанийн засаглалын кодексийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг боловсруулж батлах нь зүйтэй”, 5.8.1 дэх заалтад “Компани нь компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл ба сонирхлыг зөрчлийг зохицуулах бодлоготой байна, Төлөөлөн удирдах зөвлөлийн ёс зүйн кодекстэй байна”, 7.2.3 дэх заалтад “Компани нь хөндлөнгийн аудитыг томилох үйл ажиллагааг зохицуулсан дотоод журамтай байна”, 7.3.1 дэх заалтад “Төлөөлөн удирдах зөвлөл холбогдох этгээдийг компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангах журамтай байна” гэж заасныг үндэслэл болгон анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж хувьцаат компани болсноор компанийн засаглалтай холбоотой дүрэм, журмыг баталж ажиллахыг Хуулийн фирмээс зөвлөж байна.

Дөрөв. Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ, контракт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх асуудлын хувьд үзвэл:

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд буюу 2018 оны 05 сарын 01-ний өдрөөс 2021 оны 05 сарын 01-ний өдөр (цаашид “Гэрээг тасалбар болгосон өдөр” гэх)-өөр тасалбар болгон Компанийн бусадтай бичгээр байгуулсан гэрээг гаргуулан авч хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээг сонгон авч дүн шинжилгээ хийлээ.

Компаниас ирүүлсэн баримт материалаас үзвэл дүрдсэн хугацаанд нийт 1,532 (нэг мянга таван зуун гучин хоёр) гэрээ байгуулагдсанаас тасалбар болгосон өдрийн байдлаар 295 (хоёр зуун ерэн таван) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Үүнд:


Хүснэгт №07: Сүүлийн 3 (гурван) жил дотор бусадтай бичгээр байгуулсан нийт гэрээний тоон үзүүлэлт.

№	Гэрээ	2018.05.01 – 2019.05.01	2019.05.01 – 2020.05.01	2020.05.01 – 2021.05.01	Нийт
1	Хүчин төгөлдөр гэрээ	33	40	222	295
2	Дуусгавар болсон гэрээ	456	418	363	1237
	<b>Нийт</b>	<b>489</b>	<b>458</b>	<b>585</b>	<b>1532</b>

Компанийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийт гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл, хүчин төгөлдөр байдлыг Хавсралт №02. “Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хуулийн этгээд, хувь хүнтэй байгуулсан гэрээний мэдээлэл” хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана үү.

Түүнчлэн гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрөөс өмнө буюу 2018 оны 05 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хэдий ч гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа 1 (нэг) гэрээ байна. Иймд гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 296 (хоёр зуун ерэн зургаан) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгааг дурдаж байна. Үүнд:





Нууц баримт  
Эх хувь

Хүснэгт №08: Сүүлийн 3 (гурван) жил дотор бусадтай байгуулсан хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээний төрлийн тоон үзүүлэлт.

№	Гэрээний нэр, төрөл	2018.05.01- ний өдрөөс өмнө	2018.05.01 – 2019.05.01	2019.05.01 – 2020.05.01	2020.05.01 – 2021.05.01	Нийт
1.	Худалдах, худалдан авах гэрээ	-	-	1	136	137
2.	Зээлийн гэрээ	-	-	-	1	1
3.	Үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ	1	33	39	85	158
	<b>Нийт</b>	<b>1</b>	<b>33</b>	<b>40</b>	<b>222</b>	<b>296</b>

Хуулийн фирм нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэж үзэн ирүүлсэн нийт гэрээний хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө гэрээ байгуулах журам, гэрээний зүйл, гэрээгээр зохицуулж байгаа харилцаанаас хамааруулан дараах шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

- Компанийн үндсэн үйл ажиллагааг эрхлэн явуулахад шаардагдах бараа, бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ болон "CU" конвенциенс сүлжээ дэлгүүрээр худалдаалагдах бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ нь ИХ-ийн 243-261 дүгээр зүйлд заасан нөхцөл болон худалдах, худалдан авах гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх;
- Гадаад улсын хууль тогтоомжийг удирдлага болгохоор заасан гэрээний хүчин төгөлдөр байдалд дүгнэлт өгөөгүй;
- Зээлийн гэрээний хувьд ИХ болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан зээлийн гэрээ болон зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар байгуулсан барьцааны гэрээний гол нөхцөлийг тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх, холбогдох хууль тогтоомжид заасан хэлбэрийн шаардлага хангасан эсэх;
- Франчайзийн гэрээний хувьд ИХ-ийн 333 дугаар зүйлийн 333.1 дэх хэсэгт<sup>20</sup> заасан Франчайзийн гэрээний гол нөхцөл болон Франчайзийн гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, агуулга нь хууль болон Компаниас БНСУ-ийн хуулийн этгээд болох BGF Retail компанитай байгуулсан Мастер франчайзийн гэрээнд харшилсан эсэх, бичгээр байгуулж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан эсэх;
- Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээний хувьд ИХ-ийн 318 дугаар зүйлийн 318.1 дэх хэсэгт<sup>21</sup> заасан түрээсийн гэрээний гол нөхцөл болон Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, бичгээр байгуулж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн эсэх (үл хөдлөх эд хөрөнгийг хэсэгчлэн түрээслэх гэрээнд энэхүү шаардлага хамаарахгүй);

<sup>20</sup> Иргэний хууль (2002).

333 дугаар зүйл. Франчайзийн гэрээ

333.1. Франчайзийн гэрээгээр эрх шилжүүлэгч нь өөрийн фирмийн нэр, бараа буюу ажил, үйлчилгээний гэмдэг, бүтээгдэхүүний загвар, баглаа, боодол, түүнчлэн ажил хэргийн удирдлагын тогтолцоо, төлөвлөлт, харилцаа холбоо, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ олж авах үндсэн чиглэл зэрэг эдийн бус хөрөнгийг ашиглуулахаар тогтоосон журмаар бүрдүүлсэн лицензийг эрх хүлээн авагчид олгох. эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн боловсруулсан тогтолцоо, хамтын ажиллагааны чөлөөллийн дагуу үйл ажиллагаа явуулж, түүнд зохих шагнал, хүраамж, эсхүл эрлөгын тодорхой хувийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.


<sup>21</sup> Иргэний хууль (2002).

318 дугаар зүйл. Түрээсийн гэрээ

318.1. Түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад аж ахуйн үйл ажиллагаа явуулах болон дүрэмд заасан зорилгоо биелүүлэхэд нь зориулж тодорхой хөрөнгө шилжүүлэх, түрээслэгч нь гэрээгээр тохирсон түрээсийн төлбөрийг тгялэх үүргийг тус тус хүлээнэ.






 Нууц баримт  
Эх хувь

- Ажил гүйцэтгэх гэрээний хувьд ИХ-ийн 343 дугаар зүйлийн 343.1 дэх хэсэгт<sup>22</sup> заасан ажил гүйцэтгэх гэрээний гол нөхцөл болон ажил гүйцэтгэх гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, бичгээр байгуулж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн эсэх;
- Даатгалын гэрээний хувьд ИХ-ийн 431 дүгээр зүйлийн 431.4 дэх хэсэгт<sup>23</sup> заасан нөхцөл болон холбогдох даатгалын хуулиудад заасан нөхцөлийг тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, батлагдсан загварын дагуу бичгээр байгуулсан эсэх (батлагдсан загвараар байгуулах даатгалын гэрээний хувьд), талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх.

**Нэг. Худалдах, худалдан авах гэрээ**

Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар Компаниас бусадтай байгуулсан, хүчин төгөлдөр үйлчилж байгаа худалдах, худалдан авах гэрээнд дүн шинжилгээ хийхдээ ИХ болон Премиум Групп ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 11 сарын 06-ны өдрийн №18/A-10 тоот тушаалаар батлагдсан Гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах, дүгнэх тухай журам, Премиум групп ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 09 сарын 04-ний өдрийн №18/A-07 тоот тушаалаар батлагдсан Худалдан авалтын үйл ажиллагааны журмыг удирдлага болголоо.

Энэхүү бүлэгт Компанийн бусадтай байгуулсан хүчин төгөлдөр худалдах, худалдан авах гэрээг (i) компанийн өдөр тутмын дотоод үйл ажиллагааг явуулахад шаардагдах бараа, бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ болон (ii) "CU" конвенциен сүлжээ дэлгүүрээр худалдаалагдах бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ гэж ангилан хууль тогтоомж, Компанийн дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журамд нийцсэн эсэхэд дүгнэлт өгөх болно.

Компаниас ирүүлсэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа гэрээний жагсаалтаас үзвэл Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардагдах бараа, бүтээгдэхүүн худалдах, худалдан авах 1 (нэг) гэрээ, "CU" конвенциен сүлжээ дэлгүүрээр худалдаалагдах бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх 136 (нэг зуун гучин зургаан) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

*Хүснэгт №09: Сүүлийн 3 (гурван) жил дотор бусадтай байгуулсан, хүчин төгөлдөр үйлчилж буй худалдах, худалдан авах гэрээний тоон үзүүлэлт.*

№	Гэрээ	2018.05.01 – 2019.05.01	2019.05.01 – 2020.05.01	2020.05.01 – 2021.05.01	Нийт
1.	Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардагдах бараа, бүтээгдэхүүн худалдан авах гэрээ	-	-	1	1
2.	"CU" конвенциен сүлжээ дэлгүүрээр худалдаалагдах бараа, бүтээгдэхүүн худалдан авах гэрээ	-	1	135	136
<b>Нийт</b>		<b>-</b>	<b>1</b>	<b>136</b>	<b>137</b>

<sup>22</sup> Иргэний хууль (2002).

343 дугаар зүйл. Ажил гүйцэтгэх гэрээ

343.1. Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалач нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.

<sup>23</sup> Иргэний хууль (2002).

431 дүгээр зүйл. Даатгалын гэрээ

431.4. Даатгалын гэрээнд дараахь нөхцөлийг тусгана:

- 431.4.1. даатгалын зүйл;
- 431.4.2. даатгалын эрсдэлийн төрөл;
- 431.4.3. даатгалын үнэлгээний хэмжээ;
- 431.4.4. даатгалын хугацаа, түүнийг дахин сунгах нөхцөл;
- 431.4.5. даатгалын хураамжийн хэмжээ, түүнийг төлөх хугацаа;
- 431.4.6. даатгалч, даатгуулагчийн эрх, үүрэг, хариуцлага;
- 431.4.7. гэрээг дүгнэх, цуцлах, түүнд өөрчлөлт оруулах нөхцөл.



Нууц баримт  
Эх хувь

(i) Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардагдах бараа, бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ

Компани нь Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусдаас бараа худалдан авах нийт 1 (нэг) гэрээг ирүүлсэн байна.

Энэхүү гэрээгээр Үнэт цаас гаргагч нь Скай профешн трейд ХХК-аас ариутгалын бодисыг 1 (нэг) жилийн хугацаанд худалдан авахаар харилцан тохиролцсон байх бөгөөд тус гэрээ нь ИХ-ийн 243 дугаар зүйлийн 243.1 дэх хэсэгт заасан худалдах, худалдан авах гэрээний шинжийг хангасан, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан хүчин төгөлдөр гэрээ байна.

(ii) "CU" конвениенс сүлжээ дэлгүүрээр худалдаалагдах бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ

Компани нь Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа "CU" конвениенс сүлжээ дэлгүүрээр худалдаалагдах бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх нийт 136 (нэг зуун гучин зургаан) гэрээ бусадтай байгуулсан байна. Энэ төрлийн гэрээний хувьд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 12 сарын 26-ны өдрийн А/18-25 тоот тушаалаар Худалдан авалтын гэрээний ерөнхий нөхцөлүүд болон стандарт загварыг баталсан байх бөгөөд баталсан загварын гэрээний дагуу болон энэ загвар гэрээнээс хойш хэд хэдэн удаа өөрчлөгдөн шинэчлэгдсэн загвар гэрээний төслийг ашиглан гэрээг бусадтай байгуулсан байна.

Компани нь энэ төрлийн гэрээг худалдагч, нийлүүлэгчтэй байгуулахын өмнө Компанийн чанар, хяналтын баг тухайн худалдагч, нийлүүлэгчийн үйлдвэр, ажлын байранд очин дүгнэлт гаргадаг, дүгнэлтийг үндэслэж нийлүүлэгчтэй гэрээ байгуулах эсэхийг шийдвэрлэдэг талаар мэдээллийг Компаниас өгсөн.

Үнэт цаас гаргагчаас гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар ирүүлсэн нийт 137 (нэг зуун гучин долоон) худалдах, худалдан авах гэрээ нь ИХ-ийн 243 дугаар зүйлийн 243.1 дэх хэсэгт заасан худалдах, худалдан авах гэрээний шинжийг агуулсан, Компанийн дотоодод мөрдөгдөж байгаа Гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах, дүгнэх тухай журам болон Худалдан авалтын үйл ажиллагааны журмын дагуу байгуулагдсан, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан хүчин төгөлдөр гэрээ байна.

Хоёр. Зээлийн гэрээ

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас ирүүлсэн гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй гэрээнээс үзвэл 1 (нэг) зээлийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Энэхүү зээлийн гэрээний мэдээлэлтэй Хавсралт №02. "Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хуулийн этгээд, хувь хүнтэй байгуулсан гэрээний мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана үү.

Монголбанкны Зээлийн мэдээллийн сангийн 2021 оны 07 сарын 23-ны өдрийн дэлгэрэнгүй лавлагаанаас үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь Монголбанкны Зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэгч банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс авсан нийт 7 (долоон) зээлийн мэдээлэл бүртгэлтэй байгаа бөгөөд энэхүү дүгнэлт гаргах өдрийн байдлаар эдгээр 7 (долоон) зээл нь төлбөрийн үлдэгдэлгүй байна.

Компаниас ирүүлсэн хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа зээлийн гэрээнээс үзэхэд гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь БНСУ-ын хуулийн этгээд болох БиЖиЭф Ритейл Ко.,Лтд (BGF Retail Co.,Ltd.)-тэй 2020 оны 09 сарын 15-ны өдөр зээлийн гэрээ байгуулж, тус гэрээний дагуу Компани нь "CU" конвениенс сүлжээ дэлгүүрийг өргөжүүлэн тэлэх зориулалттайгаар, зээлдүүлэгч болох БиЖиЭф Ритейл Ко.,Лтд (BGF Retail Co.,Ltd.)-ээс 5,000,000,000 (таван тэрбум) Солонгосын вонтой тэнцэхүйц америк долларыг, жилийн 4,6 (дөрөв аравны зургаан) хувийн хүүтэй, 7 (долоон) жилийн хугацаатайгаар зээлэхээр харилцан тохиролцсон байна. Энэхүү зээлийн гэрээний батлан даагчаар Премиум Групп ХХК нь гэрээг баталгаажуулж, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь зээлийн гэрээний дагуу зээлийг эргүүлэн






Нүүд баримт  
Эх хувь



Үнэт цаасны танилцуулга



төлөхийг баталж хэрвээ зээл төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд батлан даагч нь зээлийн үлдэгдлийг зээлдэгчийн хүсэлтийг хүлээн авснаас хойш гуч хоногийн дотор төлж барагдуулах, түүнчлэн Премиум Групп ХХК-ийн хувьцаа эзэмшигч нарын тодорхой тооны хувьцааг барьцаалсан байна. Гэсэн хэдий ч гэрээний талууд 2021 оны 06 сарын 08-ны өдөр үг зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулан Премиум Групп ХХК болон хувьцаа эзэмшигч нарын хувьцааны барьцааны тодорхой хувийг чөлөөлсөн байна. Энэхүү нэмэлт гэрээг байгуулах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч нь 4,000,000,000 (дөрвөн тэрбум) фонтой тэнцэхүйц ам.долларыг БиЖиЭф Ритэйл Ко.,Лтд (BGF Retail Co.,Ltd.)-ээс зээлсэн байна. Нэмэлт гэрээгээр зээлийн дүнгээс 1,985,762,188 (нэг тэрбум есөн зуун наян таван сая долоон зуун жаран хоёр мянга нэг зуун наян найман) фонтой дүйцэхүйц ам.долларт тооцож Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувьцааг авах, үлдэгдэл 3,014,237,812 (гурван тэрбум арван дөрвөн сая хоёр зуун гучин долоон мянга найман зуун арван хоёр) воныг Компани нь гэрээний хугацаанд төлөхөөр талууд харилцан тохиролцсон байна.

Зээлийн гэрээ нь Солонгос улсын хуулиар тайлбарлагдах бөгөөд талуудын хооронд аливаа маргаан үүссэн тохиолдолд Солонгос улсын арбитраар, 3 (гурван) арбитрийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлүүлэхээр хуульд заасан байна. Хуулийн фирм нь гадаад улсын хууль тогтоомжийг удирдлага болгохоор заасан БиЖиЭф Ритэйл Ко.,Лтд (BGF Retail Co.,Ltd.)-тэй байгуулсан энэхүү зээлийн гэрээний хүчин төгөлдөр байдалд дүгнэлт өгөөгүй болно.

Зээлийн гэрээний 7 дугаар зүйлийн 7.7.10 дахь заалт зээлдэгч нь өөрийн үнэт цаасыг олон нийтэд анх удаа санал болгох тохиолдолд зээлдүүлэгчээс зөвшөөрөл авсан байхаар зохицуулсан байна. Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 07 сарын 26-ны өдрийн №6 тоот "Компанийн хэлбэрийг өөрчлөх замаар өөрчлөн байгуулах болон нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах тухай" шийдвэрээр Компанийн "CU" сүлжээ дэлгүүрийн цаашдын санхүүжилтийг хангах зорилгоор тус Компанийн хэлбэрийг өөрчилж хувьцаат компани болгох замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрсөн шийдвэрт БиЖиЭф Ритэйл Ко.,Лтд (BGF Retail Co.,Ltd.)-ээс гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байх тул Үнэт цаас гаргагчаас өөрийн үнэт цаасыг олон нийтэд анх удаа санал болгох зөвшөөрсөн байна гэж үзэх үндэслэлтэй байна.


**Гурав. Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ**

Хуулийн фирм нь хүчин төгөлдөр гэрээг судалсны үндсэн дээр Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК -ийн орлогыг бүрдүүлж, орлогын урсгалыг нэмэгдүүлэхэд гол нөлөө үзүүлж байгаа Компаниас БНСУ-ийн хуулийн этгээд болох БиЖиЭф Ритэйл Ко.,Лтд (BGF Retail Co.,Ltd.)-тэй байгуулсан Мастер франчайзийн гэрээ, Монгол Улсын хуулийн этгээдтэй байгуулж буй франчайзийн гэрээ, Компанийн дүрэмд заасан үндсэн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай оффисын болон "CU" конвениенс сүлжээ дэлгүүрийн байр түрээслэх түрээсийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, ажилтны хариуцлага алдах эрсдэлийг даатгуулсан даатгалын гэрээг тус Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх буюу чухал ач холбогдолтой гэж үзлээ.Үүнд:

*Хүснэгт №14: Сүүлийн 3 (гурван) жил дотор бусадтай байгуулсан Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх хүчин төгөлдөр үйлчилж буй бусад гэрээний төрлийн тоон үзүүлэлт.*

№	Гэрээний нэр, төрөл	2018.05.01- ний өдрөөс өмнө	2018.05.01 – 2019.05.01	2019.05.01 – 2020.05.01	2020.05.01 – 2021.05.01	Нийт
1.	1.1. Франчайзийн гэрээ	1	-	-	12	13
	1.2. Нүүц хадгалах тухай гэрээ	-	-	-	4	4
	1.3. Франчайзийн урьдчилсан нөхцөл хангах тухай гэрээ	-	-	-	5	5
	1.4. Тусгай дансаар үйлчлэх гэрээ	-	-	-	7	7
	1.5. Банкны баталгааны гэрээ	-	-	-	3	3
2.	2.1. Түрээсийн гэрээ	-	30	37	50	117
3.	3.1. Ажил гүйцэтгэх гэрээ	-	3	2	3	8
4.	4.1. Даатгалын гэрээ	-	-	-	1	1
<b>Нийт</b>		<b>1</b>	<b>33</b>	<b>39</b>	<b>85</b>	<b>158</b>





Нууц баримт  
Эх хувь

### Франчайзийн гэрээ

Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 13 (арван гурван) франчайзийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа тухай мэдээлэл ирүүлсэн. Эдгээр гэрээний дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт №02. “Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хуулийн этгээд, хувь хүнтэй байгуулсан гэрээний мэдээлэл” хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас Компанид 2021 оны 06 сарын 23-ны өдрөөр ирүүлсэн дэлгэрэнгүй лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч нь Компаниас “CU” конвенциенс сүлжээ дэлгүүрийн франчайз олгогч болох БНСУ-ийн хуулийн этгээд БиЖиЭф Ритейл Ко.,Лтд (BGF Retail Co.,Ltd.)-тэй 2018 оны 04 сарын 17-ны мастер франчайзийн гэрээг байгуулсныг улсын бүртгэлийн байгууллага бүртгэсэн байна.

Хуулийн фирмд ирүүлсэн мастер франчайзийн гэрээг талууд англи хэл дээр байгуулж, Премиум Групп ХХК батлан даагчаар тус гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан байна. Тус гэрээний дагуу франчайз олгогч БиЖиЭф Ритейл Ко.,Лтд (BGF Retail Co.,Ltd.) нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-д “CU” конвенциенс сүлжээ дэлгүүрийг ажиллуулах менежмент, удирдлагын нөү хуу, бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны иж бүрэн тогтолцоо бүхий өөрийн өмчлөлийн “CU” систем, системийн стандарт, “CU” брэнд, “CU” тэмдгийг хууль ёсны дагуу ашиглах, “CU” конвенциенс дэлгүүрийг франчайзийн хэлбэрээр Монгол Улсад байгуулж, үйл ажиллагаа эрхлэх эрхийг олгосон байна. Мастер франчайзийн гэрээний 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Батлан даагчийн эрх хүлээн авагчид олгосон бүхий л зээлийн дагуу төлөх ёстой нийт зээлийн төлбөр хуримтлагдсан хүүгийн нийт төлбөрийг батлан даагч нь эрх хүлээн авагчийн хувьцаанд хөрвүүлсэн ба үүний үр дүнд эрх хүлээн авагчийн зүгээс батлан даагчид төлөх ёстой зээлийн аливаа төлбөр болохыг батлан даагч нь үүгээр баталж, хүлээн зөвшөөрсөн байна. Батлан даагч нь эрх хүлээн авагчийн хүргүүлж эрх олгогчийн баталсан жилийн бизнесийн төлөвлөгөөнд заасан нэмэлт үнийн дүнгээр эрх хүлээн авагчийг хөрөнгөжүүлэх үүрэгтэй” гэж заасан байна. Мастер франчайзийн гэрээ нь 10 (арван) жилийн хугацаанд хүчин төгөлдөр үргэлжлэх, гэрээний хугацаа дуусгавар болохоос 1 (нэг) жилийн өмнө аль нэг талаас гэрээг дуусгавар болгох талаар бичгээр мэдэгдээгүй тохиолдолд гэрээ анх байгуулагдсан хугацаа, нөхцөлөөр сунгагдах нөхцөлтэй байна. Гэрээнээс үүдсэн болон холбогдон гарсан аливаа маргааныг талууд Сингапурын Олон Улсын Арбитрын төвөөр тухай үед үйлчилж байсан арбитрын журмын дагуу, 3 (гурван) арбитрчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлүүлэхээр тохиролцсон байна.

Мастер франчайзийн гэрээний 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн 22.6.1-т “Энэхүү гэрээ, эрх олгогч, эрх хүлээн авагч болон батлан даагч нарын хоорондын харилцааг Сингапур улсын хуулиар тайлбарлаж, зохицуулна” гэсэн байх тул гэрээний хүчин төгөлдөр байдалд Хуулийн фирмээс дүн шинжилгээ хийгээгүй болно.

Мастер франчайзийн гэрээний 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт Компанийг Монгол Улсын нутаг дэвсгэрт “CU” конвенциенс сүлжээ дэлгүүрийг ажиллуулах франчайзийн эрхийг бусад этгээдэд олгох эрхийг франчайз олгогчоос өгсөн байна. Энэхүү зөвшөөрлийн үндсэн дээр Үнэт цаас гаргагч хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд нийт “CU” конвенциенс сүлжээ дэлгүүрийн 12 (арван хоёр) салбарыг ажиллуулах франчайз эрхийг эрх хүлээн авагч бусад этгээдэд олгосон байна. Өөрөөр хэлбэл гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар Компаниас нийт 12 (арван хоёр) франчайзийн гэрээг Монгол Улсын хуулийн этгээдтэй байгуулсан байна. Франчайзийн гэрээгээр эрх хүлээн авагч нь Компаниас олгосон эрхийн хүрээнд гэрээнд заасан байршилд “CU” систем, “CU” стандартын дагуу “CU” ая тухтай дэлгүүрийн үйл ажиллагааг эрхлэн явуулж, гэрээгээр тохиролцсон хураамж, орлогын тодорхой хувийг Компанид төлөхөөр харилцан тохиролцсон байна. Компани нь франчайзийн гэрээний дагуу эрх хүлээн авагчийн ажиллах хүчнийг сургах, дэлгүүрийн үйл ажиллагааг дэмжих нэгдсэн дуудлагын төв ажиллуулах, дэлгүүрийн зөвлөхийн туслалцаа үзүүлэх, эрх хүлээн авагчийг шаардлагатай мэдээллээр хангах, эрх хүлээн авагч нь тодорхой хураамж, орлогын хувийг тооцож Компанид төлөх, эд хөрөнгийн





Нууц баримт  
Эх хувь

болон бүтээгдэхүүн үйлчилгээний хариуцлагын даатгал, бараа материалын даатгалд даатгуулах, лиценз болон франчайзийн гэрээг гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх гэх мэт үүргүүдийг харилцан хүлээсэн байна. Үнэт цаас гаргагчаас эрх хүлээн авагчтай байгуулж буй франчайзийн гэрээ нь ИХ-ийн 333 дугаар зүйлийн 333.1<sup>24</sup> болон 335 дугаар зүйлийн 335.1<sup>25</sup> дэх хэсэгт заасан франчайзийн гэрээний агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарагдсан хүчин төгөлдөр гэрээ байна.

Дээр дурдсаны дагуу Компани нь эрх хүлээн авагчтай франчайзийн гэрээг байгуулахдаа дараах төрлийн гэрээг давхар байгуулдаг талаар мэдээллийг Хуулийн фирмд ирүүлсэн. Үүнд:

- (i) Нууц хадгалах гэрээ;
- (ii) Франчайзийн урьдчилсан нөхцөл хангах тухай гэрээ;
- (iii) Дамжуулан түрээслэх гэрээ;
- (iv) Тусгай дансаар үйлчлэх гэрээ.

Нууц хадгалах гэрээ

Компаниас ирүүлсэн мэдээллээр Компани нь франчайзийн гэрээг бусадтай байгуулахдаа компанийн цахим хаягаар франчайз эзэмших хүсэлт, анкетыг хүлээн авч шалгаруулалт зохион байгуулсны үндсэн дээр шалгарсан хуулийн этгээдтэй Нууц хадгалах тухай гэрээг байгуулдаг байна. Учир нь шалгарсан хуулийн этгээдэд франчайз эрх олгох гэж буй "CU" конвенциенс салбар дэлгүүрийн санхүүгийн мэдээлэл буюу ашиг, орлогын мэдээллийг Компаниас хүргүүлдэг бөгөөд энэ мэдээлэлтэй танилцсан хуулийн этгээд нь франчайзийн гэрээг байгуулах эсэх шийдвэрийг гаргана. Үнэт цаас гаргагч нь гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 4 (дөрвөн) нууц хадгалах тухай гэрээ ирүүлсэн байх бөгөөд эдгээр гэрээ нь Байгууллагын нууцын тухай хуульд нийцсэн, бичгээр байгуулагдсан, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарагдсан хүчин төгөлдөр гэрээ байна.

Франчайзийн урьдчилсан нөхцөл хангах тухай гэрээ

Компаниас хүргүүлсэн санхүүгийн мэдээллийг хүлээн авсан хуулийн этгээд нь франчайзийн гэрээ байгуулах сонирхолтой байгаа тухайгаа Компанид мэдэгдсэн тохиолдолд талууд франчайзийн урьдчилсан нөхцөл хангах тухай гэрээг байгуулна. Энэхүү гэрээгээр эрх хүлээн авагч нь эрх олгогчоос тогтоосон тодорхой урьдчилсан нөхцөл (эрх хүлээн авагч этгээд нь хувь хүн байх тохиолдолд хуулийн этгээдээр бүртгүүлж, бичиг баримтын бүрдлийг хангах, шаардлагатай лавлагаа, тодорхойлолтыг Компанид гаргаж өгөх, франчайзийн хураамж, эхлэлийн бүтээгдэхүүний төлбөр төлөх гэх мэт)-үүдийг хангахаар заасан байна. Эрх хүлээн авагч нь франчайзийн урьдчилсан нөхцөл хангах тухай гэрээнд заасан урьдчилсан нөхцөлүүдийг хангасан тохиолдолд талууд Франчайзийн гэрээг байгуулна. Харин эрх хүлээн авагч нь гэрээгээр тохиролцсон урьдчилсан нөхцөлүүдийг хангаагүй тохиолдолд франчайзийн урьдчилсан нөхцөл хангах тухай гэрээг цуцалж, цаашид франчайзийн гэрээ байгуулах боломжгүй болдог байна. Үнэт цаас гаргагч нь гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 5 (таван) франчайзийн урьдчилсан нөхцөл хангах тухай гэрээ ирүүлсэн байх бөгөөд эдгээр гэрээ нь ИХ болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцсэн, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан хүчин төгөлдөр гэрээ байна.

<sup>24</sup> Иргэний хууль (2002).


333 дугаар зүйл. Франчайзийн гэрээ

333.1. Франчайзийн гэрээгээр эрх шилжүүлэгч нь өөрийн фирмийн нэр, бараа буюу ажил, үйлчилгээний тэмдэг, бүтээгдэхүүний загвар, баглаа, боодол, түүнчлэн ажил хэргийн удирдлагын тогтолцоо, төлөвлөлт, харилцаа холбоо, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ олж авах үндсэн чиглэл зэрэг эдийн бус хөрөнгийг ашиглуулахаар тогтоосон журмаар бүрдүүлсэн лицензийг эрх хүлээн авагчид олгох, эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн боловсруулсан тогтолцоо, хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулж, түүнд зохих шагнал, хураамж, эсхүл орлогын тодорхой хувийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.

<sup>25</sup> 335 дугаар зүйл. Франчайзийн гэрээний хэлбэр

335.1. Хуульд өөрөөр заагаагүй бол франчайзын гэрээг бичгээр хийнэ.





Нууц баримт  
Эх хувь

**Дамжуулан түрээслэх гэрээ**

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас эрх хүлээн авагчтай франчайзийн гэрээ байгуулахдаа Компани нь дэлгүүрийн байрыг түрээслэгчийн хувиар ашигладаг бол тухайн байрны түрээслүүлэгчтэй байгуулсан үндсэн түрээсийн гэрээний дагуу түрээсийн нөхцөлийг тодорхойлж, эрх хүлээн авагчид дамжуулан түрээсэлдэг байна. Үнэт цаас гаргагчаас нийт 12 (арван хоёр) дамжуулан түрээслэх гэрээ ирүүлсэн нь түрээслүүлэгчтэй Компанийн байгуулсан түрээсийн гэрээг үндэслэсэн, үг түрээсийн гэрээгээр дамжуулан түрээслэх талаар тохиролцсон зүйл байхгүй тохиолдолд нэмэлт гэрээ байгуулж түрээслүүлэгчээс дамжуулан түрээслэх зөвшөөрөл авсны үндсэн дээр хийгдсэн ИХ-ийн 323<sup>26</sup> дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хуульд нийцсэн, хүчин төгөлдөр гэрээ байна.

**Тусгай дансаар үйлчлэх гэрээ**

Үнэт цаас гаргагчаас эрх хүлээн авагчтай байгуулсан франчайзийн гэрээг үндэслэн Компани, эрх хүлээн авагч болон арилжааны банк хооронд тусгай дансаар үйлчлэх гэрээ байгуулж байна. Компани нь гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 7 (долоон) тусгай дансаар үйлчлэх гэрээг Хуулийн фирмд ирүүлсэн байна. Гэрээний дагуу Компани болон эрх хүлээн авагчийн хүсэлтээр банк эрх хүлээн авагчийн нэр дээр төгрөгийн харилцах данс нээж, Компанийг хамтран эзэмшигчээр холбох, тусгай дансаар төвлөрсөн мөнгийг тухайн өдөрт нь Компанийн төлбөрийн даалгаврын дагуу шилжүүлэн төвлөрүүлэх, эрх хүлээн авагч нь үйлчилгээний хөлсийг төлөхөөр харилцан тохиролцсон байна. Тусгай дансаар үйлчлэх гэрээний хувьд ИХ-ийн 445 дугаар зүйлийн 445.1<sup>27</sup> дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан хүчин төгөлдөр гэрээ байна.

**Банкны баталгааны гэрээ**

Үнэт цаас гаргагчаас эрх хүлээн авагчтай байгуулсан франчайзийн гэрээг үндэслэн арилжааны банкнаас Үнэт цаас гаргагчийн өмнө хүлээж буй эрх хүлээн авагчийн төлбөрийн болон ажил үйлчилгээний үүргийн биелэлтийг баталгаажуулж, тодорхой мөнгөн дүнгээр төлбөрийн үүрэг банкны баталгааны нийт 3 (гурван) гэрээг Хуулийн фирмд ирүүлсэн байна. Эдгээр банкны баталгааны гэрээний хувьд ИХ-ийн 457 дугаар зүйлийн 457.1<sup>28</sup> дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан хүчин төгөлдөр гэрээ байна.


Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчаас хуулийн фирмд ирүүлсэн Монгол Улсын хуулийн этгээд болох эрх хүлээн авагчтай байгуулж буй нууц хадгалах гэрээ, франчайзийн урьдчилсан нөхцөл хангах тухай гэрээ, франчайзийн гэрээ, дамжуулан түрээслэх гэрээ, тусгай дансаар үйлчлэх гэрээ нь ИХ-д заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан, талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулсан хүчин төгөлдөр гэрээ байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

<sup>26</sup> Иргэний хууль (2002).  
323 дугаар зүйл. Дамжуулан түрээслэх  
323.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол түрээслэгч түрээсэлсэн эд хөрөнгийг гагцхүү түрээслүүлэгчийн зөвшөөрөлтэйгөөр дамжуулан түрээслэж болно.  
323.2.Дамжуулан түрээсэлсэн эд хөрөнгийг анхны түрээслүүлэгчийн зөвшөөрснөөс өөрөөр ашигласны үр дагаврыг дамжуулан түрээслэгч нь анхны түрээслүүлэгчийн өмнө хариуцна. Энэ тохиолдолд анхны түрээслүүлэгч дамжуулан түрээслэгчийн ашиглах эрхийг дуусгавар болгохыг шаардах эрхтэй.  
<sup>27</sup> Иргэний хууль (2002).  
445 дугаар зүйл. Төлбөр тооцооны гэрээ  
445.1 Төлбөр тооцооны гэрээгээр банк, эрх бүхий бусад хуулийн этгээд /цаашид "төлбөр тооцоо гүйцэтгэгч" гэх/ нь иргэн болон хуулийн этгээд /цаашид "харилцагч" гэх/-ийн бэлэн бусаар хийх төлбөр тооцоог гүйцэтгэх үүрэг хүлээнэ.  
<sup>28</sup> Иргэний хууль (2002).  
457 дугаар зүйл. Банкны баталгааны гэрээ  
457.1 Банкны баталгааны гэрээгээр банк нь үүрэг гүйцэтгүүлэгчийн бичгээр тавьсан шаардлагаар үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс мөнгөн төлбөрийг гүйцэтгэж, үүрэг гүйцэтгэгч нь баталгаа гаргагч банкинд төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ.





Үнэт цаасны танилцуулга



Нууц баримт  
Эх хувь

Хуулийн фирм нь гадаад улсын хууль тогтоомжийг удирдлага болгохоор заасан БиЖиЭф Ритэйл Ко.,Лтд (BGF Retail Co.,Ltd.)-тэй байгуулсан мастер франчайзийн гэрээний хүчин төгөлдөр байдалд дүгнэлт өгөөгүй болохыг дурдаж байна.

**Түрээсийн гэрээ**

Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан бөгөөд гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээнээс үзвэл нийт 117 (нэг зуун арван долоон) түрээсийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Эдгээр түрээсийн гэрээний мэдээлэлтэй Хавсралт №02. “Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хуулийн этгээд, хувь хүнтэй байгуулсан гэрээний мэдээлэл” хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу.

Хуулийн фирмээс түрээсийн гэрээг хуульд нийцсэн эсэхийг шалгахдаа Компанийн түрээсэлж буй байр, талбайн хэмжээгээр үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гарсан тохиолдолд түрээсийн гэрээг ИХ-ийн 318 дугаар зүйлийн 318.3 дахь хэсэгт заасны дагуу улсын бүртгэлийн газрын бүртгүүлэх, байрны талбайг хэсэгчилсэн байдлаар эсхүл аль нэг давхрыг түрээсэлж байгаа тохиолдолд улсын бүртгэлд бүртгүүлэхийг шаардахгүй хуулийн зохицуулалтыг үндэслэл болгон авч үзлээ.

Үнэт цаас гаргагчаас хувь хүн, хуулийн этгээдтэй байгуулсан оффисын байр, “CU” конвениенс сүлжээ дэлгүүрийн байрны болон бусад түрээсийн гэрээ нь ИХ-ийн 318 дугаар зүйлийн 318.1 дэх хэсэгт заасан түрээсийн гэрээний агуулга болон хэлбэрийн шаардлагыг хангасан, гэрээг бичгээр үйлдэж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан байх тул агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан, хүчин төгөлдөр гэрээ гэж Хуулийн фирмээс үзлээ.

**Ажил гүйцэтгэх гэрээ**

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас ирүүлсэн гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй гэрээнээс үзвэл нийт 8 (найман) ажил гүйцэтгэх гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Эдгээр ажил гүйцэтгэх гэрээний мэдээлэлтэй Хавсралт №02. “Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хуулийн этгээд, хувь хүнтэй байгуулсан гэрээний мэдээлэл” хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу.

Энэ төрлийн гэрээний хувьд “CU” конвениенс сүлжээ дэлгүүрийн гадна болон дотоод засал, тавилга үйлдвэрлэл, засварын ажлыг гүйцэтгүүлэхээр бусадтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Эдгээр ажил гүйцэтгэх гэрээ нь ИХ-ийн 343 дугаар зүйлийн 343.1<sup>29</sup> дэх хэсэгт заасан агуулгын шаардлагыг хангасан, бичгээр байгуулж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан байх тул даатгалын гэрээнд тавигдах агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан байна гэж үзлээ.

**Даатгалын гэрээ**

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас ирүүлсэн тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй гэрээнээс үзвэл нийт 1 (нэг) даатгалын гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Энэхүү даатгалын гэрээний мэдээлэлтэй Хавсралт №02. “Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хуулийн этгээд, хувь хүнтэй байгуулсан гэрээний мэдээлэл” хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ уу.


Үнэт цаас гаргагч нь 2021 оны 03 сарын 02-ны өдөр Монгол даатгал ХК-тай ажиллагсдын хариуцлагын даатгалын гэрээг 1 (нэг) жилийн хугацаатайгаар байгуулсан байна. Энэхүү гэрээгээр Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-тай хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан дэлгүүрийн менежер, дэлгүүрийн туслах менежер, кассын ажилтан, хоол үйлчилгээний ажилтан, цагийн ажилчдыг ажиллагсдын хариуцлагын даатгалд хамруулсан байна.

<sup>29</sup> Иргэний хууль (2002).

343 дугаар зүйл. Ажил гүйцэтгэх гэрээ

343.1. Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэл нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.





Нүүц баримт  
Эх хувь

Энд дурдсан даатгалын гэрээ нь ИХ-ийн 431 дүгээр зүйлийн 431.4<sup>90</sup> дэх хэсэгт заасан агуулгын шаардлагыг хангасан, бичгээр байгуулж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан байх тул даатгалын гэрээнд тавигдах агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан байна гэж үзлээ.

Нэгтгэн дүгнэж үзвэл Хуулийн фирм нь Сэнтрал экспресс Си Ви Эс ХХК-аас ирүүлсэн нийт 296 (хоёр зуун ерэн зургаан) гэрээг хүлээн авч, дараах байдлаар ангилан дүгнэлээ. Үүнд:

- Компанийн үндсэн үйл ажиллагааг эрхлэн явуулахад шаардагдах бараа, бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ болон "CU" конвенциенс сүлжээ дэлгүүрээр худалдаалагдах бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ нь ИХ болон холбогдох бусад дүрэм, журамд нийцсэн, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан хүчин төгөлдөр;
- Зээлийн гэрээ нь ИХ, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бүс хөрөнгийн барьцааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан хүчин төгөлдөр;
- Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий гэрээний төрөлд хамаарах франчайзийн гэрээ, түрээсийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ болон даатгалын гэрээ нь ИХ, Даатгалын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан хүчин төгөлдөр байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Нэгтгэн дүгнэж үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас ирүүлсэн ирүүлсэн ирүүлсэн дээр дурдсан 296 (хоёр зуун ерэн зургаан) гэрээ нь ИХ болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан хүчин төгөлдөр гэрээ байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, тэдгээрийн хэрэгжилтийн тухай.

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд буюу 2018 оны 05 сарын 01-ний өдрөөс 2021 оны 05 сарын 01-ний өдрөөр тасалбар болгон Компанийн бусадтай бичгээр байгуулсан Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээг гаргуулан авч хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээг сонгон авч дүн шинжилгээ хийлээ.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд 4 (дөрвөн) удаа өөрчлөлт оруулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн байх тул хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт тухай бүрд Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (таван) хувийг дараах байдлаар тооцлоо. Үүнд:

<sup>90</sup> Иргэний хууль (2002).

431 дүгээр зүйл. Даатгалын гэрээ

431.4 Даатгалын гэрээнд дараах нөхцөлийг тусгана:

431.4.1 даатгалын зүйл;

431.4.2 даатгалын эрсдэлийн төрөл;

431.4.3 даатгалын үндлэгээний хэмжээ;

431.4.4 даатгалын хугацаа, түүнийг дахин сунгах нөхцөл;


431.4.5 даатгалын хураамжийн хэмжээ, түүнийг төлөх хугацаа;

431.4.6 даатгагч, даатгуулагчийн эрх, үүрэг, хариуцлага;


431.4.7 гэрээг дүгнэх, цуцлах, түүнд өөрчлөлт оруулах нөхцөл.







### Үнэт цаасны Танилцуулга



Нууц баримт  
Эх хувь

Хүснэгт №15: Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) хувь (төгрөгөөр).

№	Компанийн дүрэм	2018.04.04- 2018.12.11	2018.12.12- 2019.04.25	2019.04.26- 2019.10.30	2019.10.31- 2021.05.01
1.	Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,734,000,000	10,950,730,000	15,430,730,000	17,145,255,500
2.	Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувь	86,700,000	547,536,500	771,536,500	857,262,775

Үнэт цаас гаргагч нь гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн нийт 11 (арван нэгэн) гэрээний мэдээллийг Хуулийн фирмд гаргаж өгсөн. Эдгээр гэрээний мэдээлэлтэй Хавсралт №03. "Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээний мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Хүснэгт №16: Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээний төрлийн тоон үзүүлэлт.

№	Гэрээний нэр, төрөл	2018.05.01 – 2019.05.01	2019.05.01 – 2020.05.01	2020.05.01 – 2021.05.01	Нийт
1.	Худалдах, худалдан авах гэрээ	-	5	1	6
2.	Зээлийн гэрээ	-	-	1	1
3.	Ажил гүйцэтгэх гэрээ	3	-	1	4
Нийт		3	5	3	11

Эдгээр гэрээнээс Худалдах, худалдан авах гэрээний төрөлд хамаарах "CU" конвениенс сүлжээ дэлгүүрээр худалдаалагдах бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх нийт 6 (зургаан) гэрээ байна. Эдгээр худалдах, худалдан авах гэрээнээс онцгойлон дурдвал Үнэт цаас гаргагч нь 2020 оны 12 сарын 01-ний өдөр Би Жи Эф ритэйл ХХК-тай "CU" конвениенс сүлжээ дэлгүүрээр худалдаалах бараа бүтээгдэхүүн худалдан авах гэрээг байгуулсан байна. Компани нь тус гэрээгээр тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авч зөвхөн "CU" конвениенс сүлжээ дэлгүүрээр худалдахаар, 1 (нэг) жилийн хугацаатай, энэхүү хугацаа дуусахаас 30 (гуч)-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа гэрээг дуусгавар болгох болон гэрээний нөхцөлийг өөрчлөх хүсэлтийг бичгээр хургүүлээгүй тохиолдолд гэрээ адил хугацаа, нөхцөлөөр сунгагдахаар тус тус харилцан тохиролцсон байна. Энэхүү гэрээний хувьд Сингапур улсын хуулийн дагуу тайлбарлагдаж, хэрэглэгдэхээр байх тул Хуулийн фирм нь гэрээний хүчин төгөлдөр байдалд дүгнэлт өгөөгүй болно.

Компаниас ирүүлсэн Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн, гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа худалдах, худалдан авах гэрээнүүд нь ИХ-ийн 243-261 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан хүчин төгөлдөр гэрээ байна.

Үнэт цаас гаргагч нь Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн, гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа 1 (нэг) зээлийн гэрээг ирүүлсэн байна. Эдгээр зээлийн гэрээтэй холбоотой дүгнэлтийг "Бүсэдтэй байгуулсан зээлийн гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх" хэсгээс дэлгэрүүлэн танилцана үү.

Үнэт цаас гаргагч нь Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн, гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа 4 (дөрвөн) ажил гүйцэтгэх гэрээг ирүүлсэн байна. Энэ төрлийн гэрээгээр Компани нь "CU" конвениенс сүлжээ дэлгүүрийн гадна болон дотор заслын ажил, тавилга, ханын хавтангийн ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээлэгчтэй харилцан тохиролцсон байх бөгөөд эдгээр гэрээ нь ИХ-ийн 343 дугаар зүйлийн 343.1 дэх хэсэгт заасан ажил гүйцэтгэх гэрээний





Нүүц баримт  
Эх хувь

шаардлагыг хангасан, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан хүчин төгөлдөр гэрээ байна. Компани нь түгээлтийн үйлчилгээ үзүүлэх гэрээг Премиум Дистрибьюшн ХХК-тай 2019 оны 12 сарын 24-ний өдөр байгуулсан байх бөгөөд Премиум Дистрибьюшн ХХК нь Компанийн бүтээгдэхүүнийг түгээх (хүлээн авах, хадгалах, савлах, шалгах, илгээх багтсан) үйлчилгээг үзүүлэхээр харилцан тохиролцсон байна. Энэхүү түгээлтийн үйлчилгээ үзүүлэх гэрээ нь ИХ болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцсэн, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан хүчин төгөлдөр гэрээ байна.

Нэгтгэн дүгнэвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас ирүүлсэн Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн дээр дурдсан 11 (арван нэгэн) гэрээ нь ИХ болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн хүчин төгөлдөр гэрээ байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Энэхүү асуудлын хүрээнд Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн охин компани Премиум Дистрибьюшн ХХК-ийн бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ, контракт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх асуудлын хувьд дэлгэрүүлэн авч үзлээ.

Хуулийн фирм нь Премиум Дистрибьюшн ХХК-ийн сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд буюу 2018 оны 05 сарын 01-ний өдрөөс 2021 оны 05 сарын 01-ний өдөр (цаашид "Гэрээг тасалбар болгосон өдөр" гэх)-ийг хүртэл хугацаанд бусадтай бичгээр байгуулсан гэрээг гаргуулан авч хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээг сонгон авч дүн шинжилгээ хийлээ.

Премиум Дистрибьюшн ХХК-аас ирүүлсэн баримт материалаас үзвэл, дурдсан хугацаанд нийт 178 (нэг зуун далан найман) гэрээ байгуулагдсанаас тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 40 (дөчин) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Дээр дурдсанчлан компани нь 2019 оны 08 сарын 09-ний өдрөөс эхлэн үйл ажиллагааны чиглэлээ нэмж идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн тул 2018 оны 05 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулсан гэрээ байхгүй байна.

Хүснэгт №17: Сүүлийн 3 (гурван) жил дотор бусадтай бичгээр байгуулсан нийт гэрээний тоон үзүүлэлт.

№	Гэрээ	2018.05.01 – 2019.05.01	2019.05.01 – 2020.05.01	2020.05.01 – 2021.05.01	Нийт
1.	Хүчин төгөлдөр гэрээ	-	16	24	40
2.	Дүүсгавар болсон гэрээ	-	54	84	138
	<b>Нийт</b>	-	<b>70</b>	<b>108</b>	<b>178</b>

Компанийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийт гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл, хүчин төгөлдөр байдлыг Хавсралт №04. "Премиум Дистрибьюшн ХХК-ийн хуулийн этгээд, хувь хүнтэй байгуулсан гэрээний мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана үү.

Хүснэгт №18: Сүүлийн 3 (гурван) жил дотор бусадтай байгуулсан хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээний төрлийн тоон үзүүлэлт.


№	Гэрээний төрөл	2018.05.01 – 2019.05.01	2019.05.01 – 2020.05.01	2020.05.01 – 2021.05.01	Нийт
1.	Худалдах, худалдан авах гэрээ	-	11	11	22
2.	Зээл, зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах гэрээ	-	1	1	2
3.	Үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ	-	-	1	1
4.	Үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ	-	4	11	15
	<b>Нийт</b>	-	<b>16</b>	<b>24</b>	<b>40</b>

Хуулийн фирм нь Премиум Дистрибьюшн ХХК-аас гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэж үзэн ирүүлсэн нийт гэрээний хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө





Үнэт цаасны танилцуулга



Нууц баримт  
Эх хувь

гэрээ байгуулах журам, гэрээний зүйл, гэрээгээр зохицуулж байгаа харилцаанаас хамааруулан дараах шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

- Компанийн үндсэн үйл ажиллагааг эрхлэн явуулахад шаардагдах бараа, бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ нь ИХ-ийн 243-261 дүгээр зүйлд заасан нөхцөл болон худалдах, худалдан авах гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх;
- Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээний хувьд ИХ-ийн 318 дугаар зүйлийн 318.1 дэх хэсэг<sup>31</sup> заасан Түрээсийн гэрээний гол нөхцөл болон Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, бичгээр байгуулж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн эсэх (үл хөдлөх эд хөрөнгийг хэсэгчлэн түрээслэх гэрээнд энэхүү шаардлага хамаарахгүй);
- Зээлийн гэрээний хувьд ИХ болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан зээлийн гэрээ болон зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар байгуулсан барьцааны гэрээний гол нөхцөлийг тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх, холбогдох хууль тогтоомжид заасан хэлбэрийн шаардлага хангасан эсэх;
- Үйл ажиллагаанд ач холбогдол үзүүлэх бусад гэрээний хувьд агуулга нь хуульд харшилсан эсэх, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх.

**Нэг. Худалдах, худалдан авах гэрээ**

Хуулийн фирм нь гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар Компаниас бусадтай байгуулсан, хүчин төгөлдөр үйлчилж байгаа худалдах, худалдан авах гэрээнд дүн шинжилгээ хийхдээ ИХ болон Премиум Групп ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 11 сарын 06-ны өдрийн 18/А-10 тоот тушаалаар батлагдсан Гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах, дүгнэх тухай журам, Премиум Групп ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 09 сарын 04-ний өдрийн №18/А-07 тоот тушаалаар батлагдсан Худалдан авалтын үйл ажиллагааны журмыг удирдлага болголоо.

Компаниас ирүүлсэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа гэрээ, хэлцлийн жагсаалтаас үзвэл, гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар Компанийн үндсэн үйл ажиллагааг явуулахад шаардагдах түүхий эд, бүтээгдэхүүн худалдах, худалдан авах 22 (хорин хоёр) гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Эдгээр гэрээнээс 20 (хорин) гэрээ нь Компанийн дүрэмд заасан хүнсний үйлдвэрлэлийн үндсэн чиглэлийн үйл ажиллагаа явуулах зорилготойгоор бусадтай байгуулсан худалдах, худалдан авах гэрээ байна. Энэ төрлийн гэрээний хувьд хоол үйлдвэрлэлд ашиглан чанар, стандартын шаардлага хангасан сайн чанарын гурил болон гахайн мах, кимчи гэх мэт хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд худалдах, худалдан авах гэрээнүүд байна.


Компани нь гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд эрхлэн явуулахад шаардагдах үл хөдлөх хөрөнгө болон бараа худалдан авах нийт 2 (хоёр) худалдах, худалдан авах гэрээг байгуулсан нь хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Эдгээр гэрээнүүд нь ИХ-ийн 243-262 дугаар зүйл, 109 дүгээр зүйлийн 109.2 дахь хэсэг<sup>32</sup> нийцсэн талуудыг

<sup>31</sup> Иргэний хууль (2002).  
318 дугаар зүйл. Түрээсийн гэрээ  
318.1. Түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад аж ахуйн үйл ажиллагаа явуулах болон дүрэмд заасан зорилгоо биелүүлэхэд нь зориулж тодорхой хөрөнгө шилжүүлэх, түрээслэгч нь гэрээгээр тохирсон түрээсийн төлбөрийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.

<sup>32</sup> Иргэний хууль (2002).  
109 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг шилжүүлэх  
109.2. Үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх хэлцэл, холбогдох бусад баримт бичигт өмчлөх эрх шилжүүлэх болсон үндэслэлийг тодорхой зааж нотаризаар гэрчлүүлэх бөгөөд хэрэв талуудын аль нэг нь төлөөлөгчөөр дамжуулан уг харилцаанд оролцож байвал төлөөлөгч болон түүний итгэмжлэлийг дээрх баримт бичигт тэмдэглэх буюу хавсаргана.







Нууц баримт  
Эх хувь

төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан хүчин төгөлдөр гэрээ байна.

#### Хоёр. Зээлийн гэрээ

Премиум Дистрибьюшн ХХК-аас ирүүлсэн гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй гэрээнээс үзвэл нийт 2 (хоёр) зээлийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Эдгээр зээлийн гэрээний мэдээлэлтэй Хавсралт №04. "Премиум Дистрибьюшн ХХК-ийн хуулийн этгээд, хувь хүнтэй байгуулсан гэрээний мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу.

Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн 2021 оны 05 сарын 12-ны өдрийн дэлгэрэнгүй лавлагаанаас үзвэл Премиум Дистрибьюшн ХХК нь Монгол банкны ЗМС-д мэдээлэл нийлүүлэгч банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс авсан нийт 1 (нэг) зээлийн мэдээлэл бүртгэлтэй байгаа бөгөөд энэхүү зээлийг үг дүгнэлт гаргах өдрийн байдлаар төлж дуусаагүй, хэвийн ангилалд бүртгэлтэй байна. Хуулийн фирм нь тус зээлийн гэрээнд дэлгэрүүлэн авч үзэж дүн шинжилгээ хийлээ.

Премиум Дистрибьюшн ХХК болон хамтран зээлдэгч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь хөрөнгө оруулалтын зориулалтаар Голомт банк ХХК-аас 9,200,000,000 (есөн тэрбум хоёр зуун сая) төгрөгийг, жилийн Монголбанкны бодлогын хүү дээр нэмэх 5 (таван) хувийн хүүтэй, 60 (жаран) сарын хугацаатайгаар зээлэхээр 2020 оны 05 сарын 13-ны өдөр байгуулсан Зээлийн гэрээ байгуулсан байна. Үнэт цаас гаргагчаас 2021 оны 04 сарын 30-ны өдрөөр тасалбар болгон гаргаж өгсөн зээлийн үлдэгдэл нь 6,963,335,300 (зургаан тэрбум есөн зуун жаран гурван сая гурван зуун дүрчин таван мянга гурван зуун) төгрөг байгаа нь Монгол банкны ЗМС-ийн дэлгэрэнгүй лавлагаанд дурдсан зээлийн үлдэгдэлтэй нийцэж байна. Энэхүү зээлийн гэрээ нь Иргэний хуульд<sup>33</sup> заасны дагуу бичгээр байгуулагдсан, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тэмдэг (тамга) дарж баталгаажуулсан, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд<sup>34</sup> заасан зээлийн гэрээний агуулгын шаардлагыг хангасан хүчин төгөлдөр гэрээ байна.

Премиум Дистрибьюшн ХХК болон Голомт банк ХХК нарын хооронд 2020 оны 05 сарын 13-ны өдөр байгуулсан зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар 1 (нэг) барьцааны гэрээг Голомт банк ХХК-тай байгуулсан. Тус барьцааны гэрээгээр Компани нь ирээдүйд бий болох хөрөнгө буюу үйлчилгээний зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө, газрын хамт, 20,000 м.кв (хорин мянган) талбайг 2,082,000,000 (хоёр тэрбум наян хоёр сая) төгрөгөөр үнэлж барьцаалсан байна.

Энэхүү Барьцааны гэрээ нь ИХ-ийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэгт<sup>35</sup> заасны дагуу бичгээр байгуулагдсан, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд<sup>35</sup> заасан

<sup>33</sup> Иргэний хууль (2002).

451 дүгээр зүйл. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээ

451.2. Хуульд өөрөөр заагаагүй бол зээлийн гэрээг бичгээр хийнэ.

<sup>34</sup> Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (1995).

22 дугаар зүйл. Зээлийн гэрээ

22.2. Зээлийн гэрээнд зээлдэгч, зээлдүүлэгчийн оршин байгаа газрын хаяг, зээлийн дансны дугаар, зориулалт, зээлдэх мөнгөний дүн, хугацаа, зээлийн хүүгийн хэмжээ, үг гэрээгээр хүлэсэн үүргийн биелэлтийг хангах арга хэлбэр, гэрээний нөхцөлийг өөрчлөх, гэрээг цуцлах талаар тодорхой тусгана.

<sup>35</sup> Иргэний хууль (2002).

156 дугаар зүйл. Барьцааны гэрээ

156.1. Барьцааны гэрээг бичгээр байгуулна.

<sup>36</sup> Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль (2015).

10. дугаар зүйл. Барьцааны гэрээний агуулга


10.1. Барьцааны гэрээг Иргэний хуулийн нийтлэг журам, энэ хуулийг баримтлан бичгээр байгуулах бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:

10.1.1. Барьцаалагч болон барьцаалуулагч нь иогач бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хуулийн этгээдийн үлсын бүртгэлийн дугаар, оршин байгаа газрын хаяг;

10.1.2. Барьцаагаар хангах үүрэг, гэрээ байгуулах үед, мэдэгдэж байгаа бол барьцаагаар хангагдах шаардлагын хэмжээ;







Нүүц баримт  
Эх хувь

барьцааны гэрээний агуулгын шаардлагыг хангасан хүчин төгөлдөр гэрээ гэж Хуулийн фирмээс үзлээ.

Премиум Дистрибьюшн ХХК-ийн Голомт банк ХХК-тай байгуулсан зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахаар Премиум Групп ХХК-ийн хувьцаа эзэмшигч нар батлан даалтын гэрээг Голомт банк ХХК-тай байгуулсан байна. Энэхүү гэрээгээр батлан даагч нар нь Премиум Дистрибьюшн ХХК зээлийн гэрээний дагуу зээлийг бүрэн төлж барагдуулна гэдгийг Голомт банк ХХК-ийн өмнө баталж, зээлийг төлж барагдуулаагүй тохиолдолд өөрөө хариуцах үүрэг хүлээхээр харилцан тохиролцсон нь ИХ-ийн 458 дугаар зүйлийн 458.1 дэх хэсэгт<sup>37</sup> заасан агуулгын шаардлага, 459 дүгээр зүйлийн 459.1 дэх хэсэгт<sup>38</sup> заасан хэлбэрийн шаардлагыг хангасан хүчин төгөлдөр гэрээ гэж Хуулийн фирм үзлээ.

Премиум Дистрибьюшн ХХК нь тус зээлийн гэрээг Премиум бьюлдинг материалс ХХК-тай 2020 оны 04 сарын 14-ний өдөр байгуулж, 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөгийг, жилийн 14 (арван дөрвөн) хувийн хүүтэй, 24 (хорин дөрвөн) сарын хугацаатайгаар зээлэхээр харилцан тохиролцсон байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Премиум Дистрибьюшн ХХК-аас ирүүлсэн зээлийн гэрээ болон зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийн хангахаар байгуулсан барьцаа болон батлан даалтын гэрээ нь ИХ, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, холбогдох бусад хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн, хүчин төгөлдөр гэрээ хэлцэл байна гэж хуулийн фирмээс үзлээ.

#### Гурав. Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ

Хуулийн фирм нь хүчин төгөлдөр гэрээг судалсны үндсэн дээр Премиум Дистрибьюшн ХХК-ийн бусадтай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ, түрээсийн гэрээг тус Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх буюу чухал ач холбогдолтой гэрээ гэж үзлээ. Үүнд:

*Хүснэгт №19: Сүүлийн 3 (гурван) жил дотор бусадтай байгуулсан Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх хүчин төгөлдөр үйлчилж буй бусад гэрээ, хэлцлийн төрлийн тоон үзүүлэлт.*

№	Гэрээний нэр, төрөл	2018.05.01 – 2019.05.01	2019.05.01 – 2020.05.01	2020.05.01 – 2021.05.01	Нийт
1	Ажил гүйцэтгэх гэрээ	-	3	11	14
2	Түрээсийн гэрээ	-	1	-	1
	<b>Нийт</b>	-	<b>4</b>	<b>11</b>	<b>15</b>

#### Ажил гүйцэтгэх гэрээ

Компаниас ирүүлсэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа гэрээний жагсаалтаас үзвэл, гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 14 (арван дөрвөн) ажил гүйцэтгэх гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Эдгээр ажил гүйцэтгэх гэрээнээс онцлон дурдвал Үнэт цаас гаргагч нь өөрийн ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулахаар Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвтэй 2020 оны 10 сарын 09-ний өдөр, Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвтэй 2020 оны 10 сарын 01-ний өдөр

<sup>37</sup> 10.1.3 барьцаалагч, барьцаалуулагч талууд гэрээндээ барьцаагаар хангах үүргийг ирээдүйд үүсэх, эсхүл өөрчлөгдөж болохээр тохиролцсон бол түүнийг тодорхойлох журам, бусад нөхцөл;

<sup>38</sup> 10.1.4 барьцааны зүйлийн тодорхойлолт, түүний нэг бүрийн, эсхүл төрлийн шинжээр тодорхойлогдох байдал;

<sup>39</sup> 10.1.5 барьцааны гэрээний үргэлжлэх хугацаанд барьцааны зүйлийг эзэмшилдээ байлгах тал;

<sup>40</sup> 10.1.6 барьцааны гэрээ байгуулсан он, сар, өдөр.

<sup>41</sup> Иргэний хууль (2002).

<sup>42</sup> 458 дугаар зүйл. Батлан даалтын гэрээ

<sup>43</sup> 458.1. Батлан даалтын гэрээгээр батлан даагч нь үүрэг гүйцэтгэх өөрийн үүргийг гүйцэтгэж чадна гэж үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө баталж, гүйцэтгэхгүй бол өөрөө хариуцах үүрэг хүлээнэ.

<sup>44</sup> Иргэний хууль (2002).

<sup>45</sup> 459 дүгээр зүйл. Батлан даалтын гэрээний хэлбэр

<sup>46</sup> 459.1. Хуульд өөрөөр заагаагүй бол батлан даалтын гэрээг бичгээр байгуулна.





Нууц баримт  
Эх хувь

ажил гүйцэтгэх гэрээг тус тус байгуулсан байна. Эдгээр гэрээ нь ИХ-ийн 343-358 дугаар зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 44 дүгээр зүйл 44.1.2 дугаар хэсэг<sup>39</sup>, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйл<sup>40</sup>, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10 сарын 20-ны өдрийн 340 дугаар тушаал, Мэргэжлийн хяналтын газрын даргын 2017 оны 07 сарын 01-ний өдрийн №А/179 тоот тушаалын хавсралт №1 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг<sup>41</sup> тус тус нийцсэн хүчин төгөлдөр гэрээ байна.

Компаниас хортон шавж устгал, ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажил гүйцэтгэх гэрээнүүд байгуулсан нь Хүнсний аюулгүй байдлын үгтвар нөхцөлийг хангах хөтөлбөр хоол үйлдвэрлэл MNS ISO 22002-2:2020 стандарт, Мэргэжлийн хяналтын газрын даргын 2017 оны 07 сарын 01-ний өдрийн А/179 тоот тушаалын хавсралт Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг<sup>42</sup>, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2010 оны 206 дугаар тушаалын хавсралт Хоолны газрын нийтлэг журмын 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг<sup>43</sup> заасантай нийцэж байна.

Бусад ажил гүйцэтгэх гэрээгээр хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах хоолны үйлдвэрийн барилга угсралтын ажил гүйцэтгүүлэх, түгээлтийн болон интернэтийн үйлчилгээ үзүүлэх, гал унтраах тоног төхөөрөмж сүүрилуулах, чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ авах, Премиум Дистрибьюшн ХХК-д программ банкны үйлчилгээ холбох корпорейт гэйтвэй үйлчилгээ үзүүлэх гэрээнүүдийг тус тус байгуулсан байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Премиум Дистрибьюшн ХХК-аас ирүүлсэн дээр дурдсан ажил гүйцэтгэх гэрээнүүд нь бичгээр байгуулж, талуудын төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан ИХ-ийн 343-358 дугаар зүйлд нийцсэн гэрээ байна.

Түрээсийн гэрээ

Премиум Дистрибьюшн ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан бөгөөд гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээнээс үзвэл нийт 1 (нэг) түрээсийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Компани нь Акватерм ХХК-ийн өмчлөлийн 4,200 (дөрвөн мянга хоёр зуун) м.кв талбай бүхий агуулахын зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг хүнсний болон өргөн хэрэглээний барааны агуулах, түгээлтийн төвийн зориулалтаар түрээслэхээр 2020 оны 03 сарын 01-ний өдөр Акватерм

<sup>39</sup> Эрүүл мэндийн тухай хууль (2011).  
44 дүгээр зүйл. Эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаарх аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг  
44.1.2. өөрийн байгууллагын ажилтны эрүүл мэндийг дэмжих, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу зохион байгуулах;  
<sup>40</sup> Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008).  
14 дүгээр зүйл. Эрүүл мэндийн үзэл  
14.1. Ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулна.  
14.2. Энэ хуулийн 14.1-д заасны дагуу эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах заацлыг ажил олгогч хариуцна.  
14.3. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд гүйцэтгэж буй тухайн ажил, хөдөлмөрт шаардлагатай бол эмнэлгийн үзлэгт орсон байна.  
14.4. Ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.  
<sup>41</sup> Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм (2017).  
10 дугаар зүйл. Ажилчдын хүвийн ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага  
10.1. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг, түүгээр үйлчилгээ үзүүлдэг хүнсний бүтээгдэхүүн болон хэрэглэх эд зүйлстэй биелэн харьцдаг ажилтан ажиллагсад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд 6 сар тутамд хамрагдсан байна.  
<sup>42</sup> Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм (2017).  
11 дүгээр зүйл. Цэвэрлэгээ, үгаалга, халдваргүйтэлд тавих эрүүл ахуйн шаардлага  
11.1. Хоолны газар нь их цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулж, түүний хэрэгжилтэд хяналт тавина.  
<sup>43</sup> Хоолны газрын нийтлэг журам (2010).  
8 дугаар зүйл. Ариутгал, цэвэрлэгээ  
8.6 Хортон шавж, мэрэгчийн устгал, халдваргүйтгэлийг улирал тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.




 Нүүц баримт  
Эх хувь

ХХК-тай түрээсийн гэрээ байгуулсан байна, Тус түрээсийн гэрээнээс үзвэл Компани нь агуулахын байрыг хэсэгчлэн түрээслэхээр харилцан тохиролцсон байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Хуулийн фирм нь Премиум Дистрибьюшн ХХК-аас ирүүлсэн нийт 40 (дөчин) гэрээ нь ИХ болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан хүчин төгөлдөр гэрээ байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Премиум Дистрибьюшн ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд буюу 2018 оны 05 сарын 01-ний өдрөөс 2021 оны 05 сарын 01-ний өдрөөр тасалбар болгон Компанийн бусадтай бичгээр байгуулсан Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээг гаргуулан авч хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээг сонгон авч дүн шинжилгээ хийлээ.

Премиум Дистрибьюшн ХХК нь анх Гэр хөгжил дэвшил ХХК нэртэйгээр байгуулагдаж, Хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 04 сарын 03-ны өдрийн хурлын №17/01 тоот тогтоолоор компанийн дүрмээ баталсан байх бөгөөд тус дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 10,000,000 (арван сая) төгрөг гэж тогтоосон байна. Үүнээс хойш буюу гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар Компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээндээ 2 (хоёр) удаа өөрчлөлт оруулан, улсын бүртгэлд бүртгүүлсэн байх тул хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт тухай бүрд үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (таван) хувийг дараах байдлаар тооцлоо. Үүнд:

Хүснэгт №20: Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5%-ийн тоон үзүүлэлт.

№	Компанийн дүрэм	2017.04.03- 2020.04.30	2020.05.01- 2021.04.29	2021.04.30-2021.05.01
1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	10,000,000	1,082,263,000	7,724,395,814
2	Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувь	500,000	54,113,150	386,219,791

Үнэт цаас гаргагч нь гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий нийт 29 (хорин есөн) гэрээг Хуулийн фирмд ирүүлсэн. Эдгээр гэрээний мэдээлэлтэй Хавсралт №05. "Премиум Дистрибьюшн ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээний мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Хүснэгт №21: Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээний төрлийн тоон үзүүлэлт.


№	Гэрээний нэр, төрөл	2018.05.01 – 2019.05.01	2019.05.01 – 2020.05.01	2020.05.01 – 2021.05.01	Нийт
1	Худалдах, худалдан авах гэрээ	-	12	9	21
2	Зээлийн гэрээ	-	-	1	1
3	Зээлийн үүргийн гүйцэтгэлийн хангуулах гэрээ	-	-	1	1
4	Ажил гүйцэтгэх гэрээ	-	1	4	5
5	Түрээсийн гэрээ	-	1	-	1
	Нийт	-	14	15	29

Премиум Дистрибьюшн ХХК нь худалдах, худалдан авах гэрээний төрөлд хамаарах, хоол үйлдвэрлэлд шаардагдах түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх нийт 21 (хорин нэгэн) гэрээг Хуулийн фирмд ирүүлсэн байна. Премиум Дистрибьюшн ХХК-аас ирүүлсэн тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа, тус Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн 21 (хорин нэгэн) худалдах,





Нүүц баримт  
Эх хувь



худалдан авах гэрээ нь бичгээр байгуулагдаж, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан, ИХ-д нийцсэн хүчин төгөлдөр гэрээ байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Премиум Дистрибьюшн ХХК-аас ирүүлсэн гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй, хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээнээс үзвэл 1 (нэг) зээлийн гэрээ, 1 (нэг) зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Тус зээлийн гэрээ болон зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийн хангуулах гэрээнд хамаарах дүгнэлтийг “Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ, контракт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх” хэсгээс дэлгэрүүлэн танилцана үү.

Премиум Дистрибьюшн ХХК нь Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн, гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа 5 (таван) ажил гүйцэтгэх гэрээг ирүүлсэн байна. Эдгээр ажил гүйцэтгэх гэрээний төрөлд хамаарах гэрээгээр (i) үйлдвэрийн ажилчдад автобусаар үйлчлэх; (ii) түгээлтийн үйлчилгээ үзүүлэх; болон (iii) хүнсний үйлдвэрийн халуун бэлтгэлийн хэсэгт гал унтраах автомат систем угсарч суурилуулах ажил гүйцэтгүүлэхээр байгуулсан байх бөгөөд тус 5 (таваг) ажил гүйцэтгэх гэрээ нь ИХ-ийн 343 дугаар зүйлийн 343.1 дэх хэсэгт<sup>44</sup> заасан ажил гүйцэтгэх гэрээний шаардлагыг хангасан, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан хүчин төгөлдөр гэрээ байна.

Нэгтгэн дүгнэвэл Премиум Дистрибьюшн ХХК-аас ирүүлсэн Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн дээр дурдсан 29 (хорин есөн) гэрээ нь ИХ болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн хүчин төгөлдөр гэрээ байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Тав. Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх асуудлаар:

Хуулийн фирм нь энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2018 оны 05 сарын 01-ний өдрөөс 2021 оны 05 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан гэрээ, хэлцэл дотор их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан эсэх, 2018 оны 05 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хэдий ч 2021 оны 05 сарын 01-ний өдрийн байдлаар дуусгавар болоогүй хэрэгжиж байгаа их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа эсэх, байгаа нөхцөлд Компанийн тухай хуулийн дагуу хийгдсэн эсэх асуудлыг судалж үзлээ.

(i) Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх асуудлаар:

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалтад “хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй) болон 87 дугаар зүйлийн 87.1.2 дахь заалтад “компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт”-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна.

<sup>44</sup> Иргэний хууль (2002).

343 дугаар зүйл. Ажил гүйцэтгэх гэрээ

343.1. Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ачлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.





Нууц баримт  
Эх хувь

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтад “хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй)” болон 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтад “компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт”-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна.

Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас Хуулийн фирмд ирүүлсэн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангаас балансын нийт актив<sup>45</sup> болон балансын активын 25 хувийн дүнг тооцож үзвэл дараах хэмжээтэй байна. Үүнд:

*Хүснэгт №22: Балансын активын 25%-ийн тоом үзүүлэлт.*

№	Гэрээний нэр, төрөл	Тухайн улирлын балансын нийт актив (төгрөгөөр)	Тухайн улирлын балансын активын 25% (төгрөгөөр)
1.	2018 оны 1 улирал	1,142,976,782	285,744,195
2.	2018 оны 2 улирал	4,221,316,497	1,055,329,124
3.	2018 оны 3 улирал	7,694,001,308	1,923,500,327
4.	2018 оны 4 улирал	11,737,476,615	2,934,369,154
5.	2019 оны 1 улирал	27,272,821,996	6,818,205,499
6.	2019 оны 2 улирал	34,720,056,971	8,680,014,243
7.	2019 оны 3 улирал	39,678,300,706	9,919,575,176
8.	2019 оны 4 улирал	38,928,864,498	9,732,216,124
9.	2020 оны 1 улирал	39,597,529,939	9,899,382,485
10.	2020 оны 2 улирал	41,254,795,216	10,313,698,804
11.	2020 оны 3 улирал	51,101,490,694	12,775,372,674
12.	2020 оны 4 улирал	57,097,014,272	14,274,253,568
13.	2021 оны 1 улирал	58,249,231,488	14,562,307,872

Дээрх хүснэгтэд түсгэгдсэн Үнэт цаас гаргагчийн хэлцэл хийхийн өмнөх балансын сүүлийн балансын активын 25 хувийн дүн болон Компаниас ирүүлсэн гэрээ, хэлцэл, мэдээлэлд үндэслэж үзвэл Компани нь дурдсан хугацааны дотор их хэмжээний 2 (хоёр) гэрээ, хэлцэл байгуулснаас гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа их хэмжээний хэлцэл байхгүй байна.

Иймд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа их хэмжээний хэлцэл байхгүй байна гэж дүгнэлээ.

**(ii) Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх асуудлаар:**

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас 2018 оны 05 сарын 01-ний өдрөөс 2021 оны 05 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд бусадтай бичгээр байгуулсан нийт гэрээ, хэлцлийн дотор сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан эсэх, байгуулагдсан нөхцөлд Компанийн тухай хуулийн дагуу хийгдсэн эсэхийг судалж үзлээ.


Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт “Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай Компанийн тухай хуульд тодорхойлсон харилцаанд орсон бол компанитай, эсхүл

<sup>45</sup> “Балансын нийт актив” гэдэгт Санүү байдлын тайлангийн 2.4 дэх мөр /хэвтээ үзүүлэлт/ буюу “Өр төлбөр ба Эздийн өмч” гэсэн үзүүлэлтийн эсгийн үлдэгдэл гэсэн хагалзах багаанад /босоо үзүүлэлт/ байгаа мөнгөн хөрөнгийг тооцож ойлгосон болно. Хуулийн ойлголт.





Нууц баримт  
Эх хувь



түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно” гэж тодорхой заасан байна.

Компанийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.3 дахь хэсэг<sup>46</sup> заасны дагуу компани нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэлийг тухай бүр хөтлөх үүрэгтэй бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд өөрийн хувийн байдлын талаар мэдээлэл өгөх хуулиар ногдуулсан үүрэгтэй байна. Үнэт цаас гаргагчаас Хуулийн фирмд гаргаж өгсөн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалттай Хавсралт №06. “Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хамаарал бүхий этгээд болон нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт” хүснэгтээс танилцана уу. Тус мэдээлэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувьцаа эзэмшигч, тэдгээрийн хувийн мэдээллийг агуулсан хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцад хамаарах баримт тул төрийн эрх бүхий байгууллага болон одоогийн хувьцаа эзэмшигчид, ирээдүйн хөрөнгө оруулагчдаас бусад этгээдэд хаалттай, нууц мэдээлэлд тооцогдох болохыг анхаарч ажиллахыг Хуулийн фирмээс санал болгож байна.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн зүгээс 2018 оны 05 сарын 01-ний өдрөөс 2021 оны 05 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд байгуулагдсан гэрээ, хэлцлийн жагсаалтаас авч үзвэл нийт 26 (хорин зургаан) сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байгуулснаас тасалбар болгосон өдрийн байдлаар 5 (таван) сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Эдгээр хүчин төгөлдөр хэрэгжиж буй сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн жагсаалт, гэрээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт №07. “Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн мэдээлэл” хүснэгтээс дэлгэрүүлэн үзэж танилцана уу.

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн хувьд Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан журмын дагуу байгуулдаг бөгөөд тус хэсэгт “сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал)-ын гишүүдийн олонхын саналаар гаргана”, 92 дугаар зүйлийн 92.2 дахь хэсэгт “Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг энэ хуулийн 55 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл тогтооно” гэж тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах нөхцөлд гэрээний зүйлийн үнийг Төлөөлөн удирдах зөвлөл тогтоох бөгөөд хэлцэл хийх зөвшөөрлийг сонирхлын зөрчилгүй Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар зөвшөөрөл олгохоор хуулиар зохицуулсан байна.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас хэлцэл хийхийг үндэслэл болгосон холбогдох материалуудыг гаргуулан авч Компанийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн эсэхийг судалж үзэхэд дараах 5 (таван) сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс зөвшөөрөл авсны үндсэн дээр байгуулсан байна. Үүнд:


- (i) Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2019 оны 06 сарын 20-ны өдрийн №А3 тоот сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тогтоолын дагуу Нэтизен ХХК-тай №CVS-2019-364 тоот Ажил гүйцэтгэх гэрээг 2019 оны 06 сарын 20-ны өдөр 3 (гурван) жилийн хугацаатай байгуулсан байна;
- (ii) Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2019 оны 12 сарын 27-ны өдрийн №А5 тоот сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тогтоолын дагуу Премиум Дистрибушн ХХК-тай №CVS-2019-514 тоот Түгээлтийн үйлчилгээ үзүүлэх гэрээг 2019 оны 12 сарын 24-ний өдөр 3 (гурван) жилийн хугацаатай байгуулсан байна;
- (iii) Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 07 сарын 31-ний өдрийн №А1 тоот сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай тогтоолын

<sup>46</sup> Компанийн тухай хууль (2011).

91 дүгээр зүйл. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тавих шаардлага.

91.3.Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангах үүрэгтэй.




 Нууц баримт  
Эх хувь

- дагуу Рио гранде ХХК-тай №CVS-2020-297 тоот Худалдан авах гэрээг 2020 оны 07 сарын 31-ний өдөр 3 (гурван) жилийн хугацаатай байгуулсан байна.
- (iv) Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 09 сарын 21-ний өдрийн №А3 тоот сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай тогтоолын дагуу Рио гранде ХХК-тай №2020-406 тоот Хамтран ажиллах гэрээг 2020 оны 09 сарын 21-ний өдөр 3 (гурван) жилийн хугацаатай байгуулсан байна.
  - (v) Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 09 сарын 18-ны өдрийн №А2 тоот тогтоолын дагуу Рио гранде ХХК-тай №1-2020-530 тоот Түрээсийн гэрээг 2020 оны 09 сарын 18-ны өдөр 3 (гурван) жилийн хугацаатай байгуулсан байна.

Хэлцэл хийх тухай зөвшөөрөл олгосон хувьцаа эзэмшигч болон төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан эдгээр шийдвэр, тогтоолд уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал)-ийн гарын үсэг зурагдсан, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлаар аливаа эсрэг санал тэмдэглэгдээгүй байх тул сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай зөвшөөрлийг хуульд заасан журмын дагуу хэлцэл хийх тухай бүрт хувьцаа эзэмшигч болон төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосны үндсэн дээр байгуулагдсан байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Хуулийн фирм нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлохдоо Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас гаргаж өгсөн бүртгэл, баримт бичиг дээр үндэслэсэн бөгөөд эдгээр баримт материал нь Компанийн тухай хуулийн 89.1 дэх хэсэгт<sup>47</sup> заасан шаардлагыг бүрэн хамарсан эсэх болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд хэлцэл хийхдээ сүүлийн 3 жилийн хугацаанд компанид тухай бүр мэдээлэх үүргээ биелүүлсэн эсэх асуудлаар бие даан дүн шинжилгээ хийх, баталгаа гаргах боломжгүй байгааг анхаарна уу.

Дүгнэж үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас нэгдмэл сонирхолтой этгээдтэй байгуулсан сонирхлын зөрчилтэй 5 (таван) хэлцэл нь Компанийн тухай хуульд заасан журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал)-өөс зөвшөөрөл олгосны үндсэн дээр байгуулсан байна.

Компанийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.3 дахь хэсэгт "Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангах үүрэгтэй", 89 дүгээр зүйлийн 89.5 дахь хэсэгт "Компани тухайн тайлангийн хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн талаарх мэдээллийг жилийн тайландаа тусган нийтэд мэдээлэх үүрэгтэй", Компанийн засаглалын кодексийн 5 дугаар зүйлийн 5.8.1 дэх заалтад "Компани нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл ба сонирхлын зөрчлийг зохицуулах бодлоготой байна" гэж заасан. Иймд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь цаашид хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, хангах зорилгоор сонирхлын зөрчлийг зохицуулах бодлого журмыг Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм, журамд үндэслэн боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөх, мэдээллийн ил тод байдлыг баримталж ажиллахыг Хуулийн фирмээс зөвлөж байна.

<sup>47</sup> Компанийн тухай хууль (2011).

89 дүгээр зүйл. Сонирхлын зөрчил бүхий этгээд.

89.1. Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тосцогдоно:

89.1.1. хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зүүчлагчаар оролцож байгаа;

89.1.2. хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зүүчлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;


89.1.3. хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зүүчлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

89.1.4. хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.





Нууц баримт  
Эх хувь



Зургаа. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх асуудлаар:

#### Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн зүгээс үйл ажиллагаа эрхлэхдээ хууль тогтоомжид заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авахыг шаардсан буюу тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз гэсэн шалгуурын хүрээнд ойлгож дүн шинжилгээ хийлээ.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай үялдуулан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу аймаг, нийслэл болон сум, дүүргийн засаг даргаас олгогдсон спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх болон тамхи худалдах тусгай зөвшөөрөл<sup>45</sup> эзэмшдэг байна. Үүнд:

Хүснэгт №23. Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн мэдээлэл.

№	Үндсэн үйл ажиллагааны чиглэл	Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл	Тамхи худалдах тусгай зөвшөөрөл	"CU" нэрийн ая тухтай сүлжээ дэлгүүрийн нийт тоо
1.	CU нэрийн "Ая тухтай" сүлжээ дэлгүүр	53	12	127
2.	Франчайзийн гэрээгээр эрх шилжүүлэн авсан сүлжээ дэлгүүр	8	3	12

Хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль тогтоомжийн зохицуулалтаас үзвэл Монгол Улсад согтууруулах ундааны худалдах, түүгээр үйлчлэх харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль<sup>46</sup> болон Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн<sup>47</sup> дагуу аймаг, нийслэлийн засаг даргаас олгогдсон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэх хуулийн зохицуулалттай байна.

Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас ирүүлсэн баримт материалаас үзвэл хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар "CU" конвенциенс 53 (тавин гурван) салбар дэлгүүр спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдаалдаг байна. Эдгээр спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах нийт 53 (тавин гурван) тусгай зөвшөөрлийг Улаанбаатар хотын Захирагчийн албанаас 2 (хоёр) жил хүртэлх хугацаагаар олгогдсон байна. Мөн Монгол Улсын нутаг дэвсгэрт "Ая тухтай" дэлгүүрийн сүлжээ дэлгүүр ажиллуулах франчайзийн гэрээгээр эрх шилжүүлэн авсан "Ая тухтай" 8 (найман) сүлжээ дэлгүүр аж ахуйн нэгжийн нэр дээр спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл эзэмшиж байгааг дурдаж байна.

Улаанбаатар хотын Захирагчийн албаны 2021 оны 05 сарын 28-ны өдрийн №01/1292 албан тоот лавлагаанаас үзвэл спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах 53 (тавин гурван) "CU" конвенциенс салбар дэлгүүрийн тусгай зөвшөөрөл нь хүчин

<sup>45</sup> Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль (2001).

<sup>46</sup> 16 дугаар зүйл: Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл олгох аж ахуйн үйл ажиллагааны төрөл

<sup>47</sup> 16.2.5 согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх.


<sup>48</sup> Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль (2000).

<sup>49</sup> 4 дүгээр зүйл: Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл

<sup>50</sup> 4.7. Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар, согтууруулах ундаа импортох, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар тус тус сүнгэнэ.





Нууц баримт  
Эх хувь

төгөлдөр, зөвшөөрөгдсөн хугацааны дотор үйл ажиллагаа явуулж бөгөөд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүсээгүй болохыг тодорхойлсон байна.

Иймд Үнэт цаас гаргагчийн эзэмшиж байгаа "CU" конвенциенс 53 (тавин гурван) салбар дэлгүүрээр спиртийн өндөр болон сүл агууламжтай соггууруулах ундаа худалдаалах 53 (тавин гурван) тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах түдгэлзүүлэх, хүчингүй болох аливаа нөхцөл байдал үүсээгүй байна гэж үзлээ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь<sup>51</sup> хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь<sup>52</sup> хэсэгт заасны дагуу тухайн дүүргийн Засаг дарга тамхи худалдах тусгай зөвшөөрлийг олгодог хуулийн зохицуулалттай байдаг.

Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас ирүүлсэн баримт материалаас үзвэл нийт 12 (арван хоёр) салбар дэлгүүр тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр тамхи худалдах тусгай зөвшөөрөл 3 (гурван) жил хүртэлх хугацаагаар олгогдсон байна.

Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар тамхи худалдах 12 (арван хоёр) тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн ямар нэгэн тохиолдол, үйл явдал гарсан талаар аливаа гомдол санал, шаардлага байхгүй, олгогдсон тусгай зөвшөөрөл, баримт бичигт анхан шатны шалгалт хийхэд илэрсэн зөрчилгүй байсан болохыг дурдаж байна.

#### Батламж, тохирлын гэрчилгээ

Үнэт цаас гаргагч нь үндсэн үйл ажиллагааны төрийн эрх бүхий байгууллагаас олгогддог тусгай зөвшөөрлөөс гадна "CU" нэрийн ая тухтай сүлжээ дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэхдээ эрх бүхий байгууллагаас дараах батламж, тохирлын гэрчилгээ авсан талаарх мэдээллийг нэмэлтээр хүргүүлж байна.

Франчайзийн төв удирдлага болох БиЖиЭф Ритейл Ко.,Лтд (BGF Retail Co.,Ltd.)-тай 2018 оны 04 сарын 17-ны өдөр байгуулсан Мастер Франчайзийн гэрээний<sup>53</sup> дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт "Ая тухтай" дэлгүүрийн сүлжээ дэлгүүр ажиллуулах эрхийг франчайзийн гэрээгээр бусад этгээдэд олгох эрхийг эзэмшиж байна. Хуулийн дүгнэлт гарах өдрийн байдлаар энэхүү олгогдсон эрхийн дагуу 12 (арван хоёр) хуулийн этгээдэд "CU" ая тухтай дэлгүүрийн сүлжээ дэлгүүр ажиллуулах эрхийг олгосон байна.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материалаас үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь "CU" нэрийн ая тухтай 124 (нэг зүүн хорин дөрвөн) салбар дэлгүүр үйл ажиллагаа явуулах батламжийг үйл ажиллагаа явуулж буй дүүргийн Засаг даргын тамгын газраас 1 (нэг) жилийн хугацаатай авсан бөгөөд "CU" нэрийн ая тухтай 3 (гурван) салбар дэлгүүрийн үйл ажиллагаа улирлын чанартай болон үйл ажиллагаа эхлүүлээгүй байгаа үндэслэлээр батламж хүлээгдэж байгаа болохыг дурдаж байна.

Түүнчлэн Стандарт, хэмжил зүйн газраас 2020 оны 05 сарын 26-ны өдөр "CU" нэрийн ая тухтай дэлгүүрийн хувьд жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээний ерөнхий шаардлага MNS 5021-1:2019 стандартын дагуу (i) Баянгол дүүрэгт №УБД0001911 дугаартай тохирлын гэрчилгээг "CU" нэрийн ая тухтай 16 (арван зургаан) сүлжээ дэлгүүр; (ii) Баянзүрх дүүрэгт №УБД0001915 дугаартай тохирлын гэрчилгээг "CU" нэрийн ая тухтай 16 (арван зургаан) сүлжээ дэлгүүр; (iii) Сүхбаатар дүүрэгт №УБД0001910 дугаартай тохирлын гэрчилгээг "CU" нэрийн ая

<sup>51</sup> Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль (2001).

16.3. Дараах аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд сүм, дүүргийн Засаг дарга тусгай зөвшөөрөл олгоно.



16.3.4. тамхи худалдах.

<sup>52</sup> Тамхины хяналтын тухай хууль (2005).

7.3. Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сүм, дүүргийн Засаг дарга, чөлөөт бүсэд тухайн чөлөөт бүсийн захирагч олгоно.

<sup>53</sup> Master franchise contract between BGF RETAIL CO.,Ltd. CENTRAL EXPRESS CVS LLC and PREMIUM GROUP LLC dated as of April 17,2018.





Нууц баримт  
Эх хувь

түхтай 17 (арван долоон) сүлжээ дэлгүүр; (iv) Чингэлтэй дүүрэгт №УБД0001912 дугаартай тохирлын гэрчилгээг "CU" нэрийн ая түхтай 8 (найман) сүлжээ дэлгүүр; болон (v) Хан-Уул дүүрэгт №УБД0001916 дугаартай тохирлын гэрчилгээг "CU" нэрийн ая түхтай 12 (арван хоёр) сүлжээ дэлгүүрт буюу нийт "CU" нэрийн ая түхтай 69 (жаран есөн) сүлжээ дэлгүүрт 3 (гурван) жилийн хугацаатай тохирлын гэрчилгээ<sup>54</sup> түс түс олгосон байна.

Засгийн газрын тохируулагч агентлаг, Стандарт хэмжил зүйн газрын Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газрын даргын 2021 оны 05 сарын 19-ны өдрийн №08/292 тоот албан бичгээс үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь "CU" ая түхтай 69 (жаран есөн) салбар дэлгүүрийн тохирлын гэрчилгээг эзэмшдэг болохыг тодорхойлсон байна.


Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрөл, батламж, тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээлэл, тэдгээрийн хүчин төгөлдөр байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт №08. "Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн тусгай зөвшөөрөл, тохирлын гэрчилгээ болон хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

#### Зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг

Хуулийн фирмийн зүгээс Үнэт цаас гаргагч нь аливаа зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг эзэмшдэг эсэх, тэдгээр нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн асуудлаар Оюуны өмчийн газраас ирүүлсэн лавлагааг үндэслэн дараах тодорхойлолтыг гаргаж байна.

Оюуны өмчийн газрын 2021 оны 06 сарын 02-ны өдрийн №3/252 тоот тодорхойлолтоос үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн нэр дээр 2019 оны 09 сарын 09-ний өдрийн анхдагчтай дараах 3 (гурван) барааны тэмдэг бүртгэгдэж, эрхийн хамгаалалт хийгдсэн болохыг тодорхойлсон байна.

Хүснэгт №24. "Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн нэр дээр бүртгэгдсэн барааны тэмдэг мэдээлэл."

№	Барааны тэмдэг	Улсын бүртгэлийн дугаар	Анхдагч огноо	Хүчинтэй хугацаа	Холбогдох тушаал, түүний огноо
1.	Хөвсгөр	40-0021539	2019.09.09	2029.09.09	Оюуны өмчийн газрын даргын 2020.03.16-ны №А/53 тоот тушаал
2.		40-0021538	2019.09.09	2029.09.09	Оюуны өмчийн газрын даргын 2020.03.16-ны №А/53 тоот тушаал
3.	Di	40-0021670	2019.09.09	2029.09.09	Оюуны өмчийн газрын даргын 2020.04.16-ны №А/79 тоот тушаал

Оюуны өмчийн газрын 2021 оны 06 сарын 02-ны өдрийн №3/252 тоот тодорхойлолтоос үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь 2020 оны 12 дугаар сард 4 (дөрвөн) барааны тэмдэг, 2021 онд 8 (найман) бүтээгдэхүүний загварын мэдүүлэг гаргасан бөгөөд Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дугаар зүйл<sup>55</sup>, Патентийн тухай хуулийн 11-р

<sup>54</sup> Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний тухай хууль (2017).

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.3-ээ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:


4.1.11. "Тохирлын гэрчилгээ" гэж бүтээгдэхүүн нь тогтоосон шаардлагад нийцсэнийг тодорхойлсон баримт бичгийг ойлгоно.

<sup>55</sup> Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль (2010).

8 дугаар зүйл Барааны тэмдгийн мэдүүлэгт шүүлт хийх

8.2.Төрийн захиргааны байгууллага шүүлтийг барааны тэмдгийн мэдүүлгийн анхдагч огнооноос хойш есөн сарын дотор хийх бөгөөд шаардлагатай гэж үзвэл энэ хугацааг зургаан сар хүртэл хугацаагаар сунгаж болно.





Үнэт цаасны танилцуулга

Нүүц баримт  
Эх хувь

зүйлийн 11.9 дэх<sup>56</sup> хэсэгт зааснаар Төрийн захиргааны байгууллага шүүлтийг барааны тэмдгийн мэдүүлгийн анхдагч огнооноос хойш есөн сарын дотор хийх бөгөөд шаардлагатай гэж үзвэл энэ хугацааг зургаан сар хүртэл хугацаагаар сунгаж бараа тэмдгийг бүртгэх эсэх болон патент олгох эсэх талаар шийдвэр гарах хуулийн зохицуулалтын хүрээнд хүлээгдэж байгаа болохыг дурдаж байна.

Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй барааны тэмдэг нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлын хувьд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг<sup>57</sup> заасны дагуу хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн сангийн 2021 оны 06 сарын 25-ны өдрийн байдлаарх бүртгэлээс хайлт хийж үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй барааны тэмдгийн барьцаатай холбоотой мэдээлэл байхгүй болохыг дурдаж байна.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн нэр дээр бүртгэгдэж, эрхийн хамгаалалт хийгдсэн 3 (гурван) барааны тэмдэг нь хүчин төгөлдөр бөгөөд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн сангийн бүртгэлд үндэслэн Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй барааны тэмдэг нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн нэр дээр олгогдсон үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээгүй байна.

Долоо. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлаар:

Тус асуудлын хүрээнд Үнэт цаас гаргагчийн зүгээс эзэмшил, өмчлөлдөө аливаа төрлийн үнэт цаас буюу үнэт цаасны зах зээлд арилжаалагдах боломжтой санхүүгийн хэрэгсэл эзэмшдэггүй талаар Хуулийн фирмд мэдэгдсэн.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй аливаа үл хөдлөх эд хөрөнгө байхгүй гэдэг мэдээллийг Хуулийн фирмд ирүүлсэн. Тус асуудлын хүрээнд Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн үл хөдлөх эд хөрөнгийн талаар тодруулж холбогдох төрийн эрх бүхий байгууллагаас лавлагаа, тодорхойлолт хүсэж гаргуулж авсан. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 05 сарын 14-ний өдрийн №11 тоот Эд хөрөнгө бүртгэлтэй эсэх лавлагаанаас үзвэл тус компанийн өмчлөлд аливаа үл хөдлөх эд хөрөнгө бүртгэгдээгүй талаар тодорхойлсон байна.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх<sup>58</sup> эзэмшдэггүй талаарх мэдээллийг Хуулийн фирмд ирүүлсэн. Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны

<sup>56</sup> Патентын тухай хууль (2006).

11 дүгээр зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт шүүлт хийх

11.9.Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 9 сарын дотор шүүлтийн дүгнэлтийг үндэслэн патент олгох эсэх талаар шийдвэр гаргана.

<sup>57</sup> Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль (2015).

7 дугаар зүйл.Барьцааны зүйл

7.1.Иргэний гүйлгээнээс хасагдаагүй бүсдын өмчлөлд шилжүүлж болох бодитой байгаа, эсхүл ирээдүйд бий болох хөдлөх эд хөрөнгө, бүх төрлийн хувьцаа, үнэт цаас, шаардах эрх, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүх төрлийн бүтээл, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, ашигтай загвар болон бүсэд хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө нь барьцааны зүйл байж болно.

<sup>58</sup> Газрын тухай хууль (2002).

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо


3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доо дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."газар" гэж газрын гадаргуу, түүний хөрс, ой, ус, ургамал бүхий орон зайн дэвхаргыг;

3.1.2."газар өмчлөх" гэж тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг;

3.1.3."газар эзэмших" гэж газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг;





Нууц баримт  
Эх хувь

2021 оны 06 сарын 14-ний өдрийн №02-06/3829 тоот лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч нь Нийслэлийн Засаг даргын захирамжаар газар ашиглуулж, эзэмшүүлсэн эрхийн бүртгэл газрын мэдээллийн сангийн "Лэнд менежер" программд бүртгэлгүй болохыг тодорхойлсон байна.

Үнэт цаас гаргагчийн тээврийн хэрэгслийн хувьд Автотээврийн үндэсний төвийн 2021 оны 06 сарын 15-ны өдрийн Тээврийн хэрэгслийн лавлагаанаас үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн нэр дээр 3 (гурван) тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгааг тодорхойлсон байна. Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслүүд нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлын хувьд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн сангийн бүртгэлээс<sup>59</sup> үзвэл Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн барьцаатай холбоотой мэдээлэл байхгүй болохыг дурдаж байна. Үнэт цаас гаргагчийн зүгээс тээврийн хэрэгслийг аливаа үүргийн гүйцэтгэлд барьцаалсан эсэх талаар аливаа мэдээллийг Хуулийн фирмд мэдээлээгүй бөгөөд барьцаа, батлан даалт зэрэг үүргээс ангид байгаа талаар мэдээлэл өгсөн. Эдгээр мэдээлэл дээр үндэслэн Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн өмчлөл, эзэмшилд байгаа тээврийн хэрэгсэл нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй байна гэж үзлээ.

Хуулийн фирмийн зүгээс өмчлөх эрхийг баталгаажуулах боломжгүй бусад хөрөнгийн хувьд тусгайлан дүгнэлт хийгээгүй бөгөөд шалгуур асуултын хүрээнд Үнэт цаас гаргагчийн эзэмшиж байгаа эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлаар холбогдох баримт материал, төрийн эрх бүхий байгууллагын баримт материал дээр үндэслэн дүн шинжилгээ хийсэн болохыг дурдаж байна. Түүнчлэн өмчлөх эрхийг баталгаажуулах боломжгүй бусад хөрөнгө болон Гэрэг эстимэйт ХХК-ийн Хөрөнгийн үнэлгээний тайлан болон Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайланд тусгагдсан хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг баталгаажуулах боломжгүй тул хөрөнгөтэй холбоотой асуудлаар Үнэт цаас гаргагчаас тодруулж асууна үү.

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн эзэмшил/өмчлөлд байгаа дурдсан хөрөнгө өмчлөх эрх хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах нөхцөл байдал үүсээгүй, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээгээгүй байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.

**Найм. Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх асуудлын хувьд үзвэл:**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг энэ хуулийн 33.2.1-д заасан хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг энэ хуулийн 33.2.3-т заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна" гэж заасны дагуу тус Хуулийн фирм нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллүүдийг нягталж нийтэд илэрхий мэдээ баримт, төрийн болон эрх бүхий байгууллагуудаас гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолтууд, Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргаж өгсөн баримт бичигт харьцуулсан дүн шинжилгээ хийсэн.

Хуулийн фирм нь тэргүүлэх андеррайтер компани болох Голомт Капитал ҮЦК ХХК, Аликс капитал ҮЦК ХХК-ийн бэлтгэсэн Үнэт цаасны танилцуулгатай танилцаж дүн шинжилгээ хийсэн бөгөөд Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий Үнэт цаас гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, хуулийн этгээдийн үлсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн он, сар, өдөр, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хувь хэмжээ, Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, зарласан болон гаргасан үнэт цаасны тоо, төрөл,

3.1.4. "Газар ашиглах" гэж хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэхийг;

<sup>59</sup> <https://mpc.gov.mn/research>





Нүүц баримт  
Эх хувь

нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ, нийтэд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүргийн талаарх мэдээлэл нь Хуулийн фирмд Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргаж өгсөн баримттай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна гэж үзлээ.

Эдгээр дурдсан хууль зүйн ач холбогдолтой мэдээллээс бүсэд Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлт, борлуулалтын хэмжээ, ашиг, алдагдал зэрэг бизнесийн үйл ажиллагаа, Энэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тухай болон Үнэт цаас гаргагчийн зах зээлийн төлөвлөгөө зэрэг агуулагдсан эдийн засгийн ерөнхий мэдээлэл, салбарын үзүүлэлт, Үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд ил, тодорхой үйл баримт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тусгагдсан баталгаажуулах боломжгүй тоон үзүүлэлт болон хараат бус байгууллагуудын хийсэн дүн шинжилгээ, санхүүгийн тооцоолол, нийтэд санал болгож байгаа үнэт цаасыг арилжих нөхцөл, журам, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр зэрэг мэдээлэлд Хуулийн фирмийн зүгээс дүн шинжилгээ хийгээгүй болохыг дурдаж байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр байна гэж Хуулийн фирм дүгнэж байна.

**Ес. Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийн хувьд үзвэл:**

Компанийн тухай хуулийн зохицуулалтын дагуу компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг санал хураалтаар шийдвэрлэхэд энгийн хувьцаа эзэмшигч саналын нэг эрхтэй оролцдог үндсэн зохицуулалттай байдаг<sup>59</sup>. Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийг тодорхойлох асуудлын хүрээнд Хуулийн фирм нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдэгдэж байгаа аливаа асуудлаар саналын давуу эрхтэй, эцсийн шийдвэрийг гаргахад саналын давуу эрхээрээ шүүд нөлөөлөх боломжтой хувьцаа эзэмшигчийг жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгч этгээд гэж тооцож авч үзэж тогтоохыг зорьсон.

Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн дүрмээс үзвэл 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 679,807,674 (зургаан зуун далан есөн сая найман зуун долоон мянга зургаан зуун далан дөрвөн) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 67,980,767,400 (жаран долоон тэрбум есөн зуун наян сая долоон зуун жаран долоон мянга дөрвөн зуун) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бөгөөд дараах 9 (есөн) этгээд эзэмшиж байна. Үүнд:

Хүснэгт №25. Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувьцааны тоо хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц.

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо (ширхгээр)	Нийт дүн (төгрөгөөр)	Хувь хэмжээ
1.	А.Ганхуяг	235,408,889	23,540,888,900	34.64%
2.	А.Ганболд	172,327,784	17,232,778,400	25.35%
3.	Ц.Баяржаргал	88,164,258	8,816,425,800	12.97%

<sup>59</sup> Компанийн тухай хууль (2011).

59.1 дүгээр зүйл.Хувьцаа эзэмшигчдийн хурал

59.1.1 Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

63 дугаар зүйл.Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох

63.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг санал хураалтаар шийдвэрлэхэд энгийн хувьцаа эзэмшигч энэ хуулийн

34 дүгээр зүйлд, давуу эрхийн хувьцаа эзэмшигч энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан саналын эрх эдэлнэ.

63.2.Хуульд өөрөөр заагаагүй бол нэг хувьцаа саналын нэг эрхтэй байна.

34 дүгээр зүйл.Компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн эрх


34.1.Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:

34.1.1 хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;

34.1.2 давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараагаар компанийн төлөөлөн удирдах зөвлөл/байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-өөс тогтоосон хэмнээгээс ногдол ашиг авах;

34.1.3 компанийг татан буулгах үед энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдансаас олсон орлогоос хувь хүртэх.





Нууц баримт  
Эх хувь

4.	А.Одончимэг	32,304,463	3,230,446,300	4.75%
5.	А.Ганбаатар	31,248,463	3,124,846,300	4.60%
6.	О.Батмөнх	19,731,751	1,973,175,100	2.90%
7.	Г.Бат-Эрдэнэ	19,731,751	1,973,175,100	2.90%
8.	Ө.Мөнхбаяр	12,909,548	1,290,954,800	1.90%
9.	БиЖиЭф Ритейл Ко., Лтд (BGF Retail Co.,Ltd.)	67,980,767	6,798,076,700	9.99%
	<b>Нийт</b>	<b>679,807,674</b>	<b>67,980,767,400</b>	<b>100.00%</b>

Хүснэгт дэх хувьцаа эзэмшигчдийн хувь эзэмшлийн бүтцээс үзвэл Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт энгийн хувьцааны 34.64 хувьд ногдох хувьцааг Монгол Улсын иргэн А.Ганхуяг эзэмшиж байна.

Улсын бүртгэлийн газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2021 оны 06 сарын 23-ны өдрийн №08398 тоот дэлгэрэнгүй лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт энгийн хувьцааны 34.64 хувьд ногдох хувьцааг эзэмшигч Монгол Улсын иргэн А.Ганхуяг эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн байна.

Иймд дээр дурдсан мэдээлэлд үндэслэж үзвэл Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь Монгол Улсын иргэн А.Ганхуяг гэж хувь хүн байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.

Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх асуудлын хувьд үзвэл:

Хуулийн фирм нь Компаниас сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд буюу 2018 оны 05 сарын 01-ний өдрөөс 2021 оны 05 сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд гадаадын болон Монгол Улсын арбитр, шүүхэд Компани хэргийн оролцогчоор оролцсон болон оролцож байгаа эсэх талаар төрийн байгууллагаас ирүүлсэн лавлагааны хариу болон Компаниас ирүүлсэн материал дээр үндэслэн хэрэг маргааны шалтгаан, хүлээгдэж буй үр дүнд хуулийн дүн шинжилгээ хийлээ.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын 2021 оны 05 сарын 21-ний өдрийн №4/704 тоот тодорхойлолтоос үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь тус арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй болохыг тодорхойлсон байна.

Улаанбаатар хотын Худалдааны танхимын дэргэдэх Арбитрын 2021 оны 05 сарын 21-ний өдрийн №GS-21-24 тоот тодорхойлолтоос үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь сүүлийн 3 жилийн байдлаар арбитрын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй болохыг тодорхойлсон байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архивын 2021 оны 05 сарын 21-ний өдрийн №1/8192 тоот тодорхойлолтоос үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь сүүлийн 3 жилийн байдлаар Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байгаагүй болохыг тодорхойлсон байна.

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 05 сарын 19-ний өдрийн №3476 тоот албан бичгээс үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Сүхбаатар дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Ц.Идэрбатад холбогдох захиргааны хэрэгт нэхэмжлэгчээр оролцож байсан болохыг тодорхойлсон байна.

Дээр дурдсан хэргийн талаар авч үзвэл Компани нь Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Сүхбаатар дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн эрүүл ахуй, халдвар хамгааллын



үлсын байцаагч Ц.Идэрбатын 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн №0066957 дугаар зөрчилд шийтгэл оногдуулах тухай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг 2019 оны 12 сарын 11-ний өдөр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан байна. Нэхэмжлэлийн шаардлагыг товч тодруулбал Компани нь үлсын байцаагч Ц.Идэрбат нь "CU" конвениенс сүлжээ дэлгүүрийн тодорхой салбарт шалгалт явуулж, хотдог, нэрийн хоол үйлдвэрлэж, худалдаалах үйл ажиллагаа явуулахдаа Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын №156 дугаар тушаалаар батлагдсан Эрүүл ахуй болон үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх зөвлөмжийг зөрчиж бүтээгдэхүүнд дээж авдаггүй, дээжийн хөргөгч, дээжийн бүртгэл хөтөлдөггүй гэсэн зөрчил гаргасан үндэслэлээр зөрчлийн хэрэг үүсгэн, шалгаж зөрчилд шийтгэл оногдуулсан нь үндэслэлгүй байна гэж үзсэн байна. Учир нь "CU" конвениенс сүлжээ дэлгүүр нь хүнсний үйлдвэрлэл явуулдаггүй, зөвхөн үйлдвэрлэгчээс бүрэн боловсруулалт хийсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан, шинжилгээтэй бүтээгдэхүүнийг худалдаалдаг онцлогтойгоороо үйлдвэрлэл үйлчилгээний газраас ялгаатай гэж голлох үндэслэлээ гаргасан хэдий ч Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс 2020 оны 02 сарын 14-ний өдөр шийдвэр гарч нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, улмаар 2020 оны 03 сарын 17-ны өдөр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын нэр томьёо, тодорхойлолт MNS 6777:2019 стандартын 3 дугаар зүйлийн 3.10 дахь хэсэгт заасны дагуу "CU" конвениенс сүлжээ дэлгүүр нь түргэн хоолны газрын үйл ажиллагааг явуулдаг гэж үзэхээр байх тул Компани нь Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрийн 8 дугаар зүйлийн 8.3-д заасан бүтээгдэхүүний дээжийг журмын дагуу авч, зориулалтын хөргөгчид 400С температурт 48 цаг хадгалах, хоолны дээж авалтын бүртгэлийг хөтөлж, дээжийн савыг ариутгаж хэвшинэ гэснийг дагаж мөрдөж үндэслэлтэй байна гэж үзжээ.

Үнэт цаас гаргагч нь дээр дурдсан Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр болон Захиргааны хэргийн давж заалдах шатны магадлалд заасныг хэрэгжүүлж, үлсын байцаагчийн шийтгэлийн хуудсанд заасан 3,000,000 (гурван сая) төгрөгийн торгуулийг төлж, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 04 сарын 20-ний өдрийн №А/20-15 тоот тушаалаар сүлжээ дэлгүүрээр худалдаалагдаж буй хотдог, сэндвич бүтээгдэхүүнээс 2020 оны 04 сарын 21-ний өдрөөс эхлэн дээж авахыг дэлгүүрийн менежерүүдэд үүрэг болгож, дээж авах аргачлалыг баталсан байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч нь тасалбар болгосон өдрийн байдлаар 1 (нэг) захиргааны хэрэгт нэхэмжлэгчээр оролцож Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн байна. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн тул Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь шүүхийн шийдвэр, магадлалыг хэрэгжүүлж үлсын байцаагчийн шийтгэлийн хуудсанд дурдсан торгуулийг төлж, холбогдох зөрчлийг арилгаж, үйл ажиллагаандаа холбогдох дүрэм, журмыг мөрдөн ажилласан байна.


Үнэт цаас гаргагч нь тасалбар болгосон өдрийн байдлаар аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэгт татагдаж байгаагүй, аливаа иргэний хэрэг, маргаанд нэхэмжлэгч, хариуцагч, гүрвэгчид этгээдээр оролцож байгаагүй болохыг дурдаж байна.

Үнэт цаас гаргагч нь татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт болон бусдын өмнө хүлээсэн өр төлбөртэй эсэх асуудлын хувьд үзвэл:

Түүнчлэн Хуулийн фирм нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх болон бусдын өмнө хүлээсэн өр төлбөртэй эсэх асуудлыг нягталж харьяа төрийн эрх бүхий байгууллагаас дэлгэрэнгүй лавлагаа, тодорхойлолт гаргуулан авлаа. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий байгууллагаас авсан лавлагаа,







Нууц баримт  
Эх хувь

тодорхойлолтыг Хавсралт №09. "Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-тай холбогдуулан эрх бүхий байгууллагаас авсан хөндлөнгийн лавлагаа, тодорхойлолт" хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү. Үүнд:

Монголын татварын албаны 2021 оны 07 сарын 10-ны өдрийн №21.1003.fca35f56-07b8-4d1f-8ab2-67f746fae7ba тоот цахим лавлагаа, тодорхойлолтоос үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь 66,709,894.97 (жаран зургаан сая долоон зуун есөн мянга найман зуун ерэн дөрвөн төгрөг ерэн долоон мөнгө) төгрөгийн илүү төлөлттэй бөгөөд татварын өр төлбөргүй болохыг тодорхойлсон байна.

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 05 сарын 25-ны өдрийн №1/198 тоот лавлагаанаас үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь тус даатгалын хэлтэс бүртгэлтэй бөгөөд 1,133 (нэг мянга нэг зуун гучин гурван) даатгуулагчтай, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй болохыг тодорхойлсон байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Шийдвэр гүйцэтгэх албаны 2021 оны 05 сарын 21-ний өдрийн №0012618 тоот тодорхойлолтоос үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй болохыг тодорхойлсон байна.

Гаалийн ерөнхий газрын 2021 оны 05 сарын 20-ны өдрийн №01-2/1255 тоот тодорхойлолтоос үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь Гаалийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй болохыг тодорхойлсон байна.

Гаалийн ерөнхий газрын 2021 оны 05 сарын 27-ны өдрийн №03-1/1297а тоот тодорхойлолтоос үзвэл Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь гаалийн байгууллагад татварын өргүй болохыг тодорхойлсон байна.

Иймд дээр дурдсан төрийн эрх бүхий байгууллагын лавлагаа, тодорхойлолтод үндэслэн Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт болон бусдад төлөх өр төлбөргүй болохыг Хуулийн фирмээс уламжилж байна.

#### Нэгдсэн дүгнэлт

Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журамд тогтоосон шалгуурыг хангаж байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.

Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах замаар компанийн хэлбэрийг өөрчлөн нээлттэй хувьцаат компани болохыг Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн тохиолдолд энэхүү Хуулийн дүгнэлтэд тусгасан хувьцаат компанийн хувьд хуулиар тогтоосон нөхцөл, журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

-----ooOoo-----








Нүүд баримт  
Эх хувь



Үнэт цаасны танилцуулга



### Хариуцлага хязгаарлах тухай

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаанд бүхэлд нь өгсөн үнэлэлт, дүгнэлтэд тооцогдохгүй бөгөөд зөвхөн нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргахтай холбогдуулан төрийн байгууллагын тавьсан шаардлагын хүрээнд буюу дээр дурдагдсан асуудлуудын хүрээнд хязгаарлагдана.

Энэхүү Хуулийн дүгнэлтийг Компанийн хүсэлтээр, түүнээс тодорхойлсон ажлын даалгаврыг үндэслэн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд Үнэт цаас гаргагчийн нэр дээр хаяглан хүргүүлсэн болно. Үнэт цаас гаргагч, түүнээс эрх олгогдсон этгээдийн зөвшөөрөлгүйгээр энэхүү Хуулийн дүгнэлтийг бүхэлд нь болон хэсэгчлэн салган авч ашиглах, түгээх, дамжуулахыг хориглоно.


Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК, түүний холбоо, хамааралтай этгээд, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан энэхүү Хуулийн дүгнэлтийг харилцан тохиролцсоноос бусад зорилгоор ашигласан, түгээсэн, бусдад танилцуулсан, тайлбарласан, хэсэгчлэн задруулсан, нийтэд ил болгосноос үүсэх асуудлаар Хуулийн фирм хариуцлага хүлээхгүй бөгөөд энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа болон анх удаа нийтэд санал гаргаж буй үнэт цаасанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй.

Хуулийн фирм нь хараат бус байх, гаргаж өгсөн баримт материалын хүрээнд дүн шинжилгээ хийх зарчмыг баримтлан хөндлөнгийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн тул дүн шинжилгээнд хамруулах шаардлагатай чухал үйл баримт, Компаниас орхигдуулсан аливаа бусад гол баримт, материал, бүрүү дугуу, худал мэдээлэл гаргаж өгсөн, дүн шинжилгээ хийхэд ашигласан лавлагаа, тодорхойлолт бусад баримт материалд дурдагдсан хууль зүйн ач холбогдолтой аливаа нөхцөл, байдал дүн шинжилгээ хийснээс хойш Хуулийн фирмд мэдэгдэлгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн гарах аливаа асуудлаар хариуцлага хүлээхгүй болно.

ХҮНДЭТГЭСЭН,

НӨХӨРЛӨЛИЙН ГИШЭЭН Г.БАТБЯАР





## 6.17 Хуулийн дүгнэлтийн нэмэлт тодруулга



**ӨМГӨӨЛЛИЙН  
БАТБАЯР ЭНД  
ПАРТНЭРС ХХН**

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР КОТ-14253, СУХБААТАР ДҮҮРЭГ, 1-Р ХЭРЭО, ЧИНГЭСНИЙ ОРГОН ЧӨЛӨӨ-15, МОНГОЛ ТЭ ЦАХИЛАГ, 16-Р ДАВХАР, 1001-1003, УТАС/ФАКС: (976) 7711-9006, ЦАХИМ ШУУДАН: CONTACT@BNP.MN, ЦАХИМ ХАЛГА: WWW.BNP.MN

2021.08.25 № 113/21

танай \_\_\_\_\_-ны/ний № \_\_\_\_\_-т

### Хууль зүйн нэмэлт дүгнэлт хүргүүлэх тухай

СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК  
ЭРХЭМ ТАНАА

Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-аас 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдөр Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-д ирүүлсэн №01/329 тоот "Нэмэлт баримт бичиг ирүүлэх тухай" албан бичигтэй холбогдуулан дараах тодруулга, хууль зүйн нэмэлт дүгнэлтийг хүргүүлж байна. Үүнд:

Хуулийн фирм нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-тай 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөр Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан тул хуулийн дүгнэлт гаргах тасалбар болгох хугацааг 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл байхаар тооцож, хуулийн дүгнэлт гаргахад шаардлагатай гэрээ, хэлцэл, баримт материалыг 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөр Компаниас гаргуулан авч хуулийн дүгнэлт гаргасан билээ. Хуулийн дүгнэлт гаргах тасалбар болгосон хугацаатай холбоотойгоор Хуулийн дүгнэлт болон Үнэт цаасны танилцуулгад орсон бусад мэдээллийн хувьд бага зэргийн зөрүү үүссэнийг доорх байдлаар тодруулан хүргүүлж байна.

### 1. Үнэлгээний тайланд дурдсан хэдий ч хуулийн дүгнэлтэд ороогүй 5 (таван) нэгж газрын эзэмших эрхийн бүртгэлийн тухайд:

Хуулийн фирм нь дээрх асуудлаар Үнэт цаас гаргагчаас тодруулж, баримт материалыг гаргуулан авахад Премиум Дистрибьюшн ХХК нь Гэр хөгжил дэвшил ХХК нэрээр үүсгэн байгуулагдаад хуулийн этгээдийн оноосон нэрийг Премиум Дистрибьюшн ХХК болгон өөрчилснийг 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлсэн байна. Хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн хэдий ч газар эзэмших эрхийн гэрчилгээ, эзэмшигчийн бүртгэлд холбогдох өөрчлөлт ороогүй байсан тул Гэр хөгжил дэвшил ХХК-ийн нэрээр дор дурдсан газар эзэмших эрхийн гэрчилгээг Премиум Дистрибьюшн ХХК-аас Хуулийн фирмд нөхөж ирүүлээ. Үүнд:

- Улаанбаатар хот, Налайх дүүргийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн №А/161 дугаартай шийдвэрээр олгогдсон, эрхийн улсын бүртгэлийн №Э-2207000180 дугаартай, нэгж талбарын №1260110144 дугаар бүхий 10000 м2 газар;
- Улаанбаатар хот, Налайх дүүргийн Засаг даргын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн №А/316 дугаартай шийдвэрээр олгогдсон, эрхийн улсын бүртгэлийн дугаар №Э-2207000180 дугаартай, №1260110489 нэгж талбарын дугаар бүхий 10000.0 м2 газар.

Хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөнөөр тухайн компанийн санхүү байдлын тайлан, биет болон биет бус хөрөнгөд өөрчлөлт ордоггүй тул дээр дурдсан эзэмших эрх бүхий газрууд нь Гэр хөгжил дэвшил ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй байгаа нь хууль, эрх зүйн хувьд яарчилтэй гэж үзэх үндэслэлгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.



Үнэлгээний тайланд орсон бусад 3 (гурван) эзэмших эрх бүхий газрын хувьд Хуулийн дүгнэлтэд дурдсан тасалбар болгосон өдөр болох 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хойш 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Премиум Дистрибьюшн ХХК нь Ёлын цом ХХК-тай Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ байгуулж, дор дурдсан газар эзэмших эрхийг шилжүүлэхээр талууд харилцан тохиролцсон байна. Үүнд:

- Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн №А/174 тоот шийдвэрээр олгогдсон, эрхийн улсын бүртгэлийн №Э-2204005907 дугаартай, нэгж талбарын 1333102754 дугаартай Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо, Хонхор цэргийн холбооны сургуулийн баруун талд байрлах, худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай, 19980 м.кв газар;
- Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн №А/84 тоот шийдвэрээр олгогдсон, эрхийн улсын бүртгэлийн №Э-2204005010 дугаартай, нэгж талбарын 1333106697 дугаартай, Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо, Хонхор хаягт байрлах, үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газрын зориулалттай, 6999 м.кв газар;
- Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн №А/84 тоот шийдвэрээр олгогдсон, эрхийн улсын бүртгэлийн №Э-2204005150 дугаартай, нэгж талбарын 1333105199 дугаартай, Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо, Хонхор, Цэргийн холбооны сургуулийн урд тал хаягт байрлах, худалдаа, үйлчилгээний зориулалттай, 180 м.кв газар.

Премиум Дистрибьюшн ХХК болон Ёлын цом ХХК нарын хооронд байгуулсан Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ нь эрх шилжүүлэх гэрээний гол нөхцөлийг тусгасан, агуулгын хувьд хуульд харшилсан зүйлгүй, бичгээр байгуулагдаж, нотариатаар баталгаажуулсан, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.1 дэх хэсэгт<sup>1</sup> заасан шаардлагыг хангасан хүчин төгөлдөр гэрээ байна. Премиум Дистрибьюшн ХХК-аас ирүүлсэн мэдээллээс үзвэл дээр дурдсан газар тус бүрийн эзэмших эрхийг Ёлын цом ХХК-аас шилжүүлэн авахаар гэрээ болон холбогдох бусад баримт, материалыг Баянзүрх дүүргийн Газрын албанд хүргүүлсэн байна. Одоогоор эдгээр газрын эзэмших эрхийн гэрчилгээ Премиум Дистрибьюшн ХХК-ийн нэр дээр шилжүүлэх бүртгэлийн ажиллагаа хийгдэж байна.

## 2. Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх тухайд:

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалтад "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шүүд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй) болон 87 дугаар зүйлийн 87.1.2 дахь заалтад "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шүүд холбоотой хэд хэдэн гаргалт"-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна.

<sup>1</sup> Газрын тухай хууль.

38 дугаар зүйл. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх

38.2 Эрхийн гэрчилгээг шилжүүлэх үүсгэлийг талууд тэрхүү бөгөөд дараахь баримт бичгийг харуулагдана:

38.2.1. Нотариатаар гэрчилгээг гэрээ;

38.2.2 Эрхийн гэрчилгээг шилжүүлэх гэрээ байгаа өгөгдөл нь ул эрхийн гэрчилгээг шилжүүлэн авахаар үүсэх эрх үзэсгэлэний бүрэн гүйцэтгэлтэй байгаа тухай нотолгоо;

38.2.3 Албан татаар, хуралын төлсөн тухай баримт;

38.2.4 Татаарын албанд татаар татагчид бүртгүүлсэн тухай цахим эсхүл хэвлэмэл мэдээллийн гэрээ.



Үнэт цаас гаргагчийн дүрмийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтад "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалхтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шүүд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй)" болон 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтад "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шүүд холбоотой хэд хэдэн гаргалт"-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна.

Үнэт цаас гаргагч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-аас Хуулийн фирмд ирүүлсэн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангаас балансын нийт актив<sup>2</sup> болон балансын активын 25 хувийн дүнг тооцож үзвэл дараах хэмжээтэй байна. Үүнд:

**Хүснэгт №22: Балансын активын 25%-ийн тоон үзүүлэлт.**

№	Гэрээний нэр, төрөл	Тухайн улирлын балансын нийт актив (төгрөгөөр)	Тухайн улирлын балансын активын 25% (төгрөгөөр)
1.	2018 оны 1 улирал	1,142,976,782	285,744,195
2.	2018 оны 2 улирал	4,221,316,497	1,055,329,124
3.	2018 оны 3 улирал	7,694,001,308	1,923,500,327
4.	2018 оны 4 улирал	11,737,476,615	2,934,369,154
5.	2019 оны 1 улирал	27,272,821,996	6,818,205,499
6.	2019 оны 2 улирал	34,720,056,971	8,680,014,243
7.	2019 оны 3 улирал	39,678,300,706	9,919,575,176
8.	2019 оны 4 улирал	38,928,864,498	9,732,216,124
9.	2020 оны 1 улирал	39,597,529,939	9,899,382,485
10.	2020 оны 2 улирал	41,254,795,216	10,313,698,804
11.	2020 оны 3 улирал	51,101,490,694	12,775,372,674
12.	2020 оны 4 улирал	57,097,014,272	14,274,253,568
13.	2021 оны 1 улирал	58,249,231,488	14,562,307,872

Дээрх хүснэгтэд тусгагдсан Үнэт цаас гаргагчийн хэлцэл хийхийн өмнөх балансын сүүлийн балансын активын 25 хувийн дүн болон Компаниас ирүүлсэн гэрээ, хэлцэл, мэдээлэлд үндэслэж үзвэл Компани нь дурдсан хугацааны дотор их хэмжээний 2 (хоёр) хэлцлийг байгуулсан. Үүнд:

**Компанийн Голомт банк ХХК-тай 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээ**

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь хөрөнгө оруулалтын зориулалтаар Голомт банк ХХК-аас 20,000,000,000 (хорин тэрбум) төгрөгийг, жилийн Монгол банкны бодлогын хүү дээр нэмэх 5 (таван) хувийн хүүтэй, 60 (жаран) сарын хугацаатайгаар зээлэхээр, Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээг байгуулсан нь байна.

Үнэт цаас гаргагчаас Голомт банк ХХК-тай дээр дурдсан зээлийн гэрээг байгуулах асуудлаар Премиум групп ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн №12 тоот тогтоолоор их хэмжээний хэлцэл байгуулах зөвшөөрөл олгосон байна.


Компаниас ирүүлсэн балансын активын тоон үзүүлэлттэй харьцуулан үзэхэд Компанийн Голомт банк ХХК-тай байгуулсан дээр дурдсан зээлийн гэрээ нь Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх хэсэгт заасан их хэмжээний хэлцэл байх бөгөөд Үнэт цаас гаргагч нь

<sup>2</sup> "Балансын нийт актив" гэдэгт Санхүү байдлын тайлангийн 2.4 дэх мөр /хэвтээ үзүүлэлт/ буюу "Өр төлбөр ба Бэдийнэмч" гэсэн үзүүлэлтийн эцсийн үлдэгдэл гэсэн харгалзах Балансад /босоо үзүүлэлт/ байгаа мөнгөн хөрөнгийг тооцож ойлгосон болно. Хуулийн өөрөө.









(гурван тэрбум арван дөрвөн сая хоёр зуун гучин долоон мянга найман зуун арван хоёр) воныг Компани нь гэрээний хугацаанд төлөхөөр талууд харилцан тохиролцсон байна.

Компаниас ирүүлсэн балансын активын тоон үзүүлэлттэй харьцуулан үзэхэд Компанийн БиЖиЭф Ритэйл Ко.,Лтд-тэй байгуулсан дээр дурдсан зээлийн гэрээ нь Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх хэсэгт заасан их хэмжээний хэлцэл байх бөгөөд Үнэт цаас гаргагч нь зээлийн гэрээг байгуулахдаа Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлд<sup>4</sup> заасны дагуу Сэнтрал Экспресс Си Ви ЭС ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгогдсон, хууль тогтоомжийн дагуу хийгдсэн байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

**3. 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг хувьцаа нэмж гаргах замаар өсгөсөнтэй холбоотой хууль зүйн нэмэлт дүгнэлтийг дараах байдлаар хүргүүлж байна.**

Сэнтрал Экспресс Си Ви ЭС ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн №4 тоот шийдвэрээр (i) Компанийн 16,232,540,400 (арван зургаан тэрбум хоёр зуун гучин хоёр сая таван зуун дөчин мянга дөрвөн зуун) төгрөгийн зээлийг хувьцаа эзэмшигч Премиум Групп ХХК-д шилжүүлж, тус шилжүүлсэн дүнгээр хувьцаа нэмж гарган Премиум Групп ХХК-д эзэмшүүлсэн (ii) Компанийн "CU" олон улсын сүлжээ конвениенс дэлгүүрийн төсөлд Премиум Групп ХХК-аас хөрөнгө оруулалт хэлбэрээр оруулсан 19,795,024,500 (арван есөн тэрбум долоон зуун ерэн таван сая хорин дөрвөн мянга таван зуун) төгрөгийн дүнгээр Компанийн хувьцааг нэмж гарган Премиум Групп ХХК-д эзэмшүүлсэн (iii) Премиум Групп ХХК нь өөрийн 100 эзэмшлийн охин компани буюу Компанийн хоолны үйлдвэрлэл түгээлтийн үйл ажиллагааг эрхлэн явуулдаг Премиум Дистрибьюшн ХХК-ийг Компанийн 100 хувийн охин компани болгож, Премиум Групп ХХК-аас Премиум Дистрибьюшн ХХК-д оруулсан 7,724,395,814 (долоон тэрбум долоон зуун хорин дөрвөн сая гурван зуун ерэн таван мянга найман зуун арван дөрвөн) төгрөгийн дүнгээр Компанийн хувьцааг нэмж гарган Премиум Групп ХХК-д эзэмшүүлж, нийт 43,751,960,700 (дөчин гурван тэрбум долоон зуун тавин нэгэн сая есөн зуун жаран мянга долоон зуун) төгрөгт Компанийн нэгж бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 437,519,607 (дөрвөн зуун гучин долоон сая таван зуун арван есөн мянга зургаан зуун долоон) ширхэг энгийн хувьцааг нэмж гарган Премиум групп ХХК-д эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.2 дахь хэсэгт<sup>5</sup> компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцааг гаргах тохиолдолд энэ нь их хэмжээний хэлцэлд тооцогдохоор зохицуулсан байна. Компани нь энэхүү хэлцэл хийгдэхээс өмнө буюу Сэнтрал Экспресс Си Ви ЭС ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн 2019 оны 10 дугаар сарын 31-ний

<sup>4</sup> Компанийн тухай хууль.


<sup>5</sup> 88 дугаар зүйл. Их хэмжээний хэлцэл хийх

- 88.1 Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг төлөөлөн үдирдах зөвлөл/байгуул бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ санал нэгтгэйгээр гаргана;
- 88.2 Төлөөлөн үдирдах зөвлөл их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтгэй гарган чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхээр шийдвэрлэнэ.
- 88.3 Их хэмжээний хэлцэл хийх асуудлаар эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч нь энэ хуулийн 53 дугаар зүйлд заасан журмын дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрхтэй.
- 88.4 Иргэдийн нь тухайн тайлангийн сүлжээнд хийгдсэн их хэмжээний хэлцэл, түүний үнэ зэргийг үлирал, жилийн тайлангийн тодруулгад тусгах замаар нийтэд мэдээлэх эрхтэй.


<sup>5</sup> 87 дугаар зүйл. Их хэмжээний хэлцэл

- 87.1 Их хэмжээний хэлцэлд дараах хэлцлийг тооцно:
- 87.1.1 хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн зэгийг худалдаж, худалдан авах, захиран зарцуулах болон бэрхцээлтэй холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шүүд холбоотой хэд хэдэн хэлцэл/компанийн өдөр тутмын индсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамрааваггүй/;
- 87.1.2 Компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хоонох үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шүүд холбоотой хэд хэдэн гаргалт.





Үнэт цаасны танилцуулга



өдрийн №1 тоот шийдвэрээр Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 9.99%-тай тэнцэх хэмжээний энгийн хувьцааг нэмж гаргаснаар нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 171,452,555 (нэг зуун далан нэгэн сая дөрвөн зуун тавин хоёр мянга таван зуун тавин таван) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 17,145,255,500 (арван долоон тэрбум нэг зуун дөчин таван сая хоёр зуун тавин таван мянга таван зуун) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болсныг хүүлийн этгээдийн улсын бүртгэлд 2019 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр бүртгүүлсэн байна.

Иймд Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн №4 тоот шийдвэрээр 43,751,960,700 (дөчин гурван тэрбум долоон зуун тавин нэгэн сая есөн зуун жаран мянга долоон зуун) төгрөгт нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 437,519,607 (дөрвөн зуун гучин долоон сая таван зуун арван есөн мянга зургаан зуун долоон) хувьцааг нэмж гаргасан холбоо бүхий дээр дурдсан хэлцлүүд нь Компанийн тухай хүүлийн 87 дугаар зүйлийн 87.1.2 дахь хэсэгт заасан их хэмжээний хэлцэл байх бөгөөд Компанийн тухай хүүлийн 88 дугаар зүйлд<sup>6</sup> заасны дагуу Сэнтрал Экспресс Си Ви ЭС ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор тус их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгогдсон, хууль тогтоомжийн дагуу хийгдсэн байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Энэхүү Хууль зүйн нэмэлт дүгнэлт нь Хуулийн фирмийн 2021 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн дугаар №BNP-111/21 тоот "Сэнтрал Экспресс Си Ви ЭС ХХК-ийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдуулан бэлтгэсэн хуулийн дүгнэлт"-ийн салшгүй хэсэг болно.

ХҮНДЭТГЭСЭН,

НӨХӨРЛӨЛИЙН ГИШҮҮН





Г.БАТБАРЯ

<sup>6</sup> Компанийн тухай хууль.

88 дугаар зүйл. Их хэмжээний хэлцэл хийх

- 88.1 Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ санал нэгтгээр гаргана.
- 88.2 Төлөөлөн удирдах зөвлөл их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтгэй гагцаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэнэ.
- 88.3 Их хэмжээний хэлцэл хийх асуудлаар эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч нь энэ хүүлийн 53 дугаар зүйлд заасан журмын дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эрүүлэн худалдаж авахыг номиничас шаардах эрхтэй.
- 88.4 Компани нь тухайн тэвлэмийн кулсаанд хийгдсэн их хэмжээний хэлцэл түүний үнэ зэсгийг /гярав/ жилийн таван сарын тодруулгад тусгах замаар нийтэд мэдэгдэх үзэгтэй.





### 6.18 Үнэлгээний тайлан



СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК

ХАРААТ БУС БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮОУС 2020-г баримтлав

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ: СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК  
Монгол Улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо  
Олимпийн гудамж, 19а, Шангри-Ла төв  
Шангри-Ла оффис, 23 давхар

ҮНЭЛГЭЭЧИН: ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ ХХК  
Монгол улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар Дүүрэг, 8-р Хороо  
Сүхбаатарын талбай 20-6  
Эрдэм төвөр, 1004 тоот  
Утас: +976 7000 5000  
Цахим хуудас: [www.geregepartners.mn](http://www.geregepartners.mn)  
Имэйл: [gantulga@geregepartners.mn](mailto:gantulga@geregepartners.mn)

2021.06.30-ны ӨДРИЙН БАЙДЛААРХ ҮНЭЛГЭЭ

Улаанбаатар хот  
2021 оны 9-р сарын 13-ны өдөр







Үнэт цаасны танилцуулга 7



Гүйцэтгэх захирал Г.Чинзориг танаа,

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК  
Монгол Улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо  
Олимпийн гудамж, 19а, Шангри-Ла төв  
Шангри-Ла оффис, 23 давхар

2021 оны 9-р сарын 13-ны өдөр

### БИЗНЕСИЙН ӨМЧЛӨЛИЙН ҮНЭЛГЭЭ

Танай компанитай байгуулсан гэрээний дагуу бид Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн бизнесийн өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тооцоолох үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэн үнэлгээний тайланг 2021 оны 7 дугаар сарын 26-ны өдөр хүргүүлсэн.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь бизнесийн тэлэлтийг төлөвлөсний дагуу хийхэд 2023 он хүртэл нэмэлтээр нийт 33.6 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай. 2021 оны 7 дугаар сарын 26-ны өдөр хүргүүлсэн үнэлгээний тайлан нь энэхүү нэмэлтээр шаардагдах 33.6 тэрбум төгрөгийн санхүүжилтын 15.7 тэрбум төгрөгийг Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа анхлан гаргах замаар, үлдэх санхүүжилтыг 2022 оны 2-р хагаст зээлээр эсвэл хувьцааны хөрөнгө оруулалтаар татах төлөвлөгөөнд үндэслэсэн болно.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2021 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 151021-13 тоот тогтоолоор дээрх санхүүжилтын бүтцэд өөрчлөлт оруулж Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа анхлан гаргах замаар татах санхүүжилтыг 25.0 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлсэн байна.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн санхүүжилтын бүтэц ийнхүү өөрчлөгдсөнтэй холбоотойгоор үнэлгээний тайланг шинэчилэн хүргүүлж байна. Өмнө нь хүргүүлсэн үнэлгээний загварын орц, төсөөлөлд энэхүү санхүүжилтын бүтцийн өөрчлөлтөөс өөр аливаа өөрчлөлт ороогүй болно.

Энэхүү тайланг зөвхөн Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр анхлан гаргах (IPO) үйл ажиллагаанд Үйлчлүүлэгч түүнтэй холбоотой компаниудын хэрэгцээнд зориулан боловсруулсан бөгөөд үнэлгээний үр дүнг өөр зорилгоор эсхүл бусад этгээд өөр зорилгоор ашиглахад тохиромжгүй бөгөөд зориулалтгүй болохыг онцолж байна.

Бизнесийн өмчлөлийн үнэ цэнийг тооцоолохдоо Үйлчлүүлэгчээс авсан мэдээлэл болон өөрсдийн хийсэн шинжилгээ, дүгнэлтийг ашиглав.


Үнэлгээний үр дүн нь энэхүү тайланд үзүүлсэн шинжилгээ, орц мэдээлэл болон таамаглалууд, ашиглалт болон хязгаарлалтад тулгуурласан болно.

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК

1



320



Та бүхэн тайлантай холбоотой аливаа санал болон асуулт байвал бидэнтэй холбоо барина уу.

Хүндэтгэсэн,

Гэрэгэ Эстимэйт ХХК-г төлөөлж:

Д. Ганбаатар, ММУ  
Мэргэшсэн үнэлгээчин  
Гүйцэтгэх захирал

Д.Гантулга, MRICS  
Мэргэшсэн үнэлгээчин  
Үнэлгээ хариуцсан захирал

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК

2





Үнэт цаасны танилцуулга



АГУУЛГА

1. ЕРӨНХИЙ ТОЙМ .....	5
2. ТОДОРХОЙЛОЛТ БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ .....	8
Тодорхойлолтууд .....	8
Бодит болон Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолт .....	10
Үнэлгээний арга зүй .....	11
Орц мэдээлэл болон таамаглалууд .....	14
3. АШИГЛАЛТЫН НӨХЦӨЛҮҮД .....	14
4. ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ .....	15
Макро эдийн засгийн төлөв байдал .....	15
Дотоодын худалдаа, нийтийн хоолны салбарын зах зээл .....	18
Олон улсын конвениенс дэлгүүрийн зах зээлийн төлөв байдал .....	20
Дотоодын өрсөлдөгчдийн төлөв байдал .....	22
Дүгнэлт .....	25
5. КОМПАНИЙН ТУХАЙ .....	26
Компанийн товч танилцуулга .....	26
Санхүүгийн үзүүлэлт .....	28
6. ҮНЭЛГЭЭ .....	29
6.1 Хөрөнгөд суурилсан үнэлгээ .....	29
Эргэлтийн бус хөрөнгө .....	30
Эргэлтийн хөрөнгө .....	30
Өр төлбөр .....	31
Цэвэр хөрөнгө .....	31
6.2 Зах зээлийн харьцуулалтын үнэлгээ .....	31
Үржүүлэгчийн тооцоолол .....	31
Үржүүлэгчийн үнэлгээ .....	33
6.3 Орлогын хандлагын аргаар хийсэн үнэлгээ .....	35
Загварын орц, төсөөлөл, тооцооллууд .....	36
Мөнгөн үрсгалын төсөөлөл, Цэвэр өнөөгийн үнэ цэнийн тооцоолол .....	41
7. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН .....	42
8. ХАВСРАЛТ .....	45

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК





### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: Монгол Улсын бодит ДНБ-ний жилийн өсөлт .....	15
Зураг 2: Улаанбаатар хотын нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр .....	16
Зураг 3: ДНБ ба Өрхийн хэрэглээ, оны үнээр .....	16
Зураг 4: Нэг өрхийн сарын дундаж зарлагын бүтэц, Улаанбаатар хот .....	17
Зураг 5: Өрхийн хүнсний бүтээгдэхүүний дундаж зарлага, төгрөгөөр .....	17
Зураг 6: Худалдааны салбарын борлуулалт, тэрбум төгрөгөөр .....	19
Зураг 7: Нийтийн хоолны салбарын орлого .....	19
Зураг 8: Солонгос улсын савласан хоолны борлуулалт .....	21
Зураг 9: Хүнсний дэлгүүр, хоолны газрын үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ийн тоо .....	23
Зураг 10: СУ дэлгүүрүүдийн одоогийн байршил .....	26
Зураг 11: Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн санхүүгийн байдлын үндсэн үзүүлэлтүүд .....	28
Зураг 12: Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК -ийн ашигт ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд .....	29

### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүд .....	16
Хүснэгт 2: Улаанбаатар хотын хүн амын тоо, насны бүлгээр .....	18
Хүснэгт 3: Нийтийн хоолны салбарын орлогын бүтэц .....	20
Хүснэгт 4: Нийт дэлгүүрийн тоо, төрлөөр .....	23
Хүснэгт 5: Нийслэл дэх хоолны газрын тоо .....	24
Хүснэгт 6: Эргэлтийн бүс хөрөнгийн үнэлгээ .....	30
Хүснэгт 7: Эргэлтийн хөрөнгийн үнэлгээ .....	30
Хүснэгт 8: Өр төлбөр .....	31
Хүснэгт 9: Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн цэвэр хөрөнгийн хэмжээ .....	31
Хүснэгт 10: Гадаад зах зээлийн дундаж үржүүлэгчийн тооцоо .....	32
Хүснэгт 11: Харьцуулсан компаниудын 2012-2020 оны P/BV харьцаа .....	32
Хүснэгт 12: P/BV харьцуулсан үнэлгээний дүн, сая төгрөгөөр .....	33
Хүснэгт 13: EV/Sales харьцуулсан үнэлгээний дүн, сая төгрөгөөр .....	34
Хүснэгт 14: EV/EBIDTA харьцуулсан үнэлгээний дүн, сая төгрөгөөр .....	35
Хүснэгт 15: 2030 он хүртэлх үйл ажиллагааны зардлын төсөөлөл, тэрбум төгрөг .....	39
Хүснэгт 16: 2030 он хүртэлх орлогын үзүүлэлтийн төсөөлөл .....	41
Хүснэгт 17: 2023 он хүртэлх хөрөнгийн үзүүлэлтийн төсөөлөл .....	41
Хүснэгт 18: Харьцуулалт, P/BV харьцаа .....	43

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК

4



323



### 1. ЕРӨНХИЙ ТОЙМ

Тайлангийн өдөр	2021 оны 9-р сарын 13-ны өдөр
Үйлчлүүлэгч	Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг Хавсралт 1-д үзүүлэв.
Үнэлгээнд хамрагдсан хөрөнгө	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, 19а, Шангри-Ла төв, Шангри-Ла оффис, 23 давхар хаягт бүртгэлтэй Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн 100%-ийн бизнес өмчлөл
Үнэлгээний өдөр	2021 оны 6-р сарын 30-ны өдөр
Үнэлгээний стандартын нийцэл	Үнэлгээний Олон Улсын Стандарт 2020 (ҮОУС 2020)
Тайлангийн зорилго / Үнэлгээний ажлын заавар	Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгох (IPO) үйл ажиллагаанд зориулж тус компанийн 100 хувийн өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар тооцоолох
Ашигласан үнэ цэнийн суурь	Зах зээлийн үнэ цэн
Бизнес өмчлөлийн тооцоолсон нийт үнэ цэн	<p>Үнэлгээний өдрийн байдлаарх бизнес өмчлөлийн нийт үнэ цэн 211 818 313 851 (Хоёр зуун арван нэгэн тэрбум найман зуун арван найман сая гурван зуун арван гурван мянга найман зуун тавин нэг) төгрөг.</p> <p>Бидний үнэлгээ дараах мэдээлэлд тулгуурласан болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөө, санхүүгийн загвар гэх зэрэг Үйлчлүүлэгчээс ирүүлсэн мэдээлэл;</li> <li>• Зах зээлийн судалгаанаас боловсруулсан мэдээлэл;</li> <li>• Бидний тооцоолол, таамаглал болон салбарын талаарх мэдлэг зэрэг багтана.</li> </ul> <p>Бид Үйлчлүүлэгчээс өгсөн мэдээлэл болон бичиг баримтын буруу зөвд хариуцлага хүлээхгүй болно.</p>
Таамаглал	<p><u>Тооцооны нэгж:</u> Премиум Дистрибьюшн ХХК нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн 100% эзэмшлийн охин компани бөгөөд сүлжээ дэлгүүрүүдийн агуулах, түгээлтийн үйл ажиллагаа, хоол үйлдвэрлэлийн төвийг хариуцан ажилладаг. Үнэлгээнд Премиум Дистрибьюшн ХХК-ийн үйл ажиллагааг бүхэлд нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн үйл ажиллагаатай нэгтгэн, нэг компани мэтээр авч үзсэн. Үүнээс өөрөөр Үйлчлүүлэгч компанийн үйл ажиллагааг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн бусад компанийн үйл</p>



ажиллагаатай нэгтгэсэн, нийлүүлснээс үүсэх үр дагаврыг энэхүү үнэлгээний ажилд тооцоолоогүй бөгөөд зөвхөн Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн үндсэн бизнесийг бие даасан байдлаар үнэлсэн болно.

Нэмэлт санхүүжилт: Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь бизнесийн тэлэлтийг төлөвлөсний дагуу хийхэд 2023 он хүртэл нэмэлтээр нийт 33.6 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай бөгөөд эхний удаад 25.0 тэрбум төгрөгийн санхүүжилтыг Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа анхлан гаргах замаар, үлдэх санхүүжилтыг 2022 оны сүүлээр зээлээр эсвэл хувьцааны санхүүжилтээр татахаар төлөвлөж байна. Энэ нь бизнесийн үйл ажиллагаанд дээр дурдсан төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт бүрэн хийгдэх тохиолдлыг авч үзсэн үнэлгээ буюу Post-Money Valuation болно. Энэхүү үнэлгээнд үлдэгдэл санхүүжилтыг 100% зээлээр бүрдүүлэх хувилбар орсон болно.

Тасралтгүй байдал: Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь цаашид бизнесийн үйл ажиллагааг төлөвлөлтийн дагуу тасралтгүй үргэлжлүүлнэ гэж үзэв.

Газар дээрх үзлэг, шалгалт, баримтын хадгалалт

Бид Үйлчлүүлэгчийн хөрөнгийн газар дээрх үзлэгийг 2021 оны 5-р сарын 14-ны өдөр хийсэн бөгөөд холбогдох бусад мэдээллийг үнэлгээний ажлын явцад хийсэн үүлзэлт, ярилцлагуудаас авч үнэлгээнд ашиглав.

Стандартаас гажсан эсэх

Гажаагүй

\* Үнэлгээчид

Бид Үйлчлүүлэгчээс өгсөн даалгаврын дагуу энэ төрлийн бизнесийн үнэлгээг хийх туршлагатай гэдгээ үүгээр баталж байна. Д.Гантулга нь Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн Үнэлгээ хариуцсан захирал бөгөөд тус компанийн бизнесийн болон тусгай зориулалтын хөрөнгийн үнэлгээний ажлуудыг удирдан ажилладаг. Д.Ганбаатар нь Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн Гүйцэтгэх захирал болно. Л.Халиун нь ACCA буюу олон улсын мэргэшсэн нягтлан бодогч бөгөөд Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн зөвлөх үнэлгээчнээр ажилладаг. Д.Гантулга нь Мэргэшсэн Үнэлгээчдийн Рояал Институт (RICS)-ийн гишүүн бөгөөд, Д.Гантулга, Д.Ганбаатар, Л.Халиун нар нь Монгол улсын мэргэшсэн үнэлгээчид болно. Үнэлгээчний сертификатын хуулбарыг Хавсралт 3-д үзүүлэв.

Энэхүү үнэлгээний ажлын багийг Д.Гантулга удирдан ажилласан бөгөөд үнэлгээний тайланг бэлтгэсэн болно.


Ашиг сонирхлын зөрчил

Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд бидэнд аливаа сонирхлын зөрчил байхгүй болно.





Үнэт цаасны танилцуулга



Тайлангийн хэрэглэгчид /  
Нууцлал

Энэхүү тайлан нь зөвхөн Үйлчлүүлэгч болон түүнтэй холбоотой компанид зориулж дээр дурдсан зориулалтаар бэлтгэгдсэн бөгөөд гуравдагч этгээдийн өмнө нийт болон хэсэгчилсэн агуулгын талаар хариуцлага хүлээхгүй болно.

Тайлангийн хэрэглээ

Урьдчилсан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд энэхүү тайланг бүтнээр эсвэл хэсэгчлэн тараахыг хориглоно.

Урьдчилсан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд Үйлчлүүлэгч компани болон тус компанитай холбоотой бусад компани нь олон нийтэд гаргах аливаа баримт, мэдээлэл, мэдэгдэлд энэхүү үнэлгээний ажилтай холбоотойгоор Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн нэрийг дурдахыг хориглоно.

Энэхүү тайланг бизнесийн үнэлгээний чиглэлээр тодорхой мэдлэг, мэдээлэлтэй хүмүүс ашиглахад зориулж бэлтгэв. Үнэлгээний үр дүнгийн талаар аливаа санал, дүгнэлт гаргахын өмнө энэхүү тайланг бүхлээр нь уншиж танилцахыг зөвлөж байна. Энэхүү тайлантай холбоотой тайлбар авах, тодруулга хийх шаардлага гарсан тохиолдолд бидэнтэй холбоо барихыг хүсч байна.

Мэргэжлийн хариуцлагын даатгал


Үнэлгээчид нь Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 28-р зүйлд заасны дагуу Үнэлгээчний хариуцлагын даатгалд хамрагдсан болно.

Бусад

Тайланг Монгол болон Англи хэл дээр бэлтгэсэн бөгөөд нэмэлт материалыг үндсэн эхийн хуулбар байдлаар хавсралтад үзүүлэв.

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК





## 2. ТОДОРХОЙЛОЛТ БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

### Тодорхойлолтууд

Үнэлгээний зарим нэр томъёог өөр өөр утгаар ойлгож болох талтай байдаг. Ийм нөхцөл байдал үүсэхээс зайлсхийх зорилгоор үнэлгээнд хэрэглэсэн зарим нэр томъёог Үнэлгээний Олон Улсын Стандарт (ҮОУС), RICS мэргэжлийн олон улсын стандарт ("Улаан ном") болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д тодорхойлсны дагуу дараах байдлаар үзүүлэв.

**Идэвхитэй зах зээл** [СТОУС 13] – Үнийн мэдээллээр тогтмол хангахад хүрэлцэхүйц давтамж, дүнгээр хөрөнгө, өр төлбөрийн арилжаа хийгддэг зах зээл.

**Үнэ цэн** [ҮОУС 2020] – ҮОУС 104 *Үнэ Цэнийн Сууриуд* - д заасан үнэ цэнийн сууриудын аль нэгэнд нийцүүлэн тухайн тооцоолсон дүнгийн талаар үнэлгээчнийн гаргасан шүүн тунгаалтын илэрхийлэл.

**Үнэ цэнийн суурь** [ҮОУС 2020] – Тухайн тайлагнах үнэ цэнийг үндэслэн гаргах суурь урьдчилсан нөхцөлүүд.

**Өртгийн хандлага** [ҮОУС 2020] – Зохисгүй хугацаа, тохиромжтой бус байдал, эрсдэл болон бусад хүчин зүйлс нь хамааралтай биш л бол худалдан авагч нь худалдан авсан эсвэл барьж байгуулсан эсэхээс үл хамааран ижил хэрэгцээт чанар бүхий хөрөнгийг олж бэлтгэх өртгөөс илүү дүнг тухайн хөрөнгийн хувьд төлөхгүй гэсэн эдийн засгийн зарчмыг баримтлан өртгийн хандлага нь үнэ цэнийн үзүүлэлтийг тооцон гаргадаг.

**Хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ** [СТОУС 13] – Боломжит ирээдүйн мөнгөн гүйлгээг магадлалаар жинлэсэн дундаж (өөрөөр хэлбэл тархалтын дундаж дүн).

**Бодит үнэ цэн** [СТОУС 13] – Хэмжилт хийж буй өдөр зах зээлд оролцогчдын хооронд байнга хийгдэх ажил гүйлгээгээр хөрөнгийг худалдсанаар хүлээн авах буюу өр төлбөрөөр тооцох үнэ юм.

**Хамгийн сайн ашиглалт** [СТОУС 13] – Хөрөнгийг ашиглах хугацаанд хөрөнгө буюу бүлэг хөрөнгө, өр төлбөр (бизнесийн хувьд)-ийн үнэ цэнийг дээд түвшинд байлгах зах зээлд оролцогчдын санхүүгийн бус хөрөнгө ашиглалт.

**Орлогын хандлага** [СТОУС 13] – Ирээдүйн дүнгүүд (жишээлбэл: мөнгөн гүйлгээ, орлого, зардлын дүн)-ийг өнөөгийн ганц дүн (өөрөөр хэлбэл хорогдуулан)-д хөрвүүлдэг үнэлгээний арга, хандлага. Бодит үнэ цэнийг хэмжихдээ ирээдүйн дүнгүүдийн талаарх зах зээлийн өнөөгийн таамаглалаар илэрхийлсэн үнэ цэнд суурилна.

**Орц-мэдээлэл** [СТОУС 13] – Энэ нь хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо зах зээлд оролцогчдын гаргасан таамаглалыг хэлэх бөгөөд үүнд дараах эрсдэлийн таамаглал багтана:

- (a) Бодит үнэ цэнийг хэмжихэд хэрэглэсэн үнэлгээний тодорхой арга аргачлалаас шалтгаалан үүссэн эрсдэл (тухайлбал, үнэ тогтоох загвар); ба
- (b) Үнэлгээний арга, аргачлалын дагуу ашиглагдаж буй орц мэдээллээс шалтгаалан үүссэн эрсдэл.









**Үл хөдлөх өмчийн хувь оролцоо** [ҮОУС 2020] – Газар ба барилгын өмчлөл, хяналт, ашиглалт буюу эзэмшлийн эрх.

**Тусгай төсөөллүүд** [Улаан ном 2020] – Үнэлгээний өдрөөр бий болсон нөхцөл байдлаас ялгаатай нөхцөл байдлыг авч үзэж буй төсөөлөл эсвэл үнэлгээний өдөр зах зээлийн жирийн оролцогч хийхгүй байх үйлдэл.

**Тусгай үнэ цэн** [Улаан ном 2020] – Хөрөнгийн хувийн шинж чанарыг тусгаж байдаг, зөвхөн тусгай худалдан авагчдад бий болох үнэ цэн.

**Өргөжилтийн хэмнэлтийн үнэ цэн** [ҮОУС 2020] – Хоёр буюу хэд хэдэн хөрөнгө эсвэл хувь оролцоог нэгтгэн нийлүүлсэн бөгөөд уг нэгдсэн үнэ цэн нь тэдгээрийн тус тусын үнэ цэнүүдийн нийлбэрээс илүү байх зөрүү үр дүн.

**Худалдах зориулалт бүхий өмч** [Улаан ном 2020] – Тухайн бизнесийн арилжаалагдах боломжийг өмчийн үнэ цэн нь илэрхийлж байдаг тусгай бизнест зориулагдсан үл хөдлөх өмчийн аливаа төрөл.

**Эрсдэлийн шагнал** [СТОУС 13]– Зах зээлд оролцогчид хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн гүйлгээний тодорхой байдлаас шалтгаалан үүсэх эрсдэлийг хүлээсний эцэст хүртэх ашиг. Үүнийг мөн “эрсдэлийн залруулга” хэмээн нэрэлдэг.

**Тооцооны нэгж** [СТОУС 13 ] – Хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхийн тулд уг хөрөнгө, өр төлбөрийг нэгтгэх буюу задлан жижигрүүлэх СТОУС-ын хэмжүүр.

**Үл ажиглагдах орц мэдээлэл** [СТОУС 13] – Хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо зах зээлд оролцогчдын гаргасан таамаглалын талаарх боломжит хамгийн сайн мэдээллийг ашиглан боловсруулсан буюу зах зээлд бэлэн байдаггүй орц мэдээлэл.

**Үнэлгээний өдөр** [Улаан ном 2020]– Үнэлгээчний үнэлгээний дүгнэлт гаргасан өдөр.

**Үнэлгээний тайлангийн өдөр** [Улаан ном 2020] – Үнэлгээний тайланд гарын үсэг зурсан өдөр.

#### Бодит болон Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолт

СТОУС 13 Бодит Үнэ Цэнийн Хэмжилт-д Бодит үнэ цэн гэдэгт хэмжилт хийж буй өдөр зах зээлд оролцогчдын хооронд байнга хийгдэх ажил гүйлгээгээр хөрөнгийг худалдсанаар хүлээн авах буюу өр төлбөрөөр тооцох үнэ гэж тодорхойлсон. Энэхүү тодорхойлолт нь ҮОУС-ын Хамрах Хүрээнд Бодит үнэ цэн-ийг тодорхойлсноос ялгаатай бөгөөд тэрхүү тодорхойлолтыг санхүүгийн тайлагналаас бусад зорилгоор нийтлэг хэрэглэдэг.


СТОУС-д тодорхойлсон бодит үнэ цэн нь ҮОУС-д тодорхойлсон зах зээлийн үнэ цэнийн ойлголттой ерөнхийдөө нийцдэг. Иймд тооцооны нэгжийн тайлбар, эсвэл борлуулалтын хориг гэх мэт нягтлан бодох бүртгэлийн стандартын шаардлагад багтсан тусгайлсан таамаглалуудыг харгалзан авч үзсэн тохиолдолд ихэнх практик ажилд ҮОУС-ийн зах зээлийн үнэ цэн нь СТОУС 13-д тодорхойлсон бодит үнэ цэнийн шаардлагыг хангана гэж үздэг.

Зах зээлийн үнэ цэн гэдэгт хариуцлагатай, мэдээлэл тооцоотой, ямар нэг шахалтгүйгээр хандсан, арилжаанд бэлэн байгаа худалдагч, худалдан авагчийн хооронд зохих маркетинг





Үнэт цаасны Танилцуулга



хийсний дараах холбоогүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө болон өр төлбөрийг солилцож болох, тухайн үнэлгээний өдрөөр тооцоолсон дүнг ойлгоно.

Зах зээлийн үнэ цэн нь хөрөнгийн хамгийн сайн ашиглалтыг тусгасан байна. Хамгийн сайн ашиглалт гэдэг нь тухайн хөрөнгийн хүчин чадал ашиглалтыг дээд хэмжээнд байлгах биет байдлаараа боломжтой, хууль ёсоор зөвшөөрөгдсөн, санхүүгийн хувьд биелэгдэх ашиглалтыг хэлнэ. Хөрөнгийн одоогийн ашиглалт эсвэл өөр хувилбарт ашиглалтын аль нь ч хамгийн сайн ашиглалт байж болно. Энэ нь зах зээлийн оролцогч хөрөнгийн үнийг тооцоолохдоо өөртөө төсөөлж байгаа тэр ашиглалтаар тодорхойлогдоно.

#### Үнэлгээний арга зүй

Үнэлгээний ажлын зорилготой үялдуулан Үнэ цэнийн сүүр-д нээлттэй чөлөөт зах зээл дээр төсөөлж буй арилжаагаар хүрч болох хамгийн их магадлалтай үнийн илэрхийллийг авав. Энэ ангилалд УОУС-д тодорхойлсон зах зээлийн үнэ цэн багтана.

Үнэлгээнд хэрэглэдэг үндсэн гурван хандлагын тодорхойлолт, тайлбарыг доор үзүүлэв. Эдгээр хандлагууд нь үнийн тэнцвэр, үр ашгийн хүлээлт, орлуулалт зэрэг эдийн засгийн зарчмуудад тулгуурладаг. Үнэлгээний үндсэн хандлагуудад:

- (a) Зах зээлийн хандлага,
- (b) Орлогын хандлага,
- (c) Өртгийн хандлага.

Үнэлгээний эдгээр үндсэн хандлага бүр нь хэрэглээний өөр өөр нарийвчилсан аргуудтай байдаг.

Үнэлгээний хандлага болон аргуудаас сонголт хийхдээ тухайн нөхцөл байдалд хамгийн тохиромжтой аргыг олох зорилго тавина. Бүх нөхцөлд тохиромжтой нэг ч арга байхгүй. Сонголт хийхдээ хамгийн багадаа дараах хүчин зүйлсийг авч үзэх шаардлагатай. Үүнд:

- (a) үнэлгээний ажлын нөхцөл болон зорилгоор тодорхойлогдсон тохиромжтой үнэ цэнийн сүүр,
- (b) боломжит үнэлгээний хандлага болон аргуудын давуу болон сул талууд,
- (c) арга бүрийн хувьд тухайн хөрөнгийн үндсэн шинжтэй зохицолтой байдал, холбогдох зах зээлийн оролцогчид нь тухайн хандлага, аргуудыг хэр зэргээр хэрэглэдэг талаар,
- (d) тухайн аргыг хэрэглэхэд шаардагдах найдвартай мэдээллийн олдоц ямар байгаа зэрэг орно.

Үнэлгээчин нь заавал нэгээс дээш тооны үнэлгээний аргыг хөрөнгийн үнэлгээнд ашиглах ёстой гэсэн шаардлага байхгүй. Ялангуяа үнэлгээчин нь аль нэг аргын нарийвчлал болон найдвартай байдалд итгэл өндөр байхад бусад аргуудыг ашиглахыг шаарддаггүй. Үнэлгээний аль нэг аргаар итгэлтэй үр дүн гаргахад үнэн зөв эсвэл ажиглагдах орц мэдээлэл хангалттай олдоцгүй үед үнэ цэнийн баримжаа дүр зураг авах зорилгоор нэгээс дээш тооны үнэлгээний хандлага эсвэл аргыг хэрэглэдэг. Хэрэв нэгээс дээш тооны үнэлгээний хандлага эсвэл арга хэрэглэсэн, түүнчлэн нэг хандлагад хамаарах олон тооны аргуудыг хэрэглэсэн тохиолдолд эдгээр хандлага, аргуудад үндэслэн гаргасан үнэ цэнийн тооцоолол нь үндэслэл сайтай, олон аргаар гарсан өөр өөр үр дүнг хэрхэн нэг үнэ цэн болгосон талаар хийсэн шинжилгээг үнэлгээний тайланд тодорхой тайлбарлах шаардлагатай байдаг.

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК

11





Хэрэв үнэлгээний хандлага, аргуудаар гарсан үнэ цэнийн баримжаанууд нь хоорондоо зөрүү ихтэй байвал үнэлгээчин нь яагаад ийм үр дүн гарч байгаа талаар олж мэдэж ойлгох шаардлагатай бөгөөд зөрүү өндөртэй үнэ цэнийн баримжаа дүнгүүдийг хялбараар жинлэн үнэ цэнийг тооцоолох нь тохиромжтой биш юм. Энэ тохиолдолд үнэлгээчин нь дээр дурдсан удирдамжийн дагуу үнэлгээний аль нэг хандлага/арга нь бусад авч үзсэн аргуудаас илүү сайн, илүү найдвартай үнэ цэнийн баримжаа дүр зурга өгөх эсэхийг дахин нягтлан судлах шаардлагатай.

Гурван хандлагын алийг нь ч хэрэглэсэн үнэлгээчин нь зах зээлийн бэлэн олдоцтой мэдээллийг боломжит дээд хэмжээнд хүргэж ашиглах ёстой. Үнэлгээнд ашигласан орц мэдээлэл болон төсөөлөл нь ямар эх сурвалжаас авснаас үл хамааран үнэлгээчин нь тэдгээр орц мэдээлэл, төсөөлөлд үнэлэлт дүгнэлт өгөх, үнэлгээний зорилгод хэр тохиромжтой байгааг дүгнэх шинжилгээг заавал хийх ёстой байдаг.

Үнэлгээний олон улсын стандартаас гадна Монгол Улсад бизнесийн үнэлгээ хийх аргачлалыг Сангийн сайд, Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2011 оны 12-р сарын 30-ны өдрийн 274/240 тоот хамтарсан тушаалаар баталсан байдаг. Энэ аргачлалд бизнесийн үнэлгээний арга, хандлагыг Үнэлгээний Олон Улсын Стандартын дагуу тайлбарлан оруулсан байна.

#### Зах зээлийн хандлага

Зах зээлийн хандлагаар бизнесийн үнэ цэнийг тогтоохдоо үнийн мэдээлэл хангалттай олдох ижил төстэй болон орлуулагч бизнестэй харьцуулах аргыг хэрэглэнэ. Энэ хандлагаар үнэлэх эхний алхам нь зах зээл хувьцаа нь арилжаалагдаж байгаа эсвэл зах зээл дээр саяхан борлогдсон үнэлгээнд хамрагдсан бизнестэй ижил төстэй бизнесийн хувьцааны үнэ эсвэл борлуулалтын үнийг авч үзэх явдал юм.

Энэ хандлагаар бизнесийн үнэлгээ хийхэд түгээмэл ашигладаг мэдээллийн эх сурвалжид дараах мэдээллүүд орно. Үүнд:

1. Ижил төстэй бизнесийн нийтэд зориулан худалдсан бизнесийн өмчлөлийн эрхийн талаарх хөрөнгийн зах зээл буюу хувьцааны талаарх мэдээлэл
2. Ижил төстэй бизнесийг зах зээл дээр худалдсан ба худалдан авсан ажил гүйлгээний талаарх мэдээлэл
3. Тухайн субъектийн бизнесийн өмчлөл дэх өмнөх үеийн ажил гүйлгээний талаарх мэдээлэл
4. Эрх бүхий байгууллагын болон ижил төстэй бүтээгдэхүүний мэдээллийн сан
5. Үнэлгээчний хүвийн мэдээллийн сан зэрэг орно.

Энэ хандлагаар бизнесийн үнэлгээ хийхэд харьцуулж байгаа бизнесийн үнэ цэнийн дүнг орлого, нийт хөрөнгө, цэвэр хөрөнгө зэрэг суурь үзүүлэлтүүдэд харьцуулан гаргасан нэг эсвэл хэд хэдэн үржүүлэгчийг тооцно. Тухайлбал:

- *Үнэ ба ашгийн харьцаа (PE Ratio) = Нэгж хувьцааны үнэ / Нэгж хувьцааны өгөөж*
- *Үнэ ба бүртгэлийн өртгийн харьцаа (Price to Book Value Ratio) = Нэгж хувьцааны үнэ / Нэгж хувьцааны бүртгэлийн өртөг*
- *Үнэ ба борлуулалтын харьцаа (Price to Sales Ratio) = Нэгж хувьцааны үнэ / Нэгж хувьцаанд ногдох борлуулалт*









### Орц мэдээлэл болон таамаглалууд

Үнэлгээнд ашигласан үндсэн таамаглалуудыг доор үзүүлэв.

**Тооцооны нэгж:** Премиум Дистрибьюшн ХХК нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн 100% эзэмшлийн охин компани бөгөөд сүлжээ дэлгүүрүүдийн агуулах, түгээлтийн үйл ажиллагаа, хоол үйлдвэрлэлийн төвийг хариуцан ажилладаг. Үнэлгээнд Премиум Дистрибьюшн ХХК-ийн үйл ажиллагааг бүхэлд нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн үйл ажиллагаатай нэгтгэн, нэг компани шигээр авч үзсэн. Үүнээс өөрөөр Үйлчлүүлэгч компанийн үйл ажиллагааг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн бусад компанийн үйл ажиллагаатай нэгтгэсэн, нийлүүлснээс үүсэх үр дагаврыг энэхүү үнэлгээний ажилд тооцоолоогүй бөгөөд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн үндсэн бизнесийг бие даасан байдлаар үнэлсэн болно.

**Нэмэлт санхүүжилт:** Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь бизнесийн тэлэлтийн үедээ ажиллаж байгаатай холбоотойгоор 2023 он хүртэл нийт 56.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийх, үүнээс 24.1 тэрбум төгрөгийн санхүүжилтыг одоо бэлэн байгаа болон ирээдүйн өөрийн эх үүсвэрээр, үлдэх 33.6 тэрбум төгрөгийг гаднаас нэмэлт санхүүжилт татахаар төлөвлөж байна. Нэмэлт санхүүжилтыг эхний удаад Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа анхлан гаргаж 25 тэрбум төгрөгийг, үлдэх санхүүжилтыг 2022 оны сүүлээр эзлээр эсвэл нэмэлт хувьцааны санхүүжилт татахаар төлөвлөж байна. Энэ нь бизнесийн үйл ажиллагаанд дээр дурдсан төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт бүрэн хийгдэх тохиолдлыг авч үзсэн үнэлгээ буюу Post-Money Valuation болно. Энэ үнэлгээнд санхүүжилтыг 100% эзлээр бүрдүүлэх хувилбар орсон болно.

**Тасралтгүй байдал:** Үнэлгээнд хамрагдсан бизнесийн үйл ажиллагаа нь үргэлжилнэ, цаашид татан буугдах, эсвэл үйл ажиллагааны хамрах хүрээгээ багасгах шаардлагагүй гэж үзэв.

### 3. АШИГЛАЛТЫН НӨХЦӨЛҮҮД

**Мэдээллийн найдвартай байдал:** Энэхүү үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхэд Үйлчлүүлэгч компаниас гарган өгсөн тоон болон чанарын мэдээллийг ашигласан болно. Бид эдгээр мэдээллийн үнэн зөв байдал болон дотоод зөрчилдөөнтэй эсэхэд тойм шинжилгээ хийсэн боловч өөрсдийн зүгээс аудитын шалгалт, дүгнэлт хийлгээгүй болно. Үнэлгээний үр дүнгийн нарийвчлал нь мэдээллийн чанар, бүрэн бүтэн байдалтай шүүд хамааралтай. Иймд энэ тайланд алдаатай мэдээлэл орсон бол бидэнд мэдэгдэхийг хүсье. Нэмэлт мэдээлэлд үндэслэн тайланг засварлан өөрчлөх боломжтой.


Хөрөнгийн үнэлгээний аливаа тооцооллын нарийвчлал нь хязгаарлагдмал байдаг. Энэ нь худалдагч болон худалдан авагчийн хувийн сонирхол, сэтгэл ханамжаас хамаарч хөрөнгийн үнэ тогтдогтой холбоотой юм. Цаашилбал, хөрөнгийн үнэ нь ирээдүйд болох зарим үйл явдал, тухайлбал хууль хяналтын байгууллагын болон шүүхийн шийдвэр, инфляцын өөрчлөлт болон эдийн засгийн шийдвэрүүдээс хамаардаг онцлогтой болно.

Түүнчлэн үнэлгээний өдрийн байдлаар дэлхий даяар тархсан КОВИД-19 цар тахлын эдийн засаг, бизнест үзүүлэх нөлөө нь мөнгөн үрсгалын ирээдүйн төсөөллийн тодорхойгүй байдлыг улам бүр ихэсгэж байна.





Үнэт цаасны танилцуулга



Энэхүү ажилд хэрэглэсэн үнэлгээний аргачлал, таамаглалууд нь үнэлгээний ажлын зорилготой нийцэх ба үнэлгээний үр дүн нь үнэлгээнд ашигласан мэдээллүүдийн хүрээнд харьцангуй бодит тооцоолсон гэж үзэж байна.

Тооцооны аргачлалаас хамаарч тайлангийн зарим үзүүлбэр болон хүснэгтэд орсон тоон үзүүлэлтүүд нь нарийвчлал өндөртэй гарсан болно. Иймд тайланд орсон үнэлгээний үзүүлэлтүүдийг бүхэлчилсэнтэй холбоотойгоор үр дүн бага хэмжээгээр зөрж болохыг анхаарна уу.

Бидний хэрэглэсэн нарийвчилсан таамаглалууд болон бусад хязгаарлалтууд нь тайлангийн зохих бүлгүүдэд дурдагдсан болно. Энэ бүлэг нь тайлангийн зөвхөн нэг бүрэлдэхүүн хэсэг ба аливаа бүлгийг дангаар авч үзэн дүгнэлт гаргах нь буруу зөрүүтэй ойлголтод хүргэх боломжтой тул тайланг бүхэлд нь үзэж судлахыг зөвлөж байна.

#### 4. ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ


Макро эдийн засгийн төлөв байдал

Дотоодын нийт бүтээгдэхүүн

2020 оноос өмнөх арван жилд Монгол улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ийн бодит өсөлтийн дундаж 9% байсан ба 2011 онд хамгийн өндөр буюу 17.5%-д хүрч 2016 онд 0.1% болтлоо буурч байсан. ДНБ-ийн бодит өсөлт 2019 онд 5.1% болж, нэрлэсэн дүнгээр 37.3 их наяд төгрөгт хүрсэн бол 2020 онд 5.3%-иар буурч, нэрлэсэн дүнгээр 37.0 их наяд төгрөг болсон.

ДНБ-ийн бүүралтанд уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг өмнөх оноос 648.6 тэрбум төгрөг, бүтээгдэхүүний цэвэр татвар 456.8 тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ. 2020 оны ДНБ-ийн 5.3%-ийн бодит бүүралтад уул уурхай, олборлолтын салбар 2%, тээвэр, мэдээлэл холбооны салбар 1.5%, бөөний болон жижиглэн худалдааны салбар 1.3%, бүтээгдэхүүний цэвэр татвар 1.1%-ийг тус тус эзэлж байна. Энэ нь дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлаас үүдэн эдийн засаг агшсантай холбоотой бөгөөд 2021 оноос буцаад сэргэх төлөвтэй байна. "Trading economics" байгууллагын судалгаагаар 2021 онд Монгол Улсын ДНБ-ний бодит өсөлт 5.1% байхаар таамаглажээ<sup>1</sup>.

Зураг 1: Монгол Улсын бодит ДНБ-ийн жилийн өсөлт



Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн бодит болон урьдчилсан таамаглалыг дараах хүснэгтэд харуулав<sup>2</sup>.

<sup>1</sup> <https://tradingeconomics.com/mongolia/gdp-growth-annual>

<sup>2</sup> <https://tradingeconomics.com/mongolia/forecast>

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК






Хүснэгт 1: Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Бодит	2021-II	2021-III	2021-IV	2022-I	2022
ДНБ өсөлт, %	-5.3	6.5	6.5	5.1	5.1	5.1
Ажилгүйдлийн хувь, %	7.6	10	8.5	8.5	7.5	7.5
Инфляцийн хувь, %	2.6	4	4.5	4	3.6	4
Зээлийн хүү, %	6	6	6	6	6.25	7
Худалдааны тэнцэл /сая доллар/	412.3	35	31	350	350	350
ДНБ-д эзлэх засгийн газрын өр, %	55	82	82	82	82	82

CU конвениенс дэлгүүрийн салбарууд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа тул Улаанбаатар хотын нэг хүнд ногдох ДНБ-ийн өсөлтийг авч үзэв. Улаанбаатар хотын нэг хүнд ногдох ДНБ 2016 оноос тогтмол өсч 2019 онд 17.0 сая төгрөг буюу 6,204.5 ам.долларт хүрсэн байна. Харьцуулж үзвэл 2019 онд Малайз улсын нэг хүнд ногдох ДНБ 11,414 ам.доллар, Тайланд 7,806 ам.доллар, Филиппин 3,485 ам.доллар байжээ.<sup>3</sup>

Зураг 2: Улаанбаатар хотын нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр



2016-2019 онд Монгол Улсын өрхийн хэрэглээний ДНБ-д эзлэх хувь 54-55% байсан бол 2020 онд нэрлэсэн дүнгээр 21.2 их наяд төгрөг болж ДНБ-ийн 57%-ийг эзэлж байна<sup>4</sup>. 2019 онд Дэлхийн 151 орны мэдээлэл дээр үндэслэн тооцоолоход ДНБ-д эзлэх өрхийн хэрэглээний дундаж үзүүлэлт 63.44% байсан.<sup>5</sup>

Зураг 3: ДНБ ба Өрхийн хэрэглээ, оны үнээр



<sup>3</sup> Дэлхийн банк

<sup>4</sup> <https://www.i212.mn>

<sup>5</sup> [https://www.theglobaleconomy.com/rankings/household\\_consumption/](https://www.theglobaleconomy.com/rankings/household_consumption/)






**Өрхийн сарын орлого, зарлага, хүнсний хэрэглээ**

Үндэсний Статистикийн Хорооны мэдээгээр<sup>4</sup> нэг өрхийн сарын дундаж орлого 2020 оны 4-р улирлын байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд 1.5 сая төгрөг, орон нутагт 1.2 сая төгрөг байна. Өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг бүтцээр нь авч үзвэл цалин хөлсний орлого 54%, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 23.9%, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 7.6%, үйлчилгээний орлого 5.6%, бусад орлого 8.9%-ийг тус тус эзэлж байна.

Нэг өрхийн сарын дундаж зардал 2020 оны 4-р улирлын байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд 1.5 сая төгрөг, хөдөөд 1.3 сая төгрөг байна. Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагыг бүтцээр нь авч үзвэл хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 68.2%, хүнсний бүтээгдэхүүний зарлага 21.5%, бусад зарлага 8.5%, бусад өгсөн бэлэг, тусламжийн зарлага 1.8%-ийг тус тус эзэлж байна.

Нэг өрх дунджаар нэг сард 330,000 төгрөгийг хүнсний зүйлд зарцуулдаг гэж тооцож болно.


Зураг 4: Нэг өрхийн сарын дундаж зарлагын бүтэц, Улаанбаатар хот



Өрхийн хүнсний бүтээгдэхүүний сарын дундаж зарлагын 31.5%-ийг мах, махан бүтээгдэхүүн, 24.7%-ийг үр тариа, гурилан бүтээгдэхүүн, 11%-ийг сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, 7.1%-ийг хүнсний ногоо, 3.7%-ийг элсэн чихэр, амттан эзэлж байна.

Зураг 5: Өрхийн хүнсний бүтээгдэхүүний дундаж зарлага, төгрөгөөр





### Хүн ам, насны ангилал

Монгол улсын нийт хүн ам 2021 оны 5-р сарын байдлаар 3,357,542, үүнээс нийт 1,499,140 хүн, 414,292 өрх Улаанбаатар хотод бүртгэлтэй байна. Цаашид Улаанбаатар хотын хүн ам 2025 он хүртэл жилд дунджаар 3.67%-иар, 2035 он хүртэл жилд 2.42%-иар, 2045 он хүртэл жилд 2.25%-иар тус тус өсөх төсөөлөлтэй байна.

Улаанбаатар хотын оршин суугчдыг насны бүлгээр авч үзвэл конвинеенс дэлгүүрээр үйлчлүүлэх өндөр давтамж бүхий 20-49 насны хүн ам 666,964 байгаа нь нийт хүн амын 45%-ийг эзэлж байна. 15-19 насны ахлах ангийн сурагчид мөн конвинеенс дэлгүүрээр үйлчлүүлэх нь элбэг байдаг бөгөөд энэ насны бүлгийг нэмбэл нийт хүн амын ойролцоогоор 51% болно.

Хүснэгт 2: Улаанбаатар хотын хүн амын тоо, насны бүлгээр

Насны бүлэг	Хүн амын тоо	Эзлэх хувь
0-14	580,208	39%
15-19	85,910	6%
20-29	200,434	13%
30-39	274,689	18%
40-49	191,841	13%
50-59	137,123	9%
60-64	47,955	3%
65+	66,890	4%

2020 оны байдлаар нэгж газарт ногдох хүн амын тоо улсын хэмжээнд 2.1 хүн, Улаанбаатар хотын хэмжээнд 339.8 хүн байна. Хүн амын нягтрал хамгийн ихтэй дүүргүүд болох Баянгол дүүрэгт нэгж газар нутагт 7,850 хүн, Чингэлтэй дүүрэгт 1,693 хүн, Сүхбаатар дүүрэгт 693 хүн тус тус ногдож байна.

1990 оноос хойш өнөөг хүртэл Монгол Улсын иргэд Солонгос улсад олноор зорчиж, ажиллаж, амьдарч ирсэн. Ковид 19 цар тахлаас өмнөх үед, тухайлбал 2018 оны байдлаар Монгол Улсын 46,243 иргэн Солонгос улсад оршин сууж байсан ба тухайн онд нийт 118,783 иргэн Солонгос улсад зорчсон байна.<sup>6</sup> Солонгос улсын соёл, амьдарлын хэв маяг Монголд, ялангуяа залуучуудын дунд ихээр нэвтэрч байгаа нь конвинеенс дэлгүүрийн зах зээл Монголд хөгжих боломж өндөр болохыг харуулна.

### Дотоодын худалдаа, нийтийн хоолны салбарын зах зээл


#### Бөөний болон жижиглэнгийн худалдаа

Конвинеенс дэлгүүрийн зах зээл нь жижиглэн худалдааны зах зээлд хамрагдах бөгөөд тухайн зах зээлийн нийт багтаамж, цаашид өсөх орон зай байгаа эсэх нь энэхүү зах зээлийг тодорхойлох чухал үзүүлэлт болно. Жижиглэн худалдааны зах зээл 2019 онд улсын хэмжээнд 13.5 их наяд төгрөг байсан байна. Энэ нь ДНБ-ий 36%-ийг эзэлж байгаа тул эдийн засгийн хувьд чухал зах зээл болох нь тодорхой.

<sup>6</sup> <https://www.seoul.embassy.mn>



Зураг 6: Худалдааны салбарын борлуулалт, тэрбум төгрөгөөр



Жижиглэн худалдааны борлуулалт 2019 онд өмнөх оноос 22%-иар өссөн бол 2020 онд 3%-иар бүүрч, 2021 оны I улиралд өмнөх үеэс 16%-иар өссөн байна. Энэ нь КОВИД 19 цар тахалтай холбоотойгоор жижиглэн худалдааны зах зээл 2020 онд агшиж 2021 онд эргээд сэргэх хандлага ажиглагдаж байгааг харуулж байна.


Худалдааны салбарын нийт борлуулалтын ойролцоогоор 83% нь Улаанбаатар хотод ногддог ба Улаанбаатар хотын худалдааны салбарын борлуулалт 2021 оны эхний улиралд 4.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 19.4%-иар, 3-р сард 1.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 30.9%-иар тус тус өссөн байна.<sup>4</sup>

**Нийтийн хоолны салбарын орлого**

Конвиниенс дэлгүүрийн борлуулалтын орлогын томоохон хэсгийг савлаж бэлтгэсэн бэлэн хоол эзэлдэг. Рестораны хоолыг бодвол түргэн шүүрхай авах боломжтой, үнэ нь ойролцоогоор 2 дахин хямд, цайны газар, гуанзны хоолтой харьцуулахад үнэ ойролцоо боловч эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, чанартай, баталгаатай байдгаараа давуу талтай.

Нийтийн хоолны салбарын орлогын статистик мэдээллээс<sup>4</sup> харахад тухайн салбарын орлого жил бүр өсөн нэмэгдэж байгаа нь гадуур хооллох соёл жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа, мөн дэлхий нийтийн жишгийн дагуу хүмүүсийн амьдралын хэв маяг өөрчлөгдөж, завгүй болж бэлэн хоол захиалж идэх нь элбэг болсонтой холбоотой гэж үзэж болно. Нийтийн хоолны салбарын орлого 2020 оны 1-р улирлын байдлаар өмнөх үеэс 14%-иар өссөн бол 2021 оны 1-р улирлын байдлаар 6%-иар бүүрсэн байна.

Зураг 7: Нийтийн хоолны салбарын орлого



Нийтийн хоолны салбарын орлогыг ресторан, кафе, баар, гуанз, захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлогоор ангилан дор харуулав. Үүнд, 2021 оны 1-р улирлын борлуулалтын орлогын бүүралтын дийлэнх хэсгийг захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлогын бүүралт эзэлж байна. Энэ нь КОВИД 19 цар тахалтай холбоотойгоор оффис, үйлчилгээний





ажилчдын өдрийн хоолны хэрэглээ буурсантай холбоотой гэж үзэж болно. Хөл хорио дахин тогтоохгүй тохиолдолд энэ хэсгийн орлого тогтмол өсөх хандлага ажиглагдаж байна.

Хүснэгт 3: Нийтийн хоолны салбарын орлогын бүтэц

Үзүүлэлт, тэрбум төгрөг	2018	2019	2020	2021*
	I-III	I-III	I-III	I-III
Ресторан	45.1	61.2	76.3	76.4
Кафе	7.4	7.9	7.4	7.2
Баар	3.5	4.2	2.5	2.4
Гуанз	5.8	7.2	6.5	5.7
Захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээ	23.6	25.1	28.6	22.8
Нийт орлого	85.4	105.6	121.3	114.5

\*төсөөлөл

### Олон улсын конвениенс дэлгүүрийн зах зээлийн төлөв байдал

Дэлхийн анхны сүлжээ конвениенс дэлгүүр 1927 онд АНУ-ын Техас мужийн Даллас хотод нээгдсэн ба хожим дэлхийн хамгийн том 7-Eleven гэх конвениенс сүлжээ дэлгүүр болжээ.<sup>7</sup> Түүнээс хойш конвениенс дэлгүүрүүд нь тухайн орны соёл, иргэдийн амьдралын хэв маягтай уялдан өөр өөрийн онцлогтойгоор хөгжиж иржээ.

### Өмнөд Солонгос улсын конвениенс дэлгүүрийн зах зээлийн төлөв байдал

Өмнөд Солонгос улсад 2018 оны 2-р сарын байдлаар 39,890 конвениенс дэлгүүр байгаа нь зах зээлд нэвтрэлтийн түвшингээр (penetration rate) дэлхийд тэргүүлж байна. Солонгос улсын хувьд нэвтрэлтийн түвшин 1000 хүн тутамд 644 дэлгүүр байна. Харин 2018 оны байдлаар Солонгос улсад 1 дэлгүүрийн жилийн дундаж борлуулалт 428 сая вон, Япон улсын хувьд 1,991 сая вон байгаа нь Япон улстай харьцуулахад 4 дахин бага үзүүлэлт болно. Солонгос улсын конвениенс дэлгүүрийн зах зээлийн чиг хандлагын талаар баримт, мэдээлэл дурдвал<sup>8</sup>:


- Конвениенс сүлжээ дэлгүүрийн 2018 оны нийт борлуулалтын 39%-ийг тамхины борлуулалт, 20%-ийг боловсруулсан хоол хүнс, 12%-ийг сүүн бүтээгдэхүүн, 8%-ийг согтууруулах ундаа, 7%-ийг амттан, 6%-ийг шинэ хүнс, 8%-ийг бусад зүйлс түс түс эзэлж байна.
- Конвениенс дэлгүүрээр үйлчлүүлэгчдийн 66.5%-ийг 20-39 насны үйлчлүүлэгчид эзэлж байна. Нийт худалдан авалтын 44.8 хувь нь оройны 8 цагаас шөнийн 12 цагийн хооронд байдаг ба шөнийн 12 цагаас өглөөний 8 цагийн хоорондох худалдан авалт бас нилээдгүй өндөр хувийг эзэлдэг.
- Ганц бие хүмүүс олширсон тул конвениенс дэлгүүрийн борлуулалтын жилийн нийлмэл өсөлтийн хувь (CAGR) 2010 оноос 2019 оны хооронд 15.1%-иар өссөн байна. Энэ нь их дэлгүүр (1.4%) болон хүнсний дэлгүүртэй (3.3%) харьцуулахад өндөр үзүүлэлт юм.
- Савласан хоолны борлуулалтын жилийн нийлмэл өсөлтийн хувь (CAGR) 2013 оноос 2018 оны хооронд 35.1%-иар өссөн байна. Конвениенс дэлгүүр нь олон төрлийн эрүүл хоолны сонголттой болсон, мөн рестораны хоолны үнэтэй харьцуулахад бараг тал үнээр зарагдаж байгаа тул конвениенс дэлгүүрийн савласан хоолны борлуулалт жил ахих тусам өсч байна.

<sup>7</sup> [https://en.wikipedia.org/wiki/Convenience\\_store](https://en.wikipedia.org/wiki/Convenience_store)

<sup>8</sup> Convenience Stores Industry Overview - South Korea, by Speeda, revised on 03/03/2020







Зураг 8: Солонгос улсын савласан хоолны борлуулалт



- Байр бүрийн дор шахуу конвениенс дэлгүүр байгаа тул хүргэлт, шуудангийн үйлчилгээ конвениенс дэлгүүрийн гол үйлчилгээний нэг болж байна. 2017 оны байдлаар Солонгос улсын конвениенс дэлгүүрүүдийн 95.2% нь энэ үйлчилгээг нэвтрүүлсэн байна. Үйлчлүүлэгч өөрт хамгийн ойрын дэлгүүрээс хэзээ дуртай цагтаа очиж захиалсан бараагаа авах боломжтой тул энэ үйлчилгээ нь маш түгээмэл болсон.


#### Филиппин улсын конвениенс дэлгүүрийн зах зээлийн төлөв байдал

2016 оны байдлаар Филиппин улсын жижиглэн худалдааны зах зээлийн 74%-ийг супермаркет, 19%-ийг хайпермаркет, 6%-ийг конвениенс дэлгүүр, 1%-ийг бусад төрлийн дэлгүүрүүд эзэлж байна. Филиппин нь хэрэглээний зардал өндөртэй улс бөгөөд ДНБ-д эзлэх өрхийн хэрэглээ 2018 онд 85.7% байсан байна. Филиппин улсын конвениенс дэлгүүрийн чиг хандлагын талаар баримт, мэдээлэл дурдвал<sup>2</sup>:

- Конвениенс дэлгүүрийн нийлмэл өсөлтийн хувь (CAGR) 2009 оныг 2016 онтой харьцуулахад 18.1%, хайпермаркетийн CAGR 14.4%, супермаркетийн CAGR 8% байгаа нь конвениенс дэлгүүрийн өсөлт харьцангуй өндөр байгаа нь ажиглагдаж байна.
- Филиппинд бизнесийн үйл ажиллагааны аутсорс гэсэн ажлын байр түгээмэл бий болсон. Энэ нь шөнийн 10 цагаас өглөөний 6 цаг хүртэл ажилладаг ажил юм. Ийм ажлын байр нэмэгдсэнтэй холбоотойгоор конвениенс дэлгүүрээр үйлчлүүлэх иргэдийн тоо нэмэгдсэн. 2017 оны байдлаар нийт ажиллах хүчний 3% буюу 1.3 сая ажилчид байна гэсэн тоо баримт байна.
- Интернетийн нэвтрэлтийн түвшин нэмэгдсэнтэй (2016 онд 43.5%) холбоотойгоор онлайн жижиглэнгийн худалдаа түгээмэл болсон. Түүнчлэн, гуравдагч этгээдтэй хамтарсан түгээлтийн үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн. Энэ нь хүргэлт, ложистикийн компаниудын зардал, цагийг маш их хэмнэж байгаа тул цаашид улам өргөжих хандлага ажиглагдаж байна.
- Бургер, сэндвич, ролл, мөстэй ундаа, жимсний шүүс зэрэг түргэн бэлэн болдог хоолыг санал болгож байгаа, мөн суугаад үйлчлүүлэх кафе маягийн тохтой булан зэргийг нэвтрүүлж байгаа тул кафе, хоолны газартай өрсөлдөж эхэлж байна.
- Франчайз аргыг ашиглан зах зээлээ тэлэх бодлого баримталж байна. Жишээ нь 7-Eleven франчайз дэлгүүрийн тоо 2018 онд 1406 буюу нийт дэлгүүрийн 55.1%, компанийн өөрийн эзэмшлийн дэлгүүрийн тоо 2018 онд 1144 буюу нийт дэлгүүрийн 44.9%-ийг эзэлж байна.
- 7-Eleven дэлгүүр нь Филиппинд анх 1982 онд нээгдсэн, 2011 онд 689 дэлгүүртэй, 2018 оны төгсгөлд нийт 2250 дэлгүүртэй болжээ. Жилийн нийлмэл өсөлтийн хувь нь 2011

<sup>2</sup> Speeda, Филиппин улсын конвениенс дэлгүүрийн зах зээлийн байдал





оноос 2018 оны хооронд 23.7% байна. Үйл ажиллагааны ашгийн маржин 2014 онд 6.5%, 2018 онд 4.9% байсан байна.

#### Вьетнам улсын конвинеенс дэлгүүрийн зах зээлийн төлөв байдал

Вьетнам улсын жижиглэн худалдааны зах зээлийн 70 хувийг уламжлалт зах болон дэлгүүрүүд эзэлдэг. Вьетнам хүмүүс нь өдөр бүр шинэ хүнс бага хэмжээгээр авч хэрэглэдэг хандлагатай байдаг нь үүнтэй холбоотой. Хятадад нэг конвинеенс дэлгүүрт 24,900 хүн, Японд 2,300 хүн, Солонгосд 2,100 хүн ногддог. Харин, Вьетнам улсын хувьд нэг конвинеенс дэлгүүрт ногдох хүн амын тоо 31,487 (2018 он) байгаа нь энэ зах зээл цаашид өргөжих боломж байгааг харуулж байна. Филиппин улсын конвинеенс дэлгүүрийн чиг хандлагын талаар баримт, мэдээлэл дүрдвал<sup>10</sup>:

- 2020 оны 3-р сарын байдлаар нийт 5,228 конвинеенс дэлгүүр болон мини-март ажиллаж байна. Ихэнх нь олон оршин суугчидтай хорооллын дунд жижиг хүнсний дэлгүүрүүдтэй өрсөлдөх хэлбэрээр, мөн их сургууль, ахлах сургуулийн ойролцоо байрлалтай байдаг. Хоол, ундаа, цайны үнэ нь бусад хоолны газартай харьцуулахад хямд байдаг тул үйлчлүүлэгчдийн тоо өсөн нэмэгдэж байна. Бэлэн хоол, худалдагчийн бэлтгэж өгдөг цай, кофе, савтай ус нь хамгийн их зарагддаг бүтээгдэхүүнээр нэрлэгдсэн байна.
- Сарын орлого нь 714 ам.доллараас дээш буюу дундаж орлоготой хүмүүсийн нийт хүн амд эзлэх хувь 2026 он гэхэд 26% болно таамаглал байна. 2018 онд буюу дундаж орлоготой хүмүүсийн нийт хүн амд эзлэх хувь 13% байсан. Хүн амын дундаж орлого өсөхийн хэрээр эрүүл ахуйн шаардлага хангасан орчин үеийн дэлгүүрээр үйлчлүүлэх хандлага өсөн нэмэгддэг тул конвинеенс дэлгүүрийн зах зээлд эзлэх хувь нэмэгдэнэ гэсэн төлөвтэй байна.
- Экспатын тоо 2019 оны байдлаар 91,200 болсон, жилд ирэх жуулчдын тоо 2018 оны байдлаар 15.5 сая хүн байгаа бөгөөд энэ нь жил ирэх тусам өсөн нэмэгдэж байгаа тул конвинеенс дэлгүүрийн борлуулалтанд эерэгээр нь нөлөөлнө гэж харж байна.
- Хотод шилжин ирж суурьших хөдөлгөөн байнга өсөн нэмэгдэж байна. 2014 оноос 2019 оны хооронд хот руу шилжин сүүсэн хүн амын нийлмэл жилийн өсөлтийн хувь 2.2 болсон байна, энэ нь хүн амын 35% нь хотод амьдарч байна гэсэн үг. 2030 он гэхэд McKinsey компанийн судалгаагаар энэ хувь 55%-д хүрнэ гэсэн тооцоо байна. Хот руу шилжих хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотойгоор төрөлх нутаг, эцэг эхээсээ хол хотод амьдрах ганц бие хүмүүсийн тоо өсөн нэмэгдэж байна. Энэ нь конвинеенс дэлгүүрээс бэлэн, түргэн, бага хэмжээтэй хоол, хүнс худалдан авах эрэлтийг улам нэмэгдүүлж байна. Бэлэн савласан хүйтэн хоолноос гадна шүүд халуунаар нь идэх банш, шөл зэргийг хямд үнээр худалдаалдаг.

#### Дотоодын өрсөлдөгчдийн төлөв байдал

##### Хүнсний дэлгүүр, нийтийн хоолны үйлчилгээ

Монгол улсын хэмжээнд 2021 оны 1-р улирлын байдлаар хүнсний дэлгүүрийн жижиглэн худалдаа эрхэлдэг 6986 аж ахуйн нэгж, дэлгүүрээр дамжин хийгддэггүй жижиглэн худалдаа эрхэлдэг 625 аж ахуйн нэгж, ресторан, кафе, цайны газар, хоол бэлтгэх үйл ажиллагаа явуулдаг 1761 аж ахуйн нэгж бүртгэлтэй байна.

<sup>10</sup> Speeda, Вьетнам улсын конвинеенс дэлгүүрийн зах зээлийн байдал





Зураг 9: Хүнсний дэлгүүр, хоолны газрын үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ийн тоо



2020 оны 6-р сарын байдлаар үйл ажиллагаа явуулж буй жижиглэн худалдааны газруудын тоо дараах байдалтай байна. Конвениенс дэлгүүрийн шүүд өрсөлдөгч болох минимаркет, ая тухтай дэлгүүр буюу конвениенс дэлгүүр, бага оврын хүнсний дэлгүүр, ШТС-ын дэргэдэх дэлгүүр, мұхлаг Улаанбаатар хотын хэмжээнд 6091 ширхэг байна.<sup>11</sup>

Хүснэгт 4: Нийт дэлгүүрийн тоо, төрлөөр

Д/д	Ангилал	Дэлгүүрийн төрөл	Байршил		Нийт
			Нийслэл	Аймаг	
1	Том	Хайпермаркет +	33	10	43
2	Дунд	Супермаркет +	142	175	317
3	Багавтар	Минимаркет +	670	574	1,244
4		Ая тухтай дэлгүүр	84	70	154
5	Бага	Хүнсний дэлгүүр	3,638	6,332	9,970
6		ШТС-ын дэргэдэх	30	69	99
7		Мұхлаг	1,669	582	2,251
8	Хүнсний бус худалдаа	Төрөлжсөн бараа	520	1,048	1,568
9		Аутлет +	30	33	63
10		Бутик +	53	1	54
	Нийт		6,899	8,864	15,763

Хүнсний худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийт газруудын 82% нь зориулалтын, 18% нь зориулалтын бус ажлын байртай байна. Хүргэлт хийдэг 27 компаниас хүнсний бүтээгдэхүүний хүргэлт хийдэг 10 компани ажиллаж байна. Онлайн хүргэлт хийдэг <https://odoshop.mn> аппликэйшн ажиллуулдаг компани улсын хэмжээнд 250 дэлгүүрийг хамруулан ажиллаж байна.<sup>12</sup>


Нийслэл хотын хэмжээнд 1021 ресторан, 945 баар, 1297 цайны газар, 225 кафе, 2100 архи согтууруулах ундааны түсгай зөвшөөрөлтэй хоолны газар, 950 гаруй гал тогоо бүхий сүргүүл, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж ажиллаж байна. Үүнээс Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт цайны газар, Сүхбаатар, Хан-Уул дүүрэгт рестораны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хоолны газрын тоо өндөр байна.<sup>13</sup>

<sup>11</sup> Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

<sup>12</sup> <https://moja.gov.mn/exp/blog/10/181>

<sup>13</sup> <https://moja.gov.mn/exp/blog/10/85>





Хүснэгт 5: Нийслэл дэх хоолны газрын тоо

д/д	Үйлчилгээний төрлөөр	Тоо
1	Ресторан	1,021
2	Кафе	225
3	Баар	945
4	Эмнэлэг, сувилал	100
5	Цэцэрлэг сургуулийн	685
6	Дотуур байрны	10
7	МСҮТ, Их дээд сургуулийн	35
8	Үйлдвэр, байгууллагын	1,297
	Нийт	4,318

MICC компанийн судалгаагаар<sup>14</sup> 2019 оны байдлаар Улаанбаатар хотын конвинеенс дэлгүүрийн зах зээлийг 628 – 998, дундажаар 813 ширхэг дэлгүүр байхаар тооцоолжээ. Судалгаанд дундажаар 1,876 хүнд 1 конвинеенс дэлгүүр байхаар тооцоолсон ба цаашид хүн амын тоо өсөхийн хэрээр зах зээл өргөжих боломжтойг дурджээ.

Ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг өрсөлдөгчид

CIRCLE K



Circle-K нь 1951 онд АНУ-д үүсгэн байгуулагдсан. 2017 оны байдлаар дэлхийн 30 улсад 16,000 гаруй салбартай болоод байна. 2018 оны 4-р сард анхны дэлгүүрээ Монгол улсын нийслэл хотод нээсэн, үнэлгээний өдрийн байдлаар нийт 23 дэлгүүртэй, Улаанбаатар хот болон орон нутагт франчайз хөтөлбөр зарлаад байна.

Бүтээгдэхүүн: Чихэр болон жигнэмэг, савласан ундаа, өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн, сүүн бүтээгдэхүүн, чипс болон зууш, ахуйн бүтээгдэхүүн, согтууруулах ундаа гэсэн төрлийн бүтээгдэхүүнүүдийг борлуулдаг.

Үйлчилгээ: ATM, автобусны карт цэнэглэх, нэгж худалдаж авах, үнэгүй wi-fi болон сүүж үйлчлүүлэх үйлчилгээнүүдийг нэвтрүүлэн ажиллаж байна.

ECO EXPRESS



Номин холдинг ХХК-ийн 100 хувь үндэсний хөрөнгө оруулалттай конвинеенс сүлжээ дэлгүүр, 2018 оны 9-р сард анхны дэлгүүрээ нээсэн бөгөөд өдгөө 12 салбар дэлгүүртэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Хүнсний бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний бүтээгдэхүүн ахуйн бараа, арьс арчилгааны бүтээгдэхүүн, ширхэгийн болон түргэн хоол, цай, кофе худалдаалдаг. Circle K, CU-гийн нэгэн адил сүүж үйлчлүүлэх боломжоор хангадаг.

GS25



Өмнөд Солонгос улсын сүлжээ дэлгүүр, 1990 онд анхны дэлгүүрээ Солонгос улсад нээсэн. 2019 оны байдлаар Солонгос улсдаа хамгийн олон конвинеенс дэлгүүртэй дэлгүүрээр шалгарсан. Солонгос улсын конвинеенс дэлгүүрийн зах зээл ханасан, ашгийн өсөлт нь бүүрч байгаа тул Ази тивийн бүсэд

<sup>14</sup> Convenience Store Market in Ulaanbaatar: An Analysis of Market Size and Opportunities, by MICC, 2019











Үнэт цаасны танилцуулга



Цаашид нээх дэлгүүрүүдийг Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу 2,149 га хотжилтын талбайд төлөвлөж байна. Нягтаршлын хувьд дэлгүүр хоорондын зай 150-200 метр болон түүнээс дээш тохиолдолд CU-гийн өөрийн дэлгүүрийн борлуулалт хуваагдах эрсдэл бага байдаг тул газар зүйн хувьд 360 дэлгүүр багтах боломжтой гэж компанийн зүгээс үзэж байна.

Цаашид хүн амын нягтаршил, орлогын чадвар, дэлгүүр хоорондын зай 150 метрээс дээш байх гэсэн чиглэлийг баримталж аль бүсэд хэдэн дэлгүүр нээх төлөвлөгөөг менежментийн зүгээс гарган ажиллаж байна. Жишээ нь Их тойруу болон Энхтайваны өргөн чөлөө, Сүхбаатарын 1-р хороо зэрэг оффис ихээр төвлөрсөн нутаг дэвсгэрт, мөн Баянзүрх дүүргийн 15, 16, 26-р хорооны хүн амын нягтаршил ихтэй бүсэд дэлгүүрийн тоог нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

**Хоол үйлдвэрлэлийн төв**

Хоол үйлдвэрлэлийн төв нь Улаанбаатар хотын төвөөс зүүн тийш 25 орчим км-ийн зайд орших 24 цагийн тасралтгүй үйл ажиллагаатай, 2100 мкв талбай бүхий үйлдвэр бөгөөд 2021 онд НАССР /GHP, GMP/, ISO 22000 стандартуудыг ханган, гэрчилгээ авахаар ажиллаж байна. Энэ төвд одоогоор 20 гаруй нэр төрлийн, хөргөгчний болон хөлдүү хэмд түгээгдэх хоолнуудыг үйлдвэрлэдэг.



**Түгээлтийн төв**

4200 мкв талбай бүхий 4500 нэр төрлийн бүтээгдэхүүн хадгалах 20 хэмийн түгээлтийн төв, 350 мкв талбай бүхий 600 нэр төрлийн өдөр тутмын шинэ хүнсний бүтээгдэхүүн хадгалах 6 хэмийн түгээлтийн төв, 80 мкв талбай бүхий -20 хэмийн түгээлтийн төвтэй. Түгээлтийн төв дээр үйлдвэрүүдээс бүх төрлийн бүтээгдэхүүний татан авалтыг хийсний дараа шөнийн цагаар дэлгүүрүүд рүүгээ захиалгын дагуу бараа хүргэлт хийгддэг.



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК







МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-09-17  
Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-02



### Нийт ажилчид, үйлчлүүлэгчид, IT систем

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь байгуулагдсан цагаасаа эхлэн үйлчилгээний олон улсын стандартыг Монгол улсад нутагшуулах зорилготойгоор ажилчдаа түршлагажуулан ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар 1100 гаруй түршлагатай ажилчидтай болсон байна. Өдөрт дунджаар CU дэлгүүрээр 25,000 хүн үйлчлүүлж байна. Компани нь цогц IT системийн дэд бүтцийг хөгжүүлж байгаа бөгөөд CU аппликэйшийг 200,000 гаруй үйлчлүүлэгч тогтмол хэрэглэдэг болсон байна.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь 2020 онд Монгол Улсын Засгийн газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас шалгаруулдаг “Монголын топ 100 аж ахуйн нэгж”-ийн нэгээр шалгарсан.


### Санхүүгийн үзүүлэлт

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн 2019, 2020 оны PwC аудитын компаниар аудитлагдсан болон 2021 оны эхний хагас жилийн компанийн санхүүгийн тайланд тойм шинжилгээ хийв.

2021 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн бизнесийн хөрөнгө оруулалт ба үйл ажиллагаанд нийт 80.5 тэрбум төгрөгийн урт хугацаат санхүүжилт татсан бөгөөд үүний 84.3% буюу 68.0 тэрбум төгрөгийг хувьцааны санхүүжилтээр, 15.7% буюу 12.57 тэрбум төгрөгийг урт хугацаат зээлийн санхүүжилтээр татсан байна. Тайлант хугацааны хуримтлагдсан алдагдал нь 40.8 тэрбум төгрөг ба 80.1 тэрбум төгрөгийн балансын хөрөнгөтэй байна.

2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хувьцаат капиталын дүн нь оны эхнээс 50.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэний 7.7 тэрбум төгрөг нь Премиум Дистрибьюшн ХХК-ийг Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн 100% эзэмшлийн охин компани болгосонтой холбоотой, 41.1 тэрбум төгрөг нь зээлийг хувьцаанд шилжүүлсэнтэй холбоотой, харин 2 тэрбум төгрөг нь нэмэлт хувьцааны хөрөнгө оруулалт байна.

Зураг 11: Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн санхүүгийн байдлын үндсэн үзүүлэлтүүд



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь 2019 онд 37.5 тэрбум төгрөгийн цэвэр борлуулалтын орлоготой, 11.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол 2020 онд 45.3 тэрбум төгрөгийн цэвэр борлуулалт хийж 15.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллажээ. 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тус оны компанийн цэвэр борлуулалт нь 32.5 тэрбум төгрөг, алдагдал 7.5 тэрбум төгрөг байна. Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь өнгөрсөн жилүүдэд






бизнесээ өргөжүүлэн 120 гаруй шинэ дэлгүүр, түгээлтийн суваг, хоолны үйлдвэр, мэдээллийн технологийн системд хөрөнгө оруулж томоохон дэд бүтцийг үүсгээд байгаа ба бизнесийн амьдралын мөчлөгийн дагуу өсөлтийн үе шат үргэлжилэн 2023 оноос эхлэн цэвэр ашигтай ажиллахаар тооцоолж байна.

Тус салбарыг бизнесийн амьдралын мөчлөг нь өсөлтийн үе шатанд яваа учраас их хэмжээний капитал хөрөнгө оруулалт шаардагдаж байна. Түүнчлэн, суурь хүү бага байгаагаас шалтгаалан капиталын өртөг бага байгаань амьдралын мөчлөг үрттай түс төрлийн өсөлтийн бизнест томоохон дүнтэй капитал хөрөнгө оруулалтыг хийх хамгийн тохиромжтой үе<sup>17</sup> гэж менежментийн баг үзэж буй бөгөөд, компани сүлжээ дэлгүүрийн тэлэлтийг хурдасгаж 2023 он гэхэд 360 дэлгүүртэй болохоор төлөвлөжээ.

Зураг 12: Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК -ийн ашигт ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд



## 6. ҮНЭЛГЭЭ

### 6.1 Хөрөнгөд сүүрилсэн үнэлгээ


Хөрөнгөд сүүрилсэн хандлагыг үнэлгээнд хэрэглэхэд тухайн бизнесийн нийт хөрөнгөөс өр төлбөрүүдийг хасах замаар бизнесийн үнэ цэнийг тодорхойлдог. Энэ аргаар үнэлгээ хийхийн тулд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК болон Премиум Дистрибьюшн ХХК-үүдэн биет болон биет бус бүх хөрөнгүүд, мөн өр төлбөрийн үзүүлэлтүүдийн зах зээлийн үнэ цэнийг тогтоох замаар цэвэр хөрөнгийн хэмжээг тодорхойлох шаардлагатай.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК болон Премиум Дистрибьюшн ХХК-үүдэн хөрөнгө болон өр төлбөрүүдийг үнэлгээний зориулалтаар дараах байдлаар хувааж үнэлэв. Үүнд:

- Эргэлтийн бус хөрөнгө:
  - Газар эзэмших эрх
  - Барилга
  - Хөдлөх хөрөнгө
  - Тээврийн хэрэгсэл
- Эргэлтийн хөрөнгө:
  - Бараа материал
  - Бусад хангамж
  - Бусад

<sup>17</sup> <https://hbr.org/2017/05/stop-focusing-on-profitability-and-go-for-growth>





- Авлага
  - НӨАТ-ийн авлага
  - Бэлэн мөнгө
3. Өр төлбөр:
- Өглөг, зээл, бусад зэрэг орно.

### Эргэлтийн бус хөрөнгө

Эргэлтийн бус хөрөнгүүдийн онцлог байдлуудаас хамааран ҮОУС-д тодорхойлсон дараах аргуудыг ашиглав. Үүнд газар эзэмших эрх, тээврийн хэрэгслийн үнэлгээнд зах зээлийн хандлагын нийтэд арилжаалагддаг зүйлсийн арга, барилга байгууламж, бусад хөдлөх хөрөнгийн үнэлгээнд өртгийн хандлагын аргыг тус тус ашиглав.

Эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээнд Баянзүрх дүүрэг 11-р хороо, Хонхорт байрлалтай 3ш газар эзэмших эрхийн гэрчилгээтэй нийт 27,159 мкв, Налайх дүүрэгт байрлалтай 2ш газар эзэмших эрхийн гэрчилгээтэй нийт 20,000 мкв газар эзэмших эрх, Баянзүрх дүүрэг 11-р хороо, Хонхорт байрлалтай Хүнсний үйлдвэрийн барилга байгууламжууд, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК болон Премиум Дистрибьюшн ХХК-уудын дансанд бүртгэлтэй тавилга, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, компьютер, биет бус хөрөнгө, бусад хөрөнгүүдийг хамруулав. Үнэлгээний үр дүнг дараах хүснэгтэд, үнэлгээний дэлгэрэнгүй тооцооллыг Хавсралт 2-д үзүүлэв.

Хүснэгт 6: Эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээ

Хөрөнгө	Тодорхойлолт	Тооцоолсон үнэ цэн, төгрөгөөр
Газар эзэмших	Нийт 47,159 мкв талбайтай 5ш газар эзэмших эрх	3,402,746,417
Барилга байгууламж	Нийт 3,330.62 мкв талбайтай үйлдвэр, оффис, агуулахын барилга, инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, гадна тохижилт	10,919,089,483
Хөдлөх хөрөнгө	Нийт 13,607 ш хөдлөх хөрөнгө	22,685,672,662
Тээврийн хэрэгсэл	3ш тээврийн хэрэгсэл	106,623,571
Нийт		37,114,132,132

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн эргэлтийн бус хөрөнгийн нийт үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар нийт 37 тэрбум 114 сая төгрөгөөр тооцоолов.

### Эргэлтийн хөрөнгө

2021 оны 2-р улирлын санхүүгийн тайланд орсон дүнгээр тус компанийн нийт эргэлтийн хөрөнгө 16 тэрбум 319 сая төгрөг байна.

Хүснэгт 7: Эргэлтийн хөрөнгийн үнэлгээ

Хөрөнгө	Дүн, төгрөгөөр
Бараа материал	7,475,366,646
Урьдчилж гарсан зардал	2,235,031,715
Авлага	2,646,963,347
Бэлэн мөнгө	3,961,887,842
Нийт	16,319,249,551





Үнэт цаасны танилцуулга



### Өр төлбөр

2021 оны 2-р улирлын санхүүгийн тайланд орсон дүнгээр тус компанийн нийт өр төлбөр 27 тэрбум 367 сая төгрөг байна.

Хүснэгт 8: Өр төлбөр

Өр төлбөр	Дүн, өгрөгөөр
Эргэлтийн өр төлбөр	14,793,400,519
Урт хугацаат зээл	12,574,311,656
Нийт	27,367,712,174

### Цэвэр хөрөнгө

Хөрөнгөд суурилсан аргаар бизнесийг үнэлэхэд нийт хөрөнгөөс өр төлбөрийг хассан цэвэр хөрөнгөд үндэслэн тооцоолов.

Хүснэгт 9: Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн цэвэр хөрөнгийн хэмжээ

Үзүүлэлтүүд	Дүн, төгрөгөөр
Эргэлтийн хөрөнгө	16,319,249,551
Эргэлтийн бус хөрөнгийн үнэ цэн	37,114,132,132
Эргэлтийн өр төлбөр ба урт хугацаат зээл	(27,367,712,174)
Цэвэр хөрөнгийн хэмжээ	26,065,669,559

Дээрх тооцоолоор Сэнтрал Экспресс Си Ви Эд ХХК-ийн цэвэр хөрөнгө үнэлгээний өдрийн байдлаар 26 тэрбум 65 сая төгрөг байна. Энэ аргаар Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн үнэ цэнийг тодорхойлоход учир дутагдалуудтай. Учир нь тооцоололд тус компанийн ирээдүйн орлого олох чадварт чухал нөлөө үзүүлэх гоодвилл, барааны тэмдэгт, менежментийн үр чадвар зэрэг биет бус хөрөнгүүд ороогүйтэй холбоотой. Харьцуулан судлах ижил төстэй бизнесийн зах зээлийн мэдээлэл хомс үед компанийн ирээдүйн ашигт ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэх эдгээр биет бус хөрөнгийн үнэ цэнийг тооцоолохдоо эхлээд бизнесийн нийт үнэ цэнийг тооцоолж түүнээс бусад хөрөнгийн үнэ цэнийг хасах аргыг хэрэглэх нь оновчтой байдаг.

### 6.2 Зах зээлийн харьцуулалтын үнэлгээ

#### Үржүүлэгчийн тооцоолол

Конвиниенс сүлжээ дэлгүүрийн үнэлгээнд харьцуулалтаар авч болох ойролцоо эсвэл ижил төстэй олон нийтийн компани одоогоор Монгол Улсад байхгүй байгаа тул үнэлгээнд олон улсын компаниудын үржүүлэгчийг тооцоолж хэрэглэв.

Бид газарзүйн хувьд аль болох өргөн хүрээг хамруулах зорилгоор Ази, Америк, Европ, Өмнөд Америк тивд үйл ажиллагаа явуулж буй конвиниенс дэлгүүрүүдийн мэдээллийг ашиглан зах зээлийн дундаж үржүүлэгчдийг тодорхойлов. Дараах хүснэгтэд тухайн компанийн өрсөлдөгч компаниудын дундаж үржүүлэгчийг тодорхойлсон тул гадаадын зах зээлийг илэрхийлнэ гэж үзэж болно.

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК



Хүснэгт 10: Гадаад зах зээлийн дундаж үржүүлэгчийн тооцоо

Компаниуд	Улс	Өрсөлдөгч компаниудын дундаж үржүүлэгч		
		EV/Sales	EV/EBITDA	P/BV
Convenience Retail Asia Ltd	Хонг-Конг	0.96	6.4	3.43
FamilyMart Co Ltd	Япон	1.00	8.3	3.75
BGF Co Ltd	Солонгос	1.17	7.7	3.39
GS Retail Co Ltd	Солонгос	0.99	6.9	3.46
7-Eleven Malaysia Sdn Bhd	Малайз	1.02	7.0	3.66
Fomento Economico Mexicano SAV de CV	Мексик	3.23	16.2	6.21
Philippine Seven Corp	Филиппин	1.10	8.1	4.34
Magnit PJSC	Орос	1.02	7.0	3.66
Taiwan FamilyMart Co Ltd	Тайвань	1.01	7.1	4.31
President Chain Store Corp	Тайвань	1.04	7.2	3.97
7-Eleven Inc	Америк	1.02	7.0	3.66
Дундаж		1.23	8.1	3.99
Медиан		1.02	7.1	3.66
Хамгийн бага		0.96	6.4	3.39
Хамгийн их		3.23	16.2	6.21

Эх сурвалж: [www.ub-speeda.com](http://www.ub-speeda.com)

Америк, Япон улсуудын хувьд эдийн засгийн өсөлт багатай, түүнчлэн конвинеенс сүлжээ дэлгүүр үүсч хөгжөөд 50-иас дээш жил болж байгаа учир шүүд харьцуулалтанд ашиглахад тохиромж муутай.

Харин шүүд харьцуулалт хийх зорилгоор сонгон авсан улсын компаниудын 2013 оноос 2021 оны эхний хагас жилийг хүртэлх P/BV харьцааг дараах хүснэгтэд харуулав. Түүнчлэн, эдгээр компаниудын сүүлийн 5 жилийн дундаж EV/EBITDA харьцааг мөн харууллаа.

Хүснэгт 11: Харьцуулсан компаниудын 2012-2020 оны P/BV харьцаа

Компаниуд	Улс	P/BV										EV/EBITDA
		2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021.II	5 жил	
GS Retail Co Ltd	Солонгос	1.36	1.18	2.33	1.97	1.55	1.49	1.38	1.17	1.63	1.44	6.9
BGF Retail Co Ltd	Солонгос						7.20	4.95	3.48	4.16	4.95	4.0
President Chain Store Corp.	Тайвань	9.59	10.13	8.25	8.95	10.23	9.79	9.10	8.10	7.62	8.97	10.4
Taiwan FamilyMart Co Ltd	Тайвань	9.87	9.91	9.91	9.51	8.21	9.25	8.85	9.55	11.44	9.46	9.6
Philippine Seven Corp	Филиппин	11.81	8.22	7.67	8.32	16.05	14.53	14.53	12.54	9.87	13.50	18.9
Robinsons Retail Holdings Inc	Филиппин	8.27	2.74	2.07	2.21	2.65	2.35	1.77	1.41	1.13	1.86	10.7
CP All PCL	Тайланд	14.22	13.53	10.48	13.69	9.87	7.76	7.35	5.62	5.32	7.18	18.5
Central Retail Corp PCL	Тайланд								3.18	3.35	3.27	16.5
Sumber Alfaria Trijaya Tbk	Индонез	7.72	7.67	5.35	5.27	5.02	7.24	5.72	4.89	7.07	5.99	13.1
PT Midi Utama Indonesia Tbk	Индонез	3.28	3.17	3.57	2.96	3.44	3.17	2.82	4.28	3.75	3.49	7.5
Hero Supermarket Tbk	Индонез	2.07	1.87	0.89	1.01	0.70	0.63	0.95	1.10	4.29	1.53	20.5
Дундаж		7.6	6.5	5.6	6.0	6.4	6.3	5.7	5.0	5.4	5.6	12.4
Медиан		8.3	7.7	5.4	5.3	5.0	7.2	5.3	4.3	4.3	4.9	10.7







Үнэт цаасны танилцуулга



Хамгийн бага	1.4	1.2	0.9	1.0	0.7	0.6	1.0	1.1	1.1	1.4	4.0
Хамгийн их	14.2	13.5	10.5	13.7	16.1	14.5	14.5	12.5	11.4	13.5	20.5

Эх сурвалж: [www.morningstar.com](http://www.morningstar.com)

Харьцуулалтад хамрагдсан компаниудын дундаж P/BV харьцаа сүүлийн 5 жилд дунджаар 5.6, КОВИД 19 цар тахлын нөлөөгөөр 2020 онд 5.0 болж буураад 2021 оны эхний хагас жилд 5.4 болж буцаад өссөн байна.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь бизнесийн мөчлөгийн хувьд тэлэлтийн үедээ байгаа тул дэд бүтцээ хөгжүүлэх, шинээр дэлгүүр нээхэд хөрөнгө оруулалт ихээр хийж байгаатай холбоотойгоор өнгөрсөн онуудад алдагдалтай ажиллаж ирсэн. Иймд бизнесийн үнэ цэнийг тооцоолохдоо ашгийн харьцаанаас илүүтэйгээр орлогын харьцаа (EV/Sales) болон эздийн өмчийн харьцаа (P/BV)-г авч үзэх нь илүү тохиромжтой болно.

### Үржүүлэгчийн үнэлгээ

#### P/BV Үнэлгээ

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн цэвэр эздийн өмч үнэлгээний өдөр буюу 2021 оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаар 27.2 тэрбум төгрөг байна. IPO хийж нэмэлт 25.0 тэрбум төгрөгийн хувьцааны хөрөнгө оруулалт татсанаар эзэмшигчдийн өмч 52.2 тэрбум төгрөг болно. Гадаад зах зээлийн дундаж үржүүлэгч болон харьцуулсан компаниудын дундаж үржүүлэгчийг ашиглан тооцоолоход Post-Money буюу IPO-оор 25.0 тэрбум төгрөгийн санхүүжилт татсаны дараах Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн ерөнхий болон тухайлсан харьцуулалтыг харгалзан 207.990 тэрбум төгрөг болон 282.903 тэрбум төгрөг байхаар гарч байна.

Хүснэгт 12: P/BV харьцуулсан үнэлгээний дүн, сая төгрөгөөр



	P/BV, Зах зээлийн дундаж		P/BV, Компаниуд	
	Харьцаа	Бизнесийн үнэлгээ	Харьцаа	Бизнесийн үнэлгээ
Дундаж	3.99	207,990	5.42	282,903
Медиан	3.66	191,006	4.29	223,884
Хамгийн бага	3.39	176,915	1.13	58,972
Хамгийн их	6.21	324,083	11.44	597,023

Дээрх тооцоололд ашигласан P/BV харьцаанууд нь 2020 болон 2021 оны буюу КОВИД 19 цар тахлын нөлөө орсон үзүүлэлтүүд бөгөөд хэрэв цар тахлаас өмнөх 5 жилийн дундаж харьцааг ашиглавал үнэлгээ 3.39%-иар нэмэгдэхээр байна.

#### EV/Sales Үнэлгээ

Гадаадын зах зээл дэх компаниудын өрсөлдөгчдийн EV/Sales харьцааг ашиглан Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн үнэлгээг 2021-ээс 2025 оны жил бүрийн борлуулалтын орлогыг ашиглан тооцоолж үзэхэд дараах үр дүн гарч байна.





Хүснэгт 13: EV/Sales харьцуулсан үнэлгээний дүн, сая төгрөгөөр

EV/Sales дундаж харьцаа		1.23		
Хугацаа	Борлуулалт	Enterprise value	Equity value <sup>1</sup>	Present value of Equity <sup>2</sup>
2021	88,543	109,149	102,539	92,963
2022	237,897	293,262	270,186	201,343
2023	390,080	480,862	476,843	292,077
2024	475,369	586,000	627,111	315,730
2025	517,963	638,507	729,422	301,855

<sup>1</sup>Enterprise value = Equity value + Debt – Cash – Non operating assets

<sup>2</sup>Хорогдуулах хувийг DCF загварт тооцоолсноор 21.7%-иар авав

Дээрх хүснэгтийн 2021 оны борлуулалтын орлогыг ашиглан тооцоологдох үнэлгээний хувьд IPO-оор нэмэлт санхүүжилт татахаас өмнөх үеийн үр дүнгүүдийг хамаарч буй учир үг үнэлгээг шууд тодотгох нь зохимжгүй. Харин IPO-оор татах нэмэлт санхүүжилтын нөлөөллийг тусгахын тулд нэмэлт санхүүжилтээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэний дараах үеийн борлуулалтын орлогын үзүүлэлтийг авч үзэх шаардлага гарна.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь IPO-оор татах 25.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээс 19 тэрбум төгрөгийг 95 дэлгүүр шинээр нээхэд, үлдэгдэл 6 тэрбум төгрөгийг түгээлтийн төв болон хоолны үйлдвэрт нэмэлт тоног төхөөрөмж худалдан авахаар төлөвлөж байна. Харин бизнес төлөвлөгөөнд орсон 360 хүртэлх нэмэлт дэлгүүрийн анхны хөрөнгө оруулалтыг 2022 оны сүүлээр татах нэмэлт санхүүжилт болон цаашдын үйл ажиллагааны мөнгөн урсгалаас санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

Шинэ дэлгүүр нээгдсэнээс хойш 2 жилийн дотор борлуулалтын орлого нь тогтворждог гэж үзвэл IPO-оор татах нэмэлт санхүүжилтын шууд нөлөө нь 2023 оноос, харин эдгээр дэлгүүрийг амжилттай болгосны дараа нээгдэх цаашдын нэмэлт дэлгүүрийн нөлөө нь 2025 оноос компанийн орлого, ашигт ажиллагаанд томоохон нөлөөг бий болгохоор байна.

Харьцуулсан компаниудын дундаж EV/Sales харьцааг ашиглан Post-Money сууриар хийж гүйцэтгэсэн Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн өөр өөр оны борлуулалтад харгалзах үнэлгээний үр дүнг дээрх хүснэгтэд үзүүлэв.

#### EV/EBITDA Үнэлгээ

EV/EBITDA үнэлгээг EV/Sales үнэлгээтэй төстэй байдлаар хийж гүйцэтгэв. Ингэхдээ Хүснэгт 11-д үзүүлсэн компаниудын сүүлийн 5 жилийн EV/EBITDA харьцааны дундаж утга буюу 12.4 тоон утгыг авч ашиглав. Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн EBITDA-г сөрөг эсвэл бага утгатай байх жилүүдэд тус харьцааг ашиглах нь зохимжгүй. Бусад жилүүд дээр тооцоолсон үнэлгээний үр дүнг доорх хүснэгтэд үзүүлэв.



Хүснэгт 14: EV/EBITDA харьцуулсан үнэлгээний дүн, сая төгрөгөөр

EV/EBITDA дундаж харьцаа		12.4		
Хугацаа	EBITDA	Enterprise value	Equity value <sup>1</sup>	Present value of Equity <sup>2</sup>
2021	(6,629)	N/A	-	-
2022	847	10,509	-	-
2023	24,606	305,188	301,168	184,472
2024	41,831	518,822	559,933	281,908
2025	57,177	709,147	800,062	331,088

<sup>1</sup>Enterprise value = Equity value + Debt – Cash – Non operating assets  
<sup>2</sup>Хорогдуулах хувийг DCF загварт тооцоолсноор 21.7%-иар авав

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь бизнесийн мөчлөгийн хувьд тэлэлтийн үе шатанд байгаа тул шинээр дэлгүүр олноор нээж байгаа ба 2020-2022 жилүүдэд ашгийн түвшин хасах эсвэл бага байхаар байгаа нь EV/EBITDA харьцааг ашиглахад зохимжгүй нөхцөл үүсгэж байна. Харин 2023, 2024 оноос EV/EBITDA харьцааг ашиглан үнэлгээ хийх боломжтой бөгөөд санхүүгийн загварын үр дүнгээс тооцогдсон EBITDA-ийн хүлээгдэж буй утгыг ашиглавал бусад үнэлгээтэй нийцтэй тооцогдож байна.

#### Дүгнэлт

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн бизнес өмчлөлийн үнэ цэнийг Зах зээлийн харьцуулалтын аргаар тооцоолоход харьцуулах компаниар авч ашиглах үнэлгээчдэд итгэл үнэмшил төрүүлэхүйц, найдвартай мэдээлэлтэй дотоодын нээлттэй компани алга байна.

Иймд зах зээлийн харьцуулалтын аргаар хийх үнэлгээг ижил төстэй гадаад компаниудын үзүүлэлтийг ашиглан хийж гүйцэтгэв. Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь бизнесийн мөчлөгийн хувьд тэлэлтийн буюу өсөлтийн үе шатанд байгаа тул шинээр дэлгүүр нээх болон дэд бүтцийн хөгжүүлэлтэд хөрөнгө оруулалт ихээр хийж байна. Иймд ашгийн үзүүлэлт, харьцаанд үндэслэн хийсэн үнэлгээ нь үнэлгээний ажлын зорилгод нийцэл муутай байна.

Үйлчлүүлэгчийн бизнес хөгжүүлэлтийн өнөөгийн нөхцөл байдал, үнэлгээний ажлын зорилготой үялдуулан үнэлгээний эцсийн үр дүнг Хорогдуулсан Мөнгөн Гүйлгээний Аргаар хийж гүйцэтгэсэн үр дүнгээр авсан болно. Иймд P/BV харьцаа болон бусад харьцааг ашиглан хийсэн үр дүнг зөвхөн Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн зах зээлийн тооцоолсон үнэ цэнийг конвиниенс дэлгүүрийн зах зээл хөгжсөн гадаадын компаниудтай харьцуулах зорилгоор ашиглахыг зөвлөж байна.

#### 6.3 Орлогын хандлагын аргаар хийсэн үнэлгээ

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн бизнесийн мөчлөг болон санхүүгийн загварт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр олон нийтээс хөрөнгө татсаны дараах үеийн орлогын хандлагаар хийсэн үнэлгээ (Post-Money valuation) нь үнэлгээний ажлын зорилго болон үнэлгээний даалгавартай нийцнэ гэж дүгнэв.


Үнэлгээнд Орлогын хандлагын Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга, тодруулбал Байгууллагын цэвэр мөнгөн гүйлгээ (Free Cash Flow to Firm)-ний загварыг ашиглав.

Үнэлгээнд ашигласан орц, төсөөллүүд болон үндсэн тооцооллыг доор тайлбарлав.

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК

35





### Загварын орц, төсөөлөл, тооцооллууд

#### Шинээр нээх дэлгүүрийн тоо

Үнэлгээний өдрийн байдлаар Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь CU сүлжээ дэлгүүрийн нийт 124 салбар дэлгүүр нээн ажиллуулж байгаа ба цаашид 2021 оны 2-р хагаст 61 дэлгүүр, 2022 онд 100 дэлгүүр, 2023 онд 75 дэлгүүр нээж 2023 оны төгсгөлд нийт 360 дэлгүүртэй болохыг зорин ажиллаж байна.

Дараах үндэслэлээр 2023 он хүртэл нээх дэлгүүрийн төлөвлөтийг биелэх боломжтой гэж Үнэлгээчид үзсэн:

1. Улаанбаатар хот нь үнэлгээний өдрийн байдлаар нийт 800 орчим конвениенс дэлгүүрийн багтаамжтай гэж үзсэн бөгөөд 360 CU дэлгүүр нь үүний 45% орчмыг эзэлж байна. Энэ нь зах зээл дээр шинээр орж ирж байгаа GS25 шууд өрсөлдөгчийг тооцож үзсэн ч зах зээлийн өнөөгийн тэргүүлэгчийн хувьд биелэх бүрэн боломжтой зорилт болно.
2. IPO-оор татан төвлөрүүлэх нийт 25.0 тэрбум төгрөгийн санхүүжилтын 19 тэрбум төгрөгийг шинээр 95 дэлгүүр нээхэд зарцуулах, үлдсэн дэлгүүрүүдийн анхны хөрөнгө оруулалтыг 2022 онд татах нэмэлт санхүүжилт болон цаашдын үйл ажиллагааны эерэг мөнгөн үрсгалаас санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа нь харьцангуй бодитой төсөөлөл гэж үзэж байна.
3. IPO-оор татан төвлөрүүлэх нийт 25.0 тэрбум төгрөгийн санхүүжилтын 6 тэрбум төгрөгийг одоогийн түгээлтийн төв, хоол үйлдвэрлэлийн төвийг сайжруулахад зарцуулахаар төлөвлөж байгаа бөгөөд ингэснээр Үйлчлүүлэгчийн дэд бүтэц нь цаашид нийт 360 орчим дэлгүүрийн найдвартай ажиллагааг хангах, нэгж зардал буурах (economy of scale) нөхцөл бүрдэж байгаа нь бодитой зорилт гэж үзэж байна.

#### Борлуулалтын орлогын төсөөлөл

CU дэлгүүрүүдийн ирээдүйн борлуулалтын орлогын төсөөллийг хийх зорилгоор дэлгүүрийн өнгөрсөн хугацааны борлуулалтын статистик мэдээлэлд үндэслэн дэлгүүрүүдийг дараах 4 бүлэгт ангилж үзсэн болно.

Дэлгүүрүүдийн өдрийн дундаж борлуулалт	Нэгж	Эхний сар	12 сарын дараа	24 сарын дараа
<i>Тогтворжсон үед, 2021 оны 6 сарын байдлаар</i>				
Топ борлуулалттай дэлгүүрүүд	сая.төг	4.54	4.91	5.25
Борлуулалт сайн дэлгүүрүүд	сая.төг	3.03	3.27	3.50
Дундаж борлуулалттай дэлгүүрүүд	сая.төг	2.51	2.71	2.90
Дунджаас бага борлуулалттай дэлгүүрүүд	сая.төг	1.73	1.87	2.00
Дундаж	сая.төг			3.12

Дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалтын дээрх төсөөллийг хийхэд КОВИД 19 цар тахал Монгол Улсад дотоодод тархаснаас үүдэн хатуу хөл хорио тогтоохоос өмнөх сар болох 2020 оны 10-р сарын мэдээлэлд үндэслэн хийж гүйцэтгэв.

Үйлчлүүлэгчийн бизнес төлөвлөгөө, шинээр нээх дэлгүүрүүдийн байршлын төлөвлөлтөд үндэслэн Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн нийт 360 дэлгүүрийг дараах байдлаар ангилж борлуулалтын төсөөллийг гаргав.

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК

36





Шинэ дэлгүүрийн тоо	Дэлгүүрийн ангилал, борлуулалтаар					Тайлбар
	Он	Топ	Сайн	Дундаж	Бага	
2018	5	2	10	5	22	Ажиллаж байгаа дэлгүүрүүд
2019	1	1	21	11	34	
2020	-	2	15	30	47	
2021	-	4	53	25	82	Шинээр нээгдэх дэлгүүрүүд
2022	-	5	64	31	100	
2023	-	4	48	23	75	
<b>Нийт</b>	<b>6</b>	<b>18</b>	<b>211</b>	<b>125</b>	<b>360</b>	

Борлуулалтын орлогын суурь төсөөлөл дээр Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн менежментээс ойрын жилүүдэд авч хэрэгжүүлэх дараах арга хэмжээнүүдийн борлуулалтыг нэмэлтээр авч үзсэн болно.

Борлуулалтын нэмэгдэл	2022	2023	2024	2025	2026
Согтууруулах үндааны борлуулалт	0.2%	0.6%	1.8%	3.1%	4.0%
Хүнсний бус барааны борлуулалт	1.8%	3.3%	4.3%	5.3%	6.3%
24 цагийн хүргэлтийн үйлчилгээ	0.8%	1.4%	1.9%	2.4%	3.0%
<b>Нийт</b>	<b>2.8%</b>	<b>5.3%</b>	<b>8.0%</b>	<b>10.8%</b>	<b>13.3%</b>

Дээрх шинжилгээ, төсөөлөлд үндэслэн тооцоолж үнэлгээнд ашигласан Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн борлуултын цэвэр орлогын төсөөллийг доор үзүүлэв.

тэрбум төгрөг	2021H2	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Цэвэр борлуулалт	56.1	237.9	390.1	475.4	518.0	561.4	595.1	630.8	668.7	708.8

#### Үйл ажиллагааны зардлын төсөөлөл

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн нийт үйл ажиллагааны бүх зардлыг үнэлгээний зориулалтаар 1) борлуулалтын орлогоос шууд хамаарах хувьсах зардал, 2) дэлгүүрийн тооноос хамаарах зардал, 3) ерөнхий ба удирдлагын зардал гэж ангилан авч үзэв.

#### Борлуулалтын зардал

Борлуулалтаас шууд хамаарах зардалд борлуулсан бүтээгдэхүүний өртөг, дэлгүүрийн ажилчдын цалин болон борлуултын шүүд зардал, мастер франчайзын төлбөр гэх мэт зардлууд орсон ба үнэлгээний өдрийн байдлаар зардлууд борлуулалтын орлогын 94% орчмыг эзэлж байна.

Дэлгүүрийн тооноос хамаарч гарах зардалд дэлгүүрүүдийн түрээсийн зардал, ашиглалтын төлбөр, хамгаалалтын зардал гэх мэт зардлууд орсон бөгөөд 2021 оны нийт дүн 10.5 орчим тэрбум төгрөг орчим байна. Цаашид шинэ дэлгүүр нээгдэхийн хирээр нийт зардал өсөх боловч борлуулалтад эзлэх хувь нь буурахаар төлөвлөж байна.

2021 оны 1-р хагасын байдлаар Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Борлуулалтын зардал нь Борлуулалтын орлогын ойролцоогоор 103% орчим хувийг эзэлж байгаа бөгөөд тус компанийн менежмент нь цаашид энэ харьцааг бууруулж 2030 онд 82-83% болохоор тооцоолж байна. Үнэлгээчид энэ зорилтыг биелэх боломжтой зорилт гэж үзсэн болно. Учир нь:

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК

37







Ерөнхий удирдлагын зардал нь гадны хүчин зүйлээс шалтгаалахаас илүүтэй компанийн удирдлагын шийдвэрээс хамааралтай тул үнэлгээнд Сентрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн төлөвлөсөн дүнгээр авсан болно.

Сентрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн үйл ажиллагааны нийт зардлын 2030 он хүртэлх төсөөллийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 15: 2030 он хүртэлх үйл ажиллагааны зардлын төсөөлөл, тэрбум төгрөг

Зардлууд	2021H2	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Борлуулалтын зардал	59.2	228.8	356.1	423.7	450.5	476.6	502.2	528.3	556.4	588.2
Ерөнхий ба удирдлагын зардал	3.5	8.2	9.3	9.8	10.3	10.8	11.4	12.0	12.7	13.3
<b>Нийт</b>	<b>62.7</b>	<b>237.0</b>	<b>365.5</b>	<b>433.5</b>	<b>460.8</b>	<b>487.4</b>	<b>513.6</b>	<b>540.3</b>	<b>569.1</b>	<b>601.5</b>

#### Капиталын болон элэгдлийн зардлын төсөөлөл

CU сүлжээний 1 салбар дэлгүүрийг нээхэд ойролцоогоор 200 орчим сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдаж байгаа бөгөөд IPO-оор босгох 25 тэрбум төгрөгийн санхүүжилтийн 19 тэрбум төгрөгөөр 95 орчим дэлгүүр нээх, үлдэх санхүүжилтыг түгээлтийн төв, хоол үйлдвэрлэлийн төв болон IT дэд бүтцэд хөрөнгө оруулах хийхээр төлөвлөж байна. Цаашлаад 2023 он хүртэл нийт 360 дэлгүүртэй болохыг зорин ажиллаж байгаа ба шаардагдах хөрөнгө оруулалтын болон элэгдлийн зардлын 2030 он хүртэлх төсөөллийг доор үзүүлэв.

тэрбум төгрөгөөр

Үзүүлэлтүүд	2021H2	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Капитал зардал	14.6	25.2	16.9	1.5	2.2	3.9	5.1	5.2	2.1	2.9
Элэгдлийн зардал	2.9	8.4	11.1	11.3	10.3	9.8	9.6	9.1	8.2	6.5

#### Ажлын капиталын өөрчлөлт

Сентрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн цэвэр мөнгөн урсгалын төсөөллийг хийхэд ашиглагдах ажлын капиталын өөрчлөлтийг тооцоолов. Сентрал Экспресс Си Ви Эс ХХК нь гурвадгач компанийн бүтээгдэхүүнийг 3-5 долоо хоногийн дараа төлбөр хийх нөхцөлтэйгээр худалдан авч CU сүлжээ дэлгүүрүүдээр борлуулж байна. Дэлгүүрийн бараа эргэлт харьцангуй хурдан учир ихэнх тохиолдолд бараа нь энэ хугацаа дуусахаас өмнө борлуулагддаг. Үр дүнд тус компанийн цэвэр ажлын капиталын өөрчлөлт сөрөг дүнтэй буюу компанийн мөнгөн урсгалыг нэмэгдүүлэх байдлаар нөлөөлж байна. Ажлын капиталын мөнгөн урсгалын төсөөллийг доор үзүүлэв.

тэрбум төгрөгөөр

Ажлын капитал (АК)-ын мөнгөн урсгал (тэрбум төг)	2021H2	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт	2.9	6.3	(1.6)	(4.3)	0.7	0.8	1.0	1.2	1.3	1.4
Богино хугацаат өр төлбөрийн өөрчлөлт	5.5	17.2	13.3	3.9	2.6	2.6	3.7	4.1	4.4	4.7
Премиум Дистрибьюшн АЖК-н өөрчлөлт	(0.3)	(0.9)	(0.8)	-	0.0	0.0	(0.0)	0.0	-	-
<b>Цэвэр АК-ын өөрчлөлт</b>	<b>(2.8)</b>	<b>(11.8)</b>	<b>(15.8)</b>	<b>(8.2)</b>	<b>(1.8)</b>	<b>(1.9)</b>	<b>(2.7)</b>	<b>(2.9)</b>	<b>(3.1)</b>	<b>(3.3)</b>





Хэдийгээр худалдан авалтын өнөөдрийн жишгээр ажлын капиталын өөрчлөлт нь компанийн цэвэр мөнгөн урсгалыг нэмэгдүүлж байгаа боловч цаашид энэ байдал хэрхэн өөрчлөгдөх нь тодорхойгүй, мөнгөн урсгал нь тогтмол, найдвартай гарна гэж тооцоолох нь учир дутагдалтай тул үнэлгээнд болгоомжтой хандлагыг барьж энэхүү ажлын капиталын мөнгөн урсгалыг үнэлгээнд авч үзээгүй болно.

#### Хорогдуулах хувь

Бизнесийн үнэлгээнд ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцоолоход хорогдуулах хувийг ашиглана. Энэ нь тооцоолсон ирээдүйн цэвэр мөнгөн урсгал биеллээ олох эсэх магадлалтай уялдаатай бөгөөд хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын өгөөжийн хүлээлтийг илэрхийлдэг хэмжигдэхүүн юм.

Үнэлгээнд ашигласан мөнгөн урсгалын загвар болох FCFF загвартай үялдуулан хорогдуулах хувийг Weighted Average Cost of Capital (WACC) загвараар 18% байхаар тооцоолов. Томъёо болон тооцооллыг доор үзүүлэв.

- $WACC_{CE,MNT} = Weight_{Debt} \cdot K_{debt,at} + Weight_{equity} \cdot K_{equity}$
- $K_{debt,at} = CoD_{CE,MNT,After,Tax} = CoD_{CE,MNT,Before,Tax} \cdot (1 - \tau\%_{MNT})$
- $K_{equity} = CoE_{CE,MNT} = (1 + CoE_{CE,USD}) \cdot \frac{(1 + \pi_{MGL})}{(1 + \pi_{US})} - 1$
- $CoE_{CE,USD} = R_f + \beta_{CE} \cdot ERP_{Mature} + \lambda_{MGL} \cdot CRP + SizePremium_{CE} + BusinessLifecyleRiskPremium_{CE}$
- $\beta_{CE} = R_f + \beta_{Unl} \cdot ERP_{Mature} + \lambda_{MGL} \cdot CRP + SizePremium_{CE}$

WACC components	Symbols	Дүн	Тайлбар, эх сурвалж
Risk free rate	$R_f$	2.20%	30y US Treasury yield, an average of June 2021 <a href="https://www.treasury.gov/resource-center/data-chart-center/interest-rates/pages/textview.aspx?data=yield">https://www.treasury.gov/resource-center/data-chart-center/interest-rates/pages/textview.aspx?data=yield</a>
Country risk premium	CRP	6.30%	<a href="http://pages.stern.nyu.edu/~adamodar/New_Home_Page/datafile/ctryprem.html">http://pages.stern.nyu.edu/~adamodar/New_Home_Page/datafile/ctryprem.html</a>
Equity-market risk premium, mature	$ERP_{mature}$	4.72%	<a href="http://pages.stern.nyu.edu/~adamodar/New_Home_Page/datafile/ctryprem.html">http://pages.stern.nyu.edu/~adamodar/New_Home_Page/datafile/ctryprem.html</a>
Unlevered beta	$\beta_{Unl}$	0.5	<a href="http://pages.stern.nyu.edu/~adamodar/">http://pages.stern.nyu.edu/~adamodar/</a>
Levered beta	$\beta_{CE}$	0.66	Дээр үзүүлсэн томъёог ашиглан тооцоолсон дүн
Size premium		3.48%	Компанийн хэмжээтэй үялдуулан тооцсон эрсдэлийн нэмэгдэл
Business lifecycle risk premium		2.50%	Компани нь бизнесийн амьдралын циклийн өсөлтийн үе шатанд явж байгаа тул үүнтэй холбоотой эрсдэлийн нэмэгдэл
Cost of equity (USD)	$CoE_{CE,USD}$	17.6%	Дээр үзүүлсэн томъёог ашиглан тооцоолсон дүн
CPI - Mongolia	$\pi_{MGL}$	5.0%	Монгол Улсын Хэрэглээний үнийн индекс
CPI - United States	$\pi_{US}$	1.5%	<a href="https://www.bls.gov/cpi/">https://www.bls.gov/cpi/</a>
Cost of equity (MNT)	$K_{equity}$	21.7%	Дээр үзүүлсэн томъёог ашиглан тооцоолсон дүн
Cost of Debt		12.0%	СЭ компанийн бизнесийн зээлийн хүү
Tax rate	$\tau\%_{MNT}$	23.6%	СЭ компанийн санхүүгийн төсөөлөлд үндэслэн тооцоолов
Total cost of Debt	$K_{debt,at}$	9.16%	Cost of Debt (1-Tax rate)
Share of Equity	$Weight_{equity}$	70%	Салбарын дундаж харьцаагаар авав





Share of Debt	Weight <sub>debt</sub>	30%	1 – Share of Equity
WACC	WACC <sub>CE,MNT</sub>	18%	Дээр үзүүлсэн томъёог ашиглан тооцоолсон дүн

Урт хугацааны буюу 2030 оноос хойших цэвэр мөнгөн гүйлгээний жилийн дундаж өсөлтийг 4% байхаар авч үлдэх өртгийн тооцоололд ашиглав.

#### Мөнгөн урсгалын төсөөлөл, Цэвэр өнөөгийн үнэ цэнийн тооцоолол

Үнэлгээнд эхлээд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Байгууллагын үнэ цэн (Enterprise value)-ийг Байгууллагын цэвэр мөнгөн гүйлгээ (Free Cash Flow to Firm) загвараар тооцоолов. Тус компанийн 2030 он хүртэлх цэвэр мөнгөн урсгалын төсөөллийг IPO-оор санхүүжилт татсаны дараах байдлаар гаргаж дараах хүснэгтүүдэд үзүүлэв.

Хүснэгт 16: 2030 он хүртэлх орлогын үзүүлэлтийн төсөөлөл

Орлогын үзүүлэлтүүд, тэрбум ₮	2021H2	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Цэвэр борлуулалт	56.1	237.9	390.1	475.4	518.0	561.4	595.1	630.8	668.7	708.8
Борлуулалтын өртөг	59.2	228.8	356.1	423.7	450.5	476.6	502.2	528.3	556.4	588.2
Нийт ашиг	(3.1)	9.1	33.9	51.6	67.5	84.8	92.9	102.6	112.2	120.6
Ерөнхий удирдлагын зардал	3.5	8.2	9.3	9.8	10.3	10.8	11.4	12.0	12.7	13.3
ЕВITDA	(6.6)	0.8	24.6	41.8	57.2	74.0	81.5	90.5	99.6	107.3
Элэгдлийн зардал	2.9	8.4	11.1	11.3	10.3	9.8	9.6	9.1	8.2	6.5
ЕВIT	(9.5)	(7.6)	13.5	30.5	46.9	64.2	71.9	81.5	91.3	100.8
Хүүний зардал	1.8	1.7	2.3	1.9	1.5	1.1	0.6	0.1	0.0	0.0
Татварын өмнөх ашиг	(11.3)	(9.2)	11.2	28.7	45.5	63.1	71.3	81.3	91.3	100.8
ААНОАТ	-	-	0.2	6.3	10.5	14.9	16.9	19.4	21.9	24.3
Татварын дараах ашиг	(11.3)	(9.2)	11.0	22.4	35.0	48.2	54.4	61.9	69.4	76.5

Хүснэгт 17: 2030 он хүртэлх хөрөнгийн үзүүлэлтийн төсөөлөл

Хөрөнгийн үзүүлэлтүүд, тэрбум ₮	2021H2	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Хөрөнгө оруулалтын зардал	14.6	25.2	16.9	1.5	2.2	3.9	5.1	5.2	2.1	2.9
Зээл	16.9	25.0	22.3	17.9	13.7	8.7	3.0	0.0	0.0	0.0
Эздийн өмч	91.2	91.2	91.2	91.2	91.2	91.2	91.2	91.2	91.2	91.2
Хуримтлагдсан ашиг/алдагдал	(50.3)	(59.6)	(48.5)	(26.2)	8.8	57.1	111.4	173.3	242.7	319.2
Цэвэр эздийн өмч	40.9	31.6	42.6	65.0	100.0	148.2	202.6	264.5	333.9	410.4

Дээрх төсөөлөлд үндэслэн тооцоолоход 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг 211 818 313 851 (Хоёр зуун арван нэгэн тэрбум найман зуун арван найман сая гурван зуун арван гурван мянга найман зуун тавин нэг) төгрөг байхаар тооцоолов. Тооцооллыг үзүүлбэл:



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЭГ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-09-17  
Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-02



### Free Cash Flow to Firm

	2021H2	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
EBIT	(9,513)	(7,567)	13,481	30,510	46,915	64,155	71,912	81,450	91,336	100,781
Tax rate	0.0%	0.0%	1.8%	21.9%	23.0%	23.6%	23.7%	23.9%	24.0%	24.1%
Net operating profit after tax	(9,513)	(7,567)	13,244	23,841	36,115	49,031	54,841	61,989	69,402	76,486
Depreciation and Amortization	2,885	8,414	11,125	11,321	10,262	9,841	9,558	9,087	8,244	6,490
Capital expenditure	(14,637)	(25,195)	(16,894)	(1,547)	(2,168)	(3,931)	(5,057)	(5,151)	(2,070)	(2,901)
FCFF	<b>(21,266)</b>	<b>(24,348)</b>	<b>7,476</b>	<b>33,615</b>	<b>44,209</b>	<b>54,941</b>	<b>59,342</b>	<b>65,925</b>	<b>75,576</b>	<b>80,075</b>
PV of FCFF	(19,582)	(19,010)	4,950	18,871	21,044	22,175	20,309	19,131	18,596	16,707

### ESTIMATED MARKET VALUE OF EQUITY

Cost of Capital (WACC)	18%
Terminal growth	4.0%
Terminal value	557,624 сая.төг
PV of FCFF	103,190 сая.төг
PV of Terminal value	124,689 сая.төг
Enterprise value	127,879 сая.төг
Cash	3,961 сая.төг
Non operating assets	400 сая.төг
<b>Firm value</b>	<b>232,239 сая.төг</b>
Market value of Debt	12,575 сая.төг
Market value of Future debt	7,846 сая.төг
<b>Equity value</b>	<b>211,818,313,851 төгрөг</b>

## 7. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

ҮОУС-д заасны дагуу үнэлгээний ажлын зорилгод нийцүүлэн сонгосон зах зээлийн үнэ цэнийн суурьд хамгийн тохиромжтой үнэлгээний хандлага нь орлогын хандлага байна. Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 211 818 313 851 (Хоёр зүүн арван нэгэн тэрбум найман зүүн арван найман сая гурван зүүн арван гурван мянга найман зүүн тавин нэг) төгрөг байхаар тооцоолов.

Энэ нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн олон нийтээс 25.0 тэрбум төгрөгийн санхүүжилт татаж эздийн өмчөө нэмэгдүүлсний дараах үед хамаарах үнэлгээ (Post-Money valuation) болно. Харин олон нийтээс хөрөнгө татахын өмнөх үеийн үнэлгээ (Pre money valuation)-г дараах аргачлалаар тогтоохыг зөвлөж байна. Үүнд:

$$\begin{matrix} \text{Олон нийтээс хөрөнгө} & \text{Олон нийтээс хөрөнгө} & \text{Шинэ мөнгө буюу компанийн эздийн} \\ \text{татахаас өмнөх үнэлгээ} & \text{татахын дараах үнэлгээ} & \text{өмчийг нэмэгдүүлэх хөрөнгийн дүн} \\ \text{(Pre-Money valuation)} & \text{(Post-Money valuation)} & \text{(New money)} \end{matrix}$$

Үнэлгээний үр дүнг  $P/BV$  харьцаагаар олон улсын конвенциенс сүлжээ дэлгүүрийн бизнес эрхэлдэг компаниудтай харьцуулж үзүүлэв.

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК

42



Хүснэгт 18: Харьцуулалт, P/BV харьцаа

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК		4.06	
		Гадаад зах зээл	Гадаад компаниуд
1	Дундаж	3.99	5.42
2	Медиан	3.66	4.29
3	Хамгийн бага	3.39	1.13
4	Хамгийн их	6.21	11.44

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн бизнес өмчлөлийн тооцоолсон үнэ цэнийг эздийн өмчид харьцуулсан харьцаа (Price/BookValue) 4.06 гарсан ба энэ нь гадаад зах зээлийн дундаж үзүүлэлт болох 3.99-тэй ойролцоо, харин тухайлан сонгосон гадаад компаниудын дундаж үзүүлэлтээс бага гарсан байна.

#### Мэдрэмжийн шинжилгээ

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн бизнесийн үнэлгээний үр дүнгийн мэдрэмжийн шинжилгээг үнэлгээний тооцооллын үндсэн төсөөллүүд болох Борлуулалтын орлогын өөрчлөлт, Борлуулалтын зардлын харьцаа, Хорогдуулах хувь, Урт хугацааны өсөлтийн хувьд хийж гүйцэтгэв.

#### 1. Борлуулалтын орлого

Хувилбарууд	Хэмжээ, %	Үнэлгээ, тэрбум төг	Өөрчлөлт
Хувилбар 1	90%	164.9	-22.2%
Хувилбар 2	95%	188.5	-11.0%
Сүүр хувилбар	100%	211.8	100%
Хувилбар 3	105%	235.1	11.0%
Хувилбар 4	110%	258.1	21.9%

Борлуулалтын орлого үнэлгээний сүүр хувилбараас тодорхой хувиар өөрчлөгдөхөд үнэлгээний үр дүнгийн өөрчлөлтөд ойролцоогоор 2.2 мэдрэмжтэйгээр нөлөөлж байна. Тухайлбал, борлуулалтын орлого сүүр төсөөллөөс 5%-иар өсөх эсвэл буурахад үнэлгээний үр ойролцоогоор 11%-иар өсөх эсвэл буурахаар байна.

#### 2. Борлуулалтын зардлын харьцаа

Хувилбарууд	Хэмжээ, %	Үнэлгээ, тэрбум төг	Өөрчлөлт
Хувилбар 1	69.0%	539.9	154.9%
Хувилбар 2	75.0%	400.1	88.9%
Хувилбар 3	80.0%	281.5	32.9%
Сүүр хувилбар	83.0%	211.8	100%
Хувилбар 4	85.0%	162.6	-23.2%

Борлуулалтын зардлыг Борлуулалтын орлогод харьцуулсан харьцааг Үйлчлүүлэгчийн төлөвлөлтөд үндэслэн 2030 гэхэд 83.0% байхаар үнэлгээний сүүр хувилбарт авсан. Харин олон улсын сүлжээ дэлгүүрүүдийн CoS/Revenue дундаж харьцаа 2021 оны 1-р улирлын байдлаар 69% буюу харьцангуй бага түвшинд байна. Үнэлгээний үр дүн нь Борлуулалтын зардлын харьцаанаас маш мэдрэмтгийн хамааралтай байна.


#### 3. Хорогдуулах хувь-WACC

Хувилбарууд	Хэмжээ, %	Үнэлгээ, тэрбум төг	Өөрчлөлт
-------------	-----------	---------------------	----------

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК

43





Үнэт цаасны танилцуулга

Хувилбар 1	16.0%	271.5	28.2%
Хувилбар 2	17.0%	238.2	12.5%
Суурь хувилбар	18.0%	211.8	100%
Хувилбар 3	19.0%	186.1	-12.1%

Хорогдуулах хувийг 2.0 хувиар бууруулж 16.0%-иар авахад үнэлгээний үр дүн 28.2%-иар өсч 271.5 тэрбум төгрөг, 17.0%-иар авахад 12.5%-иар өсөж 238.2 тэрбум болж байгаа бөгөөд харин 1.0 хувиар өсгөж 19.0% болгоход үнэлгээ 12.61-иар буурч 186.1 тэрбум төгрөг болж байна. Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн менежментийн тооцоолсон хорогдуулах хувь (WACC) 16.0% бөгөөд Үнэлгээчид компанийн тэлэлтийн үеийн эрсдэлтэй үялдуулан хөрөнгө оруулагчийн хүлээх өгөөжийг 2.5%-иар нэмэгдүүлж авсан ба үр дүнд WACC 18.0% болсон болно.

#### 4. Урт хугацааны өсөлт

Хувилбарууд	Хэмжээ, %	Үнэлгээ, тэрбум төг	Өөрчлөлт
Хувилбар 1	3.5%	206.9	-2.3%
Суурь хувилбар	4.0%	211.8	100%
Хувилбар 2	4.5%	217.1	2.5%
Хувилбар 3	5.0%	222.7	5.2%

Урт хугацааны өсөлтийг 0.5 нэгж хувиар бууруулж 3.5%-иар авахад үнэлгээний үр дүн 2.3%-иар буурч 206.9 тэрбум төгрөг болж байгаа бөгөөд харин 0.5 хувиар өсгөж 4.5%-иар авахад үнэлгээ 2.5%-иар өсөж 217.1 тэрбум төгрөг, 5.0%-иар авахад 222.7 тэрбум төгрөг болж байна. Дүгнэхэд, урт хугацааны нэрлэсэн өсөлтийн бага хэмжээний өөрчлөлт нь үнэлгээний үр дүнг мөн бага хэмжээгээр өөрчилж байна.

#### Мэдрэмжийн шинжилгээний дүгнэлт

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн үнэлгээний үр дүн нь Борлуулалтын орлого, Борлуулалтын зардал, Хорогдуулах хувийн өөрчлөлтөд мэдрэмж өндөртэй, харин Урт хугацааны өсөлтийн хувийн өөрчлөлтөд мэдрэмж харьцангуй багатай байна. Үнэлгээний ажлын зорилготой үялдуулан үнэлгээний суурь хувилбарт мэдрэмж өндөр үзүүлэлтүүдийг харьцангуй болгоомжтой хандлага барьж авсан болно. Иймд цаашид үндсэн үзүүлэлтүүдийн өөрчлөлт нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн үнэ цэнийг бууруулах биш харин өсгөх байдлаар нөлөөлөх магадлал өндөр гэж үзэж болно.







Үнэт цаасны танилцуулга



### 8. ХАВСРАЛТ

- ХАВСРАЛТ 1: Үйлчлүүлэгч компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- ХАВСРАЛТ 2: Эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээ
- ХАВСРАЛТ 3: Үнэлгээчдийн сертификатын хуулбар

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК

45



364



СЭХ  
 2021-09-17  
 БҮРТГЭВ  
 № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
 MONGOLIAN STOCK EXCHANGE  
 2021-09-17  
 Үнэт цаасны танилцуулга  
 БҮРТГЭВ-02  
 ГЭРЭГЭ  
 ЭСТИМЭЙТ

ХАВСРАЛТ 1: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАР

СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК

Хууль зүйн сайдын 2016 оны 02204 тоогаар тусгайлан баталсан

МОНГОЛ УЛС  
 ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
 УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ  
 000136572

2017 02 22 / Бүртгэсэн өдөр / 9011651142 / Улсын бүртгэлийн дугаар /

6155804 / Регистрийн дугаар /

Сэнтрал экспресс Си Ви Эс Хязгаарлагдмал хариуцлагатай компани  
 / Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын нэлбэр /

Дүрэм / Гүрэм байгуулах баримт бичиг /

Шийдвэр 01 2017 02 20  
 / шийдвэрийн нэр / / дугаар / / өдөр /

4721 / лод / Хүнсний дэлгүүр / Үндсэн зэрлэх үйл ажиллагааны чиглэл /

4799 / лод / Худалдааны зүүчлэл / Туслах зэрлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй 1 100,0  
 / хугацаа / / ашиггүйн тоо / / өөрийн хөрөнгийн хэмжээ мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Баянгол 15-р хороо, энхтайвны өргөн чөлөө, 35 Махс моол худалдааны төв, 501 тоот, Утас: 88103888, Утас2: , Факс: 70122292  
 / хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн бүртгэлийн газар  
 / бүртгэсэн байгууллагын нэр /

Global  
 Capital  
 Delivering diversity  
 1115070111 1115070111

365



Үнэт цаасны танилцуулга



ХАВСРАЛТ 1: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАР

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/А	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэл	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Адилбил оюутай Ганболд-а Гуйцэтгэх захирал -р томилсныг бүртгэв.	2017.02.22	С.Мянгалуур
1	Өөрийн хөрөнгийн хэмжээ 527327 мян.төг-р нэмэгдэж нийт 527427 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2017.03.10	С.Шинэбаяр
2	Адилбил оюутай Ганцлал -а Гуйцэтгэх захирал -р томилсныг бүртгэв.	2017.10.30	Ж.Нямдорж
3	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, юнесто, МТМ голцонбор, 12 давхарт тоот, Утас: 88103889, Утас: 70122292 хаягийг шинээр бүртгэв.	2018.01.05	Д.Гансүмбэр
4	Ганболд оюутай Чинзориг -а Гуйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2018.02.19	Д.Гансүмбэр
5	Өөрийн хөрөнгийн хэмжээ 1206573 мян.төг-р нэмэгдэж нийт 1734000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2018.04.09	С.Мянгалуур
5	Өөрийн хөрөнгийн хэмжээ 9216730 мян.төг-р нэмэгдэж нийт 10950730 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2018.12.25	С.Мянгалуур
7	1075 Хүнсний үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааг шинээр бүртгэв.	2018.12.25	С.Мянгалуур
8	4610 Гадаад худалдаа эрхлэх үйл ажиллагааг шинээр бүртгэв.	2019.01.14	С.Мянгалуур
9	Өөрийн хөрөнгийн хэмжээ 4480000 мян.төг-р нэмэгдэж нийт 15430730 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2019.04.30	Д.Чутуулзуул
10	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимпын, 19, Шаньри-ла төв, Шаньри-ла офис 23 давхарт тоот, Утас: 88103889, Утас: 70122292 хаягийг шинээр бүртгэв.	2019.08.20	Д.Гансүмбэр
11	Дүрийн 11-т оруулсан өөрчлөлтийг бүртгэв.	2019.09.24	Ж.Нямдорж
12	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1714525.5 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2019.11.05	Ж.Нямдорж
13	Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2019.11.05	Ж.Нямдорж
19	Эцсийн өмчлөхч 1 иргэн бүртгэв.	2020.09.25	Б.Мянгалуур
20	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 50835511.9 мян.төг-р нэмэгдэж нийт 67980767.4 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2021.06.11	У.Баттөв
21	Хувьцаа эзэмшигч 8 нэмэгдэж 1 хэсэгдэж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 9 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2021.06.11	С.Сэнгэ, Г.Сэнгэ
22	Эцсийн өмчлөхч 1 иргэн бүртгэв.	2021.06.11	С.Сэнгэ
23	7730 Францын ахуйн үндсэн дээр бизнесийн үйл ажиллагаа явуулах үйл ажиллагааг шинээр бүртгэв.	2021.06.11	С.Сэнгэ







ХАВСРАЛТ 1: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАР

ПРЕМИУМ ДИСТРИБЬЮШН ХХК

Хууль зүйн байгуулсан 2016 онд  
А 2014 дугаар тусгайлоор батлагдсан

МОНГОЛ УЛС  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ  
000185291

2017.04.05 /Бүртгэсэн он, сар, өдөр / 9011668040 /Хувийн хэргийн дугаар /

6169287 /Регистрийн дугаар /

Премиум дистрибьюшн Хязгаарлагдмал хариуцлагатай компани  
/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм /Үүсэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр 01 2017.04.03  
/шийдвэрийн нэр / /дугаар / /он, сар, өдөр /

4863 Барилгын материалын худалдаа /код / /Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

4610 Гадаад худалдаа  
1079 Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл  
4630 Хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа  
4923 Агуулгын болон тээврийн туслах үйл ажиллагаа  
/код / /Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй 1 10,000.0  
/хугацаа / /шилшүүдийн тоо / /өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимпын, 19а, Шангри-Ла төв, Шангри-Ла оффис 23 давхарт, Утас: 70122292, Угас: 70122292, Факс: 70122292  
/хуулийн этгээдийн албан ёсны таяаг /

Гарчилгээ дахин олгосон 2019 он 8 сар 21 өдөр

Улсын бүртгэлийн ерөнхий газар  
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар  
/бүртгэсэн бадгуулигийн нэр /







ХАВСРАЛТ 1: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАР

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажлын тэмдэг
1	Адгалбиш овогтой Ганболд-е Гүйдцтэй захирал-р томилсоны бүртгэл.	2017.04.05	М.Монголжин
2	Давин гэрчилгээ өгөө.	2019.08.21	Г.Цолмон
3	Ганболд овогтой Чинзориг-е Гүйдцтэй захирал-р томилсоны бүртгэл.	2019.09.20	Э.Золмонболд
4	Шинэчилсэн дүрэм бүртгэл.	2019.09.20	Э.Золмонболд
5	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1072263 мин.төг-р нэмэгдэж нийт 1082263 мян.төг болсон өөрчлөлтийн бүртгэл.	2020.05.11	Г.Санжиа
6	Өссийн өмчлөгч 2 ирэн бүртгэл.	2020.05.11	Г.Санжиа
7	Өссийн өмчлөгч 2 ирэн бүртгэл.	2020.09.04	Н.Доржсүх
8	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 6642132.8 мян.төг-р нэмэгдэж нийт 7724395.8 мян.төг болсон өөрчлөлтийн бүртгэл.	2021.05.05	Э.Золмонболд
9	Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж 1 хэсвэдэж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэл.	2021.06.11	Г.Санжиа
10	Өссийн өмчлөгч бүртгэл.	2021.06.11	Г.Санжиа





## ХАВСРАЛТ 2: ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ

### ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээнд Баянзүрх дүүрэг 11-р хороо, Хонхорт байрлалтай 3ш газар эзэмших эрхийн гэрчилгээтэй нийт 27,159 мкв, Налайх дүүрэгт байрлалтай 2ш газар эзэмших эрхийн гэрчилгээтэй нийт 20,000 мкв газар эзэмших эрх, Баянзүрх дүүрэг 11-р хороо, Хонхорт байрлалтай Хүнсний үйлдвэрийн барилга байгууламжууд, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК болон Премиум Дистрибьюшн ХХК-үүдэн дансанд бүртгэлтэй тавилга, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, компьютер, биет бус хөрөнгө, бусад хөрөнгүүдийг хамруулав.

Эргэлтийн бус хөрөнгүүдийн онцлог байдлуудаас хамааран ҮОУС-д тодорхойлсон дараах аргуудыг ашиглав. Үүнд, газар эзэмших эрх, тээврийн хэрэгслийн үнэлгээнд зах зээлийн хандлагын нийтэд арилжаалагддаг зүйлсийн арга, барилга байгууламж, бусад хөдлөх хөрөнгийн үнэлгээнд өртгийн хандлагын аргыг тус тус ашиглав.

#### 1. Газар эзэмших эрхийн үнэлгээ

Харьцуулалтаар авсан хөрөнгийн мэдээлэл:

Харьцуулах үзүүлэлтүүд	Харьцуулах хөрөнгө 1	Харьцуулах хөрөнгө 2	Харьцуулах хөрөнгө 3
Зарлагдсан үнэ, төг	250,000,000	120,000,000	180,000,000
Нийт талбай, мкв	3,500	1,400	2,800
Нэгж үнэ, төг	71,429	85,714	64,286
Байршил, орчины байдал	БЗД 11-р хороо, Хонхор явах зам дагуу байрлалтай	БЗД 11-р хороо, Хонхороос Налайх явах зам дагуу байрлалтай	БЗД 11-р хороо, Хонхороос Налайх явах зам дагуу байрлалтай
Эзэмшлийн төрөл	Өмчлөх	Эзэмших	Эзэмших
Техник нөхцлүүд	Төвлөрсөн цахилгаан, цэвэр бохир усны шугамд ойроос холбогдох боломжтой	Төвлөрсөн цахилгаан, цэвэр бохир усны шугамд ойроос холбогдох боломжтой	Төвлөрсөн цахилгаан, цэвэр бохир усны шугамд ойроос холбогдох боломжтой
Зөвшөөрөгдсөн хэрэглээ, төлөвлөлт	Үйлдвэрлэл үйлчилгээ	Үйлдвэрлэл үйлчилгээ	Үйлдвэрлэл үйлчилгээ
Орц гарц, дэд бүтэц, карагдах байдал	Нүүрний эгнээнд байрлалтай	Нүүрний эгнээнд байрлалтай	2-р эгнээнд байрлалтай
Гэзрын төлөв байдал	Тэгш, хуурай гадаргуутай	Тэгш, хуурай гадаргуутай	Тэгш, хуурай гадаргуутай
Орчны тохижилт	-	-	-
Эх сурвалж	<a href="http://unegui.mn">unegui.mn</a>	<a href="http://remax.mn">remax.mn</a>	<a href="http://unegui.mn">unegui.mn</a>
Огноо	2021.05	2021.05	2021.05

Харьцуулсан тооцоолол:


№	Үзүүлэлт	Тооцоолол	ХХ-1	ХХ-2	ХХ-3
1	Зарахаар зарлагдсан нэгжийн үнэ, төг	1	71,429	85,714	64,286
2	Зарлагдсан үнэд хийсэн тохируулга	2	5%	5%	5%
3	Худалдсан эсвэл худалдах боломжит үнэ	3=1-1*2	67,857	81,429	61,071
4	Байршил, орчины байдал	4.1	1.00	1.00	1.00
	Эзэмшлийн төрөл	4.2	1.00	1.00	1.00

v





Үнэт цаасны танилцуулга



ХАВСРАЛТ 2: ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ

	Техник нөхцлүүд	4.3	1.00	1.00	1.00
	Зөвшөөрөгдсөн хэрэглээ, төлөвлөлт	4.4	1.00	1.00	1.00
	Орц гарц, дэд бүтэц, харагдах байдал	4.5	1.00	1.00	1.10
	Газрын төлөв байдал	4.6	1.00	1.00	1.00
	Орчны тохижилт	4.7	1.00	1.00	1.00
	Газрын хэмжээ, талбай ашиглах боломж	4.8	1.00	1.00	1.00
5	Тохируулсан нэгж талбайн үнэ, төг	5=П4j*3	67,857	81,429	67,179
6	Ач холбогдлын хувь	6	33.33%	33.33%	33.33%
7	Нэгж талбайн жинлэсэн дундаж үнэ, төг	7=ΣSi*Gi			72,155

Дээрх тооцоололд үндэслэн үнэлгээнд хамрагдсан нэгж талбайн эзэмших эрхийн үнэ цэнийг 72,155 төгрөг байхаар тооцоолов.

Эрхийн улсын бүртгэлийн дугаар	Талбай, кв	1 кв-ын үнэ	Нийт тооцоолсон үнэ цэнэ, төг
Э-2207000786	10,000	72,155	721,547,619
Э-2207000180	10,000	72,155	721,547,619
Э-2204005907	19,980	72,155	1,441,652,143
Э-2204005010	6,999	72,155	505,011,179
Э-2204005150	180	72,155	12,987,857
Нийт дүн	47,159	72,155	3,402,746,417

2. Барилга байгууламжийн үнэлгээ

Өртгийн хандлагын аргаар хийсэн барилгын үнэлгээний тооцооллыг үзүүлбэл:

Үзүүлэлт тохируулгын хүчин зүйлүүд	Үйлдвэрийн барилга	Оффисын барилга	Агуулах
Барилгын хийц	Төмөр бетон каркасан барилга	Тоосгон барилга	Тоосго, блокон барилга
Нэгж талбайн жишиг үнэ /2015.12.31 байдлаар/	1,380,000	885,480	629,000
Үнийн өсөлтийн итгэлцүүр	1.24	1.24	1.24
Үнэлгээнд тооцох талбай, кв	2,894.32	261.60	174.70
Халаалтын итгэлцүүр	1.00	1.00	1.00
Барилгын өндрийн итгэлцүүр	1.00	1.00	1.00
Гадна хана, талбайн итгэлцүүр	1.00	1.00	1.00
Чанарын итгэлцүүр	1.10	1.00	1.00
Байгалийн нөлөөллийн итгэлцүүр	1.05	1.00	1.00
Тээврийн итгэлцүүр	1.00	1.00	1.00
Үйл ажиллагааны элэгдэл	0%	0%	0%
Биет элэгдэл	0.00%	10.00%	10.00%
Нийт элэгдэл	0.00%	10.00%	10.00%
Өртгийн аргаар тооцоолсон үнэ цэнэ, төг	5,720,438,244	258,511,990	122,633,111
Нийт дүн			6,101,583,344

Барилга байгууламжийн нийт тооцоолсон үнэ цэнэ:

Хөрөнгө	Үндэслэл	Тооцоолсон үнэ цэнэ, төг
---------	----------	--------------------------

vi



370



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-09-17  
Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-02



ХАВСРАЛТ 2: ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ

Барилга	Өртгийн аргаа	6,101,583,344
Дэд бүтэц	Гэрээний үнэ	774,382,568
Уурын зуух	Гэрээний үнэ	492,661,675
Холбоо дохиолол, автоматжуулалт	Гэрээний үнэ	910,540,993
Хөргөлт	Гэрээний үнэ	688,764,833
Гадна тохижилт	Гэрээний үнэ	478,211,246
Бусад зардал	Гэрээний үнэ	1,472,944,824
Нийт дүн		10,919,089,483

3. Хөдлөх хөрөнгийн үнэлгээ

Хөдлөх хөрөнгийн үнэлгээнд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-д бүртгэлтэй 12,353 ширхэг хөрөнгө, Премиум Дистрибьюшн ХХК-д бүртгэлтэй 1,254 ширхэг, нийт 13,607 ширхэг хөрөнгө хамрагдав. Эхлээд хөрөнгүүдийн анхны үнийг үнийн өсөлтийн индексээр өсгөж шинэчилээд, дараа нь шулуун шугмын аргаар элэгдлийг тооцож үнэ цэнийг тооцоолов. Ингэхдээ үнэлгээний зориулалтаар хөрөнгүүдийг дараах байдлаар ангилж харгалзах онуудын үнийн өсөлтийн индексийг тодорхойлов.

Хөрөнгийн ангилал	Үнийн өсөлтийн индекс тооцох арга
Түрээсийн сайжруулалт	Барилгын өртгийн индекс
Тавилга	Хэрэглээний үнийн индекс, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны төрлөөр
Тоног төхөөрөмж	Долларын ханшийн өөрчлөлтөөр
Компьютер дагалдах хэрэгсэл	Долларын ханшийн өөрчлөлт 50%, Хэрэглээний үнийн индекс 50%
Цахилгаан хэрэгсэл	Долларын ханшийн өөрчлөлт 50%, Хэрэглээний үнийн индекс 50%
Бусад	Хэрэглээний үнийн индекс, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны төрлөөр
Биет бус хөрөнгө	Долларын ханшийн өөрчлөлтөөр

Үр дүнд дараах үнийн өсөлийн индексийг үнэлгээнд ашиглав.

Хөрөнгийн ангилал	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Түрээсийн сайжруулалт	1.00	1.00	1.00	1.12	1.09	1.08	1.00
Тавилга	1.22	1.20	1.17	1.10	1.06	1.03	1.00
Тоног төхөөрөмж	1.45	1.33	1.17	1.15	1.07	1.01	1.00
Компьютер дагалдах хэрэгсэл	1.34	1.27	1.17	1.13	1.07	1.02	1.00
Цахилгаан хэрэгсэл	1.34	1.27	1.17	1.13	1.07	1.02	1.00
Бусад	1.22	1.20	1.17	1.10	1.06	1.03	1.00
Биет бус хөрөнгө	1.45	1.33	1.17	1.15	1.07	1.01	1.00

Үнэлгээний үр дүнг үзүүлбэл:

Хөрөнгийн ангилал	Сэнтрал Экспресс		Премиум Дистрибьюшн		Нийт	
	Тоо	Дүн, төг	Тоо	Дүн, төг	Тоо	Дүн, төг
Түрээсийн сайжруулалт	137	6,756,627,728	2	87,715,156	139	6,844,342,884
Тавилга	5,044	1,800,795,887	357	99,752,630	5,401	1,900,548,517
Тоног төхөөрөмж	42	644,514,415	173	1,500,267,833	215	2,144,782,248
Компьютер дагалдах хэрэгсэл	3,670	704,811,766	-	-	3,670	704,811,766
Цахилгаан хэрэгсэл	2,943	5,163,146,409	-	-	2,943	5,163,146,409
Бусад	382	865,558,617	722	2,108,552,784	1,104	2,974,111,401
Биет бус хөрөнгө	135	2,953,929,437	-	-	135	2,953,929,437
Нийт	12,353	18,889,384,258	1,254	3,796,288,404	13,607	22,685,672,662

vii





**ХАВСРАЛТ 2: ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ**

**4. Тээврийн хэрэгслийн үнэлгээ**


Харьцуулалтаар авсан тээврийн хэрэгслийн мэдээлэл:

№	Тодорхойлолт	Марк	Үйлдвэрлэсэн огноо	Монголд ашиглаж эхэлсэн огноо	Ашиглалтын байдал	Зарын үнэ, төг
1	1382 УНИ	BMWХЗ	2013	2014	Хэвийн	
	Харьцуулах хөрөнгө 1 <sup>1</sup>	BMWХЗ	2012	2018	Хэвийн	45,000,000
	Харьцуулах хөрөнгө 2 <sup>2</sup>	BMWХЗ	2012	2021	Хэвийн	52,800,000
	Харьцуулах хөрөнгө 3 <sup>3</sup>	BMWХЗ	2012	2021	Хэвийн	44,400,000
2	1928 УАЕ	Hyundai Mega	2009	2019	Хэвийн	
	Харьцуулах хөрөнгө 1 <sup>4</sup>	Hyundai Mega	2002	2021	Хэвийн	40,000,000
	Харьцуулах хөрөнгө 2 <sup>5</sup>	Hyundai Mega	2008	2021	Хэвийн	50,000,000
3	5940 УНП	Hyundai Starex	2010	2019	Хэвийн	
	Харьцуулах хөрөнгө 1 <sup>6</sup>	Hyundai Starex	2010	2019	Хэвийн	19,000,000
	Харьцуулах хөрөнгө 2 <sup>7</sup>	Hyundai Starex	2010	2020	Хэвийн	20,000,000
	Харьцуулах хөрөнгө 3 <sup>8</sup>	Hyundai Starex	2011	2021	Хэвийн	23,000,000

Тээврийн хэрэгслийн үнэлгээний тооцоолол:

№	Тодорхойлолт	Зарын үнэ, төг	Тохируулгууд						Тохируулга хийсэн үнэ, төг	Тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ, төг
			Зарын үнийн тохируулга	Үйлдвэрлэсэн он	Импортолсон он	Нэмэлт тоноглол	Ашиглалтын байдал	Гадаад үзэмж өнгө		
1	1382 УНИ									45,185,250
	Харьцуулах	45,000,000	0.95	1.10	0.95	1.00	1.00	1.00	44,673,750	
	Харьцуулах	52,800,000	1.00	1.10	0.85	1.00	1.00	1.00	49,368,000	
	Харьцуулах	44,400,000	1.00	1.10	0.85	1.00	1.00	1.00	41,514,000	
2	1928 УАЕ									42,440,063
	Харьцуулах	40,000,000	0.95	1.30	0.90	1.00	0.95	1.00	42,237,000	
	Харьцуулах	50,000,000	0.95	1.05	0.90	1.00	0.95	1.00	42,643,125	
3	5940 УНП									18,998,258
	Харьцуулах	19,000,000	0.97	1.00	1.00	1.00	1.00	1.00	18,430,000	
	Харьцуулах	20,000,000	0.97	1.00	0.95	1.00	1.00	1.00	18,430,000	
	Харьцуулах	23,000,000	0.97	0.95	0.95	1.00	1.00	1.00	20,134,775	
	Нийт									106,623,571

<sup>1</sup> [https://www.unequi.mn/adv/4742207\\_bmw-x3-2012-2018/](https://www.unequi.mn/adv/4742207_bmw-x3-2012-2018/)  
<sup>2</sup> [https://www.unequi.mn/adv/4746032\\_bmw-x3-2012-2021/](https://www.unequi.mn/adv/4746032_bmw-x3-2012-2021/)  
<sup>3</sup> [https://www.unequi.mn/adv/4841026\\_bmw-x3-2012-2021/](https://www.unequi.mn/adv/4841026_bmw-x3-2012-2021/)  
<sup>4</sup> [https://www.unequi.mn/adv/4855323\\_hyundai-tevshte-i-2002/](https://www.unequi.mn/adv/4855323_hyundai-tevshte-i-2002/)  
<sup>5</sup> [https://www.unequi.mn/adv/4837118\\_hyundai-tevshte-i-2008/](https://www.unequi.mn/adv/4837118_hyundai-tevshte-i-2008/)  
<sup>6</sup> [https://www.unequi.mn/adv/5061453\\_hyundai-starex-2010-2019/](https://www.unequi.mn/adv/5061453_hyundai-starex-2010-2019/)  
<sup>7</sup> [https://www.unequi.mn/adv/4990760\\_hyundai-starex-2010-2020/](https://www.unequi.mn/adv/4990760_hyundai-starex-2010-2020/)  
<sup>8</sup> [https://www.unequi.mn/adv/4782513\\_hyundai-starex-2011-2021/](https://www.unequi.mn/adv/4782513_hyundai-starex-2011-2021/)



Унэт цаасны танилцуулга

ХАВСРАЛТ 3: ҮНЭЛГЭЭЧДИЙН СЕРТИФИКАТЫН ХУУЛБАРУУД

САНГИЙН ЯАМ

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар \_\_\_\_\_

Иргэний ургийн овог \_\_\_\_\_  
 Иргэний өвсг нэр \_\_\_\_\_  
 Иргэний үнэмлэхний дугаар \_\_\_\_\_  
 Иргэний бүртгэлийн дугаар \_\_\_\_\_  
 Үнэлгээний гэрчилгээний дугаар \_\_\_\_\_  
 Иргэний хаяг \_\_\_\_\_

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: \_\_\_\_\_

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан адресс хойш 3 жилийн хугацаанд түүний төгөлдөр үйлчилнэ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд заасныг бусад төлөвд өөрчлөх, байгуулах, бэлэглэх, барьцвалгах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД  УЛААНБААТАР ХОТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2018 оны 144 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2018 оны 12-р сарын 18-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав

САНГИЙН САЙД  / Б.БО.ТОР

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2018 оны 264 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2018 оны 12-р сарын 18-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав

САНГИЙН САЙД  / М.ХИРЭЛБААТАР

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20\_\_\_ оны \_\_\_ дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20\_\_\_ оны \_\_\_-р сарын \_\_\_-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав

САНГИЙН САЙД \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

ix







МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-09-17  
Үнэт цаасны танилцуулга  
БҮРТГЭВ-02



ХАВСРАЛТ 3: ҮНЭЛГЭЭЧДИЙН СЕРТИФИКАТЫН ХУУЛБАРУУД

САНГИЙН ЯАМ

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 11210001

Иргэний үргийн овог \_\_\_\_\_  
Иргэний овог нэр \_\_\_\_\_  
Иргэний үнэмлэхний дугаар \_\_\_\_\_  
Иргэний бүртгэлийн дугаар \_\_\_\_\_  
Үнэлгээний гэрчилгээний дугаар \_\_\_\_\_  
Иргэний хаяг \_\_\_\_\_  
Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо \_\_\_\_\_

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд түүний төгөлдөр үйлчилнэ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дугаар зүйлний 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тусгай зөвшөөрлийн үйлчилгээний байршил, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД *[Signature]* / ЧУБААН /  
УЛААНБААТАР ХОТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2015 оны 11 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг  
2015 оны 13-р сарын 18 ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.  
САНГИЙН САЙД *[Signature]* / Б.БО.ЛОП /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2015 оны 28 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг  
2015 оны 12-р сарын 18 ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.  
САНГИЙН САЙД *[Signature]* / Ч.ХҮРЭЛБААТАР /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ


Сангийн сайдын 20... оны ... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг  
20... оны ...-р сарын ... ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.  
САНГИЙН САЙД /







Үнэт цаасны танилцуулга



ХАВСРАЛТ 3: ҮНЭЛГЭЭЧДИЙН СЕРТИФИКАТЫН ХУУЛБАРУУД

САНГИЙН ЯАМ

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЯХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 101290183

Иргэний ургэйн овог: Хөвүүн  
Иргэний овог нэр: Доргов Оюунтөгн 1 хангаатар  
Иргэний үнэмлэхний дугаар:  
Иргэний бүртгэлийн дугаар: 0037112572  
Үнэлгээний гэрчилгээний дугаар:  
Иргэний хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 23-р хороо хуучир болон А-111 тал

Зөвшөөрөл олгосон шөйдөөр, огноо: Сангийн сайдын 2017 оны 1 дугаар сарын 11-ний өдөрхи 7 тоот тушаал

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгалсан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Ажлын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тусгай хуучин 5 дугаар хүснэгт 5.3 дэхь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуучин хэсэгт бусад төлөлд оруулах, худалдан авалтаас хамгаалах, барьцаалах зэргээр шалгуулга үл болно.

САНГИЙН САЙД 

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20... оны ... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг  
... оны 12 ... сарын 17 ... өдөрхи 3 жилийн хугацаагаар сунгаа.  
САНГИЙН САЙД  Ч.ХҮРЭЛБААТАР

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20... оны ... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг  
20... оны ... сарын ... өдөрхи 3 жилийн хугацаагаар сунгаа.  
САНГИЙН САЙД

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20... оны ... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг  
20... оны ... сарын ... өдөрхи 3 жилийн хугацаагаар сунгаа.  
САНГИЙН САЙД





6.19 Аудитын тайлан



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-09-17

Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-02


**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОЛОН УЛСЫН  
СТАНДАРТЫН ДАГУУ БЭЛТГЭСЭН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД БА ХАРААТ БУС  
АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**


**2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

"ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК ("PwC") нь 2019 оны 12 дугаар сарын 31-ээр болон 2020 оны 12 дугаар сарын 31-ээр дуусгавар болсон санхүүгийн тайлангуудын аудитыг хийж гүйцэтгэсэн. Гэвч PwC нь Хөрөнгийн Зах Зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д заасан дүгнэлтийг гаргаагүй бөгөөд Үнэт Цаасны Танилцуулгыг уншиж танилцаагүй болно. Тиймээс Үнэт Цаасны Танилцуулгад тусгасан мэдээлэлд үндэслэн аливаа гуравдагч этгээдийн гаргасан шийдвэр, авсан арга хэмжээнээс үүдэн тухайн этгээдэд учирсан хохирол, нэхэмжлэлд ямар нэг үүрэг, хариуцлага хүлээхгүй болно."





Үнэт цаасны танилцуулга



**Агуулга**

Хараат бус аудиторын дүгнэлт


**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД**

Санхүүгийн байдлын тайлан .....	1
Орлого үр дүн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайлан.....	2
Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	3
Мөнгөн гүйлгээний тайлан.....	4

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

1	Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн үйл ажиллагаа .....	6
2	Компанийн үйл ажиллагаа явуулж буй орчин.....	6
3	Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд .....	7
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан үндсэн тооцоолол ба үнэлэлт .....	18
5	Нягтлан бодох бүртгэлийн шинэ ба нэмэлт өөрчлөлт орсон стандартууд болон тайлбарууд .....	19
6	Шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн стандартын мэдэгдлүүд .....	20
7	Сегментийн мэдээлэл .....	21
8	Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ болон дансны үлдэгдлүүд .....	23
9	Үндсэн хөрөнгө .....	25
10	Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө болон түрээсийн өглөг .....	26
11	Биет бус хөрөнгө .....	27
12	Бараа материал .....	27
13	Урьдчилгаа .....	27
14	Дансны ба бусад авлага .....	28
15	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө .....	29
16	Санхүүгийн түрээсийн авлага .....	29
17	Хувьцаат капитал.....	31
18	Бусад татварын өглөг .....	31
19	Дансны ба бусад өглөг .....	31
20	Зээл .....	32
21	Санхүүжилтийн үйл ажиллагаанаас үүсэх өр төлбөрийн тохируулга .....	33
22	Гэрээний өр төлбөр .....	33
23	Орлого .....	33
24	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг .....	34
25	Ерөнхий ба удирдлагын зардал.....	34
26	Бусад орлого болон зардал, цэвэр дүнгээр .....	35
27	Санхүүгийн орлого.....	35
28	Санхүүгийн зардал .....	35
29	Орлогын албан татварын зардал .....	35
30	Мөнгөн бус хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа .....	37
31	Нэгж хувьцаанд ногдох ашиг.....	37
32	Болзошгүй өр төлбөр ба үүрэг .....	37
33	Санхүүгийн эрсдлийн удирдлага .....	38
34	Капиталын удирдлага.....	42
35	Бодит үнэ цэнийн тодруулга .....	42
36	Тайлагналын дараах үйл явдал.....	43
37	Орчуулга.....	44





## Хараат бус аудиторын тайлан

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдэд

### Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК ("Компани" гэх)-ийн санхүүгийн тайлангууд нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал хийгээд мөн тухайн өдрүүдээр дуусгавар болсон тайлант жилүүдийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

### Бид юунд аудит хийсэн талаар

Дараах бүрэлдэхүүн бүхий Компанийн санхүүгийн тайлангуудад бид аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдлын тайлангууд;
- тухайн өдрүүдээр дуусгавар болсон тайлант жилүүдийн орлого үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайлангууд;
- тухайн өдрүүдээр дуусгавар болсон тайлант жилүүдийн өмчийн өөрчлөлтийн тайлангууд;
- тухайн өдрүүдээр дуусгавар болсон тайлант жилүүдийн мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд болон бусад тайлбар мэдээллээс бүрдсэн санхүүгийн тайлангуудын тодруулга

### Дүгнэлтийн үндэслэл

Бид Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар тус тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

### Хараат бус байдал

Нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЭСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЭЗД)-ийн (Хараат бус байдлын олон улсын стандартыг оруулан) дагуу Компаниас бид хараат бус болно. Бид НБОУЭСЗ-ийн МНБЭЗД-ийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.


ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК, Сэнтрал Тауэр, 6 давхар, 601 тоот, Сүхбаатарын талбай, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Улаанбаатар хот 14200, Монгол улс  
Утас: +976 70009089, Факс: +976 (11)322068, www.pwc.com/mn







Үнэт цаасны танилцуулга



**Тасралтгүй байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал үүсэх**

Санхүүгийн тайлангийн Тодруулга 4-т анхаарлаа хандуулна уу. Энд 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Компанийн богино хугацаат өр төлбөр нь эргэлтийн хөрөнгөөс 26,904,936 мянган төгрөг (2019: 5,307,152 мянган төгрөг)-өөр илүү тусгагдаж, хуримтлагдсан алдагдал 33,525,294 мянган төгрөг (2019: 17,797,199 мянган төгрөг) байсан. Тодруулга 4-т дурдсанаар, эдгээр үйл явдал болон бусад асуудлуудтай холбоотой нөхцөл байдлууд нь Компанийн цаашдын тасралтгүй үйл ажиллагаанд ихээхэн эргэлзээ үүсгэж болзошгүй материаллаг тодорхойгүй байдал оршин байгааг харуулж байна. Энэ асуудлын хүрээнд бидний дүгнэлт өөрчлөгдөөгүй болно.

**Онцлох асуудал**

Санхүүгийн тайлангийн Тодруулга 3-т анхаарлаа хандуулна уу. Энд 2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн тайлангууд нь алдааны залруулгын үр дүнд дахин илэрхийлэгдсэн. Энэ асуудлын хүрээнд бидний дүгнэлт өөрчлөгдөөгүй болно.

**Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор засаглал хариуцсан эрх бүхий этгээд болон удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага**

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, бодитойгоор тайлагнах болон залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлангууд бэлтгэхэд шаардлагатай гэж удирдлагаг тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага байна.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад удирдлага Компанийн үйл ажиллагааг цаашид тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх, тухайн чадамжид нөлөөлөх нөхцөл байдлын талаар зохистой үед тодруулах болон Компанийн үйл ажиллагааг татан буулгах, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл зогсоохоос өөр сонголтгүй болсноос бусад тохиолдлуудад нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Компанийн засаглал хариуцсан эрх бүхий этгээд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

**Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Бидний зорилго бол залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл байх тохиолдол бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх боломжтой ба энэ нь санхүүгийн тайланг хэрэглэгчдийн эдгээр тайланд үндэслэн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц байвал материаллаг буруу илэрхийлэл болно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандах, мэргэжлийн холбогдох итгэл үнэмшил бүхий үнэлэлтүүдийг хийдэг. Мөн бид:

- Залилан болон алдааны улмаас санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг илрүүлэн үнэлэх, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг тодорхойлон гүйцэтгэх, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Залилан нь нууцаар үгсэн тохирох, хуурамч бичиг баримт үйлдэх, санаатайгаар орхигдуулах, хуурамч батламж гаргах эсвэл эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

Үнэт цаасны танилцуулга

2021-10-17  
БҮРТГЭВ-02



Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага  
(үргэлжлэл)

зэрэг үйлдлүүдтэй холбоотойгоор үүсдэг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас шалтгаалж үүсэх материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэлээс илүү өндөр байдаг.

- Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг тодорхойлох зорилгын хүрээнд дотоод хяналтын тогтолцооны ойлголтуудыг аудитын явцад олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцоолуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Компани нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадварт томоохон хэмжээний эргэлзээ үүсч болох нөхцөл байдал, тухайн үйл явдлуудтай холбоотойгоор материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэх болон удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр хангахад зөв зохистой нягтлан бодох бүртгэлийн суурийг сонгосон эсэхийг аудитын туршид бүрдүүлсэн нотолгоонд үндэслэн дүгнэдэг. Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжид материаллаг тодорхойгүй байдал оршин байгаа гэж үзсэн тохиолдолд санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг аудиторын тайланд тусгах, анхааруулах мөн эдгээр тодруулгууд хангалтгүй гэж үзсэн тохиолдолд дүгнэлтээ өөрчилдөг. Бид дүгнэлтээ аудиторын тайланг гаргах өдрийг хүртэл олж авсан аудитын нотолгоонуудад үндэслэн гаргадаг боловч ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлуудаас шалтгаалан Компанийн үйл ажиллагаа зогсох нөхцөл байдал үүсч болно.
- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд мөн багтдаг.



Даваагийн Баярмаа  
Гүйцэтгэх захирал

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Баталсан:

Шаукат Талиа

Партнер

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК


Монгол улс, Улаанбаатар хот

2021 оны 8 сарын 3-ны өдөр






Үнэт цаасны танилцуулга



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК


ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Сэнтрал Экспресс Си Ви Эс (цаашид "Компани" гэх) -ийн Гүйцэтгэх захирал Г.Чинзориг, болон Ерөнхий нягтлан бодогч Ш.Одончимэг, бид 1-ээс 4 дүгээр хуудаснаас бүрдсэн энэхүү санхүүгийн тайлан нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал болон мөн тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн болохыг үүгээр мэдэгдэж байна

  
Г.Чинзориг  
Гүйцэтгэх захирал

  
Ш.Одончимэг  
Ерөнхий нягтлан бодогч





Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК  
Санхүүгийн байдлын тайлан


Мянган төгрөгөөр	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>Хөрөнгө</b>			
	Эргэлтийн бус хөрөнгө		
	Үндсэн хөрөнгө	17,916,171	13,613,070
	Ашиглах эрхтэй хөрөнгө	16,813,036	15,617,396
	Биет бус хөрөнгө	2,808,115	2,913,232
	Бусад авлага	404,800	362,547
	Бусад эргэлтийн бус урьдчилгаа	369,717	21,324
	Санхүүгийн түрээсийн авлага	2,062,987	-
	Хойшлогдсон татварын хөрөнгө	240,809	-
	<b>Нийт эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>40,615,635</b>	<b>32,527,569</b>
	Эргэлтийн хөрөнгө		
	Бараа материал	6,710,974	4,024,691
	Урьдчилгаа	1,844,388	866,447
	Дансны ба бусад авлага	1,469,744	858,675
	Санхүүгийн түрээсийн авлага	171,821	-
	Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	6,104,077	651,484
	<b>Нийт эргэлтийн хөрөнгө</b>	<b>16,301,004</b>	<b>6,401,297</b>
	<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>56,916,639</b>	<b>38,928,866</b>
	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
	Хувьцаат капитал	17,145,256	17,145,256
	Хуримтлагдсан алдагдал	(33,525,294)	(17,797,199)
	<b>НИЙТ ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	<b>(16,380,038)</b>	<b>(651,943)</b>
	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
	Урт хугацаат өр төлбөр		
	Урт хугацаат түрээсийн өр төлбөр	19,570,737	15,321,360
	Урт хугацаат зээл	10,520,000	12,551,000
	<b>Нийт урт хугацаат өр төлбөр</b>	<b>30,090,737</b>	<b>27,872,360</b>
	Богино хугацаат өр төлбөр		
	Дансны ба бусад өглөг	24,320,649	6,857,967
	Богино хугацаат зээл	16,360,739	3,282,410
	Богино хугацаат түрээсийн өглөг	1,627,744	1,004,568
	Бусад татварын өглөг	439,644	516,840
	Гэрээний өр төлбөр	457,164	46,664
	<b>Нийт богино хугацаат өр төлбөр</b>	<b>43,205,940</b>	<b>11,708,449</b>
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>73,296,677</b>	<b>39,580,809</b>
	<b>НИЙТ ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР</b>	<b>56,916,639</b>	<b>38,928,866</b>

2021 оны 8 дугаар сарын 3-ны өдөр энэхүү тайланг нийтлэхийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурав.

  
Г. Чинзориг  
Гүйцэтгэх захирал

  
Ш. Одоымиег  
Ерөнхий нягтлан бодогч


Хуудас 5-44-д хавсаргасан Тодруулгууд нь энэхүү Санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.







Үнэт цаасны танилцуулга



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК  
Орлого үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	Тодр уулга	2020	2019
Орлого	23	45,348,032	37,467,874
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	24	(50,706,836)	(43,355,591)
<b>Нийт алдагдал</b>		<b>(5,358,804)</b>	<b>(5,887,717)</b>
Ерөнхий ба удирдлагын зардал	25	(5,102,425)	(4,189,853)
Үйл ажиллагааны бус орлого, зардал	26	(33,610)	1,987,673
<b>Үйл ажиллагааны алдагдал</b>		<b>(10,494,839)</b>	<b>(8,089,897)</b>
Санхүүгийн орлого	27	159,415	6,542
Санхүүгийн зардал	28	(5,588,408)	(3,190,813)
<b>Татварын өмнөх алдагдал</b>		<b>(15,923,832)</b>	<b>(11,274,168)</b>
Орлогын албан татварын зардал	29	195,737	(654)
<b>ТАЙЛАНТ ЖИЛИЙН АЛДАГДАЛ</b>		<b>(15,728,095)</b>	<b>(11,274,822)</b>
<b>Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого</b>		<b>-</b>	<b>-</b>
<b>ТАЙЛАНТ ЖИЛИЙН НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ АЛДАГДАЛ</b>		<b>(15,728,095)</b>	<b>(11,274,822)</b>
Нэгж энгийн хувьцаанд ногдох үргэлжилж буй үйл ажиллагааны суурь болон хорогдуулсан ашиг (алдагдал), (нэгж хувьцаанд ногдох төгрөг)	31	(91.73)	(80.25)

Хуудас 5-44-д хавсаргасан Тодруулгууд нь энэхүү Санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

2






**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Өмчийн өөрчлөлтийн тайлан**

Мянган төгрөгөөр	Тодруулга	Хувьцаат капитал	Хуримтлагдсан алдагдал	Нийт эздийн өмч
2019 оны 1 сарын 1-ний үлдэгдэл		10,950,730	(6,522,377)	4,428,353
Тайлант үеийн алдагдал		-	(11,274,822)	(11,274,822)
Гаргасан хувьцаа	17	6,194,526	-	6,194,526
2019 оны 12 сарын 31-ны дахин тайлагнасан үлдэгдэл		17,145,256	(17,797,199)	(651,943)
Тайлант үеийн алдагдал		-	(15,728,095)	(15,728,095)
2020 оны бусад дэлгэрэнгүй орлого		-	-	-
Гаргасан хувьцаа	17	-	-	-
2020 оны 12 сарын 31-ны үлдэгдэл		17,145,256	(33,525,294)	(16,380,038)

Хуудас 5-44-д хавсаргасан Тодруулгууд нь энэхүү Санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

3





Үнэт цаасны танилцуулга

**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Мөнгөн гүйлгээний тайлан**

Мяаган төгрөгөөр	Тодруулга	2020	2019
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
	Орлогын албан татварын өмнөх алдагдал	(15,923,832)	(11,274,168)
Тохируулгууд:			
	Үндсэн хөрөнгийн элэгдэл	9	3,048,671
	Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	10	1,823,177
	Биет бус хөрөнгийн хорогдуулалт	11	454,885
	Бараа материалын хэвийн бус хорогдол		26,870
	Найдваргүй авлагын зардал	26	1,052
	Ашиглах эрхтэй хөрөнгө данснаас хассаны цэвэр гарз	26	(234,568)
	Данснаас хассан хөрөнгө	26	76,645
	Гадаад валютын ханшийн зөрүү	26,28	145,819
	Бодит үнэ цэнээр хэмжигдсэн ашиг алдагдлаарх бусад санхүүгийн өр төлбөрөөс үүссэн олз хасах гарз	26	-
	Санхүүгийн орлого	27	(159,415)
	Санхүүгийн зардал	28	5,716,607
			3,105,275
	<b>Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>(5,024,089)</b>	<b>(5,534,111)</b>
	Дансны ба бусад авлагын өсөлт	(654,374)	(801,669)
	Бараа материалын өсөлт	(2,713,153)	(2,234,074)
	Урьдчилгаа төлбөрийн өсөлт	(977,941)	(629,592)
	Дансны ба бусад өглөгийн өсөлт	17,331,644	2,313,046
	Татварын өглөгийн бууралт	(77,196)	-
	Гэрээний өр төлбөрийн өсөлт	410,500	46,664
	<b>Ажлын капиталын өөрчлөлтийн дүн</b>	<b>8,295,391</b>	<b>(6,839,736)</b>
	Төлсөн орлогын албан татвар	(45,072)	(79,835)
	Хүлээн авсан хүүгийн орлого	27	159,415
	Төлсөн хүүгийн зардал – Зээл	21	(2,240,343)
	Төлсөн хүүгийн зардал – Түрээсийн өр	21	(2,974,883)
			(1,900,768)
	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>3,194,508</b>	<b>(9,914,703)</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
	Худалдаж авсан үндсэн хөрөнгө	9	(7,951,042)
	Худалдаж авсан биет бус хөрөнгө	11	(353,020)
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		174,232
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		3,251
	Санхүүгийн түрээсийн авлагаас хүлээж авсан дүн		571,098
			-
	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(7,555,481)</b>	<b>(10,696,680)</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
	Гаргасан хувьцаа	17	-
	Авсан зээл	21	13,787,912
	Зээлийн эргэн төлөлт	21	(3,241,964)
	Санхүүгийн түрээсийн төлөлт	21	(717,602)
			(759,905)
	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>9,828,346</b>	<b>21,078,892</b>
	Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	(14,780)	(3,788)
	<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>15</b>	<b>651,484</b>
			<b>187,763</b>
	<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт</b>	<b>5,452,593</b>	<b>463,721</b>

Хуудас 5-44-д хавсаргасан Тодруулгууд нь энэхүү Санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

4



386



Үнэт цаасны танилцуулга

**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Мөнгөн гүйлгээний тайлан**

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15	6,104,077	651,484
---	----	-----------	---------

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг ашиглах шаардлагагүй, мөнгөн гүйлгээний тайлангаас хассан хөрөнгө оруулалтын гүйлгээг Тодруулга 30-ээс харна уу.

Хуудас 5-44-д хавсаргасан Тодруулгууд нь энэхүү Санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

5





**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**1 Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн үйл ажиллагаа**

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК (цаашид "Компани" гэх)-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант хугацааны эдгээр санхүүгийн тайлангууд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС") -ын дагуу бэлтгэгдсэн

Тус компани нь Монгол Улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Компанид 6155804 бүртгэлийн дугаар бүхий 9011651142 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээг 2017 оны 2 сарын 22-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас олгосон.

2020 оны 12-р сарын 31 болон 2019 оны 12-р сарын байдлаар Премиум Групп ХХК ("Толгой Компани" эсвэл "ПГ" гэх) нь Монгол Улсад бүртгэлтэй бөгөөд Компанийн шууд ба эцсийн хувьцаа эзэмшигч юм. ПГ Компанийн 90.1%-ийг эзэмшдэг бөгөөд эцсийн хяналтыг Монгол Улсын иргэд А. Ганболд болон А. Ганхуяг нар хэрэгжүүлдэг. Компанийн 9.99%-ийг БНСУ-д бүртгэлтэй БиЖиЭф Ритэйл ХХК эзэмшдэг.

Компанийн удирдлага нь Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагаас бүрддэг. Хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцох замаар Компанийг удирддаг.

2019 оны 12-р сарын 31 болон 2020 оны 12-р сарын 31-ны байдлаар Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд:

- А. Ганхуяа, ТУЗ-ын дарга, Премиум Групп ХХК-ын хувьцаа эзэмшигч
- А. Ганболд, Премиум Групп ХХК-ын хувьцаа эзэмшигч
- О. Батмөнх, Премиум Групп ХХК-ын хувьцаа эзэмшигч
- Г. Бат-Эрдэнэ, Премиум Групп ХХК-ын хувьцаа эзэмшигч
- Г. Чинзориг, Компанийн гүйцэтгэх захирал

**Үндсэн үйл ажиллагаа.** Компанийн үндсэн бизнесийн үйл ажиллагаа нь жижиглэнгийн бараа, бүтээгдэхүүнийг Монгол улсад сүлжээ дэлгүүрүүдээр зарж борлуулдаг. 2018 оны 4-р сарын 18-ны өдөр компани нь ая тухтай үйлчилгээ үзүүлэх дэлгүүрийн үйл ажиллагаа эрхэлдэг БНСУ-д байрладаг БиЖиЭф Ритэйл ХХК компанитай мастер франчайзийн гэрээ байгуулж, дэлгүүрүүдээ солонгос улсын бренд болох "CU" болгон шинэчилсэн.

2020 оны 12-р сарын 31-ний байдлаар дэлгүүрийн тоо 105 (2019: 56).


2020 оны 12-р сарын 31-ний байдлаар Компанийн ажилчдын тоо 993 (2019: 791).

**Бүртгэлтэй хаяг болон бизнесийн үйл ажиллагаа явуулж буй байршил.** Компанийн бүртгэлтэй хаяг нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 19А, Шангри-Ла төв, Шангри-Ла оффис, 23 давхарт байрладаг.

**Тайлагналын мөнгөн тэмдэгт.** Эдгээр санхүүгийн тайлангууд нь өөрөөр заагаагүй бол Компанийн бүртгэлийн мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр толилуулагдаж мянган Монгол төгрөг (төгрөг)-өөр илэрхийлэгдсэн.

**2 Компанийн үйл ажиллагаа явуулж буй орчин**

Монгол Улсын өндөр инфляци болон хүүгийн түвшний өсөлт нь хөгжиж буй зах зээлийн шинж чанарыг харуулж байна. 2017-2019 онд дунджаар 6 орчим хувиар өссөлттэй байсан эдийн засаг COVID-19 цар тахлын сөрөг нөлөөгөөр, гадаадын хөрөнгө оруулалт удааширч, макро эдийн засгийн эмзэг байдал бий болсон зэргээс шалтгаалан Монголын эдийн засаг хумигдаж байна. 2021-2022 онд Монголын эдийн засаг 4-өөс дээш хувиар өсөх хандлагатай байгаа нь хувийн хэрэглээ, уул уурхай, үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалт хийхэд хүчтэй түлхэц болно.



**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**2 Компанийн үйл ажиллагаа явуулж буй орчин (Үргэлжлэл)**

Гэсэн хэдий ч эдийн засгийн секторуудын хувьд сэргэлт жигд бус байгаа бөгөөд цаашдын төлөв байдал ч харилцан адилгүй байгаа ба Ковид-19 цар тахалын дотоод дахь дэгдэлттэй холбоотой тодорхой бус байдал буураагүй байна.

Тус улсын үнэлгээ нь 2020 оны 7-р сарын 9-ний өдрийн байдлаар Стандарт Энд Пүүрс Үнэлгээний Үйлчилгээнээс тогтвортой төлөвтэй В түвшинд байсан. Мүүди'с үнэлгээний агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2020 оны 12-р сарын 18-ны өдөр "В" гэж зарласан. "В" -ийн зэрэглэлийг хадгалахад дараахь хүчин зүйлс гол нөлөө үзүүлдэг: Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлт, Засгийн газрын тэргүүлсэн төсвийн сахилга батыг сайжруулах; түүхий эдийн үнэ.

Дэлхийн эдийн засагт үүсээд буй тодорхойгүй байдал, санхүүгийн зах зээлийн хэлбэлзэл, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн уналт, шинэ коронавирус COVID-19-ийн үүсэл, тархалт, Хятадын эдийн засгийн өсөлтийн удаашрал, Монголын эдийн засгийн өсөлтийн удаашрал, төгрөгийн ам доллар болон евротой харьцах ханшийн сулралт, бусад болзошгүй эрсдлүүд нь Монголын санхүүгийн болон бизнесийн салбарт мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.

Монгол Улсын эдийн засгийн ирээдүйн гүйцэтгэл нь Хятадаас түүхий эдийн эрэлт тасралтгүй үргэлжлэх, дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ өндөр байх, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засаг, санхүү, мөнгөний бодлогын үр ашиг, татвар, хууль эрх зүйн зохицуулалт, улс төрийн үйл ажиллагаантай хамааралтай хэвээр байна. Эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулахын тулд Монгол Улсын Засгийн газраас Нийгмийн даатгалын шимтгэлийг чөлөөлөх, түрээсийн төлбөрөөс хөнгөлөлт үзүүлж буй аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх зэрэг шийдвэр гаргасан нь Компанийн бизнесийн үр дүнд нөлөөлсөн.

Монгол Улсын Засгийн Газар 2021 оны 2-р сарын 11-ээс 2021 оны 2-р сарын 23-ны хооронд, 2021 оны 4-р сарын 10-наас 2021 оны 5-р сарын 10-ны хооронд хатуу хөл хорио тогтоосон. Зохицуулалтын өөрчлөлтийг үндэслэн дэлгүүрүүдийн ажлын цагийг ихэвчлэн 07:00 - 22:00 цаг хүртэл хязгаарлав.

Компани хөл хориог 4-р сарын эцсээр дуусна гэж таамаглаж байсан ба 2021 оны эхний хагас жилийн борлуулалт төсөвтэй харьцуулахад 89.4%-н биелэлттэй байна. Нэг дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалт төсөвтэй харьцуулахад 89.7% -н биелэлттэй байна.

Удирдлагын зүгээс Компани нь бизнесийнхээ тогтвортой байдал, хөгжлийг дэмжихэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Удирдлага нь Монголын эдийн засагт нөлөөлж болох бүх үйл явцыг, тэдгээр нь Компанийн ирээдүйн санхүүгийн байдалд ямар нөлөө үзүүлж болохыг урьдчилан таамаглах боломжгүй байгаа юм. Компанийн удирдлага бизнесийнхээ тогтвортой байдал, хөгжлийг дэмжихэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч байна гэж үзэж байна.

**3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд**


**Тайлан бэлтгэх үндэслэл.** Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналийн Олон Улсын Стандарт ("СТОУС") -ын дагуу түүхэн өртгийн зарчмын дагуу бэлтгэгдсэн бөгөөд санхүүгийн хэрэглүүрийн өөрчлөгдсөн анхдагч хүлээн зөвшөөрөлт нь бодит үнэ цэнэд суурилсан ба ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр санхүүгийн хэрэглүүрийг ангилсан. Эдгээр санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогыг доор харуулав. Өөрөөр тэмдэглээгүй бол, эдгээр бодлогыг танилцуулсан бүх хугацаанд тууштай мөрдсөн

СТОУС-ын дагуу санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн зарим чухал тооцоолуудыг ашиглахыг шаарддаг. Мөн Компанийн удирдлагаас НББ-ийн бодлогуудыг хэрэгжүүлэхдээ үнэлэлт, дүгнэлт хийхийг шаарддаг. Санхүүгийн тайлангуудад мэдэгдэхүйц хэмжээгээр нөлөө үзүүлэх тооцоолол болон таамаглалууд эсвэл нарийн, өндөр түвшний үнэлэлт, дүгнэлтийн талаар Тодруулга 4-д тусгасан.





Үнэт цаасны танилцуулга



**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)**

2019 Санхүүгийн тайлангуудын дахин тайлагнал. Өмнө нь олгосон хувьцааны опционыг мөнгөн төлбөрт хувьцаанд суурилсан төлбөрөөр 2019 оны 12-р сарын 31-ээр санхүүгийн тайландаа тусгасан байсан ба энэ нь компани ХХК бүтэцтэй байсан бөгөөд сөрөг тал хувьцааныхаа өгөөжийг хүртэхдээ Компанид буцааж худалдана хэмээн таамагласантай холбоотой. Хувьцааны опционыг 2019 оны 6-р сард хэрэгжүүлсэн (Тодруулга 18). 2020 оны санхүүгийн тайланг бэлтгэх явцада менежмент сөрөг талд гаргасан хувьцааг 2019 оны 6-р сараас хойш СТОУС 2: хувьцаанд суурилсан төлбөрийн дагуу биш НББОУС 32. Санхүүгийн хэрэглүүр: Топилуулгын дугаа бүртгэнэ гэсэн дүгнэлт гаргасан. НББОУС 32-ын дагуу бэлэн мөнгөөр тооцоо хийх эдийн засгийн албадлага нь өр төлбөр бүртгэн үндэслэл болдоггүй. Иймд Менежмент 2019 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн тайланг уг өөрчлөлтийг залруулан, дахин тайлагнасан.

**Гадаад валютын хөрвүүлэг.** Компанийн үйл ажиллагааны валют нь тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн анхдагч орчны валют юм. Компанийн үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт, мөн компанийн танилцуулах валют нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг ("төгрөг") юм.

**Гүйлгээ болон үлдэгдэл дүнгүүд.** Мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлант хугацааны эцэст Монголбанк ("МБ")-ны албан ханшаар Компанийн бүртгэлийн мөнгөн тэмдэгт рүү хөрвүүлдэг. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ болон гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлан тэнцлийн өдрийн МБ-ны албан ханш руу хөрвүүлснээс үүсэх ханшийн олз, гарзыг ашиг алдагдалд зөвшөөрдөг.

Зээл ба мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөтэй холбоотой гадаад валютын ханшийн олз, гарзыг орлого үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайланд "санхүүгийн орлого" эсвэл "санхүүгийн зардал"-д тусгадаг. Бусад бүх гадаад валютын ханшийн олз, гарзыг орлого үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайланд "Үйл ажиллагааны бусад зардал - цэвэр дүнгээр" тусгана. Жилийн эцсийн ханшаарх хөрвүүлэлт нь түүхэн өртөгөөр хэмжигддэг мөнгөн бус зүйлсэд хамаарахгүй. Гадаад валютаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх мөнгөн бус зүйлс болон өмчөөрх хөрөнгө оруулалтыг оруулаад бүгдийнх нь бодит үнэ цэнийг тодорхойлсон бол тухайн өдрийн арилжааны ханшийг ашиглан хөрвүүлнэ. Гадаад валютаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийн ханшийн өөрчлөлтийн үр нөлөө нь бодит үнэ цэнийн олз эсвэл гарзын нэг хэсэг болж бүртгэгддэг. 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх гадаад валютаар илэрхийлэгдсэн балансын дансдыг хөрвүүлэхэд ашигласан албан ханш 1 АМ ДОЛ. = 2,849.51 ТӨГ (2019 онд: 1 АМ ДОЛ. = 2,733.52), 1 ВОН = 2.63 (2019 онд 2.37) байв. Орлого, зардлыг хөрвүүлэхэд ашигласан валютын дундаж ханш нь гүйлгээ хийсэн өдрийн спот ханш.

**Үндсэн хөрөнгө.** Үндсэн хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнэ бууралтын гарзыг хассан дүнгээр толилуулна.

Дараа нэмэгдэн гарах зардал, өртгүүдийн ирээдүйн эдийн засгийн өгөөжийг Компани хүртэх магадлалтай бөгөөд тухайн хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой тохиолдолд тухайн хөрөнгийн өртөгт тусгах эсвэл тусдаа хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Урсгал засвар үйлчилгээний өртгийг тухайн үед нь зардал болгож бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн гол эд ангийг солиход гарсан өртгийг капиталжуулж, хуучин эд ангийг данснаас хасна.

Тайлант хугацааны эцэс бүрт удирдлага нь тухайн хөрөнгийн үнэ цэнэ буурсан шинж тэмдэг илэрсэн эсэхийг үнэлж тодорхойлдог. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл удирдлага уг хөрөнгийн нөхөгдөх өртгийг хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулахад гарах зардлыг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль ихээр нь тодорхойлдог. Дансны дүнг нөхөгдөх өртөг хүртэл бууруулж, холбогдох үнэ цэнийн бууралтын гарзыг тухайн жилийн орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг. Хэрэв үндсэн хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ эсвэл бодит үнэ цэнээс борлуулахад гарах зардлыг хассан дүнг тодорхойлоход ашигласан тооцоололд өөрчлөлт орох тохиолдолд өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцааж болно. Хөрөнгийг борлуулж данснаас хасах үед хөрөнгийн ашиглалт эсвэл борлуулалтаас ирээдүй эдийн засгийн өгөөж гарахгүй гэж тооцсон тохиолдолд үндсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.







**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)**

Үндсэн хөрөнгө борлуулсны олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулсан үнийг тухайн үеийн бүртгэлийн дүнтэй харьцуулан тооцож тухайн жилийн орлого үр дүнгийн тайланд үйл ажиллагааны орлого, зардал (цэвэр) хэгэст хүлээн зөвшөөрнө.

**Элэгдэл.** Газрыг элэгдүүлэхгүй. Үндсэн хөрөнгийн бусад зүйлсийн элэгдлийг элэгдэх өртгийг ашиглалтын хугацаанд шулуун шугамаар элэгдүүлэх аргаар тооцно.

Ашиглалтын хугацаа, жилээр

Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл	10 жил
Тавилга ба оффисын хэрэгсэл	10 жил
Түрээсийн сайжруулалт	Түрээсийн хугацаа болон ашиглалтын хугацааны аль багад

Компанийн тухайн хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацааны эцэст хэрвээ уг хөрөнгө аль хэдийн ашиглагдаж дууссан бол хөрөнгийн борлуулах үнээс холбогдох тооцоолсон зардлуудыг хасч тооцсон дүнг хөрөнгийн үлдэх өртөг гэдэг. Тайлант хугацаа бүрийн эцэст хөрөнгийн үлдэх өртөг болон ашиглалтын хугацааг хянаж үзэх ба шаардлагатай бол залруулдаг.

**Ашиглах эрхтэй хөрөнгө.** Компани нь дэлгүүрийн үйл ажиллагаанд зориулан талбай түрээслэдэг. Гэрээ нь түрээсийн болон түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулж болно. Түрээсийн гэрээг ихэвчлэн 2 жилээс 10 жилийн хугацаанд тогтмол хугацаагаар хийдэг.

Ашиглах эрхтэй хөрөнгийг өртгөөр нь хэмжих ба өртөг нь түрээсийн өр төлбөрийн анхны хэмжилттэй тэнцүү байна.

Ашиглах эрхтэй хөрөнгийг хөрөнгийн ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль богинод нь шулуун шугамын аргаар элэгдүүлдэг. Компани худалдан авах сонголтыг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэх үндэслэлтэй байгаа бол ашиглах эрхтэй хөрөнгийг ашиглалтын хугацаанд нь элэгдүүлж болно.

Ашиглах эрхтэй хөрөнгийн зүйлийн элэгдлийг доор тооцсон ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар элэгдүүлнэ:

Ашиглалтын хугацаа, жилээр

Дэлгүүрийн талбай	7-9 жил
Машин	1-2 жил

**Бараа материал.** Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар нь бүртгэдэг. Барилгын материал, ханган нийлүүлэх материалын тооллогын өртгийг эхэлж авснаа эхэлж зарлагдах (ЭАЭЗ) өртгийн аргаар тооцоолдог. Дахин борлуулах барааны бараа материалын өртгийг жижиглэн худалдааны тооллогын аргаар тооцоолдог. Цэвэр боломжит үнэ цэнийг бизнесийн хэвийн нөхцөлд барааг борлуулах үнээс холбогдох тооцоолсон зардлуудыг хасч тооцно.

**Гүүдвиллээс бусад биет бус хөрөнгө.** Компанийн гүүдвиллээс бусад биет бус хөрөнгүүдийн ашиглалтын хугацаа нь тодорхой ба түүнд голдуу компьютерийн программ хангамж, патент, худалдааны тэмдэг болон лицензууд ордог.

Биет бус хөрөнгийг нийт ашиглалтын хугацааны турш шулуун шугамын аргаар хорогдуулна:

Ашиглалтын хугацаа, жилээр

Франчайзын төлбөр	10 жил
Програм хангамжийн лиценз	5 жил

Биет бус хөрөнгүүдийг үлдэх өртөг, ашиглалтын хугацаа болон хорогдуулалтын агрыг тайлант хугацаа бүрийн төгсгөлд хянаж, шаардлагатай бол залруулдаг.

Хэрэв үнэ цэнэ буурсан тохиолдолд биет бус хөрөнгийн дансны үнийг ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан дүнгийн аль илүү байгаа дүн хүртэл бууруулдаг.





**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)**

**Санхүүгийн хэрэглүүрүүд – гол хэмжих нөхцөлүүд.** Бодит үнэ цэнэ гэж хэмжилт хийгдэх тухайн өдөр зах зээлд оролцогч талуудын хооронд хөрөнгө худалдсан бол хүлээн авах буюу өр төлбөр шилжүүлсэн бол төлөх байсан үнийг хэлнэ. Бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо бол идэвхтэй зах зээл дээрх үнэ байдаг. Идэвхтэй зах зээл гэдэг нь давтамж, тоо хэмжээний хувьд үнийн мэдээллийг тогтмол нийлүүлж чадах хөрөнгө, өр төлбөртэй холбоотой гүйлгээ гарч байдаг зах зээлийг хэлдэг.

Идэвхтэй зах зээлд арилжаалагдаж байгаа санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хөрөнгө буюу өр төлбөр тус бүрийн жишиг үнэ болон аж ахуйн нэгжийн эзэмшиж буй хэрэглүүрүүдийн тоо хэмжээгээр хэмждэг. Зах зээлийн өдөр тутмын хэвийн арилжааны хэмжээ нь компанийн эзэмшиж байгаа тоо хэмжээтэй харьцуулахад хангалтгүй байх мөн нэг арилжаагаар борлуулах захиалгын тоо хэмжээ зэрэг нь жишиг үнэд нөлөөлөх тохиолдол байдаг.

Зах зээлийн үнийн талаарх хөндлөнгийн мэдээлэл олдохгүй байх зарим санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд тэдгээрийн бодит үнэ цэнийг хөрөнгө оруулагч талын санхүүгийн мэдээлэл дээр үндэслэн дискаунтлагдсан мөнгөн гүйлгээний үнэлгээний загвар эсвэл үнэлгээний бусад аргачлалыг ашиглан тооцно. Бодит үнэ цэнийн хэмжилтийг бодит үнэ цэнийн шатлалын дагуу дараах байдлаар шинжилдэг.

Үүнд: (i) Нэгдүгээр түвшин нь ижил хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээл дээрх жишиг үнэнд (залруулагдаагүй) үндэслэн хийсэн хэмжилт, (ii) Хоёрдугаар түвшний хэмжилт нь тухайн хөрөнгө, өр төлбөрийн хувьд шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс тооцон гаргасан) ажиглагдахуйц бүхий л материаллаг хэмжээний орц мэдээллийг ашиглах үнэлгээний арга, техникүүд (iii) Гуравдугаар түвшний хэмжилт нь зах зээлээс ажиглагдахуйц бус тоо мэдээнд үндэслэн хийсэн үнэлгээнүүд (хэмжилт нь чухал үл ажиглагдахуйц орц мэдээллийг шаарддаг) орно.


**Гүйлгээний зардлууд** нь санхүүгийн хэрэглүүрийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал нь гүйлгээ хийгдээгүй тохиолдолд гарахгүй байх байсан зардлыг хэлнэ.

Гүйлгээний зардалд зуучлагч, борлуулагч (борлуулалтын үүрэг гүйцэтгэж буй ажилтнуудын цалин), зөвлөх, брокер, дилерүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулах байгууллага, хөрөнгийн зах зээлийн байгууллагад төлсөн төлбөрүүд, мөн шилжүүлэлтэд ногдуулсан татвар

хураамжууд хамаарна. Гүйлгээний зардалд өрийн шимтгэлийн зардал эсвэл хөнгөлөлт, санхүүжилтийн зардал, захиргааны дотоод зардал буюу хадгалалтын зардлууд орохгүй.

**Хорогдуулсан өртөг (ХӨ)** гэдэг нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн дүнгээс хийгдсэн эргэн төлөлтийг хасч, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдалтай холбоотой аливаа нөөцийн дүнг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүнд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлуулсан гүйлгээний зардлаас болон аливаа нэмэгдэл үнэ, хөнгөлөлтөөс үр ашигт хүүгээр тооцсон дискаунт хамаарна. Хуримтлагдсан хүүгийн орлого, зардал, мөн хуримтлагдсан хүүгийн зардал, анх хүлээн зөвшөөрөх үед хойшлуулсан хураамж, хорогдуулсан хөнгөлөлт, нэмэгдэл зэргийг тусад нь толилуулахгүй бөгөөд санхүүгийн байдлын тайланд тусгагдсан холбогдох хэрэглүүрүүдийн бүртгэлийн үнэнд орсон байна.

**Үр ашигт хүүгийн арга** нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны туршид дансны үнээс тооцогдох хүүгийн хувийг тогтмол байлгахаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид дискаунтчилж, санхүүгийн хэрэглүүрүүдийн бүртгэлийн цэвэр дүнг гаргаж авах хүүгийн хувь болно. Үр ашигт хүүгийн хувь нь хувьсах хүүтэй хэрэглүүрүүдийн мөнгөн урсгалын хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл дискаунтчлах боловч хэрэглүүрт тусгагдсан хөвөгч хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн урамшуулал болон хөнгөлөлтийг, мөн зах зээлийн түвшинд тохируулагддаггүй ба бусад хувьсах хүчин зүйлсэд үл хамаарна. Эдгээр урамшуулал болон хөнгөлөлтийг хэрэглүүрүүдийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулна. Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд гэрээний талуудын хооронд төлөх эсвэл хүлээн авах бүх хураамжийг оруулах ба тэдгээр нь үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болно. Худалдаж авсан эсвэл дотооддоо бий болгосон хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө зээлийн үнэ цэнэ буурсан бол үр ашигт хүүг ч мөн үнэ цэнийн бууралтанд тохируулан бүртгэнэ, жишээ нь гэрээнд заасан эргэн төлөлтийн оронд анх хүлээн зөвшөөрсөн хүлээгдэж буй мөнгөн урсгалд тулгуурлан тооцоолно.



Сантрал Экспресс Си Ви Эс ХХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр

### 3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

**Санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан хүлээн зөвшөөрөх.** Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ бүхий санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан бодит үнэ цэнээр бүртгэдэг. Компанийн бүх санхүүгийн хэрэглүүрүүд нь анх зах зээлийн үнэ дээр гүйлгээний зардал нэмсэн дүнгээр бүртгэгддэг. Анхлан хүлээн зөвшөөрөх бодит үнэ цэнэ нь гүйлгээний дүнгээр хамгийн сайн нотлогдоно. Анхлан хүлээн зөвшөөрөх үед үүсэх олз эсвэл гарз нь зах зээлийн үнэ болон гүйлгээний дүнгийн хооронд зөрүү гарсан тохиолдолд л бүртгэгдэх бөгөөд үүнийг зөвхөн ижил төрлийн хэрэглүүрийн идэвхтэй зах зээл дээрх сүүлийн үеийн арилжааны мэдээллээр баталгаажуулсан эсвэл зөвхөн идэвхтэй зах зээлээс авсан мэдээлэл дээр үндэслэж хийсэн үнэлгээний аргачлалаар тооцсон тохиолдлуудад бүртгэх болно. Анхлан хүлээн зөвшөөрсний дараа ХБЭА-ын хасагдуулгыг хорогдуулсан өртөгөөр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгүүдийн хувьд хүлээн зөвшөөрдөг ба өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтуудыг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжиж гарсан үр дүн нь шууд бүртгэлийн гарз болдог.

Зохицуулах байгууллагаас тогтоосон эсвэл зах зээлийн жишгээр тогтсон ("хэвийн" борлуулалт болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан нийлүүлэх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л борлуулалт болон худалдан авалтыг арилжаа хийсэн өдөр буюу Компани тухайн санхүүгийн хөрөнгийг нийлүүлэх үүрэг хүлээсэн үед бүртгэнэ. Бусад бүх худалдан авалтыг Компани нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

**Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - хэмжилтийн төрөл.** Компани нь санхүүгийн хөрөнгийг хэмжилтээр нь дараах төрлүүдэд ангилна: Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ ("ААБҮЦ"), бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ ("БДОБҮЦ") болон Хорогдуулсан өртөг ("ХӨ"). Өрийн хэлбэрээрх санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал болон дараа үеийн хэмжилт нь (i) санхүүгийн хөрөнгө нь гэрээний дагуу ирээдүйн мөнгөн урсгалыг цуглуулах зорилготойгоор санхүүгийн хөрөнгийг эзэмших бизнесийн загварт багтсан байх ба (ii) санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлүүд нь үндсэн төлбөр болон үлдэгдэл төлбөрийн хүүгийн төлбөр болох мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд бий болгож байдаг.

**Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - бизнес загвар.** Бизнес загвар нь Компани санхүүгийн хөрөнгийг мөнгөн урсгал бий болгох зорилгоор хэрхэн удирдаж байгаагаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл Компанийн зорилго нь (i) зөвхөн тухайн хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах (гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмших) эсвэл (ii) хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авахаас болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авахын аль нь вэ гэдгээс хамаарах (гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах ба худалдах зорилгоор эзэмших) бөгөөд хэрэв (i) ба (ii)-ын аль нь ч биш тохиолдол бол санхүүгийн хөрөнгийг нь "бусад" гэсэн бизнес загварт хамааруулан ангилах ба ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжинэ.

Бизнес загварыг үнэлгээ хийсэн өдрийн байдлаар бэлэн байгаа багцын хувьд тодорхойлсон зорилгод хүрэхийн тулд Компанийн хийж буй үйл ажиллагаанд хамааралтай бүхий л нотолгоонд үндэслэн бүлэг хөрөнгүүдийн (багцын түвшинд) хувьд тодорхойлно. Бизнес загварыг тодорхойлоход Компанийн авч үзсэн хүчин зүйлүүдэд багцын бүрэлдэхүүн болон зорилго, холбогдох хөрөнгүүдийн мөнгөн урсгал хэрхэн цуглуулагдаж байсан талаарх өнгөрсөн үеийн туршлагауд, эрсдэлийг хэрхэн удирдаж үнэлж байсан, хөрөнгүүдийн гүйцэтгэлийг хэрхэн үнэлж байсан болон менежерүүдэд хэрхэн нөхөн төлбөр олгогдож байсан зэргийг авч үздэг.

**Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - мөнгөн урсгалын онцлог.** Бизнес загвар нь хөрөнгийн гэрээт мөнгөн урсгалыг цуглуулж, хөрөнгийг эзэмших эсвэл хөрөнгийн гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авах зорилготой үед мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн болон хүүгийн төлбөрөөс бүрдэж буй ("ЗҮХТ") эсэхэд Компани үнэлгээ өгдөг. Гэрээт мөнгөн урсгал нь ЗҮХТ-ийн онцлогтой нийцсэн эсэхийг тодорхойлоход нуугдмал деривативыг агуулсан санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь авч үзнэ. Энэ үнэлгээг хийхдээ гэрээт мөнгөн урсгал нь зээлийн гэрээний үндсэн тохиролцоонд нийцтэй эсэх, ялангуяа хүү нь зээлийн эрсдэл, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон зээлийн бусад эрсдэл, ашгийн түвшинг багтаасан эсэхийг авч үздэг.

Гэрээний нөхцөлүүд нь эрсдэлтэй эсвэл зээлийн үндсэн нөхцөлтэй үл нийцэх хэлбэлзлийг харуулж байвал санхүүгийн хөрөнгө нь ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэнэ. ЗҮХТ үнэлгээ нь хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед хийгдэх бөгөөд дараа үед дахин хийгдэхгүй.



**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)**

**Санхүүгийн хөрөнгө – дахин ангилал.** Багцыг удирдаж байгаа бизнес загвар бүхэлдээ өөрчлөгдсөн бол санхүүгийн хэрэглүүрийг дахин ангилна. Дахин ангилал нь ирээдүйд нөлөө үзүүлэх бөгөөд бизнес загвар өөрчлөгдсөний дараа хамгийн эхний тайлант үеийн эхнээс хэрэгжинэ. Компани нь тайлант болон харьцуулсан өмнөх тайлант хугацааны туршид бизнесийн загвараа өөрчлөөгүй бөгөөд дахин ангилал хийгээгүй.

**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт - хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хасагдуулга.** Компани нь хорогдуулсан өртөг болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр бүртгэгдэх санхүүгийн өрийн хэрэглүүр болон гэрээний хөрөнгөтэй холбоотой хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг ирээдүй рүү харсан мэдээлэлд үндэслэн үнэлдэг. Компани нь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг ("ХБЭА") хэмжиж, санхүүгийн болон гэрээний хөрөнгийн үнэ цэнэ бууралтыг цэвэр алдагдлыг тайлант хугацаа бүрт хүлээн зөвшөөрдөг.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилт нь (i) олон янзын боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлсон зохистой, магадлалаар жинлэсэн дундаж дүн; (ii) мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ; болон (iii) өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хэт их өртөг, хүчин чармайлтгүйгээр олдох боломжтой үндэслэл бүхий бэлэн мэдээллүүд дээр үндэслэнэ.

Хорогдуулсан өртөөр хэмжигдсэн өрийн хэрэглүүр болон гэрээний хөрөнгө нь санхүүгийн байдлын тайланд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын хасагдуулгыг хассан цэвэр дүнгээр тусгагддаг.

Компани анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах зээлийн чанарын өөрчлөлтөд үндэслэсэн үнэ цэнийн бууралтын "3 шатлал" бүхий загварыг ашигладаг. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш ямар нэг үнэ цэнийн бууралтгүй санхүүгийн хэрэглүүр нь "1-р шатлал"-д ангилагдана. 1-р шатлалын санхүүгийн хэрэглүүрийн ХБЭА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдлын тайлант өдрөөс хойш 12 сарын дотор эсвэл хэрэв үүнээс богино бол гэрээний хугацаа дуусах хүртэл (12 сарын ХБЭА) үүсч болох санхүүгийн хэрэглүүрийн үүргээ биелүүлээгүйгээс үүдэн гарах хүлээгдэж буй алдагдлын хэмжээтэй ижил дүнгээр хэмжигдэнэ. Хэрэв Компани анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц өссөн ("ЗЭМӨ") гэдгийг тогтоовол хөрөнгийг "2-р шатлал"-д ангилах бөгөөд ХБЭА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэх ба энэ нь гэрээ дуусах хүртэл боловч хэрэв байгаа бол хүлээгдэж буй эргэн төлөлтүүдийг авч үзнэ (Ашиглалтын хугацааны ХБЭА). Тодруулга 32-д Компани нь зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийн хэрхэн тодорхойлодог талаар тайлбарласан. Хэрэв Компани санхүүгийн хөрөнгийн зээлийн үнэ цэнэ буурсан гэж тодорхойлсон бол хөрөнгийг "3-р шатлал" руу шилжүүлэх ба ХБЭА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэнэ. Компанийн зээлийн үнэ цэнэ буурсан хөрөнгийн тодорхойлолт болон дефолтын тодорхойлолтыг Тодруулга 32-д тайлбарласан. Худалдан авсан, шинээр гаргасан зээлийн – зээлжих чадамжаас үүдэлтэй үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд ХБЭА нь үргэлж хөрөнгийн ашиглалтын хугацааны турш дах ХБЭА-тай ижил хэмжигдэнэ. ХБЭА-ын загварыг хэмжихэд ашиглагдсан мэдээллүүд, таамаглал болон тооцооллын аргуудыг мөн Компани ХБЭА-ын загваруудын ирээдүйн мэдээллүүдийг хэрхэн нэгтгэх талаарх тайлбарыг Тодруулга 31-оос үзнэ үү.

**Санхүүгийн хөрөнгө - данснаас хасах.** Компани санхүүгийн хөрөнгийг нэхэмжлэх ажилд бүх хүчин чармайлтаа өгч нэхэмжлэх үндэслэл байхгүй гэж дүгнэсэн тохиолдолд бүхэлд нь буюу зарим хэсгийг нь данснаас хасдаг. Данснаас хасах нь үл хүлээн зөвшөөрөх үйл явдлыг илэрхийлнэ. Компани нь гэрээний дагуу төлөх дүнг нэхэмжлэхийг хүсч байгаа боловч төлөгдөх боломжийн таамаглал байхгүй байгаа тохиолдолд шүүхийн шийдвэрийг албадан хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа санхүүгийн хөрөнгийг данснаас хасах боломжтой.

**Санхүүгийн хөрөнгө - өөрчлөлт.** Компани нь санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлийг өөрчлөх буюу дахин тохиролцох тохиолдол гардаг. Компани нь гэрээт мөнгөн урсгалын өөрчлөлт нь мэдэгдэхүйц эсэхийг дараах зүйлсийг харгалзан үзэж үнэлнэ; хөрөнгийн эрсдэлийн үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээр гэрээний шинэ зүйл заалт байгаа эсэх, хүүгийн түвшний мэдэгдэхүйц өөрчлөлт, валютын ханшийн өөрчлөлт, шинэ барьцаа эсвэл хөрөнгөтэй холбоотой зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц нөлөөлөх зээлийн өсөлт, эсвэл зээлдэгч санхүүгийн хүндрэлд ороогүй тохиолдолд зээлийн хугацааг мэдэгдэхүйц сунгах гэх мэт.





**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)**

Хэрэв өөрчлөгдсөн нөхцөлүүд нь анхны нөхцөлөөс мэдэгдэхүйц зөрүүтэй бол анхны хөрөнгийн мөнгөн урсгалыг хүчингүй болгож Компани анхны санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч бодит үнэ цэнээр нь шинэ хөрөнгөд хүлээн зөвшөөрнө. Дахин тохиролцоо хийсэн өдөр нь дараах үеийн үнэ цэнийн бууралтыг тооцоолох зорилгоор анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр болно. Мөн зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт байгаа эсэхийг харгалзан үзнэ. Мөн Компани шинэ зээл буюу өрийн хэрэглүүр нь зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөрийн шалгуурт нийцэж байгаа эсэхийг үнэлж үзнэ. Үл хүлээн зөвшөөрөгдсөн анхны хөрөнгийн дансны үнэ болон мэдэгдэхүйц өөрчлөлт орсон шинэ хөрөнгийн бодит үнэ цэнийн зөрүү нь өмчлөгчидтэй хийсэн хөрөнгийн гүйлгээтэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Дахин тохиролцоо нь нөгөө талын санхүүгийн хүндрэлтэй байдал болон анхны тохиролцсон төлбөрөө төлөх боломжгүй болсон үед хийгдэж байгаа нөхцөлд Компани нь хөрөнгийн одоогийн шинэчлэгдсэн мөнгөн гүйлгээ болон анхны мөнгөн гүйлгээг харьцуулж гэрээний өөрчлөлтөөс үүдэлтэй мэдэгдэхүйц өөрчлөгдсөн хөрөнгөнд эрсдэл болон өгөөж байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв эрсдэл болон өгөөж өөрчлөгдөөгүй бол өөрчилсөн хөрөнгө нь анхны хөрөнгөөс мэдэгдэхүйц өөрчлөлтгүй гэх ба өөрчлөлтөөс үүдэн үл хүлээн зөвшөөрөхгүй. Компани нь анхны үр ашигт хүүгийн түвшин (эсвэл худалдан авсан, шинээр гаргасан зээлийн – зээлжих чадамжаас үүдэлтэй үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд зээлийн тохируулгатай үр ашигт хүүгийн түвшин)-г ашиглан өөрчлөгдсөн гэрээт мөнгөн урсгалыг хоргодуулах замаар нийт дансны үнийг дахин тооцоолж, өөрчлөлтийн олз гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

**Санхүүгийн өр төлбөр - хэмжилтийн ангилал.** Санхүүгийн өр төлбөрүүдийг дараахаас бусад тохиолдолд дараа үеийн хоргодуулсан өртгөөр хэмжиж ангилна. Үүнд (i) ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдсэн санхүүгийн өр төлбөр: энэхүү ангилал нь дериватив, борлуулахаар эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр (үүнд богино хугацаат үнэт цаас), бизнесийн нэгдэл дэх нэгтгэгчийн хүлээн зөвшөөрсөн болзошгүй зүйлс болон анхны хүлээн зөвшөөрөлтөөрөө илэрхийлэгдсэн бусад санхүүгийн өр төлбөр, (ii) мөн санхүүгийн баталгааны гэрээ болон зээлийн амлалтууд хамаарна.

**Санхүүгийн өр төлбөр - үл хүлээн зөвшөөрөлт.** Санхүүгийн өр төлбөр хүчингүй болох үед (өөрөөр хэлбэл гэрээгээр хүлээсэн үүргийг гүйцэтгэж дууссан, цуцлагдсан эсвэл хугацаа дууссан) бүртгэлээс хасагдана.

Компани болон түүний анхны зээлдэгчдийн мэдэгдэхүйц өөр нөхцөл бүхий өрийн хэрэглүүр болон одоо буй санхүүгийн өр төлбөрийн нөхцөл, хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлт нь анхны санхүүгийн өр төлбөрийг данснаас хасаж, шинэ санхүүгийн өр төлбөр бүртгэх үндэслэл болно.

Аливаа төлсөн төлбөр хураамж болон хүлээн авсан төлбөр хураамжийн цэвэр дүнг багтаасан шинэ нөхцөлөөрх мөнгөн гүйлгээний хоргодуулсан өнөөгийн үнэ цэнэ нь анхны санхүүгийн өр төлбөрийн үлдэх хугацааны мөнгөн гүйлгээний хоргодуулсан өнөөгийн үнэ цэнээс хамгийн багадаа 10% зөрүүтэй бол мэдэгдэхүйц өөр нөхцөлтэй гэж үзнэ. Өрийн хэрэглүүрийн нөхцөл хугацаа өөрчлөгдсөнөөр хэрэв өрийн хэрэглүүр хүчингүй болсон гэж үзвэл төлсөн төлбөр хураамж болон аливаа зардал нь өрийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөгдсөнөөс үүдсэн олз, гарзаар бүртгэдэг. Харин эсрэг тохиолдолд төлсөн төлбөр хураамжийн зардлын дүнгээр өр төлбөрийн дансны үнийг нэмэгдүүлэх бөгөөд өөрчлөгдсөн өр төлбөрийн үлдэх хугацааны туршид хоргодуулна. Дансны үнийн өөрчлөлтийн эдийн засгийн шинж чанар нь өмчлөгчидтэй хийсэн хөрөнгийн гүйлгээтэй холбоотойгоос бусад тохиолдолд барагдуулаагүй байгаа өр төлбөрийн өөрчлөлтийг хуримтлуулан тооцох аргыг ашиглан тооцоолоход гарсан өөрчлөлт гэж тооцон бүртгэдэг. Үүссэн аливаа олз, гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Өр төлбөрийн өөрчлөлтийг дансны үнэ цэнийн зөрүүний эдийн засгийн агуулгыг капиталд хамааруулахаас бусад тохиолдолд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн хуримтлуулах аргыг ашиглан тооцооны өөрчлөлтөд тооцдог.

**Санхүүгийн хэрэглүүрүүдийг хооронд нь хаах.** Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр бүртгэх нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийн хаалт хийх эрх зүйн үндэслэл байгаа бөгөөд төлбөрийг цэвэр дүнгээр хийх эсвэл хөрөнгийг худалдаж, нэгэн зэрэг өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө байгаа тохиолдолд л зөвшөөрөгдөнө. Энэхүү хооронд нь хаах эрх нь (а) ирээдүйд болох үйл явдлын болзошгүй төлбөр биш байх, (б) дараах тохиолдол бүрийг хуульд заагдсанаар шийдэх буюу (i) бизнесийн хэвийн үйл ажиллагаа, (ii) төлбөр төлөгдөхгүй болох (iii) төлбөрийн чадваргүй болж дампуурсан үед бий болдог.



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр

### 3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

**Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.** Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөнд бэлэн мөнгө, банкинд байршуулсан харилцах хадгаламжийн мөнгө, 3 сар болон түүнээс богино хугацаатай, хөрвөх чадвар сайтай богино хугацаат хөрөнгө оруулалтыг хамааруулна. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Учир нь: (i) тэдгээр нь гэрээний мөнгөн урсгалаас цуглуулагдан эзэмшиж байгаа болон тэдгээр мөнгөн гүйлгээ нь ЗҮХТ-ийг харуулсан байдаг болон (ii) тэдгээр нь ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр тодорхойлогдоогүй байдаг. Зарим улсын батлан даалтын хууль тогтоомж гэх мэт зөвхөн хуулиар баталгаажуулсан онцлог шинжүүд нь хууль тогтоомж өөрчлөгдсөн ч гэсэн уг онцлог шинж чанарыг хэрэглэж болох тул гэрээний нөхцөлд оруулахаас гадна ЗХҮТ-ийн тестэд нөлөөлөхгүй.

**Дансны ба бусад авлага.** Дансны ба бусад авлагуудыг анхлан бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба цаашдаа үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

**Дансны ба бусад өглөг.** Дансны өглөгийг нөгөө тал гэрээнд заасан үүргээ биелүүлсэн үед хуримтлуулан бүртгэх ба анх бодит үнэ цэнээр, цаашид үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрдөг.

**Зээл.** Зээлийн эх үүсвэрийг бүртгэхдээ гүйлгээний зардлыг хасан бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрч, дараа нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулан бүртгэнэ.

**Санхүүгийн түрээсийн авлага.** Компани нь өмчлөлтэй холбоотой бүхий л эрсдэл, урамшууллыг түрээслэгчид шилжүүлдэг дэд түрээсийн түрээслүүлэгч бол түрээслүүлсэн хөрөнгийг түрээсийн цэвэр хөрөнгө оруулалттай тэнцэх хэмжээний санхүүгийн түрээсийн авлага хэлбэрээр тайлагнана. Эхлэх өдрөөс түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтыг хэмжихэд дараах түрээсийн төлбөр орно:

- түрээсийн урамшууллыг хасч тооцсон тогтмол төлбөр (мөн чанарын хувьд тогтмол төлбөр орно),
- үлдэх өртгийн баталгааны дагуу Компани хүлээн авахаар хүлээгдэж буй дүн,
- түрээсийг цуцалсны торгуулийн төлбөр.


Санхүүгийн түрээсийн авлагыг түрээсийн хугацаа эхлэхэд зэрэг хүлээн зөвшөөрөх ба түрээсийн гэрээнд түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтын дүнг тооцохоор тусгасан хорогдуулалтын хүүг ашиглана.

Нийт авлага ба өнөөгийн үнэ цэнийн зөрүү нь хойшлогдсон санхүүгийн орлогыг илэрхийлнэ. Энэхүү орлогыг түрээсийн хугацааны туршид цэвэр хөрөнгө оруулалтын аргыг ашиглан хүлээн зөвшөөрөх (татварын өмнөх) ба энэ нь өгөөжийн тогтмол хувийг илэрхийлнэ. Түрээсийн хэлэлцээр хийх, тохиролцоотой шууд холбоотой нэмэгдсэн зардлыг санхүүгийн түрээсийн авлагын анхны хэмжилтэд багтааж, түрээсийн хугацаанд хүлээн зөвшөөрсөн орлогын хэмжээг бууруулна. Дэд түрээсийн санхүүгийн орлогыг тухайн жилийн ашиг, алдагдлын тайланд санхүүгийн орлого хэсэгт бүртгэнэ.

Эрсдлийн алдагдлын хагасдуулгыг тооцохдоо хүлээгдэж буй эрсдлийн алдагдлын хялбаршуулсан аргыг ашигладаг. Хүлээгдэж буй эрсдлийн алдагдлыг дансны авлагынхтай адил аргаар тооцдог. Хүлээгдэж буй эрсдлийн алдагдлыг хасагдуулгын дансаар дамжуулан авлагын дансны цэвэр дүнг бууруулж бүртгэх ба санхүүгийн түрээсэд хамааруулсан хүүгийн хэмжээгээр дискаунтлагдсан хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр хэмждэг. Хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ нь түрээстэй холбоотой хөрөнгийг олж авах, борлуулахтай холбоотой гарах мөнгөн урсгалыг илэрхийлнэ.

**Санхүүгийн түрээсийн өр төлбөр.** Түрээсийн өрийг анхлах хэмжихдээ өнөөгийн үнэ цэнэд суурилдаг. Түрээсийг өр нь доорх түрээсийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийг агуулсан байна:

- түрээсийн урамшууллыг хасч тооцсон тогтмол төлбөр (мөн чанарын хувьд тогтмол төлбөр орно),
- индекс эсвэл хувь дээр үндэслэсэн түрээсийн хувьсах төлбөрийг эхлэх өдрийн байдлаар индекс эсвэл хувь хэмжээг ашиглан хэмжсэн,
- үлдэх өртгийн баталгааны дагуу Компаниас төлөх ёстой хэмжээ,
- Компани хэрэгжүүлнэ гэж үзэх үндэслэлтэй байгаа бол хэрэгжүүлэх опционы хэрэгжих үнэ,
- Түрээсийг цуцалсны торгуулийн төлбөр



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК  
Санхүүгийн тайлангийн модруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр

### 3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Түрээсийн хугацааг сунгах болон цуцлах сонголт бүхий хэд хэдэн түрээсийн талбай Компанид бий. Эдгээр нь Компанийн үйл ажиллагаанд ашигласан хөрөнгийг удирдах тал дээр үйл ажиллагааны уян хатан байдлыг нэмэгдүүлэхэд ашиглагддаг. Хугацаа сунгах, цуцлах сонголтуудын дийлэнхийг зөвхөн Компани хэрэгжүүлэх эрхтэй болох бөгөөд тухайн түрээслүүлэгчид хэрэгжүүлэх эрх байхгүй. Сунгалтын эрхийг (эсвэл гэрээг цуцласнаас хойших эрх) зөвхөн түрээсийн хугацааг сунгах (эсвэл цуцлахгүй) үндэслэлтэй тохиолдолд л оруулна.

Хугацааг сунгах эрх нь үндэслэлтэй тохиолдолд түрээсийн төлбөрийг мөн өр төлбөрийн тооцонд оруулна.

Түрээсийн төлбөрийг түрээсийн дотоод хүүгээр хорогдуулна. Уг хүүг шууд тодорхойлж чадахгүй тохиолдолд (Компанийн ихэнх түрээс ийм байгаа) Компанийн зээлийн ахиуц хүүг ашиглана. Энэ нь ашиглах эрхтэй хөрөнгийг түрээстэй адил нөхцөл, барьцаа, хугацаатайгаар зээлээр худалдаж авах үед компанийн зээлэндээ төлөх хүү байна.

Зээлийн ахиуц хүүг тооцохдоо Компани:

- Боломжтой бол ойрын хугацаанд түрээслэгчийн гуравдагч этгээдээс хүлээж авсан санхүүжилтийн өртгийг тухайн санхүүжилтийг хүлээж авсанаас хойш санхүүжилтийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлтүүдэд залруулан ашиглана,
- Эрсдэлгүй хүүгийн түвшин дээр зээлийн эрдслийн урамшууллыг нэмэх,
- Түрээсийн онцлогуудыг тусгах, жишээ нь хугацаа, улс, вальют, барьцаа.

Индекс болон хүүнээс хамаарсан түрээсийн хувьсах төлбөр нэмэгдэх эрсдэл Компанид байгаа бөгөөд уг түрээсийн төлбөрийг бодитоор өсөх хүртэл түрээсийн өр төлбөрт оруулахгүй. Индекс болон хүүнээс хамаарсан түрээсийн төлбөрт өөрчлөлт орох үед түрээсийн өр төлбөрийг дахин хэмжиж өөрчлөлтийг ашиглах эрхтэй хөрөнгөд тусгана.

Түрээсийн төлбөрийг үндсэн төлбөр болон санхүүжилтийн зардалд хуваарилна. Санхүүжилтийн зардлыг ашиг алдагдалд өр төлбөрийн үлдэгдэлд үе тутам тооцсон хүүгийн хувь тогтмол байхаар тусгана.

Богино хугацаат түрээс болон бага дүнтэй хөрөнгийн түрээстэй холбоотой төлбөрүүдийг ашиг алдагдалд шулуун шугамын аргаар тусгана. Богино хугацаат түрээс нь 12 сар болон түүнээс богино хугацаатай байна.

**Орлогын албан татвар.** Орлогын албан татвар нь санхүүгийн тайланд тайлант хугацааны эцсийн байдлаар батлагдсан эсвэл үндсэндээ батлагдсан байгаа хууль тогтоомжийн хүрээнд хуримтлуулан бүртгэгдсэн байна. Орлогын албан татварын зардал нь тайлант хугацааны болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн буюу өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл шууд өмчид бүртгэгдсэнээс бусад тохиолдолд тухайн жилийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөнө.

Тайлант хугацааны албан татвар нь тухайн болон өмнөх тайлант хугацааны татвар ногдуулах ашиг эсвэл алдагдлаас бодогдсон татварын байгууллагад төлөх эсвэл буцаан авах дүн байна. Санхүүгийн тайланг холбогдох татварын тайланг тушаахаас өмнө баталгаажуулсан тохиолдолд татвар ногдуулах ашиг, алдагдлыг урьдчилсан тооцоон дээр үндэслэж тооцдог. Орлогын албан татвараас бусад татваруудыг үйл ажиллагааны зардалд бүртгэдэг.

Татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлэх үед хойшлогдсон орлогын албан татварыг тооцохдоо тайлант тэнцлийн өглөгийн аргыг ашиглах ба хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн тайлангийн зорилгоор бүртгэлийн дүн болон татварын суурийн хоорондын түр зөрүүг тайлант хугацаанд тооцож бүртгэдэг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн чөлөөлөлтийн дагуу татвар ногдуулах ашиг болон бүртгэлийн ашгийн алинд нь ч нөлөөлдөггүй, мөн бизнесийн нэгдлээс бусад ажил гүйлгээнд хөрөнгө ба өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөх үед үүссэн түр зөрүүнд хойшлогдсон татвар бүртгэгдэггүй.

Хойшлогдсон татварын үлдэгдлийг тайлант хугацааны эцэст бүхэлдээ буюу үндсэндээ батлагдсан байсан татварын хувь хэмжээгээр тооцож байгаа бөгөөд түр зөрүү гарах хугацаанд буцаах эсвэл татварын алдагдлыг ирээдүйд ашиглагдах үед хэрэглэхээр хүлээгдэж байдаг.



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр

### 3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Хасагдах түр зөрүү болон татварын алдагдал шилжүүлснээс үүссэн хойшлогдсон татварын хөрөнгийг ирээдүйд түр зөрүү буцах магадлалтай үед бүртгэх бөгөөд эдгээр түр зөрүүг ирээдүйд олох татварын ашгаас хасч ашиглаж болохуйц хэмжээгээр л хүлээн зөвшөөрнө.

**Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ).** Борлуулалтанд ногдуулах нэмэгдсэн өртгийн татварыг (а) харилцагчаас авлага хүлээн авсан өдөр (б) харилцагчид бараа үйлчилгээ үзүүлсэн өдөр хоёрын аль эртгээр нь тооцогдож татварын албанд борлуулалттай холбоотой өглөг үүсгэнэ. НӨАТ-ын худалдан авалт нь ерөнхийдөө НӨАТ-ын нэхэмжлэлийг хүлээн авах үед НӨАТ-ын борлуулалтаас буцаан хасагддаг. Татварын байгууллага НӨАТ-ыг цэвэр буюу хасагдуулсан дүнгээр төлөхийг зөвшөөрдөг. Борлуулалт, худалдан авалттай холбоотой НӨАТ нь санхүүгийн байдлын тайланд нийт дүнгээр хүлээн зөвшөөрөгдөх буюу НӨАТ-ын авлага буюу өглөгийн дүнгээр санхүүгийн байдлын тайлангийн өглөг эсвэл авлагын хэсэгт тусгагддаг.

**Урьдчилж төлсөн төлбөр.** Урьдчилж төлсөн төлбөрийг өртгөөс үнэ цэнэ бууралтын зардлыг хассан дүнгээр бүртгэнэ. Урьдчилгаа төлбөр хийгдсэн бараа үйлчилгээг нэг жилээс хойш хүлээн авахаар хүлээгдэж буй тохиолдолд эсвэл урьдчилгаа төлбөр хийгдсэн хөрөнгө нь өөрөө анх эргэлтийн бус гэж ангилагдсан тохиолдолд уг урьдчилж төлсөн төлбөрийг эргэлтийн бус гэж ангилна. Компани холбогдох хөрөнгийг хянах эрх олж авсан бөгөөд уг хөрөнгө нь Компанид эдийн засгийн үр өгөөж ирээдүйд өгөх магадлалтай болсон үед хөрөнгө худалдан авахаар хийгдсэн урьдчилж төлсөн төлбөрийн дүнг хөрөнгийн дансны үнэнд шилжүүлэн бүртгэнэ. Бусад урьдчилж төлсөн төлбөрийг холбогдох бараа, үйлчилгээг хүлээн авсан үед зардлаар бүртгэнэ. Урьдчилж төлсөн төлбөртэй холбоотой хөрөнгө, бараа, үйлчилгээ нийлүүлэгдэхгүй байх шинж тэмдэг илэрсэн тохиолдолд урьдчилж төлсөн төлбөрийн дүнг зохих хэмжээгээр бууруулж холбогдох үнэ цэнийн бууралтын гарзыг тайлант жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

**Хувьцаат капитал.** Энгийн хувьцааг эзэмшигчдийн өмчид тусгана. Гаргасан хувьцааны нэрлэсэн үнээс хүлээн авсан төлбөр болох зах зээлийн үнийн илүү гарсан дүнг нэмж төлөгдсөн капитал хэсэгт бүртгэдэг.

**Холбоотой талуудтай хийсэн гүйлгээний анхлан хүлээн зөвшөөрөлт.** Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад Компани холбоотой талуудтай гүйлгээ хийдэг. СТОУС 9-ийн дагуу санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнийг ашигладаг. Хэрэв тухайн гүйлгээний хувьд идэвхтэй зах зээлийнх биш бол зах зээлийн хүүг эсвэл зах зээлийн бус хүүг хэрэглэх тал дээр удирдлага өөрсдийн үнэлэлтийг хийдэг. Үнэлэлт нь холбоогүй талуудтай хийсэн ижил төрлийн гүйлгээ болон үр ашигт хүүгийн шинжилгээнд суурилдаг. Холбоотой талуудын дансдын үлдэгдэлтэй холбоотой нөхцөлүүдийг Тодруулга 10-аас харна уу.

**Орлого хүлээн зөвшөөрөлт.** Орлого нь Компанийн ердийн үйл ажиллагаанаас үүсдэг. Орлогыг Ажил гүйлгээний үнийн дүнгээр хүлээн зөвшөөрнө. Ажил гүйлгээний үнэ гэдэг нь үйлчлүүлэгчид гэрээгээр нийлүүлэхээр амласан бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээгээ шилжүүлснийхээ оронд авах эрхтэй болсон төлбөрийн дүн юм. Үүнд гуравдагч талын өмнөөс цуглуулсан дүн орохгүй. Орлогыг борлуулалтын цэвэр дүнгээр (хөнгөлөлт, буцаалт) буюу нэмэгдсэн өртгийн албан татвар, экспортын татвар, онцгой албан татвар, адилтгах бусад төлбөрийг хасч цэвэр дүнгээр нь хүлээн зөвшөөрдөг.

#### Хэрэглэгчдэд бараа борлуулсан орлого

(а) Компани жижиглэнгийн сүлжээ дэлгүүр ажиллуулдаг. Борлуулсан барааны орлогыг харилцагчид бүтээгдэхүүн борлуулах үед хүлээн зөвшөөрдөг.

(б) Харилцагч бараа худалдаж авахдаа төлбөрийг бэлнээр төлдөг. Компанийн бодлогын дагуу Харилцагчдад 24 цагийн дотор худалдан авсан бараагаа буцаах эрх өгдөг. Түүхэн туршлагаас харахад буцаагдсан барааны тоо материаллаг биш дүнтэй байдаг бөгөөд одоогоор хүлээн зөвшөөрсөн борлуулалтад томоохон хэмжээний буцаалт хийгдэх магадлал бага юм.

(в) Компани харилцагчиддаа худалдан авалтаас урамшууллын оноо олгох хөтөлбөр хэрэгжүүлдэг бөгөөд харилцагчид уг оноог ирээдүйн худалдан авалтандаа ашиглах боломжтой. Онооны дагуу харилцагчидад олгогддог материаллаг эрх нь гэрээний үндсэнд олгогддог. Тиймээс, харилцагчдад оноо олгох амлалт нь тусдаа гүйцэтгэлийн үүрэг юм. Борлуулалтын үнийг бүтээгдэхүүн болон оноонд тус тусад нь харьцангуй дан борлуулалтын үнэд суурилан хуваарилдаг. Нэг онооны дан борлуулалтын нэгжийн үнэ нь нэг төгрөг. Борлуулсан бүтээгдэхүүний дан борлуулалтын үнэ нь жижиглэнгийн үнэтэй тэнцүү. Борлуулалтын үнээс оноонд хуваарилсан дүнгээр гэрээний өр төлбөр үүсгэж бүртгэдэг ба харилцагч оноогоо ашиглах үед орлогоор хүлээн зөвшөөрнө.







МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

Үнэт цаасны танилцуулга

2021-09-17  
БҮРТГЭВ-02

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр

3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

(г) Компани заримдаа харилцагчдад урамшууллын хөтөлбөр санал болгодог (жишээ нь гурвыг авбал нэг үнэгүй) Энэ нь тусдаа гүйцэтгэлийн үүрэг үүсгэх материаллаг эрх юм. Борлуулалтын үнээс харьцангуй дан борлуулалтын үнэд суурилан материаллаг эрхэд хуваарилдаг. Үнэгүй бүтээгдэхүүн авах эрх сүүлийн худалдан авалт дээр 100% хэрэгжих ба тухайн үед орлогыг хүлээн зөвшөөрнө

(д) Хямдралтай борлуулалтаас олсон орлогын хямдруулалтын дүнг хассан цэвэр борлуулалтын үнэ дээр үндэслэн хүлээн зөвшөөрнө.

**Дэд франчайзын орлого.** Барааны хяналтыг шилжүүлэх үед буюу барааг дэд франчайз дэлгүүрт хүргэж өгөх үед борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрдөг. Дэд франчайз дэлгүүрүүд барааг захиран зарцуулан бүрэн эрхтэй бөгөөд дэд франчайз барааг хүлээж авах эсэхэд нөлөөлөхүйц биелэгдээгүй үүрэг байхгүй. Барааг тухайн байршилд аваачсан; барааны хугацаа дуусах, алдагдах эрсдэл дэд франчайзад шилжсэн; дэд франчайз нь барааг гэрээний дагуу хүлээж авсан эсхүл хүлээн авсанаа илэрхийлэх хугацаа өнгөрсөн; эсвэл Компанид бүх шаардлага хангагдсан гэж үзэх бодит баримт байгаа тохиолдолд хүргэлт хийгдсэн гэж үзнэ.

**Брэнд нэр ашигласны эрхийн шимтгэл.** Компани өөрийн брэнд нэрийг ашиглан дэлгүүрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрхийг дэд франчайзинг олгох ба төлбөрийг урьдчилан хүлээж авна. Дэд франчайзын эрх нь тусдаа гүйцэтгэлийн үүрэг болох бөгөөд хугацааны туршид хэрэгжинэ. Дэд франчайзаас хүлээн авсан урьдчилгаа төлбөрийг франчайзын гэрээний хугацаанд шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрнө. Ирээдүйн хугацаанд хамаарах дүн дээр гэрээний өр төлбөр хүлээн зөвшөөрнө

**Бусад үйлчилгээний орлого.** Компани тогтмол болон хувьсах үнэ бүхий гэрээт үйлчилгээ үзүүлдэг. Үйлчилгээний орлогыг тухайн үйлчилгээг үзүүлсэн тайлант хугацаанд хүлээн зөвшөөрдөг. Тогтмол үнэтэй гэрээний хувьд тайлант хугацааны төгсгөл хүртэл бодитоор үзүүлсэн үйлчилгээн дээр үндэслэн орлогыг хүлээн зөвшөөрнө.

Гэрээнд нэгээс олон гүйцэтгэлийн үүрэг байгаа тохиолдолд дан борлуулалтын үнэд үндэслэн борлуулалтын үнийг гүйцэтгэлийн үүргүүдэд хуваарилна. Дан борлуулалтын үнийг шууд тодорхойлох боломжгүй үед өртөг дээр ашгийн ахиуцыг нэмэх аргаар тооцоолно. Тогтмол үнэтэй гэрээний хувьд, харилцагчид гэрээндээ тулгуурлан тогтмол дүн төлдөг.

Хэрэв гэрээнд хувьсах нөхцлийг багтаасан бол орлогыг буцаалт хийгдэхгүй байх өндөр магадлалтай хэмжээгээр хүлээн зөвшөөрнө

**Хүүгийн орлого.** Хүүгийн орлогыг бүх өрийн хэрэгслүүдэд аккруэл сууриар үр ашигт хүүгийн аргыг ашиглан бүртгэдэг. Энэ арга нь хүүгийн орлогын нэг хэсэг болох үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох гэрээний талуудын хооронд хүлээн авсан бүх шимтгэл, бусад бүх шимтгэл эсвэл хөнгөлөлтийг үл тоомсорлодог

Үр ашигт хүүгийн салшгүй төлбөрт санхүүгийн хөрөнгийг бий болгох, олж авахтай холбоотой Компаниас хүлээн авсан буюу төлсөн төлбөр, жишээлбэл, зээлийн чадварыг үнэлэх, баталгаа эсвэл барьцааны зүйлийг үнэлэх, бүртгэх, уг хэрэгслийн нөхцлийг тохиролцох, боловсруулах төлбөр зэрэг орно.

**Ажилчдын зардал ба тэтгэмж – богино хугацаат тэтгэмжүүд.** Цалин хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг ажиллагсад холбогдох үйлчилгээ үзүүлсэн жилд зардлаар хүлээн зөвшөөрдөг. Ээлжийн амралт гэх мэт цалинтай богино хугацааны хуримтлагдан тооцогдох чөлөөг ажиллагсад ирээдүйд цалинтай чөлөө авах эрх олж авах үйлчилгээг үзүүлсэн үед, цалинтай богино хугацаат хуримтлагдахгүй чөлөөг (жишээ нь, өвчний улмаас чөлөө авах) чөлөө авах үед тус тус хүлээн зөвшөөрдөг.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компаниуд хуулийн дагуу улсын тэтгэврийн, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын сангуудад шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлүүдийг үүссэн үед нь орлого үр дүнгийн тайланд зардлаар бүртгэдэг. Компанийн хуулинд зааснаас өөр тэтгэвэр болон бусад тэтгэмжийн хөтөлбөрт төлбөр төлөх ямар нэгэн эрх зүйн эсвэл үүсмэл үүрэг хүлээгээгүй болно.

**Нэгж хувьцаанд ногдох ашиг.** Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)-ийг энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдох ашиг (алдагдал)-ийн дүнг тайлант хугацаанд эргэлтэнд байсан хувьцааны жинлэсэн дундаж тоонд харьцуулж тооцдог.





**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)**

**Сегментийн тайлагнал.** Үйл ажиллагааны сегментийн тайланг АҮАШГаргагчид ашигладаг дотоод тайлагналтай нийцүүлэн гаргадаг. Орлого, үр дүн, эсвэл хөрөнгийн аль нэг нь нийт сегментүүдийн нийлбэр дүнгийн 10 буюу түүнээс дээш хувийг бүрдүүлдэг сегментийг тусад нь тайлагнана.

**4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан үндсэн тооцоолол ба үнэлэлт**

Компани нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүд болон дараагийн санхүүгийн тайлант жилийн хөрөнгө болон өр төлбөрийн бүртгэлийн дүнгүүдэд нөлөө үзүүлэх үнэлэлт болон тооцооллыг хийдэг. Тооцоолол болон үнэлэлтүүд нь үргэлж хянагддаг бөгөөд удирдлагын туршлага болон ирээдүйн үйл явдлын талаарх нөхцөл байдалд зохистой гэж үзсэн хүлээлт, таамаглал зэрэг бусад хүчин зүйлүүдэд суурилдаг. Удирдлага нь тооцоололд үнэлэлт хийхийн зэрэгцээ нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцыг мөн үнэлдэг. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд хамгийн мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үнэлэлтүүд болон дараагийн санхүүгийн жилийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнгүүдэд мэдэгдэхүйц залруулга хийх шаардлага үүсгэж болох тооцооллуудад дараах зүйлс хамаарна.

**Тасралтгүй байх.** Удирдлага нь эдгээр санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмын үндсэн дээр бэлтгэсэн. Энэхүү дүгнэлтийг гаргахдаа Компанийн санхүүгийн байдал, одоогийн зорилго, үйл ажиллагааны ашигт байдал, санхүүгийн эх үүсвэр татах боломжийг харгалзан үзсэн.

Тодруулга 1-т дурдсанчлан, Компани нь хөгжлийн шатандаа явж байгаа бөгөөд менежмент өргөжилтийг үргэлжлүүлэн, 2023 он гэхэд дэлгүүрийн тоог 350 хүргэхээр төлөвлөж байна. 2020 оны 12 сарын 31-ны байдлаар Компани 103 дэлгүүртэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Компанийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ нь төлөвлөгөөт дэлгүүрүүдийг нээхэд шаардлагатай капиталыг бүрдүүлж хүрэлцэхгүй юм. Ирээдүйн мөнгөн гүйлгээний таамаглалын дагуу Компани 2022 онд хугарлын цэгтээ хүрэхээр хүлээгдэж байна.

Хуримтлагдсан алдагдал 2020 оны 12 сарын 31-ны байдлаар 33,525,294 мянган төгрөг (2019: 17,797,199 мянган төгрөг). 2020 оны 12 сарын 31-ны байдлаар компанийн эргэлтийн өр төлбөр эргэлтийн хөрөнгөөс 26,904,936 мянган төгрөгөөр илүү (2019: 5,307,152 мянган төгрөгөөр) байна. Дэлгүүрийн өргөжилтийг санхүүжүүлэхийн тулд Компани гаднаас нэмэлт санхүүжилт татах хэрэгтэй. Эдгээр нөхцөл байдал нь Компанийн тасралтгүй байх зарчимд эргэлзээ төрүүлэхүйц материаллаг тодорхой бус байдал үүсгэж байна. Тиймээс Компани нь ерийн бизнесийн үйл ажиллагааны явцад хөрөнгөө ашиглаж, өр төлбөрөө барагдуулж чадахгүй байх магадлалтай.


2021 оны 6-р сарын 8-ны өдрийн Хувьцаа эзэмшигчидийн тогтоол #4-ийн дагуу компани санхүүгийн өр төлбөрөө дахин бүтэцчилсэн. Үүний дагуу, 2021 оны 6-р сарын 8-ны өдөр Компани Премиум Групп ХХК болон Голомт Банктай эзэлийг дахин бүтэцчилэх гэрээнд гарын үсэг зурснаар Компани Голомт банкнаас авсан 15,591,333 мянган төгрөг (2020 оны 12 сарын 31-ны байдлаар 16,293,786 мянган төгрөг)-ийн богино хугацаат эзэлийг Премиум Групп ХХК-д шилжүүлсэн.

Мөн, 2021 оны 6-р сарын 8-ны өдрийн Хувьцаа эзэмшигчидийн тогтоол #4-ийн дагуу Компанийн Премиум Групп ХХК-д төлөх 19,795,025 мянган төгрөгийн (2020 оны 12 сарын 31-ны байдлаар 15,509,270 мянган төгрөг) бусад өр төлбөр, холбоотой тал болох БиЖиЭф Ритэйл ХХК-аас авсан 5,083,551 мянган төгрөгийн урт хугацаат зээл, хамааралтай талуудаас авсан 641,207 мянган төгрөгийн зээл, толгой компаниас Премиум Дистрибушн ХХК-д оруулсан 7,724,396 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг шинээр энгийн хувьцаа гаргах замаар эздийн өмч рүү хөрвүүлсэн.

Түүнчлэн, 2021 оны 6-р сарын 8-ны хувьцаа эзэмшигчидийн тогтоолын дагуу Компанийн эзэмшлийн бүтэц өөрчлөгдсөн. Премиум Групп ХХК-ын эзэмшилд байсан нийт эргэлтэд байсан хувьцааны 90.9 хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг 8 хувьцаа эзэмшигчийн нэр дээр шилжүүлсэн. 7 хувьцаа эзэмшигч иргэн нэмэлтээр 2,000,000 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг Компанид хийсэн.

Үүний дараагаар, 2021 оны 6-р сарын 30-ны байдлаар, Компанийн эргэлтийн хөрөнгийн дүн (16,307,913 мянган төгрөг) эргэлтийн өр төлбөрийн дүнг (13,222,872 мянган төгрөг) давж байгаа бөгөөд дээр дурьдсан Компанийн тасралтгүй байх чадвартай холбоотой эрсдлийг бууруулж байгаа юм.





**Сэнтрал Экспресс Су Ву Эс ХХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан үндсэн тооцоолол ба үнэлэлт (Үргэлжлэл)**

Компанийн удирдлага олон нийтэд хувьцаагаа гаргах хүсэлтээ Монгол улсын санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргах замаар өмчийн санхүүжилт татан, цаашдын өргөжилтөө санхүүжүүлэхээр ажиллаж байна. Компани эргэлтэнд байгаа хувьцааныхаа 10 хувийг гаргаж, 15,711,111 мянган төгрөгийн санхүүжилт босгохоор төлөвлөж байна. Компани уг санхүүжилтийн ойрын ирээдүйд татан төвлөрүүлэх хүлээлттэй байгаа бөгөөд Менежмент тасралтгүй байх зарчмыг баримтлах нь тохиромжтой хэмээн дүгнэсэн. Тиймээс эдгээр санхүүгийн тайланд Компани хангалттай санхүүжилт босгож чадахгүй байх эрсдлийн улмаас нэмэлт эх үүсвэр олж авах боломжгүй тохиолдолд бүртгэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн дүн нөхөгдөх боломжтой эсэх болон ангилахтай холбоотой аливаа залруулгыг оруулаагүй болно. 2020 оны 12 сарын 31-ны байдлаар дээрх үйл явдлууд Компанийн тасралтгүй байх зарчимд эргэлзээ төрүүлэхүйц материаллаг тодорхой бус байдал үүсгэж байна.

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа.** Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойлох нь ижил төстэй хөрөнгүүдийг ашиглаж үзсэн туршлага дээр тулгуурладаг. Ирээдүйн эдийн засгийн өгөөж нь энэхүү хөрөнгийн ашиглалтаас орж ирнэ. Хэдий тийм ч, техникийн болон хоцрогдол, биет элэгдэл хорогдуулалт зэрэг үзүүлэлтүүдээс хамааран хөрөнгөд агуулагдаж буй эдийн засгийн өгөөж буурдаг. Компанийн удирдлага нь хөрөнгийн үлдсэн ашиглалтын хугацааны шинжилгээг одоогийн техникийн нөхцөл байдал болон хөрөнгийн ирээдүйд өгөх үр ашигт тулгуурлан явуулдаг. Энд: (а) хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалт, (б) хүлээгдэж буй биет хорогдуулалт, энэ нь засвар үйлчилгээ болон үйл ажиллагааны хүчин зүйлсээс хамаарах, (в) эдийн засагт орж буй өөрчлөлтөөс хамаарч буй техникийн болон арилжааны хоцрогдол гэсэн үндсэн хүчин зүйлсийг авч үздэг.

**Хувьцаанд суурилсан төлбөр.** Компани нь бэлэн мөнгөний төлбөр тооцоотой хувьцаанд суурилсан төлбөр хийсэн бөгөөд энэ хүрээнд аж ахуйн нэгж нь компанийн өмчийн хэрэгслийн үнэ (үнэт цаас, хувьцааны опционыг оролцуулан) үнэ эсвэл үнийн дүн дээр үндэслэн гуравдагч этгээдээс бараа, үйлчилгээ хүлээн авсан.

**Өмчийн хэрэгслээр барагдуулсан тодорхойлогдоогүй бараа, үйлчилгээ.** Бэлэн мөнгөөр тооцоологдсон хувьцаанд суурилсан төлбөрийн оронд хүлээн авсан тусдаа тодорхойлогдоогүй бараа, үйлчилгээг өмчийн хэрэгслийн бодит үнээр хэмждэг.


Бэлэн мөнгөөр хийгдсэн гүйлгээний өр төлбөрийн бодит үнэ цэнийг тайлант өдөр бүр болон төлбөр тооцооны өдөр дахин хэмждэг. Бодит үнэ цэнийн аливаа өөрчлөлтийг тухайн үеийн ашиг, алдагдалд бүртгэнэ. Опцион хэрэгжихэд гүйлгээний зардлыг хассан дүнгээр хувьцаат капитал (нэрлэсэн үнэ) ба хувьцааны нэмэгдлын дүнг нэмдэг. Өр төлбөрийн бодит үнэ цэнийг тооцоход хорогдуулалтын хувь, өсөлтийн хувийг тооцоолон ашигладаг. Эдгээр тооцооллууд өөрчлөгдөх нь өр төлбөрийн дансны үнэд нөлөөлнө.

Компани хорогдуулалтын хувь болон өсөлтийн хувийн зохих түвшинг жил бүрийн эцэст тодорхойлно. Уг хүүг ашиглан өр төлбөрийг төлж барагдуулахад шаардлагатай ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцно. Хорогдуулалтын хувийг тооцохдоо компани ирээдүйн төлбөртэй ижил валютын, ойролцоо эргэн төлөгдөх хугацаа бүхий өндөр чанартай засгийн газрын бондын хүүгийн түвшинг авч үздэг.

**5 Нягтлан бодох бүртгэлийн шинэ ба нэмэлт өөрчлөлт орсон стандартууд болон тайлбарууд**

**COVID-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтөд хамаарах 2020 оны 5-р сарын 28-ны өдөр гаргасан СТОУС 16-д оруулсан нэмэлт өөрчлөлт, 2020 оны 6-р сарын 1-ний өдрөөс хойших тайлант жилүүдэд хүчин төгөлдөр болно.** Нэмэлт өөрчлөлт нь түрээслэгчдэд COVID-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийг түрээсийн өөрчлөлт мөн эсэхийг үнэлэхээс чөлөөлөх хэлбэрээр хөнгөлөлт үзүүлдэг. Түрээслэгчид түрээсийн хөнгөлөлтийг түрээсийн өөрчлөлт хийгээгүйтэй адилаар тооцож бүртгэх боломжтой. Практик арга нь зөвхөн COVID-19 цар тахлын шууд үр дагавар болох түрээсийн хөнгөлөлтөд хамааралтай бөгөөд зөвхөн дараах бүх нөхцлийг хангасан тохиолдолд хэрэглэнэ: өөрчлөлт орсон түрээсийн төлбөр нь өөрчлөлтийн өмнөхөн түрээсийн төлбөртэй бараг ижил хэмжээтэй буюу үүнээс бага хэмжээтэй байх; түрээсийн төлбөрийн аливаа бууралт нь зөвхөн 2021 оны 6-р сарын 30-ны өдрөөс өмнө төлөх төлбөрт нөлөөлдөг байх; мөн түрээсийн бусад





**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

нөхцлүүдэд мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүй байх. Нэмэлт өөрчлөлтийг хэрэглэх нь ашиглах эрхийн хөрөнгөд нөлөөгүй.

Дараах нэмэлт, өөрчлөлт оруулсан стандартууд 2020 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн боловч Компанид материаллаг нөлөө үзүүлэхгүй:

- Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд оруулсан нэмэлт өөрчлөлт (2018 оны 3 сарын 29-ны өдөр батлан гаргасан бөгөөд 2020 оны 1 сарын 1-ний өдрөөс хойших жилийн хугацаануудад хүчин төгөлдөр болно).
- Бизнесийн тодорхойлолт – СТУОС 3-т оруулсан нэмэлт өөрчлөлтүүд (2018 оны 10 сарын 22-ны өдөр батлан гаргасан бөгөөд 2020 оны 1 сарын 1-ний өдрөөс хойших жилийн хугацаануудад хүчин төгөлдөр болно).
- Материаллаг байдлын тодорхойлолт – НББОУС 1 болон НББОУС 8-д оруулсан нэмэлт өөрчлөлт (2018 оны 10 сарын 31-ний өдөр батлан гаргасан бөгөөд 2020 оны 1 сарын 1-ний өдрөөс хойших жилийн хугацаануудад хүчин төгөлдөр болно).
- Зах зээлийн жишиг хүүгийн түвшний шинэчлэл - НББОУС 39, СТУОС 7, СТУОС 9-д оруулсан нэмэлт өөрчлөлт (2019 оны 9 сарын 26-ны өдөр батлан гаргасан бөгөөд 2020 оны 1 сарын 1-ний өдрөөс хойших жилийн хугацаануудад хүчин төгөлдөр болно).

**6 Шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн стандартын мэдэгдлүүд**

2021 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойших жилийн хугацаанд заавал биелүүлэх ёстой бөгөөд Компанийн эрт батлаагүй зарим стандарт, тайлбарыг гаргасан. Доорх шинэ болон нэмэлт өөрчлөлт орсон стандартууд нь Компанийн санхүүгийн тайлангуудад томоохон нөлөө үзүүлэхгүй.

Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд	Хэрэгжих огноо
Хөрөнгө оруулагч болон түүний хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр хоорондын хөрөнгө худалдан борлуулах болон хөрөнгө оруулах – СТУОС 10 болон НББОУС 28-д орсон өөрчлөлтүүд	Тодорхойлогдоогүй
СТОУС 17 Даатгалын Гэрээнүүд	2023 оны 1 сарын 1
СТОУС 17-д орсон нэмэлт өөрчлөлтүүд болон СТУОС 4-д орсон нэмэлт өөрчлөлт	2023 оны 1 сарын 1
Богино болон урт хугацаат өр төлбөрийн ангилал - НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлтүүд	2022 оны 1 сарын 1
Өр төлбөрийг богино болон урт хугацаат гэж ангилах, дагаж мөрдөх хугацааны хойшлуулалт - НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлтүүд	2023 оны 1 сарын 1
Зориулалтын дагуу ашиглахаас өмнөх орлого, нарийн төвөгтэй гэрээнүүд – гэрээ гүйцэтгэлийн өртөг, үзэл баримтлалын хүрээний мэдээлэл – НББОУС 16, НББОУС 37 болон СТУОС 3-д орсон хязгаарлагдах/нарийн цар хүрээний нэмэлт өөрчлөлтүүд, СТУОС-ын 2018-2020 онуудын жил тутмын нэмэлт өөрчлөлтүүд – СТУОС 1, СТУОС 9, СТУОС 16 болон НББОУС 41-д хамааралтай өөрчлөлтүүд	2022 оны 1 сарын 1
Зах зээлийн жишиг хүүгийн түвшний шинэчлэл – СТУОС 9-ын 2-р шатны болон НББОУС 39, СТУОС 17, СТУОС 4, СТУОС 16 –д орсон нэмэлт өөрчлөлтүүд	2021 оны 1 сарын 1
НББОУС 1 болон СТУОС Практик Тайлагнал 2: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгад орсон нэмэлт өөрчлөлтүүд	2023 оны 1 сарын 1
НББОУС 8: Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолтод орсон нэмэлт өөрчлөлтүүд	2023 оны 1 сарын 1
Нэгж гүйлгээнээс үүсэх хөрөнгө, өр төлбөртэй холбоотой хойшлогдсон татвар – НББОУС 12-д орсон нэмэлт өөрчлөлтүүд	2023 оны 1 сарын 1

Дээр дурдсанаас өөрөөр тайлбарлаагүй тохиолдолд шинэ стандарт болон өөрчлөлтүүд Компанийн санхүүгийн тайланд мэдэгдэхүйц их хэмжээний нөлөө үзүүлэхгүй гэж таамаглаж байна.





**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**7 Сегментийн мэдээлэл**

Үйл ажиллагааны сегмент гэж орлого олох эсвэл зардал гаргах боломжтой бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, үйл ажиллагааны үр дүнг ахлах үйл ажиллагааны шийдвэр гаргагч (АҮАШГ) тогтмол хянаж үздэг бөгөөд санхүүгийн хувьд салангид мэдээлэл авах боломжтой бүрэлдэхүүн хэсгүүдийг хэлнэ. АҮАШГ нь байгууллагын нөөцийг хуваарилж, гүйцэтгэлийг үнэлдэг хүн эсвэл бүлэг хүмүүс юм. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх Менежментийг АҮАШГ гэж тодорхойлсон.

**(a) Тайлагнах сегмент бүрийн орлого олдог бүтээгдэхүүн, үйлчилгээний тодорхойлолт**

АҮАШГ нь Компанийн гүйцэтгэлийг бүтээгдэхүүний өнцгөөс шинэжилж, бизнесийн хоёр сегмент тодорхойлсон. Газарзүйн өнцгөөс авч үзээгүй; Компани газарзүйн нэг байршилд үйл ажиллагаагаа явуулдаг.

- Сегмент 1 – Эцсийн хэрэглэгчид борлуулсан бараа;
- Сегмент 2 – Дэд франчайзад үзүүлсэн үйлчилгээ болон хүлээж авсан эрхийн шимтгэл;

**(b) Тайлангийн сегментийг тодорхойлоход удирдлага ашигласан хүчин зүйлүүд**

Компанийн гол үйлчлүүлэгчид нь жижиглэнгийн худалдаа эрхлэгчид болон дэд франчайзын эрх эзэмшигч тусдаа хуулийн этгээдүүд юм. Компанийн сегментүүд нь өөр өөр бүтээгдэхүүн, үйлчилгээнд анхаарлаа төвлөрүүлдэг стратегийн бизнесийн нэгжүүд юм. Бизнесийн нэгж бүр өөр өөр маркетингийн стратеги, үйлчилгээний түвшинг шаарддаг тул тэдгээрийг тусад нь удирддаг.

**(в) Үйл ажиллагааны сегментийн ашиг, алдагдал, хөрөнгө, өр төлбөрийг хэмжих**

АҮАШГ нь дотоод тайлагналын шаардлагад нийцүүлсэн санхүүгийн тайлагналын олон улсын стандартад үндэслэн бэлтгэсэн санхүүгийн мэдээллийг хянаж үздэг. Ийм санхүүгийн мэдээлэл нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартаас зарим талаараа ялгаатай байдаг:

- (i) Орлогын албан татварыг сегментэд хуваарилдаггүй;
- (ii) Компанийн тэтгэврийн сангийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөггүй;
- (iii) Авлагын нөөцийг СТОУС 9-д тусгасан хүлээгдэж буй алдагдлын загвараар биш удирдлагын удирдлагын дүгнэлт, мэдээллийн олдоцод үндэслэн хүлээн зөвшөөрнө;

**(г) Тайлангийн сегментийн ашиг, алдагдал, хөрөнгө, өр төлбөрийн талаархи мэдээлэл**

2020 оны 12-р сарын 31-ний өдөр дууссан жилийн тайлагнах сегментүүдийн мэдээллийг дор харуулав:

Мянган төгрөгөөр	Сегмент 1	Сегмент 2	Нийт
<b>2020</b>			
Гадаад орлого			
- Үндсэн үйл ажиллагааны орлого	45,018,396	329,636	45,348,032
<b>Нийт борлуулалтын орлого</b>	<b>45,018,396</b>	<b>329,636</b>	<b>45,348,032</b>
<b>Борлуулалтын өртөг:</b>			
Шууд түүхий эд материал	31,940,167	-	31,940,167
Шууд хөдөлмөрийн зардал	6,249,140	-	6,249,140
Элэгдэл, хорогдол	4,896,166	354,937	5,251,103
Түгээлтийн зардал	1,903,757	-	1,903,757
Цахилгааны зардал	821,247	-	821,247
Бусад	4,541,422	-	4,541,422
<b>Ерөнхий, удирдлагын болон борлуулалтын зардал:</b>			
Хөдөлмөрийн зардал	3,299,521	-	3,299,521





**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

Маркетингийн зардал	565,091	-	565,091
Элэгдэл, хорогдол	573,624	-	573,624
Харилцаа, холбоо, мэдээллийн технологи	167,076	-	167,076
Мэргэжлийн үйлчилгээний хөлс	80,230	-	80,230
Хүлээн авалтын зардал	70,810	-	70,810
Хүний нөөцийн үйл ажиллагааны зардал	43,685	-	43,685
Судалгаа, хөгжүүлэлтийн зардал	34,533	-	34,533
Бичиг хэргийн зардал	19,864	-	19,864
Сургалт, хөгжүүлэлтийн зардал	17,420	-	17,420
Интернэтийн зардал	15,983	-	15,983
Бизнесийн уулзалтын зардал	7,048	-	7,048
Түрээсийн зардал	1,345	-	1,345
Бусад	206,195	-	206,195
<b>Бусад орлого, зардал</b>			
Үйл ажиллагааны бус орлого	332,673	-	332,673
Үйл ажиллагааны бус зардал	(366,283)	-	(366,283)
Санхүүгийн орлого	159,415	-	159,415
Санхүүгийн зардал	(5,588,408)	-	(5,588,408)
<b>Сегментийн татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(15,898,531)</b>	<b>(25,301)</b>	<b>(15,923,832)</b>

Сегментийн хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн тайланд хэмждэгтэй адил хэмжинэ. Эдгээр хөрөнгийг сегментийн үйл ажиллагаа болон хөрөнгийн бие байршил дээр үндэслэн хуваарилна.

2020 оны 12-р сарын 31-ний өдөр дууссан жилийн тайлагнах сегментүүдийн мэдээлэл (үргэлжлэл):

Мянган төгрөгөөр	Сегмент 1	Сегмент 2	Нийт
Үндсэн хөрөнгө	16,455,768	1,460,407	17,916,171
Ашиглах эрхтэй хөрөнгө	16,813,036	-	16,813,036
Биет бус хөрөнгө	2,771,850	36,265	2,808,115
Бусад авлага	404,800	-	404,800
Бусад эргэлтийн бус урьдчилгаа	369,717	-	369,717
Санхүүгийн түрээсийн авлага	2,062,987	-	2,062,987
Хойшлогдсон татварын хөрөнгө	240,809	-	240,809
Бараа материал	6,710,974	-	6,710,974
Урьдчилгаа	1,844,388	-	1,844,388
Дансны ба бусад авлага	1,111,289	358,455	1,469,744
Санхүүгийн түрээсийн авлага	171,821	-	171,821
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	6,104,077	-	6,104,077
<b>Сегментийн нийт хөрөнгө</b>	<b>55,061,516</b>	<b>1,855,127</b>	<b>56,916,643</b>
Урт хугацаат түрээсийн өр төлбөр	19,570,737	-	19,570,737
Урт хугацаат зээл	10,520,000	-	10,520,000
Дансны ба бусад өглөг	24,320,649	-	24,320,649
Богино хугацаат зээл	16,360,739	-	16,360,739
Богино хугацаат түрээсийн өглөг	1,627,744	-	1,627,744
Бусад татварын өглөг	439,644	-	439,644
Гэрээний өр төлбөр	99,036	358,128	457,164
<b>Сегментийн нийт өр төлбөр</b>	<b>72,938,549</b>	<b>358,128</b>	<b>73,296,677</b>

2020 онд Сегмент 1, Сегмент 2-т нэмэгдсэн нийт үндсэн хөрөнгө харгалзан 7,212,702 мянган төгрөг болон 1,460,407 мянган төгрөг байв. Мөн Сегмент 1, Сегмент 2-т нэмэгдсэн нийт биет бус хөрөнгө 316,755 мянган төгрөг болон 36,265 мянган төгрөг байв.

**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**8 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ болон дансны үлдэгдлүүд**

2019 оны 12-р сарын 31-ний байдлаар нэгдсэн ерөнхий хяналтанд буй байгууллагууд нь Премиум Индастриал энд Инженеринг ХХК, Премиум Бьюлдинг Материалс ХХК, Премиум Прожектс ХХК, Премиум Дистрибьюшн ХХК, Руссо Моторс ХХК, Юу Эм Эс ХХК байв. Эрх бүхий албан тушаалнууд нь Гүйцэтгэх захирал болон хэлтсийн дарга нараас бүрдэнэ. Бусад холбоотой талуудад нь компанийн эцсийн хувьцаа эзэмшигчид шууд болон шууд бус хэлбэрээр санал өгөх эрхийн талаас илүү хувь нь ашиг сонирхол бүхий эсвэл үйл ажиллагаанд нь хяналт тавих эрх мэдэл бүхий аж ахуйн нэгжүүд болон хувьцаа эзэмшигч БиЖиЭф Ритэйл ХХК багтана.

2020 оны 12-р сарын 31-ний өдөр холбоотой талуудын үлдэгдэл дараах байдалтай байна.

Мянган төгрөгөөр	Тодруулга	Шууд толгой компани	Эцсийн хувьцаа эзэмшигч	Ерөнхий хяналтанд буй байгууллагууд	Бусад холбоотой тал
	Бусад авлагын нийт дүн	-	-	203,581	-
	Дансны ба бусад өглөг	19,15,509,270	-	840,308	-
	Урьдчилгаа	13	-	1,059,438	200,139
	Зээл	20	11,095,040	-	10,520,000

Худалдан авалт болон борлуулалтын зээлийн нөхцөл 60 хоног. Энэ хугацаанд борлуулалт болон худалдан авалтын төлөгдөөгүй дүнд ямар нэг хүү тооцохгүй. Мөн төлбөрийн үлдэгдлүүд барьцаагүй ба тайлант хугацаанд болон өмнөх тайлант хугацаанд гуравдагч талын авлагатай холбоотой эрсдлийн алдагдал хүлээн зөвшөөрөөгүй.

Компанид холбоотой талуудаас авсан хоёр зээл байгаа ба эцсийн эзэмшигчээс авсан зээлийг 2021 оны 6-р сард энгийн хувьцаанд хөрвүүлсэн. Энэхүү зээл нь Солонгос воноор илэрхийлэгдсэн 4.6%-ийн хүүтэй бөгөөд 2025 оны 9 сард төлөгдөж дуусна. Тодруулга 20-ийг харна уу.

2021 оны 6-р сарын 30-ны байдлаар бусад холбоотой талын зээлээс бусад холбоотой талуудтай хийсэн гүйлгээний үлдэгдлүүд бүгд хаагдсан. Бүх ажил гүйлгээ харилцан тохиролцсон нөхцөл болон зах зээлийн ханшийн үндсэн дээр хийгдсэн.

2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон тайлант жилд холбоотой талуудтай дараах орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн:

Мянган төгрөгөөр	Тодруулга	Шууд толгой компани	Эцсийн хувьцаа эзэмшигч	Ерөнхий хяналтанд буй байгууллагууд	Бусад холбоотой тал
	Бэлэн бүтээгдэхүүний борлуулалт	3,975	-	119,257	-
	Санхүүгийн зардал	-	-	-	-
	Бусад орлого	-	-	34,304	-
	Бусад зардал	4,374	-	19,337	-
	Үндсэн хөрөнгийн худалдан авалт	-	-	307,401	1,508,529
	Үндсэн хөрөнгийн борлуулалт	-	-	1,075,607	-
	Түгээлтийн үйлчилгээ	-	-	1,903,510	-
	Бараа материал худалдан авалт	24,7,420	-	3,168,157	2,297,160

Бараа материалыг Премиум Дистрибьюшн ХХК болон БиЖиЭф Ритэйл ХХК-аас худалдан авсан. Үндсэн хөрөнгийн худалдан авалт нь БиЖиЭф Ритэйл ХХК-ээс авсан худалдан авалт болон ерөнхий хяналтанд буй байгууллагуудаас худалдан авсан үндсэн хөрөнгүүд нь түрээсийн байрны сайжруулалт юм. Бүх ажил гүйлгээ харилцан тохиролцсон нөхцөл болон зах зээлийн ханшийн үндсэн дээр хийгдсэн. Худалдан авалтын зээлийн нөхцөл нь ажил гүйцэтгэж дууссанаас хойш 10 хоног байна.

**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**8 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ болон дансны үлдэгдлүүд (Үргэлжлэл)**

2019 оны 12-р сарын 31-ний өдөр холбоотой талуудын үлдэгдэл дараах байдалтай байна :

<i>Мянган төгрөгөөр</i>	Тодруул- га	Шууд толгой компани	Эцсийн хувьцаа эзэмшигч	Ерөнхий хяналтанд буй байгууллагууд
Бусад авлагын нийт дүн				382,449
Дансны ба бусад өглөг	19			1,331,771
Урьдчилгаа	13	179,243		
Зээл	20		581,000	
Нэмэлт хувьцаат капитал	17		6,194,526	

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон тайлант жилд холбоотой талуудтай дараах орлого, зарлагын гүйлгээ хийсэн:

<i>Мянган төгрөгөөр</i>	Тодруул- га	Шууд толгой компани	Эцсийн хувьцаа эзэмшигч	Ерөнхий хяналтанд буй байгууллагууд	Бусад холбоотой тал
Бэлэн бүтээгдэхүүний борлуулалт				15,112	
Түрээс болон холбоотой орлого				154,831	
Бусад орлого				326,006	
Бусад зардал		6,200		24,698	
Түгээлтийн үйлчилгээ				118,704	
Санхүүгийн зардал			98,362		
Бэлэн бүтээгдэхүүний худалдан авалт	24			2,260,648	1,669,952
Бодит үнэ цэнээр хэмжигдсэн ашиг алдагдлаарх бусад санхүүгийн өр төлбөрөөс үүссэн олз хасах гарз	26		2,037,753		

Компанийн эрх бүхий 8 албан тушаалтнуудад олгосон цалин урамшууллыг доорх байдлаар харуулсан (2019: 5):

<i>Мянган төгрөгөөр</i>	2020	2019
	Зардал	Зардал
Богино хугацааны тэтгэмж		
- Цалин хөлс	579,793	375,372
- Богино хугацааны урамшуулал	175,947	12,703
Тэтгэвэр болон нийгмийн даатгалын шимтгэл	44,712	48,509
<b>Нийт</b>	<b>800,453</b>	<b>436,584</b>

Богино хугацааны цалин урамшуулал нь удирдлагын холбогдох үйлчилгээг үзүүлсэн тайлант хугацаанаас хойш арван хоёр сарын дотор бүрэн төлөгддөг.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр

9 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны хөдөлгөөнийг дараах байдлаар харууллаа:

Мяанган төгрөгөөр	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	Оффисын тавилга, эд хогшил	Түрээсийн саяжруулалт	Нийт
2018 оны 12 сарын 31 өртөг	124,684	3,477,255	2,582,393	6,184,332
Хуриятлагдсан элэгдэл	(6,536)	(188,710)	(304,482)	(499,728)
2019 оны 1 сарын 1 үлдэгдэл	116,148	3,288,545	2,277,911	5,684,604
Нэмэгдсэн Борлуулсан Элэгдлийн зардал	1,047,262	5,941,156	2,953,729	9,942,147
	(90,855)	(13,108)	-	(13,108)
	(90,855)	(1,186,834)	(722,885)	(2,000,574)
2019 оны 12 сарын 31 үлдэгдэл	1,074,555	8,029,759	4,508,755	13,613,070
2019 оны 12 сарын 31 өртөг	1,171,946	9,405,303	5,536,122	16,113,372
Хуриятлагдсан элэгдэл	(97,391)	(1,375,544)	(1,027,367)	(2,500,302)
2020 оны 1 сарын 1 үлдэгдэл	1,074,555	8,029,759	4,508,755	13,613,070
Нэмэгдсэн Борлуулсан	2,034	5,732,144	2,943,931	8,678,109
Борлуулсан – элэгдэл	(100,452)	(858,999)	(580,322)	(1,539,773)
Данснаас хассан	5,711	108,026	176,343	290,080
Данснаас хассан – элэгдэл	-	(151,191)	-	(151,191)
Элэгдлийн зардал	(103,113)	74,547	-	74,547
	(103,113)	(2,211,691)	(733,867)	(3,048,671)
2020 оны 12 сарын 31 үлдэгдэл	878,735	10,722,595	6,314,840	17,916,171
2020 оны 12 сарын 31 өртөг	976,137	14,127,257	7,899,731	23,100,517
Хуриятлагдсан элэгдэл	(97,402)	(3,404,662)	(1,584,981)	(5,184,346)
2020 оны 12 сарын 31 үлдэгдэл	878,735	10,722,595	6,314,840	17,916,171

Банкнаас авсан зээлэнд компанийн эзэмшиж буй үндсэн хөрөнгийг барьцаалсан. Компанийн эзэмшиж буй барьцаанд байгаа үндсэн хөрөнгө болох 10,232,010 мянган төгрөг нь тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл болон оффисын хэрэгсэлээс бүрдэж байна. Тодруулга 20 харна уу.





**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулагууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**10 Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө болон түрээсийн өглөг**

Компани нь дэлгүүрийн талбай болон тээврийн хэрэгсэл түрээсэлдэг. Түрээсийн гэрээг ихэвчлэн тогтмол 2 жилээс 10 жилийн хугацаанд хийгддэг.

Мянган төгрөгөөр	Талбай	Тээврийн хэрэгсэл	Нийт
<b>2019 оны 1 сарын 1 үлдэгдэл</b>	<b>8,162,956</b>	-	<b>8,162,956</b>
Нэмэгдсэн	8,874,977	47,900	8,922,877
Элэгдлийн зардал	(1,466,154)	(2,283)	(1,468,437)
<b>2020 оны 1 сарын 1 үлдэгдэл</b>	<b>15,571,779</b>	<b>45,617</b>	<b>15,617,396</b>
Нэмэгдсэн	5,590,155	-	5,590,155
Худалдсан	(2,571,338)	-	(2,571,338)
Элэгдлийн зардал	(1,818,866)	(4,311)	(1,823,177)
<b>2020 оны 12 сарын 31 үлдэгдэл</b>	<b>16,771,730</b>	<b>41,306</b>	<b>16,813,036</b>

Дэд түрээсийн гүйлгээ болон санхүүгийн түрээсийн авлагыг хүлээн зөвшөөрөхтэй холбоотойгоор 2020 онд талбай худалдсан гүйлгээ гарсан.

Компани дараах түрээсийн өглөгийг хүлээн зөвшөөрсөн.

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Богино хугацаат түрээсийн өр төлбөр	1,627,744	1,004,568
Урт хугацаат түрээсийн өр төлбөр	19,570,737	15,321,360
<b>Нийт түрээсийн өр төлбөр</b>	<b>21,198,481</b>	<b>16,325,928</b>

2020 оны санхүүгийн зардалд бүртгэсэн түрээсийн хүүгийн зардал 2,974,883 мянган төгрөг (2019: 1,900,768 мянган төгрөг) байсан. Тодруулга 28-с харна уу.



Борлуулалтын зардал, ерөнхий болон удирдлагын зардалд багтсан богино хугацааны түрээс, богино хугацааны түрээс гэж үзээгүй үнэ цэнэ багатай хөрөнгийн түрээсийн зардлууд:

Мянган төгрөгөөр	2020	2019
Богино хугацааны түрээстэй холбоотой зардал	50,755	344,007
Дээрх богино хугацааны түрээсээр оруулаагүй бага үнэ цэнэтэй хөрөнгийн түрээсийн зардал	1,633	1,591
Борлуулалтын орлогоос хамаарсан хувьсах түрээсийн зардал	94,420	-

Түрээсийн хугацааг сунгах болон цуцлах сонголт бүхий хэд хэдэн түрээсийн талбай Компанид бий. Эдгээр нь Компанийн үйл ажиллагаанд ашигласан хөрөнгийг удирдах тал дээр үйл ажиллагааны уян хатан байдлыг нэмэгдүүлэхэд ашиглагддаг. Хугацаа сунгах, цуцлах сонголтуудын дийлэнхийг зөвхөн Компани хэрэгжүүлэх эрхтэй болох бөгөөд тухайн түрээслүүлэгчид хэрэгжүүлэх эрх байхгүй.

Түрээсийн гэрээнд түрээслэсэн хөрөнгийн аюулгүй байдлыг хангахаас өөрөөр ямар нэгэн хязгаарласан заалт байхгүй. Түрээсийн хөрөнгийг зээлийн барьцаа болгон ашиглах боломжгүй.

2020 оны 12-р сарын 31-ны байдлаар түрээсийн хугацааг сунгахгүй (эсвэл цуцлах) гэсэн тодорхой үндэслэлтэй гэрээ байхгүй. Опционыг бодитоор хэрэгжүүлсэн (эсвэл хэрэгжүүлээгүй) эсвэл Компани үүнийг хэрэгжүүлэх (эсвэл хэрэгжүүлэхгүй) үүрэг хүлээсэн тохиолдолд түрээсийн хугацааг дахин үнэлнэ. Боломжийн баталгааны үнэлгээг энэ үнэлгээнд нөлөөлөхгүй чухал үйл явдал эсвэл нөхцөл байдалд томоохон өөрчлөлт гарсан тохиолдолд л хянан үзэх бөгөөд энэ нь Компанийн мэдэлд байна. 2020 онд түрээстэй холбоотой гарсан мөнгөн урсгал 3,692,485 мянган төгрөг (2019: 2,660,673 мянган төгрөг). Тодруулга 21-г харна уу.



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр

### 11 Биет бус хөрөнгө

Мянган төгрөгөөр	Франчайзын төлбөр	Програм хангамжийн лиценз	Нийт
<b>2018 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,227,364</b>	<b>240,899</b>	<b>2,468,263</b>
Нэмэгдсэн	-	815,087	815,087
Хорогдуулалтын зардал	(239,406)	(130,712)	(370,118)
<b>2019 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,987,958</b>	<b>925,274</b>	<b>2,913,232</b>
2019 оны 12 сарын 31-ний өртөг	2,396,680	1,082,291	3,478,971
Хуримтлагдсан хорогдуулалт	(408,722)	(157,017)	(565,739)
<b>2019 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,987,958</b>	<b>925,274</b>	<b>2,913,232</b>
Нэмэгдсэн	-	353,020	353,020
Борлуулсан	-	(3,252)	(3,252)
Хорогдуулалтын зардал	(240,324)	(214,561)	(454,885)
<b>2020 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,747,634</b>	<b>1,060,481</b>	<b>2,808,115</b>
2020 оны 12 сарын 31-ний өртөг	2,396,680	1,432,059	3,828,739
Хуримтлагдсан хорогдуулалт	(649,046)	(371,578)	(1,020,624)
<b>2020 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,747,634</b>	<b>1,060,481</b>	<b>2,808,115</b>

### 12 Бараа материал

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Борлуулах бараа	6,081,829	3,299,519
Борлуулах бараа – замд яваа	84,031	-
Барилгын материал	42,904	135,894
Хангамжийн материал	502,210	589,278
<b>Нийт бараа материал</b>	<b>6,710,974</b>	<b>4,024,691</b>



Борлуулалтын өртөгт бүртгэсэн 31,913,297 мянган төгрөг (2019: 27,451,329 мянган төгрөг)-ийн бараа материалын өртгийг тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрсөн. Тодруулга 24-өөс харна уу.

### 13 Урьдчилгаа

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа	1,844,388	866,447
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа – тоног төхөрөмж	369,717	21,324
<b>Нийт урьдчилгаа</b>	<b>2,214,105</b>	<b>887,771</b>
Урт хугацааны урьдчилгаа	369,717	21,324
Богино хугацааны урьдчилгаа	1,844,388	866,447







**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**15 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Бэлэн мөнгө	126,248	201,798
Замд яваа бэлэн мөнгө	-	133,839
Банкны харилцах дансанд буй мөнгө	5,977,829	315,847
<b>Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө</b>	<b>6,104,077</b>	<b>651,484</b>

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг үр ашигт хүүний аргаар тооцсон хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дансны үнэ бодит үнэ цэнээсээ материаллаг зөрүүгүй.

Дараах хүснэгтэнд 2020 оны 12 сарын 31 болон 2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн зээлжилтийн чанарыг зээлийн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн нэгтгэн харууллаа. Компанийн зээлийн эрсдэлийн үнэлгээний системийн талаарх тайлбарыг Тодруулга 33-аас харна уу.

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
- Маш сайн	-	-
- Сайн	-	-
- Хангалтай	5,977,829	449,686
- Тусгай хяналттай	-	-
<b>Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө (бэлэн мөнгө ороогүй)</b>	<b>5,977,829</b>	<b>449,686</b>

**16 Санхүүгийн түрээсийн авлага**

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Богино хугацаат түрээсийн авлага	171,821	-
Урт хугацаат түрээсийн авлага	2,062,987	-
<b>Нийт санхүүгийн түрээсийн авлага</b>	<b>2,234,808</b>	<b>-</b>

2020 онд Компани нь есөн дэлгүүрийн байрыг дэд франчайз эзэмшигчдэдээ түрээслүүлсэн.


Түрээсийн авлагын дансны үнэ нь бодит үнэ цэнээсээ материаллаг зөрүүгүй. Компани хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хэмжихэд СТОУС 9-ийн хялбаршуулсан аргыг хэрэглэдэг бөгөөд энэ нь түрээсийн авлагад хугацааны турш дахь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хасагдуулгыг тооцдог.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хэмжихийн тулд түрээсийн авлагууд зээлийн эрсдэлийн онцлог шинж болон хугацаа хэтэрсэн өдрүүдэд үндэслэн ангилагдсан.

Хүлээгдэж буй алдагдлын хувь хэмжээг тайлант хугацаа дуусахаас өмнөх 36 сарын хугацаан дахь төлбөрийн түүх болон энэ хугацаанд гарсан зээлийн холбогдох түүхэн алдагдалд үндэслэнэ. Алдагдлын түүхэн түвшинг түрээслэгчдийн авлагыг барагдуулах чадварт нөлөөлж буй макро эдийн засгийн хүчин зүйлсийн одоогийн болон хэтийн төлөвийн мэдээллийг харгалзан тохируулна.








**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**16 Санхүүгийн түрээсийн авлага (Үргэлжлэл)**

Санхүүгийн түрээсийн төлбөрийн авлагын насжилтын шинжилгээг харуулав.

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
1 жил	524,291	-
2 жил	524,291	-
3 жил	524,291	-
4 жил	524,291	-
5 жил	524,291	-
5 жилээс дээш	1,179,192	-
<b>Нийт дисквантчилаагүй санхүүгийн түрээсийн төлбөрийн авлага</b>	<b>3,800,647</b>	-
Хойшлогдсон санхүүгийн орлого	1,565,838	-
Эрсдлийн алдагдлын хасагдуулга	-	-
<b>Санхүүгийн түрээсийн авлага – 12 сарын 31</b>	<b>2,234,808</b>	-





**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**17 Хувьцаат капитал**

Мянган төгрөгөөр	Хувьцааны тоо (мянган ширхэг)	Энгийн хувьцаа	Нийт дун
2018 оны 12 сарын 31-нээрх	109,507	10,950,730	10,950,730
Шинээр гаргасан хувьцаа	61,945	6,194,526	6,194,526
2019 оны 12 сарын 31-нээрх	171,452	17,145,256	17,145,256
Шинээр гаргасан хувьцаа	-	-	-
2020 оны 12 сарын 31-нээрх	171,452	17,145,256	17,145,256

2019 оны 6 -р сард БиЖиЭф Ритэйл ХХК нь калл опционыг Мастер Франчайз Гэрээний 9.1 параграфын дагуу хэрэгжүүлэн нэг ширхэг хувьцаа нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 17,145,255 ширхэг хувьцаа шинээр худалдаж авсан. Үүний дараа БиЖиЭф Ритэйл ХХК-ийн хувьцаа 9.99% болсон.

Нийт зөвшөөрөгдсөн энгийн хувьцаа нэгжийн нэрлэсэн үнэ 100 төгрөг бүхий 171,452 мянган ширхэг хувьцаа (2019 он: 171,452 мянган ширхэг)-тай байна. Бүх гаргасан энгийн хувьцаанууд бүрэн төлөгдсөн. Энгийн хувьцаа бүр нэг саналын эрхтэй.

**18 Бусад татварын өглөг**

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
НДШ өглөг	55,978	257,217
ХХОАТ өглөг	119,974	163,587
НӨАТ өглөг	226,722	92,041
Бусад татварын өглөг	36,970	3,995
<b>12 сарын 31-нээрх нийт бусад татварын өглөг</b>	<b>439,644</b>	<b>516,840</b>

**19 Дансны ба бусад өглөг**

Мянган төгрөгөөр	Толр уулга	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Бусад өглөг – холбоотой талууд	8	16,349,578	1,331,771
Бусад өглөг – гуравдагч талууд		107,870	-
Дансны өглөг – гуравдагч талууд		7,393,522	5,457,216
Өр төлбөр - худалдан авсан үндсэн хөрөнгө		45,233	-
<b>Хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн дансны ба бусад өглөгөөрх нийт санхүүгийн өр төлбөр</b>		<b>23,896,203</b>	<b>6,788,987</b>
Ажилчдад өгөх өглөг		424,446	68,980
<b>Нийт бусад өглөг</b>		<b>424,446</b>	<b>68,980</b>
<b>12 сарын 31-нээрх дансны ба бусад өглөг</b>		<b>24,320,649</b>	<b>6,857,967</b>

Дансны ба бусад өглөгийн үлдэгдэл нь бодит үнэ цэнээсээ материаллаг зөрүүгүй.



**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**20 Зээл**

Мянган төгрөгөөр	Тодруулга	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
<b>Урт хугацаат</b>			
Зээл - гуравдагч тал		-	11,970,000
Зээл - холбоотой тал	8	10,520,000	581,000
<b>Богино хугацаат</b>			
Зээл - гуравдагч тал		15,713,911	3,282,410
Зээл - холбоотой тал	8	646,828	-
<b>Нийт зээл</b>		<b>26,880,739</b>	<b>15,833,410</b>

Компанийн зээлийг вальютаар ангилан харуулав:

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Монгол Төгрөг	16,360,739	12,654,600
Солонгос Вон	10,520,000	-
Америк Доллар	-	3,178,810
<b>Нийт зээл</b>	<b>26,880,739</b>	<b>15,833,410</b>

Банкинаас авсан зээлэнд компанийн эзэмшиж буй үндсэн хөрөнгөөс байрцаалсан. Компанийн эзэмшиж буй барьцаанд байгаа үндсэн хөрөнгө болох 10,232,010 мянган төгрөг нь тоног төхөөрөмж тээврийн хэрэгсэл болон оффисын хэрэгслээс бүрдэж байна. Тодруулга 9-с харна уу.


Компанийн өр төлбөрийн вальют болон хүүгийн түвшинг харуулав (хүүгийн өр төлбөр ороогүй):

Мянган төгрөгөөр	Вальют	Нэрлэсэн хүү (жилд)	Зээлийн хугацаа	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Арилжааны банк	MNT	16%	2021.06.08	15,263,168	12,053,954
Зээл - холбоотой тал	KRW	4.6%	2025.09.24	10,586,953	-
Зээл - холбоотой тал	MNT	16%	2021.06.08	579,875	588,106
Арилжааны банк	MNT	9%	2021.06.08	450,743	-
Арилжааны банк	USD	9%	2020.04.15	-	3,191,350
<b>Нийт хүүтэй зээл</b>				<b>26,880,739</b>	<b>15,833,411</b>

Компани нь хеджийн бүртгэл тооцоогүй бөгөөд гадаад валютын өр төлбөр, хүүгийн эрсдэлтэй холбоотой хеджийн гэрээ хийгээгүй болно. Зээлийн дансны үнэ нь бодит үнэ цэнтэйгээ ойролцоо.

Дээрх зээлийн гэрээнүүд нь зарим нэг санхүүгийн бус үүргийг биелүүлэхийг шаарддаг. Биелүүлээгүй тохиолдолд зээлийн гэрээг зөрчсөнд тооцох ба үлдэгдэл дүнг шууд төлж барагдуулах үүрэгтэй. Ийм учраас Санхүүгийн албанаас зээлийн үүргийн биелэлтийг улирал тутам хянадаг. 2020 оны 12 сарын 31 болон 2019 оны 12 сарын 31-ны байдлаар компани бүх үүргийн биелэлтийг хангасан байна.

2020 онд Компани БиЖиЭф Ритэйл ХХК ("зээлдүүлэгч")-тай зээлийн гэрээ байгуулсан бөгөөд Зээлдэгчийн хувьцааны 10 хувийг бодит үнэ цэнээр худалдан авах эрх бүхий опцион Зээлдүүлэгчид өгсөн. Опционыг зээл авснаас 3 жилийн дараагаас эхлэн хэрэгжүүлэх боломжтой. Кол опционыг зээлийн гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу зээлийн үлдэгдлийг тооцоход ашиглана.



**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**21 Санхүүжилтийн үйл ажиллагаанаас үүсэх өр төлбөрийн тохируулга**

Доорхи хүснэгтэд санхүүгийн үйл ажиллагааны өр төлбөрийн дүн шинжилгээ, санхүүгийн тайлант хугацааны Компанийн өр төлбөрийн өөрчлөлтийг хугацаа тус бүрээр харуулав. Эдгээр өр төлбөрийн зүйлүүд нь мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилт гэж тайлагнагдсан.

Мянган төгрөгөөр	Зээл	Санхүүгийн өр төлбөр	Нийт
<b>2019 оны 1 сарын 1-нээрх өр *</b>	-	<b>8,162,956</b>	<b>8,162,956</b>
<b>Мөнгөн урсгал</b>			
Авсан зээл	15,844,271	-	<b>15,844,271</b>
Үндсэн төлбөрийн эргэн төлөлт	(200,000)	(759,905)	<b>(959,905)</b>
Хүүгийн төлөлт	(1,100,906)	(1,900,768)	<b>(3,001,674)</b>
<b>Бэлэн бус гүйлгээ</b>			
Шинэ түрээс	-	8,922,877	<b>8,922,877</b>
Хуримтлагдсан хүү	1,204,507	1,900,768	<b>3,105,275</b>
Гадаад валютын тохируулга	85,538	-	<b>85,538</b>
<b>2019 оны 12 сарын 31-нээрх өр</b>	<b>15,833,410</b>	<b>16,325,928</b>	<b>32,159,338</b>
<b>Мөнгөн урсгал</b>			
Авсан зээл	13,787,912	-	<b>13,787,912</b>
Үндсэн төлбөрийн эргэн төлөлт	(3,241,964)	(717,602)	<b>(3,959,566)</b>
Хүүгийн төлөлт	(2,240,343)	(2,974,883)	<b>(5,215,226)</b>
<b>Бэлэн бус гүйлгээ</b>			
Шинэ түрээс	-	5,590,155	<b>5,590,155</b>
Хуримтлагдсан хүү	2,253,612	2,974,883	<b>5,228,495</b>
Гадаад валютын тохируулга	359,913	-	<b>359,913</b>
<b>2020 оны 12 сарын 31-нээрх өр</b>	<b>26,752,540</b>	<b>21,198,481</b>	<b>47,951,021</b>

**22 Гэрээний өр төлбөр**

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Гэрээний өр төлбөр – эрхийн шимтгэл	358,128	-
Урамшууллын оноо	88,030	1,710
Бэлгийн карт	11,006	44,954
<b>Нийт гэрээний өр төлбөр</b>	<b>457,164</b>	<b>46,664</b>

Гэрээний өр төлбөртэй холбоотой хүлээн зөвшөөрсөн орлого.

Гэрээний өр төлбөртэй холбоотой тайлант хугацаанд 45,348,032 мянган төгрөгийн орлогыг 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар хүлээн зөвшөөрсөн (2019: 37,467,874 мянган төгрөг), үүнээс эрхийн шимтгэлийн төлбөртэй холбоотой 39,260 мянган төгрөг байна. (2019: байхгүй).

**23 Орлого**

Мянган төгрөгөөр	2020	2019
Эцсийн хэрэглэгчид бараа борлуулсны орлого	42,626,801	37,467,874
Дэд франчайзад бараа борлуулсны орлого	2,391,595	-
Дэд франчайзад үйлчилгээ үзүүлсний орлого	290,376	-
Брэндийн нэрний эрхийн шимтгэлийн орлого	39,260	-
<b>Нийт харилцагчтай байгуулсан гэрээний орлого</b>	<b>45,348,032</b>	<b>37,467,874</b>

**23 Орлого (Үргэлжлэл)**





**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

Орлого хүлээн зөвшөөрөх хугацаа (орлогын эх үүсвэр бүрээр):

Мянган төгрөгөөр	2020	2019
Тухайн цаг хугацаанд	45,018,396	37,467,874
Хугацаанд хуваарилах	329,636	-
<b>Нийт харилцагчтай байгуулсан гэрээний орлого</b>	<b>45,348,032</b>	<b>37,467,874</b>

Гадны харилцагчдаас олсон орлогыг ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээгээр бүлэглэв:

Мянган төгрөгөөр	2020	2019
<b>Сегмент 1</b>		
- Бараа борлуулсны орлого	42,626,801	37,467,874
- Бараа борлуулсны орлого – дэд франчайз	2,391,595	-
<b>Сегмент 2</b>		
- Дэд франчайзын үйлчилгээний орлого	329,636	-
<b>Нийт харилцагчтай байгуулсан гэрээний орлого</b>	<b>45,348,032</b>	<b>37,467,874</b>

**24 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг**

Мянган төгрөгөөр	Тодруулга	2020	2019
Шууд түүхий эд материал *	12	31,940,167	28,167,277
Хөдөлмөрийн шууд зардал **		6,249,140	7,266,705
Элэгдэл ба хорогдуулалтын зардал	9,10,11	5,251,103	3,409,500
Түгээлтийн зардал		1,903,757	118,704
Цахилгааны зардал		821,247	583,445
Бусад зардал		4,541,422	3,809,960
<b>Нийт борлуулалтын өртөг</b>		<b>50,706,836</b>	<b>43,355,591</b>


\*Холбоотой талаас худалдан авсан шууд тухий эд материал 1,681,140 мянган төгрөг байсан. (2019: 3,930,600 мянган төгрөг)

\*\*Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 342,863 мянган төгрөг байсан. (2019: 808,671 мянган төгрөг)

**25 Ерөнхий ба удирдлагын зардал**

Мянган төгрөгөөр	Тодруулга	2020	2019
Хөдөлмөрийн зардал *		3,299,521	2,468,016
Маркетингийн зардал		565,091	264,779
Элэгдэл ба хорогдуулалтын зардал	9,11	573,624	429,629
Цахилгаан холбоо болон МТ-ийн зардал		167,076	63,265
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр		80,230	85,361
Баяр ёслолын зардал		70,810	103,711
Хүний нөөцийн зардал		43,685	117,806
Судалгаа, хөгжүүлэлтийн зардал		34,533	30,261
Бичиг хэргийн зардал		19,864	19,967
Сургалт хөгжүүлэлтийн зардал		17,420	38,715
Интернетийн зардал		15,983	18,227
Бизнесийн уулзалтын зардал		7,048	68,435
Түрээсийн төлбөр		1,345	103,235
Бусад зардал		206,195	378,446
<b>Нийт ерөнхий ба захиргааны болон борлуулалтын зардал</b>		<b>5,102,425</b>	<b>4,189,853</b>

\* Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 176,816 мянган төгрөг байсан. (2019: 275,590 мянган төгрөг)



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр

**26 Бусад орлого болон зардал, цэвэр дүнгээр**

Мянган төгрөгөөр	2020	2019
Бодит үнэ цэнээр хэмжигдсэн ашиг алдагдлаарх бусад санхүүгийн өр төлбөрөөс үүссэн олз хасах гарз	-	2,037,753
Үйл ажиллагааны бус бусад орлого	93,825	-
Түрээсийн хөрөнгө борлуулсны олз	234,568	-
Бусад орлого	4,280	18,450
<b>Нийт үйл ажиллагааны бус орлого</b>	<b>332,673</b>	<b>2,056,203</b>
Гадаад валютын ханшийн гарз	262,689	24,648
Хөрөнгө данснаас хассаны гарз	76,645	-
Торгууль, хураамж болон бусад ижил төстэй зардал	6,821	15,860
Найдваргүй авлагын зардал	1,052	13,814
Үйл ажиллагааны бусад зардал	19,076	14,208
<b>Нийт үйл ажиллагааны бус зардал</b>	<b>366,283</b>	<b>68,530</b>
<b>Нийт үйл ажиллагааны бус орлого (зардал), цэвэр дүнгээр</b>	<b>(33,610)</b>	<b>1,987,673</b>

**27 Санхүүгийн орлого**

Мянган төгрөгөөр	2020	2019
Банкны харилцах данс болон хадгаламжийн дансны хүүгийн орлого	36,043	6,542
Түрээсийн авлагын хүүгийн орлого	123,372	-
<b>Ашиг, алдагдалд бүртгэгдсэн нийт санхүүгийн орлого</b>	<b>159,415</b>	<b>6,542</b>

**28 Санхүүгийн зардал**

Мянган төгрөгөөр	2020	2019
Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал	2,974,883	1,900,768
Зээлийн хүүгийн зардал	2,253,612	1,204,507
Гадаад валютаар илэрхийлэгдсэн зээлийн ханшийн гарз	359,913	85,538
<b>Ашиг, алдагдалд бүртгэгдсэн нийт санхүүгийн зардал</b>	<b>5,588,408</b>	<b>3,190,813</b>

**29 Орлогын албан татварын зардал**

**(а) Орлогын албан татварын зардал / (өгөөж)-ын бүрэлдэхүүн хэсгүүд**

Ашиг, алдагдалд бүртгэгдсэн орлогын татварын зардал дараах бүрэлдэхүүнтэй байна:

Мянган төгрөгөөр	2020	2019
Тайлант жилийн орлогын албан татварын зардал	45,072	654
Орлогын албан татварын өгөөж	(240,809)	-
<b>Тайлант жилийн орлогын албан татварын зардал / (өгөөж)</b>	<b>(195,737)</b>	<b>654</b>

**(б) Татварын зардал ба ашиг алдагдлыг ногдох татварын хувиар үржүүлсэн тооцооллын тохируулга**

Компанийн 2020 оны орлогын дийлэнх хэсэгт хамаарах орлогын албан татварын хувь хэмжээ 10% байна. Хуулиар тогтоосон хувь хэмжээгээр татварын өмнөх ашгаас тооцож гаргасан орлогын татварын зардлыг Компанид хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв.



**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**29 Орлогын албан татварын зардал (Үргэлжлэл)**

Мянаан төгрөгөөр	2020	2019
<b>Орлогын татварын өмнөх алдагдал</b>	<b>(15,923,832)</b>	<b>(11,274,168)</b>
Хуулиар заасан хувиар тооцсон татварын зардал 10%:	(1,592,238)	(1,127,417)
Хуулиар заасан хувиар тооцсон татварын зардал 25%: (3 тэрбум төгрөгнөөс дээш орлоготой)	-	-
Татварын зорилгоор татвар ногдохгүй орлого, татвараас хасагдахгүй зардлын нөлөө:		
- Хасагдахгүй зардал	117,997	807,462
- Хүлээн зөвшөөрөгдөөгүй боломжит хойшлогдсон татварын хөрөнгө	1,233,432	319,955
- Тусгай хувь хэмжээгээрх татварын нөлөө	45,072	654
<b>Тайлант жилийн орлогын албан татварын нийт зардал</b>	<b>(195,737)</b>	<b>654</b>

СТУОС болон Монголын татварын зохицуулалтын зөрүүнээс болж хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн тайлангийн зорилгоорх болон татварын зорилгоорх дансны үнэд түр зөрүү үүсдэг.

**(а) Татварын алдагдлын шилжүүлэг**

Компани ашиглагдаагүй татварын алдагдал шилжүүлэхтэй холбоотой 1,233,714 мянган төгрөгийн (2019: байхгүй) хүлээн зөвшөөрөөгүй боломжит хойшлогдсон татварын хөрөнгөтэй. Татварын алдагдлыг дуусах хугацаагаар нь дор харуулав:

Мянган төгрөгөөр	2020	2019
Татварын алдагдлын шилжүүлэг – дуусах огноогоор:		
- 2024 оны 12 сарын 31	12,334,319	-
<b>12 сарын 31-ээрт татварын алдагдлын шилжүүлэг</b>	<b>12,334,319</b>	<b>-</b>


2020 оны 1 сарын 1-ээс эхлэн Монгол улсын татварын хуулинд оруулсан татварын алдагдал шилжүүлэхтэй холбоотой нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Татварын алдагдлын шилжүүлэг 4 жилийн хөөн хэлэлцэх хугацаатай. Тухайн жилд ашиглах боломжтой татварын алдагдлын шилжүүлэг нь жилийн татвар ногдох орлогын 50 хувиас хэтрэхгүй.

Компани 2020 оны байдлаар хасагдах түр зөрүүтэй холбоотой хүлээн зөвшөөрөөгүй боломжит хойшлогдсон татварын хөрөнгөгүй (2019: байхгүй).

2020 оны 12 сарын 31-ээр дууссан жил түр зөрүүний хөдөлгөөнөөс үүссэн татварын нөлөө:

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31	Орлого үр дүнгийн тайланд орсон	2020 оны 13 сарын 31
Хасагдах/татвар ногдох түр зөрүүний татварын нөлөө			
Ашиглах эрхтэй хөрөнгө, түрээсийн өр төлбөрийн хугацааны зөрүү	-	160,964	160,964
Үндсэн хөрөнгийн татварын болон бүртгэлийн дүнгийн зөрүү (элэгдлийн зөрүү)	-	37,658	37,658
Бусад		42,187	42,187
<b>Цэвэр хойшлогдсон татварын хөрөнгө</b>	<b>-</b>	<b>240,809</b>	<b>240,809</b>





**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**30 Мөнгөн бус хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа**

Мөнгөн гүйлгээний тайлангаас хасагдсан, мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө зарцуулахыг шаардаагүй хөрөнгө оруулалтын гүйлгээг доор харууллаа

Мянган төгрөгөөр	2020	2019
Мөнгөн бус хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа		
Үндсэн хөрөнгийн худалдан авалт*	-	151,288
<b>Мөнгөн бус хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа</b>	<b>-</b>	<b>151,288</b>

\* Тавилга эд хогшлийн худалдан авалт нь бартерийн гүйлгээгээр хийгдсэн.

**31 Нэгж хувьцаанд ногдох ашиг**

Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)-ийг энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдох ашиг (алдагдал)-ийн дүнг тайлант хугацаанд эргэлтэнд байсан хувьцааны жинлэсэн дундаж тоонд харьцуулж тооцдог. Компанийн энгийн хувьцааг хорогдуулах боломжит үнэт цаас байхгүй тул суурь нэгж хувьцаанд ногдох ашиг, хорогдуулсан нэгж хувьцаанд ногдох ашиг хоёр тэнцүү.

Үргэлжилж буй үйл ажиллагааны нэгж хувьцаанд ногдох ашгийн тооцоолол:

Мянган төгрөгөөр	Тодруулга	2020	2019
Энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдох үргэлжилж буй үйл ажиллагааны алдагдал		(15,728,095)	(11,274,822)
<b>Үргэлжилж буй үйл ажиллагааны ашиг, (алдагдал)</b>		<b>(15,728,095)</b>	<b>(11,274,822)</b>
Эргэлтэнд байгаа энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоо (мянган ширхэг)	17	171,452	171,452
<b>Нэгж энгийн хувьцаанд ногдох үргэлжилж буй үйл ажиллагааны суурь болон хорогдуулсан ашиг (алдагдал), (нэгж хувьцаанд ногдох төгрөг)</b>		<b>(91.73)</b>	<b>(80.25)</b>

**32 Болзошгүй өр төлбөр ба үүрэг**


**Шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг.** Бизнесийн үйл ажиллагааны явцад Компанийн эсрэг зарга үүсэх боломжтой. Удирдлагууд өөрсдийн хийсэн тооцоололд үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудад тусгагдсан нөөц сангаас илүү дүнгээр материаллаг хэмжээний алдагдал учрахгүй гэж үзэж байна.

2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Компанийн эсрэг ямар нэгэн шүүхийн нэхэмжлэл ирээгүй тул, удирдлага ирээдүйд мэдэгдэхүйц хэмжээний их алдагдал үүсэхгүй гэж үзэн болзошгүй өр төлбөртэй холбоотойгоор эрсдлийн нөөц байгуулаагүй болно.

**Татварын болзошгүй өглөг.** Тайлант хугацааны эцэст батлагдсан эсвэл хэрэгжиж байсан Монгол Улсын татварын хууль тогтоомжийг Компанийн ажил гүйлгээ, үйл ажиллагаанд хэрэгжүүлэхэд олон янзын нөхцөл байдал тулгардаг. Үүний үр дүнд удирдлагын авч хэрэгжүүлж буй татварын байр суурь болон татварын хууль тогтоомжийн зөрүүгээс татварын хэсэгт сорилт тулгарч байна.







Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр

### 32 Болзошгүй өр төлбөр ба үүрэг (Үргэлжлэл)

Монгол Улсын үнэ шилжилт (ҮШ)-ийн тухай хууль тогтоомжоор хэрвээ ажил гүйлгээ нь сунгасан гарын зарчмын дагуу хийгдээгүй бол хянагдах ажил гүйлгээнд (харилцан хамааралтай талуудын хоорондын гүйлгээ ба холбоогүй талуудын хооронд хийгдэх тодорхой гүйлгээ) нэмэлт татвар ногдуулах болон үнэ шилжилтийн залруулгууд хийх боломжийг татварын байгууллагуудад олгосон. Хяналтанд байгаа ажил гүйлгээнээс үүсэх татварын өр төлбөрийг ажил гүйлгээний бодит үнээс нь хамаарч тогтоодог. Үнэ шилжилтийн дүрмийг хэрэгжүүлэх явцад ийм үнийг хэрэглэх сорилттой тулгарах боломжтой байдаг. Ийм сорилтын үр нөлөөг найдвартай үнэлэх боломжгүй боловч энэ нь Компанийн санхүүгийн байдал болон/эсвэл үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой байж болох юм.

Монгол улсын татварын хууль тогтоомжуудын зарим нэгэн заалтууд нь тодорхой тайлбар зааварчилгаагүй байдаг. Компани нь үе үе татварын ерөнхий хувь хэмжээг бууруулах ийм тодорхойгүй байдалтай тулгардаг. Одоогийн байдлаар удирдлагын зүгээс татварын байр суурь, тайлбарыг тогтвортой байлгах боломжтой гэж тооцож байгаа боловч татварын алба эдгээр татварын байр суурь, тайлбарыг эсэргүүцэх тохиолдолд нэмэлт татвар төлөх эрсдэлтэй болно. Ийм сорилтын үр нөлөөг найдвартай үнэлэх боломжгүй боловч энэ нь Компанийн санхүүгийн байдал болон/эсвэл үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой байж болох юм.

**Үүрэг хариуцлагын биелэлт.** Компани авсан зээлтэй холбоотойгоор зарим үүргийн биелэлтийг хангах ёстой. Үүргийн биелэлтийг хангаагүй тохиолдолд Компаниас зээлдүүлэгч төлбөрөө шууд төлөхийг нэхэмжилснээр төлбөрийн эрсдэл нэмэгдэх эрсдэлтэй. 2020 оны 12 сарын 31 болон 2019 оны 12 сарын 31-ны байдлаар Компани бүх үүргийн биелэлтийг хангаж байна

### 33 Санхүүгийн эрсдлийн удирдлага

Компани доторх эрсдэлийн удирдлагын чиг үүргийг санхүүгийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, хууль эрх зүйн эрсдэлээс хамааран гүйцэтгэдэг. Санхүүгийн эрсдэл нь зах зээлийн эрсдэл (валютын эрсдэл, хүүгийн түвшний эрсдэл болон бусад үнийн эрсдэл гэх мэт), зээлийн эрсдэл ба төлбөрийн чадварын эрсдэлээс бүрдэнэ. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго бол эрсдэлийн хязгаарлалтыг тогтоож, эрсдэлийн хэмжээг тогтоосон хязгаарлалтандаа барих явдал юм. Үйл ажиллагааны болон эрх зүйн эрсдэлийн удирдлага нь үйл ажиллагааны болон эрх зүйн эрсдэлийг багасгахын тулд дотоод бодлого, журмын зохистой хэрэгжилтийг хангаж ажиллах зорилготой.

**Зээлийн эрсдэл.** Компани зээлийн эрсдэлд өртдөг бөгөөд энэ нь санхүүгийн хэрэглүүрт нэг тал хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс нөгөө тал санхүүгийн алдагдал үүрэх эрсдэл юм.

Зээлийн эрсдэлд өртөх нь Компанийн зээлдүүлэгч талуудтай байгуулсан бусад зээлийн гүйлгээний үр дүнд бий болж, санхүүгийн хөрөнгө болон зээлтэй холбоотой үүрэг бүхий балансын гадурх дүнг үүсдэг.

Компанийн зээлийн эрсдэлд хамгийн ихээр өртөж болох дүнгүүдийг санхүүгийн хөрөнгийн дансны нийт дүнд тусган харуулсан:

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
<b>Дансны болон бусад авлага (Тодруулга 14)</b>		
- Дансны авлага	616,647	431,019
- Бусад санхүүгийн авлага	451,304	424,766
<b>Санхүүгийн түрээсийн авлага (Тодруулга 16)</b>		
- Санхүүгийн түрээсийн авлага	2,234,808	-
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө (Тодруулга 15)</b>		
- Банкны харилцах дансанд буй мөнгө	5,977,829	449,686
<b>Нийт зээлийн эрсдэлд хамгийн их өртөх дүн</b>	<b>9,280,588</b>	<b>1,305,471</b>

**Зээлийн эрсдэлийн удирдлага.** Зээлийн эрсдэл нь Компанийн бизнесийн үйл ажиллагааны хамгийн том эрсдэл юм; тиймээс удирдлага нь зээлийн эрсдэлийг сайтар хянадаг.





Үнэт цаасны танилцуулга

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр

### 33 Санхүүгийн эрсдлийн удирдлага (Үргэлжлэл)

Зээлийн эрсдэлийн үнэлгээний систем Зээлийн эрсдэлийг үнийн дүнгээр нь санхүүгийн хэрэглүүрийг үнэлэх болон зээлийн эрсдэлийг хэмжихийн тулд Компани нь хөндлөнгийн олон улсын үнэлгээний байгууллагуудын (Стандарт энд Пүүрс "S&P", Фитч, Мүүди'с) гаргасан эрсдэлийн үнэлгээг үндэслэсэн аргачлалыг ашигладаг. Гадны болон дотоод эрсдэлийн үнэлгээг дотооддоо тодорхойлогдсон үнэлгээний үндсэн хэмжүүрийг төлбөр төлөгдөхгүй болох магадлалын тодорхой хязгаартай уялдуулан харуулсныг дараах хүснэгтэнд тусгасан:

Зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр	Хөндлөнгийн олон улсын үнэлгээний байгууллагын үнэлсэн харгалзах зэрэг (Стандарт энд Пүүрс)	Төлбөрийн чадваргүй болох магадлалын харгалзах интервал
Маш сайн	AAA -зэс BB+	0,01% – 0,5%
Сайн	BB -зэс B+	0,51% – 3%
Хангалттай	B, B-	3% – 10%
Анхаарал татсан	CCC+ зэс CC-	10% – 99,9%
Үнэ цэнийн бууралттай	C, D-I, D-II	100%

Зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр бүрээр зээлжих чадварын зэргийг тодорхойлсон:

- Маш сайн - хүлээгдэж буй зээлийн эрсдэл багатай, чанартай зээл;
- Сайн - дунд зэргийн зээлийн эрсдэлтэй, зээлийн чанар хангалттай;
- Хангалттай – хангалттай зээлийн эрсдэлтэй, зээлийн чанар дунд зэрэг;
- Анхаарал татсан – удирдлага илүү ойр ойрхон хяналт тавьж, арга хэмжээ авах шаардлагатай;
- Үнэ цэнийн бууралттай – төлбөрийн чадваргүй болсон хэрэгслүүд.


Хөндлөнгийн зэрэглэлийн үнэлгээг Стандарт энд Пүүрс, Мүүди'с, Фитч зэрэг хөндлөнгийн хараат бус олон улсын үнэлгээний байгууллагууд гаргадаг. Эдгээр үнэлгээ нь олон нийтэд нээлттэй байдаг.

**Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын хэмжилт**. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь ирээдүйн бэлэн мөнгөний алдагдлын өнөөгийн үнэ цэнийг магадлалын үндсэн дээр жинлэсэн тооцоолол (өгөгдсөн хугацаанд төлбөр төлөгдөхгүй болох эрсдэлээр жинлэсэн эрсдэлийн алдагдлын жинлэсэн дундаж) юм.

ХБЭА хэмжилт нь олон янзын боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлогддог. ХБЭА-ын хэмжилтийг Компанийн хэрэглэдэг дөрвөн бүрэлдэхүүн хэсгүүдэд үндэслэн тогтооно: Үүнд төлбөр төлөгдөхгүй болох магадлал (PD), төлбөр төлөгдөхгүй болсон үеийн дүн (EAD), төлбөр төлөгдөхгүй болсон тохиолдолд хүлээх алдагдлын хэмжээ (LGD) (төлбөр төлөгдөхгүй болсон үеийн алдагдлын хэмжээ) болон дискаунтын хувь (DR) орно.

Төлбөр төлөгдөхгүй болсон үеийн дүн гэдэг нь тайлант хугацааны дараах зээлийн хүлээгдэж буй өөрчлөлтийг авч үзэн зээлдэгч ирээдүйд төлбөр төлөгдөхгүй болох үед хэдий хэмжээний өр (үндсэн зээл болон хүүгийн эргэн төлөлтийг оруулан)-тэй байх таамаглал юм. Төлбөр төлөгдөхгүй болох магадлал гэдэг нь зээлдэгч өгөгдсөн хугацаанд төлбөр төлөгдөхгүй болох магадлалыг тооцоолдог. Төлбөр төлөгдөхгүй болсон үеийн алдагдлын хэмжээ гэдэг нь төлбөр төлөгдөхгүйгээс болж үүссэн алдагдлын тооцоолол юм. Үүнийг төлөх ёстой гэрээний мөнгөн урсгал болон зээлдүүлэгчийн барьцаа хөрөнгөөс гарах мөнгийг оролцуулан хүлээж буй мөнгөн дүн хоёрын зөрүүнд үндэслэнэ. Ихэвчлэн төлбөр төлөгдөхгүй болсон үеийн дүнгийн хувиар илэрхийлдэг. Хүлээгдэж буй алдагдал нь тайлант хугацааны эцэст дискаунтчилагдан өнөөгийн үнэ цэнээр бүртгэгддэг. Дискаунтын хувь нь санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн түвшингээр, ойролцоогоор тодорхойлогдоно.




**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**
**33 Санхүүгийн эрсдлийн удирдлага (Үргэлжлэл)**

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь хэрэглүүрийн хугацааны туршид загварчлагдсан. Хугацааны турш гэдэг нь гэрээний үлдсэн хугацаа буюу өрийн хэрэглүүрийн дуусгавар болох өдөр хүртэл үргэлжилнэ (хүлээгдэж буй урьдчилж төлсөн төлбөр залруулагдсан бол).

Удирдлага нь хугацааны турш хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг загварчилдаг ба энэ нь санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын үлдэх хугацааны туршид үүсч болзошгүй бүх тохиолдлоос үүсэх алдагдал юм. 12 сарын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь тайлагналын өдрөөс хойш 12 сарын дотор эсвэл санхүүгийн хэрэглүүрийн үлдэх хугацаа нь нэг жилээс бага байгаа бол санхүүгийн хэрэглүүрт тохиолдох болзошгүй үйл явдлаас үүсэх ба ашиглалтын хугацааны хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын нэг хэсгийг илэрхийлнэ.

Санхүүгийн тайлангаар менежмент хүлээгдэж буй эрсдлийн алдагдлыг тооцохдоо хугацааны нэг цэг дээр үнэлдэг. Эдгээр тооцоолол нь ирээдүйн таамаглал дээр үндэслэдэг буюу эрсдэлд нөлөөлөх боломжит макро эдийн засгийн хувьсагчдын жинлэсэн дундаж өөрчлөлтөд суурилдаг.

Компани дефолт болох магадлалыг тооцоолохдоо доор дурдсан нөхцөлүүдийн аль нэгийг эсвэл хэд хэдэн нөхцөлийг зэрэг хангасан зээлийг дефолт болсон гэж үздэг. Үүнд:

- зээлдэгч гэрээний дагуу төлөх ёстой төлбөрөө төлөхгүй 90-ээс дээш хоног хэтэрсэн;
- олон улсын үнэлгээний байгуулагуудаас зээлдэгчийг үнэ цэнийн бууралттай гэж ангилсан;
- зээлдэгч доор дурдсан төлбөрийн тааламжгүй байдлын шалгуурыг хангасан бол:
  - зээлдэгч нь нас барсан;
  - зээлдэгч төлбөрийн чадваргүй болсон;
  - зээлдэгч нь санхүүгийн үүргээ зөрчсөн;
  - зээлдэгч дампуурах магадлал өндөр болж тохиолдолд.


Тодруулгын зорилгоор Компани нь төлбөр төлөгдөхгүй байх тодорхойлолтыг үнэ цэнэ буурсан хөрөнгийн тодорхойлолттой бүрэн нийцүүлсэн. Дээр дурдсан төлбөр төлөгдөхгүй байх тодорхойлолт нь Компанийн бүх төрлийн санхүүгийн хөрөнгийн хувьд ашиглагдана.

Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (SICR) байгаа эсэх үнэлгээг тухайн санхүүгийн хэрэглүүр тус бүрийн хувьд хийнэ. 30 хоногоос дээш хугацаа хэтэрсэн санхүүгийн хөрөнгийн хувьд анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт байсан гэсэн таамаглалыг няцаагаагүй болно.

**Зах зээлийн эрсдэл.** Компани нь зах зээлийн эрсдэлийн нөлөөлөлд үйл ажиллагаагаа явуулдаг. Зах зээлийн эрсдэл нь (а) валютын ханш, (б) хүүний түвшин гэх мэт зах зээлийн ерөнхий болон тусгай хувьсагчуудын хэлбэлзлийн улмаас үүсдэг. Компани хүлээн зөвшөөрөгдөж болох эрсдэлийн үнэнд хязгаарыг тогтоох замаар өдөр тутам хяналт тавьдаг. Гэхдээ тухайн хязгаараас давсан, томоохон зах зээлийн өөрчлөлт үүсвэл энэхүү арга нь алдагдал хүлээх эрсдэлээс хамгаалж чадахгүй.

**Гадаад валютын ханшийн эрсдэл.** Гадаад валютын ханшийн эрсдэлийн тухайд удирдлага нь өдөр бүр хянаж байдаг өдрийн болон шөнийн байдлаарх нийт дүнд болон валют өртөлтийн хэмжээнд хязгаарлалтыг тогтоодог.





**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**33 Санхүүгийн эрсдлийн удирдлага (Үргэлжлэл)**

Дараах хүснэгтэнд тайлант хугацааны эцэс дэх Компанийн гадаад валютын ханшийн эрсдэлд өртөх дүнг хураангуйлан харуулав :

Мянган төгрөгөөр	2020				2019		
	Ам доллар	Солонгос вон	Евро	Нийт	Ам доллар	Солонгос вон	Нийт
<b>Санхүүгийн хөрөнгө</b>							
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,228,687	201	-	5,228,888	1,831	35	1,866
<b>Нийт санхүүгийн хөрөнгө</b>	<b>5,228,687</b>	<b>201</b>	<b>-</b>	<b>5,228,888</b>	<b>1,831</b>	<b>35</b>	<b>1,866</b>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>							
Дансны ба бусад өглөг	4,699	536,706	6,575	547,980	9,666	252,659	262,325
Зээл	-	10,520,000	-	10,520,000	3,178,809	-	3,178,809
<b>Нийт санхүүгийн өр төлбөр</b>	<b>4,699</b>	<b>11,056,706</b>	<b>6,575</b>	<b>11,067,980</b>	<b>3,188,475</b>	<b>252,659</b>	<b>3,441,134</b>
<b>Цэвэр өр төлбөр</b>	<b>5,223,988</b>	<b>11,056,505</b>	<b>6,575</b>	<b>5,839,092</b>	<b>3,186,644</b>	<b>252,624</b>	<b>3,439,268</b>

Дээр дурдсан шинжилгээнд зөвхөн мөнгөөрх хөрөнгө, өр төлбөрүүд орно. Мөнгөн бус хөрөнгө нь аливаа валютын материаллаг эрсдэлийг үүсгэдэггүй гэж үздэг.

Дараах хүснэгтэнд Компанийн бүртгэлийн валюттай холбоотой тайлант хугацааны эцэст ашигласан ханш боломжит үндэслэлээр өөрчлөгдөхөд (бусад бүх хувьсагч тогтмол байхад) ашиг, алдагдал болон өөрийн хөрөнгөнд нөлөөлөх мэдрэмжит байдлыг харуулав:

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31-нд		2019 оны 12 сарын 31-нд	
	Ашиг алдагдалд үзүүлэх нөлөө	Эздийн өмчид үзүүлэх нөлөө	Ашиг алдагдалд үзүүлэх нөлөө	Эздийн өмчид үзүүлэх нөлөө
Ам доллар 20%-аар чангарсан үед (2019: 20%)	1,044,798	1,044,798	(637,329)	(637,329)
Ам доллар 20%-аар суларсан үед (2019: 20%)	(1,044,798)	(1,044,798)	637,329	637,329
Солонгос вон 20%-аар чангарсан үед (2019: 20%)	(2,211,301)	(2,211,301)	(50,525)	(50,525)
Солонгос вон 20%-аар суларсан үед (2019: 20%)	2,211,301	2,211,301	50,525	50,525

**Төлбөрийн эрсдэл.** Төлбөрийн эрсдэл гэдэг нь компани санхүүгийн өр төлбөртэй холбоотой үүргээ биелүүлэхэд учрах хүндрэлтэй холбоотой эрсдэл юм. Компанийн бэлэн мөнгөний нөөцөөсөө өдөр тутам төлбөр тооцоо хийх хэрэгтэй болдог.

Компани нь бэлэн мөнгөний үлдэгдэл, бэлэн зээлийн хязгаарыг хадгалах, бэлэн мөнгөний орлого, зардлын урьдчилсан тооцоо болон бодит дүнг тогтмол хянах, санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн төлөгдөх хугацааны шинжилгээг хийх замаар хөрвөх чадвараа удирддаг.

Дараах хүснэгтэнд Компанийн 2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх өр төлбөрийн дүнг гэрээнд заасан төлөх хугацааны үлдсэн хугацаагаар харуулав. Төлбөрийн дуусгавар болох хугацааг харуулсан хүснэгтэд тусгагдсан дүн нь гэрээний дагуу дискаунт тооцоогүй мөнгөн гүйлгээ бөгөөд ийм дискаунт тооцоогүй мөнгөн гүйлгээ нь санхүүгийн байдлын тайланд тусгагдсан дүнгээс ялгаатай тул санхүүгийн байдлын тайлангийн дүн нь дискаунтлагдсан мөнгөн гүйлгээнд суурилдаг.

Төлбөрийн хэмжээ хувьсах шинжтэй тохиолдолд тайлант хугацааны эцэс дэх оршин байгаа нөхцөл байдлыг харгалзан тодруулсан дүнг тодорхойлно. Гадаад валютын төлбөрийг тайлант хугацааны эцсийн спот ханшийг ашиглан хөрвүүлдэг.





**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**33 Санхүүгийн эрсдлийн удирдлага (Үргэлжлэл)**

2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн өр төлбөрийн төлөгдөх хугацааны шинжилгээ дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	Хугацаандаа байгаа ба 1 сараас бага	1-6 сар хүртэл	6-12 сар хүртэл	1 жил- 5 жил хүртэл	Нийт дүн
Дансны ба бусад өглөг (Тодруулга 19)	23,055,895	840,308	-	-	23,896,203
Зээл – Гуравдагч этгээд (Тодруулга 20)	-	416,667	15,353,655	-	15,770,322
Зээл – Хамааралтай тал (Тодруулга 20)	-	575,040	-	11,572,000	12,147,040
Түрээсийн өр (Тодруулга 10)	206,118	923,622	821,664	21,171,784	23,123,188
<b>Нийт ирээдүйд төлөх төлбөр /ирээдүйн үндсэн болон хүүгийн төлбөрийн хамт/</b>	<b>23,262,013</b>	<b>2,755,637</b>	<b>16,175,319</b>	<b>32,743,784</b>	<b>74,936,753</b>

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн өр төлбөрийн төлөгдөх хугацааны шинжилгээ дараах байдалтай байна :

Мянган төгрөгөөр	Хугацаандаа байгаа ба 1 сараас бага	1-6 сар хүртэл	6-12 сар хүртэл	1 жил- 5 жил хүртэл	Нийт дүн
Дансны ба бусад өглөг (Тодруулга 19)	6,857,968	-	-	-	6,857,968
Зээл – Гуравдагч этгээд (Тодруулга 20)	194,944	4,239,638	1,012,333	18,635,217	24,082,132
Зээл – Хамааралтай тал (Тодруулга 20)	-	-	-	581,000	581,000
Түрээсийн өр (Тодруулга 10)	-	2,704	1,009,102	19,217,586	20,229,392
<b>Нийт ирээдүйд төлөх төлбөр /ирээдүйн үндсэн болон хүүгийн төлбөрийн хамт/</b>	<b>7,052,912</b>	<b>4,242,342</b>	<b>2,021,435</b>	<b>38,433,803</b>	<b>51,750,492</b>

**34 Капиталын удирдлага**

Компанийн капиталын удирдлагын үндсэн зорилго нь хувьцаа эзэмшигчдийг өгөөжтэй, бусад нөлөө бүхий талуудыг үр ашигтай байлгах болон капиталын бүтцийг илүү тохиромжтой, зардал багатай байдлаар зохион байгуулахын тулд Компанийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахад оршино. Капиталын бүтцийг хэвийн хадгалах эсвэл өөрчлөхийн тулд Компани нь хувь нийлүүлэгчдэд төлөх ногдол ашгийн хэмжээг тохируулан тогтоох, хувь нийлүүлэгчдийн хөрөнгийг буцаах, шинэ хувьцаа гаргах эсвэл зээлийг бууруулах зорилгоор хөрөнгөө худалдах боломжтой. 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн удирдаж буй капиталын нийт хэмжээ нь 16,380,038 мянган төгрөг (2019 онд 651,943 мянган төгрөг) байсан. 2020 оны 12-р сарын 31 болон 2019 оны 12-р сарын 31-ны байдлаар компанийн эздийн өмч сөрөг дүнтэй байсан.

**35 Бодит үнэ цэнийн тодруулга**

Бодит үнэ цэнийг бодит үнэ цэнийн ангилал тус бүрд тодорхойлох ба эдгээр нь (i) Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан 1-р түвшинд тодорхойлно (ii) Хөрөнгө болон өр төлбөрийн хувьд боломжит өгөгдлийг ашиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) бодит үнэ цэнийг тодорхойлох аргачлалыг 2-р түвшинд хэрэжүүлнэ (iii) 3-р түвшинд зах зээлийн ашиглаж болох өгөгдөлд тулгуурлахгүйгээр (ашиглагдахгүй өгөгдөл) бодит үнэ цэнийг тодорхойлно. Хэрэв бодит үнэ цэнийг тодорхойлоход ихээхэн тохируулга хийгдэх өгөгдлийг ашиглаж байгаа бол тухайн хэмжилт нь 3-р түвшинд хийгдэж байна гэсэн үг. Ашиглаж буй үнэлгээний өгөгдлийн ач холбогдлыг бодит үнэ цэнийн хэмжигдэхүүнтэй бүхлээр нь харьцуулан тооцдог.



**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**35 Бодит үнэ цэнийн тодруулга (Үргэлжлэл)**

Компанийн үндсэн санхүүгийн хэрэглүүрүүд нь касс дахь бэлэн мөнгө болон банкин дахь мөнгө, дансны авлага болон бусад авлага, бусад эргэлтийн хөрөнгө, зээл болон өглөгөөс бүрдэнэ. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ нь бодит үнэ цэнээс материаллаг хэмжээний зөрүүгүй байна гэж удирдлага үзэж байна. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг нэг дүгээр түвшний хөрөнгөд тооцно. Компанийн ихэнх санхүүгийн хөрөнгө, өр төлбөр богино хугацаатай байдаг. Үнэлгээнд үндэслэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг хэмжээний зөрүүгүй бөгөөд 2019 болон 2020 оны хувьд бодит үнэ цэнийн шатлалын 2-р түвшинд бүгд багтсан гэж үзэж байна.

Компанид бодит үнэ цэнээр бүртгэгддэг санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр байхгүй бөгөөд компанийн бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүд хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн. Компани эдгээр санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг дараах байдлаар тодорхойлдог:

Бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүд. Хөрвөх чадвар сайтай, 1 жилээс бага богино хугацаатай санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо байна.

**36 Тайлагналын дараах үйл явдал**

Монгол Улсын Засгийн газар 2021 оны 2-р сарын 11-ээс 2021 оны 2-р сарын 23-ны хооронд, 2021 оны 4-р сарын 10-наас 2021 оны 5-р сарын 10-ны хооронд хатуу хөл хорио тогтоосон. Зохицуулалтын өөрчлөлтийг үндэслэн дэлгүүрүүдийн ажлын цагийг ихэвчлэн 07:00 - 22:00 цаг хүртэл хязгаарлав.

Компани хөл хориог 4-р сарын эцсээр дуусна гэж таамаглаж байсан ба 2021 оны эхний хагас жилийн борлуулалт төсөвтэй харьцуулахад 89.4%-н биелэлттэй байна. Нэг дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалт төсөвтэй харьцуулахад 89.7%-н биелэлттэй байна.

2021 оны 6-р сарын 8-ны өдрийн Хувьцаа эзэмшигчидийн тогтоол #4-ийн дагуу компани санхүүгийн өр төлбөрөө дахин бүтэцчилсэн. Үүний дагуу, 2021 оны 6-р сарын 8-ны өдөр Компани Премиум Групп ХХК болон Голомт Банктай зээлийг дахин бүтэцчилэх гэрээнд гарын үсэг зурснаар Компани Голомт банкнаас авсан 15,591,333 мянган төгрөг (2020 оны 12 сарын 31-ны байдлаар 16,293,786 сая төгрөг)-ийн богино хугацаат зээлийг Премиум Групп ХХК-д шилжүүлсэн.

Мөн, 2021 оны 6-р сарын 8-ны өдрийн Хувьцаа эзэмшигчидийн тогтоол #4-ийн дагуу Компанийн Премиум Групп ХХК-д төлөх 19,795,025 мянган төгрөгийн (2020 оны 12 сарын 31-ны байдлаар 15,509,270 мянган төгрөг) бусад өр төлбөр, холбоотой тал болох БиЖиЭф Ритэйл ХХК-аас авсан 5,083,551 мянган төгрөгийн урт хугацаат зээл, хамааралтай талуудаас авсан 641,207 мянган төгрөгийн зээл эздийн өмч рүү хөрвүүлсэн.

Түүнчлэн, 2021 оны 6-р сарын 8-ны хувьцаа эзэмшигчидийн тогтоолын дагуу Компанийн эзэмшлийн бүтэц өөрчлөгдсөн. Премиум Групп ХХК-ын эзэмшилд байсан нийт эргэлтэд байсан хувьцааны 90.9 хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг 8 хувьцаа эзэмшигчийн нэр дээр шилжүүлсэн. 7 хувьцаа эзэмшигч иргэн нэмэлтээр 2,000,000 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг Компанид хийсэн.

Уг хувьцаа эзэмшигчидийн тогтоолын дагуу компани нь Премиум Дистрибушн ХХК -ийг 7,724,396 мянган төгрөгөөр Премиум Групп ХХК -иас худалдаж авсан.


Компанийн удирдлага олон нийтэд хувьцаагаа гаргах хүсэлтээ Монгол улсын санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргах замаар өмчийн санхүүжилт татан, цаашдын өргөжилтөө санхүүжүүлэхээр ажиллаж байна. Компани эргэлтэнд байгаа хувьцааныхаа 10 хувийг гаргаж, 15,711,111 мянган төгрөгийн санхүүжилт босгохоор төлөвлөж байна.

Тайлангийн хугацааны төгсгөлөөс хойш санхүүгийн тайланг гаргахаар батлагдсан өдрийн хооронд санхүүгийн тайлангуудад нөлөө үзүүлэхүйц үйл явдал менежментийн мэдэж байгаагаар дээр дурьдсанаас өөр байхгүй.





Үнэт цаасны танилцуулга





**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31-ний өдөр**

**37 Орчуулга**

Эдгээр санхүүгийн тайланг Монгол, Англи хоёр хэлээр бэлтгэсэн бөгөөд Монгол хэлээрх, Англи хэлээрх хоёр хувилбарын хооронд утгын зөрүү гарсан тохиолдолд Англи хэлээрх хувилбарыг баримтална.





**БҮРТГЭВ-02**

2021 оны 06-р сарын 30-ны өдрөөр  
тасалбар болсон зургаан сарын

# НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

/НББОУС 34 болон бусад холбогдох СТОУС-ын дагуу  
илэрхийлэгдсэн/

**“СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС” ХХК**  
ба түүний охин компани





**2021 оны 06-р сарын 30-ны өдрөөр тасалбар болсон зургаан сарын нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл**

Энэхүү тайлангийн 2-3 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын завсар үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нягтлах гэрээт ажлын тайланд дурдсан нягтлах гэрээт ажлын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь "Сентрал Экспресс Си Ви Эс" Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн (цаашид "Компани" гэх) ба түүний охин компанийн (цаашид хамтад нь "Групп" гэх) 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болсон зургаан сарын нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

Группийн удирдлага нь эдгээр завсар үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 34, Завсар үеийн санхүүгийн тайлагнал ("НББОУС 34") болон бусад холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС") -ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр завсар үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, завсар үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаа Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт ("НББОУС 34") болон бусад холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС"), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Группийн 2021 оны 06-р сарын 30-ны өдрөөр тасалбар болсон зургаан сарын нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.



ХХК Г.ЧИНЗОРИГ  
Гүйцэтгэх захирал

Ш.ДОНЧИМЭГ  
Ерөнхий нягтлан бодогч

Огноо: 2021/08/10

Улаанбаатар хот, Монгол улс





Tel: +976 77404040  
 Fax: +976 77404041  
 www.bdo.mn  
 Zip code: 14230-0059

Room 1502, Level 15  
 Union Building - B, Unesco Street  
 Naraii Zam - 62, Khoroо - 1  
 Sukhbaatar District, Ulaanbaatar  
 Mongolia

Утас: +976 77404040  
 Факс: +976 77404041  
 www.bdo.mn  
 ЦХК: 14230-0059

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
 1-р хороо, Нарны зам - 62, ЮНЕСКО-гийн  
 гудамж, ЮНИОН БИЛДИНГ Б блок  
 15-р давхар, 1502 тоот

## Завсар Үеийн Нэгтгэсэн Санхүүгийн Тайланг Нягтлах Гэрээт Ажлын Тайлан

"Сентрал Экспресс Си Ви Эс" ХХК -ийн Хувьцаа эзэмшигчдэд

### Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар

"Сентрал Экспресс Си Ви Эс" ХХК ("Компани" гэх) ба түүний охин компанийг багтаасан групп ("Групп" гэх)-ийн 2021 оны 06-р сарын 30-ны өдрөөр тасалбар болсон зургаан сарын хугацааны дараах тайлангуудаас бүрдсэн завсар үеийн нэгтгэсэн санхүүгийн тайланг нягтлан шалталаа:

- 2021 оны 06-р сарын 30-ны өдрөөрх завсар үеийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон зургаан сарын хугацааны нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад далгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

### Нэгтгэсэн санхүүгийн тайланд Удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Энэхүү завсар үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 34, Завсар Үеийн Санхүүгийн Тайлагнал ("НББОУС 34") болон бусад холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС" гэх)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах болон алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

### Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага


Энэхүү завсар үеийн санхүүгийн мэдээллийг нягталсны үндсэн дээр өөрсдийн санал дүгнэлтээ илэрхийлэх нь бидний үүрэг хариуцлага болно.

### Нягтлах ажлын цар хүрээ


Бид нягтлах гэрээт ажлаа Нягтлах Гэрээт Ажлын Олон Улсын Стандарт 2410 "Завсар үеийн санхүүгийн мэдээлэлд байгууллагын хараат бус аудиторын гүйцэтгэсэн нягтлах гэрээт ажил"-ын дагуу гүйцэтгэсэн. Завсар үеийн нэгтгэсэн санхүүгийн тайланг нягтлах гэрээт ажил нь санхүү болон нягтлан бодох бүртгэлийн талаар шууд хариуцлага хүлээсэн хүмүүсээс асуулга авах, мөн шинжилгээний болон бусад нягтлах гэрээт ажлын горимуудыг гүйцэтгэх зэргээс бүрдэнэ. Нягтлах гэрээт ажлын цар хүрээ нь Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийгддэг аудитын цар хүрээгээс харьцангуй бага тул аудитын үр дүнд илэрч болох байсан нөлөө бүхий асуудлуудыг бүрэн олж илрүүлсэн гэсэн баталгаажуулалт олж авах боломжоор хангадаггүй. Тиймээс бид аудитын дүгнэлт илэрхийлээгүй болно.

BDO AUDIT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the International BDO network of independent member firms.  
 Монгол Улсын хэдгээрэгдсэн хариуцлагатай компани болох БДО АУДИТ ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернационал Лимитетдийн гэрүүр, олон улсын БДО сүлжээний бие дэвсэн гишүүн байгууллагуудын нэг юм.





Үнэт цаасны танилцуулга



20-8871473



### Завсар Үеийн Нэгтгэсэн Санхүүгийн Тайланг Нягтлах Гэрээт Ажлын Тайлан (үргэлжлэл)

#### Нягтлах гэрээт ажлын санал дүгнэлт

Бидний нягтлах гэрээт ажлын үр дүнгээр завсар үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь компанийн 2021 оны 06-р сарын 30-ны өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн өдрөөр тасалбар болсон зургаан сарын хугацааны нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд НББОУС 34, *Завсар Үеийн Санхүүгийн Тайлагнал* болон бусад холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлээгүй гэж үзэх үндэслэл болох аливаа зүйл ажиглагдаагүй болно.

#### Өөдрөг төсөөлөлтэй холбоотой материаллаг тодорхой бус байдал

Энэхүү санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 5, Тасралтгүй байх -д дурдсан нөхцөл байдал, үйл явдал нь групп цаашид үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэхтэй холбоотой материаллаг тодорхой бус байдал үүсгэж болзошгүйг илэрхийлж байна. Группийн тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлаар бид дүгнэлтээ өөрчлөөгүй болно.



Д.АЛТАНСҮХ  
"БДО Аудит" ХХК-аар хийгдсэн  
Монгол улс; Улаанбаатар хот-  
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
Юнескогийн гудамж, Нарны зам-62  
Юнион Бюлдинг В блок, 1502 тоот өрөө

Огноо: 2021.09.14

BDO AUDIT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the international BDO network of independent member firms.  
Монгол Улсын хэвээр байгаа эхлүүлэгчтэй компанийн болох БДО АУДИТ ХХК нь Их Британийн Нэгдсэн Ван Улсын БДО Интернационал Лимитедийн гишүүн, олон улсын БДО сүлжээний бие даасан гишүүн байгууллагуудын нэг юм.





**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**


**Хагас жилийн нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан**

Мянган төгрөгөөр	Тодруулга	2021 оны 6 сарын 30	2020 оны 6 сарын 30
Орлого	23	32,457,247	17,649,560
Борлуултын өртөг	24	(36,255,199)	(20,573,330)
<b>Нийт алдагдал</b>		<b>(3,797,952)</b>	<b>(2,923,770)</b>
Ерөнхий ба удирдлагын зардал	25	(2,702,819)	(2,354,562)
Бусад ола/(гарз), цэвэр	26	343,108	(266,699)
Үйл ажиллагааны алдагдал		(6,157,663)	(5,545,031)
Санхүүгийн орлого	27	191,862	1,232
Санхүүгийн зардал	28	(2,481,001)	(2,574,533)
Татварын өмнөх алдагдал		(8,446,802)	(8,118,332)
Орлогын албан татварын зардал	29	1,254,345	(23,790)
<b>ТАЙЛАНТ ЖИЛИЙН АЛДАГДАЛ</b>		<b>(7,192,457)</b>	<b>(8,142,122)</b>
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого			
<b>ТАЙЛАНТ ЖИЛИЙН НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ АЛДАГДАЛ</b>		<b>(7,192,457)</b>	<b>(8,142,122)</b>
Нэгж энгийн хувьцаанд ногдох үргэлжилж буй үйл ажиллагааны суурь болон хорогдуулсан ашиг (алдагдал), (нэгж хувьцаанд ногдох төгрөг)	30	(30.79)	(47.49)









**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**

**Хагас жилийн нэгтгэсэн Мөнгөн гүйлгээний тайлан  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан**

	Тодруулга	2021 оны 6 сарын 30	2020 оны 6 сарын 30
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Татварын өмнөх алдагдал</b>		<b>(8,446,802)</b>	<b>(8,118,332)</b>
<b>Тохируулга:</b>			
Үндсэн хөрөнгийн элэгдэл	9	2,214,454	1,424,324
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	10	1,496,086	1,061,100
Биет бус хөрөнгийн хорогдол	11	216,622	193,275
Найдваргүй авлагын зардал		90,508	
Бараа материалын хэвийн бус хорогдол		-	349,499
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	10	(291,501)	(18,221)
Гадаад валютын ханшийн зөрүү		-	7,954
Санхүүгийн орлого	27	(191,862)	(1,232)
Санхүүгийн зардал	28	2,481,001	2,566,581
<b>Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		<b>(2,431,494)</b>	<b>(2,535,053)</b>
<b>Ажлын капиталын өөрчлөлт</b>			
Дансны ба бусад авлагын (өсөлт)/бууралт		762,415	(988,669)
Бусад татварын авлагын (өсөлт)/бууралт		(624,943)	-
Бараа материалын (өсөлт)/бууралт		(357,660)	216,917
Бусад хөрөнгийн (өсөлт)/бууралт		(431,279)	-
Урьдчилгааны (өсөлт)/бууралт		(1,760,747)	163,544
Дансны ба бусад өглөгийн өсөлт		378,663	7,455,532
Татварын өглөгийн өсөлт		371,239	8,078
Гэрээний өр төлбөрийн өсөлт		333,945	404,379
<b>Ажлын капиталын өөрчлөлтийн дараах үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		<b>(3,759,861)</b>	<b>4,724,729</b>
<b>Төлсөн орлогын албан татвар</b>			
Хүлээн авсан хүүгийн орлого		(30,935)	(23,789)
Төлсөн хүү		191,862	1,232
		<b>(2,868,275)</b>	<b>(2,509,386)</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(6,465,209)</b>	<b>2,192,786</b>



**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**

**Хагас жилийн нэгтгэсэн Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан**

	Тодруулга	2021 оны 6 сарын 30	2020 оны 6 сарын 30
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
Худалдаж авсан үндсэн хөрөнгө	9	(3,087,541)	(3,464,685)
Худалдаж авсан биет бус хөрөнгө	11	(201,423)	(89,559)
Үндсэн хөрөнгө борлуулалтаас хүлээн авсан мөнгө	9	2,589,934	1,246,019
Биет бус хөрөнгө борлуулалтаас хүлээн авсан мөнгө	11	-	3,252
Бизнесийн нэгдлээс бий болсон мөнгө		242,777	-
Бусад хөрөнгийн борлуулалтаас хүлээн авсан мөнгө		2,919,265	-
Санхүүгийн түрээсийн авлагын төлөлтөөс хүлээн авсан мөнгө	16	103,377	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>2,566,389</b>	<b>(2,304,973)</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
Гаргасан хувьцаа	18	2,000,000	-
Авсан зээл	21	1,051,220	3,587,500
Зээлийн эргэн төлөлт	21	(570,000)	(3,236,004)
Санхүүгийн түрээсийн төлөлт	10	(734,513)	(254,651)
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>1,746,707</b>	<b>96,845</b>
<b>Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө</b>		<b>9,924</b>	<b>128</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт</b>		<b>(2,142,189)</b>	<b>(15,214)</b>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15	6,104,077	651,484
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15	3,961,888	636,270



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК

Хагас жилийн нээгээсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	Хувьцаат капитал	Хуримтлагдсан алдагдал	Нийт эздийн өмч
2020 оны 1 сарын 1-ний үлдэгдэл		17,145,256	(17,797,199)	(651,943)
Тайлант үеийн алдагдал		-	(15,728,095)	(15,728,095)
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		17,145,256	(33,525,294)	(16,380,038)
Тайлант үеийн алдагдал Гаргасан хувьцаа	18	50,835,511	(7,192,457)	(7,192,457) 50,835,511
2021 оны 6 сарын 30-ний үлдэгдэл		67,980,767	(40,717,761)	27,263,016

8





Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

## 1 Тайлагнагч этгээд

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК (цаашид "Компани" гэх) нь Монгол Улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай Компани юм. Компанид 6155804 бүртгэлийн дугаар бүхий 9011651142 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээг 2017 оны 2 сарын 22-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас олгосон.

2021 оны 6-р сарын 30-ны байдлаар Компанийн эцсийн хувьцаа эзэмшигчид нь хувь хүмүүс байна. 8 хувь хүн Группийн 90.1%-ийг эзэмшдэг бөгөөд эцсийн хяналтыг Монгол Улсын иргэд А. Ганболд болон А. Ганхуяг нар хэрэгжүүлдэг. Компанийн 9.99%-ийг БНСУ-д бүртгэлтэй БиЖиЭф Ритэйл ХХК эзэмшдэг.

Компани нь 2021 оны 6-р сарын 8-ны өдөр Премиум Дистрибьюшн ХХК-ын 100% хувьцааг худалдан авсан бөгөөд хамтад нь Групп гэнэ.

**Үндсэн үйл ажиллагаа.** Группийн үндсэн бизнесийн үйл ажиллагаа нь бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жижиглэнгийн бараа, бүтээгдэхүүнийг Монгол улсад сүлжээ дэлгүүрүүдээр зарж борлуулдаг. 2018 оны 4-р сарын 18-ны өдөр Групп нь ая тухтай үйлчилгээ үзүүлэх дэлгүүрийн үйл ажиллагаа эрхэлдэг БНСУ-д байрладаг БиЖиЭф Ритэйл ХХК компанитай мастер франчайзийн гэрээ байгуулж, дэлгүүрүүдээ солонгос улсын бренд болох "CU" болгон шинэчилсэн.

2021 оны 6-р сарын 30-ний байдлаар дэлгүүрийн тоо 127 (2020: 105).  
2021 оны 6-р сарын 30-ний байдлаар Группийн ажилчдын тоо 1,359 (2020: 993).

**Бүртгэлтэй хаяг болон бизнесийн үйл ажиллагаа явуулж буй байршил.** Компанийн бүртгэлтэй хаяг нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 19А, Шангри-Ла төв, Шангри-Ла оффис, 23 давхарт байрладаг. Эдгээр санхүүгийн тайлангууд нь өөрөөр заагаагүй бол Группийн бүртгэлийн мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр толилуулагдаж мянган Монгол төгрөг (төгрөг)-өөр илэрхийлэгдсэн.

## 2 Группийн үйл ажиллагаа явуулж буй орчин

Монгол Улсын өндөр инфляци болон хүүгийн түвшний өсөлт нь хөгжиж буй зах зээлийн шинж чанарыг харуулж байна. 2017-2019 онд дунджаар 6 орчим хувиар өсөлттэй байсан эдийн засаг COVID-19 цар тахлын сөрөг нөлөөгөөр, гадаадын хөрөнгө оруулалт удааширч, макро эдийн засгийн эмзэг байдал бий болсон зэргээс шалтгаалан Монголын эдийн засаг хумигдаж байна. 2021-2022 онд Монголын эдийн засаг 4-өөс дээш хувиар өсөх хандлагатай байгаа нь хувийн хэрэглээ, уул уурхай, үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалт хийхэд хүчтэй түлхэц болно. Гэсэн хэдий ч эдийн засгийн секторуудын хувьд сэргэлт жигд бус байгаа бөгөөд цаашдын төлөв байдал ч харилцан адилгүй байгаа ба Ковид-19 цар тахалын дотоод дахь дэгдэлттэй холбоотой тодорхой бус байдал буураагүй байна.


Тус улсын үнэлгээ нь 2020 оны 7-р сарын 9-ний өдрийн байдлаар Стандарт Энд Пүүрс Үнэлгээний Үйлчилгээнээс тогтвортой төлөвтэй В түвшинд байсан. Мүүди'с үнэлгээний агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2020 оны 12-р сарын 18-ны өдөр "В" гэж зарласан. "В" -ийн зэрэглэлийг хадгалахад дараахь хүчин зүйлс гол нөлөө үзүүлдэг: Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлт; Засгийн газрын тэргүүлсэн төсвийн сахилга батыг сайжруулах; түүхий эдийн үнэ.

Дэлхийн эдийн засагт үүсээд буй тодорхойгүй байдал, санхүүгийн зах зээлийн хэлбэлзэл, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн уналт, шинэ коронавирус COVID-19-ийн үүсэл, тархалт, Хятадын эдийн засгийн өсөлтийн удаашрал, Монголын эдийн засгийн өсөлтийн удаашрал, төгрөгийн ам.доллар болон евротой харьцах ханшийн сулралт, бусад болзошгүй эрсдэлүүд нь Монголын санхүүгийн болон бизнесийн салбарт мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.

Монгол Улсын эдийн засгийн ирээдүйн гүйцэтгэл нь Хятадаас түүхий эдийн эрэлт тасралтгүй үргэлжлэх, дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ өндөр байх, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засаг, санхүү, мөнгөний бодлогын үр ашиг, татвар, хууль эрх зүйн зохицуулалт, улс төрийн үйл ажиллагаатай хамааралтай хэвээр байна. Эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулахын тулд Монгол Улсын Засгийн газраас Нийгмийн даатгалын шимтгэлийг чөлөөлөх, түрээсийн төлбөрөөс хөнгөлөлт үзүүлж буй аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх зэрэг шийдвэр гаргасан нь Группийн бизнесийн үр дүнд нөлөөлсөн.

9





Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

## 2 Группийн үйл ажиллагаа явуулж буй орчин (Үргэлжлэл)

Монгол Улсын Засгийн Газар 2021 оны 2-р сарын 11-ээс 2021 оны 2-р сарын 23-ны хооронд, 2021 оны 4-р сарын 10-наас 2021 оны 5-р сарын 10-ны хооронд хатуу хөл хорио тогтоосон. Зохицуулалтын өөрчлөлтийг үндэслэн дэлгүүрүүдийн ажлын цагийг ихэвчлэн 07:00 – 22:00 цаг хүртэл хязгаарлав.

Групп хөл хориог 4-р сарын эцсээр дуусна гэж таамаглаж байсан ба 2021 оны эхний хагас жилийн борлуулалт төсөвтэй харьцуулахад 89.4%-н биелэлттэй байна. Нэг дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалт төсөвтэй харьцуулахад 89.7% -н биелэлттэй байна.

Удирдлагын зүгээс Групп нь бизнесийнхээ тогтвортой байдал, хөгжлийг дэмжихэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Удирдлага нь Монголын эдийн засагт нөлөөлж болох бүх үйл явцыг, тэдгээр нь Группийн ирээдүйн санхүүгийн байдалд ямар нөлөө үзүүлж болохыг урьдчилан таамаглах боломжгүй байгаа юм. Группийн удирдлага бизнесийнхээ тогтвортой байдал, хөгжлийг дэмжихэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч байна гэж үзэж байна.

## 3 Тайлан бэлтгэх үндэслэл

2021 оны 6 сарын 30 -наар тасалбар болсон хагас жилийн санхүүгийн тайлангуудыг НББОУС 34 Завсрын санхүүгийн тайлагнал болон бусад холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэсэн болно. Бүтэн тайлант хугацааны санхүүгийн тайланд тусгагддаг бүх тодруулгыг агуулаагүй тул 2020 оны жилийн тайлантай хавсарч танилцана уу.

## 4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

**Гадаад валютын хөрвүүлэг.** Группийн үйл ажиллагааны валют нь тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн анхдагч орчны валют юм. Группийн үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт, мөн Группийн толилуулгын валют нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг ("төгрөг") юм.

**Гүйлгээ болон үлдэгдэл дүнгүүд.** Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлант хугацааны эцэст Монголбанк ("МБ")-ны албан ханшаар Группийн бүртгэлийн мөнгөн тэмдэгт рүү хөрвүүлдэг. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ болон гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлан тэнцлийн өдрийн МБ-ны албан ханш руу хөрвүүлснээс үүсэх ханшийн олз, гарзыг ашиг алдагдалд зөвшөөрдөг.

Зээл ба мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөтэй холбоотой гадаад валютын ханшийн олз, гарзыг орлого үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайланд "санхүүгийн орлого" эсвэл "санхүүгийн зардал"-д тусгадаг. Бусад бүх гадаад валютын ханшийн олз, гарзыг орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд "Бусад орлого/зардал – цэвэр дүнгээр" тусгана. Жилийн эцсийн ханшаарх хөрвүүлэлт нь түүхэн өртгөөр хэмжигддэг мөнгөн бус зүйлсэд хамаарахгүй. Гадаад валютаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх мөнгөн бус зүйлс болон өмчөөрх хөрөнгө оруулалтыг оруулаад бүгдийнх нь бодит үнэ цэнийг тодорхойлсон бол тухайн өдрийн арилжааны ханшийг ашиглан хөрвүүлнэ. Гадаад валютаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийн ханшийн өөрчлөлтийн үр нөлөө нь бодит үнэ цэнийн олз эсвэл гарзын нэг хэсэг болж бүртгэгддэг.

**Үндсэн хөрөнгө.** Үндсэн хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр толилуулна.

Дараа нэмэгдэн гарах зардал, өртгүүдийн ирээдүйн эдийн засгийн өгөөжийг Групп хүртэх магадлалтай бөгөөд тухайн хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой тохиолдолд тухайн хөрөнгийн өртөгт тусгах эсвэл тусдаа хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Урсгал засвар үйлчилгээний өртгийг тухайн үед нь зардал болгож бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн гол эд ангийг солиход гарсан өртгийг капиталжуулж, хуучин эд ангийг данснаас хасна.

Тайлант хугацааны эцэс бүрд удирдлага нь тухайн хөрөнгийн үнэ цэн буурсан шинж тэмдэг илэрсэн эсэхийг үнэлж тодорхойлдог. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл удирдлага уг хөрөнгийн нөхөгдөх өртгийг хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулахад гарах зардлыг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль ихээр нь тодорхойлдог.

10



**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан**

**4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)**

Дансны дүнг нөхөгдөх өртөг хүртэл бууруулж, холбогдох үнэ цэнийн бууралтын гарзыг тухайн жилийн орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг. Хэрэв үндсэн хөрөнгийн ашиглалтын үнэ цэн эсвэл бодит үнэ цэнээс борлуулахад гарах зардлыг хассан дүнг тодорхойлоход ашигласан тооцооллод өөрчлөлт орох тохиолдолд өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцааж болно. Хөрөнгийг борлуулж данснаас хасах үед хөрөнгийн ашиглалт эсвэл борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн өгөөж гарахгүй гэж тооцсон тохиолдолд үндсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгө борлуулсны олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулсан үнийг тухайн үеийн бүртгэлийн дүнтэй харьцуулан тооцож тухайн жилийн орлого үр дүнгийн тайланд үйл ажиллагааны орлого, зардал (цэвэр) хэсэгт хүлээн зөвшөөрнө.

**Элэгдэл.** Газрыг элэгдүүлэхгүй. Үндсэн хөрөнгийн бусад зүйлсийн элэгдлийг элэгдэх өртгийг ашиглалтын хугацаанд шулуун шугамаар элэгдүүлэх аргаар тооцно:

	<u>Ашиглалтын хугацаа, жилээр</u>
Барилга	40 жил
Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл	10 жил
Тоног төхөөрөмж	10 жил
Бусад хөрөнгө	10 жил
Тавилга ба оффисын хэрэгсэл	2-10 жил
Түрээсийн сайжруулалт	Түрээсийн хугацаа болон ашиглалтын хугацааны аль багад

Группийн тухайн хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацааны эцэст хэрвээ уг хөрөнгө аль хэдийн ашиглагдаж дууссан бол хөрөнгийн борлуулах үнээс холбогдох тооцоолсон зардлуудыг хасаж тооцсон дүнг хөрөнгийн үлдэх өртөг гэдэг. Тайлант хугацаа бүрийн эцэст хөрөнгийн үлдэх өртөг болон ашиглалтын хугацааг хянаж үзэх ба шаардлагатай бол залруулдаг.

**Ашиглах эрхтэй хөрөнгө.** Групп нь дэлгүүрийн үйл ажиллагаанд зориулан талбай түрээсэлдэг. Гэрээ нь түрээсийн болон түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулж болно. Түрээсийн гэрээг ихэвчлэн 2 жилээс 10 жилийн хугацаанд тогтмол хугацаагаар хийдэг.

Ашиглах эрхтэй хөрөнгийг өртгөөр нь хэмжих ба өртөг нь түрээсийн өр төлбөрийн анхны хэмжилттэй тэнцүү байна.

Ашиглах эрхтэй хөрөнгийг хөрөнгийн ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль богинод нь шулуун шугамын аргаар элэгдүүлдэг. Групп худалдан авах сонголтыг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэх үндэслэлтэй байгаа бол ашиглах эрхтэй хөрөнгийг ашиглалтын хугацаанд нь элэгдүүлж болно.


Ашиглах эрхтэй хөрөнгийн зүйлийн элэгдлийг доор тооцсон ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар элэгдүүлнэ:

	<u>Ашиглалтын хугацаа, жилээр</u>
Дэлгүүрийн талбай	7-9 жил
Машин	1-2 жил
Агуулах	3 жил

**Бараа материал.** Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар нь бүртгэдэг. Бараа материалын өртгийг эхэлж авснаа эхэлж зарлагдах (ЭАЭЗ) өртгийн аргаар тооцоолдог. Дахин борлуулах барааны бараа материалын өртгийг жижиглэн худалдааны тооллогын аргаар тооцоолдог. Цэвэр боломжит үнэ цэнийг бизнесийн хэвийн нөхцөлд барааг борлуулах үнээс холбогдох тооцоолсон зардлуудыг хасч тооцно.

**Гүүдвиллээс бусад биет бус хөрөнгө.** Группийн гүүдвиллээс бусад биет бус хөрөнгүүдийн ашиглалтын хугацаа нь тодорхой ба түүнд голдуу компьютерын программ хангамж, патент, худалдааны тэмдэг болон лицензүүд ордог.





Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Биет бус хөрөнгийг нийт ашиглалтын хугацааны турш шулуун шугамын аргаар хорогдуулна:

Франчайзын төлбөр	Ашиглалтын хугацаа жилээр
Програм хангамжийн лиценз	10 жил
Газар ашиглалтын эрх	5 жил
	Түрээсийн хугацаанд

Биет бус хөрөнгүүдийг үлдэх өртөг, ашиглалтын хугацаа болон хорогдуулалтын аргыг тайлант хугацаа бүрийн төгсгөлд хянаж, шаардлагатай бол залруулдаг:

Хэрэв үнэ цэн буурсан тохиолдолд биет бус хөрөнгийн дансны үнийг ашиглалтын үнэ цэн болон бодит үнэ цэнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан дүнгийн аль илүү байгаа дүн хүртэл бууруулдаг.

**Санхүүгийн хэрэглүүрүүд – гол хэмжих нөхцөлүүд.** Бодит үнэ цэн гэж хэмжилт хийгдэх тухайн өдөр зах зээлд оролцогч талуудын хооронд хөрөнгө худалдсан бол хүлээн авах буюу өр төлбөр шилжүүлсэн бол төлөх байсан үнийг хэлнэ. Бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо бол идэвхтэй зах зээл дээрх үнэ байдаг. Идэвхтэй зах зээл гэдэг нь давтамж, тоо хэмжээний хувьд үнийн мэдээллийг тогтмол нийлүүлж чадах хөрөнгө, өр төлбөртэй холбоотой гүйлгээ гарч байдаг зах зээлийг хэлдэг.

Идэвхтэй зах зээлд арилжаалагдаж байгаа санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хөрөнгө буюу өр төлбөр тус бүрийн жишиг үнэ болон аж ахуйн нэгжийн эзэмшиж буй хэрэглүүрүүдийн тоо хэмжээгээр хэмждэг. Зах зээлийн өдөр тутмын хэвийн арилжааны хэмжээ нь Группийн эзэмшиж байгаа тоо хэмжээтэй харьцуулахад хангалтгүй байх мөн нэг арилжаагаар борлуулах захиалгын тоо хэмжээ зэрэг нь жишиг үнэд нөлөөлөх тохиолдол байдаг.

Зах зээлийн үнийн талаарх хөндлөнгийн мэдээлэл олдохгүй байх зарим санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд тэдгээрийн бодит үнэ цэнийг хөрөнгө оруулагч талын санхүүгийн мэдээлэл дээр үндэслэн дискаунтлагдсан мөнгөн гүйлгээний үнэлгээний загвар эсвэл үнэлгээний бусад аргачлалыг ашиглан тооцно. Бодит үнэ цэнийн хэмжилтийг бодит үнэ цэнийн шатлалын дагуу дараах байдлаар шинжилдэг.

Үүнд: (i) Нэгдүгээр түвшин нь ижил хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээл дээрх жишиг үнэнд (залруулагдаагүй) үндэслэн хийсэн хэмжилт, (ii) Хоёрдугаар түвшний хэмжилт нь тухайн хөрөнгө, өр төлбөрийн хувьд шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс тооцон гаргасан) ажиглагдахуйц бүхий л материаллаг хэмжээний орц мэдээллийг ашиглах үнэлгээний арга, техникүүд (iii) Гуравдугаар түвшний хэмжилт нь зах зээлээс ажиглагдахуйц бус тоо мэдээнд үндэслэн хийсэн үнэлгээнүүд (хэмжилт нь чухал үл ажиглагдахуйц орц мэдээллийг шаарддаг) орно. Бодит үнэ цэнийн шатлал хоорондох шилжүүлгийг тайлант хугацааны төгсгөлт хийсэн гэж үзнэ.

**Гүйлгээний зардлууд** нь санхүүгийн хэрэглүүрийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал нь гүйлгээ хийгдээгүй тохиолдолд гарахгүй байх байсан зардлыг хэлнэ.

Гүйлгээний зардалд зуучлагч, борлуулагч (борлуулалтын үүрэг гүйцэтгэж буй ажилтнуудын цалин), зөвлөх, брокер, дилерүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулах байгууллага, хөрөнгийн зах зээлийн байгууллагад төлсөн төлбөрүүд, мөн шилжүүлэлтэд ногдуулсан татвар хураамжууд хамаарна. Гүйлгээний зардалд өрийн шимтгэлийн зардал эсвэл хөнгөлөлт, санхүүжилтийн зардал, захиргааны дотоод зардал буюу хадгалалтын зардлууд орохгүй.

**Хорогдуулсан өртөг (ХӨ)** гэдэг нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн дүнгээс хийгдсэн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдалтай холбоотой аливаа нөөцийн дүнг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүнд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлуулсан гүйлгээний зардлаас болон аливаа нэмэгдэл үнэ, хөнгөлөлтөөс үр ашигт хүүгээр тооцсон дискаунт хамаарна. Хуримтлагдсан хүүгийн орлого, зардал, мөн хуримтлагдсан хүүгийн зардал, анх хүлээн зөвшөөрөх үед хойшлуулсан хураамж, хорогдуулсан хөнгөлөлт, нэмэгдэл зэргийг тусад нь толилуулахгүй бөгөөд санхүүгийн байдлын тайланд тусгагдсан холбогдох хэрэглүүрүүдийн бүртгэлийн үнэнд орсон байна.





#### 4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Үр ашигт хүүгийн арга нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны туршид дансны үнээс тооцогдох хүүгийн хувийг тогтмол байлгах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид дискаунтчилж, санхүүгийн хэрэглүүрүүдийн бүртгэлийн цэвэр дүнг гаргаж авах хүүгийн хувь болно. Үр ашигт хүүгийн хувь нь хувьсах хүүтэй хэрэглүүрүүдийн мөнгөн урсгалын хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл дискаунтчлах боловч хэрэглүүрт тусгагдсан хөвөгч хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн урамшуулал болон хөнгөлөлтийг, мөн зах зээлийн түвшинд тохируулагддаггүй ба бусад хувьсах хүчин зүйлсэд үл хамаарна. Эдгээр урамшуулал болон хөнгөлөлтийг хэрэглүүрүүдийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулна. Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд гэрээний талуудын хооронд төлөх эсвэл хүлээн авах бүх хураамжийг оруулах ба тэдгээр нь үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болно. Худалдаж авсан эсвэл дотооддоо бий болгосон хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө зээлийн үнэ цэн буурсан бол үр ашигт хүүг ч мөн үнэ цэнийн бууралтад тохируулан бүртгэнэ, жишээ нь: гэрээнд заасан эргэн төлөлтийн оронд анх хүлээн зөвшөөрсөн хүлээгдэж буй мөнгөн урсгалд тулгуурлан тооцоолно.

**Санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан хүлээн зөвшөөрөх.** Ашиг алдагдлаарх бодит үнэ цэн бүхий санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан бодит үнэ цэнээр бүртгэдэг. Группийн бүх санхүүгийн хэрэглүүрүүд нь анх зах зээлийн үнэ дээр гүйлгээний зардал нэмсэн дүнгээр бүртгэгддэг. Анхлан хүлээн зөвшөөрөх бодит үнэ цэн нь гүйлгээний дүнгээр хамгийн сайн нотлогдоно. Анхлан хүлээн зөвшөөрөх үед үүсэх олз эсвэл гарз нь зах зээлийн үнэ болон гүйлгээний дүнгийн хооронд зөрүү гарсан тохиолдолд л бүртгэгдэх бөгөөд үүнийг зөвхөн ижил төрлийн хэрэглүүрийн идэвхтэй зах зээл дээрх сүүлийн үеийн арилжааны мэдээллээр баталгаажуулсан эсвэл зөвхөн идэвхтэй зах зээлээс авсан мэдээлэл дээр үндэслэж хийсэн үнэлгээний аргачлалаар тооцсон тохиолдлуудад бүртгэх болно. Анхлан хүлээн зөвшөөрсний дараа ХБЭА-ын хасагдуулгыг хорогдуулсан өртөгөөр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгүүдийн хувьд хүлээн зөвшөөрдөг ба өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтуудыг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжиж гарсан үр дүн нь шууд бүртгэлийн гарз болдог.

Зохицуулах байгууллагаас тогтоосон эсвэл зах зээлийн жишгээр тогтсон ("хэвийн" борлуулалт болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан нийлүүлэх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л борлуулалт болон худалдан авалтыг арилжаа хийсэн өдөр буюу Групп тухайн санхүүгийн хөрөнгийг нийлүүлэх үүрэг хүлээсэн үед бүртгэнэ. Бусад бүх худалдан авалтыг Групп нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

**Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - хэмжилтийн төрөл.** Групп нь санхүүгийн хөрөнгийг хэмжилтээр нь дараах төрлүүдэд ангилна: Ашиг алдагдлаарх бодит үнэ цэн ("ААБҮЦ"), бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэн ("БДОБҮЦ") болон Хорогдуулсан өртөг ("ХӨ"). Өрийн хэлбэрээрх санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал болон дараа үеийн хэмжилт нь (i) санхүүгийн хөрөнгө нь гэрээний дагуу ирээдүйн мөнгөн урсгалыг цуглуулах зорилготойгоор санхүүгийн хөрөнгийг эзэмших бизнесийн загварт багтсан байх ба (ii) санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлүүд нь үндсэн төлбөр болон үлдэгдэл төлбөрийн хүүгийн төлбөр болох мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд бий болгож байдаг.

**Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - бизнес загвар.** Бизнес загвар нь Групп санхүүгийн хөрөнгийг мөнгөн урсгал бий болгох зорилгоор хэрхэн удирдаж байгаагаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл Группийн зорилго нь (i) зөвхөн тухайн хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах (гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмших) эсвэл (ii) хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авахаас болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авахын аль нь вэ гэдгээс хамаарах (гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах ба худалдах зорилгоор эзэмших) бөгөөд хэрэв (i) ба (ii)-ын аль нь ч биш тохиолдол бол санхүүгийн хөрөнгийг нь "бусад" гэсэн бизнес загварт хамааруулан ангилах ба ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжинэ.

Бизнес загварыг үнэлгээ хийсэн өдрийн байдлаар бэлэн байгаа багцын хувьд тодорхойлсон зорилгод хүрэхийн тулд Группийн хийж буй үйл ажиллагаанд хамааралтай бүхий л нотолгоонд үндэслэн бүлэг хөрөнгүүдийн (багцын түвшинд) хувьд тодорхойлно. Бизнес загварыг тодорхойлоход Группийн авч үзсэн хүчин зүйлүүдэд багцын бүрэлдэхүүн болон зорилго, холбогдох хөрөнгүүдийн мөнгөн урсгал хэрхэн цуглуулагдаж байсан талаарх өнгөрсөн үеийн туршлагауд, эрсдэлийг хэрхэн удирдаж үнэлж байсан, хөрөнгүүдийн гүйцэтгэлийг хэрхэн үнэлж байсан болон менежерүүдэд хэрхэн нөхөн төлбөр олгогдож байсан зэргийг авч үздэг.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

#### 4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

**Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - мөнгөн урсгалын онцлог.** Бизнес загвар нь хөрөнгийн гэрээт мөнгөн урсгалыг цуглуулж, хөрөнгийг эзэмшиж эсвэл хөрөнгийн гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авах зорилготой үед мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн болон хүүгийн төлбөрөөс бүрдэж буй ("ЗҮХТ") эсэхэд Групп үнэлгээ өгдөг. Гэрээт мөнгөн урсгал нь ЗҮХТ-ийн онцлогтой нийцсэн эсэхийг тодорхойлоход нуугдмал деривативыг агуулсан санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь авч үзнэ. Энэ үнэлгээг хийхдээ гэрээт мөнгөн урсгал нь зээлийн гэрээний үндсэн тохиролцоонд нийцтэй эсэх, ялангуяа хүү нь зээлийн эрсдэл, мөнгөний цаг хугацааны үнэ цэн болон зээлийн бусад эрсдэл, ашгийн түвшинг багтаасан эсэхийг авч үздэг.

Гэрээний нөхцөлүүд нь эрсдэлтэй эсвэл зээлийн үндсэн нөхцөлтэй үл нийцэх хэлбэлзлийг харуулж байвал санхүүгийн хөрөнгө нь ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэнэ. ЗҮХТ үнэлгээ нь хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед хийгдэх бөгөөд дараа үед дахин хийгдэхгүй.

**Санхүүгийн хөрөнгө – дахин ангилал.** Багцыг удирдаж байгаа бизнес загвар бүхэлдээ өөрчлөгдсөн бол санхүүгийн хэрэглүүрийг дахин ангилна. Дахин ангилал нь ирээдүйд нөлөө үзүүлэх бөгөөд бизнес загвар өөрчлөгдсөний дараах хамгийн эхний тайлант үеийн эхнээс хэрэгжинэ. Групп нь тайлант болон харьцуулсан өмнөх тайлант хугацааны туршид бизнесийн загвараа өөрчлөөгүй бөгөөд дахин ангилал хийгээгүй.

**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт - хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хасагдуулга.** Групп нь хорогдуулсан өртөг болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр бүртгэгдэх санхүүгийн өрийн хэрэглүүр болон гэрээний хөрөнгөтэй холбоотой хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг ирээдүй рүү харсан мэдээлэлд үндэслэн үнэлдэг. Групп нь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг ("ХБЭА") хэмжиж, санхүүгийн болон гэрээний хөрөнгийн үнэ цэн бууралтыг цэвэр алдагдлыг тайлант хугацаа бүрт хүлээн зөвшөөрдөг.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилт нь (i) олон янзын боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлсон зохистой, магадлалаар жинлэсэн дундаж дүн; (ii) мөнгөний цаг хугацааны үнэ цэн; болон (iii) өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдлын талаарх зэт их өртөг, хүчин чармайлтгүйгээр олох боломжтой үндэслэл бүхий бэлэн мэдээллүүд дээр үндэслэнэ.

Хорогдуулсан өртөөр хэмжигдсэн өрийн хэрэглүүр болон гэрээний хөрөнгө нь санхүүгийн байдлын тайланд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын хасагдуулгыг хассан цэвэр дүнгээр тусгагддаг.

Групп анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах зээлийн чанарын өөрчлөлтөд үндэслэсэн үнэ цэнийн бууралтын "3 шатлал" бүхий загварыг ашигладаг. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш ямар нэг үнэ цэнийн бууралтгүй санхүүгийн хэрэглүүр нь "1-р шатлал"-д ангилагдана. 1-р шатлалын санхүүгийн хэрэглүүрийн ХБЭА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдлын тайлант өдрөөс хойш 12 сарын дотор эсвэл хэрэв үүнээс богино бол гэрээний хугацаа дуусах хүртэл (12 сарын ХБЭА) үүсч болох санхүүгийн хэрэглүүрийн үүргээ биелүүлээгүйгээс үүдэн гарах хүлээгдэж буй алдагдлын хэмжээтэй ижил дүнгээр хэмжигдэнэ. Хэрэв Групп анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц өссөн ("ЗЭМӨ") гэдгийг тогтоовол хөрөнгийг "2-р шатлал"-д ангилах бөгөөд ХБЭА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэх ба энэ нь гэрээ дуусах хүртэл боловч хэрэв байгаа бол хүлээгдэж буй эргэн төлөлтүүдийг авч үзнэ (Ашиглалтын хугацааны ХБЭА).

**Санхүүгийн хөрөнгө - данснаас хасах.** Групп санхүүгийн хөрөнгийг нэхэмжлэх ажилд бүх хүчин чармайлтаа өгч нэхэмжлэх үндэслэл байхгүй гэж дүгнэсэн тохиолдолд бүхэлд нь буюу зарим хэсгийг нь данснаас хасдаг. Данснаас хасах нь үл хүлээн зөвшөөрөх үйл явдлыг илэрхийлнэ. Групп нь гэрээний дагуу төлөх дүнг нэхэмжлэхийг хүсч байгаа боловч төлөгдөх боломжийн таамаглал байхгүй байгаа тохиолдолд шүүхийн шийдвэрийг албадан хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа санхүүгийн хөрөнгийг данснаас хасах боломжтой.

**Санхүүгийн хөрөнгө – үл хүлээн зөвшөөрөх.** Групп нь (а) хөрөнгийг эргүүлэн худалдаж авсан эсвэл хөрөнгийн мөнгөн гүйлгээний эрх өөрөөр дуусгавар болсон эсвэл (б) Групп нь санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээний эрхийг шилжүүлсэн эсвэл шаардлага хангасан шууд дамжуулах гэрээ байгуулахын зэрэгцээ (i) мөн хөрөнгийг өмчлөхтэй холбоотой бүхий л эрсдэл, өгөөжийг шилжүүлэх, эсвэл (ii) өмчлөлийн бүх эрсдэл, өгөөжийг шилжүүлэхгүй, хадгалахгүй боловч хяналтаа хадгалахгүй байх тохиолдолд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.



Сэнтрал Экспресс Су Ви Эс ХХК

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

#### 4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Хэрэв эсрэг тал нь уг хөрөнгийг нэмэлт хязгаарлалт тавихгүйгээр бүхэлд нь хамааралгүй гуравдагч этгээдэд худалдах практик чадваргүй бол Группыг хяналтаа хадгалсанд тооцно.

**Санхүүгийн хөрөнгө - өөрчлөлт.** Групп нь санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлийг өөрчлөх буюу дахин тохиролцоо тохиолдол гардаг. Групп нь гэрээт мөнгөн урсгалын өөрчлөлт нь мэдэгдэхүйц эсэхийг дараах зүйлсийг харгалзан үзэж үнэлнэ: хөрөнгийн эрсдэлийн үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээр гэрээний шинэ зүйл заалт байгаа эсэх (жишээ нь: ашиг хуваах эсвэл хувьцаанд суурилсан төлбөр), хүүгийн түвшний мэдэгдэхүйц өөрчлөлт, нэрлэсэн валютын өөрчлөлт гэх мэт.

Хэрэв өөрчлөгдсөн нөхцөлүүд нь анхны нөхцөлөөс мэдэгдэхүйц зөрүүтэй бол анхны хөрөнгийн мөнгөн урсгалыг хүчингүй болгож Групп анхны санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч бодит үнэ цэнээр нь шинэ хөрөнгөд хүлээн зөвшөөрнө. Дахин тохиролцоо хийсэн өдөр нь дараах үеийн үнэ цэнийн бууралтыг тооцоолох зорилгоор анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр болно. Мөн зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт байгаа эсэхийг харгалзан үзнэ. Мөн Групп шинэ зээл буюу өрийн хэрэглүүр нь зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөрийн шалгуурт нийцэж байгаа эсэхийг үнэлж үзнэ. Үл хүлээн зөвшөөрөгдсөн анхны хөрөнгийн дансны үнэ болон мэдэгдэхүйц өөрчлөлт орсон шинэ хөрөнгийн бодит үнэ цэнийн зөрүү нь өмчлөгчидтэй хийсэн хөрөнгийн гүйлгээтэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.<sup>2</sup>

Дахин тохиролцоо нь нөгөө талын санхүүгийн хүндрэлтэй байдал болон анхны тохиролцсон төлбөрөө төлөх боломжгүй болсон үед хийгдэж байгаа нөхцөлд Групп нь хөрөнгийн одоогийн шинэчлэгдсэн мөнгөн гүйлгээ болон анхны мөнгөн гүйлгээг харьцуулж гэрээний өөрчлөлтөөс үүдэлтэй мэдэгдэхүйц өөрчлөгдсөн хөрөнгөнд эрсдэл болон өгөөж байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв эрсдэл болон өгөөж өөрчлөгдөөгүй бол өөрчилсөн хөрөнгө нь анхны хөрөнгөөс мэдэгдэхүйц өөрчлөлтгүй гэх ба өөрчлөлтөөс үүдэн үл хүлээн зөвшөөрөхгүй. Групп нь анхны үр ашигт хүүгийн түвшин (эсвэл худалдан авсан, шинээр гаргасан зээлийн – зээлжих чадамжаас үүдэлтэй үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд зээлийн тохируулгатай үр ашигт хүүгийн түвшин)-г ашиглан өөрчлөгдсөн гэрээт мөнгөн урсгалыг хорогдуулах замаар нийт дансны үнийг дахин тооцоолж, өөрчлөлтийн олз гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

**Санхүүгийн өр төлбөр - хэмжилтийн ангилал.** Санхүүгийн өр төлбөрүүдийг дараахаас бусад тохиолдолд дараа үеийн хорогдуулсан өртгөөр хэмжиж ангилна. Үүнд (i) ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдсэн санхүүгийн өр төлбөр: энэхүү ангилал нь дериватив, борлуулахаар эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр (үүнд богино хугацаат үнэт цаас), бизнесийн нэгдэл дэх нэгтгэгчийн хүлээн зөвшөөрсөн болзошгүй зүйлс болон анхны хүлээн зөвшөөрөлтөөрөө илэрхийлэгдсэн бусад санхүүгийн өр төлбөр, (ii) мөн санхүүгийн баталгааны гэрээ болон зээлийн амлалтууд хамаарна.

**Санхүүгийн өр төлбөр - үл хүлээн зөвшөөрөлт.** Санхүүгийн өр төлбөр хүчингүй болох үед (өөрөөр хэлбэл гэрээгээр хүлээсэн үүргийг гүйцэтгэж дууссан, цуцлагдсан эсвэл хугацаа дууссан) бүртгэлээс хасагдана.

Групп болон түүний анхны зээлдэгчдийн мэдэгдэхүйц өөр нөхцөл бүхий өрийн хэрэглүүр болон одоо буй санхүүгийн өр төлбөрийн нөхцөл, хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлт нь анхны санхүүгийн өр төлбөрийг данснаас хасаж, шинэ санхүүгийн өр төлбөр бүртгэх үндэслэл болно.

Аливаа төлсөн төлбөр хураамж болон хүлээн авсан төлбөр хураамжийн цэвэр дүнг багтаасан шинэ нөхцөлөөрх мөнгөн гүйлгээний хорогдуулсан өнөөгийн үнэ цэн нь анхны санхүүгийн өр төлбөрийн үлдэх хугацааны мөнгөн гүйлгээний хорогдуулсан өнөөгийн үнэ цэнээс хамгийн багадаа 10% зөрүүтэй бол мэдэгдэхүйц өөр нөхцөлтэй гэж үзнэ. Үүнээс гадна, нэрлэсэн валют, зээлийн хүүгийн төрлийн өөрчлөлт, хэрэгсэлд хавсаргасан шинэ хөрвүүлэх нөхцөл, зээлийн гэрээний үүргийн өөрчлөлт зэрэг бусад чанарын хүчин зүйлийг харгалзан үздэг. Өрийн хэрэглүүрийн нөхцөл хугацаа өөрчлөгдсөнөөр хэрэв өрийн хэрэглүүр хүчингүй болсон гэж үзвэл төлсөн төлбөр хураамж болон аливаа зардал нь өрийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөгдсөнөөс үүдсэн олз, гарзаар бүртгэдэг Харин эсрэг тохиолдолд төлсөн төлбөр хураамжийн зардлын дүнгээр өр төлбөрийн дансны үнийг нэмэгдүүлэх бөгөөд өөрчлөгдсөн өр төлбөрийн үлдэх хугацааны туршид хорогдуулна.

Өр төлбөрийн өөрчлөлтийг дансны үнэ цэнийн зөрүүний эдийн засгийн агуулгыг капиталд хамааруулахаас бусад тохиолдолд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн хуримтлуулах аргыг ашиглан тооцооны өөрчлөлтөд тооцдог.





Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

#### 4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

**Санхүүгийн хэрэглүүрүүдийг хооронд нь хаах.** Санхүүгийн хөрөнгө болон ер төлбөрийг хооронд нь хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр бүртгэх нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийн хаалт хийх эрх зүйн үндэслэл байгаа бөгөөд төлбөрийг цэвэр дүнгээр хийх эсвэл хөрөнгийг худалдаж, нэгэн зэрэг ер төлбөрийг барагдуулах төлөвлөгөө байгаа тохиолдолд л зөвшөөрөгдөнө. Энэхүү хооронд нь хаах эрх нь (а) ирээдүйд болох үйл явдлын болзошгүй төлбөр биш байх, (б) дараах тохиолдол бүрийг хуульд заагдсанаар шийдэх буюу (i) бизнесийн хэвийн үйл ажиллагаа, (ii) төлбөр төлөгдөхгүй болох (iii) төлбөрийн чадваргүй болж дамлуурсан үед бий болдог.

**Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.** Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөнд бэлэн мөнгө, банкинд байршуулсан харилцах хадгаламжийн мөнгө, 3 сар болон түүнээс богино хугацаатай, хөрвөх чадвар сайтай богино хугацаат хөрөнгө оруулалтыг хамааруулна. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Учир нь: (i) тэдгээр нь гэрээний мөнгөн урсгалаас цуглуулагдан эзэмшиж байгаа болон тэдгээр мөнгөн гүйлгээ нь ЗҮХТ-ийг харуулсан байдаг болон (ii) тэдгээр нь ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр тодорхойлогдоогүй байдаг. Зарим улсын батлан даалтын хууль тогтоомж гэх мэт зөвхөн хуулиар баталгаажуулсан онцлог шинжүүд нь хууль тогтоомж өөрчлөгдсөн ч гэсэн уг онцлог шинж чанарыг хэрэглэж болох тул гэрээний нөхцөлд оруулахаас гадна ЗХҮТ-ийн тестэд нөлөөлөхгүй.

**Дансны ба бусад авлага.** Дансны ба бусад авлагуудыг анхлан бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба цаашид үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

**Дансны ба бусад өглөг.** Дансны өглөгийг нөгөө тал гэрээнд заасан үүргээ биелүүлсэн үед хуримтлуулан бүртгэх ба анх бодит үнэ цэнээр, цаашид үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрдөг.

**Зээл.** Зээлийн эх үүсвэрийг бүртгэхдээ гүйлгээний зардлыг хасан бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрч, дараа нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулан бүртгэнэ.

**Санхүүгийн түрээсийн авлага.** Групп нь өмчлөлтэй холбоотой бүхий л эрсдэл, урамшууллыг түрээслэгчид шилжүүлдэг дэд түрээсийн түрээслүүлэгч бол түрээслүүлсэн хөрөнгийг түрээсийн цэвэр хөрөнгө оруулалттай тэнцэх хэмжээний санхүүгийн түрээсийн авлага хэлбэрээр тайлагнана. Эхлэх өдрөөс түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтыг хэмжихэд дараах түрээсийн төлбөр орно:

- түрээсийн урамшууллыг хасч тооцсон тогтмол төлбөр (мөн чанарын хувьд тогтмол төлбөр орно),
- үлдэх өртгийн баталгааны дагуу Групп хүлээн авахаар хүлээгдэж буй дүн,
- түрээсийг цуцалсны торгуулийн төлбөр.

Санхүүгийн түрээсийн авлагыг түрээсийн хугацаа эхлэхэд зэрэг хүлээн зөвшөөрөх ба түрээсийн гэрээнд түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтын дүнг тооцохоор тусгасан хорогдуулалтын хүүг ашиглана.

Нийт авлага ба өнөөгийн үнэ цэнийн зөрүү нь хойшлогдсон санхүүгийн орлогыг илэрхийлнэ. Энэхүү орлогыг түрээсийн хугацааны туршид цэвэр хөрөнгө оруулалтын аргыг ашиглан хүлээн зөвшөөрөх (татварын өмнөх) ба энэ нь өгөөжийн тогтмол хувийг илэрхийлнэ. Түрээсийн хэлэлцээр хийх, тохиролцоотой шууд холбоотой нэмэгдсэн зардлыг санхүүгийн түрээсийн авлагын анхны хэмжилтэд багтааж, түрээсийн хугацаанд хүлээн зөвшөөрсөн орлогын хэмжээг бууруулна. Дэд түрээсийн санхүүгийн орлогыг тухайн жилийн ашиг, алдагдлын тайланд санхүүгийн орлого хэсэгт бүртгэнэ.

Эрсдэлийн алдагдлын хасагдуулгыг тооцохдоо хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хялбаршуулсан аргыг ашигладаг. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг дансны авлагынхтай адил аргаар тооцдог. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хасагдуулгын дансаар дамжуулан авлагын дансны цэвэр дүнг бууруулж бүртгэх ба санхүүгийн түрээсэд хамааруулсан хүүгийн хэмжээгээр дискаунтлагдсан хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр хэмждэг. Хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ нь түрээстэй холбоотой хөрөнгийг олж авах, борлуулахтай холбоотой гарах мөнгөн урсгалыг илэрхийлнэ.

**Санхүүгийн түрээсийн өр төлбөр.** Түрээсийн өрийг анхлах хэмжихдээ өнөөгийн үнэ цэнд суурилдаг. Түрээсийг өр нь доорх түрээсийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийг агуулсан байна:





Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

#### 4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

- түрээсийн урамшууллыг хасаж тооцсон тогтмол төлбөр (мөн чанарын хувьд тогтмол төлбөр орно),
- индекс эсвэл хувь дээр үндэслэсэн түрээсийн хувьсах төлбөрийг эхлэх өдрийн байдлаар индекс эсвэл хувь хэмжээг ашиглан хэмжсэн,
- үлдэх өртгийн баталгааны дагуу Группээс төлөх ёстой хэмжээ,
- Групп хэрэгжүүлнэ гэж үзэх үндэслэлтэй байгаа бол хэрэгжүүлэх опционы хэрэгжих үнэ,
- Хэрэв Групп опцион хэрэгжүүлснээс болж түрээсийн хугацаа өөрчлөгдсөн бол, түрээсийг цуцалсны торгуулийн төлбөр.

Түрээсийн хугацааг сунгах болон цуцлах сонголт бүхий хэд хэдэн түрээсийн талбай Группэд бий. Эдгээр нь Группийн үйл ажиллагаанд ашигласан хөрөнгийг удирдах тал дээр үйл ажиллагааны уян хатан байдлыг нэмэгдүүлэхэд ашиглагддаг. Хугацаа сунгах, цуцлах сонголтуудын дийлэнхийг зөвхөн Групп хэрэгжүүлэх эрхтэй болох бөгөөд тухайн түрээслүүлэгчид хэрэгжүүлэх эрх байхгүй. Сунгалтын эрхийг (эсвэл гэрээг цуцалснаас хойших эрх) зөвхөн түрээсийн хугацааг сунгах (эсвэл цуцлахгүй) үндэслэлтэй тохиолдолд л оруулна.

Хугацааг сунгах эрх нь үндэслэлтэй тохиолдолд түрээсийн төлбөрийг мөн өр төлбөрийн тооцоонд оруулна.

Түрээсийн төлбөрийг түрээсийн дотоод хүүгээр хорогдуулна. Уг хүүг шууд тодорхойлж чадахгүй тохиолдолд (Группийн ихэнх түрээс ийм байгаа) Группийн зээлийн ахиуц хүүг ашиглана. Энэ нь ашиглах эрхтэй хөрөнгийг түрээстэй адил нөхцөл, барьцаа, хугацаатайгаар зээлээр худалдаж авах үед Группийн зээлдээ төлөх хүү байна.

Зээлийн ахиуц хүүг тооцохдоо Групп:

- Боломжтой бол ойрын хугацаанд түрээслэгчийн гуравдагч этгээдээс хүлээж авсан санхүүжилтийн өртгийг тухайн санхүүжилтийг хүлээж авснаас хойш санхүүжилтийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлтүүдэд залруулан ашиглана,
- Эрсдэлгүй хүүгийн түвшин дээр зээлийн эрсдэлийн урамшууллыг нэмэх,
- Түрээсийн онцлогуудыг тусгах, жишээ нь хугацаа, улс, валют, барьцаа.

Индекс болон хүүгээс хамаарсан түрээсийн хувьсах төлбөр нэмэгдэх эрсдэл Группэд байгаа бөгөөд уг түрээсийн төлбөрийг бодитоор өсөх хүртэл түрээсийн өр төлбөрт оруулахгүй. Индекс болон хүүгээс хамаарсан түрээсийн төлбөрт өөрчлөлт орох үед түрээсийн өр төлбөрийг дахин хэмжиж өөрчлөлтийг ашиглах эрхтэй хөрөнгөд тусгана.

Түрээсийн төлбөрийг үндсэн төлбөр болон санхүүжилтийн зардалд хуваарилна. Санхүүжилтийн зардлыг ашиг алдагдалд өр төлбөрийн үлдэгдэлд үе тутам тооцсон хүүгийн хувь тогтмол байхаар тусгана. Богино хугацаат түрээс болон бага дүнтэй хөрөнгийн түрээстэй холбоотой төлбөрүүдийг ашиг алдагдалд шулуун шугамын аргаар тусгана. Богино хугацаат түрээс нь 12 сар болон түүнээс богино хугацаатай байна.

**Орлогын албан татвар.** Орлогын албан татвар нь санхүүгийн тайланд тайлант хугацааны эцсийн байдлаар батлагдсан эсвэл үндсэндээ батлагдсан байгаа хууль тогтоомжийн хүрээнд хуримтлуулан бүртгэгдсэн байна. Орлогын албан татварын зардал нь тайлант хугацааны болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн буюу өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл шууд өмчид бүртгэгдсэнээс бусад тохиолдолд тухайн жилийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөнө.

Тайлант хугацааны албан татвар нь тухайн болон өмнөх тайлант хугацааны татвар ногдуулах ашиг эсвэл алдагдлаас бодогдсон татварын байгууллагад төлөх эсвэл буцаан авах дүн байна. Санхүүгийн тайланг холбогдох татварын тайланг тушаахаас өмнө баталгаажуулсан тохиолдолд татвар ногдуулах ашиг, алдагдлыг урьдчилсан тооцоон дээр үндэслэж тооцдог. Орлогын албан татвараас бусад татваруудыг үйл ажиллагааны зардалд бүртгэдэг.

Татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлэх үед хойшлогдсон орлогын албан татварыг тооцохдоо тайлан тэнцлийн өглөгийн аргыг ашиглах ба хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн тайлангийн зорилгоорх бүртгэлийн дүн болон татварын суурийн хоорондын түр зөрүүг тайлант хугацаанд тооцож бүртгэдэг.



**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан**

**4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)**

Анхны хүлээн зөвшөөрөлтийн чөлөөлөлтийн дагуу татвар ногдуулах ашиг болон бүртгэлийн ашгийн алинд нь ч нөлөөлдөггүй, мөн бизнесийн нэгдлээс бусад ажил гүйлгээнд хөрөнгө ба өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөх үед үүссэн түр зөрүүнд хойшлогдсон татвар бүртгэдэггүй.

Хойшлогдсон татварын үлдэгдлийг тайлант хугацааны эцэст бүхэлдээ буюу үндсэндээ батлагдсан байсан татварын хувь хэмжээгээр тооцож байгаа бөгөөд түр зөрүү гарах хугацаанд буцаах эсвэл татварын алдагдлыг ирээдүйд ашиглагдах үед хэрэглэхээр хүлээгдэж байдаг.

Хасагдах түр зөрүү болон татварын алдагдал шилжүүлснээс үүссэн хойшлогдсон татварын хөрөнгийг ирээдүйд түр зөрүү буцах магадлалтай үед бүртгэх бөгөөд эдгээр түр зөрүүг ирээдүйд олох татварын ашгаас хасаж ашиглаж болохуйц хэмжээгээр л хүлээн зөвшөөрнө.

**Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ).** Борлуулалтад ногдуулах нэмэгдсэн өртгийн татварыг (а) харилцагчаас авлага хүлээн авсан өдөр (б) харилцагчид бараа үйлчилгээ үзүүлсэн өдөр хоёрын аль эртээр нь тооцогдож татварын албанд борлуулалттай холбоотой өглөг үүсгэнэ. НӨАТ-ын худалдан авалт нь ерөнхийдөө НӨАТ-ын нэхэмжлэлийг хүлээн авах үед НӨАТ-ын борлуулалтаас буцаан хасагддаг. Татварын байгууллага НӨАТ-ыг цэвэр буюу хасагдуулсан дүнгээр төлөхийг зөвшөөрдөг. Борлуулалт, худалдан авалттай холбоотой НӨАТ нь санхүүгийн байдлын тайланд нийт дүнгээр хүлээн зөвшөөрөгдөх буюу НӨАТ-ын авлага буюу өглөгийн дүнгээр санхүүгийн байдлын тайлангийн өглөг эсвэл авлагын хэсэгт тусгагддаг.

**Урьдчилж төлсөн төлбөр.** Урьдчилж төлсөн төлбөрийг өртгөөс үнэ цэн бууралтын зардлыг хассан дүнгээр бүртгэнэ. Урьдчилгаа төлбөр хийгдсэн бараа үйлчилгээг нэг жилээс хойш хүлээн авахаар хүлээгдэж буй тохиолдолд эсвэл урьдчилгаа төлбөр хийгдсэн хөрөнгө нь өөрөө анх эргэлтийн бус гэж ангилагдсан тохиолдолд уг урьдчилж төлсөн төлбөрийг эргэлтийн бус гэж ангилна. Групп холбогдох хөрөнгийг хянах эрх олж авсан бөгөөд уг хөрөнгө нь Группэд эдийн засгийн үр өгөөж ирээдүйд өгөх магадлалтай болсон үед хөрөнгө худалдан авахаар хийгдсэн урьдчилж төлсөн төлбөрийн дүнг хөрөнгийн дансны үнэнд шилжүүлэн бүртгэнэ. Бусад урьдчилж төлсөн төлбөрийг холбогдох бараа, үйлчилгээг хүлээн авсан үед зардлаар бүртгэнэ. Урьдчилж төлсөн төлбөртэй холбоотой хөрөнгө, бараа, үйлчилгээ нийлүүлэгдэхгүй байх шинж тэмдэг илэрсэн тохиолдолд урьдчилж төлсөн төлбөрийн дүнг зохих хэмжээгээр бууруулж холбогдох үнэ цэнийн бууралтын гарзыг тайлант жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

**Хувьцаат капитал.** Энгийн хувьцааг эзэмшигчдийн өмчид тусгана. Гаргасан хувьцааны нэрлэсэн үнээс хүлээн авсан төлбөр болох зах зээлийн үнийн илүү гарсан дүнг нэмж төлөгдсөн капитал хэсэгт бүртгэдэг.

**Холбоотой талуудтай хийсэн гүйлгээний анхлан хүлээн зөвшөөрөлт.** Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад Групп холбоотой талуудтай гүйлгээ хийдэг. СТОУС 9-ийн дагуу санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнийг ашигладаг. Хэрэв тухайн гүйлгээний хувьд идэвхтэй зах зээлийнх биш бол зах зээлийн хүүг эсвэл зах зээлийн бус хүүг хэрэглэх тал дээр удирдлага өөрсдийн үнэлэлтийг хийдэг. Үнэлэлт нь холбоогүй талуудтай хийсэн ижил төрлийн гүйлгээ болон үр ашигт хүүгийн шинжилгээнд суурилдаг.

**Орлого хүлээн зөвшөөрөлт.** Орлого нь Группийн ердийн үйл ажиллагаанаас үүсдэг. Орлогыг Ажил гүйлгээний үнийн дүнгээр хүлээн зөвшөөрнө. Ажил гүйлгээний үнэ гэдэг нь үйлчлүүлэгчид гэрээгээр нийлүүлэхээр амласан бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээгээ шилжүүлснийхээ оронд авах эрхтэй болсон төлбөрийн дүн юм. Үүнд гуравдагч талын өмнөөс цуглуулсан дүн орохгүй. Орлогыг борлуулалтын цэвэр дүнгээр (хөнгөлөлт, буцаалт) буюу нэмэгдсэн өртгийн албан татвар, экспортын татвар, онцгой албан татвар, адилтгах бусад төлбөрийг хасаж цэвэр дүнгээр нь хүлээн зөвшөөрдөг.

**Хэрэглэгчдэд бараа борлуулсан орлого**

(а) Групп жижиглэнгийн сүлжээ дэлгүүр ажиллуулдаг. Борлуулсан барааны орлогыг харилцагчид бүтээгдэхүүн борлуулах үед хүлээн зөвшөөрдөг.

(б) Харилцагч бараа худалдаж авахдаа төлбөрийг бэлнээр төлдөг. Группийн бодлогын дагуу Харилцагчдад 24 цагийн дотор худалдан авсан бараагаа буцаах эрх өгдөг. Түүхэн туршлагаас харахад буцаагдсан барааны тоо материаллаг биш дүнтэй байдаг бөгөөд одоогоор хүлээн зөвшөөрсөн борлуулалтад томоохон хэмжээний буцаалт хийгдэх магадлал бага юм.



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн подруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

#### 4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

(в) Групп харилцагчдаа худалдан авалтаас урамшууллын оноо олгох хөтөлбөр хэрэгжүүлдэг бөгөөд харилцагчид уг оноог ирээдүйн худалдан авалтдаа ашиглах боломжтой. Онооны дагуу харилцагчдад олгогддог материаллаг эрх нь гэрээний үндсэнд олгогддог. Тиймээс, харилцагчдад оноо олгох амлалт нь тусдаа гүйцэтгэлийн үүрэг юм. Борлуулалтын үнийг бүтээгдэхүүн болон оноонд тус тусад нь харьцангуй дан борлуулалтын үнэд суурилан хуваарилдаг. Нэг онооны дан борлуулалтын нэгжийн үнэ нь нэг төгрөг. Борлуулсан бүтээгдэхүүний дан борлуулалтын үнэ нь жижиглэнгийн үнэтэй тэнцүү. Борлуулалтын үнээс оноонд хуваарилсан дүнгээр гэрээний өр төлбөр үүсгэж бүртгэдэг ба харилцагч оноогоо ашиглах үед орлогоор хүлээн зөвшөөрнө.

(г) Групп заримдаа харилцагчдад урамшууллын хөтөлбөр санал болгодог (жишээ нь гурвыг авбал нэг үнэгүй). Энэ нь тусдаа гүйцэтгэлийн үүрэг үүсгэх материаллаг эрх юм. Борлуулалтын үнээс харьцангуй дан борлуулалтын үнэд суурилан материаллаг эрхэд хуваарилдаг. Үнэгүй бүтээгдэхүүн авах эрх сүүлийн худалдан авалт дээр 100% хэрэгжих ба тухайн үед орлогыг хүлээн зөвшөөрнө.

(д) Хямдралтай борлуулалтаас олсон орлогын хямдруулалтын дүнг хассан цэвэр борлуулалтын үнэ дээр үндэслэн хүлээн зөвшөөрнө.

**Дэд франчайзын орлого.** Барааны хяналтыг шилжүүлэх үед буюу барааг дэд франчайз дэлгүүрт хүргэж өгөх үед борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрдөг. Дэд франчайз дэлгүүрүүд барааг захиран зарцуулан бүрэн эрхтэй бөгөөд дэд франчайз барааг хүлээж авах эсэхэд нөлөөлөхүйц биелэгдээгүй үүрэг байхгүй. Барааг тухайн байршилд аваачсан; барааны хугацаа дуусах, алдагдах эрсдэл дэд франчайзад шилжсэн; дэд франчайз нь барааг гэрээний дагуу хүлээж авсан эсхүл хүлээн авснаа илэрхийлэх хугацаа өнгөрсөн; эсвэл Группад бүх шаардлага хангагдсан гэж үзэх бодит баримт байгаа тохиолдолд хүргэлт хийгдсэн гэж үзнэ.

**Брэнд нэр ашигласны эрхийн шимтгэл.** Групп өөрийн брэнд нэрийг ашиглан дэлгүүрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрхийг дэд франчайзинг олгох ба төлбөрийг урьдчилан хүлээж авна. Дэд франчайзын эрх нь тусдаа гүйцэтгэлийн үүрэг болох бөгөөд хугацааны туршид хэрэгжинэ. Дэд франчайзаас хүлээн авсан урьдчилгаа төлбөрийг франчайзын гэрээний хугацаанд шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрнө. Ирээдүйн хугацаанд хамаарах дүн дээр гэрээний өр төлбөр хүлээн зөвшөөрнө.

**Бусад үйлчилгээний орлого.** Групп тогтмол болон хувьсах үнэ бүхий гэрээт үйлчилгээ үзүүлдэг. Үйлчилгээний орлогыг тухайн үйлчилгээг үзүүлсэн тайлант хугацаанд хүлээн зөвшөөрдөг. Тогтмол үнэтэй гэрээний хувьд тайлант хугацааны төгсгөл хүртэл бодитоор үзүүлсэн үйлчилгээ дээр үндэслэн орлогыг хүлээн зөвшөөрнө.


Гэрээнд нэгээс олон гүйцэтгэлийн үүрэг байгаа тохиолдолд дан борлуулалтын үнэд үндэслэн борлуулалтын үнийг гүйцэтгэлийн үүргүүдэд хуваарилна. Дан борлуулалтын үнийг шууд тодорхойлох боломжгүй үед өртөг дээр ашгийн ахиуцыг нэмэх аргаар тооцоолно. Тогтмол үнэтэй гэрээний хувьд, харилцагчид гэрээндээ тулгуурлан тогтмол дүн төлдөг.

Хэрэв гэрээнд хувьсах нөхцөлийг багтаасан бол орлогыг буцаалт хийгдэхгүй байх өндөр магадлалтай хэмжээгээр хүлээн зөвшөөрнө.

**Хүүгийн орлого.** Хүүгийн орлогыг бүх өрийн хэрэгслүүдэд аккруал сууриар үр ашигт хүүгийн аргыг ашиглан бүртгэдэг. Энэ арга нь хүүгийн орлогын нэг хэсэг болох үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох гэрээний талуудын хооронд хүлээн авсан бүх шимтгэл, бусад бүх шимтгэл эсвэл хөнгөлөлтийг үл тоомсорлодог

Үр ашигт хүүгийн салшгүй төлбөрт санхүүгийн хөрөнгийг бий болгох, олж авахтай холбоотой Группээс хүлээн авсан буюу төлсөн төлбөр, жишээлбэл, зээлийн чадварыг үнэлэх, баталгаа эсвэл барьцааны зүйлийг үнэлэх, бүртгэх, уг хэрэгслийн нөхцөлийг тохиролцох, боловсруулах төлбөр зэрэг орно.





Үнэт цаасны танилцуулга

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулагууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

#### 4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

**Ажилчдын зардал ба тэтгэмж – богино хугацаат тэтгэмжүүд.** Цалин хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг ажиллагсад холбогдох үйлчилгээ үзүүлсэн жилд зардлаар хүлээн зөвшөөрдөг. Ээлжийн амралт гэх мэт цалинтай богино хугацааны хуримтлагдан тооцогдох чөлөөг ажиллагсад ирээдүйд цалинтай чөлөө авах эрх олж авах үйлчилгээг үзүүлсэн үед, цалинтай богино хугацаат хуримтлагдахгүй чөлөөг (жишээ нь, өвчний улмаас чөлөө авах) чөлөө авах үед тус тус хүлээн зөвшөөрдөг.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компаниуд хуулийн дагуу улсын тэтгэврийн, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын сангуудад шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлүүдийг үүссэн үед нь орлого үр дүнгийн тайланд зардлаар бүртгэдэг. Группийн хуульд зааснаас өөр тэтгэвэр болон бусад тэтгэмжийн хөтөлбөрт төлбөр төлөх ямар нэгэн эрх зүйн эсвэл үүсмэл үүрэг хүлээгээгүй болно.

**Нэгж хувьцаанд ногдох ашиг.** Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)-ийг энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдох ашиг (алдагдал)-ийн дүнг тайлант хугацаанд эргэлтэд байсан хувьцааны жинлэсэн дундаж тоонд харьцуулж тооцдог.

**Сегментийн тайлагнал.** Үйл ажиллагааны сегментийн тайланг Ахлах үйл ажиллагааны шийдвэр гаргагчид (АҮАШГ) ашигладаг дотоод тайлагналтай нийцүүлэн гаргадаг. Группийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх Менежментийг АҮАШГ гэж тодорхойлсон. АҮАШГ нь үйл ажиллагааны сегментүүдийн нөөцийг хуваарилж, гүйцэтгэлийг үнэлнэ. Орлого, үр дүн, эсвэл хөрөнгийн аль нэг нь нийт сегментүүдийн нийлбэр дүнгийн 10 буюу түүнээс дээш хувийг бүрдүүлдэг сегментийг тусад нь тайлагнана.

**Бизнесийн нэгдэл.** Нэгдсэн хяналтад байдаггүй аж ахуйн нэгжүүдийн бизнесийн худалдан авалтыг бизнесийн нэгдлийн худалдан авалтын аргаар бүртгэдэг. Бизнесийн нэгдлээр худалдан авсан зүйлсийг бодит үнэ цэнээр нь хэмжих ба худалдан авалтын өдрөөрх Групп-д шилжсэн хөрөнгийн бодит үнэ цэн, олж эзэмшсэн зүйлийн өмнөх эзэмшигчээс Групп-д шилжсэн өр төлбөр болон олж эзэмшсэн зүйлийн хяналтыг авахын тулд Группийн гаргасан өмчийн хэрэгслийн нийлбэрээр хэмждэг. Худалдан авалттай холбоотой зардлыг ашиг алдагдлын тайланд тусгадаг.

Худалдан авалтын өдөр дараахаас бусад хөрөнгө ба өр төлбөрийг бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрдөг. Үүнд:

- НББОУС 12 Орлогын татвар –ын дагуу хүлээн зөвшөөрч, бүртгэсэн хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөр, мөн НББОУС 19 Ажилчдын тэтгэвэр тэтгэмж-ийн дагуу хүлээн зөвшөөрч, бүртгэсэн ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн гэрээтэй холбоотой хөрөнгө ба өр төлбөр
- СТОУС 2 Хувьцаанд суурилсан төлбөр –ийн дагуу худалдан авалтын өдрөөрх хувьцаанд суурилсан төлбөрийн хэлцэлтэй холбоотой өрийн ба өмчийн хэрэгсэл
- СТОУС 5 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа –ийн дагуу тодорхойлогдсон худалдан борлуулах зорилготой хөрөнгө.

Гүүдвэлийг худалдан авалтын өдрөөрх тодорхойлогдох хөрөнгө болон тооцоолсон өр төлбөрийн цэвэр дүнгээс шилжүүлсэн зүйлийн бодит үнэ цэн, нэгдэгч тал дахь хяналтын эрхгүй хувь оролцоо болон нэгдэгч талд Группийн өмнө нь эзэмшиж байсан хувь оролцооны худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнийн нийлбэрийн илүү гарсан дүнгээр хэмждэг. Хэрэв дахин хэмжилтийн дараа худалдан авалтын өдрөөрх тодорхойлогдох хөрөнгө болон тооцоолсон өр төлбөрийн цэвэр дүн нь шилжүүлсэн зүйлийн бодит үнэ цэн, нэгдэгч тал дахь хяналтын эрхгүй хувь оролцоо болон нэгдэгч талд Группийн өмнө нь эзэмшиж байсан хувь оролцооны худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнийн нийлбэрээс илүү гарвал түүнийг ашиг алдагдлын тайланд тохиролцоот худалдан авалтын олзоор бүртгэдэг.





**Сэнтрал Экспресс Су Ви Эс ХХК**

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд**  
**2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан**

**4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)**

**Стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийг эрт дагаж мөрдөх**

Доорх хүснэгтэд ирээдүйн тайлант хугацаанд хүчинтэй байх бүх стандартыг жагсаасан болно. Эдгээр өөрчлөлтийн аль нэгийг сайн дураараа эрт дагаж мөрдөх аж ахуйн нэгжүүд тухайн дагаж мөрдөж буй тайлант хугацааны жилийн тайлангаас гадна тэр өдөр, эсвэл хойших өдрөөр эхэлж буй бүх тайлант хугацааны завсрын тайланд мөн дагаж мөрдөнө.

Хугацааны эхэн болон 2021 оны 4-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхлэх СТОУС 16 Түрээс: 2021 оны 6-р сарын 30-с цааших Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт	2022 оны 1-р сарын 1-ний өдрөөр эхлэх буюу түүнээс хойшхи хугацаанд хүчин төгөлдөр мөрдөж эхлэх 2018-2020 онуудын СТОУС -ын жилийн сайжруулалт	Хугацааны эхэн болон 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхлэх СТОУС 17 Даатгалын гэрээ
	НББОУС 16 Өмч, Барилга болон Тоног төхөөрөмж (Нэмэлт өөрчлөлт- Зориулагдсан ашиглалтаас өмнөх орлого)	НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба НББОУС 8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба Алдаа (Нэмэлт өөрчлөлт - Өр төлбөрийг урт болон богино хугацаат гэж ангилах)
	НББОУС 37 Нөөц, Болзошгүй өр төлбөр ба Болзошгүй хөрөнгө (Нэмэлт өөрчлөлт - Алдагдалтай гэрээ - Гэрээг биелүүлэх өртөг)	НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба СТОУС Практик Тунхаглал 2 (Нэмэлт өөрчлөлт - НББ-н бодлогын тодруулга)
	СТОУС 3 Бизнесийн нэгдэл- (Нэмэлт өөрчлөлт- Онолын үзэл баримтлалын тайлбар)	НББОУС 8 НББ-н бодлого, НББ-н тооцооллын өөрчлөлт ба Алдаа (Нэмэлт өөрчлөлт- Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт)

**5 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан үндсэн тооцоолол ба үнэлэлт**

Групп нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүд болон дараагийн санхүүгийн тайлант жилийн хөрөнгө болон өр төлбөрийн бүртгэлийн дүнгүүдэд нөлөө үзүүлэх үнэлэлт болон тооцооллыг хийдэг. Тооцоолол болон үнэлэлтүүд нь үргэлж хянагддаг бөгөөд удирдлагын туршлага болон ирээдүйн үйл явдлын талаарх нөхцөл байдалд зохистой гэж үзсэн хүлээлт, таамаглал зэрэг бусад хүчин зүйлүүдэд суурилдаг. Удирдлага нь тооцоололд үнэлэлт хийхийн зэрэгцээ нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцыг мөн үнэлдэг. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд хамгийн мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үнэлэлтүүд болон дараагийн санхүүгийн жилийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнгүүдэд мэдэгдэхүйц залруулга хийх шаардлага үүсгэж болох тооцооллуудад дараах зүйлс хамаарна:

**Тасралтгүй байх.** Удирдлага нь эдгээр санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмын үндсэн дээр бэлтгэсэн бөгөөд Групп бизнесийн ердийн нөхцөлд хөрөнгийнхөө үр өгөөжийг хүртэж, өр төлбөрөө барагдуулж чадна гэж үзсэн. Энэхүү дүгнэлтийг гаргахдаа Группийн санхүүгийн байдал, одоогийн зорилго, үйл ажиллагааны ашигт байдал, санхүүгийн эх үүсвэр татах боломжийг харгалзан үзсэн.

2021 оны 06-р сарын 30-ны байдлаар группийн хуримтлагдсан алдагдал 40,717,751 мянган төгрөг (2020 оны 12 сарын 31: 33,525,294 мян.төг), эргэлтийн өр төлбөр эргэлтийн хөрөнгөөс 35,297 мянган төгрөг (2020 оны 12 сарын 31: 26,904,936 мянган төгрөг)-өөр илүү, үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ сэрэг 6,465,209 мянган төгрөг (2020 оны 06 сарын 30: зөрөг 2,192,786 мян.төг) байна. Групп нь ойрын хоёр жилийн хугацаанд алдагдалтай ажиллах төлөвтэй байгаа бөгөөд Монголын хөрөнгийн бирж дээрээс хөрөнгө татан төвлөрүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлснээр 2023 оноос ашигтай ажиллаж эхлэх төлөвлөгөөтэй байна. Эдгээр нөхцөл байдал нь группийн тасралтгүй байх зарчимд эргэлзээ төрүүлэхүйц материаллаг тодорхой бус байдал үүсгэж байна.



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

**5 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан үндсэн тооцоолол ба үнэлэлт (Үргэлжлэл)**

**Тасралтгүй байх (үргэлжлэл).** Групп нь дээрх шалтгаануудаас үүдэж тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломжгүй гэж үзсэн тохиолдолд бүхий л хөрөнгийн үнэ цэнийг нөхөгдөх боломжтой дүнгээр дахин тайлагнаж, ирээдүйд гарах өр төлбөрүүдийн сан байгуулж, зргэлтийн бус хөрөнгө ба урт хугацаат өр төлбөрийг зргэлтийн хөрөнгө ба богино хугацаат өр төлбөрөөр тус тус ангилах залруулгуудыг хийнэ. Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад эдгээр залруулгын нөлөөлөл тусгагдаагүй болно.

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа.** Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойлох нь ижил төстэй хөрөнгүүдийг ашиглаж үзсэн туршлага дээр тулгуурладаг. Ирээдүйн эдийн засгийн өгөөж нь энэхүү хөрөнгийн ашиглалтаас орж ирнэ. Хэдий тийм ч, техникийн болон хоцрогдол, биет элэгдэл хорогдуулалт зэрэг үзүүлэлтүүдээс хамааран хөрөнгөд агуулагдаж буй эдийн засгийн өгөөж буурдаг. Группийн удирдлага нь хөрөнгийн үлдсэн ашиглалтын хугацааны шинжилгээг одоогийн техникийн нөхцөл байдал болон хөрөнгийн ирээдүйд өгөх үр ашигт тулгуурлан явуулдаг. Энд: (а) хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалт, (б) хүлээгдэж буй биет хорогдуулалт, энэ нь засвар үйлчилгээ болон үйл ажиллагааны хүчин зүйлсээс хамаарах, (в) эдийн засагт орж буй өөрчлөлтөөс хамаарч буй техникийн болон арилжааны хоцрогдол гэсэн үндсэн хүчин зүйлсийг авч үздэг.

**Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт.** Хөрөнгө эсвэл хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ нь эргэн нөхөгдөх дүнгээсээ давбал үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрнө. Эргэн төлөгдөх дүнг тогтоохдоо удирдлага нь хөрөнгө тус бүрийн эсвэл мөнгө бий болгогч нэгжийн ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн урсгалыг тооцоолж, эдгээр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлохын тулд тохирох хүүг сонгож ашигладаг. Ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн урсгалыг хэмжихдээ удирдлага нь ирээдүйн үйл ажиллагааны үр дүнгийн талаар төсөөлөл гаргадаг. Энэ төсөөлөл нь ирээдүйд болох тодорхой нөхцөл байдал болон үйл явдлуудтай холбоотой болно. Бодит үр дүн нь өөр байж болох ба энэ нь дараагийн санхүүгийн жилд багтаж группийн хөрөнгүүдэд хийгдэх томоохон залруулгуудын шалтгаан байж болно.

Группийн удирдлага нь тохирох хөнгөлөлтийн түвшнийг тодорхойлохдоо зах зээлийн эрсдэл болон хөрөнгөтэй холбоотой эрсдэлийн хүчин зүйлийн тохируулгыг хийдэг.

**Бараа материалын цэвэр боломжит үнэ цэн.** Бараа материалыг өртөг, цэвэр боломжит үнийн аль багаар нь тусгана. Цэвэр боломжит үнэ цэнийг тооцохдоо тооцоолол хийх үеийн хамгийн найдвартай бэлэн байгаа нотолгоог авч үздэг. Бараа материалын дансны үнийн ирээдүйд гарах өөрчлөлт нь зах зээлийн сегмент бүр дэх үнийн өөрчлөлтөөс шалтгаална.

**Түрээсийн гэрээний хугацаа ба хүүгийн түвшин.** Групп нь түрээслэгчээр оролцож буй түрээсийн гэрээний хувьд түрээсийн хугацааг тодорхойлох, Групп түрээслэгчийн сунгах болон цуцлах сонголтыг хэрэгжүүлэх нь ул үндэслэлтэй эсэхийг гэрээ тус бүрийн хувьд түрээсийн эхлэл өдрөөр авч үзэж зохих тооцооллыг хийдэг. Мөн түрээсийн эхлэл өдрөөр өсөн нэмэгдэх зээлийн хүүгийн түвшнийг авч үздэг.

**Хойшлогдсон татвар.** Татвар болон нягтлан бодох бүртгэлийн хөрөнгө, өр төлбөрийн суурь хоорондын бүх түр зөрүүний хувьд ирээдүйд хэрэгжихээр хүлээгдэж буй үр ашигт татварын хувь хэмжээг ашиглан хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрдөг.

**Хүлээгдэж буй зээлийн алдагдал.** СТОУС 9-өөр шаардсан 12 сар болон нийт хугацааны турш хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжиж тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК****Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан****6 Онцлох үйл явдал, хэлцлүүд**

2021 оны 6-р сарын 8-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн тогтоол #4-ийн дагуу Групп санхүүгийн өр төлбөрөө дахин бүтэцчилсэн. Үүний дагуу, 2021 оны 6-р сарын 8-ны өдөр Групп Премиум Групп ХХК болон Голомт Банктай зээлийг дахин бүтэцчилэх гэрээнд гарын үсэг зурснаар Групп Голомт банкнаас авсан 15,591,333 мянган төгрөгийн богино хугацаат зээлийг Премиум Групп ХХК-д шилжүүлсэн.

Мөн, 2021 оны 6-р сарын 8-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн тогтоол #4-ийн дагуу Группийн Премиум Групп ХХК-д төлөх 19,795,025 мянган төгрөгийн бусад өр төлбөр, холбоотой тал болох БиЖиЭф Ритэйл ХХК-аас авсан 5,083,551 мянган төгрөгийн урт хугацаат зээл, хамааралтай талуудаас авсан 641,207 мянган төгрөгийн зээл эздийн өмч рүү хөрвүүлсэн.

Түүнчлэн, 2021 оны 6-р сарын 8-ны хувьцаа эзэмшигчдийн тогтоолын дагуу Группийн эзэмшлийн бүтэц өөрчлөгдсөн. Премиум Групп ХХК-ын эзэмшилд байсан нийт эргэлтэд байсан хувьцааны 90.9 хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг 8 хувьцаа эзэмшигчийн нэр дээр шилжүүлсэн. 7 хувьцаа эзэмшигч иргэн нэмэлтээр 2,000,000 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг Группэд хийсэн.

Уг хувьцаа эзэмшигчдийн тогтоолын дагуу Компани нь Премиум Дистрибьюшн ХХК -ийг 7,724,396 мянган төгрөгөөр Премиум Групп ХХК -иас худалдаж авсан.

Группийн удирдлага олон нийтэд хувьцаагаа гаргах хүсэлтээ Монгол улсын санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргах замаар өмчийн санхүүжилт татан, цаашдын өргөжилтөө санхүүжүүлэхээр ажиллаж байна. Групп эргэлтэд байгаа хувьцааныхаа 10 хувийг гаргаж, 15,711,111 мянган төгрөгийн санхүүжилт босгохоор төлөвлөж байгаа бөгөөд 2021 оны 10-р сард хувьцаагаа гаргана хэмээн тооцож байна.

**7 Сегментийн мэдээлэл**

Үйл ажиллагааны сегмент гэж орлого олох эсвэл зардал гаргах боломжтой бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, үйл ажиллагааны үр дүнг ахлах (АҮАШГ) тогтмол хянаж үздэг бөгөөд санхүүгийн хувьд салангид мэдээлэл авах боломжтой бүрэлдэхүүн хэсгүүдийг хэлнэ. АҮАШГ нь байгууллагын нөөцийг хуваарилж, гүйцэтгэлийг үнэлдэг хүн эсвэл бүлэг хүмүүс юм. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх менежментийг АҮАШГ гэж тодорхойлсон.

**(а) Тайлагнах сегмент бүрийн орлого олдог бүтээгдэхүүн, үйлчилгээний тодорхойлолт**

Удирдлага Группийн гүйцэтгэлийг бүтээгдэхүүний өнцгөөс шинэчилж, бизнесийн хоёр сегмент тодорхойлсон. Газарзүйн өнцгөөс авч үзээгүй; Групп газарзүйн нэг байршилд үйл ажиллагаагаа явуулдаг.

- Сегмент 1 – Эцсийн хэрэглэгчид борлуулсан бараа;
- Сегмент 2 – Дэд франчайзад үзүүлсэн үйлчилгээ болон хүлээж авсан эрхийн шимтгэл.

**(б) Тайлагнагч сегментийг тодорхойлоход удирдлага ашигласан хүчин зүйлүүд**

Компанийн гол үйлчлүүлэгчид нь жижиглэнгийн худалдаа эрхлэгчид болон дэд франчайзын эрх эзэмшигч тусдаа хуулийн этгээдүүд юм. Компанийн сегментүүд нь өөр өөр бүтээгдэхүүн, үйлчилгээнд анхаарлаа төвлөрүүлдэг стратегийн бизнесийн нэгжүүд юм. Бизнесийн нэгж бүр өөр өөр маркетингийн стратеги, үйлчилгээний түвшинг шаарддаг тул тэдгээрийг тусад нь удирддаг.


**(в) Үйл ажиллагааны сегментийн ашиг, алдагдал, хөрөнгө, өр төлбөрийг хэмжих**

АҮАШГ нь дотоод тайлагналын шаардлагад нийцүүлсэн санхүүгийн тайлагналын олон улсын стандартад үндэслэн бэлтгэсэн санхүүгийн мэдээллийг хянаж үздэг. Ийм санхүүгийн мэдээлэл нь СТОУС-аас зарим талаараа ялгаатай байдаг.

- i. Орлогын албан татварыг сегментэд хуваарилдаггүй;
- ii. Компанийн тэтгэврийн сангийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөггүй;







Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

7 Сегментийн мэдээлэл (Үргэлжлэл)

(г) Үйл ажиллагааны сегментийн ашиг, алдагдал, хөрөнгө, өр төлбөрийн талаарх мэдээлэл

2021 оны 6-р сарын 30-ны өдөр дууссан тайлант хугацааны тайлагнах сегментүүдийн мэдээллийг дор харуулав:

Мянган төгрөгөөр	Сегмент 1	Сегмент 2	Нийт
2021 оны 6 сарын 30			
Гураадагч талд хийсэн борлуулалтын орлого	32,021,344	435,903	32,457,247
Сегментийн татварын өмнөх ашиг	(8,441,056)	(5,746)	(8,446,802)

Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн тайланд хэмждэгтэй адил хэмжинэ. Эдгээр хөрөнгийг сегментийн үйл ажиллагаа болон хөрөнгийн биет байршил дээр үндэслэн хуваарилна.

2021 оны 06-р сарын 30-ний өдрөөрх тайлагнах сегментүүдийн мэдээлэл

Мянган төгрөгөөр	Сегмент 1	Сегмент 2	Нийт
Үндсэн хөрөнгө	30,869,340	2,246,128	33,115,468
Ашиглах эрхтэй хөрөнгө	19,033,072	-	19,033,072
Биет бус хөрөнгө	2,845,908	51,078	2,896,986
Бусад авлага	1,087,722	-	1,087,722
Бусад эргэлтийн бус урьдчилгаа	319,805	-	319,805
Санхүүгийн түрээсийн авлага	3,408,418	-	3,408,418
Хойшлогдсон татварын хөрөнгө	1,526,088	-	1,526,088
Гүүдвилл	2,818,895	-	2,818,895
Бараа материал	7,475,367	-	7,475,367
Урьдчилгаа	2,241,743	-	2,241,743
Бусад татварын авлага	431,279	-	431,279
Дансны ба бусад авлага	1,156,052	676,015	1,832,067
Санхүүгийн түрээсийн авлага	143,153	-	143,153
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	3,961,888	-	3,961,888
<b>Сегментийн нийт хөрөнгө</b>	<b>77,318,730</b>	<b>2,973,221</b>	<b>80,291,951</b>
Урт хугацаат зээл	12,570,434	-	12,570,434
Урт хугацаат түрээсийн өр төлбөр	24,333,830	-	24,333,830
Урт хугацаат бусад өр төлбөр	3,877	-	3,877
Дансны ба бусад өглөг	13,312,126	-	13,312,126
Богино хугацаат зээл	102,989	-	102,989
Богино хугацаат түрээсийн өглөг	1,293,114	-	1,293,114
Орлогын албан татварын өглөг	20,925	-	20,925
Бусад татварын өглөг	600,531	-	600,531
Гэрээний өр төлбөр	235,377	555,732	791,109
<b>Сегментийн нийт өр төлбөр</b>	<b>52,473,203</b>	<b>555,732</b>	<b>53,028,935</b>





**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд**  
**2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан**

**8 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ болон дансны үлдэгдлүүд**

2021 оны 06-р сарын 30-ны өдрөөрх группийн холбоотой талууд нь дараах байдалтай байна.

Холбоотой талын нэр	Харьяалал	Харилцан хамаарал
А.Ганхуяг	Монгол улс	Хувьцаа эзэмшигч /2021 оны 06 сарын 08-аас хойш/, ТУЗ-ийн дарга
А.Ганболд	Монгол улс	Хувьцаа эзэмшигч /2021 оны 06 сарын 08-аас хойш/, ТУЗ-ийн гишүүн
Ц.Баяржаргал	Монгол улс	Хувьцаа эзэмшигч /2021 оны 06 сарын 08-аас хойш/
А.Ганбаатар	Монгол улс	Хувьцаа эзэмшигч /2021 оны 06 сарын 08-аас хойш/
А.Одончимэг	Монгол улс	Хувьцаа эзэмшигч /2021 оны 06 сарын 08-аас хойш/
О.Батмөнх	Монгол улс	Хувьцаа эзэмшигч /2021 оны 06 сарын 08-аас хойш/, ТУЗ-ийн гишүүн
Г.Бат-Эрдэнэ	Монгол улс	Хувьцаа эзэмшигч /2021 оны 06 сарын 08-аас хойш/, ТУЗ-ийн гишүүн
Ө.Мөнхбаяр	Монгол улс	Хувьцаа эзэмшигч /2021 оны 06 сарын 08-аас хойш/
Г.Чинзориг	Монгол улс	ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал
Би жи эф Ритэйл	Бүгд найрамдах Солонгос Улс	Хувьцаа эзэмшигч
Премиум Групп ХХК	Монгол улс	Талгой компани /2021 оны 06 сарын 08 хүртэл/
Премиум Индастриал Энд Инженеринг ХХК	Монгол улс	Холбоотой тал
Премиум Бьолдинг Материалс ХХК	Монгол улс	Холбоотой тал
Премиум Эквити ХХК	Монгол улс	Холбоотой тал
Премиум Ойл энд Энержи ХХК	Монгол улс	Холбоотой тал
Премиум Майнинг Сэрвисэс ХХК	Монгол улс	Холбоотой тал
Юу Эм Эс ХХК	Монгол улс	Холбоотой тал
Аркадиа гарден ХХК	Монгол улс	Холбоотой тал
Финланд Лайф хаус ХХК	Монгол улс	Холбоотой тал
Саут гоби Рок ХХК	Монгол улс	Холбоотой тал
Премиум Прожэкт ХХК	Монгол улс	Холбоотой тал
Сабвэй Монгол ХХК	Монгол улс	Холбоотой тал
Сэрмүүн хүнс ХХК	Монгол улс	Холбоотой тал
Сэлэнгэ Агро ХХК	Монгол улс	Холбоотой тал
Рио Гранде ХХК	Монгол улс	Холбоотой тал
Ганброс ХХК	Монгол улс	Холбоотой тал
Нэтизен ХХК	Монгол улс	Холбоотой тал

**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**

**Нээтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан**

**8 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ болон дансны үлдэгдлүүд (Үргэлжлэл)**

2021 оны 6-р сарын 30-ны өдөр холбоотой талуудын үлдэгдэл дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	Тодруулга	Эцсийн хувьцаа эзэмшигч	Бусад холбоотой тал
Дансны ба бусад өглөг	20	-	1,094,984
Урьдчилгаа	13	181,735	-
Зээл	21	5,178,868	-

2021 оны 6-р сарын 30-ний өдрөөр тасалбар болгосон тайлант хугацаанд холбоотой талуудтай дараах орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн:

Мянган төгрөгөөр	Эцсийн хувьцаа эзэмшигч	Бусад холбоотой тал
Бэлэн бүтээгдэхүүний борлуулалт	-	1,070
Санхүүгийн зардал	248,293	-
Бусад орлого	-	42,225
Бусад зардал	-	7,309
Үндсэн хөрөнгийн борлуулалт	242,241	332,905
Бараа материал худалдан авалт	602,385	552,408
Гол удирдлагад олгосон цалин, урамшуулал	-	356,072

2020 оны 12-р сарын 31-ны өдөр холбоотой талуудын үлдэгдэл дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	Тодруулга	Шууд толгой Групп	Эцсийн хувьцаа эзэмшигч	Ерөнхий хяналтад буй байгууллагууд	Бусад холбоотой тал
Дансны авлагын нийт дүн	14	-	-	203,581	-
Дансны ба бусад өглөг	20	15,509,270	-	840,308	-
Урьдчилгаа	13	-	-	1,059,438	200,139
Зээл	21	-	646,828	-	10,520,000

2020 оны 6-р сарын 30-ний өдрөөр тасалбар болгосон тайлант хугацаанд холбоотой талуудтай дараах орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн:

Мянган төгрөгөөр	Тодруулга	Шууд толгой Групп	Эцсийн хувьцаа эзэмшигч	Ерөнхий хяналтад буй байгууллагууд	Бусад холбоотой тал
Бэлэн бүтээгдэхүүний борлуулалт	-	1,007	-	103,896	-
Бусад орлого	-	-	-	3,006	-
Бусад зардал	-	-	-	7,377	-
Үндсэн хөрөнгө худалдан авалт	-	-	98,194	-	370,400
Түгээлтийн зардал	24	-	-	619,820	-
Бэлэн бүтээгдэхүүний худалдан авалт	-	-	210,722	1,071,983	450,512
Санхүүгийн зардал	-	-	46,352	-	-
Гол удирдлагад олгосон цалин, урамшуулал	-	-	-	-	435,453

**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодрууллауд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан**

**9 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгө дансны хөдөлгөөнийг дараах байдлаар харууллаа:

Мянаан төгрөгөөр	Тээврийн хэрэгсэл, эд тоног төхөөрөмж	Оффисын тавилга, эд хогшил	Түрээсийн сайжруулалт	Дуусаагүй барилга	Барилга	Нийт
2019 оны 12 сарын 31 өртөг	1,171,946	9,405,303	5,536,122	-	-	16,113,372
Хуримтлагдсан элэгдэл	(97,391)	(1,375,544)	(1,027,367)	-	-	(2,500,302)
<b>2020 оны 1 сарын 1 үлдэгдэл</b>	<b>1,074,555</b>	<b>8,029,759</b>	<b>4,508,755</b>	-	-	<b>13,613,070</b>
Нэмэгдсэн	2,034	5,732,144	2,943,931	-	-	8,678,109
Борлуулсан	(100,452)	(858,999)	(580,322)	-	-	(1,539,773)
Борлуулсан – элэгдэл	5,711	108,026	176,343	-	-	290,080
Данснаас хассан	-	(151,191)	-	-	-	(151,191)
Данснаас хассан – элэгдэл	-	74,547	-	-	-	74,547
Элэгдлийн зардал	(103,113)	(2,211,691)	(733,867)	-	-	(3,048,671)
<b>2020 оны 12 сарын 31 үлдэгдэл</b>	<b>878,735</b>	<b>10,722,595</b>	<b>6,314,840</b>	-	-	<b>17,916,171</b>
2020 оны 12 сарын 31 өртөг	976,137	14,127,257	7,899,732	-	-	23,100,517
Хуримтлагдсан элэгдэл	(97,402)	(3,404,662)	(1,584,961)	-	-	(5,184,346)
<b>2020 оны 12 сарын 31 үлдэгдэл</b>	<b>878,735</b>	<b>10,722,595</b>	<b>6,314,841</b>	-	-	<b>17,916,171</b>
Нэмэгдсэн	654,451	5,740,290	617,786	-	1,788,679	17,753,269
Дуусаагүй барилгад дахин ангилсан	-	-	-	8,952,063	8,952,063	-
Борлуулсан	(1,400)	(235,572)	-	-	-	(236,972)
Борлуулсан – элэгдэл	182	25,179	-	-	-	25,361
Данснаас хассан	-	(18,545,00)	-	-	-	(18,545)
Элэгдлийн зардал	(83,907)	(1,712,196)	(492,424)	-	(35,289)	(2,323,816)
<b>2021 оны 6 сарын 30 үлдэгдэл</b>	<b>1,448,061</b>	<b>14,521,751</b>	<b>6,440,203</b>	-	<b>10,705,453</b>	<b>33,115,468</b>
2021 оны 6 сарын 30 өртөг	1,629,188	19,613,430	8,517,518	-	10,740,742	40,500,878
Хуримтлагдсан элэгдэл	(181,127)	(5,091,679)	(2,077,315)	-	(35,289)	(7,385,410)
<b>2021 оны 6 сарын 30 үлдэгдэл</b>	<b>1,448,061</b>	<b>14,521,751</b>	<b>6,440,203</b>	-	<b>10,705,453</b>	<b>33,115,468</b>

Банкнаас авсан зээлд охин компанийн ирээдүйд бий болох хөрөнгийг барьцаалсан.



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

**10 Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө болон түрээсийн өглөг**

Групп нь дэлгүүрийн талбай болон тээврийн хэрэгсэл түрээсэлдэг. Түрээсийн гэрээг ихэвчлэн тогтмол 2 жилээс 10 жилийн хугацаанд хийгддэг.

Мянган төгрөгөөр	Талбай	Тээврийн хэрэгсэл	Агуулах	Нийт
<b>2020 оны 1 сарын 1 үлдэгдэл</b>	<b>15,571,779</b>	<b>45,617</b>	-	<b>15,617,396</b>
Нэмэгдсэн	5,590,155	-	-	5,590,155
Худалдсан	(2,571,338)	-	-	(2,571,338)
Элэгдлийн зардал	(1,818,866)	(4,311)	-	(1,823,177)
<b>2020 оны 12 сарын 31 үлдэгдэл</b>	<b>16,771,730</b>	<b>41,306</b>	-	<b>16,813,036</b>
Нэмэгдсэн	4,618,779	-	795,369	5,414,148
Худалдсан	(1,657,417)	(40,609)	-	(1,698,026)
Элэгдлийн зардал	(1,439,770)	(697)	(55,619)	(1,496,086)
<b>2021 оны 6 сарын 30 үлдэгдэл</b>	<b>18,293,322</b>	-	<b>739,750</b>	<b>19,033,072</b>

Групп дараах түрээсийн өглөгийг хүлээн зөвшөөрсөн:

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 12 сарын 31
Урт хугацаат түрээсийн төлбөрийн өнөөгийн хэсэг	1,293,114	1,627,744
Урт хугацаат түрээсийн өр төлбөр	24,333,830	19,570,737
<b>Нийт түрээсийн өр төлбөр</b>	<b>25,626,944</b>	<b>21,198,481</b>

Түрээсийн гэрээнд түрээсэлсэн хөрөнгийн аюулгүй байдлыг хангахаас өөрөөр ямар нэгэн хязгаарласан заалт байхгүй. Түрээсийн хөрөнгийг зээлийн барьцаа болгон ашиглах боломжгүй.

Түрээсийн хугацааг сунгах болон цуцлах сонголт бүхий хэд хэдэн түрээсийн талбай Группад бий. Эдгээр нь Группийн үйл ажиллагаанд ашигласан хөрөнгийг удирдах тал дээр үйл ажиллагааны уян хатан байдлыг нэмэгдүүлэхэд ашиглагддаг. Хугацаа сунгах, цуцлах сонголтуудын дийлэнхийг зөвхөн Групп хэрэгжүүлэх эрхтэй болох бөгөөд тухайн түрээслүүлэгчид хэрэгжүүлэх эрх байхгүй.

2021 оны 6-р сарын 30-ны байдлаар түрээсийн хугацааг сунгахгүй (эсвэл цуцлах) гэсэн тодорхой үндэслэлтэй гэрээ байхгүй. Опционыг бодитоор хэрэгжүүлсэн (эсвэл хэрэгжүүлээгүй) эсвэл Групп үүнийг хэрэгжүүлэх (эсвэл хэрэгжүүлэхгүй) үүрэг хүлээсэн тохиолдолд түрээсийн хугацааг дахин үнэлнэ. Боломжийн баталгааны үнэлгээг энэ үнэлгээнд нөлөөлөхүйц чухал үйл явдал эсвэл нөхцөл байдалд томоохон өөрчлөлт гарсан тохиолдолд л хянан үзэх бөгөөд энэ нь Группийн мэдэлд байна.





Сентрал Экспресс Си Ви Эс ХХК

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

11 Биет бус хөрөнгө

Мянган төгрөгөөр	Газар ашиглалтын эрх	Франчайзын төлбөр	Программ хангамжийн лиценз	Нийт
<b>2019 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>1,987,958</b>	<b>925,274</b>	<b>2,913,232</b>
Нэмэгдсэн Борлуулсан Хорогдуулалтын зардал	-	-	353,020 (3,252) (214,561)	<b>353,020 (3,252) (454,885)</b>
<b>2020 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>1,747,634</b>	<b>1,060,481</b>	<b>2,808,115</b>
2020 оны 12 сарын 31-ний өртөг Хуримтлагдсан хорогдуулалт	-	2,396,680 (649,046)	1,432,059 (371,578)	<b>3,828,739 (1,020,624)</b>
<b>2020 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>1,747,634</b>	<b>1,060,481</b>	<b>2,808,115</b>
Нэмэгдсэн Хорогдуулалтын зардал	104,070 (656)	- (120,405)	201,424 (95,562)	<b>305,494 (216,623)</b>
<b>2021 оны 6 сарын 30-наарх үлдэгдэл</b>	<b>103,414</b>	<b>1,627,229</b>	<b>1,166,343</b>	<b>2,896,986</b>
2021 оны 6 сарын 30-ны өртөг Хуримтлагдсан хорогдуулалт	104,070 (656)	2,396,680 (769,451)	1,633,483 (467,140)	<b>4,134,233 (1,237,247)</b>
<b>2021 оны 6 сарын 30-наарх үлдэгдэл</b>	<b>103,414</b>	<b>1,627,229</b>	<b>1,166,343</b>	<b>2,896,986</b>

12 Бараа материал


Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 12 сарын 31
Түүхий эд материал Борлуулах бараа	208,239 6,771,968	- 6,081,829
Борлуулах бараа – замд яваа	-	84,031
Барилгын материал	101,643	42,904
Хангамжийн материал	393,517	502,210
<b>Нийт бараа материал</b>	<b>7,475,367</b>	<b>6,710,974</b>

Борлуулалтын өртөгт бүртгэсэн 25,499,258 мянган төгрөг (2019: 12,725,754 мянган төгрөг)-ийн бараа материалын өртгийг тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрсөн.

13 Урьдчилгаа

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 12 сарын 31
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа	2,143,801	1,844,388
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа – тоног төхөөрөмж	417,747	369,717
<b>Нийт урьдчилгаа</b>	<b>2,561,548</b>	<b>2,214,105</b>
Урт хугацааны урьдчилгаа	417,747	369,717
Богино хугацааны урьдчилгаа	2,143,801	1,844,388

29



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

#### 14 Дансны ба бусад авлага

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 12 сарын 31
Дансны авлага – гуравдагч талууд	736,348	412,582
Дансны авлага – холбоотой талууд	-	203,581
Бусад авлага – гуравдагч талууд	712,511	451,304
<b>Нийт санхүүгийн хөрөнгө- дансны ба бусад авлага</b>	<b>1,448,859</b>	<b>1,067,467</b>
Ажигчдаас авах авлага	86,842	122,958
НӨАТ болон бусад татварын авлага	1,815,366	684,119
<b>Нийт дансны ба бусад авлага – 12 сарын 31-нээрх</b>	<b>3,351,068</b>	<b>1,874,544</b>
Дансны болон бусад авлага – Эргэлтийн бус	1,087,722	404,800
Дансны болон бусад авлага – Эргэлтийн	2,263,346	1,469,744

Дансны авлагын үлдэгдэл нь бодит үнэ цэнээсээ материаллаг зөрүүгүй.

Групп хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хэмжихэд СТОУС 9-ийн хялбаршуулсан аргыг хэрэглэдэг бөгөөд энэ нь гэрээний хөрөнгөнд хугацааны турш дахь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хасагдуулгыг тооцдог.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хэмжихийн тулд авлагууд зээлийн эрсдэлийн онцлог шинж болон хугацаа хэтэрсэн өдрүүдэд үндэслэн ангилагдсан.

Хүлээгдэж буй алдагдлын түвшин нь тайлагналыг өдрөөс өмнөх 3 сарын хугацаанд хийсэн борлуулалтын дүнд үндэслэн энэ хугацаанд тохиолдсон холбогдох түүхэн эрсдэлийн алдагдалд үндэслэгддэг. Түүхэн алдагдлын түвшин нь харилцагчдын авлагыг барагдуулах чадварт нөлөөлж буй макро эдийн засгийн хүчин зүйлсийн одоогийн болон ирээдүйн мэдээллийг харгалзан тохируулагддаг.

2020 оны 12-р сарын 31-ны болон 2021 оны 6-р сарын 30-ны байдлаар хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын дүн материаллаг бус байсан тул ХБЗА хүлээн зөвшөөрөөгүй.

#### 15 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 12 сарын 31
Бэлэн мөнгө	216,350	126,248
Банкны харилцах дансанд буй мөнгө	3,745,539	5,977,829
<b>Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө</b>	<b>3,961,888</b>	<b>6,104,077</b>

#### 16 Санхүүгийн түрээсийн авлага

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 12 сарын 31
Богино хугацаат түрээсийн авлага	143,153	171,821
Урт хугацаат түрээсийн авлага	3,408,418	2,062,987
<b>Нийт санхүүгийн түрээсийн авлага</b>	<b>3,551,571</b>	<b>2,234,808</b>

2021 оны 6-р сарын 30-ны байдлаар Групп нь 17 дэлгүүрийн байрыг дэд франчайз эзэмшигчдэдээ түрээслүүлсэн.



**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан**

**16 Санхүүгийн түрээсийн авлага (Үргэлжлэл)**

Түрээсийн авлагын дансны үнэ нь бодит үнэ цэнээсээ материаллаг зөрүүгүй. Групп хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хэмжихэд СТОУС 9-ийн хялбаршуулсан аргыг хэрэглэдэг бөгөөд энэ нь түрээсийн авлагад хугацааны турш дахь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хасагдуулгыг тооцдог.

**17 Гүүдвилл**

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 12 сарын 31
Тайлант хугацааны эхний үлдэгдэл	-	-
Нэгтгэсэн охин компани	2,818,895	-
Тайлант хугацаанд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралт	-	-
<b>Тайлант хугацааны эцсийн үлдэгдэл</b>	<b>2,818,895</b>	<b>-</b>

Тайлант хугацаанд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь Премиум Дистрибьюшн ХХК-ийн 100% хувьцааг 2021 оны 6 сарын 8-нд худалдан авсан. Уг нэгтгэлийн дүнд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК 2,818,895 мянган төгрөгийн гүүдвилл хүлээн зөвшөөрсөн.


Хувьцаагаарх худалдан авалтын нэгтгэлийн огноогоорх тодорхойлох боломжит хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийг дор харуулав:

Мянган төгрөгөөр	Дансны үнэ	Бодит үнэ цэн
Нийт цэвэр тодорхойлох боломжит хөрөнгө	22,610,553	22,610,553
Нийт цэвэр тодорхойлох боломжит өр төлбөр	(17,705,053)	(17,705,053)
<b>Нийт цэвэр хөрөнгө</b>	<b>4,905,501</b>	<b>4,905,501</b>

Нэгтгэлээс үүссэн гүүдвиллийн тооцоо:

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30
Төлсөн дүн	7,724,396
Хасах нь: Нэгтгэсэн цэвэр хөрөнгө	4,905,501
<b>Гүүдвилл</b>	<b>2,818,895</b>





Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

18 Хувьцаат капитал

Мянган төгрөгөөр	Хувьцааны тоо (мянган ширхэг)	Энгийн хувьцаа	Нийт дүн
2019 оны 12 сарын 31-нээрх Шинээр гаргасан хувьцаа	171,452	17,145,256	17,145,256
2020 оны 12 сарын 31-нээрх Шинээр гаргасан хувьцаа	171,452 508,355	17,145,256 50,835,511	17,145,256 50,835,511
2021 оны 6 сарын 30-наарх	679,807	67,980,767	67,980,767

Тайлант хугацаанд Групп 508,355 хувьцааг шинээр гаргасан.

Нийт зөвшөөрөгдсөн энгийн хувьцааны тоо 679,807 мянган ширхэг (2020: 171,452 мянган ширхэг) ба нэгжийн нэрлэсэн үнэ 100 төгрөг (2020: 100 төгрөг). Эргэлтэд гаргасан бүх энгийн хувьцаа бүрэн төлөгдсөн. Энгийн хувьцаа бүр нэг саналын эрхтэй.

19 Бусад татварын өглөг

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 12 сарын 31
НӨАТ	336,283	55,978
ХХОАТ	219,638	119,974
НДШ	15,008	226,722
Бусад татвар	29,602	36,970
<b>Нийт</b>	<b>600,531</b>	<b>439,644</b>

20 Дансны ба бусад өглөг

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 12 сарын 31
Бусад өглөг – холбоотой талууд	1,094,984	16,349,578
Бусад өглөг – гуравдагч талууд	176,549	107,870
Дансны өглөг – гуравдагч талууд	11,405,058	7,393,522
Өр төлбөр - худалдан авсан үндсэн хөрөнгө	93,506	45,233
<b>Хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн дансны ба бусад өглөгөөрх нийт санхүүгийн өр төлбөр</b>	<b>12,770,097</b>	<b>23,896,203</b>
Ажилчдад өгөх өглөг	542,027	424,446
<b>Нийт бусад өглөг</b>	<b>542,027</b>	<b>424,446</b>
<b>Тайлант хугацааны эцсийн дансны ба бусад өглөг</b>	<b>13,312,126</b>	<b>24,320,649</b>

Дансны ба бусад өглөгийн үлдэгдэл нь бодит үнэ цэнээсээ материаллаг зөрүүгүй.





**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд**  
**2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан**

**21 Зээл**

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 12 сарын 31
<b>Урт хугацаат</b>		
Зээл - гуравдагч тал	7,494,555	-
Зээл - холбоотой тал	5,075,879	10,520,000
<b>Богино хугацаат</b>		
Зээл - гуравдагч тал	-	15,713,911
Зээл - холбоотой тал	102,989	646,828
<b>Нийт зээл</b>	<b>12,673,423</b>	<b>26,880,739</b>

Группийн зээлийг валютаар ангилан харуулав:

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 12 сарын 31
Монгол Төгрөг	7,494,555	16,360,739
Солонгос Вон	5,178,868	10,520,000
<b>Нийт зээл</b>	<b>12,673,423</b>	<b>26,880,739</b>

Банкаас авсан зээлд охин компанийн ирээдүйд бий болох хөрөнгийг барьцаалсан .

Групп нь хеджийн бүртгэл тооцоогүй бөгөөд гадаад валютын өр төлбөр, хүүгийн эрсдэлтэй холбоотой хеджийн гэрээ хийгээгүй болно. Зээлийн дансны үнэ нь бодит үнэ цэнтэйгээ ойролцоо.


Дээрх зээлийн гэрээнүүд нь зарим нэг санхүүгийн бус үүргийг биелүүлэхийг шаарддаг. Биелүүлээгүй тохиолдолд зээлийн гэрээг зөрчсөнд тооцох ба үлдэгдэл дүнг шууд төлж барагдуулах үүрэгтэй. Ийм учраас Санхүүгийн албанаас зээлийн үүргийн биелэлтийг улирал тутам хянадаг. 2020 оны 12 сарын 31 болон 2021 оны 6 сарын 30-ны байдлаар Групп бүх үүргийн биелэлтийг хангасан байна.

**22 Гэрээний өр төлбөр**

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 12 сарын 31
Гэрээний өр төлбөр – эрхийн шимтгэл	623,732	358,128
Урамшууллын оноо	152,519	88,030
Бэлгийн карт	14,858	11,006
<b>Нийт гэрээний өр төлбөр</b>	<b>791,109</b>	<b>457,164</b>

**23 Орлого**

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 6 сарын 30
Эцсийн хэрэглэгчид бараа борлуулсны орлого	28,109,216	17,569,221
Дэд франчайзад бараа борлуулсны орлого	3,912,128	25,036
Дэд франчайзад үйлчилгээ үзүүлсний орлого	363,453	55,303
Брэндийн нэрийн эрхийн шимтгэлийн орлого	72,450	-
<b>Нийт харилцагчтай байгуулсан гэрээний орлого</b>	<b>32,457,247</b>	<b>17,649,560</b>



**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулагууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан**

**23 Орлого (Үргэлжлэл)**

Орлого хүлээн зөвшөөрөх хугацаа (орлогын эх үүсвэр бүрээр):

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 6 сарын 30
Тухайн цаг хугацаанд	32,021,344	17,594,257
Тодорхой хугацааны турш	435,903	55,303
<b>Нийт харилцагчтай байгуулсан гэрээний орлого</b>	<b>32,457,247</b>	<b>17,649,560</b>

Гаднын харилцагчдаас олсон орлогыг ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээгээр бүлэглэв:

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 6 сарын 30
<b>Сегмент 1</b>		
- Бараа борлуулсны орлого	28,109,216	17,569,221
- Бараа борлуулсны орлого – дэд франчайз	3,912,128	25,036
<b>Сегмент 2</b>		
- Дэд франчайзын үйлчилгээний орлого	435,903	55,303
<b>Нийт харилцагчтай байгуулсан гэрээний орлого</b>	<b>32,457,247</b>	<b>17,649,560</b>

**24 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг**

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 6 сарын 30
Шууд түүхий эд материал	25,499,258	12,725,754
Хөдөлмөрийн шууд зардал	3,991,685	2,843,871
Элэгдэл ба хорогдуулалтын зардал	3,538,142	2,406,548
Түгээлтийн зардал	852,017	619,820
Цахилгааны зардал	219,451	408,935
Бусад зардал	2,154,646	1,568,402
<b>Нийт борлуулалтын өртөг</b>	<b>36,255,199</b>	<b>20,573,330</b>

**25 Ерөнхий ба удирдлагын зардал**

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 6 сарын 30
Хөдөлмөрийн зардал	1,672,907	1,495,407
Маркетингийн зардал	275,993	321,255
Элэгдэл ба хорогдуулалтын зардал	388,507	272,150
Цахилгаан холбоо болон МТ-ийн зардал	59,190	11,093
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	45,506	96,806
Бусад	260,716	157,851
<b>Нийт ерөнхий ба захиргааны болон борлуулалтын зардал</b>	<b>2,702,819</b>	<b>2,354,562</b>



**Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК**

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан**

**26 Бусад олз болон гарз, цэвэр дүнгээр**

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 6 сарын 30
Торгууль, хураамж болон бусад ижил төстэй орлого	339,662	101,143
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	290,029	18,272
Засгийн газрын тусламж	121,329	-
Бусад олз	12,279	4,139
<b>Нийт олз</b>	<b>763,299</b>	<b>123,554</b>
Бусад гарз	(327,766)	(387,246)
Торгууль, хураамж болон бусад ижил төстэй зардал	(918)	(3,007)
Найдваргүй авлагын зардал	(91,508)	-
<b>Нийт гарз</b>	<b>(420,192)</b>	<b>(390,253)</b>
<b>Цэвэр олз (гарз)</b>	<b>343,108</b>	<b>(266,699)</b>

**27 Санхүүгийн орлого**

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 6 сарын 30
Банкны харилцах данс болон хадгаламжийн дансны хүүгийн орлого	-	1,232
Түрээсийн авлагын хүүгийн орлого	191,862	-
<b>Ашиг, алдагдалд бүртгэгдсэн нийт санхүүгийн орлого</b>	<b>191,862</b>	<b>1,232</b>

**28 Санхүүгийн зардал**

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 6 сарын 30
Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал	1,775,530	1,383,073
Зээлийн хүүгийн зардал	705,471	1,191,460
<b>Ашиг, алдагдалд бүртгэгдсэн нийт санхүүгийн зардал</b>	<b>2,481,001</b>	<b>2,574,533</b>

**29 Орлогын албан татварын зардал**

**(а) Орлогын албан татварын зардал / (өгөөж)-ын бүрэлдэхүүн хэсгүүд**

Ашиг, алдагдалд бүртгэгдсэн орлогын татварын зардал дараах бүрэлдэхүүнтэй байна:

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 6 сарын 30
Тайлант жилийн орлогын албан татварын зардал	30,935	23,790
Орлогын албан татварын өгөөж	(1,285,280)	-
<b>Тайлант жилийн орлогын албан татварын зардал / (өгөөж)</b>	<b>(1,254,345)</b>	<b>23,790</b>

Сэнтрал Экспресс Су Ву Эс ХХК

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

## 29 Орлогын албан татварын зардал (Үргэлжлэл)

(б) Татварын зардал ба ашиг алдагдлыг ногдох татварын хувиар үржүүлсэн тооцооллын тохируулга

Группийн 2021 оны орлогын дийлэнх хэсэгт хамаарах орлогын албан татварын хувь хэмжээ 10% байна. Хуулиар тогтоосон хувь хэмжээгээр татварын өмнөх ашгаас тооцож гаргасан орлогын татварын зардлыг Группэд хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв.

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 6 сарын 30
<b>Орлогын татварын өмнөх алдагдал</b>		
Хуулиар заасан хувиар тооцсон татварын зардал 10%:	(822,697)	(811,833)
Хуулиар заасан хувиар тооцсон татварын зардал 25%: (3 тэрбум төгрөгөөс дээш татвар ногдох орлоготой)		
Татварын зорилгоор татвар ногдохгүй орлого, татвараас хасагдахгүй зардлын нөлөө:		
- Хасагдахгүй зардал	167,622	184,814
- Хүлээн зөвшөөрөгдөөгүй боломжит хойшлогдсон татварын хөрөнгө (Шилжүүлэггүй татварын алдагдал)	730,224	627,019
- Тусгай хувь хэмжээгээрх татварын нөлөө	30,935	23,790
- Татвар ногдохгүй орлого	(126,996)	-
Ирээдүйд шилжүүлэн тооцсон татварын алдагдал	(1,233,432)	-
<b>Тайлант жилийн орлогын албан татварын нийт зардал</b>	<b>(1,254,345)</b>	<b>23,790</b>

СТОУС болон Монголын татварын зохицуулалтын зөрүүнээс болж хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн тайлангийн зорилгоорх болон татварын зорилгоорх дансны үнэд түр зөрүү үүсдэг.

## 30 Нэгж хувьцаанд ногдох ашиг

Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)-ийг энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдох ашиг (алдагдал)-ийн дүнг тайлант хугацаанд эргэлтэд байсан хувьцааны жинлэсэн дундаж тоонд харьцуулж тооцдог.

Группийн энгийн хувьцааг хорогдуулах боломжит үнэт цаас байхгүй тул суурь нэгж хувьцаанд ногдох ашиг, хорогдуулсан нэгж хувьцаанд ногдох ашиг хоёр тэнцүү.

Үргэлжилж буй үйл ажиллагааны нэгж хувьцаанд ногдох ашгийн тооцоолол:

Мянган төгрөгөөр	2021 оны 6 сарын 30	2020 оны 6 сарын 30
Энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдох үргэлжилж буй үйл ажиллагааны алдагдал	(7,192,457)	(8,142,122)
Үргэлжилж буй үйл ажиллагааны ашиг, (алдагдал)	(7,192,457)	(8,142,122)
Эргэлтэд байгаа энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоо (мянган ширхэг)	233,584	171,452
<b>Нэгж энгийн хувьцаанд ногдох үргэлжилж буй үйл ажиллагааны суурь болон хорогдуулсан ашиг (алдагдал), (нэгж хувьцаанд ногдох төгрөг)</b>	<b>(30.79)</b>	<b>(47.49)</b>






50-8611478



Үнэт цаасны танилцуулга



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд  
2021 оны 6-р сарын 30-аарх зургаан сарын тайлан

### 31 Болзошгүй өр төлбөр ба үүрэг

**Шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг.** Бизнесийн үйл ажиллагааны явцад Группийн эсрэг зарга үүсэх боломжтой. Удирдлагууд өөрсдийн хийсэн тооцоололд үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудад тусгагдсан нөөц сангаас илүү дүнгээр материаллаг хэмжээний алдагдал учрахгүй гэж үзэж байна.

2021 оны 6 сарын 30-ний өдрийн байдлаар Группийн эсрэг ямар нэгэн шүүхийн нэхэмжлэл ирээгүй тул, удирдлага ирээдүйд мэдэгдэхүйц хэмжээний их алдагдал үүсэхгүй гэж үзэн болзошгүй өр төлбөртэй холбоотойгоор эрсдэлийн нөөц байгуулаагүй болно.

**Татварын болзошгүй өглөг.** Тайлант хугацааны эцэст батлагдсан эсвэл хэргэжиж байсан Монгол Улсын татварын хууль тогтоомжийг Группийн ажил гүйлгээ, үйл ажиллагаанд хэрэгжүүлэхэд олон янзын нөхцөл байдал тулгардаг. Үүний үр дүнд удирдлагын авч хэрэгжүүлж буй татварын байр суурь болон татварын хууль тогтоомжийн зөрүүгээс татварын хэсэгт сорилт тулгарч байна.

Монгол Улсын үнэ шилжилт (ҮШ)-ийн тухай хууль тогтоомжоор хэрвээ ажил гүйлгээ нь сунгасан гарын зарчмын дагуу хийгдээгүй бол хянагдах ажил гүйлгээнд (харилцан хамааралтай талуудын хоорондын гүйлгээ ба холбоогүй талуудын хооронд хийгдэх тодорхой гүйлгээ) нэмэлт татвар ногдуулах болон үнэ шилжилтийн залруулгууд хийх боломжийг татварын байгууллагуудад олгосон. Хяналтад байгаа ажил гүйлгээнээс үүсэх татварын өр төлбөрийг ажил гүйлгээний бодит үнээс нь хамаарч тогтоодог. Үнэ шилжилтийн дүрмийг хэрэгжүүлэх явцад ийм үнийг хэрэглэх сорилттой тулгарах боломжтой байдаг. Ийм сорилтын үр нөлөөг найдвартай үнэлэх боломжгүй боловч энэ нь Группийн санхүүгийн байдал болон/эсвэл үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой байж болох юм.

Монгол улсын татварын хууль тогтоомжуудын зарим нэгэн заалтууд нь тодорхой тайлбар зааварчилгаагүй байдаг. Групп нь үе үе татварын ерөнхий хувь хэмжээг бууруулах ийм тодорхойгүй байдалтай тулгардаг. Одоогийн байдлаар удирдлагын зүгээс татварын байр суурь, тайлбарыг тогтвортой байлгах боломжтой гэж тооцож байгаа боловч татварын алба эдгээр татварын байр суурь, тайлбарыг эсэргүүцэх тохиолдолд нэмэлт татвар төлөх эрсдэлтэй болно. Ийм сорилтын үр нөлөөг найдвартай үнэлэх боломжгүй боловч энэ нь Группийн санхүүгийн байдал болон/эсвэл үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой байж болох юм.

**Үүрэг хариуцлагын биелэлт.** Групп зээлийн үүргийн биелэлтийг хангасан.

### 32 Тайлагналын дараах үйл явдал

Группийн удирдлага олон нийтэд хувьцаагаа гаргах хүсэлтээ Монгол улсын санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргах замаар өмчийн санхүүжилт татан, цаашдын өргөжилтөө санхүүжүүлэхээр ажиллаж байна. Групп эргэлтэд байгаа хувьцааныхаа 10 хувийг гаргаж, 15,711,111 мянган төгрөгийн санхүүжилт босгохоор төлөвлөж байгаа бөгөөд 2021 оны 10-р сард хувьцаагаа гаргана хэмээн тооцож байна.

Тайлангийн хугацааны төгсгөлөөс хойш санхүүгийн тайланг гаргахаар батлагдсан өдрийн хооронд санхүүгийн тайлангуудад нөлөө үзүүлэхүйц үйл явдал менежментийн мэдэж байгаагаар дээр дурдсанаас өөр байхгүй.

### 33 Тайлангийн орчуулга

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг Монгол, Англи хоёр хэл дээр бэлтгэсэн бөгөөд Монгол хэлээрх, Англи хэлээрх хоёр хувилбарын хооронд утгын зөрүү гарсан тохиолдолд Англи хэлээрх хувилбарыг баримтална.

37



464

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ,  
ЗАСАГЛАЛЫН СУУРЬ ҮНЭЛГЭЭНИЙ  
**ТАЙЛАН**





CU

СЭХ  
2021.10.13  
БҮРТГЭВ  
№ 01

Үнэт цаасны танилцуулга

БӨЛӨГӨӨН ДЭМЖЭГ  
МОНГОЛЫН СҮДЭМЖЭГ  
2021.10.13  
БҮРТГЭВ-02

Төсөв Кэпитал ВЛКЗООК  
Golomt Capital  
Public Sector  
ТЭГЖЭГЭЛЭГ  
Улаанбаатар

466



## Гарчиг

1. Хураангуй тайлан	2
2. Оршил	6
3. Арга зүй	9
4. Байгууллагын танилцуулга	12
5. Засаглалын үнэлгээ	15
6. Нийгмийн үнэлгээ	18
7. Байгаль орчины үнэлгээ	37
8. Байгаль орчин, нийгэм, засаглалын шалгуур үзүүлэлтийн бодит нөлөөллийн дүн шинэжилгээ	41
9. Тогтвортой хөгжлийн зорилт	46
10. Зөвлөмж	48
Ашигласан материал	51





# 1. Хураангуй тайлан

“Ризилиенс Консалтинг Сервиз” ХХК нь “Сентрал Экспресс Си Ви Эс ХХК, “Премиум дистрибушн” ХХК-ийн харьяа CU сүлжээ дэлгүүрүүд болон нэгдсэн түгээлтийн систем, хоол боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд ESG (environment, social, and governance, цаашид “БОНЗ” гэх) суурь үнэлгээ хийх ажлыг 2021 оны 5 сарын 10-аас 2021 оны 6 дугаар сарын 14-ны дотор хийж гүйцэтгэлээ.

Энэхүү үнэлгээний ажил нь дараах үндсэн 6 алхамаас (зураг 1) бүрдсэн.


Үнэлгээ хийхдээ НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн зорилтууд (цаашид ТХЗ гэх), олон улсын санхүүжүүлэгч байгууллагуудын түгээмэл мөрддөг байгаль орчин, нийгэм, засаглалын шаардлагууд болох Олон улсын санхүүгийн корпорацийн (цаашид ОУСК): Байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн стандарт, конвенци, тунхаглал болон Монгол улсын холбогдох хууль, стандарт, журамд заасан шаардлагуудыг шалгуур болгон авч үзлээ. БОНЗ-ийн суурь үнэлгээг хийх хугацааг тодорхойлсон шаардлага одоогоор байхгүй байна. Гэхдээ дараах хүчин зүйлүүдийн шаардлагаар БОНЗ суурь үнэлгээнд мэргэжлийн байгууллагаар тодотгол хийлгэх шаардлагатай байдаг. Үүнд:

1. Санхүүжүүлэгч байгууллага
2. Хөрөнгийн биржийн стандарт шаардлага
3. Бизнесийн өөрчлөлт
4. Хууль эрхзүйн орчинд нэмэлт орох (бизнесийн үнэ цэнд нөлөөлөхүйц)
5. ТУЗ-н БОНЗ-н хорооны санаачлагаар
6. Гүйцэтгэх удирдлагын санаачлагаар



БОНЗ-ийн суурь үнэлгээг нийт 182 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж үзэхэд 174 шалгуур бүрэн биелсэн, 8 шалгуур бүрэн бус биелсэн байна. Өөрөөр хэлбэл 95,6% бүрэн биелэлттэй байна.

БОНЗ суурь үнэлгээ




Зураг 8. БОНЗ үнэлгээний дүн

“Сентрал экспресс Си Ви Эс” ХХК, “Премиум дистрибьюшн” ХХК нь (цаашид хамтад нь “Компани” гэх) БОНЗ-ын хувьд арвин ололт амжилттай үйл ажиллагаа явуулж байна.

Үнэлгээний үр дүнгээс харахад “Сентрал Экспресс Си Ви Эс” ХХК, “Премиум дистрибьюшн” ХХК нь (цаашид хамтад нь “Компани” гэх) одоогоор нээлттэй компани биш хэдий ч нийгмийн хариуцлагаа ухамсарласан, үйл ажиллагаандаа БОНЗ-ыг хангалттай түвшинд нэвтрүүлсэн





## Ололт, амжилт

### Бизнесийн ёс зүйн хэм хэмжээ төлөвшсөн

Компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа нь жигдэрсэн, баримт бичгийн бүртгэл, хяналт, хадгалалт сайн, "Бизнесийн Ёс зүйн хэм хэмжээ" баримт бичигт Компанийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчмыг тодорхойлсон. Энэ нь итгэлцэл хүндлэл дээр суурилсан ажил хэрэгч хамтын ажиллагааны суурь болсон байна.

### Нийгэмд эергээр нөлөөлөгч

Худалдаа үйлчилгээний салбарт эрүүл ахуй, үйлчилгээний стандартыг ахиулсан төдийгүй нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулж завгүй иргэдийн амьдарлын хэв маягт тохирсон нийгмийн нэг дэд бүтэц болж өргөжиж байгаа нь иргэд CU сүлжээ дэлгүүрээр үйлчлүүлснээр цагаа хэмнэж, ажил хөдөлмөр, сурч боловсрох, хөгжихөд болон гэр бүлтэйгээ хамт цагаа илүү зарцуулах боломжтой болсон.


### Хариуцлагатай ажил олгогч

Ажилтнууд ОУ-ын сайн туршлагуудаас сурч хөгжих, хувь хүний үнэ цэнээ нэмэгдүүлэх, албан тушаал ахихад нь тэгш боломжоор хангаж дэмжин ажилладаг. Залуучуудын ажил хөдөлмөртөө өсөн дэвжих боломжийг нэн түрүүнд тавьж, тэднийг сургах хөгжүүлэхэд, харилцааны соёл, үйлчилгээний соёлд сургахад ихээхэн анхаарч ажилладаг. Залуучуудад болон оюутан залууст хичээлийнхээ хажуугаар цагийн ажил хийх боломжийг олгож байгаа нь тэднийг биеэ даах, орлого олохын зэрэгцээ цагаар ажиллах боломжийг бий болгосноор тэдний ажлын анхны гараа нь болж, тэднийг үйлчилгээний соёлд сургаж ирээдүйн соёлтой, хөдөлмөрч иргэдийг бүтээхэд дэмжлэг болох юм.

### Нийгмийн олон талт, ялгаатай байдлын оролцоо, тэгш боломжийг хангагч

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэдний нийгмийн оролцоо нэмэгдүүлэн тэднийг нийгмээрээ хүлээн зөвшөөрөхөд дэмжлэг болгон ажилладаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусгайлан үйлчилгээ явуулах үйлчилгээг үйлчилгээний соёлдоо төлөвшүүлсэн.





1. ХУРААНГУЙ ТАЙЛАН

#### Үндэсний үйлдвэрлэлийг дэмжигч

Дотоодын хүнсний үйлдвэр, бэлтгэн нийлүүлэгчдийг эрүүл ахуйн шаардлага хангасан, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чанарын хяналтаараа дамжуулж эергээр нөлөөлж хамтдаа сайжрах, хөгжих боломжийг нээж байна. Мөн түүнчлэн үйл ажиллагаа нь тогтворжсон дэлгүүрүүдээ ЖДҮ бизнес эрхлэгчдээс сонгон шалгаруулж дэд франчайз эрхээр эзэмшүүлдэг нь тэднийг илүү тогтвортой, урт хугацааны бизнес эрхлэх боломжтой

#### Нийгмийн аюулгүй байдлыг сайжруулагч

CU сүлжээ дэлгүүр нь хурдацтай, далайцтай тэлж нь УБ хотын гудамж талбайд аюулгүй, гэрэлтэй, харуул хамгаалалтай, үнэгүй интернэттэй орчныг 24 цагийн туршид бүрдүүлж байгаа юм. Мөн дэлгүүр бүр гадна, дотор хяналтын камержуулалд, дохиолол хамгааллын мэдээлэх системтэй тул гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлд болон төөрсөн хүүхдүүдийг түр хамгаалах, мэдээлэл солилцох чиглэлд цагдаагийн байгууллагатай хамтарч

#### Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг эрхэмлэгч

Худалдан авалтын бодлогын баримт бичигтээ нэн түрүүнд улс орныхоо хөгжилд дэмжлэг үзүүлэх, байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөөгүй, эрчим хүчний хэмнэлттэй, дахин боловсруулан ашиглах боломжтой бүтээгдэхүүн, үйлчилгээг сонгон компанийн нийгэмд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зарчмыг тусган баримтлан ажилладаг.

Дэлгүүрүүдийн захиалсан 300 гаран нийлүүлэгчийн 3500 гаран нэр төрлийн бүтээгдэхүүнийг өөрсдийн түгээлтийн төвөөрөө дамжуулан нэгдсэн байдлаар түгээдэг нь УБ хотын замын түгжрэл, агаарын бохирдол болон авто зогсоолын ачааллыг бууруулахад бусад компаниудад үлгэр дуурайл болж байна. Хог хаягдлын менежментийг сайжруулах, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад хувь нэмрээ оруулдаг.

#### Сайжруулах боломжууд:

Компанийн БОНЗ-ын гүйцэтгэлийг цаашид улам сайжруулах дараах боломжууд байна.

1. ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын тогтолцоог иж бүрнээр нэвтрүүлж, хэрэгжүүлэх
2. Байгаль орчин, нийгэм, засаглалын гүйцэтгэлийн тогтолцоог нэвтрүүлж, хэвшүүлэх
3. Дотоод хяналт, эрсдлийн удирдлагын тогтолцоог сайжруулах
4. Байгаль орчин, ХАБЭА, тогтвортой худалдан авалтын бодлого боловсруулж, зорилт тодорхойлох





## 2. Оршил

Техник технологийн инновацын хурд нэмэгдэхийн хэрээр бизнесийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл эрчимжсээр байна. Мөн түүнчлэн, хөрөнгө оруулагч болон санхүүжүүлэгч байгууллагын зүгээс бизнесийн тогтвортой байдлын харилцан үйлчлэл бүхий үндсэн хүчин зүйл болох бизнесийн ашигт ажиллагаа ба ёс зүйд онцгой анхаарал хандуулснаар байгууллага урт хугацаандаа зөвхөн хувь нийлүүлэгчдэд төдийгүй нийгэмд үнэ цэн бий болгох стратегийн чухал алхам хийх шаардлага гарч ирсэн болно. Үүний хүрээнд бизнесийн үйл ажиллагаанаас үүсэж буй нөлөөллийг авч үзэх, удирдах, хянах механизмыг бүрдүүлж, Байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) гүйцэтгэлийг тодорхой, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлтээр хянах, ил тод нээлттэй тайлагнах шаардлага урган гарсан.

БОНЗ нь өртгийн сүлжээний үнэ цэн нэмэх үйл ажиллагааны үндсэн бүрэлдэхүүн хэсэг биш боловч хурдацтай өөрчлөгдөж буй гадаад орчны эрсдэл ба боломжийг үнэлэн, удирдах замаар урт хугацааны, тогтвортой үнэ цэнийг бүтээх чадавхыг бүрдүүлэхэд гол хөшүүрэг болдог. БОНЗ-ийн гүйцэтгэлийг сайжруулах, тайлагнах механизм нь сайн дурын шинжтэй сэдэвчилсэн байдалтай эхэлсэн боловч цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хүрээгээ улам тэлж, баяжигдан, хариуцлага өндөрсөж иж бүрэн тогтолцоо болон хөгжиж байна.


Тухайлбал, компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд байгууллага нь бизнесийн гүйцэтгэлтэй уялдаа сул, ихэвчлэн сайн дурын шинжтэй түр хугацааны санаачлаг гаргаж, ил тод нээлттэй тайлагнах үүрэг хүлээдэггүй. Харин БОНЗ нь байгууллагын бизнесийн үр өгөөж, үнэ цэнийг өсгөх санхүүгийн бус үзүүлэлтийн гол хөшүүрэг учраас БОНЗ-ын багц стандартын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт нь удирдлагын багийн жилийн үүрэг амлалт, зорилтын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсноор баг хамт олны олон талт ялгаатай байдал, ижил тэгш боломж, оролцоог чухалчилж, хариуцлагыг сайжруулж, мэдээллийн ил тод нээлттэй байдлыг эрхэмлэх замаар хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч болон бусад оролцогч талуудын итгэл хүлээсэн таатай орчин бүрдүүлдгээрээ онцлог юм. (Зураг 3).

### БОНЗ төлөвшилийн замнал



Зураг 3. БОНЗ-ийн төлөвшилийн замнал





БОНЗ нь тухайн байгууллагын дотоод ба гадаад орчинд үзүүлж буй нөлөөллийг үнэлэх багц шалгууруудаас бүрддэг.

**БОНЗ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ (жишиг)**

БАЙГАЛЬ ОРЧИН	НИЙГЭМ	ЗАСАГЛАЛ
<ul style="list-style-type: none"> <li>Уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хий ялгаруулалт</li> <li>Байгалийн нөөцийн ашиглалт (эрчим хүчний үр ашиг, усны менежмент)</li> <li>Экологийн ул мөр (хог хаягдлын менежмент, биологийн олон янз байдал)</li> <li>Бохирдол (агаар, ус, хөрс)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>ХАБЭА гүйцэтгэл</li> <li>Жендер ба хүйсийн ялгаатай байдлын талаар баримтлах бодлого</li> <li>Хүний эрх</li> <li>Хөдөлмөрийн стандарт</li> <li>Ажилчдын сургалт, хөгжлийн хөтөлбөр</li> <li>Ажилчдын оролцоо</li> <li>Хэрэглэгчийн сэтгэл ханамж</li> <li>Олон нийтийн харилцаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хувьцаа эзэмшигчийн эрх (ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, Аудиты хорооны бүтэц)</li> <li>Хээл хахууль, авлигын эсрэг бодлого</li> <li>Эрсдлийн удирдлага (лоббидох үйл ажиллагаа, улс төрийн хувь нэмэр)</li> <li>Татварын ил тод байдал</li> <li>Лобби үйл ажиллагаа</li> </ul>

Зураг 4. БОНЗ-ын үзүүлэлт

Тухайн байгууллага БОНЗ-ын шалгуурыг хангасан "нийгмийн хариуцлагатай, ёс зүйтэй" хөрөнгө оруулалтын стратегийг хэрэгжүүлснээр хөрөнгө оруулагчдын итгэлийг олж, санхүүжилт татах боломжийг нэмж, бизнесийн үр өгөөж, үнэ цэнийг өсгөх найдвартай орчин БОНЗ-н төгөлдөршилд нь дараахь үндсэн 3 хүчин зүйлээр тодорхойлогдоно.

✓ **Бизнес бодитоор нөлөөлөх байдал/ Materiality**

Байгууллагын өсөлт, санхүү, хөрөнгө оруулалтын өгөөж, тогтвортой байдал болон хөрөнгө оруулагч ба бусад оролцогч талуудын ашиг сонирхол, итгэлд нөлөөлөх БОНЗ-н үндсэн үзүүлэлтийг тодорхойлж, удирдаж, хянах процесс;


✓ **Эрх зүй/ Regulation**

Үндэсний болон олон улсын эрх зүйн баримт бичиг, конвенцын нийцлийг хангах, жишээлбэл, 2015 онд Фолксвагон компани "Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-н суурь конвенц"-г үл тоомсорлон 11 сая дизель хөдөлгүүртэй автомашиныг хүлэмжийн хийн ялгаралын туршил хэмжилт хийхгүйгээр худалдаанд гаргаснаар 27.4 тэрбум еврогийн торгууль шийтгэл авсан байна (Corporate Finance Institute@);

✓ **Ил тод байдал/ Transparency**

Үйл ажиллагааны (хөрөнгө оруулагчийн мөнгө зарцуулалт, удирдлагын тухай) мэдээллийн ил тод байдлыг хангах, нээлттэй тайлагнах, тухайлбал, санаатайгаар аливаа мэдээллийг нуун дарагдуулахгүй байх соёлыг хэвшүүлсэн байх





БОНЗ-ийн тогтолцоог байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж, гүйцэтгэлийг хангаж ажлах нь байнга давтагдан сайжирдаг процесс бөгөөд дараахь 6 алхам (Зураг 5)-г түгээмэл ашигладаг.




Зураг 5. БОНЗ-ийн тогтолцоог нэвтрүүлэх 6 алхам

Олон улсын хөрөнгийн бирж болон хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч байгууллагууд БОНЗ-н тайлагналын багц стандартыг нэвтрүүлж, үйлчлүүлэгч/харилцагч талтай хэрэгжүүлэлтийг хангах чиглэлээр хамтран ажиллах процесс үргэлжилж байна.

2020 оны 9 дүгээр сарын 11-нд дэлхийн тогтвортой хөгжлийн тайлагналын 5 байгууллага Уур амьсгалтай холбоотой санхүүгийн тайлагналын ажлын хэсгийн санаачлага (Task Force on Climate-related Financial Disclosures (TCFD))-н хүрээнд БОНЗ-н тайлагналын нэгдсэн стандартыг нэвтрүүлэхээр санал нэгдэв (Statement of Intent to Work Together Towards Comprehensive Corporate Reporting, Facilitated by the Impact Management Project, World Economic Forum and Deloitte, September, 2020). Үүнд:





### 3. Арга зүй

#### Хамрах хүрээ

БОНЗ суурь үнэлгээг "Премиум Групп"-ын "Сентрал Экспресс Си Ви Эс" ХХК-ийн сүлжээ дэлгүүрүүд, түгээлтийн төв, хоол боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд хийлээ.

#### Үнэлгээний баг

"РИЗИЛИЕНС КОНСАЛТИНГ СЕРВИЗ" ХХК нь 2020 онд Тогтвортой хөгжлийг дэмжих төрөл бүрийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ААН-үүдэд Тогтвортой хөгжлийн зөвлөгөө өгөх чиглэлээр байгуулагдсан.

БОНЗ суурь үнэлгээ хийх багийн ахлагчаар БОНЗ зөвлөх Ш.Байгалмаа, багийн гишүүнээр БОНЗ зөвлөх Др. Т.Индра, БОНЗ зөвлөх Ц.Нямгарав, нийгмийн зөвлөх А.Батжаргал, байгаль орчны аудитор Б.Сарангоо, туслах ажилтан П.Мөнхзул, М.Дулаанжаргал нар ажилласан.

Зөвлөхүүдийн Байгаль орчин, нийгэм, засаглалын менежментийн чиглэлээр хийсэн ажлын туршлага:

- Mongolian Mining Corporation нь Хонконгийн хөрөнгийн бирж дээр 2010 онд хувьцаа гаргасан бөгөөд тус төслийн IPO баримт бичгийн Нийгэм болон байгаль орчны хэсгийг боловсруулсан.
- Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) -ны санхүүжилтэд тавих үндсэн шаардлагын хүрээнд Ухаа худаг коксжих нүүрсний уурхай (UHG) -ийн I ба II үе шатны үйл ажиллагааны Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОНБУ) -ний тайлан, менежментийн төлөвлөгөөг боловсруулж амжилттай хэрэгжүүлсэн.
- ОУСК-н Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн стандарт (2012) -ын дагуу Оюу Толгойн төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОНБУ) -ний тайлан, менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлсэн.
- Таван Толгойн зүүн Цанхийн ордын үйл ажиллагаанд зориулж Хонконгийн Хөрөнгийн Биржээс санхүүжилт босгох ажлын хүрээнд төслийн БОНЗ-н үнэлгээ хийх ажилд оролцсон.
- Энержи Ресурс ХХК-н БОХАБЭА менежментийн тогтолцоог бий болгосон;
- Манай зөвлөхүүд нь ISO 9001, ISO 14001, ISO22000 ба ISO / PAS 45005 стандартын аудиторуд бөгөөд ISO 9001, ISO 14001, ISO45001, Хөдөө аж ахуйн зохистой дадал /ХААЗД/ стандартуудын зөвлөгөө өгөх, аудит хийж байсан туршлагатай.






#### Үнэлгээний шалгуур үзүүлэлт

БОНЗ-ийн үнэлгээнд НҮБ-ийн Тогтвортой Хөгжлийн Зорилтууд, Олон улсын санхүүгийн корпорац (УСК)-н Байгаль орчин, Нийгэм Засаглалд тавигддаг гүйцэтгэлийн шалгуурууд, конвенц, тунхаглал болон Монгол улсын холбогдох хууль, журам стандартуудын шаардлагуудыг шалгуур болгон авч үзлээ. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн Хууль
- Иргэний хууль
- Компанийн тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон байгаль орчны тухай бусад 30 хууль тогтоомжууд
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль
- Авто тээврийн тухай хууль
- Байгууллагын нууцын тухай хууль
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль
- Оюуны өмч, патентын тухай хууль
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
- Өрсөлдөөний тухай хууль
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль
- Технологи дамжуулах тухай хууль
- Эрүүл ахуйн тухай хууль ба бусад
- MNS 4946:2019. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага
- ОУСК: Байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн стандарт 1,2,3,4 (2012)
- НҮБ-ийн Хүний эрхийн тунхаглал





Үнэлгээний аргачлал

- Ярилцлага
  - 16 салбар дэлгүүрийн 16 менежер, 16 ажилтан
  - 3 бэлтгэн нийлүүлэгч
  - Засаглал, хүний нөөц, чанар, эрүүл ахуй, ХАБЭА, хоолны үйлдвэр, нэгдсэн түгээлтийн төв, хүйтэн хэлхээний агуулах хариуцсан ажилтанууд
- Газар дээр ажиглалт
  - 16 салбар дэлгүүр
  - Хүнсний үйлдвэр
  - Түгээлтийн төв
  - Хүйтэн хэлхээний агуулах агуулах
- Үйлчлүүлэгчийн судалгаа
  - 198 үйлчлүүлэгч компанийн БОНЗ-ийн талаар авсан судалгаа
- Баримт бичгийн судалгаа
- Өгөгдлийн судалгаа

Цугларсан нийт өгөгдөлд нийгэм, засаглал, байгаль орчны үнэлгээ, дүн шинжилгээ хийсэн.





## 4. Байгууллагын танилцуулга

“Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХХК нь Солонгос улсын CU конвинеенс брэндийн мастер франчайз эрхийг албан ёсоор хүлээн авагч 2018 оны 8-р сараас хойш өнөөдрийг хүртэл Монгол Улсын Улаанбаатар хотод CU сүлжээ конвинеенс дэлгүүрийн 110 гаруй салбар дэлгүүрийн үйл ажиллагааг 1300 гаруй ажилтантайгаар амжилттай хөгжүүлж байна.

CU брэнд нь их хотын завгүй амьдралын хэв маягт таарсан, хэрэглэгчийн хурдтай өөрчлөгдөн буй хэрэгцээ, шаардлагыг хангасан, өдөр тутмын, чанартай бүтээгдэхүүнийг цэвэр тохилог орчинд, чин сэтгэлийн найрсаг үйлчилгээгээр хүргэж ажилладаг. “Хэрэглэгчийн үйлчилгээгээрээ дэлхийд танигдана” гэсэн том мөрөөдөл, эрхэм зорилгоор хэрэглэгчийнхээ амьдралын өдөр тутам хэрэгцээг хаялбар, эрч хүч, цагийг хэмнэсэн шийдлээр хангахаар ажиллаж байна.





4. Байгууллагын танилцуулга

“Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХХК-ийн харьяа компани “Премиум дистрибушн” ХХК нь хоол үйлдвэрлэл, тээвэр, логистикийн үйл ажиллагааг хариуцдаг. Тус компани нь 2020 оны 11 сард Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хорооны нутаг дэвсрэгт орших Хонхор тосгонд хоолны үйлдвэр шинээр барьж ашиглалтад оруулсан. Уг үйлдвэр нь хагас автомат тоног төхөөрөмжөөр тоноглогдсон бөгөөд өдөр тутмын үйл ажиллагаандаа Аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналтын зарчмыг (НАССР) нэвтрүүлэн ажиллаж байна. Премиум дистрибушн ХХК нь CU дэлгүүрүүдийн ханган нийлүүлэлт, түгээлтийг дараах 2 сувагтайгаар гүйцэтгэж байна. Үүнд:

Хүйтэн хэлхээ

Температурын тусгай буюу 0-4°C горим шаарддаг бүтээгдэхүүнийг шинээр нь хэрэглэгчдэд хүргэхэд зориулан байгуулсан 325м2 тайлбай бүхий, зориулалтын тоног төхөөрөмж, агаар сэлгэлтийн систем бүхий хөргөгч байгууламжтай бөгөөд өөрийн хоолны үйлдвэрийн дэргэд байршилтай юм.

Одоогоор тус хүйтэн хэлхээгээр өөрийн үйлдвэрийн болон дотоодын нийлүүлэгчдийн 70 орчим нэр төрлийн хоол болон өрх гэрийн хэрэгцээний бүтээгдэхүүнүүдийг түгээж байна.

Бүтээгдэхүүнүүдийг хүлээн авах, дэлгүүрүүдэд захиалгын дагуу түгээх бүх үйл ажиллагаа шөнийн цагаар нэгдсэн байдлаар хийгддэг тул УБ хотын замын түгжрэл, агаарын бохирдол, автомашины зогсоолын ачаалал зэргийг багасгахад сайн нөлөөтэй юм. Үүнээс гадна шөнө үйлдвэрлэгдсэн шинэ хоол, бэлэн бүтээгдэхүүнүүдийг зориулалтын хөргөгчид бэлтгэн, температурын шаардлага хангасан тээврийн хэрэгслээр дэлгүүрт түгээдэг нь хэрэглэгч өглөө хэрэгцээт бүтээгдэхүүнээ шинээр нь хэрэглэх боломж олгож байгаа юм.

Хүйтэн хэлхээний бүтээгдэхүүнийг дэлгүүр бүрд хоногт 2 удаа шинээр нь түгээж байна.





4. Байгууллагын танилцуулга

**Түгээлтийн төв**

Хадгалалтын хэвийн буюу 18 to 25°C горимтой бүтээгдэхүүнийг нийлүүлэгчдээс хүлээн авч хадгалах, бэлтгэн түгээх үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэдэг.

Түгээлтийн төв нь ложистикийн зориулалттай баригдсан 4200м2 талбайтай байгууламж бөгөөд Дулааны 4-р станцын ойролцоо байрлах тул замын хөдөлгөөний хязгаарлалтгүй, хотын төв цэгээс 9.8 км зайтай гэх мэт нь нийлүүлэгчид бүтээгдэхүүнээ хүргэх, дэлгүүрүүдэд түгээлтийн гараг, цаг, маршрутын хязгаарлалтгүй түгээх боломжийг бүрдүүлж байгаа юм.

Бидний тооцоолсноор 3500 нэр төрлийн бүтээгдэхүүнийг хадгалах, 280 хүртэл дэлгүүрт түгээх хүчин чадалтай юм.

Компанийн өөрсдийн импортын 470 гаран нэр төрлийн бүтээгдэхүүний нөөцийг хадгалах бөгөөд дотоодын бэлтгэн нийлүүлэгчдээс бүтээгдэхүүний аюулгүйн нөөцийг тооцоолон татдаг тул улирлын нөлөөтэй болон олон нийтийн амралт, цар тахлын үед ч бүтээгдэхүүнийг нөөцлөн, түгээлтийн үйл ажиллагааг тасралтгүй гүйцэтгэж дэлгүүрийг бүтээгдэхүүнээр хангах боломжийг бүрдүүлж байгаа юм.

Түгээлтийн төв нь нэгдсэн харуул хамгаалалтай бөгөөд дохиолол хамагааллын автомат системээр тоноглогдсон тул аюулгүй ажиллагааг хангаж ажиллаж байна.


Агуулах түгээлтийн өдөр тутмын үйл ажиллагаа болох захиалга хүлээн авах, бэлтгэх, нөхөн дүүргэх, илгээх ажилбаруудыг нэгдсэн менежментийн системээр (WMS) удирдан гүйцэтгэдэг тул түгээлтийн бүтээмжийг нэмэгдүүлж дэлгүүрүүд захиалсан бүтээгдэхүүнээ тухайн өдөртөө багтаан хүлээн авах боломжийг бүрдүүлж байгаа юм.

CU брэндийн үнэ цэнэ, өрсөлдөөний давуу талыг ашиглан амжилттай бизнес эрхлэх хүсэлтэй жижиг дунд бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллаж үйл ажиллагаа нь тогтворжсон, хэрэглэгчдэдээ танигдсан салбар дэлгүүрүүдээ дэд франчайзийн эрх шилжүүлэн эзэмшүүлдэг. Одоогийн байдлаар 17 дэд франчайз эзэмшигчидтэй хамтран ажиллаж байна.



Зураг 7. Нэгдсэн түгээлтийн төв






## 5. Засаглалын үнэлгээ

“Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХХК-ийн засаглалын тогтолцоонд Монгол улсын Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам, ОУСК-н Гүйцэтгэлийн стандарт (ГС), Эрсдэлийн удирдлага (ГС-1 Байгаль орчин нийгмийн эрсдэл ба нөлөөллийн үнэлгээ, удирдлага) болон НҮБ-н холбогдох конвенцын хүрээнд компанийн засаглал тухайлбал ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын хариуцлагын тогтолцоо, дотоод хяналт, ил тод байдал, хувь нийлүүлэгчийн эрх үүрэг, эрсдэлийн удирдлагын тогтолцоонд үнэлгээ хийв.


ТУЗ, удирдлага - 7, Мэдээллийн ил тод байдал - 23, Хяналтын тогтолцоо - 15, хамааралгүй -11 нийт 44 шалгуур үзүүлэлтээ үнэлэхэд 32 шалгуур бүрэн биелсэн, 1 шалгуур бүрэн бус биелсэн байна. Мөн түүнчлэн, компани нь мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах ямар нэгэн үүрэг хүлээгээгүй боловч Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журмын хүрээнд боловсруулсан 23 шалгуур үзүүлэлтийн 12-г биелүүлсэнг тэмдэглэх нь зүйтэй юм. Засаглалын үнэлгээ 97% бүрэн биелэлттэй (Зураг 6) байгаа нь тухайн компанийн засаглалын төлөвшил сайн байгааг харуулж байна.

Засаглалын үнэлгээ



Зураг 8. Засаглалын үнэлгээний нэгдсэн дүн






Компанийн засаглалын хувьд дараах ололттой талууд байгааг онцлон тэмдэглэж байна.

- ✓ Компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа нь жигдэрсэн, баримт бичгийн бүртгэл, хяналт, хадгалалт төлөвшсөн.
- ✓ Бизнесийн Ёс зүйн хэм хэмжээний бодлогоор үйл ажиллагаанд оролцогч талуудын харилцаанд баримтлах үндсэн зарчмыг тодорхойлсон нь итгэлцэл, хүндлэл дээр суурилсан ажил хэрэгч хамтын ажиллагааны үндэс болсон.
- ✓ Бизнесийн үйл ажиллагаандаа ERP системийн программ хангамжийг нэвтрүүлснээр мэдээлэл, өгөгдлийн аюулгүй байдлыг хангаж, байгууллагын санхүү ба худалдан авалтын процессыг боловсронгуй болгож, үйлчлүүлэгчид ээлтэй удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байна.
- ✓ Дотоод хяналтын иж бүрэн тогтолцоо хараахан бүрдээгүй боловч үйл ажиллагаандаа чанар, хүнсний аюулгүй байдал, бараа материалын хөдөлгөөн, үлдэгдлийн үнэн зөв байдлыг автоматжуулсан системийн тусламжтайгаар хялбархан бүртгэх, залруулах үйл ажиллагаа жигдэрсэн, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчин, эрүүл ахуйн хяналт тогтмол тавин ажиллаж байна. Цаашдаа тухайн Дотоод хяналтын нэгдсэн тогтолцоо хариуцсан (Эрсдэлийн удирдлага, нийцлийн) нэгж байгуулж дараах асуудалд чиглэсэн үйл ажиллагааг явуулж, хяналтын тайланг төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнах боломжтой. Үүнд:
  - Санхүүгийн тайлангийн үнэн зөв, бодит байдал, мэдээллийн системийн найдвартай ажиллагаа;
  - Компанийн эрсдэлийг үнэлэх үйл ажиллагаа;
  - Компанийн өдөр тутмын үйл ажиллагааны хяналт шалгалт;
  - Хууль, журам, стандартын хэрэгжилтийн хяналт;





Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагааны чиглэлээр шалгуур үзүүлэлтийн шаардлага хангаагүй үл тохирол үнэлгээгээр илэрсэн. Үүнд: удирдлагын тогтолцоотой холбоотой 1 шалгуур бүрэн бус биелсэн байна. Хүснэгт 1-т үл тохирлуудыг харуулав.

Бүрэлдэхүүн хэсэг	Шалгуур үзүүлэлт	Өнөөгийн байдал	Биелэлт
ТУЗ, Гүйцэтгэх удирдлага	Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх	Хүнсний аюулгүй байдал, ХАБЭА удирдлагын тогтолцоо хүрээнд эрсдэл үнэлдэг	Бүрэн бус

Хүснэгт 1. Засаглалын үнэлгээгээр илэрсэн үл тохирол

Компанийн засаглалын нэг томоохон бүрэлдэхүүн нэсэг нь аливаа өөрчлөлтөд бизнесийн хариу үйлдэл үзүүлэх чадамж /Business resilience/ байдаг. Өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх чадамжийг бий болгоход олон хүчин зүйл нөлөөлдөг бөгөөд эдгээрийн ихэнх нь компанийн удирдлагын тогтолцооны салшгүй нэгэн хэсэг болон хэрэгжиж байна.

Өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх чадамжийг улам бэхжүүлэхийн тулд дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, бизнесийн тасралтгүй байдлын удирдлага, хямралын удирдлагыг сайжруулах шаардлагатай.

**Хяналтад байгаа хүчин зүйлс**

- ✓ Санхүүгийн чадамж/ Finance health and viability
- ✓ Хүний нөөцийн удирдлага /Human Resource Management
- ✓ ХАБЭАБОЧ удирдлага/ HSEQ management
- ✓ Мэдээллийн аюулгүй байдал/Information Security
- ✓ МХТ-н тасралтгүй байдал/Information & Communication Technology Continuity
- ✓ Хууль/ Legal
- ✓ Байгууллагын соёл/Organizational Behavior
- ✓ Ханган нийлүүлэлтийн удирдлага/Supply Chain Management

**Сайжруулах шаардлагатай хүчин зүйлс**


- ☒ Аудит, дотоод хяналт ба нийцэлийн удирдлага /Audit, and Internal Control & Compliance
- ☒ Эрсдлийн удирдлага / Risk Management
- ☒ Бизнесийн тасралтгүй байдлын удирдлага /Business continuity
- ☒ Хямралын удирдлага/Crisis management






## 6. Нийгмийн үнэлгээ

“Сентрал Экспресс Си Ви Эс” ХХК, “Премиум Дистрибьюшн” ХХК-ийн үйл ажиллагаанд нийгмийн үнэлгээ хийхдээ Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, Хүнсний аюулгүй байдлын тухай хууль, Олон улсын санхүүгийн корпорацийн Гүйцэтгэлийн стандарт #2 Хөдөлмөр эрхлэлт ба ажлын нөхцөл, Гүйцэтгэлийн стандарт #3 Нөөцийн үр ашигтай байдал, бохирдлоос сэргийлэх, Гүйцэтгэлийн стандарт #4 Иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, НҮБ-ийн Хүний эрхийн түгээмэл тунхаглал зэрэг хууль эрхзүйн баримт бичгийн хүрээнд хамаарал бүхий шаардлагуудыг сонгон авч нийт 118 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж үзсэн. 115 шалгуур бүрэн биелсэн, 3 бүрэн бус биелсэн буюу 97.4% бүрэн биелэлттэй байна. (Зураг 9).




“Сентрал Экспресс Си Ви Эс” ХХК, “Премиум Дистрибьюшн” ХХК-ийн үйл ажиллагаа нь нийгэмд эергээр нөлөөлж, бизнесийн салбарт сайн жишгийг бий болгож байна.



✓ Нийгэмд эергээр нөлөөлөгч

- Компани нь Хөдөлмөрийн хуульд заасны дагуу нийт ажилчдын 4%-оос доошгүй хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулахыг эрмэлздэг. 2020 онд "Сентрал Экспресс Си Ви Эс" ХХК, "Премиум Дистрибьюшн" ХХК нийлээд хөгжлийн бэрхшээлтэй ажилтны тоо 36 буюу нийт ажилтны 3.85%-ийг эзэлж байсан. (Хавсралт 2, БОНЗ гүйцэтгэлийн үзүүлэлт), Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил хөдөлмөр эрхлэх боломж бүрдүүлснээрээ хөгжлийн бэрхшээлтэй иргэд орлого олохоос гадна биеэ даах чадвар, нийгэмд эзлэх байр суурь нь нэмэгдэж байна. Мөн хамт ажилладаг ажилчид тэднийг илүү ойлгох, хүндлэх, анхаарал халамж тавих, тэдэнтэй зөв зохистой харьцах ур чадварт суралцаж байна. Энэ нь нийгмийн олон талт, ялгаатай байдлын оролцоог нэмэгдүүлэх, тэгш боломжийг хангахад оруулж буй том хувь нэмэр юм.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд дэлгүүрээр аюулгүй, ая тухтай үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Харааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчид зориулж брайл үсгээр бичсэн барааны меню, тусламж хүсэх хонх дэлгүүрүүдэд байрлуулсан, Тэргэнцэртэй үйлчлүүлэгчид зориулсан налуу зам дэлгүүрийн гадна хийсэн.
- Худалдаа үйлчилгээний салбарт эрүүл ахуй, үйлчилгээний стандартыг ахиулсан. CU сүлжээ дэлгүүрүүд, хоолны үйлдвэр нь MNS4946:2019 "Хоол үйлдвэрлэл үйлчилгээнд тавигдах шаардлага", MNS CAC/RCP 39:2011 "Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал" стандартуудын шаардлагад нийцээд зогсохгүй, эелдэг боловсон, соёлтой үйлчилгээг нэвтрүүлсэн.
- Цаг хэмнэх нь конвинеенс дэлгүүрийн үйлчлүүлэгчдээ бий болгож буй гол үнэ цэн юм. CU сүлжээ дэлгүүрүүд өөрийн нэрийн болон бэлтгэн нийлүүлэгчдийн үйлдвэрлэсэн бэлэн бүтээгдэхүүнээр (хоол) үйлчилдэг тул үйлчлүүлэгчид гэртээ хоол хийх цагийг хэмнэдэг. Ялангуяа, гэрийн эзэгтэй нарын цагийг илүү хэмнэж, ажил хөдөлмөр, хичээл, хобби, гэр бүлдээ илүү цаг зарцуулах боломж олгодог. (Хавсралт ххх, Үйлчлүүлэгчийн судалгааны тайлан). Энэ нь эмэгтэйчүүд өөрсдийгөө хөгжүүлэх улмаар нийгэмд эзлэх байр сууриа нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлнө.





✓ **Хариуцлагатай ажил олгогч**

- Ажилчид сурч хөгжих, албан тушаал ахих тэгш боломжоор хангадаг.
- Оюутан залуучууд цагийн ажил хийж орлого олохоос гадна байгууллагын зөв соёлтой компанид ажиллаж, хувь хүний хувьд төлөвших, хөгжих улмаар хөдөлмөрийн зах зээлд илүү өндрөөр үнэлэгдэх боломжийг олгож байна.

✓ **Үндэсний жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжигч**

- Компани дотоодын жижиг дунд хүнсний үйлдвэр, цехүүдийг эрүүл ахуйн шаардлага хангасан, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чанарын хяналтаараа дамжуулж эергээр нөлөөлдөг.
- Дотоодын ЖДҮ эрхлэгчдэд борлуулалт, орлогоо урьдчилан тооцох, дунд хугацааны төлөвлөгөө гаргах боломж бий болгож байна.
- Жижиг дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн чадамжийг нэмэгдүүлж байна. CU дэлгүүрийн салбарын тоо нэмэгдэхийн хэрээр бүтээгдэхүүний эрэлт, борлуулалт нэмэгдэж, дотоодын бэлтгэн нийлүүлэгчдийн орлого өсөж, санхүүгийн чадамж нь сайжирч байна.
- Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн бизнес эрхлэгчдийг дэмжиж байна. Түрээслэгчтэй 3+2 жилийн хугацаатайгаар гэрээ байгуулдаг бөгөөд түрээсийн төлбөрийг тогтмол хийдэг, түрээсэлсэн объектын засвар үйлчилгээг "Сентрал Экспресс Си Ви Эс" ХХК өөрийн зардлаар хийдэг. CU дэлгүүр байрласнаар тухайн байршлын үнэ цэнийг нэмэгдүүлдэг гэх зэргээр үл хөдлөх хөрөнгийн зах зээлд эергээр нөлөөлж байна.

✓ **Нийгмийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэгч**

- Аюулгүй, цэвэрхэн орчин бүрдүүлсэн. CU сүлжээ дэлгүүрүүд нь 24 цагийн ажиллагаатай тул шөнийн цагаар орчны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэхээс гадна 24 цагийн харуул хамгаалалт, камержуулалт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд эергээр нөлөөлж байна.
- Хүүхэд хамгааллын төсөл хэрэгжүүлж байна. 2021 оны 5 дугаар сараас хүүхэд төөрөх, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "CU чамд тусалъя" төслийг санаачлан, хэрэгжүүлж байна.




Үнэлгээний явцад илэрсэн үл тохирлуудыг арилган, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлснээр нийгмийн гүйцэтгэлийг улам сайжруулах боломжтой. Хүснэгт 2-т нийгмийн үнэлгээгээр илэрсэн 3 бүрэн бус биелэлттэй шалгуурыг харууллаа. Тэдгээрийн 2 нь аюулгүй байдал, эрүүл мэнд, 1 нь хөдөлмөр эрхлэлттэй холбоотой байна.

Бүрэлдэхүүн хэсэг	Шалгуур	Өнөөгийн байдал	Үнэлэмж
	ХАБЭА хууль. Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх	2019 онд "Ололт амжилтын түлхүүр" мэргэжлийн байгууллагаар АДШ, эрсдэлийн үнэлгээ хийсэн. 2020 онд шинээр хүнсний үйлдвэр, агуулах ашиглалтад орсон тул эрсдэлийн үнэлгээг шинэчлэх шаардлагатай.	Бүрэн бус
	IFC стандарт 4. Ажилтны аюулгүй байдлыг хангах	Компанийн зүгээс ажилтны аюулгүй байдлыг хангахын тулд ажлын байрыг 24 цагийн харуул хамгаалалттай болгох, ажилтан гэрээсээ ажилдаа очих, буцах маршрутыг тодорхойлох, унааны мөнгө өгөх, гэнэтийн ослын даатгалд хамруулах зэрэг олон арга хэмжээг авсан. Хэдий тийм боловч үйлчлүүлэгч дэлгүүрт танхайрах, ажилчдыг үгээр доромжлох, биед нь халдах тохиолдол гардаг. Тиймээс үйлчлүүлэгчдийн соёлыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хийх нь зүйтэй.	Бүрэн бус
Хөдөлмөр эрхлэлт	Хүний эрхийн тунхаглал. МХБ-ын ESG тайлагналын үзүүлэлт. Тогтвортой хөгжил, хүний эрхийн тухай сургалт ордог эсэх	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй хэрхэн хамт ажиллах тухай сургалт ордог. Тогтвортой хөгжил, хүний эрхтэй холбоотой өөр сургалт ажилтанд ордоггүй. Цаашдаа ажилтнуудад зориулж тогтвортой хөгжлийн суурь ойлголт, байгаль хамгаалал, НҮБ-ийн хүний эрхийн түгээмэл тунхаглалын талаар сургалт орох хэрэгтэй.	Бүрэн бус

Хүснэгт 2 Нийгмийн үнэлгээгээр илэрсэн үл тохирол







### Тогтвортой худалдан авалт

Олон улсын санхүүгийн корпорацын Гүйцэтгэлийн стандарт #3 Нөөцийн үр ашигтай байдал, бохирдлоос сэргийлэх, Монголын хөрөнгийн биржид нэвтрүүлэхээр хэлэлцэж буй БОНЗ-ийн тайлагналын үзүүлэлтийн дагуу "Сентрал Экспресс Си Ви Эс" ХХК-ийн худалдан авалтын үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн. Тогтвортой худалдан авалттай холбоотой 6 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж үзэхэд бүгд биелсэн байна (Зураг 7).

Компанийн хувьд дотоодын бэлтгэн нийлүүлэгчдийг дэмжих бодлого баримталж ажилладаг. "Худалдан авалтын үйл ажиллагааны журам"-ыг 2018 оны 9 сард баталсан. Уг журамд худалдан авахдаа баримтлах 4 үндсэн зарчмыг тодорхойлсон. Үүнд:

- Үс зүйн зарчим- Монгол Улсын хууль дүрэм журмыг чандлан мөрдөнө. Ашиг сонирхлын аливаа зөрчлөөс ангид байна, үнэнч шударгаар ажиллана.
- Эдийн засгийн зарчим-Бараа, үйлчилгээний үнэ, чанар, бэлтгэн нийлүүлэгчийн найдвартай байдал, хэмнэлттэй, шуурхай нийлүүлэх зэрэг эдийн засгийн үр ашгийг харгалзаж үзнэ.
- Шударга, ил тод байх зарчим-Бараа, үйлчилгээг нийлүүлэх боломжтой бүхий л бэлтгэн нийлүүлэгчид нээлттэй шударга, ил тод байдлаар, тэгш өрсөлдөх боломжийг олгоно.
- Нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх зарчим- нэн тэргүүд улс орныхоо хөгжилд дэмжлэг үзүүлэх, байгаль орчинд ээлтэй,сөрөг нөлөөгүй, эрчим хүчний хэмнэлттэй,дахин боловсруулан ашиглах боломжтой бараа, үйлчилгээг сонгож худалдаж авна гэж заасан.






2020 онд 358 бэлтгэн нийлүүлэгчтэй хамтарч ажилласнаас 340 нь дотоодын, 18 нь гадаадын ААН, байгууллага байна. Худалдан авалтын дүнгээс харахад 3 тэрбум төгрөгийн бараа гадаадаас импортлосон бол 33,7 тэрбум төгрөгийн худалдан авалтыг дотоодын бэлтгэн нийлүүлэгчдээс хийжээ.

Жил бүр дотоодын худалдан авалтын дүн өсөн нэмэгдэж бид хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, дотоодын жижиг дунд үйлдвэрүүдтэй хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн ажиллаж байна. "Сентрал Экспресс Си Ви Эс" ХХК, "Премиум Дистрибьюшн" ХХК-тай хамтран ажилласнаар олон зэрэг нөлөөлөл бий болж байна. Онцолбол,

- Чанарын хяналтаараа дамжуулж дотоодын жижиг дунд хүнсний үйлдвэр, цех эрүүл ахуйн шаардлага хангасан, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд эергээр нөлөөлдөг;
- Дотоодын бизнес эрхлэгчид борлуулалт, орлогоо урьдчилан тооцоолох улмаар дунд хугацааны төлөвлөгөө гаргах боломж бий болж байна. Энэ нь тухай бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад эергээр нөлөөлж байна;
- CU дэлгүүрийн салбарын тоо нэмэгдэхүүн хэрээр бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж, дотоодын бэлтгэн нийлүүлэгчдийн борлуулалт нэмэгдэж, санхүүгийн чадамжийг сайжруулж байна.
- Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн бизнес эрхлэгчдийг дэмжиж байна. CU сүлжээ дэлгүүрүүд нь бүгд түрээсийн байранд байрладаг. 2020 оны байдлаар .... объектыг түрээсээр ашигласан. Түрээслэгчтэй 3+2 жилийн хугацаатайгаар гэрээ байгуулдаг бөгөөд түрээсийн төлбөрийг тогтмол хийдэг, түрээсийн объектын засвар үйлчилгээг "Сентрал Экспресс Си Ви Эс" ХХК өөрийн зардлаар хийдэг. Мөн CU дэлгүүр тухайн объектод үйл ажиллагаа явуулснаар тухайн байршил нийтэд илүү танигдан зах зээлийн үнэлгээг өсгөж байна.

Бэлтгэн нийлүүлэгчидтэй гэрээ байгуулахдаа чанар, ХАБЭА-н шаардлагыг гэрээнд тусгадаг. Тухайн бэлтгэн нийлүүлэгчийн бүтээгдэхүүнтэй холбоотой гомдол, чанарын доголдол гарсан тохиолдолд бэлтгэн нийлүүлэгчид мэдэгдэж, асуудлыг шийдвэрлэх шаардлага тавин, доголдлыг арилгах хүртэл бүтээгдэхүүний нийлүүлэлтийг зогсоодог. Хэрвээ шаардлагыг хэрэгжүүлэхгүй бол гэрээ цуцлах хүртэл арга хэмжээ авдаг.





**Хөдөлмөр эрхлэлт**

Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Олон улсын санхүүгийн корпорацын Гүйцэтгэлийн стандарт #2 Хөдөлмөр эрхлэлт ба ажлын нөхцөл, Хүний эрхийн тунхаглал зэрэг эрх зүйн баримт бичгээс сонгон авсан 26 шалгуураар хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үнэлгээ хийсэн. Нийт 25 шалгуур бүрэн биелсэн, 1 шалгуур бүрэн бус биелсэн байна.

**Жендерийн харьцаа**

Компани нь Хөдөлмөрийн тухай хуулийг чандлан мөрдөж ажилладаг. Бүх ажилтантай Хөдөлмөрийн гэрээ байгуулж, нийгмийн даатгалын шимтгэлийг зохих хувиар төлдөг. Хөдөлмөрийн дотоод журмаар хөдөлмөрийн харилцааг зохицуулдаг.

2020 онд “Сентрал Экспресс Си Ви Эс” ХХК 800 ажилтантай, “Премиум Дистрибьюшн” ХХК 133 ажилтантай үйл ажиллагаа явуулж байсан. “Сентрал Экспресс Си Ви Эс” ХХК, “Премиум Дистрибьюшн” ХХК-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь худалдаа, үйлчилгээ, хүнсний үйлдвэрлэл бөгөөд салбарын нийтлэг жишгийн нэгэн адил эмэгтэй ажилтны тоо давамгайлдаг. 2020 оны тоон баримтаас харахад “Сентрал Экспресс Си Ви Эс” ХХК-ийн нийт ажилтны 63% нь эмэгтэй, “Премиум Дистрибьюшн” ХХК-ийн нийт ажилтны 60% нь эмэгтэй байжээ. Удирдлагын түвшин дэх хүйсийн харьцааг авч үзвэл анхан, дунд удирдах түвшинд эмэгтэй ажилтны тоо (66-78%), дээд түвшинд эрэгтэй ажилтны тоо (60%) давамгайлсан байна.

Компанийн нэр	Нийт ажилчдын тоо		Анхан дунд шатны удирдлага		Дээд түвшний удирдлага	
	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
“Сентрал Экспресс Си Ви Эс” ХХК	290	510	16	57	6	4
“Премиум Дистрибьюшн” ХХК	53	80	3	6	3	2

Хүснэгт 1. Эзэмшлэлийн үнэлгээгээр илэрсэн үл тохирол



Цалингийн хувьд, нэрлэсэн цалин албан тушаалууд дээр хүйсийн ялгаагүй тодорхойлогддог. Харин илүү цаг болон, тасалсан, хоцорсон зэрэг үзүүлэлтээс хамаарч, олгогдож байгаа цалингийн зөрүү үүсэх боломжтой. Олгогдсон цалингийн хувьд, эрэгтэй эмэгтэй ажилтны цалингийн зөрүү нь албан тушаалын түшингээр авч үзэхэд оффисын ажилтны хувьд эмэгтэй ажилтны дундаж цалин эрэгтэй ажилтантай харьцуулахад 260,000 төгрөгөөр илүү, дээд удирдлагын түвшинд эмэгтэй ажилтны дундаж цалин эрэгтэй ажилтны дундаж цалингаас 400,000 төгрөгөөр илүү гэсэн зөрүү гарсан байна. Дэлгүүрийн ажилтан, анхан дунд, шатны менежерийн хувьд цалингийн харьцаа 1:1 байна. Өөрөөр хэлбэл хүйс хоорондын цалингийн зөрүү бага байна.

Албан тушаалын түвшин	Цалингийн харьцаа Эр:Эм
Удирдлага	1:1.1
Оффис ажилтан	1:1.3
Дэлгүүрийн менежер, туслах менежер	1:1
Дэлгүүрийн ажилтан	1:1

Хүснэгт 4. Хүйс хоорондын олгогдсон цалингийн харьцуулалт

### Насны бүтэц

Насны бүтцийг авч үзвэл компанийн ажилтны дийлэнх олонх нь 18-33 насны залуучууд байна. Тэр дундаа олон тооны оюутны дэлгүүрт цагийн ажилтан хийдэг.



Зураг 10. Насны бүтэц



2020 онд 255 оюутан CU сүлжээ дэлгүүрт цагийн ажилтан хийсэн байна. Оюутан ажилтантай Хөдөлмөрийн хуулийн дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажилласан цагаар цалин, хөлсийг тооцож олгодог. Мөн үндсэн ажилтантай адил унаа, хоолны мөнгө, урамшуулалт авдаг. Эдгээр оюутнуудын хувьд “Сентрал Экспресс Си Ви Эс” ХХК нь анхны ажил олгогч, ажил хөдөлмөрийн анхны гараа болсон байна. Оюутнууд ажиллаж байх хугацаандаа орлоготой байхаас гадна харилцааны ур чадвар, хариуцлагатай байдал, эрүүл ахуйн зохистой дадал, цагийн менежмент зэрэг олон зүйлд суралцдаг. Мөн олон улсын сайн туршлага, “know-how”-аас суралцаж хувь хүний үнэ цэнээ нэмэгдүүлэх, албан тушаал дэвших боломжтой. Оюутнууд сургуулиа төгссөний дараа компанид үндсэн ажилтнаар ажиллаж туслах менежер, менежер болох тохиолдол багагүй байдаг. Жишээлбэл, 2020 онд CU сүлжээ дэлгүүрт ажилладаг байсан 41 оюутан албан тушаал дэвшсэн байна.

**Ажилтны сэтгэл ханамж**

Компани жил бүр ажилтны оролцоо, сэтгэл ханамжийн судалгаа авдаг. 2020 онд авсан сэтгэл ханамжийн судалгааны дүнгээс харахад “Сентрал Экспресс Си Ви Эс” ХХК-ийн нийт ажилтны 90%, “Премиум Дистрибьюшн” ХХК-ийн нийт ажилтны 83% нь сэтгэл ханамж дундаас дээш байна. Өөрөөр хэлбэл ажилтны сэтгэл ханамж хангалттай сайн байна гэж дүгнэж байна.

Сентрал Экспресс



Премиум Дистрибьюшн



**Ажилтны шилжилт хөдөлгөөн**

Худалдаа үйлчилгээний салбарт ажилтны шилжилт хөдөлгөөн бусад салбартай харьцуулахад харьцангуй өндөр байдаг. “Сентрал Экспресс Си Ви Эс” ХХК-ийн хувьд 2020 онд ажилчдын шилжилт хөдөлгөөн 99% байсан нь 2019 онтой харьцуулахад 65%-аар буурсан үзүүлэлт юм. “Премиум Дистрибьюшн” ХХК-ийн ажилтын шилжилт хөдөлгөөн 2020 онд 67% байсан. Компанийн зүгээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний дүнд “Сентрал Экспресс Си Ви Эс” ХХК-ийн ажилтны шилжилт хөдөлгөөн 2020 онд багассан байна. Үүнд:



#### Ажилтны шилжилт хөдөлгөөн

Худалдаа үйлчилгээний салбарт ажилтны шилжилт хөдөлгөөн бусад салбартай харьцуулахад харьцангуй өндөр байдаг. "Сентрал Экспресс Си Ви Эс" ХХК-ийн хувьд 2020 онд ажилчдын шилжилт хөдөлгөөн 99% байсан нь 2019 онтой харьцуулахад 65%-аар буурсан үзүүлэлт юм. "Премиум Дистрибьюшн" ХХК-ийн ажилтын шилжилт хөдөлгөөн 2020 онд 67% байсан. Компанийн зүгээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний дүнд "Сентрал Экспресс Си Ви Эс" ХХК-ийн ажилтны шилжилт хөдөлгөөн 2020 онд багассан байна. Үүнд:

- Компанийн үнэт зүйлсийг тодорхойлон, түүнд нийцсэн ажилтныг сонгон шалгаруулах тал дээр анхаарсан;
- Ажилтныг идэвхжүүлэх, багийн ажиллагаа сайжруулах, оролцоог нэмэгдүүлэх ажлуудыг хэрэгжүүлсний дүнд ажилтны сэтгэл ханамжийг сайжруулсан;
- Ажилтны сургалт хөгжилд ихээхэн анхаарч ажилласан;
- Гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулж, гүйцэтгэлээс хамааран цалингийн 120% хүртэл урамшуулал олгох болсон.

Ажилтны шилжилт хөдөлгөөнийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг 2021 онд бас үргэлжлүүлэн хийж байна.


#### Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан

Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу нийт ажилчдын 4-өөс доошгүй хувийг хөгжлийн бэрхшээлтэй ажилтнаар бүрдүүлэх зорилт тавьж ажилладаг. 2020 онд "Сентрал Экспресс Си Ви Эс" ХХК, "Премиум Дистрибьюшн" ХХК нийлээд хөгжлийн бэрхшээлтэй ажилтны тоо 36 буюу нийт ажилтны 3,85%-ийг эзэлж байсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу богиносгосон цагаар ажилладаг. Ажлын байрны зарыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй түгээх үүднээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоонуудтай хамтарч ажилладаг.



Компанид ажилладаг хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд 50-100% хөдөлмөрийн чадвар алдалттай байна. Тэдний дийлэнх нь сонсгол, хараа, хэл ярианы 100% хүртэл бэрхшээлтэй, мөн өнчин тархины хавдар, эпилепси, мэдрэлийн гэмтэл, тохойн зөөлөн эд ясажсан, тулгуур эрхтний гэмтэл, төвхний мултрал, хоёрдогч менингит зэргээс шалтгаалсан 79% хүртэл хөдөлмөрийн чадвар алдсан байсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олгосноор тэдэнд орлогоо нэмэгдүүлэхээс гадна нийгэмших, бие даах чадвар нь сайжрах зэрэг эерэг боломжуудыг бий болгож байна. Нөгөө талаас харахад бусад ажилтан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ойлгох, хүндлэх, тэдэнтэй зөв зохистой харьцах, халамжлах мэдлэг олж авч байна. Ингэснээрээ нийгмийн олон талт, ялгаатай байдлын оролцоо, тэгш боломжийг хангах боломж бүрдүүлж буй нь маш том эерэг нөлөөлөл юм.

Хөгжлийн бэрхшээлтэй ажилчдын хөдөлмөрийн чадвар алдалтын хувь 



Зураг 12. Хөгжлийн бэрхшээлтэй ажилчдын хөдөлмөрийн чадвар алдалтын хувь

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийн тулд компанийн сурталчилгааны материал үүнд, тор, зөөлөн тоглоом, уут, түлхүүрийн оосор зэргийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдээр хийлгэх боломжтой.



**Сургалт, хөгжил**

Компанийн зүгээс худалдаа, үйлчилгээнийхээ стандартыг өндөр түвшинд байлгах тал дээр ихээхэн анхаардаг. Салбарын онцлогоос шалтгаалан ажилтны шилжилт хөдөлгөөн өндөр байдаг тул шинээр ажилд орсон ажилтанд байгууллагын соёлыг танилцуулах, ойлгуулах, үйлчилгээний соёлыг хэвшүүлэх, эрүүл ахуйн зөв дадалтай болгох, ажлын ур чадвар мэдлэг олгох зэрэг сургалтуудыг ордог. Сургалтын дараа авсан мэдлэгийг шалгах тест бөглүүлэх бөгөөд 80%-аас бага үзүүлэлтэй бөглөсөн тохиолдолд тухайн ажилтан давтан сургалтад сурдаг.

Мөн үндсэн ажилчдад зориулж компанийн үндсэн 7 зарчмын тухай сургалт, хувь хүний хөгжлийн сургалт, манлайлын сургалт, үйлчилгээний соёлын тухай сургалт, дотоод IT систем хэрхэн ашиглах тухай сургалт, санхүүгийн менежментийн тухай сургалт, чанар, эрүүл ахуйн тухай, ажлын байранд шаардагдах ур чадвар олгох сургалтууд зэрэг олон төрлийн сургалт ордог.


Түүнчлэн франчайз эрх эзэмшигчдэд зориулж хүний нөөц, IT систем, агуулахын менежмент зэрэг чиглэлээр багц хичээл ордог. Ингэснээр франчайз дэлгүүрүүдийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар компаниас мөрддөг нэгдсэн стандарт, загварын дагуу явагдах нөхцөлийг бүрдүүлдэг.

Ковид-19 цар тахал гарч, хөл хорио дэглэм тогтоосонтой уялдуулан онлайн сургалтын контентууд бэлдэж компанийн дотоод систем болох Moodle, Yammer платформ, шэйрэд фолдерт байрлуулсан. Сургалтын материалууд нь ойлгомжтой, сонирхолтой байдлаар бэлтгэгдсэн.

2020 онд “Сентрал Экспресс Си Ви Эс” ХХК, “Премиум Дистрибьюшн” ХХК-ийн ажилтанд нийт 5,105,915 хүн цаг сургалт орсон бөгөөд сургалтын нийт зардал 26,1 сая төгрөг болжээ.

Компанийн нэр	Сургалт		
	Сургалтад хамрагдсан ажилчдын тоо	Сургалт үргэлжилсэн хугацаа	Хүн цаг
“Сентрал Экспресс Си Ви Эс” ХХК	5290	949	5,020,210
“Премиум Дистрибьюшн” ХХК	963	89	85,707

Хүснэгт 5. Сургалтын нөдөрлөл





Цаашид Олон улсын санхүүгийн корпорацийн Гүйцэтгэлийн стандарт, Хүний эрхийн тунхаглал зэрэг баримт бичигт заасны дагуу ажилтанд зориулж тогтвортой хөгжил, байгаль хамгаалал, хүний эрхийн тухай сургалтууд орвол зохимжтой.

Мөн сургалтуудыг ач холбогдлоор нь зайлшгүй суух шаардлагатай, сайн дурын гэж ангилан, ажилтныг зайлшгүй сургалтад бүрэн хамруулах, сайн дурын сургалтад хамрагдах хуваарийг уян хатан байдлаар зохицуулах нь зүйтэй.

#### *Аюулгүй байдал, эрүүл мэнд*

"Сентрал Экспресс Си Ви Эс" ХХК, "Премиум Дистрибьюшн" ХХК-ийн үйл ажиллагааны хүрээнд аюулгүй байдал, эрүүл мэндийн үнэлгээ хийхдээ хөдөлмөрийн болон иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэнд авч үзсэн.


Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Олон улсын санхүүгийн корпорацийн Гүйцэтгэлийн стандарт #4, Иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, НҮБ-ийн Хүний эрхийн тунхаглал, холбогдох журам, стандартын хүрээнд 48 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж үзэхэд 43 шалгуур бүрэн биелсэн, 5 шалгуур бүрэн бус биелсэн байна.

#### *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежмент*

Компанийн зүгээс ХАБЭА-н зөв хандлага, соёл бүрдүүлж, салбартаа үлгэр жишээ үйлчилгээний байгууллага байхад анхаарч үйл ажиллагаагаа тогтмол сайжруулж ажилладаг. "Сентрал Экспресс Си Ви Эс" ХХК, "Премиум дистрибьюшн" ХХК тус бүрд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой журам, заавар, зааварчилгааг нягт баримтлан мөрдөж ажилладаг.

Цаашид Олон улсын санхүүгийн корпорацийн Гүйцэтгэлийн стандарт, Хүний эрхийн тунхаглал зэрэг баримт бичигт заасны дагуу ажилтанд зориулж тогтвортой хөгжил, байгаль хамгаалал, хүний эрхийн тухай сургалтууд орвол зохимжтой.

Мөн сургалтуудыг ач холбогдлоор нь зайлшгүй суух шаардлагатай, сайн дурын гэж ангилан, ажилтныг зайлшгүй сургалтад бүрэн хамруулах, сайн дурын сургалтад хамрагдах хуваарийг уян хатан байдлаар зохицуулах нь зүйтэй.



Осол гарсан тухай мэдээлэл, түүнээс авсан сургамжийг компанийн дотоод сүлжээгээр мэдээлдэг. Ингэснээрээ ижил төстэй осол гарахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Ослын ангилал	"Сентрал Экспресс Си Ви Эс" ХХК	"Премиум Дистрибьюшн" ХХК
ЛТИ (нас баралт, хөдөлмөрийн чадвар бүрэн болон түр алдалт)	0	0
Эмнэлгийн тусламж	2	0
Анхны тусламж (Хөнгөн)	4	8
Осол дөхсөн тохиолдол	5	6
Эд хөрөнгийн хохирол	19	1
Нийт	30	15

Хүснэгт 6. Ослын мэдээлэл

#### ХАБЭА эрсдэлийн менежмент

2019 онд компанийн ХАБЭА ажилтнууд "Ололт амжилтын түлхүүр" мэргэжлийн байгууллагатай хамтран ажлын байран дахь ХАБЭА эрсдэлийн үнэлгээ, аюулгүй ажиллагааны дүн шинжилгээг хийлгэсэн. 2020 онд хоолны үйлдвэр, нэгдсэн агуулах, Кроссдок-Хүйтэн хэлхээний агуулахын байрууд шинээр ашиглалтад орсон тул эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн бүртгэлийг шинэчлэх хэрэгтэй. Ер нь жил бүр ХАБЭА эрсдэлийн үнэлгээг шинэчилж, эрсдэлийг хянах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

1. ХАБЭА-н албанаас гаргасан ослыг Онц яаралтай үеийн мэдээ дамжуулах хүснэгт
2. Утас
3. Дотоод сүлжээ- TEAMS болон и-мэйл

"Аюул ослыг мэдээллэх хуудас" нэвтрүүлж, хэвшүүлэхээр ажиллаж байна.

Мэдээлэгдсэн бүх төрлийн аюул, зөрчлийг арилгах хариу арга хэмжээг хамаарах алба хэлтсүүд тухай бүрд нь авч хэрэгжүүлдэг.




### ХАБЭА сургалт

Шинээр ажилд орсон бүх ажилтанд компанийн сургагч багш ХАБЭА-н талаарх мэдлэг ойлголтыг өгдөг. Цааш ажиллах хугацаанд нь бүх ажилтныг 6-8 цагийн хөтөлбөр бүхий "ХАБЭА-н нийт ажилтны сургалт"-нд хамруулдаг. Сургалтыг тусгай зөвшөөрөл бүхий "Ололт амжилтын түлхүүр" ХАБЭА мэргэжлийн байгууллага ордог. Чиглүүлэх сургалт болон Нийт ажилтны сургалтаар олсон мэдлэгийг бататгах зорилгоор сургалтын төгсөлд тест авдаг бөгөөд 80%-аас бага оноо авсан тохиолдолд давтан сургалтад суудаг. Чиглүүлэх сургалтаас гадна сэдэвчилсэн сургалтуудыг танхимаар болон ажлын байран дээр нь ХАБЭА-н ажилтнууд орж мэдлэг мэдээлэл мэргэжил арга зүйгээр хангадаг. Үүнд:

- Шинэ ажилтны чиглэл олгох
- Нийт ажилтны сургалт
- Ажлын байран дээрх давтан сургалт
- Ахлах ажилтныг чадавхжуулах сургалт
- Даралтад сав болон шатамхай шингэн хийн шугамын хоолойн ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа, хяналтын сургалт
- Сэрээт өргүүрийн операторын эрх олгох болон аюулгүй ажиллагаа ур чадвар (дадлага) сургалт
- Лабораторийн аюулгүй ажиллагааны чиглэл олгох сургалт
- "А" шат ашиглах аюулгүй ажиллагааны сургалт
- Галын аюулгүй байдлын тухай сургалт
- Хязгаарлагдмал орчинд ажиллах сургалт
- Цахилгааны аюулгүй ажиллагааны тухай ойлголт /Тоног төхөөрөмжийн/
- Тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлага, Тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын хяналт, Хөдөлгөөн эхлүүлэх, парклах үеийн аюулгүй ажиллагааны сургалт
- Хурц иртэй тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн аюулгүй ажиллагаа, зүсэгддэггүй бээлий ашиглах заавар
- Корона вирусийн эсрэг вакцин, вакцинд хамрагдах чиглэл олгох сургалт
- Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт зэрэг сургалтууд орсон

2020 онд нийт 2399 хүн цагийн сургалт орсон байна.



Handwritten signature in red ink over a stamp.

Handwritten signature in blue ink over a stamp.

#### Ажилтны эрүүл мэнд

Компанийн зүгээс ажилтны эрүүл мэндэд анхаарч спортын арга хэмжээг нэлээдгүй авч хэрэгжүүлдэг. Ажилтны төлөөлөөс бүрдсэн "Спорт комисс" байгуулсан бөгөөд "Спорт комисс" жил бүр ажилтны дунд сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөгийн тэмцээн болон бусад спортын арга хэмжээ зохион байгуулдаг. Мөн компани спорт заал түрээслэн, компанийн ажилтнууд долоо хоног бүр спортоор хичээллэх, дасгал хөдөлгөөн хийх боломжийг бүрдүүлсэн төдийгүй ажилтны дунд сайн дурын спорт клуб байгуулсан. 2020 онд компанийн зүгээс ажилтны эрүүл мэндийг дэмжихэд зориулж нийт 27,3 сая төгрөг зарцуулсан байна.

#### Ажилтны аюулгүй байдал


Компанийн зүгээс ажилтны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Бүх дэлгүүрийг камераар тоногосон;
- Харуул хамгаалалтын компанитай гэрээ байгуулсан. Дэлгүүрт аюултай нөхцөл үүсэхэд хамгаалалт дуудах тусгай товч байдаг бөгөөд товч дарснаас хойш 10 минутын дотор хамгаалалтын баг ирдэг;
- Ажилтанд ХАБЭА сургалтын үеэр аюултай нөхцөл үүсэх үед авах арга хэмжээний талаар зааварладаг;
- Бүх ажилтныг гэнэтийн ослын даатгалд хамруулсан. Ингэснээрээ ажлын байрандаа, эсвэл гэртээ харих, ажилдаа ирэх замдаа ямар нэг осолд орох, гэмт халдлагад өртсөн тохиолдолд нөхөн олговор авах боломжийг бүрдүүлсэн;
- Ажилтан гэрээсээ ажилд ирэх, буцах маршрутыг тогтоосон.

Хэдийгээр компани ихээхэн хүчин чармайлт гаргаж ажилладаг боловч үйлчлүүлэгчид дэлгүүрт зүй бус үйлдэл гаргаж ажилтны аюулгүй байдалд халдсан тохиолдол гардаг. Тиймээс үйлчлүүлэгчид зөв боловсон үйлчлүүлэх, дэлгүүрийн ажилтнуудтай зүй зохистой харьцах талаар нийгмийн нөлөөллийн ажлуудыг хийх боломжтой.

Компанийн хэмжээнд онцгой байдлын төлөвлөгөө байхгүй байгаа тул онцгой байдлын төлөвлөгөө боловсруулж, бүх ажилчдад танилцуулах, онцгой байдлын үед холбогдох албан тушаалтны нэр, утасны дугаарыг ажлын байрнуудад байрлуулах нь зүйтэй.





### Иргэдийн аюулгүй байдал

Компанийн зүгээс үйлчлүүлэгчид зориулж тавтай тухтай, цэвэрхэн, аюулгүй, нөхөрсөг орчинг бүрдүүлэхэд ихээхэн анхаардаг. Үйлчлүүлэгчид ч дэлгүүрийн үйлчилгээний соёл, тав тухай байдлыг өндрөөр үнэлдэг. Дэлгүүрүүд нь гэрэлтүүлэг сайтай, камераар тоноглогдсон, харуул хамгаалалттай төдийгүй корона вирусийн халдвараас сэргийлэх зорилгоор гар ариутгалын бодисыг дэлгүүр бүрд байрлуулсан. Ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийдэг.

Дэлгүүр бүрд эрүүл ахуйн шаардлага хангасан биеэ засах газар, угаалтууртай. CU сүлжээ дэлгүүрүүд нь 24 цагийн ажиллагаатай тул шөнийн цагаар орчны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэхээс гадна 24 цагийн харуул хамгаалалт, камержуулалд нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд эергээр нөлөөлж байна.

2021 оны 5-р сараас Нийслэлийн цагдаагийн ерөнхий газрын гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх газартай хамтран “CU чамд тусалъя” төслийг хэрэгжүүлж байна. Уг төслийн зорилго нь бага насны хүүхдийг төөрөхөөс сэргийлэх, төөрсөн хүүхдийг аюулгүй байлгах, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилготой. CU дэлгүүрийн салбаруудаар дамжуулж хүүхдэд тусламж үзүүлэх, дэлгүүрийн дотоод мэдээллийн сүлжээг ашиглан бүх салбарт төөрсөн хүүхдийн мэдээллийг хүргэх, харьяа дүүргийн цагдаагийн газартай шуурхай холбогдож мэдээллийг хүргүүлэн, хүүхдийг гэр бүлд нь аюулгүй хүлээлгэн өгөх юм.


Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдэд тухайлан анхаарал тавьдаг. Жишээлбэл, харааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчид зориулж брайл үсгээр бичсэн барааны меню, тусламж хүсэх хонх дэлгүүрүүдэд байрлуулсан. Тэргэнцэртэй иргэдэд зориулж 25 дэлгүүрт стандартын шаардлага хангасан налуу шат байрлуулсан. Дэлгүүрийн гадна талбайн зайнаас хамаарч зарим дэлгүүрт налуу шат стандартын шаардлага хангадаггүй. Шаардлага хангаагүй налуу зам дээр тэргэнцэртэй хүн унаж, бэртэх эрсдэлтэй тул зохих стандартын дагуу налуу зам хийх хэрэгтэй.

Мөн УБ-ын “Эрдмийн ундраа цогцолбор” 78-р сургуулийн сурагчдад галын аюулгүй байдал, гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар ойлголт өгөх зорилгоор галын аюулгүй байдлын булан тохижуулж өгч байна.

### Ковид 19 цар тахлын эсрэг арга хэмжээ

Корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлж ажилтны эрүүл мэнд дархлааг дэмжих зорилгоор ажилтнуудад амин дэмээр баялаг хоол хүнс, амин дэм витамин, амны хаалт, бээлий, ариутгалын бодисоор хангахаас гадна салбар дэлгүүрүүдэд кассын урдуур тусгаарлагч гялгар пластик унжуулж үйлчлүүлэгчдээс тусгаарласан. Дэлгүүр, хоолны үйлдвэр, түгээлтийн төвд ариутгал цэвэрлэгээ үйлчилгээ болон хортон шавж устгал, ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол давтамжтайгаар тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагуудаар хийлгэн хяналт тавин ажилладаг.





6. Нийгмийн үнэлгээ



Чанар, хүнсний аюулгүй байдал

Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүнсний аюулгүй байдалд 38 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж үзэхэд бүх шалгуур бүрэн биелсэн байна.

Шалгуур үзүүлэлт болгон Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хууль, MNS CAC/RCP 39:2011 Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал стандарт, MNS 4946:2019 Хүнсний үйлдвэрлэл үйлчилгээнд тавигдах шаардлага зэрэг хууль эрхзүйн баримт бичигт тавигдсан хамааралтай шаардлагыг сонгон авсан.

CU сүлжээ дэлгүүрт зарагддаг бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар өндөр, хэрэглэгчдийн сэтгэл ханамж сайн байдаг. Компанийн Чанарын албаны зүгээс чанар, эрүүл ахуйн дотоод хяналтыг тогтмол тавьдаг. Салбар дэлгүүрүүдэд сард 2 удаа дотоод хяналт хийдэг. Хяналтаар илэрсэн үл тохирлыг арилгах арга хэмжээг тухай бүрд нь хийдэг.

2020 оны 11-р сард Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэрт орших Хонхор тосгонд Хоол үйлдвэрлэлийн төвийг шинээр барьж ашиглалтад оруулсан. Уг үйлдвэрийг батлагдсан зургийн дагуу, хүнсний үйлдвэрийн зохистой дадлын шаардлагад бүрэн нийцүүлэн барьсан. Энэ тал дээр мэргэжлийн зөвлөх үйлчилгээний байгууллагатай хамтран ажилласан. Үйлдвэр хагас автомат тоног төхөөрөмжөөр тоноглогдсон. Хоол үйлдвэрлэлийн технологийн шат дамжлагыг нэг чигийн урсгалтай байхаар зохион байгуулсан бөгөөд Аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог (НАССР) нэвтрүүлэн ажиллаж байна.





Үйлдвэр дотроо микробиологийн лабораторитой. Микробиологийн лаборатори нь 2020 оны 11 сард ашиглалтад орсон бөгөөд 2022 онд ISO17025 Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага стандартын дагуу итгэмжлэл авахаар төлөвлөн ажиллаж байна. Уг лабораторид түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний дээжид нянгийн бохирдол байгаа эсэхэд шинжилгээ хийдэг. Хөндлөнгийн хяналтыг улирал тутам итгэмжлэгдсэн лабораториор хийлгэдэг. Хөндлөнгийн хяналтаар гэдэсний бүлгийн эмгэг төрөгчид болох E.Coli, Salmonella-аас гадна хөгц, мөөгөнцрийн шинжилгээ хийлгэдэг.

Чанарын алба нь компанийн харьяа хүнсний үйлдвэрээс гадна хоол, хүнс, хүнсний ногоо, жимс нийлүүлдэг бэлтгэн нийлүүлэгчдэд хяналт тавьдаг. Бэлтгэн нийлүүлэгчидтэй гэрээ байгуулахын өмнө үйлдвэрийн байр, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд чанарын болон эрүүл ахуйн зохистой дадлын үнэлгээ хийж, дүгнэлт гаргадаг. Үл нийцэл илэрсэн тохиолдолд залруулах арга хэмжээ авахыг шаардаж, үл нийцлийг бүрэн залруулсны дараа гэрээ байгуулдаг.


Дэлгүүрүүдэд EPS хэсэгт бэлэн хоол үйлдвэрлэх үйл ажиллагаа явагддаг. Конвиниенс дэлгүүрийн үйл ажиллагааны зарчмын дагуу CU дэлгүүрт 1 ээлж 3-4 ажилтан ажилладаг бөгөөд бараа хүлээн авах, бараа хүргэлт, төлбөр тооцоо, хоол үйлдвэрлэл, цэвэрлэгээ зэрэг олон төрлийн ажил хийдэг.

Тухайн ажилтан 1 ээлжид ажиллах хугацаандаа цэвэрлэгээ хийх тохиолдолд нэг удаагийн бээлий өмсөж цэвэрлэгээ хийх ба бусад үйл ажиллагаанд оролцоходоо гараа сайтар угаан, ариутгал хийн заншсан байдаг.

Конвиниенс дэлгүүрийн онцлогоос хамаарч олон төрлийн ажлыг нэг дор гүйцэтгэх шаардлага гардаг тул, цаашдаа ажил үүргийн хуваарилалтыг илүү сайжруулах нь зүйтэй.








## 7. Байгаль орчны үнэлгээ

“Сентрал экспресс Си Ви Эс” ХХК, “Премиум дистрибушн” ХХК-ийн үйл ажиллагаанд байгаль орчны үнэлгээг хийхдээ Олон улсын санхүүгийн корпорацийн Гүйцэтгэлийн стандарт, Монгол улсын холбогдох хууль эрхзүйн баримт бичгийн хүрээнд хамаарал бүхий шаардлагуудыг сонгон авч нийт 31 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж үзсэн. 27 шалгуур бүрэн биелсэн, 4 шалгуур бүрэн бус биелсэн буюу нийт шалгуурын 87% бүрэн биелэлттэй

Байгаль орчны үнэлгээ



Зураг 13. Байгаль орчны үнэлгээний дүн

Компани байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэдэг. Хог хаягдлыг бууруулах, ангилах ялгах, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах, цахилгааны хэрэглээг багасгах чиглэлээр анхаарч ажилладаг.






Байгаль орчин хариуцсан ажилтан байхгүй учраас байгаль хамгаалах зарим арга хэмжээ дутуу дулимаг байна. Тухайлбал, байгаль хамгаалах талаар сургалт хийдэггүй, үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг бүртгэж, тайлагнадаггүй. Үнэлгээгээр илэрсэн үл тохирлууд нь усны зохистой хэрэглээ, хог хаягдлыг менежменттэй холбоотой байна (Хүснэгт 7).

Бүрэлдэхүүн хэсэг	Шалгуур	Өнөөгийн байдал	Үнэлэмж
	Хог хаягдлын тухай хууль. Ажилчдад хог хаягдлын талаарх сургалтад хамруулах	Сургалт зохион байгуулаагүй	Бүрэн бус
	Хот тохижилтын журам. Үйлчилгээний газар, гудамж талбайд хогийн сав хүрэлцээтэй, Хогийн савыг цэвэрлэж халдваргүйжүүлдэг	Зарим дэлгүүрийн гадна талд хогийн сав	Бүрэн бус
	Хог хаягдлын тухай хууль. Хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр төрөл бүрээр бүртгэх	Дэлгүүрүүдэд хог хаягдлын	Бүрэн бус
	Хог хаягдлын тухай хууль. Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр, төрөл бүрээр бүртгэнэ.	Дэлгүүрт цуглуулж буй хаягдал батарейн бүртгэл	Бүрэн бус

Хүснэгт 7. Байгаль орчны үнэлгээгээр илэрсэн үл тохирлууд



### Усны хэрэглээ

CU сүлжээ дэлгүүр, хоолны үйлдвэр, нэгдсэн агуулахад баталгаажсан усны тоолуур байрлуулсан бөгөөд тоолуурын заалтын дагуу сар бүр усны төлбөр төлдөг. 2020 онд төлсөн усны төлбөр дээр үндэслэн тооцоолж үзвэл 1 дэлгүүрт дунджаар 1 сард 7,5 м3 ус ашигладаг гэсэн тооцоо гарч байна. Энэхүү тооцооллыг суурь үзүүлэлт болгон ашиглаж усны хэрэглээ жил бүр хэрхэн өөрчлөгдөж байгааг хянах боломжтой. Усны бодит хэрэглээгээ тооцохын тулд тоолуурын заалтын дагуу бүртгэх хэрэгтэй. Усны хэрэглээг бууруулахын тулд угаалтуурт мэдрэгчтэй цорго байрлуулах, цоргоор гоожих усны хэмжээг тохируулах, усны зүй зохистой хэрэглээг сурталчлах зэрэг ажлуудыг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

### Эрчим хүчний хэрэглээ

Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу цахилгааны хэрэглээг баталгаажсан тоолуураар хэмжиж, сар бүр төлбөр төлдөг. Тоолуурын бүрэн бүтэн байдлыг хэрхэн хянах, хэрхэн асааж, унтраах, залгах, салгах тухай зааварчилгааг тоолууруудын дэргэд байрлуулсан нь бусад үйлчилгээний газарт үлгэрлэх сайн ажил болсон байна.

Эрчим хүчний хэрэглээг бууруулахын тулд эрчим хүчний зарцуулалт багатай хөргүүр, хөргөгч худалдан авсан, дэлгүүр, агуулах, хүнсний үйлдвэрт LED гэрлийн чийдэн суурилуулсан зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн нь тун сайшаалтай.

АНУ-ын эрчим хүч хариуцсан албанаас гаргасан судалгаагаар LED гэрлийг хэрэглэх нь энгийн улайсдаг гэрэг ашиглахаас эрчим хүчний хэмнэлт нь 72%-80% бага байдаг судалгаа байдаг. Үүнээс харахад компани эрчим хүчний хэрэглээг бууруулах чиглэлд хүчин чармайлт гаргаж жилд хамгийн багадаа 12000 кВт эрчим хүч хэмнэж байна. Энэ үзүүлэлт нь дэлгүүрийн тоо нэмэгдэх тусам улам сайн нөлөөтэй байна гэж дүгнэхээр байна.

Эрчим хүчний хэрэглээг бүртгэдэггүй тул 2020 оны цахилгааны төлбөрт үндэслэн эрчим хүчний хэрэглээг тооцож гаргасан. Нэг дэлгүүр 1 сард дунджаар 6000 кВт.цаг эрчим хүч зарцуулсан байна. 2021 оноос цахилгааны тоолуурын үзүүдэлтээр эрчим хүчний бодит хэрэглээгээ бүртгэж, хянах хэрэгтэй.



**Хүлэмжийн хий**

Нийгэмд хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг ААН-үүд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах асуудалд хувь нэмрээ оруулах үүднээс өөрийн үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хувь нэмрээ оруулах болсон.

Хүлэмжийн хийн ялгарлыг тооцохдоо үйл ажиллагаанаас шууд болон шууд бус нөлөөлөх нөлөөллийг тооцдог. Энэхүү үнэлгээний ажлын хүрээнд үйл ажиллагаанаас үүсэх шууд ялгалын хэмжээг тооцож (Greenhouse Gases Equivalencies Calculator - Calculations and References | Energy and the Environment | US EPA) суурь үзүүлэлтийг гаргасан.

Хүлэмжийн хий ялгаруулагч хүчин зүйл	Хэмжээ CO <sub>2</sub> тн
Эрчим хүчний хэрэглээ	25.3
Шатах тослох материалын хэрэглээ	281.7
Хөргөх төхөөрөмжийн хий	215.1
Нийт	522.1

Хүснэгт 8. Хүлэмжийн хийн тооцоолол

**Хог хаягдал**

“Премиум Дистрибьюшн” ХХК-ийн хувьд хог хаягдлын журмыг 2021 оны 1-р сард батлан, мөрдөж байна. Уг журамд заасны дагуу хог хаягдлыг ангилан ялгах процессын зураглал мөн бүртгэлийн маягтуудыг боловсруулж, хоол үйлдвэрлэлээс гарч буй хог хаягдлын хэмжээг баримтжуулж эхэлсэн. 2020 онд хог хаягдлын бүртгэл огт хийгддэггүй байсан.

Компанийн зүгээс хог хаягдлын хэмжээг бууруулах тал дээр анхаар барилга, заслын ажилд эрүүл мэндэд хоргүй, эдэлгээ удаан материал сонгон хэрэглэдэг.

Бүх дэлгүүрүүдэд түр хогийн цэгийг зориулалтын дагуу шийдсэн төдийгүй хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах боломжийг бүрдүүлсэн. Мөн хаягдал батарейг цуглуулах санаачлалыг дэмжиж, хэрэгжүүлж байна. Харамсалтай нь ангилсан хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт өгдөх тал дээр зохицуулалт хийгдээгүй байна.



Зураг 14. Хог хаягдлын савнууд байршуулсан байдал



## 8. БОНЗ-ын шалгуур үзүүлэлтийн бодит нөлөөллийн дүн шинжилгээ

Байгууллагын өсөлт, санхүү, хөрөнгө оруулалтын өгөөж, тогтвортой байдал болон хөрөнгө оруулагч ба бусад оролцогч талуудын ашиг сонирхол, итгэлд нөлөөлөх БОНЗ-н үндсэн үзүүлэлтийг тодорхойлж, удирдаж, хянах нь бизнесийн байгууллагын удирдлагын тогтолцооны салшгүй нэг хэсэг юм. Иймээс БОНЗ-н үндсэн шалгуур үзүүлэлтийн бодит нөлөөллийн дүн шинжилгээ хийж, байгууллагын удирдлагын төлөвшлийг тодорхойлодог.

**01** **Хэн?**  
Нөлөөлөлд орж, болзошгүй оролцогч талуудыг тодорхойлох


**03** **Ямар түвшинд?**  
Оролцогч талуудын нөлөөллийн судалгаа хийх

**02** **Юу?**  
Эрсдэл үүсгэж болзошгүй БОНЗ-н үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох

**04** **Хэр хэмжээнд?**  
БОНЗ-н нөлөөлөл, ач холбогдлын матрикс боловсруулах







**Алхам 1: Оролцогч талуудыг тодорхойлох**

“Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХХК үнэт зүйлсээ тууштай баримтлан, тогтвортой хөгжлийг ханган ажиллахыг зорьдог. Үүний тулд оролцогч талуудаа танин мэдэх, тэдэнтэй харилцан ойлголцолд хүрч, харилцаагаа улам бэхжүүлэн итгэлцлийг бий болгох нь чухал юм. Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-н чиглэлээр анхаарал хандуулах шаардлагатай тулгамдсан асуудлуудыг оролцогч талуудтай хамтран илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлон, хэрэгжүүлж, үр дүнд дүн шинжилгээ хийж ажилласнаар бизнесийн аливаа өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх чадамж сайжрах юм.

Байгаль орчин, нийгэм, засаглалын үзүүлэлт нь байгууллага болон түүний оролцогч талуудад хэрхэн нөлөөлж буйг тодорхойлохын тулд “Оролцогч талуудын нөлөөлөл”-ийн дүн шинжилгээ хийв (Хүснэгт 9). Компанийн оролцогч талууд нийгмийн үнэ цэн, үр өгөөжийг бүтээж, итгэлцэлд суурилсан ирээдүйг цогцлоохын төлөө харилцан ашигтай хамтран ажиллаж байна.

Д/д	Оролцогч талын нэр	Анхаарах асуудал	Нөлөөлөл (бага, дунд, их)
1.	Хөрөнгө оруулагч: Зээлдүүлэгч, хөрөнгө оруулагч, санхүүгийн дэмжлэг үзүүлэгч байгууллагууд	Бизнесийн тогтвортой байдал, ил тод байдал, бизнесийн ёс зүй	дунд
2.	Бэлтгэн-нийлүүлэгч: Тусгай гэрээний зохицуулалтаар түүхий эд, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ ханган нийлүүлэгч, гэрээт байгууллагууд	Тогтвортой худалдан авалт, чанар, БОНЗ-н тухай ойлголт дутмаг, бизнесийн ёс зүйн хэм хэмжээний ойлголт харилцан адилгүй	их
3.	Франчайз:Тусгай гэрээний зохицуулалтаар “CU” брэндийн үнэ цэнэ, өрсөлдөөний давуу талыг ашиглан, урт хугацаанд харилцан ашигтай хамтран ажиллаж буй аж ахуйн нэгж, хувь хүн	БОНЗ-н тухай ойлголт дутмаг, хүнсний аюулгүй байдал, брэндийн нэр хүнд	их
4.	Үйлчлүүлэгч:CU сүлжээ дэлгүүрээс худалдан авалт хийдэг хэрэглэгч, байгууллага	Үйлчилгээний чанар, хүнсний аюулгүй байдал, мэдээ мэдээлэл хангалттай бус	их
5.	Иргэд:CU-н үйл ажиллагаа явуулдаг байршлын ойролцоо оршин суугч бүх насны (хүүхэд, залуучууд, ахмад настан, нийгмийн зорилтот бүлэг) иргэд	Хог хаягдалд санаа зовнидог, ялгаатай байдал тэгш боломж оролцоог эрэлхийлдэг, нийгмийн чиглэлийн үйл ажиллагааг хүсэмжилдэг, мэдээллийн ил тод байдал, хүртээмж	дунд
6.	Оюутан; Нөөцийн ажиллах хүч	Цагийн менежмент, хөдөлмөрийн нөхцөл, өсөж дэвших боломж, цалин урамшуулал	дунд

42



**8. БОНЗ-ын шалгуур үзүүлэлтийн бодит нөлөөллийн дүн шинжилгээ**

Д/д	Оролцогч талын нэр	Анхаарах асуудал	Нөлөөлөл (бага, дунд, их)
7.	Төрийн байгууллага:Төрийн үйлчилгээ үзүүлэх, хяналт, шийдвэр гаргах эрх бүхий газар, агентлаг, яам, УИХ болон ИТХ-н гишүүд	Татвар, хуулийн хэрэгжилт, дотоод хяналт, бизнесийн ёс зүй, авлига, хээл хахууль, мэдээллийн ил тод байдал	дунд
8.	Иргэний нийгмийн байгууллага: нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллага	БОНЗ-н ойлголт харилцан адилгүй, хүний эрх ба компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр санаачилга гаргаж, хамтарч ажиллахыг эрмэлздэг. Үйлдвэрчний эвлэлийн байгууллага байгууллагын ажилтны эрх ашгийг хамгаалах үйлдвэрчний эвлэлийн үүр байгуулах, хамтын гэрээ байгуулахыг шаарддаг	бага
9.	Мэргэжлийн холбоо: Бизнесийн үйл ажиллагаанд төрөлжсөн сэдвээр мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлж, гишүүн байгууллагуудын нэрийн өмнөөс төрийн бодлого шийдвэрт нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага	Гишүүнд элсүүлэхийг эрмэлздэг, холбоод хоорондоо өрсөлдөх магадлалтай; МХАҮТ-н зүгээс бизнесийн орчныг сайжруулах судалгаа хийж, төр засгийн шийдвэрт нөлөөлөх ажлыг зохион байгуулж байна. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд зөвлөмж гарган ажиллаж байна	бага
10	Олон улсын байгууллага:Тусгай чиглэлийн олон улсын байгууллагын төлөөлөгчийн газрууд: НҮБ-н Хүн амын сан, Хүүхдийн сан, Хөгжлийн хөтөлбөр, Хүнс ба хөдөө аж ахуйн байгууллага, Германы хамтын нийгэмлэг, Жайка, Канадын сан г.м	Нийгмийн болон ЖДҮ-г дэмжих үйл ажиллагаанд хамтарч ажиллах сонирхолтой, БОНЗ-ын тухай мэдлэг олгох, соён гэгээрүүлэх ажлууд	бага
11	Хэвлэл, мэдээллийн байгууллага:Сонин, радио, телевиз, чөлөөт сэтгүүлчид	Уур амьсгалын өөрчлөлт, хүнсний аюулгүй байдал, компанийн засаглал, хүний эрх	дунд

**Алхам 2: Байгаль орчин, нийгэм, засаглалын шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох**


Оролцогч талуудыг тодорхойлсны дараа БОНЗ-н үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилттой уялдаатай үндсэн үзүүлэлтийг багцдан дүн шинжилгээ хийхэд бэлтгэсэн (Хүснэгт 11).

**Алхам 3: Оролцогч талуудын нөлөөллийн судалгаа**

БОНЗ-н үндсэн шалгуур үзүүлэлтийн нөлөөллийн тодорхойлох судалгааг оролцогч талууд төлөөллийн хүрээнд ач холбогдол, эрсдэл, үр дагавраар 3x3 матриксаар 1 - 9 баллын системээр тодорхойлж дундаж оноогоор жагсаан эрэмбэлсэн.







8. БОНЗ-ын шалгуур үзүүлэлтийн бодит нөлөөллийн дүн шинжилгээ

БОНЗ-н үндсэн үзүүлэлтийн дүн шинжилгээнээс харахад компани болон оролцогч талуудын анхаарал төвлөрүүлж, байнга хянах шаардлагатай үзүүлэлтүүд нь маш өндөр эрсдэлийн бүсэд байрлаж буй (а) Хүнсний аюулгүй байдал, (b) Бизнесийн ёс зүй, (c) Хөдөлмөрийн харилцаа юм.

Гэхдээ, эрсдэлийн бусад бүсэд байрласан асуудлыг анхаарлын гадна орхиж болохгүй бөгөөд тодорхой хугацааны давтамжтай хяналт тавьж ажиллах шаардлагатай. БОНЗ-н үндсэн үзүүлэлтүүд болон тэдгээрийн ач холбогдол нь гадаад болон дотоод эрсдэлийн нөхцөл, хүчин зүйлсээс хамаарч хувьсан өөрчлөгдөж, хөвөгч чанартай оршдог.

Тиймээс, компани нь оролцогч талуудын харилцаанд тодорхой давтамжтай тухайлбал, улирал, хагас жилээр дүн шинжилгээ хийж, удирдлагын тогтолцооны төлөвшлийг шалгах боломжтой бөгөөд шаардлагатай гэж үзвэл тэднийг хамарсан судалгаа хийж болно. БОНЗ-н гүйцэтгэлийн тайланг компаниуд ихэвчлэн жил бүр гаргадаг бөгөөд БОНЗ-н тайлагналын стандартаас хамаарч өөрчлөгдөх магадлалтай. Асуудлуудыг эрсдэлийн бүсээр ангилж Хүснэгт 10-г үзүүлэв.

Д/д	БОНЗ-н үзүүлэлт	Хариуцлагын шатлал	Хугацаа
Маш их	Хүнсний аюулгүй байдал Бизнесийн ёс зүй Хөдөлмөрийн харилцаа	Гүйцэтгэх удирдлагын баг	Улирал, хагас жил, улирал
Дунд	Ялгаатай байдал, тэгш боломж, оролцоо Мэдээллийн ил тод байдал ХАБЭА Хүлэмжийн хийн ялгарал Усны хэрэглээ Хог хаягдал Эрчим хүчний хэрэглээ Тогтвортой худалдан авалт Бизнесийн тасралтгүй байдал Нийгмийн хариуцлага	Үйл ажиллагааны удирдлагын баг	Хагас жил, жил

Хүснэгт 10. БОНЗ-н үндсэн үзүүлэлтийн эрсдэлийн бүсээр ангилж, хянах





## 9. Тогтвортой хөгжлийн зорилт

Компанийн хэрэгжүүлж буй байгаль орчин, нийгмийн чиглэлийн үйл ажиллагаа нь НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтэнд хувь нэмэр оруулж байна (Хүснэгт 11). Үүнд:

- ТХЗ 1. Ядуурлыг зогсоох
- ТХЗ 3. Эрүүл мэндийг дэмжих
- ТХЗ 5. Жендерийн эрх, тэгш байдлыг хангах
- ТХЗ 8. Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох
- ТХЗ 9. Инноваци болон дэд бүтцийг нэмэгдүүлэх
- ТХЗ 10. Тэгш бус байдлыг бууруулах
- ТХЗ 11. Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих
- ТХЗ 12. Хариуцлагатай хэрэглээг дэмжих
- ТХЗ 13. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах
- ТХЗ 16. Энх тайван, шудрага ёсыг цогцлоох

БОНЗ-ын гүйцэтгэлийг сайжруулснаар ТХЗ-ийн хэрэгжилтэнд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх бүрэн боломжтой.

БОНЗ-н үндсэн үзүүлэлтүүд	Хийгдэж буй ажлууд	Тогтвортой хөгжлийн зорилтууд
Ялгаатай байдал, Тэгш боломж, Оролцоо	Хүн бүрд тэгш боломж олгож хэнийг ч хүйс, арьс өнгө, хөгжлийн бэрхшээл, гэр бүлийн байдал, иргэний харьяалал, үндэс угсаа, улс төрийн үзэл бодол эсхүл бусад аливаа хүчин зүйлээр үл ялгаварлан гадуурхаж, жигд оролцоо хангах бодлогыг баримталж байна.	Жендерийн эрх тэгш байдлыг
Хүлэмжийн хийн ялгарал	Тээвэр ложистикийн менежментийг сайжруулснаар бараа хадгалалт, түгээлттэй холбоотой түлшний хэрэглээ улмаар хүлэмжийн хийн ялгарлыг буурахад хувь нэмэр оруулж байна.	Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах
Хог хаягдал	Хог хаягдал үүсгэхээс аль болохоор зайлсхийх, нэг удаагийн хэрэглээний материалаас татгалзах, хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглалтыг дэмжих, урамшуулах, хог хаягдлын удирдлагын сайн туршлагыг бусад оролцогч талтай хуваалцах, сурталчлах ажлыг зохион байгуулж байна.	Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих Хариуцлагатай хэрэглээг дэмжих

БОНЗ-н үндсэн үзүүлэлтүүд	Хийгдэж буй ажлууд	Тогтвортой хөгжлийн зорилтууд
Эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний хэмнэлттэй техник, технологийг нэвтрүүлэн ажиллаж байна	Хариуцлагатай хэрэглээг дэмжих
Хөдөлмөрийн харилцаа	Ажилтан хүн аливаа төрлийн дарамтаас ангид аюулгүй эрүүл орчинд бүтээмжтэй, сэтгэлтэй, өөриймсөг ажиллаж, хөдөлмөрөө шударгаар үнэлүүлж зохистой цалин, урамшуулал авах, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, түүнийхээ төлөө хамгаалуулах эрхээр хангагдах боломжийг олгож, аливаа хөдөлмөрийн маргаанаас зайлсхийх, үүссэн тохиолдолд шударгаар шийдвэрлэх механизм бүрдүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутан залууст ажиллах, хөгжиж дэвших боломж олгож байна.	Жендерийн эрх тэгш байдлыг хангах Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих
Хүнсний аюулгүй байдал	Аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналтын зарчмыг (НАССР) нэвтрүүлж ажиллаж байна.	Эрүүл мэндийг дэмжих
Аюулгүй байдал, эрүүл мэнд Тогтвортой худалдан авалт	ХАБЭА-н удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. Дотоодын жижиг дунд хүнсний үйлдвэр, цехүүд эрүүл ахуйн шаардлага хангасан, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ашиг, орлогоо нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлж байна.	Эрүүл мэндийг дэмжих Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих
Ёс зүй	Бизнесийн ёс зүйн хэм хэмжээг тодорхойлон ажилтан болон бусад оролцогч талд сурталчлан танилцуулж, чанд мөрдөн ажиллаж	Энх тайван шударга ёсыг цогцлоох
Бизнесийн тасралтгүй	Бизнес аливаа эрсдэлээс ангид, өөрчлөгдөн хувьсаж буй орчинд дасан зохицох удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. Дотоод хяналт, эрсдэлийн удирдлага болон хямралын удирдлагын тогтолцоо төлөвшүүлэх ажил ид явагдаж байна.	Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих
Нийгмийн хариуцлага	Хүүхэд хамгаалах төсөл, гэрийн дулаан алдагдлыг бууруулах төсөл хэрэгжүүлж байна.	Ядуурлыг устгах Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих



## 10. Зөвлөмж

БОНЗ-ийн суурь үнэлгээний дүнд үндэслэн илэрсэн үл тохирлыг арилгах, БОНЗ-ийн гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн зөвлөмжийг боловсруулав. Хүснэгт 12-т ойрын хугацаанд болон дунд хугацаанд хэрэгжүүлэх зөвлөмжийг ялгаж харуулав.

### ОЙРЫН ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

#### Компанийн засаглал

- СУ-д Премиум Группийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын тогтолцоог иж бүрнээр нэвтрүүлж хэрэгжүүлэх
- Байгаль орчин, нийгэм, засаглалын нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, хэвшүүлэх ажлын хүрээнд ТУЗ-д тухайн асуудал хариуцсан хороог шинээр үүсгэн байгуулах. Энэ асуудлыг хариуцсан нэгж нь Гүйцэтгэх захирлын удирдлагын дор БОНЗ-н бодлого, журам, стандартыг боловсруулах, хэрэгжүүлэх, нийцлийг хангахад бизнес түншлэгч (business partner)-н хувиар зөвлөгөө өгч, хяналт тавьж, тайлагнах үндсэн үүрэгтэй байна.
- Үйл ажиллагааны тайланг цахим хуудсанд байршуулах, тайлангийн агуулгыг Хөрөнгийн бирж дээр бүртгэгдсэний дараа Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журмын дагуу шинэчлэх, хувь нийлүүлэгч болон олон нийтэд нээлттэй болгох
- Шүгэл үлээх (Whistleblower) тухай бодлого боловсруулж, баталгаажуулж, хэрэгжүүлэх, үүний хүрээнд бизнесийн оролцогч талуудын эрхийг дээдэлсэн, хараат бус харилцааны хэлбэртэй болох, (Бизнесийн ёс зүйн хэм хэмжээний 16.2т тусгасан), жишээлбэл: Speak out, тусгай утас Сэтгэл зүйчийн зөвлөгөө өгөх эсвэл Санал, гомдлын журмыг баяжуулан шинэчлэх
- Дотоод хяналтын иж бүрэн тогтолцоо бүрдүүлж, хэрэгжүүлэх, бүрдэл нь эрсдэлийн менежмент, дотоод хяналт ба нийцэл, дотоод аудит (risk management, internal control & compliance, internal audit),
- Дотоод хяналтын тогтолцооны баримт бичгүүдийг боловсруулж, баталгаажуулж, хэрэгжүүлэх, үүнд: дотоод хяналт, нийцлийн бодлого (шинэчлэн баяжуулах), эрсдэлийн бодлого, дотоод аудитын бодлого холбогдох үйл ажиллагааны журмууд /standard operating procedure/
- Бизнесийн тасралтгүй байдал ба хямралын удирдлагын тогтолцоо/Business continuity and crisis management framework бодлогын баримт бичиг боловсруулж, баталгаажуулж.

### Нийгэм

- Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан хийж болох ажил үүргийн жагсаалт гаргах
- Дэлгүүрт хоол үйлдвэрлэх процессыг эрүүл ахуйн зохистой дадал нийцүүлэн 1 ээлж дэх ажил үүргийн хуваарилалтыг оновчтой зохион байгуулах
- Хүнсний үйлдвэрийн түүхий эдэнд тавих чанарын хяналтыг сайжруулах
- Хүнсний үйлдвэр дэх урсгалыг оновчтой болгох
- ХАБЭА, чанар, хүнсний аюулгүй байдалтай холбоотой зөрчил, үл тохирол, гомдлыг бүртгэх, залруулах арга хэмжээг баримтжуулах, бүртгэлжүүлэх
- ХАБЭА эрсдэлийн үнэлгээг шинэчлэх, ажилчдад эрсдэлийн үнэлгээг танилцуулах, ажлын байранд байршуулах
- Онцгой байдлын төлөвлөгөө боловсруулах- оффис, үйлдвэр, агуулах, төлөвлөгөөнд дэлгүүрт онцгой байдал үүссэн үед авах арга хэмжээг тодорхой тусгах, онцгой байдал гарсан үед холбогдох албан тушаалтан, байгууллагын утасны жагсаалтыг гаргаж ажлын байранд байрлуулах.
- Ажилчдын аюулгүй байдлыг нэмэгдүүлэх
- Ажилчдын мэдээлсэн аюулыг ХАБЭА алба бүртгэх, аюулыг арилгасан эсэхийг хянах
- Үндэсний бэлтгэн нийлүүлэгчдийг дэмжиж ажиллах тухай бодлого гаргах
- Худалдан авалт хийх ESG шалгуур боловсруулах

### Байгаль орчин

- Гадна хогийн савны өнгө үзэмж сайжруулах, наасан стикерүүдийг шинэчлэх шаардлагатай. Түрээслэгч байгууллагаас байршуулсан хогийн савыг тэмдэг тэмдэглэгээ нааж хаягжуулах шаардлагатай.
- Хог хаягдал ангилан ялгах, дахин ашиглах талаар сургалт орж, бүртгэл хөтлөх.
- Дэлгүүрт цуглуулж буй ашигласан батарейг бүртгэх, дахин боловсруулах үйлдвэрт өгсөн хэмжээг бүртгэлжүүлэх
- Хог хаягдлын овор хэмжээг багасгах, цаас, хуванцрын хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт өгөх
- Усны зохистой хэрэглээний талаар зөвлөмж, сануулгыг дэлгүүрт, үйлдвэрт байрлуулах.
- Ажилчдад усны хэмнэлттэй хэрэглээний талаар сургалт орох
- Усны хэрэглээг бүртгэх
- Галын аюулгүй байдлын сургалт орж мэдлэг олгодог боловч ABC төрлийн нунтаг галын хор удаан хугацаагаар ашиглагдахгүй байснаар доторх химийн нунтаг бодисууд ялгарч шууд ашиглах боломжгүй заавал сэгсэрч хэрэглэх талаар мэдлэг олгох
- Эрчим хүчний хэрэглээг дэлгүүр, үйлдвэр, агуулах тус бүрд бүртгэх








## ДУНД ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

*Нийгэм*

- Сургалтуудыг зайлшгүй суух шаардлагатай, сайн дурын гэж ач холбогдлоор нь ангилах. Зайлшгүй суух ёстой сургалтад ажилчид бүрэн хамрагдсан эсэхэд хяналт тавих
- Ажилчдад хүний эрх, тогтвортой хөгжил, байгаль хамгаалал чиглэлээр сургалт орох
- Ажиллагсдаас үйлдвэрчний эвлэл байгуулах хүсэлт гарвал хүсэлтийг хүлээж авч хамтарч ажиллах
- Соёлтой, боловсон үйлчлүүлэгч байхыг сурталчилсан нийгмийн нөлөөллийн ажил хийх
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, савлагаанд байгаль орчинд ээлтэй технологи хэрэглэдэг эсэх мэдээллийг цуглуулах

*Байгаль орчин*

- Их цэвэрлэгээний тайлан гаргаж фото зураг хавсарган баталгаажуулж байх, их цэвэрлэгээний нэгдсэн мэдээлэл бүртгэлтэй болох.
- Угаалтуурын крантнуудыг мэдрэгчтэй крантаар солих
- Крантны цоргоор гоожих усны хэмжээг тохируулах
- Хөдөлгөөн мэдрэгчтэй чийдэн байрлуулах
- Шатахууны хэрэглээг бүртгэх
- Цахилгаанаар ажилладаг машин худалдаж авах боломжийг судлах



## Ашигласан материал

1. Corporate Finance Institute
2. Statement of Intent to Work Together Towards Comprehensive Corporate Reporting, Facilitated by the Impact Management Project, World Economic Forum and Deloitte, September, 2020
3. September, 2020
4. <https://www.globalreporting.org/standards/>
5. Монгол Улсын ндсэн Хууль
6. Иргэний хууль
7. Компанийн тухай хууль
8. Авлигын эсрэг хууль
9. Мнг угаах болон терроризмыг санхжлэхтэй тэмцэх тухай хууль
10. Хдлмрийн тухай хууль  
Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон байгаль орчны тухай бусад 30 хууль
11. тогтоомжууд
12. Хдлмрийн аюулгй байдал, эрл ахуйн тухай хууль
13. Хнсний бтээгдэхний аюулгй байдлын тухай хууль
14. Авто тээврийн тухай хууль
15. Байгууллагын нууцын тухай хууль
16. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль
17. Оюуны мч, патентын тухай хууль
18. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
19. рслдний тухай хууль
20. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль
21. Технологи дамжуулах тухай хууль
22. Эрл ахуйн тухай хууль ба бусад
23. MNS 4946:2019. Хоол йлдвэрлэл, йлчилгээний газарт тавих шаардлага
24. ОУСК: Байгаль орчны болон нийгмийн гйцэтгэлийн стандарт 1,2,3,4 (2012)
25. НБ-ийн Хний эрхийн тунхаглал
26. Компанийн засаглалыг нэлэх нэлгээний асуулга, Санхгийн зохицуулах хороо  
Greenhouse Gases Equivalencies Calculator - Calculations and References | Energy and the Environment | US EPA





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

Үнэт цаасны танилцуулга

2021.10.01

БҮРТГЭВ-02



ДУГААР 151021-13  
ОГНОО 2021 оны 09-р сарын 09

		Зөвшөөрсөн	Эс зөвшөөрсөн
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:	А.ГАНХУЯГ		
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШУУД:	А.ГАНБОЛД		
	О.БАТМӨНХ		
	Г.БАТ-ЭРДЭНЭ		
	Г.ЧИНЗОРИГ		
Тогтоолын батлагдсан хувь:		100%	



## 6.21 Төлөөлөн удирдах зөвлөлийн хувьцааны тоог нэмэгдүүлэх нөхцөлийн тухай нэмэлт тогтоол



### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ДУГААР	151021-14
ХАВСРАЛТ	0
ОГНОО	2021 оны 09-р сарын 21
УТГА	Компанийн нийтэд санал болгон анх удаа гаргах хувьцааны тоог нэмэгдүүлэх нөхцөлийн тухай

Компанийн тухай хуулийн, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг 43 дугаар зүйл, 55 дугаар зүйл, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.4, 76.1.5, 76.1.6, 76.1.13, 76.1.15, 76.1.18 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Үнэт цаасны бүртгэлийн журмын 7 дугаар зүйлийн 7.20 дох хэсэг, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК ("Компани")-ийн Дүрмийн 10 дугаар зүйлийн 10.5.1, 10.5.7, 10.5.11, 10.5.15 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 07-р сарын 26-ны өдрийн 6 тоот тогтоол, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2021 оны 07-р сарын 26-ны өдрийн 11 тоот тогтоол, ТУЗ-ийн 2021 оны 09-р сарын 09-ний өдрийн 151021-13 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. МХБ-ийн анхдагч зах зээлд Компанийн нийтэд санал болгосон хувьцааны эрэлтийн хэмжээ нь нийлүүлэлтийн хэмжээнээс давсан тохиолдолд нийтэд гаргасан энгийн хувьцааны 15 хүртэлх хувь буюу 17,994,909 ширхэг хүртэлх энгийн хувьцааг МХБ-ийн анхдагч зах зээлийн арилжаагаар санал болгохыг зөвшөөрсүгэй.
2. Тогтоолын 1 дэх хэсэгт дурдсан хувьцааг нэмж гаргасан тохиолдолд Компанийн МХБ-ийн анхдагч зах зээлд арилжаалах нийт энгийн хувьцааны тоо 137,960,969 ширхэг хүртэлх, олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 28,695,881,552 төгрөг хүртэлх болохыг дурдсугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид холбогдох журмын дагуу мэдэгдэж, зөвшөөрөл авах, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах, холбогдох баримт бичигт Компанийг төлөөлж гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д олгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)


Сэнтрал Экспресс СиВиЭс ХХК  
Улсын бүртгэлийн дугаар 9011681142  
Улаанбаатар хот







Үнэт цаасны танилцуулга



ДУГААР 151021-14  
ОГНОО 2021 оны 09-р сарын 21

		Зөвшөөрсөн	Эс зөвшөөрсөн
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:	А.ГАНХУЯГ		
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:	А.ГАНБОЛД		
	О.БАТМӨНХ		
	Г.БАТ-ЭРДЭНЭ		
	Г.ЧИНЗОРИГ		
Тогтоолын батлагдсан хувь:		100%	

